UNIVERSITY OF INTERNAL AFFAIRS,
MONGOLIA

LAW ENFORCEMENT

THEORETICAL AND METHODOLOGICAL
QUARTERLY JOURNAL

2021
№01, 02 (26)

Ulaanbaatar



СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн дарга:
Батбаатар П. Дотоод хэргийн их сургуулийн захирал, хууль зүйн доктор, профессор, цагдаагийн хурандаа

Зөвлөлийн орлогч дарга:
Зоригт О. Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, хууль зүйн доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа

Гишүүд:
Амарсанаа Ж. Монгол Улсын Гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, академич

Ариунбуян Г. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал

Болд Ж. Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагч, хошууч генерал

Болд Л. Академич

Лхагвасүрэн Х. Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагч, бригадын генерал

Загджав Д. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, улс төрийн ухааны доктор, хурандаа

Жигалов Н.Ю. Оросын Холбооны Улсын Дотоод явдлын яамны Дорнод Сибирийн их сургуулийн дэд захирал, хууль зүйн доктор, профессор

Чулуунбаатар Г. Академич

Эрдэнэбаатар Д. Дотоод хэргийн их сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал, хууль зүйн доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа

Ядамдорж Д. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал, цагдаагийн хурандаа

Болдбаатар Ж. Гэмт явдал, цагдаа судлалын хүрээлэнгийн захирал, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, цагдаагийн хурандаа

JOURNAL BOARD

Chief of the Board:
Batbaatar P. President of the University of Internal Affairs, Ph.D, Professor, Police Colonel

Deputy Chief of the Board:
Zorigt O. Vice President in Charge of Academic research of the University of Internal Affairs, Ph.D, Associate Professor, Police Colonel

Members:
Amarsanaa J. Honored Lawyer of Mongolia, Sc.D, Professor, Academician

Ariunbuyan G. Commissioner General, National mergency Management Agency, Brigadier General

Bold J. Commissioner General, National Police Agency, Commander of Internal Troop, Major General

Bold L. Academician

Lkhagvasuren Kh. Head of the General Authority for Border Protection, Commander of Border Troops, Brigadier General

Zagdjav D. Commissioner General, General Executive Agency of Court Decision, Ph.D, Colonel

Jigalov N.Yu. Deputy Director, Eastern-Siberian Institute of Ministry of Internal Affairs, Russian Federation, Ph.D, Professor

Chuluunbaatar G. Academician

Erdenebaatar D. Vice President for Training, University of Internal Affairs, Ph.D, Associate Professor, Police Colonel

Yadamdorj D. Chief, National Institute of Forensic Science, Police Colonel

Boldbaatar J. Director of the Institute for Criminology and Police, Sc.D, Professor Police Colonel

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

Сэтгүүлийн эрхлэгч:
Зоригт О. Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, хууль зүйн доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:
Бат-Эрдэнэ Б. ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал, хууль зүйн доктор, цагдаагийн хурандаа

Нарийн бичгийн дарга:
Бямбажаргал Б. Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хэвлэл редакцын хэлтсийн дарга бөгөөд ахлах редактор, цагдаагийн хошууч

Гишүүд:

Мөнхзаяа Б. Сургалтын бодлого төлөвлөлтийн газрын дарга, хурандаа

Азбаяр Ц. Удирдлагын академийн захирал, цагдаагийн хурандаа

Лхагвасүрэн Б. Ахисан шатны боловсролын сургуулийн захирал, хууль зүйн доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

Буянхишиг Г. Цагдаагийн сургуулийн захирал, цагдаагийн хурандаа

Ганбаатар Д. Хилийн албаны сургуулийн захирал бөгөөд хилийн 0345 дугаар ангийн захирагч, бригадын генерал

Нямгомбо Б. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн захирал, хурандаа

Сүхбаатар Х. Онцгой байдлын сургуулийн захирал, хурандаа

Болдбаатар Ч. Эрх зүй нийгмийн ухааны сургуулийн захирал, цагдаагийн хурандаа

Ганбаатар Г. Ахлагчийн сургуулийн захирал, хууль зүйн доктор, цагдаагийн хурандаа

Гантулга Ц. Шинжлэн магадлахуйн институтын захирал, хууль зүйн доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа

Чулуунбат Ш. Гадаад хэлний институтын захирал, доктор, дэд профессор, хурандаа

Нямсүрэн Ч. Судлаачийн хөгжлийн төвийн судалгааны арга зүйч-багш, хууль зүйн доктор, профессор, цагдаагийн хурандаа

JOURNAL EDITORIAL BOARD

Editor of the journal:
Zorigt O. Vice President in Charge of Academic research of the University of Internal Affairs, Ph.D, Associate Professor, Police Colonel

First Secretary:
Bat-Erdene B. Director of Integrated Research Institute, University of Internal Affairs, Ph.D, Police Colonel

Secretary:
Byambajargal B. Head of the Center for Law Enforcement Education Studies, Scientific Research Institute, University of Internal Affairs, Master of

Members:

Munkhzaya B. Head of the Training Policy and Planning Departmentl, Colonel

Azbayar Ts. Director of Academy of Leadership, Police Colonel

Lkhagvasuren B. Director for Graduate School, Ph.D, Associate Professor,Police Lieutenant Colonel

Buyankhishig G. Director of Police School, Police Colonel

Ganbaatar D. Director, School for Border Services, Brigadier General

Nyamgombo B. Head, Security Studies Center, Integrated Research Institute, University of Internal

Sukhbaatar Kh. Director of Emergency Management School, Colonel

Boldbaatar Ch. Director of The Institute of Laws and Social Sciences, Police Colonel

Ganbaatar G. Director of Non-commissioned officer School, Ph.D, Police Lieutenant Colonel

Gantulga Ts. Head, Department of Criminology and Criminal Law, Police School, University of Internal Affairs, Ph.D, Police Major

Chuluunbat Sh. Chairman, Foreign Language Institute, Ph.D, Associate professor, Colonel

Nyamsuren Ch. Methodologist of the Centre for Researcher's Development, Ph.D, Professor, Police Colonel

ГАРЧИГ–TITLE

АЮУЛГҮЙ БАЙДАЛ СУДЛАЛ
SECURITY STUDIES

МОНГОЛ УЛСЫН ДОТООД АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САХИУЛАХАД УУЛ УУРХАЙ, АШИГТ МАЛТМАЛ, ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НӨЛӨӨЛӨЛ

THE IMPACTS OF MINING NATURAL RESOURCES ON MONGOLIAN INTERNAL SECURITY

Ж.Өвгөнбүргэд
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Аюулгүй байдал судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор, дэд профессор, хурандаа
Uvgunburged.J
Colonel, Associate professor, doctor (PhD.), senior researcher of Security Study center, Integrated Research institute, the University of Internal Affairs — 10

ҮР ТАРИАНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ОРЛОГЫН ХЭЛБЭЛЗЭЛ

INCOME FLUCTUATIONS OF GRAIN INDUSTRIAL ENTREPRENEURIAL

Б.Юмаажав
Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн багш, мэргэшсэн нягтлан бодогч, магистр, дэслэгч
Д.Энхчимэг
Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн багш, доктор (Ph.D) — 21
Yumaajav.B
University of Internal Affairs, lecturer, Master, CPA,
Enkhchimeg.D
National Defense university, Institute of security lecturer, doctor and associate professor, department of economics and management, Mongolia

ГЭМТ ЯВДАЛ СУДЛАЛ
CRIMINOLOGY

ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХЭД МЭДЭЭЛЛИЙН НЭГДМЭЛ БАЙДАЛ, УЯЛДААГ ХАНГАХ АСУУДАЛ

THE ISSUE OF PROVIDING INTEGRATED AND INTERDEPENDENT INFORMATION IN THE FIGHT AGAINST ENVIRONMENTAL CRIME

Б.Мөнхдорж
ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хууль сахиулахуйн боловсрол судлалын төвийн эрхлэгч, хууль зүйн ухааны доктор, математикийн ухааны магистр, цагдаагийн дэд хурандаа
Munkhdorj B.
Head of the Center for Law Enforcement Education Studies, Scientific Research Institute, University of Internal Affairs of Mongolia, Master of Mathematics, Ph.D, Police Lieutenant Colonel — 40

ҮР ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДСЭН ЭТГЭЭДИЙН ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ АРГА ХЭРЭГСЭЛ, ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

СПОСОБЫ ВОЗДЕЙСТВИЯ НА ПОВЕДЕНИЕ ЛИЦ, СОВЕРШИВШИХ НАСИЛЬСТВЕННЫЕ ПРЕСТУПЛЕНИЯ ПРОТИВ СЕМЬИ И НЕСОВЕРШЕННОЛЕТНИХ, ИХ ПРОБЛЕМНЫЕ АСПЕКТЫ

Г.ДЭЛГЭРСҮРЭН
Баянгол дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлстийн хүүхдийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад
Б.ДАЯДАН–ЭРМЭД
ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Инновацийн төвийн эрдэм шинжилгээ, туршилт судалгааны ажилтан, ахлах дэслэгч — 60
ДЭЛГЭРСҮРЭН.Г
Старший инспектор по делам несовершеннолетних 1-го отдела полиции Баянгольского района, капитан полиции
ДАЯДАН–ЭРМЭД.Б
Научный сотрудник Инновационного центра Объединенного института научных исследований Университета внутренних дел, старший лейтенант

КРИПТОЮВАЛЮТ БА ТЕРРОРИСТ БОЛОН ГЭМТ БҮЛЭГЛЭЛ

CRYPTOCURRENCY VERSUS TERRORIST AND CRIMINAL ORGANIZATION

Ж.Болд 68
Дотоод хэргийн их сургуулийн докторант
Bold.J
Ph.D. candidate in the University of Internal Affairs

ТАГНУУЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ МӨН ЧАНАР

INTELLIGENCE ACTIVITIES AND ITS NATURE

П.Очбадрах
Дотоод хэргийн их сургуулийн докторант, цагдаагийн дэд хурандаа
Т.Оюунчимэг 73
Дотоод хэргийн их сургуулийн Гэмт явдал цагдаа судлалын хүрээлэнгийн судлаач, доктор (Ph,D), профессор, цагдаагийн хурандаа
Ochbadral.P
Doctorate student
Oyunchimeg.T
Doctor, professor, police colonel, researcher of the institute of criminology and Police study of the Inited institution of UIA

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

CURRENT SITUATION AND FUTURE TRENDS OF DOMESTIC VIOLENCE PREVENTION ACTIVITIES

А.Мөнхсувд 81
Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч
Munkhsuvd.A
Senior Specialist of the Department for Combating Domestic Violence and Crimes against Children, Police Major

ХИЛ СУДЛАЛ
LIMNOLOGY

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ҮНДСЭН СУДЛАГДАХУУН

AN UNDERSTANDING OF BORDER SECURITY

А.Муратхан 88
Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн захирал, доктор, прфессор, бэлтгэл хурандаа
Muratkhan.A
Director, Institute for Border Security Studies, The Joint Research Institute, UIA, Ph.D, Professor, Colonel

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ БОЛОН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ГАЗАР НУТГИЙН УЛАМЖЛАЛТ НЭРИЙН ӨӨРЧЛӨЛТ НӨЛӨӨЛӨХ НЬ

IMPACT OF THE CHANGE OF TOPONYMS TO THE NATIONAL SECURITY AND BORDER SECURITY F MONGOLIA

Ц.Ганболд 102
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн судлаач, доктор, профессор.
Ganbold.Ts
Researcher, Institute for Border Security Studies, The Joint Research Institute, University of Internal Affairs, Ph.D, Professor, Colonel

ХИЛИЙН ЗӨРЧЛИЙГ ШИЙДВЭРЛЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES ON DECISION MAKING FOR BORDER VIOLATION

Б.Зулбадрах 117
ДХИС-ийн ЭШНХ-ийн Инновацийн төвийн эрхлэгч, докторант, хурандаа.
Zulbardah.B
Ph.D candidate, Colonel, Director of the Innovation Center, the Joint Research Institute, University of Internal Affairs

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ ТУСГАЙЛСАН ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИНТОЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

COMPARATIVE STUDY BETWEEN BORDER PROTECTION ORGANIZATION'S LEGISLATION AND LEGISLATION OF ORGANIZATIONS OF SPECIAL PURPOSES

М.Ганбаатар
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан-багш, дэд хурандаа
Эрдэм шинжилгээний удирдагч: Ц.Ганболд 135
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан, доктор, профессор, хурандаа
Ganbaatar.M
Senior Officer, Institute for Border Security Studies, The Joint Research Institute, University of Internal Affairs, Ph.D Candidate, Lieutenant Colonel
Ganbold.Ts
Researcher, Institute for Border Security Studies, The Joint Research Institute, University of Internal Affairs, Ph.D, Professor, Colonel

ХИЛ СУДЛАЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ НЭР ТОМЬЁО, ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ АСУУДАЛ

ASPECTS OF TERMS AND TERMINOLOGIES OF FRONTIER STUDIES SCIENCE AND THEIR SUITABLE USAGE

Ж.Болормаа
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, ахмад
Эрдэм шинжилгээний удирдагч: Ц.Ганболд 142
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн судлаач, доктор, профессор.
Bolormaa.J
Researcher, Institute of Border Security, Joint Research Institute of Internal Affairs University, captain
Ganbold.Ts
Researcher, Institute of Border Security, Joint Research Institute of Internal Affairs University, Doctor, professor

ГАЗАР, ГАЗРЫН ХЭВЛИЙН ХИЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ЗАРИМ АСУУДАЛ

UNDERSTANDING OF THE LAND, SUBSOIL BORDER ON THE LAW ON STATE BORDER

Б.Амармэнд
Дотоод хэргийн их сургуулийн эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн хил судлалын ухааны докторант
Эрдэм шинжилгээний удирдагч: Ц.Ганболд
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн судлаач, доктор, профессор, хурандаа 153
Amarmend.B
Ph.D candidate, Institute for Border Security Studies, The Joined Research Institute, University of Internal Affairs
Ganbold.Ts
Researcher, Institute for Border Security Studies, The Joint Research Institute, UIA Ph.D, Professor, Colonel

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ
COURT DESICION EXECUTION STUDIES

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ИРГЭДИЙН ТӨСӨӨЛӨЛ

CIVILIAN PRESPECTIVE ON THE ACTIVITIES OF THE ORGANIZATION RESPONSIBLE FOR THE EXECUTION OF COURT DECISIONS

Б.Алтангэрэл
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрхлэгч, хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор, хурандаа 173
Altangerel.B
Head of the Center for decision execution studies, University of Internal Affers, doctor of law (Ph.D) professor, colonel

ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ АЛБАДАН СУРГАЛТЫН ҮР НӨЛӨӨНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ / Судалгааны тайлангаас/

ANALYSIS ON THE EFFECTS OF BEHAVIOR INFLUENCING COMPULSORY COURSES /From the research report/

А.Жаргалзаяа 180
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, ахмад
Jargalzaya.A
Captain, Researcher, Center of Court Decision Enforcement Studies, Integrated Research Institute, University of Internal Affairs

ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ХОРИГДЛЫН ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

ПРЕДУПРЕЖДЕНИЕ ОТ СОВЕРШЕНИЕ ПРЕСТУПЛЕНИЯ ЛИЦ, ОТБЫВАЮЩИХ НАКАЗАНИЕ ЛИШЕНИЯ СВОБОДЫ 188

Ч.Батболд
Дотоод хэргийн их сургуулийн докторант, хошууч
Ч.Батболд
Докторант, университета внутренних дел Монголии, майор

ПРОБАЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОЙЛГОЛТ, ОНЦЛОГ

UNDERSTANDING AND FEATURES OF PROBATION ACTIVITIES

Д.Буяннэмэх 198
Дотоод хэргийн их сургуулийн докторант, ахмад
D.Buyannemekh
Captain Ph.D Student, University of Internal Affairs

ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ АЛБАДАН СУРГАЛТЫН ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES TO IMPROVE THE EFFECT OFCOMPULSIVE TRAINING ON BEHAVIOR

Г.Балжмаа 207
Дотоод хэргийн их сургуулийн Гэмт явдал судлал-Эрх зүйн ангийн докторант, ахлах дэслэгч
Baljmaa.G
Senior lieutenant, University of Internal Affairs Doctoral student, in the Department of Grime Studies-Law

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ СУДЛАЛ
FORENSIC STUDIES

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ НЭР ТОМЪЁОНЫ ОНОЛ, ПРАКТИКИЙН АЧ ХОЛБОГДОЛ

THEORETICAL AND PRACTICAL VALUE OF THE CONCEPTUAL AND TERMINOLOGICAL OF FORENSIC EXAMINATION

З.Сүлд 219
Шинжлэн магадлахуй судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан- багш, хууль зүйн докторант, цагдаагийн хошууч
Z.Suld
Senior researcher-teacher of Forensic Science center, law science doctoral, Police major

ХЭТ ЯГААН ТУЯАНД СУУРИЛСАН АРГА, ХЭРЭГСЛИЙГ ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГТ АШИГЛАЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

CURRENT STATUS OF USING UV-BASED METHODS AND INSTRUMENTS FOR CRIME SCENE INSPECTION

Г.Ганхүлэг 227
Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Нийслэлийн шүүхийн шинжилгээний газрын ахлах шинжээч, цагдаагийн хошууч
Gankhuleg G.
Police Major, Senior expert, Capital Forensic Science Department, National Institute of Forensic Science, doctoral candidate, University of Internal Affairs

ГАМШИГ СУДЛАЛ
DISASTER STUDIES

ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ АВРАГЧ-ХИМИЧНИЙ ОСЛЫН ГОЛОМТОД ҮҮРЭГ ГҮЙЦЭТЭХ ЧАДВАХИ, ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

MISSION, ABILITY AND CHALLENGES OF EMERGENCY SERVICE RESCUER-CHEMIST IN CENTER OF ACCIDENT

241

Б.Ганзагас
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Гамшиг судлалын төвийн эрдэм шинжилгээ, туршилт судалгааны ажилтан-багш, дэслэгч
Ganzagas.B
Lieutenant, Researcher, Disaster Risk Studies Center, Integrated Scientific Research Innstitute, University of Internal Affairs

ХУУЛЬ САХИУЛАХУЙН БОЛОВСРОЛ СУДЛАЛ
LAW ENFORCEMENT EDUCATION STUDIES

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫГ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН АГУУЛГА ДАХЬ ОНОЛ, ПРАКТИКИЙН ХАРЬЦАА

THEORETICAL AND PRACTICAL RELATIONSHIP IN THE CONTENT OF TRAINING FOR POLICE OFFICERS

246

Э.Дашгаадан
Дотоод хэргийн их сургуулийн докторант, цагдаагийн ахлах дэслэгч
Dashgaadan.E
Police Senior Lieutenant, Ph.D student, University of Internal Affairs, Mongolia

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ
LAW AND LEGAL ISSUES

ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ОНЦЛОГ

LAW ON THE LEGAL STATUS OF FOREIGN CITIZENS FEATURES OF ADDITIONS AND CHANGES

257

Д.Мөрөн
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Аюулгүй байдал судлалын төвийн эрхлэгч, Монгол Улсын гавьяат хуульч, профессор, докторант, цагдаагийн хурандаа
Muren.D
Honored Lawyer of Mongolia, Professor, Ph.D Student, Police Colonel, Head of the Security Research Center of the Scientific Institute of the University of Internal Affairs

МӨРДӨГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА /МОНГОЛ, ОХУ/

СРАВНИТЕЛЬНЫЙ АНАЛИЗ ПРАВОГО СТАТУСОВ /МОНГОЛИЯ, РФ/

263

Н.Сайнбаяр
ДХИС-ийн докторант, цагдаагийн ахмад
Сайнбаяр.Н
Адъюнктура Университета внутренных дел Монголии, капитан полиции

ШИНЭ БОЛОН НЭН ШИНЭ ҮЕИЙН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ГЭМТ ХЭРГИЙГ ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААГ ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ

REGULATION OF THE STATUTE OF LIMITATION IN THE MODERN AND POST-MODERN CRIMINAL CODES OF MONGOLIA

269

Г.Халиунаа
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан, Дотоод хэргийн их сургуулийн докторант
Khaliunaa.G
Senior Researcher, The National Legal Institute of Mongolia, Ph.D. Candidate, The University of Internal Affairs

ЭРДЭМТЭН, СУДЛААЧДЫН ҮЗЭЛ БОДОЛ
POINTS OF VIEWS OF SCIENTISTS AND RESEARCHERS

ШҮҮХ ЭРХ МЭДЭЛ БА ШҮҮХИЙН ЭРХ ЗҮЙ

JUDICIAL JURISDICTION AND JUDICIAL LAW

Б.Өлзийсайхан 288
Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Билиг дээд сургуулийн захирал, хууль зүйн доктор, дэд профессор
Ulziisaikhan.B
Director, The Bilig Institute, University of the Humanities, Doctor of law, Associate Professor

МОДЕЛИ УГОЛОВНО-ПРОЦЕССУАЛЬНОЙ МЕДИАЦИИ: ТЕОРЕТИЧЕСКИЙ АСПЕКТ

MODELS OF CRIMINAL PROCEDURAL MEDIATION: THEORETICAL ASPECT

Градский Владимир Евгеньевич, 308
преподаватель кафедры гражданско-правовых дисциплинФедерального государственного казенного образовательного учреждения высшего образования «Уральский юридический институт Министерства внутренних дел Российской Федерации» (ФГКОУ ВО УрЮИ МВД России) лейтенант полиции

Gradsky Vladimir Evgenievich,
Lecturer of department of civil law disciplines, Ural Law Institute of the Ministry of Internal Affairs of Russia

МОНГОЛ УЛСЫН ДОТООД АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САХИУЛАХАД УУЛ УУРХАЙ, АШИГТ МАЛТМАЛ, ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НӨЛӨӨЛӨЛ

THE IMPACTS OF MINING NATURAL RESOURCES ON MONGOLIAN INTERNAL SECURITY

Ж.Өвгөнбүргэд
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Аюулгүй байдал судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор, дэд профессор, хурандаа
Uvgunburged.J
Colonel, Associate professor, doctor (PhD.), senior researcher of Security Study center, Integrated Research institute, the University of Internal Affairs

Хураангуй: Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг сахиулахад улс, орны дотоод аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйл болох уул уурхайн, ашигт малтмал, олборлолтын үйл ажиллагааны асуудал бөгөөд түүний эрх зүйн орчны хэрэгжилт, хил орчмын бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын өнөөгийн байдал нь хилийн аюулгүй байдлыг сахиулахад сөргөөр нөлөөлж буйг авч үзсэн бөгөөд түүнээс сэргийлэх арга замын талаар санал, зөвлөмж, дүгнэлтийг дэвшүүлсэн.

Abstract: One of the big issue for maintaining Mongolian border security is mineral industry and mining of natural resources impacts on nation's internal security. The paper is focused on the negative impacts of current status of business entities operating near the border areas, its legal environment on our internal security as well as some suggestions and recommendations are made in conclusion to prevent the problem.

Түлхүүр үг: Хилийн аюулгүй байдал, дотоод аюулгүй байдал, уул уурхай, ашигт малтмалын олборлолт, улсын тусгай хамгаалалттай газар, хил орчмын бүс нутаг.

Keywords: Border security, internal security, mining, mining of natural resources, protected area, border area

Улс, үндэстний аюулгүй байдлыг хангахад тухайн улс дотооддоо аюулгүй байх явдал тэргүүн зэргийн ач холбогдолтой. Монгол Улс хүн ам цөөн, газар нутаг өргөн уудам, байгалийн баялаг ихтэй нь бусад улс, гүрнүүдийн ашиг сонирхлыг ихээр татаж, улмаар ашигт малтмал, олборлолт, хил орчмын бүс нутгийн лиценз эзэмших үйл ажиллагаа нь манай улсын дотоод аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхүйц хэмжээнд хүрч байгааг төр засгийн удирдлага, орон нутгийн иргэд, төрийн бус байгууллагууд онцгойлон анхаарах цаг үетэй цуг бид амьдарч байна. Дэлхий дахин даяаршиж, глобалчлагдаж буй өнөөдрийн нийгэмд жижиг, буурай манай орны хувьд аюулгүй байдлын асуудал олон хэлбэрээр

үүсэж байгаагийн нэг нь уул уурхайн ашиглалт, олборлолтын асуудал болж байна. Тодруулбал эдийн засгийн өндөр хөгжилтэй улс, гүрнээс хөгжиж буй орнуудад улс төр, эдийн засгийн бодлогоо хэрэгжүүлэхдээ өөрсдийн ашиг сонирхлыг тулгадаг, суулгадаг технологийг шинэ агуулга, хэлбэрээр хэрэгжүүлж байгаа нь тухайн улсын дотоод аюулгүй байдал, нийгмийн сэтгэл зүйд нөлөөлж, тогтворгүй байдал бий болгох, хууль, эрх зүйн орчныг өөрт ашигтайгаар шийдвэрлүүлэх, улс төрчдийг өөрийн талд урвуулах замаар уул уурхайн лицензийг олноор эзэмшиж байгаагийн жишээ нь манай улсын томоохон ордууд болох Оюу толгой, Хармагтайн орд, Цагаан суварга, Төмөртэйн овоо, Нарийн сухайт, Бороогийн ордын ашиглалт, эзэмшилтийн байдлаас харж болно.

Өнөөдөр Монгол Улсын нийт гадаад өр 32,8 тэрбум ам.доллар болж, өмнөх улирлынхаас 300 сая ам долларoор нэмэгдсэн байна. Засгийн газрын гадаад өр 655 сая ам.долларoор нэмэгдэхэд ОУВС, БНХАУ-аас авсан хөнгөлөлттэй зээл 391 сая ам. доллар, гадаад зах зээл дээр арилжсан Засгийн газрын бондын зах зээлийн үнэлгээ 260 сая ам.долларoор нэмэгдсэн нь тус тус нөлөөлсөн байна. Харин Худалдаа хөгжлийн банкны бондын өр төлөгдсөнөөр банкны салбарын гадаад өр хоёрдугаар улиралд 510 сая ам.долларoор буурсан байна[1].

График 1. Монгол Улсын нийт өр төлбөр



[1] А.Энхжин. Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал. Монгол Улсын гадаад өрийн нөхцөл байдал. УБ., 2019 он.

Манай өвөг дээдэс “тос дотроосоо өтөх нь аюултай” гэж дотоод аюулгүй байдлын мөн чанарыг зүйрлэн хэлсэн нь уул уурхай, ашигт малтмал, олборлолтын үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатай нь харагдаж байгаа бөгөөд энэ янзаараа 20-30 жил болоход манай улс цөлжилтөд нэрвэгдсэн, цэвэр усны нөөцгүй болсон, ард иргэд нь баян ядуугийн хоёр ангилалд хуваагдсан, хүчирхэг улсын нөлөөнд орсон, улмаар газар нутгийнхаа нэг хэсгийг өр төлбөрт өгөх хүртлээ дампуурч болзошгүй дүр зураг харагдаж байна. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлийг эх сурвалжаар нь дотоод, гадаад гэж ангилаад үндэсний аюулгүй байдлын системийн 9 бүрэлдэхүүн хэсэгт сөрөг нөлөөлөх 84 хүчин зүйлийг тодорхойлсноос 55 нь буюу 65,5 хувь нь дотоодоос нөлөөлөх хүчин зүйл гарч байсан. Дотоод аюулгүй байдлыг хангах систем нь нийгмийн систем тул өөрөө аяндаа цэгцрэх синергетик зүй тогтолтой боловч, өнөөгийн нээлттэй нийгэм, аюулгүй байдлын хурдан хувьсамтгай орчинд төрийн оновчтой удирдлага, зохицуулалтыг шаардаж байна[2].

Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл, мэдээллийн төлөвшлийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн[3]. Хилийн аюулгүй байдлыг улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсаныг хэлнэ[4] гэж тус тус эрх зүйн байдалдаа тусгасан бөгөөд өнөөдөр тус салбарт 30 орчим хууль, 40 гаруй журам, дүрэм үйлчилж байна[5]. Монгол Улсын нийт газар нутгийн 27.9 сая га буюу 102 бүхий газрыг тусгай хамгаалалттай газарт хамруулж байгаа бөгөөд энэ нь нийт газар нутгийн 17.8 хэсгийг эзэлж байна. Цаашид 2030 он гэхэд нийт нутаг дэвсгэрийн 30 хувьд хүргэх төлөвлөгөөтэй ажиллаж байгааг мэргэжлийн байгууллага тодорхойлж байна[6]. Улсын тусгай хэрэгцээний газарт улсын хилийн зурвас газар хамаарна.

[2] О.Үржин. Цэргийн ухааны доктор /Sc.D/, профессор, хошууч генерал
[3] Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.3.3.Дотоод аюулгүй байдал. УБ., 2010 он.
[4] Хилийн тухай хууль. УБ. 1993 он.
[5] Монгол Улсын уул уурхайн салбарын авилгын эрсдэлийн үнэлгээ: УБ., 2016 он.
[6] Т.Болдбаатар. БОАЖ-ны мэргэжилтэн. Цагийн хүрд нэвтрүүлэг. 2019 он.

Зураг 1.Хилийн зурвас дахь ашигт малтмал, олборлолтын талбай



Хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдалд харшлах, байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй байна[7] гэж хуулиндаа тодорхой заасан боловч, тусгай зөвшөөрөлтэй байгууллагын тоо нэмэгдэж, үйл ажиллагаагаа явуулсаар байна. 2020 оны байдлаар улсын тусгай хэрэгцээний газрын нийт хэмжээ 26060.7 мянган га талбай буюу улсын нийт нутаг дэвсгэрийн 16.66 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оныхоос 0.53 хувиар өссөн байна. Үүнд улсын тусгай хамгаалалттай газар 21927.0 мянган га буюу 86.87 хувийг, улсын хилийн зурвас газар 3110.34 мянган га буюу 12.32 хувийг, улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар 124.1 мянган га буюу 0.49 хувийг, гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар 0.04 мянган га буюу 0.0001 хувийг, шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай 36.13 мянган га буюу 0.14 хувийг, аймаг дундын отрын бэлчээр 691.41 мянган га буюу 2.74 хувийг, улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай 110.94 мянган га буюу 0.44 хувийг, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай 24.47 мянган га буюу 0.1 хувийг, чөлөөт бүсийн газар 2.11 мянган га буюу 0.01 хувийг, үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар 34.2 мянган га буюу

[7] Газрын тухай хууль. УБ. 2002 он.

0.14 хувийг, аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар 0.02 мянган га буюу 0.0001 хувийг тус тус эзэлж байна[8].

График 2. Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо[9]



Монгол Улс хуулиндаа ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон газрыг тусгай хэрэгцээний газарт тооцно[10] гэж тусгасан боловч тэрхүү тусгай хэрэгцээний 13 газарт хилийн бүс, зурвас, боомтын бүс орж байгаа боловч өнөөдрийн байдлаар 195 аж ахуйн нэгж, хилийн хориотой зурваст байрлаж, үйл ажиллагаагаа явуулж байна.

График 3. Хилийн отрядын хариуцсан хэсэгт байрлах аж ахуйн нэгж[11]



[8] Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар. УБ., 2021 он
[9] Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага төслийн тайлан., УБ., 2016 он
[10] Ашигт малтмалын тухай хууль. УБ. 2006 он.
[11] ХХЕГ-ын Хилийн алба, төлөөлөгчийн газрын хилийн албаны хэлтсийн судалгаа. УБ., 2019 он

Дээрх аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь Монгол Улсын дотоодод үзүүлэх аюулын хэлбэр нь дараах байдлаар илэрч байна. Үүнд:

- ашигт малтмалын үйл ажиллагаа нь улсын хилийн шугам руу улам ойртож, тэсэрч,

дэлбэлэх бодис ихээр ашиглаж байгаа нь холбогдох хуулиудыг зөрчиж, улмаар газрын хэвлийн хилийн асуудал хөндөгдөхөд хүргэж байна;

- хилийн хориотой зурваст зорчигч, тээврийн хэрэгслийн тоо олширсноор хил орчмын

дэглэмийг сахиулах хил залгаа улсын гэрээ хэлэлцээр, хилийн хуулийг зөрчиж байна;

- хил орчмын бүс нутагт ашигт малтмал, олборлолтын үйл ажиллагааг явуулахдаа

гүний цэвэр усыг ихээр ашиглаж байгаа нь хилийн гол, горхи, нуурын усны төвшин ихээр багасаж, улмаар ундарга нь шавхагдаж хүн, мал амьдрах боломжгүй болсноор хил орчмын орон нутаг дэвсгэр эзгүйрч байна;

- хил орчмын бүс нутагт ашигт малтмал, олборлох болон лицензтэй талбай ихээр нэмэгдсэнээр Монгол Улсын хил хамгаалалтыг зохион байгуулж удирдах, түүний албаны бэлэн байдалд сөргөөр нөлөөлөх болсон. Монгол Улсын хэмжээнд сүүлийн 5 жилд хилийн хориотой зурваст ашигт малтмал олборлох, ашиглахтай холбоотой зөрчил 6 удаа, хил орчмын дэглэмийн зөрчил түүн дотроо хилийн зурваст 44 удаа, бүсэд 48 удаа тус тус үйлдэгдсэн[12] байна.

Монгол Улсын хэмжээнд 2019 оны байдлаар ашигт малтмал, газрын кадастрын бүртгэлд 3580 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүртгэлтэй байгаагаас ашиглалтын тусгай зөвшөөрөлд нүүрсний 316, алтны 551, зэсийн 20, алт зэсийн 14, ураны 14, жоншны 181 лицензийн зөвшөөрөл олгогдсон байна. Хилийн аймгуудаар авч үзвэл хамгийн их нь Өмнөговь аймагт нийт 208 лиценз олгогдсоноос ашиглалтын 101 байгаа бол, Говь-Алтай, Баянхонгор аймагт 163, Хэнтий аймагт 246 байгаагаас ашиглалтын 116 лиценз байгаа бөгөөд бүгд ашиглалтын, бусад аймгуудад 20 - 200 уул уурхайн лицензийн зөвшөөрөл олгогдсон байна. Монгол Улсад нийт 3074 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 1514 нь дотоодын иргэд байгаа бол, 1560 нь гадаадын иргэд байна. Эдгээрийг эзэмшиж байгаа улсаар гаргаж үзвэл, БНХАУ - 172, Виржиний арлууд - 80, Сингапур - 64, Хонконг, Канад, Өмнөд Солонгос улсууд 16 - 30 тусгай зөвшөөрлийг эзэмшиж байна. Эдгээр тусгай зөвшөөрлийн 10-аас дээш лиценз эзэмшигч компианыг дурдвал, Чингис ворлд майнг - 49, Монгол росцветмет - 30, Монголын алт - 23,

[12] Хил хамгаалах байгууллагын Хилийн алба, төлөөлөгчийн газрын дүн бүртгэлийн мэдээ. УБ. 2018 он

Алтан дорнод - 17, Гацуурт - 17, Чайна инвестмент монголия - 15, Олон овоот гоулд - 14, Эрэл - 11, Моэнко - 10 тус тус эзэмшиж байна[13].

График 4. Хилийн аймгуудын лицензтэй талбай



Монгол Улсын хил орчмын бүс нутагт ашигт малтмал, олборлолтын ажиллагааг зохистой ашиглах төрийн бодлого нь хязгаар нутгийг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх боловч, замбараагүй олгогдсон тусгай зөвшөөрөл нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, нутаг дэвсгэрийн халдашгүй, бүрэн бүтэн байдал, оршин тогтнохын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх гол хүчин зүйл болж байна. Дэлхий нийтээрээ даяаршиж буй өнөөгийн нийгэмд “дотоод аюул” ихээхэн аюул, заналыг учруулж байгааг бид хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олонтоо сонсож, мөн хөгжиж буй улсад өрнөж буй үйл явцаас тодорхой харж байна. Азийн сангаас эрхлэн гаргадаг авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгааны дүнгээр Монгол Улсын уул уурхай, ашигт малтмал эзэмших ажиллагаа авлигад хамгийн их автсан байгууллагын жагсаалтад 2007 - 2014 оны хооронд хоёрдугаар байранд жагсжээ. Харин 2015 оны 4 дүгээр сард бага зэрэг буурч гуравдугаар байранд орсон байна[14] АНУ-ын Азийн сан нь бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдлын судалгааг 2012 оноос хойш жил бүр хийж эхэлснээс хойш авлигад хамгийн өртөмтгий салбарт орсон[15].

Монгол Улсын авлигатай тэмцэх газар нь 9 төрлийн гэмт хэрэгт хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт явуулдаг бөгөөд тус байгууллагын судалгаагаар сүүлийн 4 жилийн хугацаанд төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл, албан тушаалаа урвуулсан 236, хээл хахууль авсан

[13] Ашигт малтмал олборлолтын газрын мэдээлэл. 2019 он
[14] http://www.santmaral.mn/sites/default/files/SPEAK16thSurveyMNG.pdf
[15] https://asiafoundation.org/resources/pdfs/STOPPreportmongolian.pdf

268, албан тушаал, эрх мэдлээ хэтрүүлсэн 264 гэсэн 3 зүйлээр хамгийн түгээмэл үйлдэгдсэн гэмт хэрэгт орсон байна. Монгол Улсын хил орчмын бүс нутагт уул уурхай, ашигт малтмал, олборлолтын ажиллагаа ихээр явуулж байгаа нь манай улсын дотоод аюулгүй байдалд шууд нөлөөлөх нийгмийн, экологийн, улсын хил хамгаалалтын гэсэн 3 нөлөөллийн талаар товчлон дараах байдлаар авч үзэв. Үүнд:

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ:

- байгалийн баялаг ихтэй хил орчмын бүс нутагт гадаадын хөрөнгө оруулалттай

үйлдвэрүүд олноор байгуулагдсанаар хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах ажиллагаанд хүндрэл үүсгэх болсон;

- хууль сахиулах байгууллагуудын ажлын уялдаа, хамтын ажиллагаа хангалтгүйгээс

улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт гэмт хэрэг, хилийн зөрчил ихсэж, зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн үйл ажиллагаа идэвхжих хандлагатай болсон;

- хил орчмын бүс нутагт явуулах эдийн засгийн чөлөөт бүсийн хамгаалалтын

бодомж, түүний арга тактик, эрх зүйн үндэс нь холбогдох хууль, дүрэм, зааварт тусгагдаагүй байгаа нь асуудал үүсгэж болзошгүй;

- орон нутгийн удирдлага хил орчмын бүс нутгийг гадаадын иргэд, аж ахуйн нэгжид

түрээслэх, ашигт малтмал олборлоход давуу эрх олгож, хувийн ашиг сонирхол, авлигад өртөж байгаа нь иргэдийн төрд итгэх илтгэлийг бууруулж байна.

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ:

- хил орчмын бүс нутагт эрэл хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулахдаа их

хэмжээгээр химийн бодис ашиглаж байгаа нь байгальд сөргөөр нөлөөлж, улмаар орон нутгийн иргэд, малчдын бэлчээрийн талбайг хомстуулж, хордуулж байна;

- ашигт малтмал олборлох, боловсруулах ажиллагаанд гүний усыг ихээр ашиглаж

байгаагаас хил орчмын нутаг дэвсгэрт ундны усны хомсдол үүсгэх, хүн, мал, амьтан усаар гачигдах нөхцөлийг бүрдүүлж байна;

- хилийн бүс, зурваст хайгуул, ашиглалт, олборлолтын лицензийг ихээр олгож

байгаагаас орон нутгийн малчдын оторлон нүүдэллэх талбай хумигдсанаар нутгийн гүн рүү нүүдэллэх хөдөлгөөн нэмэгдэж, хилийн бүс нутаг эзэнгүйдэх хандлага ажиглагдаж байна;

- уул уурхайн олборлох, тээвэрлэх үйл ажиллагаа нь газрын гадаргууг ихээр сүйтгэж, улмаар голын гидрологи, горим алдагдуулах, хөрсний бохирдол үүсгэх, экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулах, байгалийн ландшафтад эвдрэл гарах зэрэг олон таагүй нөлөөллийг үүсгэж байна. Өнөөдрийн байдлаар уул уурхай, ашигт малтмал, олборлолтын үйл ажиллагаанаас хамаарч, Монгол Улс газрын гадаргын усны нөөцийн 28 хувь нь ширгэж, ойн сангийн 42 хувь нь устсан гэсэн тоо баримт гарсан. 2017 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд 344 гол, горхи, 760 булаг шанд ширгэж, усны ундаргын төвшин багассан бөгөөд "усны төрийн нэгдсэн бодлого" үгүйлэгдэж байна[16] гэж дүгнэсэн.

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ:

- хилийн хориотой зурваст уул уурхай, ашигт малтмал, олборлолтын үйл ажиллагаа

явуулж байгаагаас зарим хэсэгт хилийн манааны явах замнал өөрчлөгдөх, хилийн эрэл зохиох байгуулах, газар оронд үзлэг шалгалт хийхэд тухайн газар орныг тойрох, цаг хугацаа алдах, тактикийн алдаа гаргах зэрэг албаны бэлэн байдалд хүндрэл учруулах болсон;

- улсын хил дээр үйлдэгдэж буй хилийн зөрчил нь зохион байгуулалтын хэлбэрт

шилжиж, түүний хэрэглэж буй арга, тактик нь улам нарийсч, ашиглаж буй техник хэрэгсэл нь орчин үеийн өндөр хүчин чадалтай болсноор гаргаж буй хууль бус үйлдэл нь хил залгаа улстай байгуулсан хилийн харилцаанд таагүй нөлөө үзүүлэх болсон;

- хар тамхи, мансууруулах бодис, хүний болон галт зэвсгийн наймаа, татвараас

зайлсхийсэн үнэт, ховор чулуу, түүх, соёлын өвийн хулгай зэрэг зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн хууль бус ажиллагаа нь хилийн аюулгүй байдлыг сахиулахад сөргөөр нөлөөлөх болсон;

- төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагчдын нийгмийн баталгаа алдагдаж, авилга, хээл хахуульд автах болсон нь хилийн аюулгүй байдлыг сахиулахад хүндрэл үүсгэж байна. Жишээлбэл Эрдэнэс Таван толгой компаний 2013 - 2017 оны хооронд гаргасан нүүрс тээвэрлэлтийн мэдээнд Гаалийн ерөнхий газраас 390 тонн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 340 тонн нүүрс улсын хилээр нэвтэрсэн гэж үзсэн бол, Хил хамгаалах ерөнхий газраас 849 мянган машин, Гаалийн ерөнхий газраас 814 мянган машин хил нэвтэрсэн гэсэн зөрүүтэй тоо гарч, дундаас нь 15000 машин нүүрс хаачсаныг мэдэхгүй байгаагаас харж болно. Монгол Улс зах зээлийн чөлөөт эдийн засагт шилжсэн үеэс гадаадын хөрөнгө оруулагчид уул уурхайн салбарт 2010 - 2020 оны

[16] Цагийн хүрд мэдээллийн хөтөлбөр. 2018 оны 9 дүгээр сарын 27ны нэвтрүүлэг.

хооронд 27 тэрбум ам. доллар оруулсан бөгөөд нийт уул уурхайн салбарын 70 хувийг бүрдүүлсэн[17] бөгөөд эдгээр нь Монгол Улсыг хөгжүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн боловч, эсрэгээрээ байгаль орчныг доройтуулах, цэвэр усны хомстолд оруулах, хил орчмын иргэд төв рүү нүүдэллэх болсон шалтгаанууд нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдалд дараах сөрөг нөлөөллийг бий болгож байгаа тул дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

1. Монгол Улсын хил орчмын нутаг дэвсгэрт хүн ам сийрэг, дэд бүтэц хөгжөөгүй, төвөөс алслагдсан зэргээс объектив шинжтэй аюул, занал үүсэх магадлал өндөр байгааг харгалзан төр, засгийн бодлогын түвшинд хил орчмын газрыг хөгжүүлэх, авто болон төмөр зам, дэд бүтэц, эрчим хүчний эх үүсгэврийг тавих нь нэн тэргүүний асуудал болж байна.

2. Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр, хилийн тухай хуулийн хэрэгжилтэд төрийн захиргааны төв байгууллагуудаас тавих хяналт, хамтын ажиллагаа уялдахгүй байх, нөгөө талаар гурван улсыг холбосон “нэг бүс - нэг зам”-ын транзит тээврийг хөгжүүлж буй өнөө нөхцөлд хилийн аюулгүй байдлын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хил залгаа улстай байгуулсан хилийн гэрээ, хэлэлцээрүүдийг шинэчлэх, тодотгох хэрэгцээ, шаардлага үүсэж байна.

3. Хилийн аюулгүй байдлыг сахиулахад дотоодоос үүсгэж буй ашигт малтмал, олборлолтын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг газрын тухай болон ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх нь зүйтэй.

4. Хилийн зурвас буюу тусгай хэрэгцээтэй газарт ашигт малтмал, олборлолтын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллагаас олгохгүй байх нь зүйтэй бөгөөд холбогдох эрх зүйн байдалд өөрчлөлт оруулах, хил залгаа улстай байгуулсан хилийн болон хил орчмын дэглэмийн гэрээ, хэлэлцээрт тодотгол оруулах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна.

[17] Цагийн хүрд мэдээллийн хөтөлбөр. 2020 оны 04 дүгээр сарын 16 ны нэвтрүүлэг.

Ашигласан эх сурвалж

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010 он.
2. Төрөөс хилийн талаар баримтлах бодлого. УБ. 2002 он.
3. Хилийн тухай хууль. УБ. 1993 он.
4. Ашигт малтмалын тухай хууль. УБ. 2019 он.
5. Газрын тухай хууль. УБ. 2002 он.
6. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага төслийн тайлан.
7. Хилийн бүс, зурваст үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, компианийн мэдээлэл. УБ. 2018 он. ХХЕГ
8. Монгол Улсын уул уурхайн салбарын авилгын эрсдлийн үнэлгээ: УБ., 2016 он.
9. Ш.Арвай, А.Муратхан, Д.Нямдорж, Н.Наранжамц. Улсын хил судлал: онол, практикийн зарим асуудал. УБ. 2016 он.
10. О.Үржин. Цэргийн ухааны доктор /Sc.D/, профессор, хошууч генерал
11. Б.Уламбаяр. Хилийн бүсэд явагдаж буй ажил үйлдвэрлэл хилийн аюулгүй байдалд нөлөөлөх нь. УБ. 2015 он. Магистрын ажил
12. А.Энхжин. Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал. Монгол Улсын гадаад өрийн нөхцөл байдал. УБ., 2019 он.
13. Т.Болдбаатар. БОАЯЖ-ны мэргэжилтэн. Цагийн хүрд нэвтрүүлэг. 2019 он.
14. Хил хамгаалах байгууллагын Хилийн алба, төлөөлөгчийн газрын дүн бүртгэлийн мэдээ. УБ. 2018 он
15. http://www.santmaral.mn/sites/default/files/SPEAK16thSurveyMNG.pdf
16. https://asiafoundation.org/resources/pdfs/STOPPreportmongolian.pdf
17. Цагийн хүрд мэдээллийн хөтөлбөр. 2018 оны 9 дүгээр сарын 27ны нэвтрүүлэг.
18. Цагийн хүрд мэдээллийн хөтөлбөр. 2020 оны 04 дүгээр сарын 16 ны нэвтрүүлэг.

ҮР ТАРИАНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ОРЛОГЫН ХЭЛБЭЛЗЭЛ

INCOME FLUCTUATIONS OF GRAIN INDUSTRIAL ENTREPRENEURIAL

Б.Юмаажав
Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн багш, мэргэшсэн нягтлан бодогч, Магистр, дэслэгч
Д.Энхчимэг
Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн багш, доктор /Ph.D/
Yumaajav.B
University of Internal Affairs, lecturer, Master, CPA,
Enkhchimeg.D
National Defense university, Institute of security lecturer, doctor and associate professor, department of economics and management, Mongolia

Хураангуй: Монгол Улсын хүнсний үйлдвэрлэлийн нэг томоохон хэсгийг хөдөө аж ахуйн үйлдвэрлэл бүрдүүлдэг. Энэ салбар нь 2009 оныг хүртэл дотоодын нийт бүтээгдэхүүний 20 орчим хувийг бүрдүүлж байсан бол 2009 оноос хойш уул уурхайн хөрөнгө оруулалтаас хамаарч нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь нь 10 хувь хүртлээ буурсан байна. Хөдөө аж ахуйн салбарын нийт бүтээгдэхүүний 10 хувийг газар тариалангийн үйлдвэрлэл, 90 хувийг мал аж ахуйн үйлдвэрлэл бүрдүүлж байна. Монголчуудын хүнсний хэрэглээний 12 хувийг мах, махан бүтээгдэхүүн, 18 хувийг гурил, гурилан бүтээгдэхүүн эзэлж байна.

Энэхүү судалгаа нь Монголчуудын хүнсний гол бүтээгдэхүүн болох гурилын үйлдвэрлэлийн түүхий эд улаанбуудайн үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, цаашдын хандлагыг тодорхойлох зорилготой.

Монгол Улсын улаанбуудайн үйлдвэрлэлээр тэргүүлэгч аймгийн улаанбуудайн үйлдвэрлэл эрхлэгчдийг судлах явцад энэ салбарт маш олон байгууллага дампуурсан, сураггүй болсон, тайлан өгөөгүй байгаа зэрэг нь энэ үйлдвэрлэл эрсдэл ихтэй болохыг илтгэж байна.

Энэ салбарт байгаль, цаг агаар, техник, технологийн нөхцөл, хөрсний доройтол зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг бөгөөд манай улсын хувьд бизнес эрхлэгчийн хөрөнгө, орлогын хэмжээ хамгийн өндөр хэмжээнд нөлөөлдөг гэж таамаглал дэвшүүлэн судалгааг явуулсан. Nigel Key, Daniel Prager, and Christopher Burns нар “Farm Household Income Volatility: An Analysis Using Panel Data From a National Survey”[1] бүтээлдээ орлогын хэлбэлзлийг 3 аргаар тодорхойлсон байна. Эдгээр эрдэмтдийн орлогын хэлбэлзлийг тодорхойлох арга зүйг судалгаандаа ашигласан.

[1] - www.ers.usda.gov/publications/

Энэхүү ажлын шинэлэг тал нь бизнесийн нэгжийн хэмжээ нь орлогын хэлбэлзэлд хамааралтай эсэхийг тодорхойлсонд оршиж байгаа юм.

Энэхүү судалгааны үр дүнд бичил, жижиг бизнес эрхлэгчдийн орлого хэлбэлзэл өндөр, харин дунд болон том бизнес эрхлэгчдийн орлогын хэлбэлзэл бага байгааг тодорхойлсон. Иймд бизнес эрхлэгчдийн орлогын тогтвортой байдлыг хангахын тулд хөрөнгөжүүлэх, томруулах бодлого баримтлах нь чухал гэсэн дүгнэлтэд хүрсэн.

Abstract: 10 percent of the agricultural sector is made up of farming and 90 percent is made up of the livestock industry. Meat and meat products account for 12 percent of Mongolia's food consumption, and flour and bakery products for 18 percent. This research aims to determine the current situation and perspective of the wheat industry, the main raw material of flour products, the main food of Mongolians. The size of the organization has a significant impact on the income volatility of wheat producers. Therefore, in order to ensure the income stability of businesses, the government needs to take measures such as capitalization, diversification of income from the implementation of crop rotation technologies, and the establishment of a joint technology park.

Түлхүүр үгс: Орлогын хэлбэлзэл, бизнесийн байгууллагын хэмжээ, газар тариалангийн үйлдвэрлэл

Keywords: Income fluctuations, Standard deviation, income stability of businesses, crop

Оршил

Миний бие “Үр тарианы бизнес эрхлэгчдийн орлогын хэлбэлзлийг тодорхойлох нь” сэдвээр УБХИС-ийн Аюулгүй Байдлын Сургуулийн ЭЗМ-ийн тэнхимийн профессор, Ph.D Д.Энхчимэгийн хамт илтгэл бичиж Arda Virtual Conference Олон Улсын Байгууллагын зохион байгуулдаг “International Congress on Economy, Finance, and Business” хуралд 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдөр хэлэлцүүлсэн ба уг байгууллагаас impact factor, Scopus, web of science /сэтгүүлийн нэр, индексийг хавсралтаар харуулав/ бүхий сэтгүүлүүдийг санал болгодог бөгөөд ажлын сэдэвтэй тохирох сэтгүүлийг сонгон хүсэлтээ илгээсэн.

Хүсэлтийн дагуу 2021 оны 01 дугаар сарын 27-ны өдөр “INCOME FLUCTUATIONS OF GRAIN INDUSTRIAL ENTREPRENEURIAL” сэдвээр бэлтгэсэн нийт 7 хуудас өгүүллийг ISSN: 2305-7246, “International Journal of Modern Agriculture” сэтгүүлийн Volume 9, No.4, 2020 дугаарт (хуудас 659-666) хэвлэсэн мэдээг хүлээн авсан.

Энэхүү “Олон улсын орчин үеийн хөдөө аж ахуйн сэтгүүл (Int. J. Mod. Agric.)” сэтгүүл нь орчин үеийн хөдөө аж ахуй, ургамлын шинжлэх ухааны чиглэлээр өндөр чанартай судалгаа шинжилгээний ажлыг сурталчлах,

сурталчлах платформыг бий болгоход чиглэсэн, php индекстэй, шинжлэх ухааны зэрэглэл бүхий сэтгүүл юм. Ургамлын биотехнологи, химийн тойм зэрэг орчин үеийн шинэ парадигмуудыг нэвтрүүлснээр IJMA нь хөдөө аж ахуйн хувьслын талаар шинэ санаа, технологид анхаарлаа төвлөрүүлэх, судалгааны үр дүн, хэлэлцүүлгийг өндөр чанартай түгээх форум болно.

Бидний бүтээлийг http://modern-journals.com/index.php/ijma/article/view/403 линкээр дамжин уншиж сонирхож болно.

Монгол Улсын газар тариалангийн үйлдвэрлэлийн хөгжил

Монгол улсын газар тариалангийн салбар 1959 оноос хөгжиж эхэлсэн ба энэ үед атар газрыг эзэмшихээр “Атрын I”[2] аяныг эхлүүлж үр тариа, төмс хүнсний ногоо, малын тэжээл тариалж эхэлжээ. Энэ шийдвэрийн дүнд 300 мянган га атар газрыг тариалангийн зориулалтаар эзэмшиж, 295.5 мянган тонн үр тариаг авсан байдаг. Улмаар МАХН-ын Төв хорооны 1976 онд хуралдсан XI бүгд хурлаас Атрын II аяныг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд нэмж 230 мянган га атар газар эзэмшиж, техникийн баазыг бэхжүүлэхэд анхаарч ажилласан байдаг. Атрын III аяныг 2008 оноос хэрэгжүүлж атаршсан газрыг дахин эргэлтэд оруулан 2015 онд 515 мянган га, 2016 онд 505 мянган га, 2017 онд 524,3 мянган га талбайд тариалалт хийж байна.

График 1. Атрын аяны үр дүн, мян.га



Монгол Улс 1959 оноос өмнө газар тариалан эрхэлж байгаагүй ба социалист нийгмийн үед ОХУ-ын тусламжтайгаар энэ салбар хөгжиж 300 мянган га талбайд тариалалт хийж эхэлсэн бол 1989 он гэхэд нэмж атар газрыг эзэмшсээр хамгийн их буюу 673 мянган га талбайд тариалалт тарьж байв. Харин 1990 оноос зах зээлийн нийгэмд бэлтгэлгүй шилжснээр газар тариалангийн салбар уналтад орж улмаар 2007 онд хамгийн их талбайд тарьж байсан үеийнхтэй харьцуулахад 6 дахин бага газар буюу

[2] - 1959 оны 3 дугаар сард МАХН-ын Төв Хорооны III бүгд хурлаас “Атрын I” аяныг хэрэгжүүлэх тогтоолыг баталсан.

114,8 мянган га талбайд тариа тарьсан байна. Харин 2008 оноос уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын дахин хуваарилалтын ачаар Атрын III аяныг хэрэгжүүлж хамгийн өндөр тариалалтын 78%-тай тэнцэх хэмжээний атаршсан талбайг эргэлтэд оруулж чадсан байдаг. Харин дараахь тооцоололд гагийн ургацын хэмжээний өөрчлөлт, хамгийн их, хамгийн бага ургацын хэлбэлзэлийг харуулсан болно.

Хүснэгт 1. Атрын аян тус бүрийн үр дүн

	Нийт тариалсан талбай мян.га	Га-гийн ургац, хамгийн их	Га-гийн ургац, хамгийн бага	Га-гийн ургац, дундаж	Хэлбэлзлийн далайц
Атрын I	300	13.1	3.7	8.53	9.4
Атрын II	673	14.6	5.6	10.55	9
Атрын III	524.3	16.8	5.6	12.83	11.2

Атрын аян өрнүүлсэн үе тус бүрт гагаас авах хамгийн өндөр ургац ахицтай, мөн хамгийн бага ургацын хэмжээ өссөн, дундаж ургацын хэмжээ мөн сайн үзүүлэлт боловч хамгийн их хамгийн бага үзүүлэлтийн зөрүү нэмэгдсэн нь таагүй үзүүлэлт билээ.

График 2. Атрын аян тус бүрийн ургацын хэмжээ, цн-ээр



Цаашид Монгол Улсын Засгийн Газар Атрын IV аяныг 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Монгол улсын засгийн газрын 476-р тогтоолоор “АТАР-4 ТАРИАЛАНГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН АЯН”-ыг 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс орон даяар зарлан хэрэгжүүлэх тухай тогтоолыг гаргасан. Аяны хүрээнд хөрсний элэгдэл, эвдрэл, үржил шимийн доройтлыг сааруулах, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон газар тариаланг хөгжүүлэх, эрсдэл даах чадамжийг дээшлүүлэх, агроэкосистемийн тогтвортой байдлыг хангаж, хүнсний хэрэгцээ, түүний аюулгүй байдлыг бүрэн шийдвэрлэх юм.[3]

[3] - https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=gazar_tarialan_2019.pdf&ln=Mn

Манай орны байгаль цаг уурын нөхцөл[4] эрс тэс ба дэлхий нийтийг хамарсан хуурайшилт, дулаарлын уршгаар эрс тэс байдал улам ихсэж байгаа төдийгүй үр тарианы боловсрох хугацаа богино, техник, технологи, хор, бордоог гаднаас импортлож байгаа нь энэ салбарыг өгөөж өндөртэй эрхлэхэд бизнес эрхлэгчдэд сөргөөр нөлөөлж байна.

Манай орны 331 сумын 85 орчим хувь нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд суурилсан эдийн засагтай, дотоодын нийт бүтээгдэхүүний 36 хувийг хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл бүрдүүлж, нийт хөдөлмөр эрхэлж буй хүн амын 56,7 хувь нь энэ салбарт ажил эрхэлж байгаа[5] зэргээс харахад энэхүү салбар нь манай улсын эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх онцгой ач холбогдолтой салбар гэдэг нь харагдаж байна. Нөгөө талаасаа хүнсний аюулгүй байдлыг хангахад эх орны үйлдвэрлэлийн хүнсний ногоо, үр тариа нэн чухал.

Газар тариалангийн салбар дахь улаанбуудайн үйлдвэрлэлийн өнөөгийн байдал

Манай улсын хүн амын хүнсний хэрэглээний 18%-ийг гурил, гурилан бүтээгдэхүүн эзэлж байгаа ба гурилын үндсэн түүхий эд улаанбуудайн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээс хангах зорилт тавьж байгаа. Энэхүү зорилтын биелэлт ямар хэмжээнд байгааг дараах судалгаанаас тодорхойлж болно.

Монгол Улсын нийт улаанбуудай болон гурилын хэрэгцээг тодорхойлбол дараахь үр дүн гарч байна.

График 3.Газар тариалангийн салбарын нийт үйлдвэрлэл, хэрэгцээ, хангамж, 2000-2019



[4] MARCC-2014, Монгол орны уур амьсгалын өөрчлөлтийн илтгэл
https://modis.gsfc.nasa.gov/data/
https://landsat.usgs.gov/
[5] -http://mofa.gov.mn/exp/blog/8/245

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэснээр

Улаанбуудайн үйлдвэрлэл нь улсын хэмжээний бодлогоос шууд хамаардаг. Тухайлбал 2009 оноос атрын III аяныг эхлүүлсэнтэй уялдан 2008 оноос гаднаас гурил, улаанбуудай импортлох хэмжээ эрс буурч, дотоодын үйлдвэрлэлээс хангаж эхэлсэн байна. Улаанбуудайн импорт хугацаанаас хамаарч 2.68 дахин буурч байхад, гурилын импорт 6.46 дахин буурсан нь улаанбуудайн дотоодын нийлүүлэлт гурилын үйлдвэрлэлийг хангаж чадаж байгааг илэрхийлж байна. Улаанбуудайн хэрэгцээ 19.2 дахин өсч байхад буудайн дотоодын нийлүүлэлт 19 дахин өсч буй нь өсөн нэмэгдэж буй хэрэглээг нийлүүлэлт хангаж байгаагийн бас нэг илрэл. Гэвч 2015 онд хэрэглээний огцом өсөлт, нөгөө талаас 2015-2016 онуудад цаг уурын өөрчлөлтөөс хамаарч дотоодын хангаж чадаагүй хэрэгцээг импортоор хангах шаардлага тулгарсан.

Манай урд ба хойд хөрш нийлүүлэлт хийх боломжтой боловч ямар нэгэн эрсдэл тулгарахад эхлээд өөрсдийн дотоод хэрэгцээг хангаад дараа нь гадаад оронд экспортлоно. Энэ нь нийлүүлэлтийн эрсдэл байсаар байна гэсэн үг. Иймд манай улс энэ өсөн нэмэгдэж буй хэрэглээг дотоодоос найдвартай хангах боломж, арга замыг судалж, дэмжиж ажиллах нь чухал юм.

Монгол Улсын газар тариалангийн бүтцийн өөрчлөлтийг авч үзэхэд дараахь байдалтай байна.



Эх сурвалж: https://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L10_2

Дээрх графикаас харахад үр тарианы үйлдвэрлэл маш өндөр хэлбэлзэлтэй байгаа нь тодорхой байна. Тариалсан талбайтай харьцуулахад га-гийн авсан ургацын бүтээмж төмсний тариалалтын хувьд байнга өндөр, харин улаанбуудайн хувьд хэлбэлзэлтэй байна.

Орлогын хэлбэлзлийн математик тооцоолол:

Урт хугацаанд орлого хэрхэн хэлбэлзэж байгааг олж мэдэхийн тулд аж ахуйн орлогын хэлбэлзлийг шинжлэх өгөгдлийн сан ашиглан нилээд хэдэн тоон судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэнэ. (Cameron and Tracy, 1998) болон (Gottschalk and Moffitt, 1994; Haider, 2001) нар орлогын динамик судалгааг ашиглан хувийн орлогыг байнгын болон тогтмол бус орлогод хуваж урт хугацаанд гарсан өөрчлөлтөнд шинжилгээ хийсэн байна. Тэд сүүлийн судалгаандаа фермийн бус орлогын өөрчлөлтийн чиг хандлагыг судласан. (e.g., Congressional Budget Office, 2008; Dahl et al., 2011; Dynan et al., 2012; Moffitt and Gottschalk, 2011; Shin and Solon, 2011; Ziliak et al., 2011).

Орлогын өөрчлөлтийг судлах үед сөрөг утгатай өөрчлөлтийг эерэг утгаар авахын тулд ($|y_{it} - y_{is}|$) тооцооллыг ашигладаг.

y_{is} *болон* y_{it} нь s болон t жилүүдийн i аж ахуйн нэгжүүдийн орлогыг харуулна.

Орлогын өөрчлөлтийг харуулах хялбар хэмжигдэхүүн нь орлогын стандарт хазайлт юм.

$$SDi = \sqrt{\frac{(y_{is}-\bar{y}_i)^2+(y_{it}-\bar{y}_i)^2}{n-1}} \qquad [3]$$

Энд:

SD_i - Стандарт хазайлт

n- Түүврийн нэгжийн тоо

y_{is}- s жилийн i аж ахуйн нэгжийн орлого

y_{it}- t жилийн i аж ахуйн нэгжийн орлого

$\bar{y}_i$ - t хугацааны дундаж орлого

Хэ[illegible]гүйгээр хэвийн түвшинд өөрчлөгддөг бол хугацааны 68 орчим хувийн бодит орлого нь дундаж орлогоос нэг стандарт хазайлтаар буурна. Хугацааны 95 орчим хувьд дундажаас 2 стандарт хазайлтаар буурна. Үнэмлэхүй өөрчлөлт болон стандарт хазайлт нь урт хугацаан дахь орлогын хэлбэлзлийн түвшинг тодорхойлох боловч хүлээгдэж буй орлоготой холбоотой өөрчлөлтийн хэмжээг бүрэн илэрхийлэхгүй.

Дундаж орлогоор тодорхойлогддог хэлбэлзлэлийн нэг хэмжүүр нь нуман өөрчлөлтийн хувийн үнэмлэхүй утга (AAPC) юм.

$$AAPC_i = 100 * \left[\frac{y_{it}-y_{is}}{\bar{y}_i}\right] \qquad [4]$$

Энд:

$AAPC_i$ - Орлогын өөрчлөлтийн орлогын дундаж хэмжигдэхүүнд эзлэх хувь

y_{is}- s жилийн i аж ахуйн нэгжийн орлого

y_{it}- t жилийн i аж ахуйн нэгжийн орлого

$\bar{y}_t$

y_{i} - t хугацааны дундаж орлого

Орлогын өөрчлөлтийн орлогын дундаж хэмжигдэхүүнд эзлэх хувийг ердийн хувийн өөрчлөлтийн оронд орлогын хэлбэлзлийн хэмжүүр болгон ашиглаж байгаа нь орлогын өөрчлөлтийн орлогын дундаж хэмжигдэхүүнд эзлэх хувь нь орлогын өсөлт эсвэл бууралттай тэгш хэмийн хамааралтай ба энэ нь -200 ба 200-ын хооронд утгаа авдаг (Dyan et al., 2012; Hardy and Ziliak, 2014). Хоёрдахь гол хүчин зүйл нь жилээс жилд хуваарилалтын гажуудал ихтэй үед уг загварыг ашиглах шаардлага гардаг. AAPC нь 0-оос 200-ын хооронд утга авна.

Дундажаар хуваагдан гарч ирсэн ковариацийн хазайлт буюу CV хэлбэлзлийн итгэлцүүр нь дундаж орлогоор тодорхойлогдох хоёрдахь хэмжигдэхүүн юм. Хэрэв хэлбэлзлийн итгэлцүүр өндөр тохиолдолд орлого нь дундажтай шууд хамааралтайгаар өөрчлөгддөг, харин бага тохиолдолд орлого дундаж орлогоос үл ялиг хэмжээгээр буурдаг.

Орлогын хэлбэлзлийн итгэлцүүрийн үнэмлэхүй утга (ACV) нь орлогын сөрөг дундаж утга болно.

$$ACV_i = \left|\frac{SD_i}{\bar{y}_i}\right| = \left|\frac{\sqrt{(y_{is}-\bar{y}_i)^2+(y_{it}-\bar{y}_i)^2}}{\bar{y}_i}\right| \quad [5]$$

AAPC-тай харьцуулахад ACV нь утгын хязгаарлалтгүй. Өрхийн аж ахуй эрхлэгч маш бага дундаж орлоготой байх үед ACV нь маш өндөр дүнтэй байж болох ба энэ нь регресийн үзүүлэлтүүдийг гажуудуулах болно. Жишээлбэл, нэг жилд 20,000 ам.долларын орлого олдог өрхийн аж ахуй дараа жилд нь 18,000 ам.долларын алдагдал амссан гэж үзье. Энэ жишээ авсан өрхийн хувьд дундаж орлого нь 1,000 ам.доллар болж байгаа ч стандарт хазайлт нь 26,870 байна. ACV нь 26,9 ба хэт давсан дүн гарч байна. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд бид ACV-н бодит логарифмийг регрессийн хамааралтай хувьсагч болгон ашиглана. Бүртгэлийн өөрчлөлт нь хэт давсан дүнгийн нөлөөг бууруулдаг ба өгөгдлийг хэвийн тархалтанд илүү ойртуулдаг.

Аж ахуйн нэгжийн орлогын хэлбэлзлийн чиг хандлагыг шинжлэхэд ашигладаг хэмжигдэхүүн бол Дунджаас хазайх стандарт хазайлт (SDAPC) (Dahl et al., 2011; Ziliak et al., 2011; Dyan et al., 2012) юм. Өмнөх томъёонуудыг бодвол SDAPC нь тухайн нэг аж ахуйн нэгжийн орлогын

хэлбэлзлийг хэмждэггүй ба илүүтэйгээр түүвэр, түүврээс тасалж авсан хэсэг, эсвэл хугацааны нэг цэг дээрх утгыг харуулдаг.

$$SDAPC_t = \sqrt{\frac{1}{N}\sum_{i=1}^{N}\left(APC_{it} - \overline{APC_t}\right)^2} \quad [6]$$

$$\mathrm{APC}_{it} = (y_{it} - y_{is})/\,\bar{y}_i \quad [7]$$

Энд:

APC_{it} болон N нь түүвэр дэхь аж ахуйн нэгжүүдийн тоо юм.

Дундаж орлогыг $\bar{y}_i$ = 0.5 * ($|y_{it}| + |y_{is}|$) гэсэн томъёогоор олох ба эхний болон 2 дахь жилүүдэд сөрөг утгатай орлогын дүнг оруулж болно

Улаан буудайн үйлдвэрлэл эрхлэгчдийн орлогын хэлбэлзэлд байгууллагын хэмжээний нөлөөллийг тодорхойлох нь

Монгол улсын нутаг дэвсгэрийн хувьд улаанбуудай тариалахад тохиромжтой бүс нутагт Сэлэнгэ, Хэнтий, Дорнод аймаг багтах ба Сэлэнгэ аймаг нийт тариалалтаар тэргүүлдэг. Иймд Сэлэнгэ аймгийн үр тарианы үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны өнөөгийн байдлыг судлалаа.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2010 оноос өнөөг хүртэл үр тарианы үйлдвэрлэл эрхэлж буй 371 компани байгаа ба эдгээрээс 85 компани дампуурсан, 32 компани сураггүй болсон, 157 компани тайлан өгөөгүй, үйл ажиллагаа нь тогтмол бус гэсэн шалтгаанаар хасч сүүлийн 10 жил тогтвортой үйл ажиллагааг явуулж буй 97 компанийг сонгон санхүүгийн тайланд шинжилгээ хийлээ.

ААНОАТ-ийн тухай хуулийн 5-р бүлэг, Албан татварын хувь, хэмжээ бүлгийн 20.1-р зүйлд ААНБ-ийн борлуулалтын орлого 300.0 сая хүртэл бол бичил гэж үзээд 1%-ийн, 300 саяаас-1.5 тэрбум хүртэл жижиг гэсэн ангиллаар авч 10%-ийн татвар ногдуулж, 90%-ийн хөнгөлөлт эдлүүлэхээр, 1.5-6 тэрбум дунд гэж ангилаад 10%-ийн татвар ногдуулахаар, 6 тэрбумаас дээш орлоготой бол том гэж ангилаад 600 сая дээр 6 тэрбумаас давсан орлогод 25% -ийн татвар ногдуулахаар тусгасан байна. Мөн шинэчлэн найруулсан "Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай" хуулпаy 4-р зүйл, мөн 2-р бүлгийн 5-р зүйлд зааснаар аж ахуйн нэгж байгууллагыг бичил (10 хүртэл ажилтантай, Борлуулалтын орлого 300.0 сая хүртэл), жижиг(10-50 ажилтантай, борлуулалтын орлого 300 саяас- 1 тэрбум бүртэл), дунд (50-200 ажилтантай, 1-2.5 тэрбум төгрөгийн орлоготой) гэж ангилсан байдаг.

Дээрх борлуулалтын орлогын шалгууруар ангилахад судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн 58% нь бичил, 33 % нь жижиг, 4% нь дунд, 4% нь том гэсэн ангилалд багтаж байна. Дээр дурьдсан орлогын

өөрчлөлтийн хувь, орлогын хэлбэлзлийн итгэлцүүрийн үнэмлэхүй утга, орлогын хэлбэлзлийн чиг хандлага зэрэг үзүүлэлтүүдийг судалгаанд хамрагдаж буй 97 компаний орлогын мэдээлэлд үндэслэн тооцоход дараахь үр дүн гарсан болно. Судалгаанд хамрагдсан байгууллагуудыг бичил, жижиг, дунд, том гэсэн ангиллаар авч үзэн дээрх 3 үзүүлэлт тус бүрээр тооцож, байгууллагын хэмжээ орлогын хэлбэлзэлд хэрхэн нөлөөлж байгааг тогтоох зорилгыг хэрэгжүүллээ.

Үүнд:

	Sdi	ACVi	SDAPCi
Бичил	27.4	100.52	0.92
Жижиг	184.4	99.74	0.76
Дунд	52.17	97.56	0.89
Том	34.34	80.54	0.76

1. **Орлогын өөрчлөлтийн хувь (SDi).** Орлогын өөрчлөлтийн хувь бичил бизнес эрхлэгч 27.4, том бизнес эрхлэгчид 34.34, дунд бизнес эрхлэгчид 52,17 байгаа нь урт хугацаанд орлогын өөрчлөлт бага байгааг илэрхийлж байна. Харин жижиг бизнес эрхлэгчид нийт дүнд эзлэх хувь өндөр атлаа орлогын өөрчлөлтийн хувь 184,4 байгаа нь урт хугацаанд орлого тогтворгүй байгааг илтгэж байна.

2. **Орлогын хэлбэлзлийн итгэлцүүрийн үнэмлэхүй утга(ACVi).** Бичил бизнес эрхлэгчдийн 85 хувь нь дунджаас баруун тийш хэтийдсэн байна. Энэ нь орлогын өндөр өөрчлөлтийг илэрхийлж байна. Жижиг бизнес эрхлэгчдийн 93 хувь нь дунджаас баруун тийш хазайсан байна. Дунд бизнес эрхлэгчид мөн 97 хувь байгаа нь өөрчлөлт ихтэй байна. Харин том аж ахуйн нэгжийн коэффициент 80,54 хувь байгаа нь дундаж орлогоос орлогын хэлбэлзэл бусад бизнесийн бодвол өөрчлөлт бага байна.

3. **Орлогын хэлбэлзлийн чиг хандлага** (**SDAPCi).** Орлогын өөрчлөлтийн хандлагын хувьд бичил, дунд бизнес эрхлэгчид хамгийн тогтворгүй орлоготой болохыг тодорхойлж байна. Жижиг болон том бизнес эрхлэгчдийн өөрчлөлтийн хандлага арай бага байгаа ч харьцангуй өндөр үзүүлэлт юм.

Дээрх судалгаанаас нэгтгэн дүгнэвэл бичил ба жижиг бизнес эрхлэгчдийн орлого олон үзүүлэлтийн хувьд орлого тогтворгүй байна.

Цаашид улаанбуудайн үйлдвэрлэл эрхлэгчдийн орлогын хэлбэлзлийг багасгах нь энэ салбарт бизнес эрхлэгчдийн урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцлийг хангана. Орлогын тогтвортой байдлыг хангах аргуудад орлогын эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэх, усжуулалт, сэлгэн тариалалт, техникийн шинэчлэл зэрэг олон арга хэмжээ

багтдаг. Эдгээрээс хамгийн оновчтой хувилбар нь сэлгэн тариалалтын технологийг хэрэгжүүлж үр тарианы сэлгээнд хөдөө аж ахуйд шаардлагатай бусад нөөцийг үйлдвэрлэн, орлогоо төрөлжүүлэх явдал. Гэвч улаанбуудайгаас бусад төрлийн таримлын зах зээл хомс гэж тариаланчид хэлэлцдэг. Гэхдээ энэ нь тийм биш гэдгийг дараахь судалгаанаас харж болно. Өөрөөр хэлбэл, манай улс дараах бүтээгдэхүүнийг импортоор оруулж ирж байгаа ба бид тэдгээрийг дотооддоо үйлдвэрлэх бүрэн боломжтой юм.

Импортын зарим нэр төрлийн бүтээгдэхүүнд шинжилгээ хийж, түүнийг дотоодын үйлдвэрлэлээс хангах, цаашлаад улаанбуудайн үйлдвэрлэлтэй хослуулан, ээлжлэн тариалалтад ашиглах боломжийг тодорхойлох зорилгоор дараахь мэдээллийг цуглуулав. Манай улсад тарьж ургуулж байгаа бүтээгдэхүүнээс гадаад худалдааны тэнцлийн хувьд хамгийн ашигтай нь рапс ба жилд дунджаар 2846 мянган ам долларын ашигтай, хамгийн алдагдалтай бүтээгдэхүүнд улаанбуудай буюу жилд дунджаар 10998 мянган ам долларын алдагдал хүлээж байна. Үүнд:



1. Рапс. Рапс нь Улаанбуудайн үйлдвэрлэлтэй сэлгэж тариалахад тохиромжтой[6] ургамал хэмээн ХААИС-ийн багш, шинжлэх ухааны доктор, профессор О.Мөнхжаргал дурьдсан байдаг. Зах зээлийн хувьд тогтворгүй тул тариаланчид сэлгээнд тарихад эрсдэлтэй байна. Иймд рапсийн зах зээлийн нийлүүлэлтийн сувгийг тодорхой болгож тогтворжуулж чадвал

[6] -https://www.muls.edu.mn/view_news.php?value_id=ZW5jb2RldXNlcmlkMjkwMQ==

тариалан эрхлэгчдэд орлогоо тогтворжуулахад хамгийн их түлхэц үзүүлэх ач холбогдолтой. Уринш-улаанбуудай гэсэн технологиос рапс-улаанбуудай гэсэн технологи нь хөрс боловсруулалт ба орлогод давхар ач холбогдолтой байна.

2. Гурвалжин будаа. Манай Улс гурвалжин будааны хэрэглээ өндөр байгаа тул эх орондоо тарьж ургуулах арга хэмжээ авах шаардлагатай. Гурвалжин будааны импортод дунджаар 1201.54 мянган ам доллар жилд зарцуулж байна.

3. Малын тэжээлийн хувьд гадаад худалдааны алдагдал ихтэй бүтээгдэхүүн байна. Жилд дунджаар 3855 мянган ам долларын алдагдал хүлээдэг. Малын тэжээл нь манай улсад тарих бүрэн боломжтой таримал юм. Иймд импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлд малын тэжээлийг тариалах замаар газар тариалангийн үйлдвэрлэлийг өргөтгөх боломжтой ба сэлгээ тариалалтад ашиглах шаардлагатай байна.

Дээрх шинжилгээнээс дүгнэхэд улаанбуудайн сэлгээ тариалалтад рапс болон малын тэжээлийн таримлыг ашиглаж тариалалтын төрлийг нэмэгдүүлснээр тариалан эрхлэгчдийн орлогыг тогтворжуулах боломж нөхцөл байна. Учир нь рапс болон малын тэжээлийн ургамлын зах зээлийн нийлүүлэлтийн орон зай байгааг дээрх судалгаанаас харж болно.

Дүгнэлт

Дэлхий нийтээр хүн амын хэт өсөлтийг хангах хүнсний нөөц хомс буй энэ үед улс орон бүрийн өмнө хүнсний хангамжийн асуудал чухлаар тавигдаж байна.

Монгол Улсын улаанбуудайн үйлдвэрлэлийн хөгжилд түлхүү анхаарч ирсэн ба үр дүнд нь улаанбуудайн дотоодын хэрэгцээгээ хангаж чадаж байна. Гэвч зарим жил ургац алдаж, гадаадаас ихээр импортлох явдал байсаар байна. Мөн улаанбуудайн үйлдвэрлэл эрхлэгчид уг салбартаа тогтовортой бизнес эрхлэж чадахгүй байгааг дээрх судалгаагаар тогтоолоо.

Улаанбуудайн үйлдвэрлэл эрхлэгчдийн орлогын хэлбэлзэлд байгууллагын хэмжээ нөлөө ихтэй байна. Бичил болон жижиг бизнес эрхлэгчид шинэ техник, технологи нэвтрүүлэх боломжгүйгээс аз туршиж, түүнээсээ болж уг салбараас шахагдан гарах тохиолдол их байна. Иймд төрөөс дараахь арга хэмжээг авах шаардлага байна. Үүнд:

1. Төрөөс бусад орны туршлага, шинэ техник, технологийн судалгааг тогтмол явуулж, практикт нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх
2. Орлогын тогтвортой байдлыг хангахын тулд орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж, олшруулах
3. Жижиг бизнес эрхлэгчид техник, технологит их хэмжээний хөрөнгө оруулалт хийж чаддаггүй тул дундын өмчлөлийн техникийн технологийн парк байгуулах, аутсорсингийн үйлчилгээ, мэргэжлийн зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх зэрэг арга хэмжээг үр дүнтэй гэж үзэж байна.

Мөн бизнес эрхлэгчдийг санхүүгийн хувьд бэхжүүлэх, том бөгөөд тогтвортой бизнес эрхлэгчдийг бий болгох нь энэ салбарын хөгжилд томоохон нөлөө үзүүлнэ.

Хавсралт

Appendix.1 Dynamic data of Mongolian total grain manufacturing

он	Grain		
	Cultivating field/hectare/	Harvest /ton/	Unit harvest/cent/
1982	529.1	551.3	10.4
1983	586.5	812.8	13.9
1984	619.6	597.9	9.6
1985	636.2	886.2	13.9
1986	629.7	869.4	13.8
1987	622.9	689.4	11.1
1988	641.6	814.3	12.7
1989	673.4	839.1	12.5
1990	654.1	718.3	11
1991	615.3	595.3	9.7
1992	592.6	493.4	8.3
1993	546.4	479.5	8.8
1994	449.1	230.7	7.4
1995	356.5	261.4	7.3
1996	332.6	220.1	6.6
1997	316.8	240.4	7.6
1998	306.9	194.9	6.4
1999	279.1	169.5	6.1
2000	194.4	142.1	7.3
2001	199.6	142.2	7.1
2002	263	125.8	4.8
2003	207.3	165	8
2004	172.9	138.5	8
2005	159.1	75.2	4.7
2006	126.2	138.6	11
2007	121.8	114.8	9.4
2008	155.4	205.8	13.2
2009	255.5	392.9	15.4
2010	284.1	366.3	12.9
2011	293.2	448.1	15.3
2012	306.3	476.1	15.5
2013	291.9	386.7	13.2
2014	440.6	518.7	16.6

2015	519.5	216.3	5.5
2016	505.3	483.5	12.8
2017	527	238.1	6.3
2018	511	453.8	12.7
2019	526	433.3	12

Source: http://mofa.gov.mn/exp/blog/8/70

Том бизнес эрхлэгчдийн орлогын хэлбэлзлийн шинжилгээ

он	Орлогын хэлбэлзлийн түвшин				Орлогын өөрчлөлтийн хувийн үнэмлэхүй				Орлогын өөрчлөлтийн хэлбэлзлийн итгэл				Орлогын хэлбэлзлийн чиг хандлага			
	T1	T2	T3	T4	T1	T2	T3	T4	T1	T2	T3	T4	T1	T2	T3	T4
2010																
2011	-0.15559	-4.47652	-2.82668	-0.13561	163.9291	-37.5181	40.01979	167.8159	1.159154	0.265293	0.282983	1.186638	2.687275	0.094715	0.160158	1.196083
2012	-15.8288	-17.1406	-15.7157		-9.35219	7.923796	-9.42267		0.06613	0.05603	0.066628		0.008746	0.021509	0.008879	
2013	-95.966	-2.64879	-1.38027	-1.46774	1.462882	42.14113	67.75076	65.02578	0.010344	0.297983	0.47907	0.459802	0.000214	0.238959	0.459017	0.004324
2014	-186.236	-0.19117	-2.08976	-0.15486	0.756495	157.4368	50.56419	164.0683	0.005349	1.113247	0.357543	1.160138	5.72E-05	2.695478	0.255674	1.115514
2015	-9.01503	-1.5372	-2.83091	-1.56275	-17.0225	-170.368	-66.5888	-165.282	0.120367	1.20468	0.470854	1.168717	0.028976	2.677323	0.443406	5.005598
2016	-0.95397	-2.00251	-0.8178	-0.92399	85.13814	52.1923	92.74116	86.70337	0.602018	0.369055	0.655779	0.613085	0.72485	0.347329	0.860092	0.079823
2017	-7.15881	-4.09389	-3.60095	-0.71473	17.97901	-41.7569	-48.8698	99.46353	0.127131	0.295266	0.345562	0.703313	0.032324	0.122602	0.238826	0.168208
2018	-9.15955	-4.42541	-20.8393	-6.35676	-16.7314	-38.0338	-7.02463	20.0204	0.118309	0.26894	0.049672	0.141566	0.027994	0.097916	0.004935	0.147686
2019	-3.32023	-6.15561	-0.98133	-4.0406	-54.1196	-25.956	83.75856	29.78727	0.382683	0.183537	0.592262	0.210628	0.292893	0.036917	0.70155	0.082157
													3.803331	6.332748	3.132535	7.799393
Summa	-327.794	-42.6717	-51.0828	-15.357	172.0399	-53.9383	202.9286	467.603	2.591485	4.05403	3.300352	5.643887				
Mean	-36.4215	-4.7413	-5.67586	-1.91963	19.11555	-5.99314	22.54763	58.45038	0.287943	0.450448	0.366706	0.705486				
Sdi				34.34285				80.54229				0.382426				1.076242
SDAPCi													0.650071	0.838832	0.589966	0.987382

Дунд бизнес эрхлэгчдийн орлогын хэлбэлзлийн шинжилгээ

он	Орлогын хэлбэлзлийн түвшин				Орлогын өөрчлөлтийн хувийн үнэмлэхүй				Орлогын өөрчлөлтийн хэлбэлзлийн итгэл				Орлогын хэлбэлзлийн чиг хандлага			
	Д1	Д2	Д3	Д4	Д1	Д2	Д3	Д4	Д1	Д2	Д3	Д4	Д1	Д2	Д3	Д4
2010																
2011	-0.71578	-13.0308	-11.8496	-2.28806	99.39034	-11.4756	11.26261	-89.4534	0.702796	0.081145	0.079639	0.632531	1.117246	0.044469	0.000484	0.718475
2012	-5.85515	-4.94178	-4.44222	-1.41421	21.55071	25.03525	27.46403	-200	0.152387	0.177026	0.1942	1.414214	0.077619	0.023788	0.033858	3.81458
2013	-2.01772	-2.63354	-2.17417	0	-107.905	42.33356	-96.3974	200	0.763004	0.299343	0.681633	1.414214	1.032166	0.10707	1.112199	4.18982
2014	0	-1.71965	-0.431	-0.26467	0	58.27595	124.2606	145.5293	0	0.412073	0.878655	1.029048	0.003981	0.236818	1.327038	2.2566
2015	-1.41421	-2.29032	-17.2766	-2.67273	-200	-89.3257	7.863862	-71.9472	1.414214	0.631628	0.055606	0.508744	3.7516	0.978867	0.000144	0.452347
2016	0	-1.40778	-3.4149	-2.72184	200	66.86954	34.30887	-70.1937	1.414214	0.472839	0.2426	0.496344	4.256362	0.327843	0.063733	0.429067
2017	-2.48012	-18.7337	-5.32174	-1.6661	-79.7634	-7.84517	23.45744	-147.469	0.564013	0.055474	0.165869	1.042764	0.539548	0.030475	0.020719	2.038575
2018	-315.805	-2.7382	-5.05166	-0.19553	0.446812	41.04753	24.55759	156.6754	0.003159	0.29025	0.173648	1.107862	0.004565	0.098819	0.024007	2.603894
2019	-8.2411	-3.65219	-2.3853	-2.88822	15.80443	-48.0194	-84.2702	39.33481	0.111754	0.339549	0.595881	0.278139	0.048903	0.332138	0.871117	0.193823
													10.83199	2.180287	3.453299	16.69718
Summa	-327.794	-42.6717	-51.0828	-15.357	172.0399	-53.9383	202.9286	467.603	2.591485	4.05403	3.300352	5.643887				
Mean	-36.4215	-4.7413	-5.67586	-1.91963	19.11555	-5.99314	22.54763	58.45038	0.287943	0.450448	0.366706	0.705486				
Sdi				52.17268				97.56716				0.439685				1.291194
SDAPCi													1.097066	0.492193	0.619435	1.362073

Жижиг бизнес эрхлэгчдийн орлогын хэлбэлзлийн шинжилгээ

он	Орлогын хэлбэлзлийн түвшин																														
	J1	J2	J3	J4	J5	J6	J7	J8	J9	J10	J11	J12	J13	J14	J15	J16	J17	J18	J19	J21	J22	J23	J24	J25	J26	J27	J28	J29	J30	J31	J32
2011	0.17858	0.42647	0.49949	0.15002	0.1294	0.59271	1.4114	0.09698	0.66722	0.10091	0.55697	1.41421	0.513	1.41421	1.41421	0.49285	0.04773	0.66678	1.41421	0.95928	0.18859	0.32939	0	0.39273	0.28162	0.12544	0.0376	0.23824	0.20921	0.25004	1.36967
2012	0.07863	0.07257	0.75197	0.13264	0.06109	0.16189	0.10166	0.21509	0.11026	0.20677	0.18696	1.41421	0.96983	1.41421	1.41421	0.75788	1.09918	0.20013	1.41421	0.62564	0.59623	0.58089	0.29716	0.01622	0.31086	0.10519	0.05732	1.41421	0.38542	0.00033	0.00423
2013	0.10095	0.08654	0.24422	0.025	0.52738	0.03073	0.27598	0.06634	0.06361	0.24899	0.11668	1.41421	0.63273	0.00383	0.17959	0.22809	0.05324	0.28294	0.17395	0.19601	0.63912	0.48918	0.40493	0.12763	0.15563	0.31965	0.18237	0	0.17141	0.18843	0.51769
2014	0.5112	0.22927	0.8149	0.54876	0.25038	0.10178	0.44131	0.3713	1.0302	0.23081	0.53605	0.46625	0.90979	0.5048	0.47431	0.26179	0.38625	0.24213	0.51327	0.75234	0.13177	0.3905	0.21257	0.59188	1.13977	0.9582	0.502	1.41421	0.33714	0.63676	0.55617
2015	0.60716	0.47484	1.15165	0.77947	0.18281	0.48862	0.81317	0.35417	1.29314	1.16698	0.32007	0.40322	1.16086	0.67348	0.08292	0.09381	0.98857	0.66349	0.19736	1.11804	0.29687	0.41973	0.45084	0.82093	1.35639	0.56292	0.46693	1.07208	0.2646	0.61459	0.53263
2016	0.6408	0.55565	0.71835	0.30239	0.39903	0.68526	0	0.41279	1.01722	1.16807	1.06996	0.51072	0.88317	0.6929	0.02067	0.02525	0.03795	0.51184	0.8672	0.72914	0.47482	0.05967	0.56157	0.12172	1.16754	0.96482	0.33306	0.03791	0.07894	0.46403	0.07321
2017	0.31872	0.12584	0.15598	0.19666	0.08936	0.40629	0.14623	0.10499	0.62293	0.28395	1.09505	0.05638	0.56009	0.01735	0.14548	0.11486	0.73194	0.73769	1.13255	0.18806	0.16063	0.45281	0.22199	0.18526	0.62178	1.24314	0.03063	0.40197	0.4832	0.15207	0.35849
2018	0.27411	0.2809	0.1193	0.32968	0.24412	0.32592	0.04411	0.28719	0.40315	0.07808	0.75542	0.20161	0.28045	0.00986	0.02692	0.28752	0.79593	0.70177	0.48836	0.59526	0.09131	0.05202	0.07401	0.35382	1.36183	0.68796	0.35021	0.18368	0.51437	0.56139	0.36687
2019	0.2218	0.32471	0.1542	0.22844	0.34182	0.10883	0.28119	0.53493	0.20276	0.24483	0.30863	0.35559	0.4208	0.15284	0.31066	0.04115	0.10184	0.33394	0.28612	0.6223	0.28031	0.23285	0	0.44555	0.81722	0.08914	0.49965	0.59016	0.41522	0.26429	1.11511
Summa	2.93194	2.57679	4.61007	2.69307	2.22538	2.90203	3.51507	2.44377	5.41049	3.7294	4.9458	6.23641	6.33072	4.88347	4.06898	2.3032	4.24264	4.34071	6.48723	5.78607	2.85966	3.00704	2.22306	3.05574	7.21264	5.05644	2.45976	5.35246	2.85952	3.13193	4.89408
Mean	0.32577	0.3221	0.51223	0.29923	0.24726	0.32245	0.39056	0.27153	0.60117	0.41438	0.54953	0.69293	0.70341	0.54261	0.45211	0.25591	0.4714	0.4823	0.7208	0.6429	0.31774	0.33412	0.24701	0.33953	0.8014	0.56183	0.27331	0.59472	0.31772	0.34799	0.54379
Sdi																															
SDAPCi	**0.53879**	**0.46643**	**0.86675**	**0.52376**	**0.3935**	**0.54211**	**0.78287**	**0.43767**	**1.01006**	**0.8218**	**0.90463**	**1.19445**	**1.06752**	**1.07056**	**0.98468**	**0.47269**	**0.8296**	**0.7399**	**1.21774**	**0.99716**	**0.51865**	**0.52916**	**0.43262**	**0.56195**	**1.29902**	**0.97951**	**0.46954**	**1.11066**	**0.4568**	**0.57805**	**0.90173**

Бичил бизнес эрхлэгчдийн орлогын хэлбэлзлийн шинжилгээ

он	Орлогын хэлбэлзлийн түвшин																														
	b1	b2	b3	b4	b5	b6	b7	b8	b9	b10	b11	b14	b15	b16	b17	b18	b19	b20	b21	b22	b23	b24	b25	b26	b27	b28	b29	b30	b31	b32	b33
2011	1.414214	0.279091	1.414214	0.306725	0.074608	0.675887	0.092036	0.186275	0.581389	0.613479	0.108648	-143.322	0.099421	0.678792	1.008119	0.568218	0.215421	0.20625	1.091824	0.559429	0.051027	0.264539	1.414214	1.414214	0.176675	0.225193	0.492341	0.172633	1.414214	0.557114	1.414214
2012	0.109884	0.254778	0.648336	0.931706	0.333935	1.414214	0.258854	0.097313	0.483034	0.089441	0.520364	-200	0.112234	0.026807	1.139764	0.291862	0.817325	0.391809	0.038959	0.315694	0.32965	0.103521	0.092966	0.355878	0.725836	0.640766	0.985568	0.232316	1.414214	0.113271	1.414214
2013	0.022999	0.75885	0.625408	0.773511	0.298844	1.414214	0.045982	0.002869	0.162887	0.795225	0.6988	200	0.050089	1.414214	0.982363	0.256745	0.069325	0.344685	0.348238	0.441842	1.414214	0.141992	0.349722	0.17295	0.498708	0.331827	0.363974	0.346613	0.311738	0.332641	1.414214
2014	0.569048	0.747586	0.772213	1.414214	0.640543	0.161067	0.669174	0.111553	0.403248	0.388679	0.789086	103.4786	0.409995	0	1.049958	0.089027	0.32944	0.505511	0.441409	1.068863	1.414214	0.478892	1.414214	0.798712	0.471308	0.196739	0.141243	0.586424	0.477757	0.994089	1.414214
2015	0.735441	0.737897	1.172591	1.414214	0.746503	0.327188	0.753383	0.157226	0.543072	0.242595	1.094341	-143.766	0.436235	0	1.096798	0.268273	0.378174	0.561042	0.43207	1.132512	1.113857	0.610497	0	1.171591	0.55894	0.852559	0.377609	0.407494	1.008298	0.989828	1.132109
2016	0.845753	1.414214	1.110308	0.097081	0.600991	0.600774	0.440308	0.15211	0.605448	0.649506	0.916372	139.2631	0.331155	1.414214	1.087463	0.233973	0.38552	0.866347	0.059928	0.68412	1.042794	0.356239	1.414214	0.97842	1.002547	0.886036	0.491754	0.562466	0.344938	1.121324	1.414214
2017	0.65797	1.414234	0.547215	0.076667	0.070466	0.194198	0.106071	0.049164	0.401307	0.475534	0.465852	41.27623	0.374426	0.031357	0.988336	0.691854	0.46534	1.414234	0.05457	0.47385	0.747702	0.50355	0.430413	0.584223	1.086646	0.881463	0.273625	0.063172	0.998391	0.859273	1.414214
2018	0.6375	1.414234	0.174317	0.208622	0.136743	0.493958	0.408741	0.138854	0.087952	0.054667	0.635547	-39.5466	0.296333	0.593276	0.410794	1.234969	0.968673	1.414234	1.414214	0.054744	0.977736	0.34266	1.346221	0.259633	0.698524	0.573862	0.327816	0.034779	1.175449	0.818462	1.414214
2019	0.336753	0	0.326004	1.414214	0.577216	0.574301	0.2034	0.011891	0.383796	1.387431	0.014309	-65.1244	0.019559	0.199915	0.407279	1.414214	0	0.598681	1.414214	0.033558	0.293815	0.637735	0.508579	0.046675	0.471405	0.158378	0.252402	0.443715	1.008142	0.291394	1.414214
Summa	5.329559	7.020844	6.790466	6.236952	3.47145	5.855796	2.975728	0.918274	3.652133	4.697538	5.213929	-107.741	2.137848	4.352574	7.770702	5.047136	3.429019	6.26473	5.295426	4.764611	7.385009	3.259644	6.770542	5.782096	5.683562	3.946832	3.306113	2.84761	8.119101	5.477396	12.44492
Mean	0.592173	0.877606	0.754496	0.692995	0.385717	0.650644	0.330636	0.10203	0.405793	0.521948	0.579325	-11.9712	0.237539	0.483516	0.863411	0.560793	0.381002	0.696081	0.588381	0.529401	0.820557	0.362188	0.752282	0.642455	0.631507	0.438535	0.367346	0.316401	0.902122	0.6086	1.382769
Sdi																															19.43011
SDAPCi	0.973437	1.225121	1.175867	1.238535	0.648029	0.589391	0.569393	0.151333	0.608919	0.918824	0.940524	1.32309	0.399645	1.026131	1.285121	0.874692	0.679578	1.13435	1.120156	0.901626	1.336173	0.578036	1.318651	1.051083	0.953826	0.742819	0.551206	0.507685	1.38287	0.961371	1.951619

Олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэхэд санал болгосон сэтгүүлүүд:

SCOPUS JOURNALS:
International Journal of Pharmaceutical Research(Q2 Ranking Journal)
Plagiarism : Less than 25%
ISSN : 0975-2366
Publication TIme : 20-30 Days
Indexing: SCOPUS
Processing charge: 500 USD For Abroad Authors ; 30000 INR for Indian Authors

Palarch's Journal of Archaeology of Egypt/Egyptology (Q3 Ranking Journal)
ISSN: 1567-214X
Plagiarism: Below 30%
Publication: 400 USD
Indexing - SCOPUS

International Journal of Modern Agriculture
Plagiarism: Below 25%
ISSN: 2305-7246
Publication: 15000 INR
Indexing: ESCI-Web of science

European Journal of Molecular & Clinical Medicine – (Q4 Ranking journal)
Plagiarism: Below 20%
ISSN: 2515-8260
Processing charge: 350 USD
Indexing - SCOPUS

Solid State Technology - (Q4 Ranking journal)
Plagiarism: Below 25%
ISSN: 0038-111X
Processing charge: - USD 250 for Special Issue, USD 350 for Regular Issue
Indexing: SCOPUS, Scimago
Pertanika Journal of Social Sciences & Humanities
Plagiarism: Below 20%
ISSN: 0128-7702

Papers has to be submitted as per the guidelines only.
Scimago Ranking: (Q3 Ranking Journal)
Publication fee: USD 500, 36,663.90 INR

Psychology and Education
Plagiarism : Below 25%
ISSN number : 0033-3077
Publication fee: 16,000 INR/450 USD(Regular Issue)
Scimago Ranking : Scopus - (Q4 Ranking journal)

GOOGLE SCHOLAR:
International Journal of Engineering Research in Computer Science and Engineering IJERCSE
ISSN: 2394-2320
Duration of Publication: 10 working days
Publication fee: 100 USD

International Journal of Engineering Research in Electronics and Communication Engineering IJERECE
ISSN: 2394-6849
Duration of Publication: 10 working days
Publication fee: 100 USD

International Journal of Engineering Research in Electrical and Electronic Engineering IJEREEE
ISSN: 2395-2717
Duration of Publication: 10 working days
Publication fee: 100 USD

International Journal of Engineering Research in Mechanical and Civil Engineering IJERMCE
ISSN: 2456-1290
Duration of Publication: 10 working days
Publication fee: 100 USD

International Journal of Science , Engineering and Management IJSEM
ISSN: 2456-1304
Duration of Publication: 10 working days
Publication fee: 100 USD

ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХЭД МЭДЭЭЛЛИЙН НЭГДМЭЛ БАЙДАЛ, УЯЛДААГ ХАНГАХ АСУУДАЛ

THE ISSUE OF PROVIDING INTEGRATED AND INTERDEPENDENT INFORMATION IN THE FIGHT AGAINST ENVIRONMENTAL CRIME

Б.Мөнхдорж
ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хууль сахиулахуйн боловсрол судлалын төвийн эрхлэгч, хууль зүйн ухааны доктор, математикийн ухааны магистр, цагдаагийн дэд хурандаа
Munkhdorj B.
Head of the Center for Law Enforcement Education Studies, Scientific Research Institute, University of Internal Affairs of Mongolia, Master of Mathematics, Ph.D, Police Lieutenant Colonel

Хураангуй: Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт явдалтай тэмцэхэд байгаль орчны салбарын болон төрийн зарим байгууллагын мэдээллийн сангийн өгөгдөл, статистик үзүүлэлт, бүрдүүлэлт, аргачлал, мэдээллийн уялдаа, тархаалт, ашиглалт, удирдлага зохион байгуулалт, тулгамдаж буй асуудлыг судлан, мэдээллийг нэг урсгалд оруулан мэдээллийн нэгдсэн сан үүсгэх боломж, салбар дундын зохицуулалт, мэдээллийг ашиглах, тархаах болон ил тод, мэдээлэл авах иргэдийн эрхийг хангах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэсэн санал, зөвлөмжийг дэвшүүлэх энэхүү судалгааны ажлын зорилго оршиж байгаа юм.

Abstract: This research work has strived to study all the data and statistics related with environmental crime. It has attempted to provide recommendations for creating a unified database by closely scrutinising the flow of information and providing insight on the distribution, use and management of data collected from several different government agencies responsible for combatting environmental crime.

The study has shun light on several important matters including the issues of inter-sectorial regulations, dissemination of information, transparency and citizens' rights to access information (freedom of information).

Түлхүүр үгс: Хүрээлэн байгаа орчин, гэмт явдал, мэдээллийн сан, мэдээлэл, маягт, өгөгдөл, аргачлал.

Key words: environment, crime, database, data form, data, methodology.

Удиртгал

ХЗДХЯ, ГХУСАЗЗ-ийн Ажлын алба, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газартай хамтран "Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн нэгдсэн мэдээллийн сан байгуулах боломж" хэлэлцүүлгийг 2019 оны 1 дүгээр сард Хүрээлэн байгаа орчны

эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн гишүүн байгууллагууд болох ХЗДХЯ, БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар, Нийслэлийн Байгаль орчны газар, Цаг уур, орчны шинжилгээний газрын Ус, цаг уур, судалгаа мэдээллийн хүрээлэнгийн Байгаль орчны мэдээллийн сан, УУХҮЯ-ны Геологи, уул уурхай, бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, ШЕЗ-ийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, УЕПГ-ын Гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл, дүн шинжилгээний төв, ЦЕГ-ын Мөрдөн байцаах алба, ХХЕГ-ын Хилийн алба, ГЕГ-ын Зөрчил, мэдээллийн алба, МХЕГ, ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Гэмт явдал, цагдаа судлалын хүрээлэн, Шинжлэн магадлахуй судлалын төв, Лондоны амьтан судлалын нийгэмлэгийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэгийн Монгол дахь хөтөлбөрийн газар, НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэгч болон Монголын Байгаль орчны сургалт, судлалын төвийг оролцуулан зохион байгуулсан байна.

Хэлэлцүүлгийн зорилго нь хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хил, гааль, цагдаа, шүүх, прокурор, мэргэжлийн хяналт, байгаль орчны байгууллагуудын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа бүртгэл, мэдээллийн сангийн өнөөгийн байдлыг олон талын оролцоотойгоор хэлэлцэн дүгнэж, “Мэдээллийн нэгдсэн сан” байгуулах боломж, шийдлийг олох асуудал байсан. Учир нь байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагад бүрдүүлдэг мэдээллийн сангийн хаалттай болон нээлттэй урсгалыг нэгтгэх замаар дундын мэдээллийн сан бий болгох нь мэдээлэлд дүн шинжилгээ хийх, ттухайн чиглэлээр төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах, олон нийтийн байгууллага, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, иргэд хэрэгцээт мэдээллийг хугацаа алдалгүй авах, ашиглах эрхийг хангах зэрэг олон талын чухал ач холбогдолтой.

Хэлэлцүүлгээр хүрээлэн буй орчны талаарх мэдээлэл, статистикийг гаргаж байгаа өнөөгийн байдал, аргачлал, нэгдсэн мэдээллийн сан байгуулах нөхцөл, боломжийг судлах шаардлага байна гэж дүгнэсэн.

Энэхүү хэрэгцээ шаардлагыг үндэслэн ХЗДХЯ, ГХУСАЗЗАА-ны удирдлага, зохион байгуулалт, ДБХС (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын дэмжлэгтэйгээр ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачдын баг “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт явдалтай тэмцэхэд мэдээллийн нэгдмэл байдал, уялдааг хангах асуудал” судалгааны ажлыг 2020-2021 онд хийж гүйцэтгэсэн. Энэ судалгааны ажлыг гүйцэтгэсэн багийг хариуцан ажилласан судлаачийн хувьд ажлын үр дүнг тоймлон нийтийн хүртээл болгож байна.

Судалгааны үндсэн үр дүн

1. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, түүний харьяа байгууллагын мэдээлэл, судалгаа

БОАЖЯ, түүний харьяа байгууллагын статистик мэдээллийн өнөөгийн байдал, тогтолцоо, хууль эрх зүйн орчин, бүртгэлийн болон мэдээний маягт, мэдээлэл боловсруулах аргачлал, хүрээлэн буй орчны гэмт явдалтай тэмцэхэд ашиглах боломж, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлоход чиглэсэн.

Судалгааны дараах үр дүн гарсан. Үүнд:

SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
1. Байгаль орчны мэдээллийн сан бүрдэж, нэгдсэн мэдээллээр авах боломж бүрдсэн. 2. Байгаль орчны мэдээлэл, статистик мэдээ гаргах үйл ажиллагаа журмаар зохицуулагдсан. 3. Олон улсын байгууллагуудтай хамтран байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн санг шинэчилсэн, шинэ төрлийн мэдээллийн санг гаргасан.	1. Мэдээллийн санг шинэчлээгүй, ялангуяа байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн сан дахь мэдээлэл 2007-2015 оноор гарсан. Өөр мэдээлэл байхгүй байна. 2. Мэдээлэл цаг хугацаандаа шинэ мэдээллээр шинэчлэгддэггүй буюу тогтмолжоогүй 3. Зарим мэдээлэл хязгаарлагдмал учир ашиглах боломжоор тааруу 4. Мэдээллийн сангийн үзүүлэлт цөөн, аргачлал тодорхойгүй
Боломж	Эрсдэл
1. Байгаль орчны чиглэлээрх бусад мэдээллийг нэгтгэх боломжтой.	1. Мэдээллийн хаалттай урсгал, нууцлал алдагдах магадлалтай

Дэд дүгнэлт

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд зааснаар байгаль орчны мэдээллийн сан үүсгэж ашиглах эрх зүйн зохицуулалт манай улсын хууль тогтоомжийн хүрээнд бүрдсэн байна. Гэхдээ үйл ажиллагаа тогтмолжоогүй, салбар дундын эрх зүйн зохицуулалт болох журам, зааврыг хамтарсан байдлаар боловсруулах шаардлагатай.

Харин хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт явдалтай тэмцэхэд ашиглах мэдээллийн дундын нэгдсэн санг дээрх сангийн платформ дээр суурилан хөгжүүлэх, өргөтгөх, боловсронгуй болгох, “ухаалаг” болгох боломжтой байна.

Дэд санал:

1. Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээллийн нэгдсэн санг бий болгох,

2. Статистик мэдээллийг гаргах нэгдсэн загвар, маягтыг бий болгох;

2. Хүснэгтэн мэдээллийг ухаалаг тайлангийн хэлбэрт шилжүүлэх, дүн шинжилгээ хийдэг программ хангамжийг ашиглах;

3. Статистикийн чиглэлээр ажиллаж байгаа алба хаагчдыг хосолсон мэргэжлээр (статистикч) богино болон урт хугацааны сургалтад хамруулах, гадаад орны туршлага судлуулах;

4.Байгаль орчны мэдээллийн сан, түүний төрөл, бүрдүүлэлтэд ”Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаарх мэдээлэл”-ийг нэмж оруулах;

5. Байгаль орчны мэдээллийн сан /eic.mn/-д байгаль орчны холбогдолтой гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн сан үүсгэж нийтэд ил болгох саналтай байна.

2. Үндэсний статистикийн хорооны мэдээлэл, судалгаа

ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын Нийгмийн статистикийн алба бүртгэгдсэн болон шүүхээр шийдвэрлэсэн “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн статистикийн мэдээлэл”-ийг хариуцан ажилладаг. Харин хүрээлэн байгаа орчны салбарын статистик мэдээллийг тус хорооны Макро эдийн засгийн газар хариуцан гаргадаг.

Хүн ам, нийгмийн статистикийн газрын гэмт хэргийн статистикийн асуудлыг хариуцсан ажилтнууд нь хууль сахиулах, шүүх эрх мэдлийн 5 байгууллагаас сар, улирал, жилээр гэмт хэргийн талаархи мэдээлэл цуглуулж, хянан боловсруулах, дүн шинжилгээ хийх, мэдээллийг олон улсын арга зүйд нийцүүлэх; НҮБ-ын Гэмт хэргийн чиг хандлагын судалгааны асуулгын дагуу өөрийн орны гэмт хэргийн тухай мэдээллийг хүргүүлэх; гэмт хэргийн статистикийн блютень, танилцуулга, эмхэтгэл бэлтгэн нийтэд тархаах; гэмт хэргийн статистикийн үзүүлэлт, хохирогчийн судалгаа хийх аргачлал, ангиллыг боловсруулж мөрдүүлэх, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын бүртгэлийн болон мэдээллийн маягтыг боловсруулж, мөрдөх аргачлал, арга зүйн зөвлөмж өгөх; сургалт зохион байгуулах; судалгааны асуулга, зааврыг боловсруулах, дүн шинжилгээ хийх, тайлан бичих; гэмт хэргийн статистиктай холбоотой тогтвортой хөгжлийн үзүүлэлтийг тооцож гаргахад оролцох; Бодлого боловсруулагчид, хэрэглэгчдийг гэмт хэрэг, шүүхийн статистикийн үнэн бодит мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

<u>Мэдээллийн систем, программ хангамж, бусад байгууллагын уялдаа холбоо</u>

Шүүх, прокурор, цагдаа, авлигатай тэмцэх, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гэмт хэргийн талаархи статистикийн мэдээ гаргаж, тухайн байгууллага бүр мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна. ҮСХ Статистикийн тухай хуулийн дагуу дээрхи хууль сахиулах, шүүх эрх мэдлийн 10 гаруй байгууллагаас (тухайлбал: ЦЕГ (108), ШЕЗ (60), ШШГЕГ (43), АТГ (10)) нийт 350 орчим үзүүлэлтээр улс,

бүс, нийслэл, сум, дүүргээр жил, улирал, сарын давтамжтайгаар гэмт хэргийн талаархи мэдээллийг цуглуулан боловсруулж бодлого боловсруулагчид болон хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг ханган ажиллаж байна. Түүнчлэн, жил тутам НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газрын “Гэмт хэргийн чиг, хандлагын судалгаа”-ны 267 гаруй үзүүлэлтээс, 148 үзүүлэлт, асуулгыг буюу 56 орчим хувийг гарган хүргүүлж байна. Үлдсэн 44 хувьд хамаарах үзүүлэлт нь манай Эрүүгийн хуульд томьёологдоогүйгээс хуулийн байгууллагуудаас судалгаа нь гарах боломжгүй эсхүл гэмт явдалд хохирох явдлын судалгаа зэрэг чанарын судалгаа хийх ёстой боловч хийгдэхгүй байгаатай холбоотой.

Статистикийн тухай хуулийн дагуу ҮСХ-оос албан ёсны статистикийн хүрээнд гаргаж, нийтэд тархаадаг 48 багц үзүүлэлтийн 6 багц нь шүүхийн статистикийн үзүүлэлт байгаа юм. Хэдий хуульд гэмт хэргийн статистикийг зөвхөн шүүхийн статистикийн 6 багц үзүүлэлтээр төлөөлсөн боловч, ҮСХ хууль сахиулах, шүүх эрх мэдлийн 4 байгууллагын гэмт хэргийн статистикийн мэдээллийг цуглуулж нэгтгэн нийтийн хүртээл болгож байна.

Эдгээр мэдээлэл нь Үндэсний статистикийн хорооны Хүн ам, нийгмийн статистикийн газарт нэгтгэгдэн улсын хэмжээний нийгэм, эдийн засгийн байдалд тусч, улмаар төр засгийн холбогдох байгууллага, албан тушаалтнуудын түвшинд танилцуулагдаж, НҮБ-ын статистикийн төв байгууллага зэрэг олон улсын байгууллагад хүргэгддэг.

Мэдээллийн сан бүрдүүлэх, нэгдмэл байдлыг хангахад тулгамдаж буй асуудал

1. БОАЖЯ-аас салбарын яамны статистикийн мэдээллийг нийтэд хүртээмжтэй тархаах шаардлагатай.

2. БОАЖЯ-аас хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагатай хамтран мэдээлэл солилцох, тайлагнах, нийтийн хүртээл болгох ажиллагааг харилцан зөвшилцөж, хамтарсан журмаар зохицуулан мөрдүүлэх шаардлага байна.

3. БОАЖЯ-ны мэдээллийн сан бүрдүүлэлтийг хөгжүүлэх, байнгын ажиллагаанд оруулах шаардлагатай байна.

4. 1212.mn, eic.mn гэсэн цахим хуудас дахь мэдээллийг баяжуулах, хөгжүүлэлт хийх.

3. Мэргэжлийн хяналтын байгууллагын мэдээлэл, судалгаа

Хувийн хэвшлийн байгууллагад хийж буй хяналт шалгалтын ачаалал, давхардал, давтамжийг бүртгэх зорилго бүхий “Нэгдсэн цахим мэдээллийн сан” бий болгох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн № 59 тоот захирамжийн хүрээнд 2016 оны 01 сарын 01-ээс “Шилэн хяналтын цахим систем”-ийг Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Тус системийн ашиглалтын байдал болон хяналт шалгалтын мэдээллийг алдаагүй, үнэн

зөв бүртгэсэн байдалд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрсдэлийн удирдлага, стратеги төлөвлөлтийн газар хяналт тавин ажилладаг.

Тус газарт газрын болон хэлтсийн дарга, эрсдэлийн удирдлага хариуцсан ахлах мэргэжилтэн 1, эрсдэлийн үнэлгээ, хяналт шалгалтын гүйцэтгэлийн мэдээллийн сан хариуцсан 2 мэргэжилтэн, стратеги төлөвлөлт хариуцсан 2 мэргэжилтэн ажиллаж байна.

SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
Төрийн хяналтын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод нээлттэй, хүртээмжтэй болгох зорилгоор Засгийн газрын санаачилгаар байгуулсан “Шилэн хяналтын цахим систем”-ийг Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж, улсын байцаагч, бизнес эрхлэгчдийн өдөр тутмын хэрэглээ болгон бизнес эрхлэгчдэд ээлтэй, иргэд олон нийтэд ил тод нээлттэй болсон. Төрийн байгууллага, түүний дотор хяналт шалгалтын байгууллагуудаас хяналт шалгалт, зөрчил, арга хэмжээний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, мэдээллийн сангаас статистикийн мэдээлэл боловсруулан гаргадаг, дүн шинжилгээ хийж, мэдээллийн технологийн дэвшлийг эрчимтэй нэвтрүүлэн ажиллаж байна. Лабораторийн шинжилгээний аюулгүйн үзүүлэлтийг нэмэгдүүлэх, салбарын хууль тогтоомжид аюулгүй байдалд суурилсан зохицуулалтыг бий болгох зорилгоор шилэн хяналтын цахим системд оруулсан лабораторийн шинжилгээний үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг боловсруулахаар ажиллаж байна. Цахим хяналтын систем нэвтрүүлэх талаар авсан арга хэмжээний үр дүнд төлөвлөгөөт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээний төлөвлөлт, гүйцэтгэл, мэдээллийн сангууд цахим хэлбэрт шилжиж мэргэжлийн хяналтын байгууллага хяналт шалгалтын байгууллагуудаас анх удаа бүх хяналт шалгалтын төлөвлөлт, гүйцэтгэл, явц, үр дүнг аж ахуйн нэгжээр түүхчилсэн цахим системд нэвтрэх боломж бүрдсэн. Хяналт шалгалт болон шалгуулагч байгууллага шалгалтын тухай мэдээлэл оруулах, шалгалтын хуваарийн нэгтгэх, нэг байгууллага хэдэн удаа шалгагдсан тоо,	1. Мэргэжлийн хяналтын байгууллагын хэмжээнд мэдээллийн сангийн бүрдүүлэлт, хяналт шалгалтын цахим систем хариуцан ажиллаж байгаа алба хаагчдыг статистикийн чиглэлээр мэргэшүүлэх зайлшгүй шаардлагатай. 2. Мэдээллийн сангийн ачаалал, сүлжээний хурднаас шалтгаалан мэдээ мэдээлэл боловсруулах үйл явц удаашралтай.

давхардлыг хянах, нийтлэг гардаг зөрчлийг тодруулах, зөрчлүүдийн мэдээллийн санг ашиглан бодлого, төлөвлөгөө боловсруулах боломжийг бий болгох, шалгалтын үр дүнд хийсэн зөвлөгөө, сургалтын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх зорилгыг хэрэгжүүлэх хэрэгсэлтэй болсон нь хамгийн чухал үр дүн юм.	
Боломж	**Эрсдэл**
1. Үндсэн чиг үүргийн хүрээнд тоо бүртгэл хөтөлдөг бусад байгууллагатай жишиж үзвэл мэдээллийн сангийн бүрдүүлэлт, суурь бааз сайтай. Хяналт шалгалттай холбоотой мэдээ мэдээллийг аж ахуй нэгж, байгууллагууд www.khyanalt.gov.mn хаягаар холбогдон төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах эсэх, хяналтын хуудасны үнэлгээ, зөрчил, авсан арга хэмжээний талаарх мэдээллээ тоон гарын үсгээр нэвтрэн авах боломжтой.	1. Мэдээллийн сангийн ачааллаас шалтгаалан зарим тохиолдолд цаг хугацаа алдах, цахим систем гацах гэх мэт алдаа үүсдэг учир мэдээллийн сангийн өгөгдлийн баазыг өргөтгөх. 2. Анхан шатны мэдээллийг оруулж байгаа улсын байцаагчид /шинэ/ хяналт шалгалтын мэдээ мэдээлэл, мэдээллийн сангийн талаар тодорхой ойлголтгүйгээс мэдээлэл буруу, зөрүүтэй орох эрсдэлтэй.

Дэд санал

1.“Шилэн хяналтын цахим систем”-ийг хөгжүүлэх, хяналт шалгалтын мэдээллийн баазыг бэхжүүлэх, хадгалалтыг сайжруулах зорилгоор сүүлийн үеийн өндөр хүчин чадал бүхий сервер, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэх;

2. Эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн сан хариуцсан алба хаагчдын тоог нэмэгдүүлэх, мэргэшүүлэх;

3. Статистикийн чиглэлээр ажиллаж байгаа алба хаагчдыг хосолсон мэргэжлээр (статистикч) богино болон урт хугацааны сургалтад хамруулах, гадаад орны туршлага судлуулах;

4. Төрийн хяналт шалгалтын статистикийн мэдээллийн чанар, хүртээмжийг дээшлүүлэх;

5. Хяналт шалгалтын чиг үүрэг бүхий байгууллагуудын мэдээллийн нэгдсэн сантай болох;

6. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж,

7. Хяналт шалгалтын цахим санг төрийн цахим мэдээлэл солилцох системд холбох;

8. Гар утасны аппликэшнээр дамжуулж хяналт шалгалтын тухай мэдээллийг аж ахуйн нэгж байгууллагуудад түргэн шуурхай, ил тодоор хүргэх гэсэн саналуудыг дэвшүүлж байна.

4. Гаалийн байгууллагын мэдээлэл, судалгаа

Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхыг бэхжүүлэх эрхэм зорилго бүхий Гаалийн ерөнхий газар нь 1912 оны 6 дугаар сарын 02-нд анх байгуулагдсан түүхтэй.

ГЕГ нь харьяа 18 газар, хороодтой бөгөөд илрүүлсэн зөрчил тус бүрийг тухайн газар, хороонд харьяалах прокурорын газарт зөрчлийн материалын хамт хүргүүлэн хянуулж ажилладаг.

Гаалийн болон бусад хууль тогтоомжид заасны дагуу гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гэмт хэргийн шинжтэй үйлдэлд хойшлуулшгүй ажиллагаа явуулах, хуульд заасан хариуцлага ногдуулах, зөрчлийн хэрэг бүртгэлт хийх, зөрчлийн талаарх мэдээллийг нягтлан шалгаж, шийдвэрлэх үндсэн чиг үүрэг бүхий Гаалийн ерөнхий газрын Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газар нь гаалийн байгууллагаас илрүүлсэн зөрчлийн мэдээллийн санг бүрдүүлж ажилладаг.

Судалгаагаар мэдээллийн сан бүрдүүлэх, нэгдмэл байдлыг хангахад тулгамдаж буй тулгамдсан асуудал байна гэж үзсэн. Үүнд:

Гаалийн байгууллагын алба хаагчдад дараах хүндрэлтэй байдал үүсэж байна. Үүнд:

-Тухайн бараа, эд зүйлийг таних боломжгүй,

-Зөрчилд холбогдсон барааны үнийг тодорхойлох боломжгүй,

-Зөрчилд холбогдох бараа, эд зүйлтэй холбоотойгоор шинээр гарсан эрх зүйн зохицуулалтын талаарх мэдээлэл хомс,

- Зөрчилд холбогдох бараа, эд зүйлтэй холбоотойгоор ашиглах гарын авлага байхгүй.

Эдгээр асуудал нь гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, бүртгэх явцад үүсэх хүндрэлүүд бөгөөд зөрчлийн мэдээллийн санг хөгжүүлэх, мэдээллийг цуглуулах, боловсруулах, бусад байгууллага, иргэдтэй мэдээлэл солилцох, түгээх явцад үүсэж буй хүндрэлийн талаар санал хүсэлтээ илэрхийлээгүй болно.

Дотоод хэргийн их сургуулийн 2020 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн “Тайланд санал авах тухай” 03/848 дугаар албан бичгээр хүргүүлсэн хүсэлтийн хариуд Гаалийн ерөнхий газраас 2020 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 01-2/2899 дугаар албан бичгээр ирүүлсэн саналд:

1. ГЕГ-ын хувьд эрсдэлийг тодорхойлоход хугацааны хувьд тохиромжгүй байна. Иймд байгаль орчны мэдээллийн сан, түүний төрөл бүрдүүлэлтийн хугацаа болох “жил бүрийн 2 дугаар сарын 20-ны дотор улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ” гэх хугацааг улирал бүр, нэгдсэн мэдээллийг жил бүрийн 2 дугаар сарын 20-ны дотор улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ гэж оруулах,

2. Монгол Улсын Хилийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.16-д “хилийн хяналтын байгууллага” гэж “улсын хил нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хяналт шалгалт явуулах, бүртгэх эрх бүхий улсын хил хамгаалах, гааль, мэргэжлийн хяналт, гадаадын иргэн, харьяатын байгууллагыг” гэж тодорхойлсон учир эдгээр байгууллагуудын нэгдсэн мэдээллийн сангийн үзүүлэлт бий болгох боломжтой эсэхэд шинжилгээ хийлгэх саналаа илэрхийлсэн бөгөөд хилийн хяналтын байгууллагын мэдээллийн нэгдсэн санг Прокурорын нэгдсэн сантай холбох эрх зүйн орчин болон нууцлалын зэргийн мэдээлэлтэй танилцах эрх бүхий албан тушаалтан, нийтэд түгээх мэдээллийн үзүүлэлт гэж ангилж нэмэлт захиалгат судалгаа явуулах нь үр дүнд хүрэх магадлалыг бий болгоно гэсэн байна.

5. Шүүхийн байгууллагын мэдээлэл, судалгаа

2008 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн 17 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Шүүхийн статистикийн мэдээлэл, тайлан гаргах журам”, хоёрдугаар хавсралтаар “Шүүхийн статистикийн мэдээллийн маягт”-ын загвар батлагдан өнөөг хүртэл хүчин төгөлдөр үйлдчилж мэдээ, тайланг гаргах, нэгтгэн боловсруулах ажил хийгдэж байна.

2018 онд Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн болон Зөрчил шалган шийвэрлэх тухай хуулиуд шинэчлэн боловсруулагдаж, 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2018 оны 20 дугаар тогтоолоор “Шүүхийн статистикийн мэдээлэл, тайлан гаргах журам” шинэчлэгдэн бол, атлагдсан. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2018 оны 21 дүгээр тогтоолоор Эрүүгийн хэргийн бүх шатны шүүхийн гэмт хэргийн статистикийн маягт, заавар, зөрчлийн хэргийн анхан давж заалдах шатны шүүхийн статистикийн маягт, заавар батлагдан, бүх шатны шүүхэд мөрдөгдөж байна.

Шүүхийн статистикийн үйл ажиллагааг эрүү, зөрчлийн хэргийн статистикийг 1 хүн, иргэн, захиргааны хэргийн статистикийг 1 хүн, нийт 2 хүн эрхлэн гаргадаг ч тухайн алба хаагчдын харьяалагдаж буй газар, нэгж нь энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаггүй ажээ.

Судалгааны дараах үр дүн гарсан. Үүнд:

Гэмт хэргийн статистик зүйн онол, арга зүйг хөгжүүлснээр цагдаагийн байгууллага, авлигатай тэмцэх газар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, прокурор, шүүхийн гэмт хэргийн статистикийн маягт, арга зүйг боловсронгуй болгох ач холбогдолтой. Улмаар гэмт хэргийн талаарх статистикийн мэдээллийн нэгдмэл байдал, уялдаа холбоо хангагдаж, үнэн бодитой статистик мэдээллийн үндсэн дээр гэмт

хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх төрийн бодлого оновчтой хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

Хууль зүйн чиглэлийн бүхий л судалгаа, тайлан боловсруулах, өгүүлэл нийтлэл бичихэд гэмт хэргийн тоон мэдээлэл, үзүүлэлт гарцаагүй шаардагддаг бөгөөд тухайн статистик мэдээнд дүн шинжилгээ хийснээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, шүүн таслах ажиллагаанд хяналт тавих гэх мэт асуудлууд урган гарч ирдэг. Түүгээр зогсохгүй хууль зүйн салбарын их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын багш, судлаачид судалгаанд суурилсан олон улсын чанарын шаардлагад нийцсэн эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлэх, бодлогын ажил гүйцэтгэхэд судалгааны арга зүйн мэдлэг, чадварыг бүрэн эзэмшсэн байхыг шаардаж байна. Дээрх шаардлагад нийцүүлэн дараах саналыг гаргаж байна.

1. Шүүхэд статистикийн үйл ажиллагаа дагнан эрхлэх тусгайлсан нэгж байгуулах,

2. Шүүхэд статистикийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх,

3. Эрүү, зөрчлийн хэргийн бүртгэлийн маягтын асуулгуудыг нарийвчлан дэлгэрүүлэх шаардлагатай байна.

6. Прокурорын байгууллагын мэдээлэл, судалгаа

УЕПГ-ын Бүртгэл мэдээллийн технологийн алба нь хэрэг, зөрчлийн мэдээллийн сан бүрдүүлэх, статистикийн мэдээлэл гаргах, тайлагнах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

Прокурор нь дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:

1. Зөрчлийн хэрэг бүртгэлд тавих прокурорын хяналт
2. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналт
3. Прокурор төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд оролцох
4. Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах
5. Мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажилд хяналт тавих
6. Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих
7. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэх ажиллагаа зэрэг хуульд заасан үйл ажиллагааг явуулдаг.

Судалгааны дараах үр дүн гарсан. Үүнд:

SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
1. Прокурорын байгууллага нь гэмт хэргийн нэгдсэн мэдээллийн сан ашигладаг. 2. Прокурорын байгууллагаас эрүүгийн хэргийн дугаар олгохдоо цахим сангаас олгодог.	1. Прокурорын байгууллагаас гаргадаг мэдээний маягтыг Үндэсний статистикийн хороогоор 2005 оноос хойш шинэчлэн батлуулаагүй. 2. Прокурорын байгууллагаас гаргадаг гэмт хэргийн статистик мэдээ

3. Прокурорын байгууллага нь үйл ажиллагааны хувьд хэрэг бүртгэх, мөрдөх байгууллага, шүүх, шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын дунд байдаг тул мэдээллийн бүхий л урсгал дамждаг. 4. Шүүх, прокурорын байгууллага цахим системийн тусламжтайгаар мэдээлэл солилцдог, эрүүгийн хэргийн мэдээлэл давхардал үүсдэггүй. 5. Прокурорын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг мэдээллийн сангаараа дамжуулан нэгжүүддээ түгээдэг болсон. Цахим бүртгэл өдөр тутмын үйл ажиллагаанд хэвшил болсон. 6. Прокурорын байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны мэдээллээс гэмт хэргийн статистик тоо баримт бүрдэж, хүссэн цаг хугацааны интервалаар нэгтгэгдэн гардаг. 7. Дүн шинжилгээ судалгаа, хяналт, шалгалтын хэлтсээс улсын хэмжээний гэмт хэргийн мэдээллийг нэгтгэн харж болдог, энэ нь цаг хугацаа алдахгүй хялбар болсон. 8. Сар бүр дүн шинжилгээ хийж нэгжүүдийн үйл ажиллагаанд дүгнэлт хийдэг.	олон нийтэд нээлттэй биш. 3. Прокурорын байгууллагад статистикийн чиглэлээр дагнасан боловсон хүчин байхгүй. 4. Үндэсний статистикийн хорооноос гардаг гэмт хэргийн урсгал мэдээн дээр прокурорын байгууллагын мэдээ бүрэн байдаггүй.
Боломж	Эрсдэл
1. Прокурорын байгууллага хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавьдаг учраас гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтийн статистик тоо баримтыг авах боломжтой. **2.** Эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийн нэгдсэн мэдээллийн сан прокурорын байгууллагын мэдээллийн санд төвлөрөх боломжтой. **3.** Бусад төрийн байгууллагатай харилцан мэдээлэл солилцох боломжтой. **4.** Цахим нэгтгэл төслийн хүрээнд шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага харилцан мэдээлэл солилцоход прокурорын байгууллагын мэдээллийн сан үндсэн	1. Цахим мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, мэдээллийн системийн шинэчлэлийг тодорхой хугацаанд хийхэд төсвөөс шалтгаалах. 2. Лицензтэй программ хангамж ашиглах, боловсон хүчнийг бэлтгэх зэрэгт санхүүгийн асуудлууд тулгардаг.

суурь болох боломжтой. **5.** Үндэсний статистикийн хороонд прокурорын байгууллагын цахим сангаас гарч байгаа гэмт хэргийн шийдвэрлэлийн тоон мэдээг хүргүүлэх боломжтой.	

Дэд дүгнэлт

Прокурорын байгууллага ч мөн адил Улсын ерөнхий прокурорын тушаалаар хууль, тогтоомжид нийцүүлэн гэмт хэргийн мэдээ мэдээллийг бүртгэх, дамжуулах болон, дотоод үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалтын ажил үйлчилгээгээ өргөжүүлэн тэлэх үүднээс өөрийн гэсэн цахим сан бий болгон, түүнийгээ өргөжүүлэн үр дүнтэй ашиглаж байна.

Прокурорын байгууллагын зөрчлийн хэргийн мэдээллийн сан бүрдүүлэлт нь зөрчлийн хэрэг бүртгэх эрх бүхий байгууллагуудын мэдээллээс бүрддэг бөгөөд хэрэг бүртгэх эрх бүхий байгууллагуудын мэдээлийн сантай холбогдон нэгдсэн цахим сан бий болгох шаардлагатай байна.

Цаашид БОАЯЖ, бусад байгууллагатай мэдээлэл солилцох, тайлагнах журам баталж мөрдүүлэх, зөрчлийн тухай мэдээллийг олон нийтэд тайлагнах журам баталж мөрдүүлэх нь зүйтэй.

Дэд санал

1. Прокурорын байгууллагын цахим мэдээллийн сангаас гаргаж буй гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтийн статистик мэдээллийг Үндэсний статистикийн хороонд тодорхой хугацааны давтамжтайгаар хүргүүлэх, Үндэсний статистикийн хорооноос гаргадаг гэмт хэргийн албан ёсны статистикийн үзүүлэлтэд тусгуулах;
2. Прокурорын байгууллагын цахим мэдээллийн сангаас гаргаж буй гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтийн статистик мэдээллийг НҮБ-ын шаардлага, олон улсын гэмт хэргийн чиг хандлагын судалгааны маягт, үзүүлэлтүүдэд нийцүүлэх талаар тодорхой ажлуудыг гүйцэтгэх;
3. Прокурорын байгууллагын цахим мэдээллийн сангаас гаргаж буй гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтийн талаарх мэдээллийн сан, статистик мэдээллийг хууль сахиулах, шүүхийн статистик мэдээлэлтэй уялдуулах;
4. БОАЖЯ, бусад байгууллагатай мэдээлэл солилцох, тайлагнах журам баталж мөрдүүлэх,
5. Мэдээллийг олон нийтэд тайлагнах журам баталж мөрдүүлэх нь зүйтэй.
6. Хүрээлэн байгаа орчны эсрэг буюу Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлэгт заасан зүйл, хэсгээр хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгаад хаасан, зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд шилжүүлсэн, зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанаас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шилжүүлсэн

болон шийдвэрлэлтийн талаар тоон үзүүлэлт бүрэн гарч байхаар статистик мэдээнд тусгуулах;

7. Гэмт хэрэг, зөрчил түүнтэй холбоотой гомдол, мэдээллийг “аль байгууллагаас шилжиж ирсэн, аль байгууллага шалгасан болон ямар байгууллага, хэрхэн шийдвэрлэсэн зэрэг нь харагдах боломжтой байхаар бүртгэлийн маягтын үзүүлэлтийг хөгжүүлэх саналыг дэвшүүлж байна.

7. Цагдаагийн байгууллагын мэдээлэл, судалгаа

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн А/159 дүгээр тушаалаар байгуулагдсан ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Статистик, мэдээллийн хэлтэс нь цагдаагийн байгууллагын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлийн статистикийн хариуцсан ажиллаж байна.

Статистик, мэдээллийн хэлтэс нь Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээллийн сан бүрдүүлэх”, “Зөрчлийн мэдээллийн сан бүрдүүлэх” журмуудыг мөрдлөг болгон ажилладаг. Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд нэвтрэх эрхийн дагуу цагдаагийн алба хаагч нь сүлжээнд нэвтэрч гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг бүртгэлд оруулна. Тэдгээр мэдээллийг тасгийн дарга хянаж баталгаажуулах ба цагдаагийн байгууллагын нэгж бүрт мэдээлэл судалгаа хариуцсан алба хаагч ажиллан төвлөрсөн тоо бүртгэлийн ажиллагаа явуулна.

ЦЕГ-ын даргын 2017 оны “Жагсаалт батлах тухай” А/100 дугаар тушаалд зааснаар гэмт хэргийн тухай нийт 9 төрлийн мэдээ, 3 төрлийн судалгааг тухайн оны 1-11 дүгээр сарын 25-ны өдрөөр тасалбар болгон нэгтгэж холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахаар хүргүүлнэ. Гэмт хэргийн тухай мэдээллийг цагдаагийн байгууллагын police.gov.mn цахим сайтад тогтмол байршуулж хэвшжээ.

Судалгааны дараах үр дүн гарсан. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн өгөгдөл, маягт, статистикийн мэдээллийн үзүүлэлтэд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг нарийвчлан тусгах замаар мэдээллийн бааз дахь өгөгдлийг баяжуулах,

2. Цагдаагийн байгууллагаас хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг бусад байгууллагатай харилцан солилцдог, нийтэд ил тод болгоход холбогдох байгууллага, ялангуяа байгаль орчны салбарын байгууллагатай нягт хамтран ажиллах,

3. Цагдаагийн байгууллагаас сар бүр, жил бүр гаргадаг хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн статистикийн мэдээлэл, түүнд дүн шинжилгээ хийсэн танилцуулга, мэдээллийг байгаль орчны

мэдээллийн сангаар дамжуулан нийтэд ил болгох журам тогтоон хэрэгжүүлэх,

4. Цагдаагийн газрын мэдээллийн санд дан ганц гэмт хэрэг, зөрчил, ховор ургамал, ан амьтны талаарх мэдээлэл бус, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж байгаа алба хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор танин мэдэхүйн чанартай мэдээлэл, хичээл зэргийг байршуулах,

5. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн сан бүрдүүлж буй маягтад “Халдлагын зүйл” гэсэн өгөгдөл нэмж оруулах (Халдлагын зүйл гэж өгөгдөлд гэмт хэрэгт өртсөн ан амьтан, химийн хорт бодис, ургамал гэх мэт зүйлийн нэр төрлийг тусгаж байвал сангаас халдлагад өртөж буй зүйлийн нэр төрөл, тоо хэмжээ тодорхой харагдах боломж бүрдэнэ) зэрэг саналтай байна.

8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдээлэл, судалгаа

ШШГЕГ-ын даргын 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/72 дугаар тушаалаар Хорих ял эдлүүлэх албаны харьяанд Нэгдсэн тоо бүртгэлийн хэлтэс байгуулагдаж, хоригдол, хоригдогсодтой холбоотой мэдээ, судалгааг тус хэлтсийн хорих ял эдлүүлэх ажиллагааны судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн хариуцан ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус хэлтэс нь тасгийн дарга 1, ахлах мэргэжилтэн 2, мэргэжилтэн 2, нийт 5 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа бол Шийдвэр гүйцэтгэх газрын Мэдээлэл лавлагаа, дүн шинжилгээний хэлтэс нь тасгийн дарга 1, ахлах мэргэжилтэн 1, мэргэжилтэн 5 хүний орон тоотойгоор тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Шийдвэр гүйцэтгэх албаны Мэдээлэл лавлагаа, дүн шинжилгээний хэлтэс нь Улсын хэмжээний гүйцэтгэх баримт бичгийн цахим сан, түүний баяжилт, хорих ангид ял эдэлж буй төлбөртэй хоригдлын төлбөр барагдуулалтын судалгаа, өртэй этгээдийн бүртгэл, шүүхийн шийдвэрээр өр төлбөргүй талаарх лавлагаа, гүйцэтгэх баримт бичгийн бүртгэлийн программ хангамж, аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба, БХЗХТБАА-ыг холбосон шилэн кабелийн дэд бүтэц, бүртгэлийн болон холбогдох бусад байгууллагаас төлбөр төлөгч нарын мэдээлэл авах, уг мэдээллийг шийдвэр гүйцэтгэгч нарт хүргэх ажлыг хариуцан ажиллаж байна.

ШШГЕГ-ын даргын 2020 оны А/74 дүгээр тушаалаар Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны Хорихоос өөр төрлийн ялын бүртгэл хяналтын хэлтэс байгуулагдсан бөгөөд тус хэлтэс нь дарга 1, ахлах мэргэжилтэн 1, мэргэжилтэн 4, нийт 6 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж, хорихоос өөр төрлийн ялын гүйцэтгэлийн мэдээ, судалгааг гарган ажилладаг байна.

Судалгаагаар мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийн нэгдмэл байдлыг хангахад тулгарч буй бэрхшээл байна гэж үзсэн. Үүнд:

Судалгаанд оролцогчдоос мэдээллийн сан бүрдүүлэлтийн талаарх таны сэтгэгдэл? гэсэн асуултад мэдээллийн нэгдсэн системийн бүртгэл, баяжуулалт, ашиглалт, түгээлтийн асуудлаар тулгамдсан асуудал байхгүй, үйл ажиллагаа хэвийн харин мэдээ гаргах, шийтгэх тогтоолыг санд оруулах зэрэг зарим асуудлыг илүү боловсронгуй болгох шаардлага байна гэсэн хариултыг өгсөн юм.

ДХИС-ийн 07 дугаар сарын 09-ний өдрийн “Тайланд санал авах тухай” 03/848 дугаар албан бичгээр хүргүүлсэн хүсэлтийн дагуу ШШГЕГ-аас 2020 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 02/3955 дугаар албан бичигт хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн мэдээллийн нэгдсэн санд дараах мэдээллийг нэгтгэх боломжтой гэсэн байна. Үүнд:

1. Хорих ял эдлүүлэх албаны “Нэгдсэн тоо бүртгэлийн хэлтэс”-ээс Эрүүгийн хуулийн 24 дүгээр зүйл ангид хамаарах гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн, яллагдагч, хоригдогсдын ял хэргийн болон хувийн зан байдал, ял эдэлж буй байдал зэрэг хууль тогтоомжоор хориглоогүй ерөнхий мэдээлэл;

2. Шийдвэр гүйцэтгэх албаны “Мэдээлэл лавлагаа, дүн шинжилгээний хэлтэс”-ээс хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг үйлдэж, шүүхийн шийдвэрээр төлбөр тогтоосон төлбөртэй хоригдол, бусад этгээдийн төлбөр барагдуулалтын мэдээлэл;

3. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны “Хорихоос өөр төрлийн ялын бүртгэл хяналтын хэлтэс”-ээс хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг үйлдэж шүүхийн шийдвэрээр хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ шийтгүүлсэн ялтан, этгээдийн талаарх гүйцэтгэлийн мэдээлэл зэргийг дрьджээ.

9. Хил хамгаалах байгууллагын мэдээлэл, судалгаа

Хил хамгаалах байгууллага нь төрийн байгууллага болохын хувьд төрийн үйл ажиллагааны болон хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай статистикийн үйл ажиллагааг эрхлэн явуулж байна. Хилийн анги салбар, заставаас 24 цагийн туршид хилийн бүс, зурваст явагдаж байгаа үйл ажиллагаа, зөрчлийн талаарх “хилийн хоногийн нөхцөл байдлын мэдээ”-г шуурхай удирдлага, мэдээлэл нэгтгэн боловсруулах төвд хүлээн авдаг төдийгүй хилийн бүс нутагт үйлдэгдсэн зөрчлийг газар зүйн мэдээллийн программд оруулж, цаг хугацаа, орон зайн нарийвчлалтай мэдээллийг боловсруулж мэдээллийн санд нэгтгэж байна.

Статистик мэдээлэл авах журам, мэдээний маягт, үзүүлэлт нь нууцын зэрэгт хамаарагддаг бөгөөд боловсруулсан статистик мэдээллийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, ХЗДХЯ-д танилцуулах, шаардлагатай

тохиолдолд төрийн бусад байгууллагын хүсэлтээр нууцад хамааралтагаас бусад мэдээллийг гарган өгдөг байна.

Монгол Улсын Хилийн тухай болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай статистик мэдээллийг Хил хамгаалах ерөнхий газрын даргын тушаал, шийдвэрийн дагуу гарган, боловсруулж, мэдээлж байна. ХХЕГ нь өөрийн веб сайт буюу http://bpo.gov.mn/content/512 цахим хаягаар дамжуулан иргэд, аж ахуй нэгж, албан байгууллага буюу нийт зориулж, сар бүрийн инфографик мэдээллийг дараах үзүүлэлттэйгээр боловсруулан нийтэд түгээж байна.

Судалгааны дараах үр дүн гарсан. Үүнд:

Хил хамгаалах байгууллагын хэрэг, зөрчлийн статистикийн үйл ажиллагааны давуу болон сул тал, тулгарч болох эрсдэлүүд, тэдгээрийг даван туулах арга замыг дараах байдлаар тодорхойлж болохоор байна.

Давуу тал	Сул тал
Хүрээлэн байгаа орчны эсрэг хэрэг, зөрчлийн мэдээллийг 24 цагийн турш хүлээн авдаг.	Статистик мэдээллийг энгийн хэрэглээний excel программаар боловсруулдаг, зориулалтын нэгдсэн программ ашигладаггүй учраас статистикийн программын хөгжүүлэлт байхгүй, систем хөгжөөгүй.
	Мэдээлэл бүртгэдэг арга зүй дутмаг.
Мэдээллийг олон үзүүлэлтээр дэлгэрэнгүй гаргадаг	Статистикийг ихэнх мэдээлэл нууцын зэрэгт хамаардгаас шалтгаалан бусад байгууллагад мэдээлэл хүргэх, танилцуулах, иргэдэд түгээхэд учир дутагдалтай, хүндрэлтэй.
Мэдээллийг газар зүйн мэдээллийн програмд оруулж боловсруулдаг	Статистик мэдээллийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Хууль зүй, дотоод хэргийн яаманд танилцуулдаг учраас бусад байгууллагатай мэдээлэл солилцох боломж байгууллагын онцлогоос шалтгаалан хаалттай.
	Статистик мэдээллийг ихэвчлэн дотоодоо ашигладаг.
	Статистик мэдээллийг статистикийн мэргэшсэн алба хаагчгүй байна.
Боломж	Эрсдэл
Мэдээллийг бүртгэх, боловсруулах програм хангамжийг бий болгож хөгжүүлэх боломжтой	Хилийн аюулгүй байдлыг хангах байгууллагын хувьд статистик мэдээллийн боловсруулалтыг мэргэшсэн алба хаагч, зориулалтын технологийн дагуу явуулахгүйгээс мэдээлэл алдагдах эрсдэл үүсэж болзошгүй.
Хэрэг, зөрчлийн бүртгэл мэдээллийг хариуцсан нэгжийн үйл ажиллагааг өргөжүүлэх боломжтой.	Харилцан мэдээлэл солилцох байдал нь төрийн байгууллагуудын хувьд хүндрэлтэй байх нь гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлнө.

Дэд дүгнэлт

Хил хамгаалах байгууллагын онцлогтой холбоотойгоор хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн статистикийг зөвхөн байгууллагын хэмжээнд, хууль тогтоомжийн хүрээнд гаргаж н. Өөрөөр хэлбэл, мэдээллийн түгээлт хязгаарлагдмал.

Гэсэн хэдий ч хил хамгаалах байгууллагын статистикийн мэдээллээс гэмт, хэрэг зөрчилтэй холбоотой мэдээлэл нь хил орчмын бүсэд үйлдэгдэж байгаа хэрэг, зөрчлийн байдлыг үнэлэх, хэмжих, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд үр ашигтай бодлого боловсруулах, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ зохион байгуулахад ашиглах, хилийн боллон хуулийн байгууллагын хамтын ажиллагаанд чухал ач холбогдолтой гэдгийг хаа хаанаа ойлгож ажиллах шаардлагатай байна.

Дэд санал

Аливаа байгууллагын статистик мэдээ нь тухайн байгууллагын дотоодын хэрэгцээнд болон нийтэд зориулагдсан гэж ангилагдах бөгөөд Мэдээллийн ил тод байдлыг хангах хуулийн дагуу иргэдэд зориулагдсан мэдээллийг тусгайлан боловсруулж нэг урсгалд оруулах зорилгоор дараахи стратеги саналыг дэвшүүлж байна.

1. Хил орчим үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистикийн үзүүлэлт, маягт, журам, зааврыг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр баталгаажуулах,

2. Статистик мэдээллийг байгууллагын онцлогт тохирсон, нууцлалтай, цаашид хөгжүүлэх, өргөтгөх боломжтой программ хангамж дэд бүтэц, тогтолцоог бий болгох,

3. Эрх бүхий албан тушаалтан шаардлагатай мэдээллийг холбогдох журмын дагуу авч ашигладаг байх нөхцөлийг бүрдүүлэх.

Нэгдсэн дүгнэлт, санал, зөвлөмж

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт явдалтай тэмцэхэд байгаль орчны салбарын болон төрийн зарим байгууллагын мэдээллийн сангийн өгөгдөл, статистик үзүүлэлт, бүрдүүлэлт /аргачлал/, мэдээллийн уялдаа, тархаалт, ашиглалт, удирдлага зохион байгуулалт, нууцлал зэргийг судлан, цаашид мэдээллийг нэг урсгалд оруулан дундын мэдээллийн сан үүсгэх боломж, түүний ач холбогдол, салбар дундын зохицуулалт, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, мэдээллийг ашиглах, тархаах, нууцлал болон ил тод, мэдээлэл авах иргэдийн эрхийг хангах эрх зүйн орчныг бий болгоход чиглэсэн санал, зөвлөмжийг дэвшүүлэхэд зорилгоор энэхүү судалгааны ажлыг хийлээ.

Судалгааны ажлын хүрээнд БОАЖЯ, УУХҮЯ, ШЕЗ, УЕПГ, ЦЕГ, ШШГЕГ, ХХЕГ, ГЕГ, МХЕГ, БОАЖЯ-ны Цаг уур, орчны шинжилгээний газрын Ус, цаг уур, судалгаа мэдээллийн хүрээлэнгийн Байгаль орчны мэдээллийн сан, Үндэсний статистикийн хороо зэрэг байгууллагуудын

холбогдох нэгжийн удирдлага, зохих албан тушаалтнуудтай уулзан мэдээлэл цуглуулж, боловсруулалт хийж, асуудлын мөн чанарыг тодруулан гаргаж ирэхийг эрмэлзлээ.

Монгол Улсын хэмжээнд БОАЖЯ-аас салбарын статистикийн мэдээллийг гаргах маягт, аргачлалыг ҮСХ-оор батлуулан, статистикийн мэдээлэл гаргах, мэдээллийн сан бүрдүүлэхээр ажиллаж байна.

ЦЕГ, ШЕЗ-өөс холбогдох мэдээллээ гарган, нийтэд түгээж байгаа бол, бусад байгууллагуудын тухайд мэдээллийн сан бүрдүүлэлт, статистикийн мэдээлэл гаргалт, нийтэд түгээх, танилцуулах, тайлагнах асуудал шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.

БОАЖЯ-ны харьяа Байгаль орчны мэдээллийн сангийн цахим хуудаст (https://eic.mn/) 20 гаруй бүлгийн, тэр дундаа хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн санг үүсгэн баяжилт хийж байгаа боловч 2016 оноос хойш баяжилт хийгээгүй байна. Цаашид мэдээллийн сангийн цахим хуудсыг тогтмолжуулах, хөгжүүлэх, сайжруулах шаардлагатай.

ҮСХ-ны 1212.mn цахим хуудаст “Хүрээлэн буй орчин”, “Хууль эрх зүй, гэмт хэрэг” булангуудад хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн мэдээ байршуулсныг Байгаль орчны мэдээллийн сангийн цахим хуудастай уялдуулах шаардлагатай нь ч харагдаж байна.

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн сан бүрдүүлэх, статистикийн мэдээлэл гаргах, ашиглах, нийтэд түгээх үүрэгтэй байгууллагуудын үйл ажиллагаа харилцан адилгүй, уялдаа холбоо муу байгаагаас гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа Монгол Улсын хэмжээнд учир дутагдалтай байна гэж дүгнэж байна.

Иймд дараах санал, зөвлөмж, шийдлийг судалгааны үндсэн дээр дэвшүүлж байна. Үүнд:

Нэг. Тогтолцоо, удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1. БОАЖЯ-ны Байгаль орчны мэдээллийн сангийн хэлтэс дэх хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн статистикийн мэдээллийг төвлөрүүлэн нэгдсэн сан бий болгох, тэдний цахим хуудас дахь мэдээллийн өгөгдөл, мэдээллийн үзүүлэлтүүдэд баяжилт хийх,

2. БОАЖЯ-ны Байгаль орчны мэдээллийн сангийн программ хангамж системд хөгжүүлэлтийг хийх,

3. БОАЖЯ-ны Байгаль орчны мэдээллийн системд шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, хил хамгаалах, байгаль орчин, уул уурхай, ашигт малтмал, гааль, мэргэжлийн хяналтын байгууллагууд өөрт олгогдсон кодоор нэвтэрч, шаардлагатай мэдээллийг авдаг байхаар зохицуулалт хийх,

4. Прокурорын байгууллагад төвлөрч байгаа цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг ҮСХ-оос эрхлэн гаргадаг www.1212.mn болон мэдээллийн www.eic.mn системтэй уялдуулах, нийтэд хүртээмжтэй тархаах ажлыг БОАЯЖ, ҮСХ хамтран хэрэгжүүлэх,

5. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн сан, статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийдэг, энэ чигэлээр үйл ажиллагаа явуулдаг практик байгууллагуудын үйл ажиллагаанд хөндлөнгийн мониторинг хийдэг, гадаадын болон дотоодын байгууллагуудтай хамтран ажилладаг чиг үүрэг бүхий think thank судалгааны байгууллагыг ажиллуулах, хөхүүлэн дэмжих бодлого баримталж ажиллах нь энэ салбарын мэдээлэл, судалгааг боловсронгуй болгох, салбарын үйл ажиллагаанд тулгамдсан асуудлыг судалгааны үндэслэлтэй шийдэх боломжийг нэмэгдүүлнэ,

Шийдлийг зураглавал: Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэлт, судалгаа, статистик мэдээлэл боловсруулах, тайлагнах, хэрэглэгчдэд хүргэх, тархаах үйл явцыг дараах байдлаар загварчилж болох юм.

Зураг. Хүрээлэн буй орчны мэдээллийн сан бүрдүүлэлт, тайлагналт, солилцоо, тархаалтын загвар схем



Хоёр. Эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд:

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн сан бүрдүүлэх, статистикийн мэдээлэл боловсруулах, солилцох, тархаах үйл ажиллагааг зохицуулсан хамтарсан журам одоогоор байхгүй байна. Иймд:

6. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн сан бүрдүүлэх, статистикийн мэдээлэл боловсруулах, мэдээлэл солилцох,

/мэдээллээ илгээх, нэгтгэх/, тархаах үйл ажиллагааг зохицуулсан хамтарсан журмыг боловсруулан батлуулж, мөрдөх;

7. ХЗДХЯ, ГХУСАЗЗ-д хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ боловсруулагдан улирал тутам хүргүүлдэг байх,

8. ХЗДХЯ-ны ГХУСАЗЗ-ын Ажлын алба нь байгаль орчны мэдээллийн сантай нягт хамтран ажилладаг байх,

Гурав. Мэдээллийн систем, программ хангамжийг хөгжүүлэх хүрээнд:

9. Шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, хил хамгаалах, байгаль орчин, уул уурхай, ашигт малтмал, гааль, мэргэжлийн хяналтын байгууллагуудын мэдээллийн системийг хөгжүүлэх, харилцан уялдаатай ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх, шаардлагатай техник хэрэгслийн шинэчлэлт хийх,

10. БОАЖЯ-ны Байгаль орчны мэдээллийн сангийн хэлтсийн программ хангамж системийг шинээр хамтран гаргах журамд нийцүүлэн хөгжүүлэх,

Дөрөв. Хүний нөөцийг сургах, чадавхжуулах хүрээнд:

11. Шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, хил хамгаалах, байгаль орчин, уул уурхай, ашигт малтмал, гааль, мэргэжлийн хяналтын байгууллагуудын хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэл солилцох чиг үүргийг хэрэгжүүлж буй нэгж, ажилтнуудын хамтын ажиллагааг сайжруулах, уялдуулах, ажилтнуудыг сургаж, чадавхжуулах, мэдээллээр тогтмол хангалт хийдэг байх зэрэг болно.

ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДСЭН ЭТГЭЭДИЙН ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ АРГА ХЭРЭГСЭЛ, ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

СПОСОБЫ ВОЗДЕЙСТВИЯ НА ПОВЕДЕНИЕ ЛИЦ, СОВЕРШИВШИХ НАСИЛЬСТВЕННЫЕ ПРЕСТУПЛЕНИЯ ПРОТИВ СЕМЬИ И НЕСОВЕРШЕННОЛЕТНИХ, ИХ ПРОБЛЕМНЫЕ АСПЕКТЫ

Г.ДЭЛГЭРСҮРЭН
Баянгол дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлстийн хүүхдийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад
Б.ДАЯДАН-ЭРМЭД
ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Инновацийн төвийн эрдэм шинжилгээ, туршилт судалгааны ажилтан, ахлах дэслэгч
ДЭЛГЭРСҮРЭН.Г
Старший инспектор по делам несовершеннолетних 1-го отдела полиции Баянгольского района, капитан полиции
ДАЯДАН-ЭРМЭД.Б
Научный сотрудник Инновационного центра Объединенного института научных исследований Университета внутренних дел, старший лейтенант

Хураангуй: Хүчирхийлэл үйлдэгчийн зан төлөвт сэтгэл зүйн болон ухамсарт дадал хэвшил олгохын тулд ихээхэн ажил хийж байгаагийн нэг нь “Хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийлсэн этгээдийн зан үйлд нөлөөлөх арга зам”-ыг хэрэглэх явдал гэж үзэх болсон. Энэхүү арга замыг хэрэглэхэд гарч буй үр нөлөө хэр зэрэг байгаа болон цаашид анхаарах асуудлыг тодорхойлоход энэхүү илтгэлийн зорилго юм.

Аннотация: Одна из ключевых задач, направленных на воздействие психологических и сознательных установок поведения преступников заключается в использовании «Пути влияния на поведение лиц, виновных в насильственных преступлениях в отношении несовершеннолетних и женщин». Основная цель доклада заключается в определении степени использования данного подхода и определения проблем, которых необходимо решить в дальнейшем.

Түлхүүр үг: Хүүхэд, эмэгтэйчүүд, гэр бүлийн хүчирхийлэгч, гэр бүлийн хүчирхилэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдэд илрэн гарах шинж тэмдэг, үйлдсэн этгээдэд зан үйлд нөлөөлөх албадлагын арга хэмжээ авах.

Ключевые слова: несовершеннолетные дети, женщины, насилие против семьи, несовершеннолетние подвергшиеся насилию, признаки насилия над женщиной, принудительные меры к лицам, совершивших насильственные преступления над несовершеннолетними и женщинами.

Хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэл нь хүний эрхийн ноцтой зөрчил бөгөөд нас, хүйс, хөрөнгө чинээ, нийгмийн гарал үүсэл, боловсрол зэргээс төдийлөн үл хамаарч төрөл бүрийн хэлбэрээр үйлдэгддэг. Үр дагавар нь хүний сайн сайхан хүсэл мөрөөдөл, өөртөө итгэх итгэл, амьдралын баяр баясгаланг үгүй хийж сэтгэл санаа, эрүүл мэнд, амь нас түүний аюулгүй байдалд ноцтой хохирол учруулж хамгийн эмгэнэлт төгсгөлд ч хүргэх эрсдэлтэй. Үүнийг “гэр бүлийн хүрээнд дэх үйлдэл”, “гэр бүлийн маргаан”, “гэр бүлийн дотоод асуудал”, эсвэл “амьдралд байх л асуудал” гэж практикт хандах, ойлгох нь түгээмэл байсаар байна.

Гэр бүлийн хүчирхийлэл нь санаатай, болгоомжгүй хэлбэрээр үйлдэгдэх, удаан хугацаанд үргэлжлэх, хүмүүс хоорондын зохисгүй харилцаа түүнээс улбаалан гэр бүлийн гишүүдийн эрх, ашиг сонирхлыг зөрчсөн нийгэмд сөрөг үр дагавартай үзэгдэл юм.

Дэлхийн улсуудад төрийн нийтлэг хүлээх үүрэг нь гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага оногдуулах, хохирогчийн эрхийг хамгаалж түүний аюулгүй байдлыг хангах, шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Ялангуяа гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах эрх зүйн механизмыг бүрдүүлэх асуудалд илүүтэй анхаарч байна. Нөгөө талаар хүчирхийлэл үйлдэгчийн зан төлөв, үйлдлийг засах, маргааныг эв зүйгээр шийдвэрлэх хандлагыг төлөвшүүлэх нь үр дүнтэй гэж үзэж байна.

Монгол Улс нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх чиг үүргийг Улсын Их Хурал, Засгийн газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон прокурорын байгууллага, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Цагдаагийн байгууллага болон бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхээр хуульчилсан нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоо бүрдсэнийг харуулж байна.

Сүүлийн үед гэр бүл салалт ихсэх явдал нь гэр бүл хүчирхийллийн гол элемент болж байна гэж судлаач, эрдэмтэд үзсэн байдаг. Өөрөөр хэлбэл хоёр дахь амьдрал зохиоход үүнийг дагаад хүүхдийн хүчирхийлэл үүсдэг байна. Гэр бүл дэх хүүхдийн хүчирхийлэл нь хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, эрүүл мэнд, хөгжил боловсрол, хайр халамж эдлэх, аюулгүй байдлыг нь хангах зэрэг суурь хэрэгцээг нь гачигдуулсны улмаас хүүхдэд гэм хор учруулсан болон учруулахаар завдсан, эсхүл мэдсээр байж хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авааагүй байх явдал бөгөөд хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртөх нь нуугдмал шинжтэй байх бөгөөд үүнийг таньж мэдэх нь мэргэжлийн болон хүүхэдтэй ажилладаг байгууллагуудын үйл ажиллагаанд дутагдалтай байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг таньж мэдэх шинж тэмдэг:

·Байнга өлсгөлөн байх, хог түүх

·Хувийн ариун цэвэр тааруу, бохир хувцаслах нь байнгын шинжтэй байх

·Ядруу бусдыг царайчилсан, хайр хүссэн байдалтай байх

·Цаг агаарт тохиромжгүй хувцаслах

·Бусдыг үзэн ядах сэтгэл илэрч байх явдал юм.

Түүнчлэн Эрүүгийн хуульд заасан хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх, хүүхдээр гуйлга гуйлгах гэсэн зүйлүүдэд гэр бүлийн хүчирхийллийн тодорхой хэлбэрийг гэмт хэрэгт тооцохоор заасан бол тус хуулийн хүн хулгайлах, бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх зэрэг зарим гэмт хэргүүдэд ч гэр бүлийн хүчирхийллийн шинж чанартай үйлдлүүд агуулагдсан байх боломжтой юм.

Гэр бүл дэх эмэгтэйчүүдийн хүчирхийлэл.

Монгол Улс эрт үеэс эрэгтэй хүнийг хүндэлж, эцгийн эрхт ёс давамгайлдаг байсан энэ уламжлал өнөөгийн нийгэмд гэр бүлийн хүчирхийлэл болон хувирсан нь харамсалтай. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөөд нөхөр болон хамтран амьдрагчийнхаа эрүүл мэндэд хохирол учруулах бүр цаашлаад амь насыг нь хохироож, гэмт хэрэгт холбогдсон эмэгтэйчүүд олон байдаг. Өнөөдрийн байдлаар 300 гаруй эмэгтэйчүүд дээрх шалтгааны улмаас хорих ял эдэлж байна гэсэн судалгаа байна. Эдгээрийн ихэнх нь гэр бүлийн хүчирхийлэлд өртөж, нөхөр болон хамтран амьдрагчийнхаа амь насыг хөнөөснөөс болсон байна.

Түүнчлэн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа явуулж байгаа цагдаагийн байгууллага болон бусад чиг үүрэгтэй байгууллага түүний алба хаагч, ажилтанууд нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнийг илрүүлэх, илэрсэн хүчирхийллийн үйлдлийг шалгаж холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авах, хуулийн хариуцлага хүлээлгэх явдал харилцан адилгүй, хүчирхийлэлтэй тэмцэх талаар явуулж байгаа үйл ажиллагаа нь тогтмолжоогүй жигд бус байгаа нь энэ төрлийн хүчирхийлэл буурахгүй байх, хүчирхийлэл үйлдэж байгаа арга, үйлдлийн зорилго, сэдэлт нь улам бүр олныг цочроох болж, жил бүр өсөн нэмэгдэх шалтгаан болж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд “Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх, эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй байхыг тунхаглаж, төр нь хүний эрхийг баталгаатай хангах үүрэг хүлээнэ” хэмээн заасан байдаг. Гэсэн хэдий ч Гэр бүлийн хүрээн дэх эрхийг хамгаалах нийгмийн тогтсон энэ сөрөг үзэгдэлтэй тэмцэх, түүнийг таслан зогсоох талаар эрх зүйн асуудалд анхаарал төвлөрүүлэх шаардлагатай байна.

Үүнтэй холбогдох харилцааг хуулиар хэрхэн зохицуулсан талаар авч үзэх нь зүйтэй байх. 1999 онд баталсан “Гэр бүлийн тухай хуульд “Гэр бүлийн хүчирхийлэл гэдэг” нэр томьёог анх хэрэглэсэн бөгөөд гэрлэгсэд бие биеэ аливаа хэлбэрээр хүчирхийлэхгүй байх, гэрлэгсдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд хохирол учирсан эсхүл учирч болзошгүй бол шүүх эвлэрүүлэхгүй арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцалж болохоор заасан.

Манай улсад гэр бүлийн хүчирхийлэл, түүнийг таслан зогсох, урьдчилан сэргийлэх, талаар 1995 оноос төрийн болон төрийн бус байгууллага тодорхой ажил зохион явуулж, эрх зүйн орчинг бүрдүүлж байгаа ч энэ гэмт явдал таслан зогсоогдоогүй байна. Тухайлбал:

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс 1995-2019 он дуустал нийт 29250 хүн хандан үйлчлүүлсэн байна. 2019 онд улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 207 бүртгэгдэж Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг)–ээр зүйлчлэгдсэн 207 гэмт хэргийг графикаар харуулбал)





Графикаас харвал даваа гарагт үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг өмнөх оноос 4.1 пункт, лхагва гариг 4.1 пункт, бямба гараг 3.7 пунктээр буурч, харин мягмар гарагт үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 5.0 пунктээр, баасан гараг 3.1 пунктээр, ням гараг 3.6 пунктээр тус тус өссөн байна.



Бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн 207 хэргийн 67 (32%) нь 22-06 цагт, 62 (30%) нь 19-22 цагт, 45 (22%) нь 14-19 цагт, 33 (16%) нь 06-14 цагт үйлдэгдсэн байна. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн 62.3 хувийг 19 цагаас өглөөний 6 цагийн хооронд үйлдсэн байна. Энэ нь тухайн гэмт хэрэгт оногдуулж буй хариуцлагын тогтолцоо, зан үйлд нөлөөлөх албадлагын арга хэмжээ авах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож ял эдлүүлэхээс илүүтэйгээр засрал авах зан үйлийн арга хэмжээ авах тогтолцоог үйлдэхийн өмнө буюу үйлдсэний дараа хэрэглэдэг болох нь нийгэмд өнчрөл, хагацал, сэтгэл гутрал, нийгмийн сөрөг явдлаас урьчдилан сэргийлэх арга хэмжээ болно.



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдэд 2020 онд хорих ял эдэлж байгаа **71** ялтан, баривчлах ялаар шийтгэгдсэн **7420** этгээд, хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн 2, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан 73, хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан 18 этгээдэд тус тус шүүхээс оногдуулсан эрүүгийн хариуцлагыг эдлүүлэн ажилласан байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хорих ял эдэлж буй хоригдлуудад зан төлөвт нөлөөлөх албадлагын арга хэмжээг авч байгаа ч төдийлөн үр дүнд хүрэхгүй байгааг Монгол Улсад Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилтэд явуулсан мониторинг үнэлгээний тайланг 2019 онд Гэр бүл хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс гаргасан байдаг.

Сургалтын мониторинг үнэлгээ хийх нь сургалтын хөтөлбөр хэрэгжүүлсний дараа мониторингийн үнэлгээ хийх явдал нь үр дүнг тооцохоос гадна дараагийн ижил төстэй сургалт явуулахад юуг анхаарах, цаашид хэрхэн сайжруулах зэргийг тодорхойлсон чухал ач холбогдолтой судалгааны материал болсон байдаг.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын зорилгыг нь хорих болон захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээдийг дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн тогтвортой байдал, тэдний мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, өөрийгөө тайвшруулах чадвартай, амьдралын эерэг хандлага, зөв дадал, бодол санаатай иргэн болгон төлөвшүүлэх гэж тодорхойлсон. Хүчирхийлэл үйлдэгч зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамрагдсанаар бусдад хор хохирол учруулсан зан үйлдэлдээ дүгнэлт хийж, өөрийн буруутай үйлдлийг ухамсарлах, эрсдэлтэй зан үйлийг бууруулах, зохицуулах, засч сайжруулах чадварыг эзэмших, зан үйлээ өөрчлөх итгэл үнэмшил нь нэмэгдэх, эрсдэлгүй зан үйлд суралцах, уур бухимдлаа хянах чадварыг эзэмшсэн байх зэрэг оролцогчийн зан үйлд эерэг өөрчлөлтүүд гарах нь сургалтын хүлээгдэж буй үр дүн юм.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сургалт үр өгөөжтэй албадлага хэдий ч хэрэгжилт нь бүрэн хангагдаж чадахгүй байна. Сургалтын зорилгоос сургалтын үр дүн тодорхойлогдох бөгөөд зорилго нь тодорхой зорилтот этгээд рүү чиглэсэн үр дүн нь тодорхой байдлаар зохицуулагдах нь чухал юм. Зан үйлд нөлөөлөх сургалтын үндсэн зорилт нь гэмт хэрэг, зөрчлийн шинж чанараас хамаарч түүний агуулга тодорхойлогдож тухайн зөрчлийг давтан үйлдээгүй байх зан үйлд эерэг өөрчлөлт гарах, гэр бүлийн зөрчилдөөнтэй асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэх мэдлэг, чадвар, харилцааны ур чадвар олгоход чиглэгдэнэ. Иймд зөрчил, гэмт хэргийн үйлдэл бүрт хамаарах агуулга, сургалтын хүлээгдэх үр дүн өөр байх шаардлага тулгарч байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийг албадан сургалтанд хамруулах хуулийн хэрэгжилтийг хангахын тулд төрийн болон төрийн бус байгууллага хамтрах, тусгай зөвшөөрөл бүхий магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагаар сургалтыг зохион байгуулна гэж заасан хэдий ч орон нутагт магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагын хүртээмж хангалтгүй байх тул тогтвортой гэрээлэн ажиллах төрийн бус байгууллага цөөн байна.

Мөн холбогдох хууль болон журмуудад зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулах багшид тавигдах шаардлага, шалгуурын талаарх зохицуулалт дутмаг байгаа нь сургалтын үр дүнд нөлөөлөхийг харгалзан үзэх хэрэгтэй. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд чиглэсэн хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын төсөв, төрийн болон төрийн

бус байгууллагын санхүүжилт байгууллагын дотоод орлого гэсэн үүсвэрээс санхүүжүүлэхээр заасан хэдий ч гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны болон сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт дутмаг, хүрэлцээ хангалтгүй байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нь хариуцлагын гадна үлддэг байдлыг халж, хариуцлага хүлээлгэж зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулж байгаа нь сайшаалтай ч албадан сургалт зохих журмын дагуу явагдахгүй, үр дүн төдийлөн мэдэгдэхгүй, зөрчил гаргагч давтан зөрчил үйлдэх, гэмт хэрэгт холбогдох явдал буурахгүй байгаад анхаарал хандуулах хэрэгтэй байна.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулах орчин нөхцөлийг бүрдүүлэх, сургалт явуулах алба хаагчдыг мэргэшүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиг үүрэг бүхий алба хаагчдын ур чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн давтан, мэргэшүүлэх, үргэлжилсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж системтэй хамруулах ажлын зохион байгуулалтыг сайжруулах хэрэгцээ шаардлага байсаар байна.

Хүчирхийлэл үйлдэгчдийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын зохион байгуулалтын хүрээнд Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс 2019 онд 52,5 сая төгрөгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас гаргаж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвд баривчлагдсан хүмүүст зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулахад зориулан зарцуулсан байна.

Гэвч ХЭҮТ-д хандсан үйлчлүүлэгчдээс өгч буй мэдээлэл болон кейс мониторингийн үр дүнгээс харахад хүчирхийлэл үйлдэгч гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчилд хариуцлага хүлээж, албадан сургалтад хамрагдсан хэдий ч засрахгүй, давтан хүчирхийлэл үйлдэж байгаа тохиолдлууд буурахгүй байна. Иймд хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг хамгаалахад үр дүнтэй нөлөөлж чадаж байгаа эсэхийг үнэлэх, уг сургалтыг явуулах чиг үүрэгтэй байгууллага, мэргэжилтнүүдийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг илрүүлж, цаашид хуулийн хэрэгжилтийг сайжруулахад нөлөөлнө.

КРИПТОЮВАЛЮТ БА ТЕРРОРИСТ БОЛОН ГЭМТ БҮЛЭГЛЭЛ

CRYPTOCURRENCY VERSUS TERRORIST AND CRIMINAL ORGANIZATION

Ж.Болд
Дотоод хэргийн их сургуулийн докторант
Bold.J
Ph.D. candidate in the University of Internal Affairs

Хураангуй: Террорист байгууллагын хувьд томоохон хэмжээний халдлага зохион байгуулах, бусад төрлийн террор, хорлон сүйтгэх ажиллагааг тогтвортой явуулахад саад болж буй зүйл нь санхүүжилт байдаг. Тэд хэрэв санхүүжилтийг хангалттай хэмжээнд авч чадвал тэдний зүгээс ирэх халдлага, хорлон сүйтгэх ажиллагааны давтамж ихсэж, том хэмжээний халдлагыг амжилттай хийхэд хэзээд бэлэн байдаг[1]. Тэдний үйл ажиллагааны санхүүжилт нэмэгдэхэд бүтэц зохион байгуулалт сайжирч, гишүүдийг элсүүлэн авах ажиллагаа идэвхжиж, түүн дотроос амиа золиослогч нарыг тодорхойлж тэдний дадлага, сургуулалт, зэвсэг, техник хэрэгсэл сайжирч, халдлагын обьектод ажиллах гишүүдийн тоо нэмэгддэг нь бодит халдлага боох бүхий л нөхцлийг бүрдүүлж өгдөг.

Abstract: Terrorist organizations require significant funding to carry out attacks and other activities in which one of the biggest barriers for them. Indeed, there is reason to believe that, if terrorist groups were better funded overall, there might be more-frequent, more-successful, and larger attacks. More funds for operations would presumably lead to increased funding for the structures that enable these attacks, which include recruiting and training attackers and inspiring potential lone wolves.

Түлхүүр үг: Криптовалют, биткойн, террорист байгууллага, гэмт бүлэглэл, Zcash, Altcoins, Mastercoin, Blackcoin, Monero.

Key words: Cryptocurrency, Bitcoin, Terrorist and Criminal organization, Zcash, Altcoins, Mastercoin, Blackcoin, Monero.

Иймээс Олон Улсын хэмжээнд терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн үндсэн чиг үүргийн нэг нь террорист байгууллагын үйл ажиллагааг дэмжих зорилготойгоор санхүүжүүлж буй мөнгөний урсгалын эх сурвалжийг тодорхойлох, хяналтад авах, анхаарал татсан сэжигтэй санхүүгийн гүйлгээ хийхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, царцаах зорилготой. Тэр ч утгаараа энэ чиглэлд илүү анхаарал хандуулсан нь зөв болохыг шинжээчид онцолдог. Өөрөөр хэлбэл энэхүү хэрэгжүүлж буй

[1] Arabinda Acharya, Targeting Terrorist Financing: International Cooperation and New Regimes, New York: Routledge, 2009.

бодлого нь террорист бүлэглэлийн фиат мөнгөний хэрэглээг бууруулах, таслан зогсооход үндсэндээ чиглэдэг.

Дэлхий дахинаа хурдацтай хөгжин хувьсаж буй технологийн хөгжлийн явцад олон төрлийн дижитал криптовалют санхүүгийн болон хөрөнгийн зах зээлийн гүйлгээнд нэвтэрч байгаа нь ихээхэн анхаарал татсаар байна. Олон Улсын судлаачдын зүгээс криптовалют нь магадгүй террорист бүлэглэлийн үйл ажиллагаагаа болон мөнгө угаалт, хүний наймаа, хар тамхины хууль бус эргэлт зэрэг үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй холбогдсон гэмт бүлэглэлийг санхүүжүүлэх алтан боломж байхыг үгүйсгэхгүйг анхааруулсаар байгаа тул дэлхийн улс орнуудын төр засгийн байгууллагуудаас зайлшгүй зохицуулалт хийх шаардлагатай болж байна. Үүнээс гадна криптовалютын ханш нь тогтмол биш, байнга огцом хэлбэлздэг тул санхүүгийн секторын аюулгүй байдлын үүднээс хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн зохицуулалт дутагдаж, улс орнууд төрөл бүрийн арга хэмжээг эхнээсээ авч эхлээд байна.

Криптовалют нь криптографаар мэдээлэл нууцлагдсан, компьютерын сүлжээнд оршдог, аливаа нэгэн улсын төв банкны удирдлага, хяналтад ажилладаггүй чөлөөт валют юм. Криптовалютыг Олон Улсын санхүү, хөрөнгийн зах зээл эерэгээр хүлээн авч байгаа хэдий ч улс орны төв банкнуудын хувьд төдийлөн саашаахгүй байна. Учир нь богино хугацаанд үндэсний мөнгөн тэмдэгт криптовалютын эсрэг сулрах эрсдэлтэй гэж үзэж байгаатай холбоотой.

Олон Улсын шинжээчдийн дүгнэлт, судалгааны байгууллагуудын тайлангаас харахад маш олон төрлийн террорист байгууллагууд хяналтгүй, хязгааргүй санхүүжилтийг дижитал валютын тусламжтайгаар амжилттай хийж байна[2]. Тухайлбал АНУ-ын хууль тогтоох байгууллагын доод танхим буюу төлөөлөгчдийн танхимаас Биткойноор хийгдэж гүйлгээ цаашид ч нэмэгдэх хандлагатай байгаа нь терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлогыг эргэж харах зүй ёсны шаардлага тавигдаж байгаад онцгой анхаарч 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр “Санхүүгийн Инноваци, Хамгаалалтын тухай” хуулийг баталсан[3].

Тулгарч буй үндсэн асуудал нь криптовалютын хурдацтайгаар хүрээгээ тэлж буй хөгжил болоод байна. Энэ нь зөвхөн биткойны асуудал биш учир нь богино хугацаанд олон төрлийн криптовалют зах зээлд гарч

[2] Heather Nauert, “ISIS Parks Its Cash in Bitcoin, Experts Say,” Fox News, November 2011; Ian McKendry, “ISIL May Be Using Bitcoin, Fincen’s Calvery Says,” American Banker, November 16, 2015; Resty Woro Yuniar, “Bitcoin, PayPal Used to Finance Terrorism, Indonesian Agency Says,” Wall Street Journal, January 10, 2017.

[3] U.S. House of Representatives, Financial Innovation and Defense Act, H.R. 4752, January 20, 2018.

ирж байна. Криптовалютын зах зээл дээр 1550 гаруй төрлийн янз бүрийн онцлогтой валют байна. Нийт криптовалютыг дотор нь нууцлалтай, нууцлалгүй гэж ангилдаг. Нууцлалтай валютын хувьд хэрэглэгчийн талаарх мэдээллийн өндөр хэмжээнд нууцалсан байдаг тул мөнгө угаах, татвараас зайлсхийх, хүний наймаа зэрэг томоохон гэмт бүлэглэлүүд ихээхэн ашигласаар байна. Нууцлалгүй валют нь илгээсэн болон хүлээн авсан хүний хаягийг тогтоох боломжтой ба гуравдагч этгээдэд гүйлгээний утга харагддаг онцлогтой. Шинжээчдийн анхааруулж байгаагаар Altcoins, Mastercoin, Blackcoin, Monero зэрэг криптовалют нь биткойноос илүү найдвартайд тооцогддог тул террорист байгууллага болон үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт бүлэглэл ихээхэн ашиглаж байгааг анхааруулсан[4].

Биткойноос гадна шинжээчдийн анхаарлыг татаж буй өөр нэг криптовалют бол Zcash юм. Энэ нь илүү өндөр зэрэглэлийн нууцлалыг бий болгож чадсан, хууль бус гүйлгээг интернетийн сүлжээ ашиглахгүйгээр найдвартай хийх боломжит чадварыг хангаж өгсөн нь хууль сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагын үйл ажиллагаанд ихээхэн хүндрэл бэрхшээлийг авчирж байна.

Хэрэв цаашид их хэмжээний санхүүгийн гүйлгээг биткойноос илүү өндөр нууцлалттай гүйлгээг хийх чадвартай, Zcash-аас илүү хөгжүүлэгдсэн криптовалют зах зээлд нэвтрэх нь зохион байгуулалттай гэмт бүлэглэл болон террорист байгууллагын идэвхжил эрчимжинэ тэд ийм л боломжийг удаан хүлээдэг.

Криптовалютын гадаад, дотоод нөхцөл байдлаас харахад бид илүү их судлаж, нэгдсэн ойлголтод хүрч аюулгүй байдал, эрсдлийн үнэлгээг нарийн тодорхойлох шаардлага бий болж байна. Үүнд зохион байгуулалттай гэмт бүлэглэл болон террорист бүлэглэл криптовалютыг хэрхэн яаж ашиглаж байгаад болон технологийн чадавхийг ашиглаж хэрхэн боловсронгуй болгож байгаа зэрэгт тавих хяналтын зохицуулалт бий болгохын зэрэгцээ шинэ төрлийн криптовалют болон цаашид ирээдүйд хэрхэн яаж хувьсан өөрчлөгдөж ахисан зэрэглэлд өндөр нууцлалтай болох гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах байгууллагын чадавхыг хэрхэн яаж ахиулах зэрэгт дүгнэлт хийж энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогын шинэчлэл шаардлагатай байна.

Террорист байгууллагууд гүний вэбсайтаас /darknet/ криптовалютаар төлбөр хийн хорлон сүйтгэх ажиллагаанд зориулж галт зэвсэг, тэсэрч

[4] Cynthia Dion-Schwarz, David Manheim, Patrick B. Johnston “Terrorist Use of Cryptocurrencies Technical and Organizational Barriers and Future Threats”, 2019; the RAND Corporation, Santa Monica, Calif.

дэлбэрэх бодис, бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж их хэмжээгээр худалдан авч байгаа нь сэтгэл түгшээсэн асуудал болсоор байна[5].

Террорист байгууллага болон үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн зүгээс криютовалютын нууцлалын давуу талыг ашиглан ямар нэг бэрхшээлгүй, хяналтгүй хийгдэж буй санхүүжүүлэлтийн зарим нэгийг авч үзвэл.

Хөрөнгө босгох: Хөрөнгө босгох ажиллагаа нь дээрх бүлэглэлүүдийн үндсэн ажиллагааны нэг салашгүй хэсэг. Санхүүжилт нь бүхий л идэвхтэй ажиллагааг хөдөлгөгч хүч нь болж өгдөг. Тухайлбал: зэвсэг худалдаж авах, цалингийн жагсаалт, халдлагын зардал болон бусад үйл ажиллагааны зардал гэх зэрэг. Хөрөнийг олон төрлийн эх сурвалжаас босгоно: Улс гүрэн, Шашны болон буяны байгууллага, хувь хүний хандив зэрэг.

Хууль бус мансууруулах бодис, Зэвсгийн наймаа: Хууль бус мансууруулах бодис, зэвсгийн наймаа нь эдгээр байгууллагын орлогын амин эх үүсвэр байдаг тул энэ төрлийн наймаа криптовалютаар хийгдэж байна.

Мөнгөн гуйвуулга / шилжүүлэг: Террорист байгууллага болон үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн холбоотнуудууд гишүүдийнхээ бэлэн мөнгөний хэрэгцээг хангахын тулд мөнгө гуйвуулах, шилжүүлэх нь тэдний өдөр тумын үндсэн ажил нь байдаг. Энэ нь тэдний цалин хөлс, урамшуулал, өдөр тумын бусад үйл ажиллагааны зардал, шаардлагатай дэмжлэг туслалцаанд зарцуулагддаг.

Халдлага, хорлон сүйтгэх ажиллагааны санхүүжилт: Гүйцэтгэхээр төлөвлөсөн хорлон сүйтгэх террорист ажиллагааны зардал

Үйл ажиллагааны санхүүжилт: Үйл ажиллагааны аюулгүй байдал, харилцаа холбоо, удирдлага, зохион байгуулалтын зардал зэргийг тус тус криптовалютын туслалцаатайгаар хяналтгүй, саадгүй авсаар байна.

Бид зөвхөн террорист байгууллага, зохион байгуулалттай гэмт бүлэглэлтэй тэмцэх явдалд анхаарал хандуулдаг байсан бол түүнээс гадна технологийн хөгжил, дэвшилд түүний цаашдын хөгжлийн чиг хандлагад онцгой анхаарал хандуулах цаг нэгэнт ирсэн байна. Учир нь дэлхий даяар террорист байгууллагын идэвхтэй үйл ажиллагаа, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн ертөнц, нөгөө талаараа технологийн хөгжлийн талбарт маш их идэвхжил хурдтайгаар зэрэг явагдаж байгаа нь эдгээрийн аюулгүй байдлын асуудал, энэ төрлийн хууль бус үйлдлээс хэрхэн урьдчилан сэргийлэх, тэмцэх зэрэг олон асуудал байгааг бидэнд анхааруулж байна.

[5] Giacomo Persi Paoli, Judith Aldridge, Nathan Ryan, and Richard Warnes, Behind the Curtain: The Illicit Trade of Firearms, Explosives and Ammunition on the Dark Web, Santa Monica, Calif.: RAND Corporation, RR-2091-PACCS, 2017

Ашигласан эх сурвалж

1. Arabinda Acharya, Targeting Terrorist Financing: International Cooperation and New Regimes, New York: Routledge, 2009.

2. Heather Nauert, “ISIS Parks Its Cash in Bitcoin, Experts Say,” Fox News, November 2011; Ian McKendry, “ISIL May Be Using Bitcoin, Fincen’s Calvery Says,” American Banker, November 16, 2015; Resty Woro Yuniar, “Bitcoin, PayPal Used to Finance Terrorism, Indonesian Agency Says,” Wall Street Journal, January 10, 2017.

3. U.S. House of Representatives, Financial Innovation and Defense Act, H.R. 4752, January 20, 2018.

4. Cynthia Dion-Schwarz, David Manheim, Patrick B. Johnston “Terrorist Use of Cryptocurrencies

5. Technical and Organizational Barriers and Future Threats”, 2019; the RAND Corporation, Santa Monica, Calif.

6. Giacomo Persi Paoli, Judith Aldridge, Nathan Ryan, and Richard Warnes, Behind the Curtain: The Illicit Trade of Firearms, Explosives and Ammunition on the Dark Web, Santa Monica, Calif.: RAND Corporation, RR-2091-PACCS, 2017

ТАГНУУЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ МӨН ЧАНАР

INTELLIGENCE ACTIVITIES AND ITS NATURE

П.Очбадрах
Дотоод хэргийн их сургуулийн докторант, цагдаагийн дэд хурандаа
Т.Оюунчимэг
Дотоод хэргийн их сургуулийн Гэмт явдал цагдаа судлалын хүрээлэнгийн судлаач, доктор (Ph,D), профессор, цагдаагийн хурандаа
Ochbadral.P
Doctorate student
Oyunchimeg.T
Doctor, professor, police colonel, researcher of the institute of criminology and Police study of the Inited institution of UIA

Хураангуй: Энэхүү нийтлэлд цагдаагийн тагнуулын ажлын онцлогийг харуулсан болно.

Abstract: This article shows the specifics of a police intelligence work.

Түлхүүр үгс: тусгай хүчний тагнуулын байгууллагууд, тагнуулын үйл ажиллагаа, мөрдөгч, төлөөлөгч

Keywords: special forces intelligence bodies, intelligence activities, detective, agent

Аливаа тусгаар тогтносон улсын амин чухал асуудал нь иргэдийнхээ болон нийгэм, төрийн язгуур эрх ашгийн аюулгүй байдлыг хамгаалах явдал байдаг.

Тиймээс дэлхийн бүх улс аюулгүй байдлаа хангах үндсэн гол аргын нэг тагнах үйл ажиллагаа мөн гэдгийг аль эртнээс хүлээн зөвшөөрсөн бөгөөд хэдийгээр тагнах үйл ажиллагаа аюултай гэж цэрвэдэг боловч түүнийг хэрэглэхээс татгалзсан нэг ч улс дэлхий дахинд байхгүй[1] төдийгүй тэрхүү чиг үүргийг хэрэгжүүлэх тусгай албагүй улс ч гэж байдаггүй.

Дэлхий нийтэд “Тусгай албад” хэмээн нэршсэн байгууллагууд нь тухайн орны нийгэм, улс төрийн тогтолцоо, ноёрхогч ангийн үзэл суртлаас үл хамааран улс бүрд заавал байдаг төрийн механизмын нэн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Тусгай албадын үйл ажиллагаа нь улс орныхоо аюулгүй байдлаа хангах, болзошгүй дайсныхаа далд эрмэлзэл, аюул заналыг урьдчилан мэдэх, аюулаас сэргийлэх, хамгаалах, тухайн мэдээллийг өөрт ашигтайгаар хэрэглэхтэй холбоотойгоор үүссэн[2] бөгөөд ямар ч улс орон тусгай албадын хүч, арга, хэрэгсэл ашигладаг нийтлэг талууд болон өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой. Эдгээр өвөрмөц онцлог нь тухайн орны гадаад, дотоод нөхцөл байдал, улс төрийн тогтолцоо, дэглэм, улс орны хөгжлийн түвшин, гадаад, дотоод бодлого, эдийн

[1] Л.Батдолгор. Тагнах үйл ажиллагааны эрх зүйн үндсэн асуудал. УБ., 2010. 14 дэх тал
[2] Очеркий внешней разведки. Под ред. Е.М.Примаков. Москва., 1986, С.13

засгийн хүчин чадал, хүн ам, газар зүйн байршил, уламжлал зэрэг олон хүчин зүйлээр тодорхойлогдоно.

Манай улсын тусгай албадын үүсэл, хөгжил, үйл ажиллагаа нь улсынхаа түүхэн хөгжилтэй салшгүй холбоотой бөгөөд тусгай албадаас явуулах тагнуулын үйл ажиллагаа үүсч хөгжихөд манай улсын гадаад, дотоод нөхцөл байдал, тухайлбал, дотоод шалтгаан нь овог аймгуудын хоорондын зөрчил, тэмцэл, гадаад шалтгаан нь бусад улсаас монголчуудын эсрэг, монголчуудаас тэдгээрийн эсрэг явуулж байсан бодлого, цэрэг дайны үйл ажиллагаатай холбоотой байжээ. Энэ тухай баримтууд дэлхийн түүхийн хуудаснаа аль эртнээс тэмдэглэгдсэн байна. Тухайлбал, Монгол угсаатны эртний хүчирхэг улс болох Их Нирун улсын байлдах арга, тактик, мэхийн талаар хятадын эх сурвалжид тэмдэглэсэн байх бөгөөд “харгулсан” буюу тагнах гэсэн хэллэгийг хэрэглэсэн[3] байгаа нь манай улсын тусгай алба эртний улбаатай болохыг илэрхийлэлэл билээ.

1185-1206 онуудад Их монгол улсын эзэн Чингис хаан монгол овогтныг нэгтгэх олон тооны тэмцэл тулаандаа өөрийн тагнуул туршуулуудыг бий болгон бусад омог аймаг, ханлигуудыг турших, төөрөгдөлд оруулах замаар нэгтгэсэн[4] төдийгүй 1250-1260-аад онд гадаад харилцаа болон тагнуулын үйл ажиллагаа эрхэлдэг байнгын ажиллагаатай төрийн байгууллага болох Нууц бичгийн яам үүсч байгуулагдсан байна.

Олон улс оронд тагнуулын байгууллага, түүний үйл ажиллагааг улсын нүд, чихтэй адилтгадаг нь эртнээс тогтсон зүйрлэл гэлтэй. Энэ талаар доктор (Ph.D), профессор Л.Батдолгор: “Чингис хаан Шихихутугийг улсын дээд заргач буюу шүүгчээр томилсон даруйдаа түүнд хандан “ ... мөнх тэнгэрийн ивээлээр улс гүрнийг тохинуулж байхад чи үзэх нүд, сонсох чих болж яв ...” хэмээн зарлиг буулгасан нь “тагнах үйл ажиллагааг нүд, чихтэй зүйрлэдэг томъёолол төрт ёс, тагнуулын арга ажиллагааны эртний уламжлалтай Монголоос гаралтай байж болох юм”[5] гэсэн таамаглалыг дэвшүүлсэн нь ч бий.

Монгол улс тусгай албадаас үйл ажиллагаа явуулахтай холбогдсон харилцааг зохицуулдаг 1997 онд боловсруулан баталж, 1998 оноос мөрдөгдөж эхэлсэн Гүйцэтгэх ажлын тухай хуульдай бөгөөд энэ хуульд: Үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагас хамгаалах зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас ердийн болон тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглан явуулж байгаа мэдээ, мэдээлэл баримт бичиг, нотолгоо эрж олох, цуглуулах, шалгах үйл ажиллагааг

[3] Т.Сүхбаатар. Их Нирун улс. (330-555 он). УБ., 1992. 108 дахь тал
[4] Эрин., Хара-Даваан. Сод жанжин Чингис хаан, түүний үлдээсэн өв. 2003. 34 дэх тал
[5] Л.Батдолгор. Тагнах үйл ажиллагааны эрх зүйн үндсэн асуудал. УБ., 2010. 54 дэх тал

гүйцэтгэх ажил гэнэ[6] гэж үйл ажиллагааны зорилго, арга, нэршлийг тодорхойлжээ.

Энэ хуулийн 9 дүгээр зүйлд: Тагнуулын байгууллага, Цэргийн тагнуулын байгууллага, Цагдаагийн байгууллага, Шүүхийн шийдвэр биелүүлэх газрын гүйцэтгэх алба, Хилийн тагнуулын албадад гүйцэтгэх ажил буюу ердийн болон тусгай, нууц хүч, арга хэрэгсэл ашиглан үйл ажиллагаа явуулах эрхийг олгосон нь эдгээр байгууллагууд нь манай улсын тусгай албад болохыг хуульчилан баталгаажуулсан заалт гэж үзэх үндэстэй байна.

Цагдаагийн байгууллагын эрдэмтэн судлаачид[7] ЦБ-аас гэмт хэргийг урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх буюу гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор хууль болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад хэм хэмжээний хүрээнд ердийн болон нууц хүч, арга, хэрэгсэл ашиглах замаар хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн нийлбэр цогц нь ЦБ-ын эрүүгийн тагнуулын ажил мөн гэсэн нь Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 2 дугаар зүйлд тагнуулын ажлын тулгын 3 чулууны нэг болох “хүч”-ийг орхигдуулсанг залруулсан шинжтэй, нилээд дэлгэрэнгүй тодорхойлолтыг өгчээ.

Цагдаагийн байгууллага нь манай улсын тусгай албадын нэг бөгөөд тусгай ажиллагаа явуулах эрхтэй болохыг бусад хууль тогтоомжуудад ч баталгаажуулсан байдаг. Тухайлбал, Цагдаагийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлд: Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлдэг төрийн тусгай алба мөн[8] хэмээсэн бол, тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан МУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх /цаашид ЭБШ хууль гэх/ хуулийн тайлбарт: “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлж, болсон үйл явдлыг бүрэн гүйцэт тогтоох, гэмт этгээдийг олох чиг үүрэгтэй төрийн тусгай албан хаагч”[9] мөн гэж тус тус тодорхойлжээ.

2015 оны 07 сарын 09-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагуудыг:

1) Тагнуулын байгууллага - гадаад тагнуул, цэрэг-стратегийн болон хилийн тагнуул, сөрөх тагнуулын чиглэлээр гадаад улс, байгууллагын тодорхой бодлого, үйл ажиллагааны тухай болон төрийн бодлого, үйл ажиллагааны тухай, төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах,

[6] Монгол Улсын Гүйцэтгэх ажлын тухай хууль. 1997. 2 дугаар зүйл
[7] Эрүүгийн тагнуулын ажил. Сурах бичиг. ЦА. Хамтын бүтээл. УБ., 2010. 11 дэх тал
[8] Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хууль. 1993
[9] Г.Баясгалан, Ж.Бямбаа, Б.Бат-Эрдэнэ нар. Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар. УБ., 2003. 34 дэх тал

хэрэгжүүлэхэд ач холбогдол бүхий бусад мэдээ олох, дэмжлэг үзүүлэх үндэсний аюулгүй байдалд учирч болзошүй гадаад, дотоод эрсдэл, занал, хуулиар харъяалуулсан гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох;

2) Цагдаагийн байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас бусад далд аргаар үйлдэгдсэн, эсхүл тодорхой төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох, олон нийтийн аюулгүй байдал болон шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, гэрч хохирогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх, түүнчлэн сураггүй алга болсон, нас барсанд тооцогдсон хүн, оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан болон прокурор, шүүхээс даалгасан бусад хүнийг эрэн сурвалжлах, алдагдсан галт зэвсэг, сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, мансууруулах, хордуулах бодис, түүх соёлын дурсгалт болон бусад үнэт зүйлийг эрж олох;

3) Шүүхийн шийдвэр биелүүлэх газрын гүйцэтгэх алба хоригдол оргох, үймээн гаргах, бусдыг барьцаанд авах, хорлон сүйтгэх зэрэг ноцтой гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэдгээрийн урьд үйлдсэн болон хорих анги дотор гарсан хэргийг илрүүлэх, түүнчлэн оргосон хоригдлыг баривчлах, энэ хуулийн 9.1.1, 9.1.3, 9.1.6-д заасан байгууллагын гүйцэтгэх ажилд дэмжлэг үзүүлэх;

Авлигатай тэмцэх газар - авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах, гэм буруутай этгээдийг олж тогтоох, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах” зорилгоор тус тус “гүйцэтгэх ажил явуулах эрхтэй” гэжээ.

Эдгээр байгууллагууд манай улсын тусгай албад бөгөөд хуулийн дээрх заалт нь тухайн байгууллагуудын чиг үүрэг, үйл ажиллагааны харъяалал, эрх зүйн үндэслэлийг тогтоон өгсөн байна. Өөрөөр хэлбэл, Тагнуулын байгууллага нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах болон Эрүүгийн хуульд заасан үндэсний аюугүй байдлын эсрэг гэмт хэргүүдэд, Цагдаагийн байгууллага нь Тагнуулын байгууллагад харъяалуулснаас бусад тодорхой төрлийн гэмт хэргүүдэд, Авилгатай тэмцэх газар нь авилгын гэмт хэргүүдэд, Шүүхийн шийдвэр биелүүлэх газрын гүйцэтгэх алба нь хоригдол оргох, хоригдлуудаас гаргаж болзошгүй үймээн гаргах, бусдыг барьцаанд авах, хорлон сүйтгэх гэмт хэргүүдэд нууц далд аргаар үйл ажиллагаа явуулахыг хуулиар зөвшөөрсөн байна.

Мөн хуулийн 11 дүгээр зүйлд гүйцэтгэх ажил явуулах үндэслэлийг:

1). Тагнуулын байгууллага хуулиар харьяалуулсан эрүүгийн хэргийн тухай мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгахдаа энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, 3, 5, 6-д заасан үндэслэлээр "эрэн сурвалжлах" ажил явуулах эрхтэй.

2). Цагдаагийн байгууллага хуулиар харъяалуулсан гэмт хэргийг далд аргаар үйлдсэн буюу үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай үндэслэл бүхий мэдээллийг:

3). Хорих ял эдлүүлэх байгууллага оргосон ялтныг баривчлах зорилгоор эрэн сурвалжлах ажил явуулах эрхийг тус тус олгожээ.

Харин "Гадаад тагнуул, сөрөх тагнуул, цэрэг-стратегийн болон хилийн тагнуулын байгууллага ... тагнуулын үйл ажиллагаа, Авилга тэмцэх газар гүйцэтгэх ажил явуулах эрхтэй" хэмээн өөрчилсөн байна.

Ийнхүү гүйцэтгэх ажил, эрэн сурвалжлах, "тагнуулын үйл ажиллагаа" гэхчилэн өөр хоорондоо ялгаатай мэт ойлгогдохоор хуульчилсан нь эдгээр нэр томъёо нь тусгай албадын үйл ажиллагааны төрлийн нэр томъёо юу? эсвэл үйл ажиллагааны ялгаатай байдал уу? гэхчилэн мөн л энэ чиглэлээр мэргэшсэн эрдэмтэн, судлаач, практик ажилтнуудын дунд маргааныг бий болгожээ.

Тиймээс л тагнах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн судлаач Ш.Ганболд: "Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасан гүйцэтгэх ажил, тагнуулын болон эрэн сурвалжлах ажиллагаанууд нь уг чанартаа нэг л зүйлийг хэлээд байгаа мөртлөө ямар хэмжээнд очихоороо "гүйцэтгэх ажил", хаана хэрэглэхээрээ "эрэн сурвалжлах ажил", юунд хүрэхээрээ "тагнуулын ажил" болдгийг ойлгоход бэрх байна"[10] хэмээн 10 жилийн тэртээ өгүүлж байсан юм.

Шинээр батлагдан мөрдөж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд гүйцэтгэх ажлыг "мөрдөн шалгах нууц ажиллагаа", "мөрдөн шалгах бусад ажиллагаа" гэхчилэн томъёолсон төдийгүй энэ хуульд заасан мөрдөн шалгах нууц ажиллагааг мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага, түүнээс эрх олгосон мөрдөгч гүйцэтгэнэ"[11] гэж хуульчилжээ. Мөн хуулийн нэр томъёоны тайлбар хэсэгт: мөрдөн шалгах нууц ажиллагаа гэж прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулах ажиллагааг, мөрдөгч гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах эрх бүхий албан тушаалтныг ойлгоно гэсэн заалт нь өдгөө мөрдөгч гэж нэрлээд байгаа гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий ажилтанд хамааралтай эсэх нь мөн л эргэлзээтэй.

[10] Ш.Ганболд. Гүйцэтгэх ажлын хуулийг боловсронгуй болгох нь //Гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалт онол, практикийн хурлын эмхтгэл. 2010. 27 дахь тал

[11] Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 26.7 дугаар зүйл 3 дахь хэсэг

Нэр томъёо нь оноон нэрлэх ёстой ухагдахуунаасаа үүсмэл"[12] гэдэг утгаар хандвал, нууц, далд аргаар явуулах үйл ажиллагааг оновчтой томъёолох нь танин мэдэхүйн болон холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох ач холбогдолтой.

Тусгай албадын үйл ажиллагааны олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн нэршил болох “тагнах”, "тагнуул" гэдэг үгсийг этимологийн буюу үгийн гарвал зүйн талаас авч үзэхэд “тагнах” гэдэг нь ажиглах, турших, хянах сэргийлэх[13] гэсэн үйл үг бөгөөд хамгаалах утгыг илэрхийлж байгаа бол, тагнах гэсэн үйлийн үндэс “тагнуул” гэсэн нэр үг нь тусгай зорилгоор ямар нэгэн юмыг нууц аргаар мэдэх, мэдээлэх явдал хэмээн монгол хэлний тайлбар тольд тайлбарласныг үндэслэвэл олж тогтоох буюу эрэн сурвалжлах чиглэлд харъяагдахаар байна.

Энэ үгс хуучирч хэрэглээнээс гараагүй, өөр утганд шилжээгүй, одоо ч энэ л утгаараа ойлгогдож хэрэглэгдэж байгаа билээ.

“Эрэн сурвалжлах”, “гүйцэтгэх ажил”, “тагнуулын үйл ажиллагаа” “мөрдөн шалгах нууц ажиллагаа” “мөрдөн шалгах бусад ажиллагаа” гэсэн нэр томъёоны тайлбар, тодорхойлолтуудыг дүгнэн үзвэл, гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр явуулах нууц ажиллагааг “эрэн сурвалжлах”, үндэсний аюулгүй байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах чиглэлээр явуулж нууц ажиллагааг “тагнуулын үйл ажиллагаа” нэрлэсэн нь харагдана. Өөрөөр хэлбэл хамгаалахын тулд тэмцдэг.

Тиймээс манай зарим эрдэмтэн, судлаачид тухайлбал, доктор /Ph.D/, профессор Л.Батдолгор: Үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр нууцаар явуулж буй үйл ажиллагааг тагнуулын үйл ажиллагаа, эрүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглээр нууцаар явуулж буй эрэн сурвалжлах ажиллагааг гүйцэтгэх ажил[14] гэж нэрших ангилалыг санал болгож байжээ. Судлаач Г.Уянга: “Тагнуулын үйл ажиллагаа гэдэг нь төрөл бүрийн боломж, арга, техникийг ашиглан аливаа асуудлын талаар мэдээлэл цуглуулах, шалгах, үнэлж дүгнэх, тайлбарлах замаар тодорхой үр дүн гаргах үйл ажиллагаа юм[15] гэсэн тодорхойлолтыг өгчээ.

Харин доктор /Ph.D/ М.Цогтоо: “Тагнуулын үйл ажиллагаа гэдэг нь ... үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор төрөөс зохиож буй арга хэмжээг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх тусгай албаны үйл ажиллагаа”[16] хэмээн хуулиар харъяалуулсан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, гэм буруутай этгээдийг олж тогтоох зорилгыг

[12] К.Маркс Ф.Энгельс. Соб. Сочинений. Т.20. с.609
[13] Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ, 1966, 514 дэх тал, Монгол хэлний их тайлбар толь. 2016
[14] Л.Батдолгор. Тагнах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын онол, практикийн асуудал //Гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалт. ЭШ-ний хурлын эмхтгэл. УБ., 2010.
[15] Г.янга. Улсын аюулгүй байдал ба тагнуулын ажил. Сурах бичиг. УБ., 2008. 111 дэх тал
[16] М.Цогтоо. Тагнуулын ажлын толь. УБ., 2002. 82 дахь тал

орхигдуулсан явцуу тодорхойлолтыг өгсөн ч, хожим “Монгол Улсын тусгай албадын тагнуулын үйл ажиллагаа гэж ҮАБ-ыг хангах, хуулиар харъяалуулсан тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас эрх хэмжээнийхээ хүрээнд нууц ба ердийн хүч, арга, хэрэгслийг ашиглан мэдээ, баримт сэлт олох, цуглуулах, шалгах, ашиглах үйл ажиллагааг хэлнэ”[17] гэж өөрчлөн тодорхойлжээ.

Тиймээс эрүүгийн тагнуулын үйл ажиллагааг төрийн хууль тогтоомжийн дагуу гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилтыг хангахын тулд нууц хүч, арга, хэрэгслийг ашиглан хэрэгжүүлэх тусгай арга хэмжээний нийлбэр цогц[18] буюу хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийн тулд /гэмт хэргийг илрүүлэх/ мэдээлэл олох зорилгоор зориуд нууцаар хэрэгжүүлж байгаа үйлдэл ... [19] хэмээн тодорхойлсон аж.

Бидний хувьд “Эрүүгийн тагнуулын ажиллагаа гэмт хэрэгтэй тэмцэх үүргээ биелүүлэх зорилгоор эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ил болон нууц хүч, арга, хэрэгслийг ашиглан явуулж байгаа үйл ажиллагаа” гэсэн тодорхойлолтыг өгч байна.

Тиймээс тагнуулын үйл ажиллагааны ил болон “нууц” буюу “тусгай арга” нь Гүйцэтгэх ажлын тухай хууль, тогтоомж болон Монгол улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан ажиллагаанаас гадна шинжлэх ухааны танин мэдэхүйн ерөнхий арга зүйд үндэслэгдэнэ гэж үзэж байна.

Ийнхүү цагдаагийн байгууллагын тусгай албад нь нууц, далд аргаар шаардлагатай мэдээ, мэдээлэл, баримт эрж хайх, цуглуулах, үнэлэх, шалгах замаар гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох буюу гэмт хэрэгтэй тэмцэх цогц үйл ажиллагаа явуулдаг ажээ.

Аль ч улсын тусгай албадаас нууцаар явуулдаг ажиллагааг нийтлэг байдлаар "тагнуулын ажиллагаа" гэж нэрлэдэг ба харин уг ажиллагааг явуулж буй чиглэлээр нь эдийн засгийн тагнуул, технологийн тагнуул, үйлдвэрийн тагнуул гэхчилэн төрөлжүүлэн ангилдаг бол, манай улсын хувьд улс, үндэстэний аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр нууц далд аргаар тэмцэх ажиллагааг тагнуулын, тодорхой төрлийн гэмт хэрэгтэй нууц далд аргаар тэмцэх ажиллагааг эрүүгийн тагнуул ажиллагаа гэж хуваагдаж байна гэж үзэх үндэслэлтэй.

[17] М.Цогтоо, Б.Даваажав. С.Гомбо. Эрүүгийн цагдаагийн албаны эрүүгийн тагнуулын үйл ажиллагаа. Сурах бичиг. 2019.
[18] Эрүүгийн тагнуулын ажил. Сурах бичиг. Цагдаагийн Академи. (хамтын бүтээл). УБ., 2010. 9 дэх тал
[19] Л.Батдолгор. Тагнах үйл ажиллагааны эрх зүйн үндсэн асуудал. УБ., 2010. 73 дахь тал

Тусгай албадын үйл ажиллагаа бусад төрийн байгууллагуудын үйл ажиллагаанаас ялгарах гол хүчин зүйл нь “*тусгай буюу нууц хүч, арга хэрэгслээр*” үйл ажиллагаа явуулдаг онцлогт оршиж байна.

Иймээс тусгай алба гэж ямар байгууллага байх, төрийн бусад байгууллагаас ялгагдах онцлог зэрэг нь төрийн хууль тогтоомжоор баталгаажсан байх нь түүний “тусгай” гэдэг нэршлийг олох, тусгайлсан үйл ажиллагаа явуулах эрхийг баталгаажуулан хуульчилж хууль ёсны болгож байдаг нь эргэлзээгүй байна.

Монгол улсын хуулиар Гүйцэтгэх ажил хэмээн нэршсэн манай улсын тусгай албадаас явуулах үйл ажиллагаа, тэр дундаа Цагдаагийн байгууллагын эрүүгийн тагнуулын албаны үйл ажиллагааны агуулга, мөн чанар нь түүний үндсэн чиг үүрэг, зорилгын нэгээхэн хэсэг болох гэмт хэргээс нийгэм, төр, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны нууц хүч, арга, хэрэгсэлд оршиж байна.

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

CURRENT SITUATION AND FUTURE TRENDS OF DOMESTIC VIOLENCE PREVENTION ACTIVITIES

А.Мөнхсувд
Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч
Munkhsuvd.A
Senior Specialist of the Department for Combating Domestic Violence and Crimes against Children, Police Major

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Монгол Улсад сүүлийн жилүүдэд ихээхэн анхаарал татах болсон гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн өнөөгийн нөхцөл байдал, тулгарч буй асуудал, цаашид энэхүү гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авах арга хэмжээний талаар санал дэвшүүлсэн болно.

Abstract: The present Article deals with current issues, challenges, and future preventive measures in relation to domestic violence, which has drawn public scrutiny in recent years in Mongolia.

Түлхүүр үгс: Цагдаагийн байгууллага, гэр бүлийн хүчирхийлэл, сэтгэл зүй, менежмент, гэмт хэрэгтэй тэмцэх.

Keywords: Police Organization, Domestic Violation, Psychology, Managmebt, Combating Crime

Нэг. Удиртгал

Орчин үеийн улс орнуудын хөгжлийн чиг хандлага, техник технологи, шинжлэх ухааны хурдацтай хөгжил дэвшилтэй зэрэгцэн хувь хүн, гэр бүл болон, нийтийн боловсролын талаарх хөгжилд ихээхэн анхаарах болжээ. Тиймээс эрх зүй, сэтгэл зүй, социологи зэрэг шинжлэх ухаанд үндэслэн хүний дотоод мөн чанарын талаар нарийвчлан судлах болж. Түүний дундаас хүний эрхийг хамгаалах, гэр бүл хүчирхийлэлтэй тэмцэх, гэрч, хохирогчийг хамгаалалтдаа авах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах зэрэг хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэд хэдэн үндсэн чиглэлд ангилах, төрөлжүүлэх анхны оролдлого нь 1960-1970 оны үед анагаахын салбарт хэвийн нэвтэрсэн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх загварыг хуулбарлан хэрэглэх санаа байжээ. Энэ санааг судлаач Брантингхам Пол, Фредирик Фауст нар 1976 оны нийтлэлдээ дэлгэрэнгүй дурджээ.[1] Энэ

[1] Brantingham, Paul and Faust, Frederic L (1976). A conceptual model of crime prevention, Crime and Delinquency, vol. 22, No. 3, 284-296. https://www.ncjrs.gov/App/Publications/abstract.aspx?ID=35542

онолоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн арга хэмжээ гэж ангилсан байна.

Сүүлийн үед олон улсын түвшинд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг нийгмийн хөгжилд суурилсан, олон нийтэд суурилсан, нөхцөл байдалд суурилсан, нийгэмшүүлэх хөтөлбөрт суурилсан гэж ангилсан талаар зарим судлаач[2] дурджээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг дотоодын судлаачид ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн гэсэн төрөлд хуваан үзэж ирсэн бол Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль/шинэчилсэн найруулга/[3]-ийн 6 дугаар зүйлд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төрлийг өргөжүүлэн ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн, соён гэгээрүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх гэсэн таван үндсэн чиглэлээр хэрэгжүүлэхээр хуульчилжээ.

Хоёр. Гэр бүлийн хүчирхийллийн тухай товч ойлголт:

Гэр бүлийн хүчирхийлэл нь хүний эрхийн хамгийн том зөрчлийн нэг төдийгүй түүний хохирогч нь дийлэнхдээ хүүхэд, эмэгтэйчүүд болдог. НҮБ-ын Эмэгтэйчүүдийн Байгууллагын мэдээлснээр 2020 онд олон улсын хэмжээнд 15-49 насны 243 сая охид, эмэгтэйчүүд нөхөр, хамтрагчийн зүгээс бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн байна. Энэ талын мэдээлэл дутмаг, далд хэлбэртэй байдгаас гэр бүлийн болон бусад төрлийн хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээ авахад бэрхшээлтэй тулгардаг, тухайлбал, хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүдийн 40 хүрэхгүй хувь нь аливаа төрлийн тусламж хүсдэгээс 10 хүрэхгүй хувь нь цагдаад ханддаг байна[4].

Эдгээрийн дундаас гэр бүл хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажил нь анхаарал татсан чухал асуудал болж байна. Гэр бүлийн хүчирхийллийн гол хохирогч нь эмэгтэйчүүд, хүүхдүүд байх ба хаалганы цаана үйлдэгддэг нуугдмал гэмт хэрэг билээ. Нэр томьёоны хувьд “Гэр бүлийн хүчирхийлэл” гэж эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд, тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү нар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг[5] ойлгоно хэмээн тодорхойлсон байдаг.

[2] Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй. Хамтын бүтээл. УБ.,2017. 8 дахь тал
[3] Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль. Төрийн мэдээлэл. 2019 оны №42
[4] Статистикийн тойм: Гэр бүл хүчирхийлэл. Уб., 2020. 2 дахь тал.
[5] Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай .2017 он, №5 Төрийн мэдээлэл эмхтгэл.

Гурав. Гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн байдал, шалтгаан нөхцөл

Монгол Улс 2016 онд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг батлан, 2017 оноос эхлэн мөрдөж байгаагаас гадна Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрт энэ чиглэлийн асуудлыг тусган өгч, хэрэгжүүлж байгаа. Түүнчлэн хүчирхийлэлд өртсөн иргэдэд тусламж, зөвлөгөө өгөх, хамгаалах байраар хангах зэрэг үйлчилгээ үзүүлж байна. Тухайлбал, НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр байгуулсан хохирогчдод үйлчилгээ үзүүлэх 17 нэг цэгийн үйлчилгээний төвөөс гадна дэмжлэг үзүүлэн хамгаалах 18 байр тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Монгол Улсын хувьд гэр бүлийн хүчирхийллийн тухай тоон мэдээллийг гаргахад Цагдаагийн ерөнхий газрын гэмт хэргийн мэдээ болон тусгайлсан түүвэр судалгаа гэсэн 2 гол эх үүсвэрийг ашиглаж байна. Тусгайлсан судалгааны хувьд хэдийгээр энэ чиглэлийн төрийн бус байгууллагуудын хийсэн судалгаа байдаг хэдий ч Үндэсний Статистикийн Хорооноос 2017 онд улсын хэмжээний “Жендэрт суурилсан хүчирхийллийн түүвэр судалгаа”-г анх удаа зохион байгуулсан[6].

Судалгааны дүнгээр манай улсад гурван эмэгтэй тутмын нэг (31.2%) нь амьдралынхаа туршид бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна. Гэр бүлийн хүрээнд тухайлбал, нөхөр/хамтрагчийн зүгээс 10 эмэгтэйн 6 нь (57.9%) амьдралынхаа туршид хүчирхийлэлд өртсөн. Эдгээр эмэгтэйчүүдийн 4 хүн тутмын 1 нь (26.5%) хэн нэгэнд хандаж, хэлж байгаагүй байна[2].

2017 онд /Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль үйлчилж эхэлсэн/ гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гэмт хэрэг 1286, зөрчил 4369, 2018 онд гэмт хэрэг 1070, зөрчил 5821, 2019 онд гэмт хэрэг 985, зөрчил 8962, 2020 онд гэмт хэрэг 1138, зөрчил 10306 тус тус цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн[7]. 2021 оны эхний 5 сард гэмт хэрэг 596, зөрчил 4115.

Үүнээс дүгнэхэд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг шат дараатай нийгмийн бүхий л давхаргад, хүртээмжтэй зохион байгуулах шаардлагатай байгааг харж байна.

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлын өргөн хүрээтэй, нийгмийн бүх давхарга, салбарт нэгэн зэрэг чиглэсэн, хүний зан үйлд нөлөөлөх төрөл бүрийн арга хэрэгслийн тусламжтайгаар хэрэгжүүлж байдгаас хамаарч түүнийг хэрэгжүүлэх чиглэлийг олон шалгууруар төрөлжүүлэн ангилахад хүргэдэг.

[6] Мөн тэнд. 3дахь тал.
[7] Цагдаагийн ерөнхий газрын тайлан 2020 он.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлийг тогтоох нь чухам юунаас, ямар үндэслэлээр эхлэх, ямар хүрээнд зохион байгуулах, ямар арга, хүч хэрэгслийг ашиглах зэрэг олон хүчин зүйлээс хамаарна.

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад доорх 3 түвшинд анхаарал хандуулах шаардлагатай хэмээн үзэж байна. Үүнд:

➢ *Хувь хүний түвшинд:*

❖ Гэр бүл төлөвлөлт, амьдралын арга ухаанд суралцах;

❖ Ёс суртахуун, зөв дадал, зан үйлд суралцах;

❖ Өөрийн үнэт зүйл, зорилгоо төлөвлөх;

❖ Стресс менежментийн талаар мэдлэгтэй болох;

❖ Бусдыг хайрлах, хувь хүний зохион байгуулалтаа нэмэгдүүлэх.

➢ *Байгууллага болон шалгах эрх бүхий албан тушаалтны хувьд:*

❖ Төрийн байгууллагуудын уялдаа холбоог нэмэгдүүлэх. /Цагдаа, Прокурор, Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар гэх мэт/;

❖ Төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж тэдний дэмжлэгийг авч, хохирогч болон хүчирхийлэгч нарыг таньж илрүүлэн бүртгэх;

❖ Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг шалгах эрх бүхий албан тушаалтныг сурган дадлагажуулах;

❖ Хүний нөөцийн бодлого /мерит/ зарчим, тогтвор суурьшилтай байдал;

❖ Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг үнэлж, үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг криминологийн шинжлэх ухаан болон инновацийн шийдэл, техник, технологийг ашиглан шинэлэг байдлаар зохион байгуулах;

❖ Гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааг боловсронгуй болгох, гадаад орны сайн туршлагыг өөрийн хөрсөнд буулгах, тэдэнтэй хамран ажиллах;

❖ Хохирлын үнэлгээг зөв, тооцоолох;

❖ Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчилд хяналт тавих, хүчирхийллэл үйлдсэн этгээдэд шийтгэл ногдуулах ажиллагаа;

❖ Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг үр дүнтэй зохион байгуулах;

➢ *Монгол Улсын түвшинд:*

❖ Хууль эрх зүйн орчныг сайжруулах;

❖ Бүх нийтийн гэр бүлийн боловсрол олгох, мэдлэгжүүлэх;

❖ Нэгдсэн цогц бодлого боловсруулж, төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа холбоог нэмэгдүүлэх;

❖ Гэр бүл хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын үйл ажиллагаа нэмэгдүүлэх;

❖ Кино, жүжиг, ном бүтээл, дуу зэрэг урлаг соёлоор нийгэмд нөлөөлөх;

❖ Телевиз, радио, цахим орчноор дамжуулж нийгэмд эерэг зөв мэдээллийг хүргэж, урьдчилан сэргийлэх зэрэг цогц үйл ажиллагаа явуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил цаг хугацааны хувьд богино, дунд, урт хугацааны гэсэн хэлбэртэй байдаг. Цагдаагийн байгууллагаас богино болон дунд хугацааны урьдчилан сэргийлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, ард иргэдтэй хамтран зохион байгуулж, тодорхой хэмжээний үр дүнд хүрч ажиллаж байна. Тухайлбал:

Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн үүргийн хэрэгжилтийг хангах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүчирхийллийн талаар мэдээлэх үүргийг нэмэгдүүлэх зорилгоор “Би ... байна” урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг энэ оны 03 дугаар сарын 04-ний өдрөөс 10-ны өдөр хүртэлх хугацаанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, НҮБ-ын Хүн амын сан, Жендерийн үндэсний хороо зэрэг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага арга хэмжээний хүрээнд гэр бүлийн хүчирхийллийн 948 зөрчил шалгаж, 379 зөрчилд хариуцлага оногдуулсан. Мөн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулах 136 мэдэгдлийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад өгч, 43 хариу авч, 37-г газар дээр шалгасан. Зорилтот 6 видео шторк, сэрэмжлүүлэх зурган постер 11, зорилтот мэдээ 12, нийт 29 мэдээ, мэдээлэл, контентыг шинээр бүтээж, нийтийн цахим сүлжээгээр түгээснийг 1.271.421 хүн үзэж, 16.914 хүн бусадтай хуваалцаж, 12.921 хүнд таалагдсан байна[8].

Эрсдэлт бүлгийн хүүхдийг илрүүлэх, тэднийг гэмт хэрэг, зөрчил, эрсдлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэж болзошгүй этгээдэд хяналт тавих чиглэлээр зохион байгуулсан “Хүүхэд хамгаалал” арга хэмжээг энэ оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 04 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл хугацаанд улсын хэмжээнд зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд 336 алба хаагч зөвхөн илрүүлэлт, хяналт, шалгалтын чиглэлээр үүрэг гүйцэтгэж, 593 төрийн болон төрийн бус байгууллага, 537 аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран нийт 302

[8] ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн тайлан. 2021 он.

удаагийн сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулсан. Хүүхдэд хандсан 5 төрлийн стикер боловсруулан 6250 ширхэгийг хэвлүүлэн олон нийтийн газарт байршуулсан.

Арга хэмжээнүүд улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үеэр явагдсан нь онцлогтой бөгөөд хүчирхийллийн эрсдэлт зорилтот бүлгийн 2093 хүүхдийг илрүүлэн хяналтад авч, 1491 хүүхдэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж ажиллан, цагдаагийн байгууллагын Судалгаа хяналтын сангийн "Хүүхдийн нэгдсэн бүртгэл"-д 1382 хүүхдийн мэдээллийг шинээр бүртгэж, хяналтад авснаар цаашид тухайн хүүхдэд чиглэсэн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үзүүлэхэд ахиц гарсан.

Дөрөв. Цаашдын чиг хандлага:

Сүүлийн үед дэлхий нийтэд үүссэн "цар тахал" "Covid-19" үүссэнтэй холбогдуулан олон улсад хөл хорио /Lock Down/ -ны үед гэр бүлийн хүчирхийлэл 20 хувиар[9] нэмэгдэж, хүүхэд эмэгтэйчүүд сэтгэл санааны болон бие мах бодийн хохирол ихээр амсах боллоо. Үүнээс үзэхэд гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцөл нь улс төр, нийгэм, эдийн засаг зэрэг олон хүчин зүйлээс үүдэлтэй хэдий ч хувь хүний ёс суртахуун, ядуурал, ажилгүйдэл, архидалт зэргээс ихээхэн хамаарч байна.

Иймд цагдаагийн байгууллагаас энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, ард иргэдтэй хамтран зорилтод аян, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг шат дараалалтай зохион байгуулсны үр дүнд гэмт хэрэг, зөрчлийн гаралтад ил болон далдаар нөлөөлж, ард иргэдийн хандлага өөрчлөгдөж байгаа нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцдэг хүн бүрийн хамтын ажлын үр дүн билээ.

Дүгнэлт

Энэхүү өгүүллэгийн хүрээнд доорх дүгнэлтийг хийж байна.

1. Төрөөс бодлогоор бүх нийтийн гэр бүл, сэтгэл зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж, бага балчир наснаас нь хувь хүний хөгжил, гэр бүл төлөвлөлт, ёс суртахуун, зан заншлын талаарх сургалтыг ерөнхий боловсролын болон их дээд сургуулиудад нэмэлтээр оруулж өгөх.

2. Эрх зүйн орчныг сайжруулж, хууль, журамд өөрчлөлт оруулах. Зөрчлийн хууль болон Эрүүгийн хуульд зөрүүтэй байгаа ойлголтуудыг нэг мөр болгох.

[9] https://www.unwomen.org/en/news/in-focus/in-focus-gender-equality-in-covid-19-response/violence-against-women-during-covid-19

3. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг гэмт хэрэг, зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтнуудыг давтан сурган дадлагажуулж, тэднийг тодорхой төрлийн кейс өгөгдөл дээр ажиллах, бие даан суралцах чадварт сургах.

4. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаарх сургалт, судалгааны ажлыг шинэлэг байдлаар, тогтмол явуулж түүнд дүгнэлт хийж урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.

5. Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын үйл ажиллагааг сайжруулах.

Санал

1. Зөрчлийн хууль болон Эрүүгийн хуульд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах.

2. Цагдаагийн байгууллагаас гэр бүлийн хүчирхийллийн эсрэг гэмт хэрэг, зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтнуудыг давтан сурган дадлагажуулж, тэднийг тодорхой төрлийн кейс өгөгдөл дээр ажиллах, бие даан суралцах хөтөлбөр боловсруулах.

3. Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын үйл ажиллагааг сайжруулах.

Ашигласан эх сурвалж

1. НҮБ-ын тайлан мэдээ 2021 он. https://www.unwomen.org/en/news/in-focus/in-focus-gender-equality-in-covid-19-response/violence-against-women-during-covid-19

2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай .2017 он, №5 Төрийн мэдээлэл эмхтгэл.

3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль. Төрийн мэдээлэл. 2019 оны №42

4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй. Хамтын бүтээл. УБ.,2017. 8 дахь тал

5. Статистикийн тойм: Гэр бүл хүчирхийлэл. Уб., 2020. 2 дахь тал.

6. Цагдаагийн ерөнхий газрын тайлан 2020 он.

7. ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн тайлан. 2021.05 сар

8. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд инноваци нэвтрүүлэх нь онол практикийн хурлын илтгэлийн эмхтгэл. Уб., 2018 он.

9. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтны гарын авлага. Уб., 2017.

10. Brantingham, Paul and Faust, Frederic L (1976). A conceptual model of crime prevention, Crime and Delinquency, vol. 22, No. 3, 284-296.

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ҮНДСЭН СУДЛАГДАХУУН

AN UNDERSTANDING OF BORDER SECURITY

А.Муратхан
Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн захирал, доктор, прфессор, бэлтгэл хурандаа
Muratkhan.A
Director, Institute for Border Security Studies, The Joint Research Institute, UIA, Ph.D, Professor, Colonel

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Монгол Улсын хилийн тухай хууль /шинэчилсэн найруулага/-д шинээр нэмэгдэж орсон “хилийн аюулгүй байдал” гэсэн томъёоллын үндэслэл, түүнийг гадаадын зарим оронд яаж ойлгох, хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрт түүний илэрэх хэлбэр, тэдгээрийг судалдаг хил судлалын шинжлэх ухааны энэ талаарх бүрдэл хэсэг, хилийн аюулгүй байдлыг хангах талаар Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын чиглэл зэргийг тайлбарлан оруулсан болно.

Abstract: This study explains the role of the State Policy on Border of Mongolia for ensuring border security and definition basis of “Border Security” as stated on the Law on Border /amended/, its implementation at the state border and border area, and understanding of border studies.

Түлхүүр үгс: хилийн аюулгүй байдал, хилийн аюулгүй байдлын эрсдэл, хилийн орон зайд үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол, хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо, хилийн орон зай, хил орчмын нутаг дэвсгэр.

Keywords: Border Security, Risk on Border Security, National Security Interests in the State Border and Border Area, Border Security System, Border Space, Border Area

Монголын ард түмэн улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс түүх соёлынхоо өв уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан байгуулахыг эрхэм зорилго болгон хуульчилсан билээ.

Олон улсын харилцааны шинж чанар, уур амьсгал нааштайгаар өөрчлөгдсөн хэдий ч аюулгүй байдлын хамтын тогтолцоо бүрэлдэн бий болоогүй, улс болоод ашиг сонирхлын бүлэглэлүүдийн хооронд зөрчил, сөргөлдөөн үргэлжилсээр байгаа нөхцөлд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, улсын хилийн аюулгүй байдлыг хангаж, үндэсний язгуур эрх ашгаа урьтал болгосон, тогтвортой хөгжлийн асуудлаа

шийдвэрлэх бие даасан бодлого, үйл ажиллагаа явуулах шаардлага тулгарч байна.

Дэлхийн улс гүрнүүд нийгмийн хөгжлийн жам ёсоор харилцаа холбоогоо бэхжүүлж байгаа боловч үндсэрхэг үзэл газар авч, үндэстэн ястан, шашин хоорондын зөрчил, мөргөлдөөн гарсаар байна.

Монгол Улсын оршин тогтносон 2200 гаруй жилийн хугацаанд нутаг дэвсгэр хил, хязгаарын төлөө явуулсан тэмцлийн түүхээс харахад түүнд тал бүрээс учирч байсан аюул занал нь түүнийг хүн төрөлхтний түүхийн тавцангаас зайлуулах, нутаг дэвсгэрийг нь эзэмших, эс чадваас хил орчмын тодорхой газар нутгийг таслаж авах зорилго, чиглэлтэй явагдаж иржээ.

Хүн ам цөөн, газар нутаг өргөн уудам, нийгэм эдийн засгийн хөгжлөөр харьцангуй сул манай улсын хувьд өөрийн аюулгүй байдлыг хангахад нэн түрүүнд улсын хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх явдал юм гэдгийг өнгөрсөн үеийн түүхэн сургамж харуулж байна. 80 гаруй жилийн өмнө Японы милитаристуудын зүгээс Халхын голын чиглэлээр өдөөсөн дайны зорилго нь Монголын талаас эзэмшилгүй байсан хил орчмын газар нутгийг цэргийн хүчээр эзэмших, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн болон хилийн аюулгүй байдалд ноцтой нөхөж баршгүй хохирол учруулахын төлөө явагдсаныг бид мартаагүй байна.

Өнөөдөр хөдөөгийн хүн амын ихэнх нь төврүүгээ нүүдэллэж олонх нь нийслэлд амьдрах болсноор хил орчмын нутаг дэвсгэр эзэнгүйрч байна.

Экологийн нөхцөл байдалд нүүрлэж буй цөлжилт говийн бүсийг төдийгүй тал хээр, ойт хээрийн бүс нутгийг хамарч байгаагаас хүн амын амьдрал ахуйд нөлөөлж, хилийн дагуу асар уудам газар нутаг эзэнгүйрч улсын хил хамгаалалтад шууд нөлөөлөх болов.

Аливаа улсын хил нь нийгэм, улс төрийн эздрээтэй бодит үзэгдэл мөн бөгөөд түүнийг айл зэргэлдээ орших улсуудын төрийн эрх барих дээд байгууллагатай хамтран шийдвэрлэж, хоёр улсын болон олон улсын эрх зүйн баримтаар баталгаажуулан хэрэгжүүлдэг онцлогтой юм.

Монгол Улс Үндсэн хуульд “Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна” гэж заасаны дагуу зэргэлдээх улсуудтайгаа сайн хөршийн нөхөрсөг харилцаа тогтоож, дэлхийн улс бүхэнтэй олон улсын эрх тэгш, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлан нээлттэй харилцах гадаад бодлого баримталж байна.

Монгол Улс нь Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай улсын хилийн асуудлыг XX зууны сүүлийн хагаст бүрэн шийдвэрлэж, баталгаажилтыг нь хүлээн зөвшөөрснөөр олон улсын эрх

зүйн үндэс бүрдсэн байна. Цаашид тогтоон тэмдэглэж, баталгаажсан хилийг өөрчлөхгүй, зөрчилгүй, олон улсын нийтлэг жишигт нийцүүлэн манах, хамгаалах ажиллагааг улам боловсронгуй болгох нь манай хил хамгаалах байгууллагын үндсэн үүрэг мөн.

Олон улсын хэмжээнд хилийн аюулгүй байдлыг хилийн орон зай (улсын хил, хилийн зурвас, бүс, хил орчмын нутаг дэвсгэр)-д төр, нийгэм, иргэдийн язгуур ашиг сонирхол хамгаалагдсан байх нөхцөлийг хэлдэг бөгөөд хилийн аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болдог байна.

Тиймдээ ч Монгол Улсын хилийн тухай хууль /шинэчилсэн найрууллага/-д "*хилийн аюулгүй байдал гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсаныг хэлнэ", "хилийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салашгүй хэсэг мөн*"[1] гэж заасан нь зарим гадаад улсын томъёололд нийцэж байна.

Улсын Их Хурлаас баталсан "Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого" баримт бичигт "Хилийн талаар баримтлах бодлого нь байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар улсын хилийн халдашгүй байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахад чиглэнэ" гэж заасан. Энэ нь хилийн аюулгүй байдлыг агуулгын хувьд бүрэн хамарч чадаагүй байжээ гэсэн дүгнэлтэд хүрч болох юм.

Монгол Улсын хилийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "Улсын хил хамгаалалт нь үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний салшгүй хэсэг мөн"[2] гэж заасан боловч, энэ талаар тусгайлан судлагдаагүй, түүнийг хангах онол, арга зүй болон ямар арга хэмжээ авах үндэслэл, аргачлал одоогоор боловсрогдоогүй, эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Хил хамгаалах байгууллага нь хилийн тухай хуулийн дагуу хилийн орон зай /улсын хил, хилийн бүс, зурвас, хил орчмын нутаг дэвсгэр/-д үйл ажиллагаа явуулж байгаа боловч тэнд хилийн аюулгүй байдлыг хангах, тэрхүү орон зайг хамгаалах, улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөлийг яаж баталгаатай хангах талаар нэгдсэн ойлголтод хүрээгүй, энэ талаар хийгдсэн судалгаа одоогоор байхгүй байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тэр дундаа хилийн аюулгүй байдлыг хангах гадаад, дотоод таатай орчин бүрдэж байгаа боловч улсын

[1] Монгол Улсын хилийн тухай хууль /шинчилсэн найрууллага/, Төрийн мэдээлэл, №06, УБ, 2017 он
[2] Монгол Улсын хилийн тухай хууль /шинчилсэн найрууллага/, Төрийн мэдээлэл, №06, УБ, 2017 он

хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах, түүнд нөлөөлж буй сөрөг хүчин зүйлсийг багасгах нь чухал байна

Улсын хил нь нэгэнт хоёр улсын нутаг дэвсгэрийн зааг болохоор тус тусын нутаг дэвсгэр, ялангуяа хил орчмын нутаг дэвсгэр дээрх амьдрал үйл ажиллагаа, эд баялгийн ашиглалт нь тухайн улсын эрх мэдэлд хамаарагдна.

Чухам хилийн аюулгүй байдал гэдэг нь юу болохыг ойлгохын тулд улс оронд тулгарч байсан түүхэн болон тулгарч байгаа өнөөгийн аюул заналыг ухамсарлан ойлгох нь зайлшгүй шаардлагатай юм.

Аль ч улсын үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болсон хилийн аюулгүй байдлыг хэрхэн, яаж ойлгож байгаа талаар тодорхой түвшинд нэгтгэсэн ойлголт ховор бөгөөд зарим судлаачид хилийн аюулгүй байдлыг цэргийн аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэгт оруулж иржээ.

Хилийн аюулгүй байдлын тухай онолын асуудал нь харьцангуй бага судлагдсан, дөнгөж бие даасан судалгааны салбар болох дүр төрхөө олж байгаа ба хил судлалын шинжлэх ухаан /Border studies/ болон аюулгүй байдал судлал /Security studies/-ын судалгааны талбарын заагт оршиж байна.

Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогод: " *... хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхол тухайн нутаг дэвсгэрт хангагдсан байдлаар тодорхойлогдоно*[3]*"* гэж заажээ.

Тэгвэл 2016 онд батлагдсан Монгол Улсын хилийн тухай хуульд: *"... хилийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг"* мөн бөгөөд "*хилийн аюулгүй байдал гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсаныг хэлнэ"* гэж хуульчилсан байгаа.

Дээрх тодорхойлолтыг нэгтгэн дүгнэвэл: Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогод зөвхөн "*хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь ... тухайн нутаг дэвсгэрт хангагдсан байдлаар*" тодорхойлогдсон бол Монгол Улсын хилийн тухай хуульд: "*хилийн аюулгүй байдал нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт ... баталгаатай хангагдсаныг хэлнэ"* гэсэн байна.

Үүнийг дараах байдлаар ойлгож болох юм: *хэрэв хил орчмын нутаг дэвсгэр аюулгүй бол улсын хил аюулгүй байна, тэр нь заавал баталгаатай хангагдах ёстой* юм байна.

Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүнд хилийн аюулгүй байдлыг нэмж оруулсан үндэслэл нь үндэсний язгуур ашиг сонирхол, түүнд учрах

[3] Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого,УБ, 2002 он.

аюул заналыг төвлөрүүлсэн нийгмийн харилцаа (хилийн хүрээ)-ны тодорхой орчинд /*улсын хил, хилийн зурвас, хилийн бүс, хил орчмын нутаг дэвсгэрт*/ хамаарч байгаа болохоор хилийн аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын "салшгүй хэсэг" гэж онцлон авч үзсэн нь зүйн хэрэг мөн.

Түүнээс гадна хил судлалын шинжлэх ухааны болон улсын хилийн талаар баримтлах төрийн бодлогын байр сууринаас авч үзвэл хилийн аюулгүй байдал гэдэг ойлголт нь улсын хилийн өөрийнх нь аюулгүй байдал, мөн хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал гэж үзэх хоёр бодгаль элементээс бүрдэж байна. Улсын хилийн өөрийн аюулгүй байдал нь олон улсын эрхзүйгээр баталгааждаг бол харин хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь Монгол Улсын хууль эрхзүйгээр зохицуулагддаг онцлогтой.

Монгол Улсын хилийн тухай хуульд орсон "*хилийн аюулгүй байдал*" гэсэн тодорхойлтод орсон зарим нэг *ойлголтыг* албан ёсны эрх зүйн баримт бичигт /*Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл бариимтлал, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль/* дараах байдлаар тайлбарласан байна:

нэгд, *Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд*: монголын ард түмэн; соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана[4];

хоёрт, *Монгол Улсын үндэсний аюулгүй байдал* нь Монгол Улсын төр, нийгэм, иргэний аюулгүй байдал харилцан уялдаатай хангагдсанаар баталгаажих;

гуравт: *хил орчмын нутаг дэвсгэрт*-хил залгаа улстай хиллэж байгаа сумын нутаг дэвсгэр орох;

дөрөвт: *улсын хил гэж* Монгол Улсын нутаг дэвсгэрийн зах хязгаарыг газрын гадаргуу, усны мандал дээр хил залгаа улсын нутаг дэвсгэрийн хязгаараас зааглаж, Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлж, тогтоосон шугам. Уг шугамаас эгц дээш агаарын, мөн шугамаас эгц доош газрын хэвлийн хил байна гэжээ.

Эдгээр ойлголтуудаас үзэхэд хилийн аюулгүй байдал бол маш өргөн утга агуулгатай байгаа нь харагдаж байна.

Гадаадын зарим улс орон /ОХУ болон Тусгаар тогтносон улсуудын хамтын нөхөрлөлийн байгууллага, г.м./ хилийн аюулгүй байдлыг албан ёсоор тодорхойлохдоо:

[4] Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УБ.2010 он.

➢ "... *хилийн аюулгүй байдал нь-Хил хамгаалах байгууллагын удирдлагын дор улсын гүйцэтгэх болон хэрэгжүүлэгч үүрэг бүхий төрийн байгууллагууд, бусад хүчний байгууллагуудын хамтын хүчээр улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр болон түүнд орших нийгэм, улс, иргэний язгуур эрх ашиг, гадаад, дотоодын бодит халдлагаас хамгаалагдсан байдал" гэжээ. Өөрөөр хэлбэл: "нийгэм, улс, иргэний язгуур ашиг сонирхол хэрэгцээ нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт хамгаалагдсан байдал*[5]*";*

➢ " *...хилийн аюулгүй байдал нь-үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг мөн бөгөөд үндэсний ашиг сонирхол гадаад, дотоодын аюул заналаас хилийн орон зайд хамгаалагдсан байдал*[6]*"*;

➢ " *...хилийн аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг мөн бөгөөд улсын хил, хилийн орон зайд улс, нийгэм, хувь хүний улс төр, эдийн засаг, мэдээлэл, хүмүүнлэгийн болон бусад язгуур ашиг сонирхол хамгаалагдсан байдал*[7]*"*

Эдгээр болон бусад орны хилийн аюулгүй байдлын талаар хийсэн тодорхойлолтууд нь агуулгын хувьд үндсэндээ ойролцоо байна гэсэн дүгнэлтэд хүрч болмоор байна.

Дээрх гадаад орнуудын улсын хилийн аюулгүй байдлын тухай тодорхойлолтод орсон зарим нэг нэр томъёог дараах байдлаар тайлбарласан байна:

❖ *үндэсний язгуур ашиг сонирхолд учрах аюул /хилийн аюул/ гэж* хилийн орон зайд үндэсний ашиг сонирхолд тодорхой хохирол учруулж болох гадаад, дотоодын бодит болон болзошгүй нөхцөл байдал;

❖ *хилийн аюулгүй байдал үүсч болох шинж:* энэ нь хилийн аюулгүй байдал болзошгүй байдлаас бодит байдалд шилжих үеийн завсрын түвшингээр илэрэх бөгөөд, энэ үед хилийн орон зайд үндэсний язгуур ашиг сонирхолд бага зэргийн хохирол учрах, эсвэл хохирол учруулах таамаглалын хэмжээ ихсэнэ;

❖ *хилийн орон зайд үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд учрах аюулын /хилийн аюулын/ эх сурвалжид:* тодорхой нөхцөл байдал бий болсон үед хилийн аюулыг үүсгэх, түүнийг бий болгох гадаад, дотоодын хүчин зүйл эсвэл хүчин зүйлсийн хуримтлагдсан байдал; хилийн орон зайд үндэсний язгуур ашиг сонирхолд хохирол учруулах бодит болон боломжит аюулын нөхцөл;

❖ *хилийн орон зайд үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд учрах аюул /хилийн аюул/-ын тээгч нь* энэхүү орон зайд үндэсний

[5] Федеральный закон «О Государственной границе РФ», М. 2018 г.
[6] См.: пункт 27 статьи 2 Закона Республики Казахстан от 16 января 2013 г. № 70-V ЗРК «О Государственной границе Республики Казахстан».
[7] Закон Республики Беларусь «О Государственной границе Республики Беларусь»

аюулгүй байдлын ашиг сонирхолд санаатай ба санамсаргүй хохирол учруулах хүний эсвэл бүлэг хүмүүсийн үйлдэл /эс үйдэл/, мөн үйлдвэр /техногени/-ийн осол, байгалийн аюулт үзэгдэл, хохирол үзүүлэх бусад үйл ажиллагаа;

❖ *хилийн орон зайд үндэсний язгуур ашиг сонирхолд учрах хохирол* – хил дамнасан үйл ажиллагаа, мөн мэдээллийн болон бусад үйл явцын улмаас хилийн аюулгүй байдалд үзүүлэх материалын, эсвэл материаллаг бус хохиролыг хэлнэ. Энэ үед үндэсний язгуур ашиг сонирхолын хангагдсан байдлын зэрэг буурах бөгөөд учирсан хохиролыг нөхөх, холбогдох бусад эсрэг арга хэмжээг авна.

❖ *хилийн аюулгүй байдалд учрах аюул /хилийн аюул/* – хилийн орон зайд үндэсний язгуур ашиг сонирхолд үлэмж хохирол учруулах аюулын бодит байдал, хилийн аюул үүсгэх төгсгөлийн шат;

❖ *хилийн аюулгүй байдлын эрсдэл* – хилийн аюул үүсч болох боломжит шинж чанартай аюулын анхны түвшин, тэр нь хилийн орон зайд үндэсний язгуур ашиг сонирхолд таамагласан хохирол тэр бүр үзүүлдэггүй;

❖ *хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо* – хилийн орон зайд үндэсний язгуур эрх ашгийг хангах, хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулж буй субъекүүд, тэдгээрийн хэрэглэж байгаа хэрэгслийн цогц;

❖ *хилийн орон зай гэдэг нь* үндэсний язгуур ашиг сонирхол, төрийн тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор эрх бүхий байгууллагаас хяналт шалгалтын болон, хамгаалалтын тусгай дэглэм, журам сахиулж байгаа хил орчмын нутаг, агаар, ус буюу улс орны нутаг дэвсгэрийн нэг хэсэг.

Хилийн аюулгүй байдлын талаарх эдгээр ойлголт нь агуулгаараа бидний ойлголттой ижил байна гэсэн дүгнэлтэд хүрч болохоор байна.

2010 онд батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын “Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам” гуравдугаар бүлэгт оршин тогтнохын аюулгүй байдлын үндэс нь “Монгол Улсын тусгаар тогтнол бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал юм[8]” гэжээ.

Тиймээс Монгол Улсын үндсэн хууль, Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, Үндэсний аюулгүй байдлын тухай болон Монгол Улсын хилийн тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал зэрэг эрх зүйн актуудын холбогдох заалт, мөн гадаад орнуудад энэ талаар хийсэн судалгааны үр дүн, тодорхойлолт зэргийг үндэс болгон “Хилийн аюулгүй байдал” гэдгийг дараах байдлаар хялбарчуулан ойлгож болох юм:

[8] Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ. 2010

❖ *Монгол Улсын төр, нийгэм, иргэний язгуур ашиг сонирхол хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрт хангагдсан байдал буюу энэ орчинд төр нийгэм, иргэнд ямар нэгэн аюул занал учрахгүй, харин улсын хилээр нэвтрэх бүх бололцоог хангасан, хилийн болон хил орчмын дэглэм сахиулах, илэрсэн зөрчлийг цаг алдалгүй таслан зогсоох, хилийн аюул заналын эсрэг буюу түүнийг гаргахгүй байх арга хэмжээг авах явдал,*

❖ *Хил хамгаалах байгууллагын удирдлага дор үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагын хамтын хүчээр улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт орших нийгэм, улс, иргэний язгуур ашиг сонирхолыг гадаад, дотоодын бодит болон болзошгүй аюул, заналаас хамгаалах явдал,*

❖ *Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах механизм, түүний үндсэн чиглэл, зарчим, үүрэг, зорилгын талаар албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн үзэл бариимтлалын тогтолцоо.*

Эдгээрээс гадна хил судлаач, доктор /Sc.D/, профессор Ш.Арвай өөрийн бүтээлдээ хилийн аюулгүй байдлыг дараах байдлаар томъёолсон байдаг:

"Хилийн аюул гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт төр, нийгэм, хувь хүнд биеийн хүч болон материалын ямар нэгэн хэлбэрээр хохирол учруулах гэсэн оролдлогын илэрхийлэл[9]".

Хилийн аюул нь нэгэнт тогтоон тэмдэглэсэн хилийг хууль эрхийн бус болгох мөн тогтоогдсон хилийн дэглэмийг зөрчих хоёр хэлбэрээр илэрнэ. Үүнд:

a) тогтоосон хилийн хууль эрх зүйн байдлыг алдагдуулахын тулд хилийн гэрээг дангаар нэг талаас хүчингүй гэж үзэх, хилийн тэмдгийг устгаж байрлалыг өөрчлөх, хоёр тэмдгийн хоорондох хилийн шугамын татагдсан хэсгийг өөрийн талд ашигтайгаар гуйвуулах гэсэн оролдлогоор,

b) улсын хилийн дэглэмийг зөрчихдөө хилээр нэвтрэхийг хориглосон хэсгээр хууль бусаар хил зөрчих, зэвсэгт будлиан, халдлага түрэмгийлэл үйлдэх, хилээр нэвтрэхийг зөвшөөрсөн боомтоор хууль бус аргаар, хүчин төгөлдөр бус баримт бичиг ашиглан хил нэвтрэх үйлдлээр илэрнэ.

Хилийн аюул нь санаатай ба санамсаргүй гэсэн хэлбэртэй, байнгын ба цаг үеийн шинжтэй, гадаад ба дотоод гэсэн хоёр талтай байна.

Зарим судлаачид хилийн аюулгүй байдлыг цэргийн аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэгт оруулж ирсэн тухай дээр дурьдсан билээ.

Түүхийг эргэн харахад хилийн аюулгүй байдал нь бусад улсын эзлэн түрэмгийллээс тухайн улс нутаг дэвсгэрээ хориглон хамгаалах цэргийн

[9] Ш.Арвай. Шинжлэх ухааны гавъяат ажилтан, доктор /Sc.D/профессор

үүрэгтэй шууд холбоотой байжээ. Дэлхийн хоёр их дайн бусдын газар нутгийг эзлэн түрэмгийлж өөрийн болгох гэсэн Германы эсрэг болсон бол Мексик-Америкийн дайн нь америкчууд газар нутгаа баруун тийш өргөтгөх, Мексикууд газар нутгийнхаа хил хязгаарыг хамгаалах зөрчлөөс болж үүссэн байдаг. Милитарист Японы манай улсын Халх голын чиглэлээр хийсэн дайн нь мөн л нутаг дэвсгэрээ тэлэх гэсэн оролдлого байсан юм. Үүнээс үзэхэд хилийн аюулгүй байдал гэдэг нь илүү хүчирхэг улс орон газар нутгаа тэлэх зорилгоор бусад улсын нутаг дэвсгэрийг эзлэн түрэмгийлэх ажиллагааны эсрэг цэргийн хамгаалалт байжээ гэсэн дүгнэлт хийж болох юм.

Өнөө үед цэргийн байгууллага энэ чиглэлээр ямар нэг үүрэг гүйцэтгэхгүй болсон гэсэн үг биш бөгөөд харин ч Зэвсэгт хүчин нь улс орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлын төлөө хууль ёсны хүч хэрэглэх гол хэрэгсэл байсаар байна.

Хилийн аюулгүй байдал нь зөвхөн гадны улсын түрэмгийллээс улс орны хил хязгаарыг хамгаалахаас гадна олон улсын алан хядагчид, хууль бусаар цагаачлагчид, хар тамхи, хүнийг хууль бусаар хил нэвтрүүлэх, бусад үндэстэн дамнасан гэмт хэрэгтнүүд тухайн улсын нутаг дэвсгэрт хил зөрчин нэвтрэхээс сэргийлэх зэрэг илүү өргөн утгыг илэрхийлдэг нь нэгэнт тодорхой болжээ.

Улс үндэстний аюулгүй байдал алдагдах явдал юун түрүүнд улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрээс эхлэх магадлал өндөр байдаг болохоор хилийн аюулгүй байдлыг хангах асуудлыг тэргүүн ээлжинд шийдвэрлэх нь чухал.

Тиймээс хил орчмын нутаг дэвсгэрийн /хилийн аюулгүй байдал/ аюулгүй байдлыг хангахад Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын дагуу дараах чиглэлийг баримтлах ёстой:

- улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах талаар олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах, нэгдэн орох, тэдгээрийг хүндэтгэн сахих, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгож байх;
- бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан хилийн бүс, зурвасын эзэмшлийг сайжруулж, хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжлийн талаар нийгэм, эдийн засгийн цогцолбор арга хэмжээ авах;
- улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр дэх газар нутгийн уламжлалт монгол нэр, түүх, соёлын дурсгалт зүйлсийг хэвээр хадгалах;
- хил орчмын нутаг дэвсгэрийн стратегийн ач холбогдол бүхий байгалийн нөөц, баялгийг төрийн хяналтад байлгах;
- хилийн асуудлаар хил залгаа улсын холбогдох байгууллагуудтай тогтоосон харилцааг хөгжүүлэх;

- улсын хил дээр зэвсэгт халдлага, түрэмгийлэл үүсэхээс урьдчилан сэргийлж, хилийн асуудлаар үүссэн зөрчил, будлианыг энхийн аргаар шийдвэрлэхийг эрхэмлэх;
- хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх, байгалийн гамшиг, хүн малын гоц халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх, хил орчмын нутаг дэвсгэрт хүмүүнлэгийн болон экологийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хил залгаа болон бусад орнуудтай хамтран ажиллах;
- улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, цаг алдалгүй илрүүлэх, таслан зогсоох, шийдвэрлэх арга хэмжээг цогц байдлаар хэрэгжүүлэх;
- хил орчмын нутаг дэвсгэр, хилийн боомт газарт эмх замбараагүй байдал үүсэхээс сэргийлэх;
- эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааны зарчимд тулгуурлан, дэд бүтэц, барилга байгууламж бүхий хилийн хяналт шалгалт явуулах нөхцлийг хангасан хилийн боомтуудыг ажиллуулах;
- улсын хил хамгаалах байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлэх;
- иргэдийн эх оронч үзэл, улсын хил, хилийн дэглэм, журмыг хүндэтгэн сахих хүмүүжлийг төлөвшүүлэхэд чиглэгдэнэ[10].

Эдгээр чиглэлүүдээс гадна хилийн аюулгүй байдал нь хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн эрх бүхий байгууллагуудаас нэгдмэл бодлого, харилцан уялдаатай явуулах улс төр, эрх зүй, дипломат, эдийн засаг, байгаль орчин, тагнуул, улсын хил хамгаалалтын цогц үйл ажиллагаагаар хангагдана.

Хилийн аюулгүй байдлыг хил судлалын шинжлэх ухаан судалдаг бөгөөд судалгааны *оъект нь* улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт болж буй үзэгдэл, үйл ажиллагаа, хилийн үзүүлэх нөлөөлөл, мөн хилийн орчинд бүрдэх төрөл бүрийн тогтолцоо юм.

Яамар ч шинжлэх ухааны онол нь өөр хоорондоо харилцан үйлчилгээтэй бүрдэл хэсэг (зарчим, зүй тогтол, үүрэг, хууль, төрөл, ангилал ... г.м.)-тэй байдаг ба анхдагч гол элементийн үндэс болдог.

Хил судлалын шинжлэх ухаан нь хилийн аюулгүй байдлын үндсийг бүрдүүлэгч судалгааны дараах зүйлүүдээс бүрдэнэ:

- хил хамгаалах үйл ажиллагааны үүрэг, зорилго;
- хил хамгаалах үйл ажиллагааны зарчим ба хэм хэмжээ;
- хилийн гүйцэтгэх үүрэг, төрөөс хилийн талаар баримтлах бодлого, хил хамгаалах байгууллагын хүч хэрэгсэл;
- хил хамгаалах удирдлагын бүтэц /удирдлагын цогц ажиллагаа/;

[10] Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого., 2002 он.

- хил орчмын нутаг дэвсгэрт үүсэх аюул занал, өдөөн хатгалга;
- хил хамгаалах албаны арга хэмжээний нөлөөллийн төрөл, ангилал;
- хил хамгаалах албаны арга хэмжээний нөлөөллийг удирдах арга, хэлбэр;,
- хил хамгаалах үйл ажиллагааны хангалт;
- хил хамгаалах үйл ажиллагаа болон хилийн орчны нөлөөллийн давтамж;
- удирдлагын механизм ба хилийн орчны нөлөөлөл;
- хил хамгаалах үйл ажиллагааны үр дүнд нөлөөлөх хүчин зүйлс.

Дээр дурьдагдсан судалгааны бүрдэл хэсэг тус бүрийг хилийн аюулгүй байдалтай холбон судлахын тулд зарим нэгийг товчоор тайлбарлан, түүний агуулгад юу юу орохыг гадаадын холбогдох материалыг үндэслэн дараах байдлаар сийрүүлэн оруулж байна. Үүнд:

а) Хил хамгаалах үйл ажиллагааны хэм хэмжээнд дараах зүйлүүд орно:

- хууль ёсны байх;
- хувь хүн, иргэний эрх, эрх чөлөөг хамгаалах, хүндэтгэх;
- хүнлэг ёсыг сахих;
- хууль зөрчсөн хувь хүн, иргэний эрх, эрх чөлөөг хязгаарах, арга хэмжээ авахдаа зөвхөн хуулийн хүрээнд ажиллах;
- хийсэн үйдэлдээ заавал хариуцлага хүлээх;
- гэмт хэрэгтэй тэмцэхэд оролцох байгууллагууд хяналттай байх.

b) Гадаад орнуудын хил хамгаалах байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн дүгнэлтэд тулгуурлан хилийн аюулгүй байдлыг хангахад дараах зарчмуудыг баримтладаг байна:

- хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд хоёр улсын болон олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- хил дамнасан гэмт хэргийн аюул заналтай тэмцэхэд хувь хүн, олон нийтийн ба холбогдох байгууллагуудын хүчийг нэгэтгэх;
- орон нутгийн оршин суугчдын уламжлалт мэдлэг, хэл, соёлыг түшиж ажиллах;
- урьдчилсан болон таслан зогсоох арга хэмжээ авах;
- хил хамгаалалтын байнгын ба хөдөлгөөнт хүчийг хавсран ашиглах;
- хилийн аюулгүй байдлыг хангахад орон нутгийн хүч хэрэгсэлийг ашиглах;
- бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө нь хууль бусаар аж ахуй эрхлэхийг таслан зогсооход чиглэгдсэн байх;
- хилийн аюулгүй байдлыг хангах ажиллагаанд орчин үеийн хиймэл оюун ухааны аргыг ашиглах;

➢ хэрэгжиж буй хөтөлбөр, арга хэмжээний үр дүнг тодорхой цаг хугацаа, үе шатны төгсгөлд бодитой тооцож байх;

➢ зорчигч, ач тээврийн хэрэгслийг хөдөлсөн газраас эхлэн гүний хяналтад авах, терроризмд сэжиглэгдсэн этгээдийг байнгын мөрдөлт, хяналтад байлгах, алдагдсан паспортыг бүртгэлтэй байлгах нь хилийн аюулгүй байдлыг үр дүнд хүргэх арга зам байх;

➢ хилийн боомтуудад дэвшилтэд технологи, мэдээлэлийн хэрэгсэлийг ашигласанаар хилийн холбох, хаалт байх үүрэгт зарцуулах төсөв хөрөнгийг багасгах.

c) Төрөөс хилийн талаар баримтлах бодлогын үндсэн үүрэг нь урьдчилан сэргийлэх /анхааруулах/ үүрэг юм. Урьдчилан сэргийлэх гэдэг бол өөргөн утгаараа анхааруулахтай адил. Харин явцуу утгаараа урьдчилан сэргийлэх нь ямарваа аюул заналын гарах шалтгаан нөхцлийг илрүүлэх, устгах, мөн анхааруулсан мөртөө түүний эсрэг үйлдэл хийж болох этгээдийг олж тогтооход чиглэгдэнэ.

Тиймээс хилийн талаар баримтлах бодлогод уг бодлогын үр дүнд хүрэх урьдчилсан нөхцөлд улсын хилийг маргаангүй, харилцан тохирч тогтоох, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, хил орчмын оршин суугчдын нийгэм-эдийн засаг, амьдрал, аж байдлыг дээшлүүлэх, оюун санааг өндөр түвшинд байлгахад оршино.

d) Хил орчмын орон зайд үүсэх заналхийлэл (славян хэлэнд “гроза”- айдас, аймшиг) хоёр төрөлд хуваагдна. Үүнд:

➢ хил орчмын орон зайд зүй бус үйл ажиллагаа явуулдаг субъектийн эсрэг явуулдаг төр, нийгэм, хил хамгаалах байгууллагаас явуулдаг заналхийлэл;

➢ хил орчмын орон зайд зүй бус үйл ажиллагаа явуулдаг субъекээс явуулдаг заналхийлэл.

Хил хамгаалах байгууллага, төрөөс хилийн талаар баримтлах бодлогын үндсэн үүрэг болох улсын хил хамгаалалт нь - *нэгдүгээр* төрлийн заналхийллийг бий болгодог бөгөөд тэр нь хил орчмын нутаг дэвсгэрт зүй бус үйл ажиллагаа явуулдаг субъектийн заналхийллийг таслан зогсоох, хилийн аюулгүй байдлыг хангахад оршино.

Хил орчмын нутаг дэвсгэрт зүй бус үйл ажиллагааг тогтоон барих үүрэг бол бий болсон заналхийлэлд үндэслэн явагдна. Уг заналхийллийн эсрэг хариу арга хэмжээг эхний ээлжинд хил хамгаалах байгууллага өөрийн материаллаг ба оюун санааны нөөцөд тулгуурлан хэрэгжүүлнэ.

Хил хамгаалах албаны арга хэмжээний нөлөөлөл нь хил хамгаалах байгууллагын алба, байлдааны үйл ажиллагааны төрөл, хэлбэр, аргаар зохих технологийн дагуу, мөн цагийн байдлаас шалтгаалан улсын хил хамгаалалтын үүргийг гүйцэтгэх явцад хүч, хэрэгсэлийг ашиглах арга, журмын дагуу явагдна.

е) Хил хамгаалах байгууллагын албаны үйл ажиллагааны хэлбэрт:

- хилийн алба;
- хилийн эрэл;
- тусгай ажиллагаа;
- хилийн операци г.м. орно.

Дээрх албаны үйл ажиллагааны хэлбэр болгон өөрийн гэсэн аргатай байдаг. Аргууд нь дайсаны үйл ажиллагааг илэрүүлэх, таслан зогсоох талаар урьдчилан харсан байхаас гадна, заналхийлэл гарч болзошгүй чиглэлд гол хүчээ төвлөрүүлж чаддаг байх ёстой. Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааны арга, хэлбэрийг нэгэтгэсэн байдлаар (онолын хувьд) хил хамгаалах албаны арга хэмжээний нөлөөллийн төрөлд оруулж болно.

Хил хамгаалах албаны арга хэмжээний нөлөөллийн төрөл (цогц арга хэмжээ) нь төрөөс хилийн талаар баримтлах бодлогын үүрэг, хилийн аюулгүй байдлын түвшин, түүнд нөлөөлөх чиглэгдсэн заналхийллийн (нөлөөлөх субъектын) байдлаар тодорхойлогдно (хүснэгт 1).

Хүснэгт 1. Хил хамгаалах албаны арга хэмжээний нөлөөлөлийн төрөл

№	Албаны арга хэмжээний нөлөөллийн төрөл	Хилийн аюулгүй байдлын түвшин
1	Анхааруулах - урьдчлан сэргийлэх цогц (хилийн албаны, нийгмийн, эдийн засгийн, дипломатын, мэдээллийн, эрхзүйн, улс төрийн г.м.)	Хилийн болон хил орчмын аюулгүй байдал- Border Security
2	Дэглэмийн болон хамгаалах - шалгах (хилийн албаны, гаалийн г.м.)	Заналхийллийн доод түвшин *(Border Management – пограничный менеджмент)*
3	Оператив - хүчний (хууль сахиулах, цэргийн, эрэл-тагнуулын, тусгай г.м.)	Заналхийллийн доод болон дунд түвшин *(Border Control – охрана границы)*
		Заналхийллийн дээд түвшин *(Border Safety – защита границы)*

f) Дэглэмийн, заримдаа анхааруулах-урьдчлан сэргийлэх нөлөөллүүд нь албаны арга хэмжээний үйл ажиллагааны (үргэлж эсвэл үе үе давтагддаг) нөлөөллийн төрөлд багтна.

Төлөвлөгөөний дагуу явагддаг (хөдөлгөөнт) нөлөөллийг дараах байдлаар хуваах болно:

- тусгалт шинж чанартай нөлөөлөл /заналхийлэлд хариу үйлдэх мөн илэрэх үед өөрчлөгдөж байх/;
- нөхцөл байдлын шинж чанартай нөлөөлөл /бий болсон нөхцөл байдалд тохируулан нөлөөлөх/;
- өөрсөн (урьдчилан) нөлөөлөх шинж чанартай.

Хилийн арга хэмжээ болон албаны арга хэмжээний нөлөөлөлийг хосолсон хэлбэрээр хэрэглэх нь арга хэмжээний нөлөөллийг удирдах аргыг бий болгоно. Энэ аргыг боловрсуулах нь хил судлалын шинжлэх ухааны тулгамдсан асуудал мөн.

g) Улсын хил хамгаалах үйл ажиллагааны хэлбэр янз бүр байж болно. Америкийн нэгдсэн улс улсын хилээ голдуу эргүүл хийх, хяналт тавих, хилийн эрэл /үе үе эсвэл төлөвлөгөөт бус/ явуулах хэлбэрээр хамгаалдаг. Зарим улс орон /ОХУ, ТТУХ/ улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт хилийн зөрчлийг илэрүүлэх, урьдчлан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн хил хамгаалалалтын хэлбэрийг ашиглаж байна.

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ БОЛОН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ГАЗАР НУТГИЙН УЛАМЖЛАЛТ НЭРИЙН ӨӨРЧЛӨЛТ НӨЛӨӨЛӨХ НЬ

IMPACT OF THE CHANGE OF TOPONYMS TO THE NATIONAL SECURITY AND BORDER SECURITY F MONGOLIA

Ц.Ганболд
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн судлаач, доктор, профессор.
Ganbold.Ts
Researcher, Institute for Border Security Studies, The Joint Research Institute, University of Internal Affairs, Ph.D, Professor, Colonel

Хураангуй: Монгол Улсын хил орчмын нутаг дэвсгэр дэх газар орны уламжлалт монгол нэрний өөрчлөлтөд хийсэн судалгааны товч, түүнд хийсэн дүгнэлт, дэвшүүлж буй санал, зөвлөмж.

Abstract: This study describes about the result of the research on the impact of the change of Mongolian toponyms of border area, its suggestions and recommendations.

Абстракт: Изучены актуальные проблемы по изменению традиционных и исконно коренных названия местности в приграничных районах именно западной части Монголии, влияющие на национальные и пограничные безопасности.

Түлхүүр үгс: Хил судлал, үндэсний аюулгүй байдал, хилийн аюулгүй байдал, газар нутгийн түүхэн уламжлалт нэр,

Keywords: Border Studies, National Security, Historical Toponyms

Ключевые слова: Погранология, Лимология, национальная безопасность, пограничная безопасность, традиционное название местности.

Дэлхий нийтээр шинжлэх ухаан, технологийн дэвшил дээр суурилан хөгжих нь нийгмийн хөгжлийн зүй тогтол гэдгийг бодит амьдрал дээр баталж өгсөн XX зууны эцэс 1990-ээд оны дунд үеэс хил судлал (погранология) шинжлэх ухааны бие даасан салбар болж хөгжсөн билээ*.

Хил судлал нь өөр өөрийн судлах зүйлтэй (объект-хилийн аюулгүй байдал, хилийн харилцаа, хилийн түүх) олон шинжлэх ухааны уулзвар дээр үүсэж бий болжээ. Дээр үеэс “Хилийн шинжлэх ухаан” гэж нэрлэгдсэн энэ ухаан нь улсын хил дээр “бүрэлдэж”, шинжлэх ухааны нэг салбараас нөгөөд шилжих тэр зүй тогтлыг дамжсан. Энэ зүй тогтлыг Ф.Энгельс онцлон тэмдэглээд “Энэхүү “хилийн” буюу уулзварын шинжлэх

ухаан нь шинжлэх ухаан дөнгөж үүсэж байх тэр үед ч танин мэдэхүйн хөгжилд үнэлж баршгүй үүрэг гүйцэтгэсэн" гэж тэмдэглэжээ[1].

Хил судлал нь түүхийн урт удаан он жилүүдэд бүрэлдэн хөгжиж, цэрэг, тагнуулын онолын "уусмал"-аас аажмаар тунгаагдан боловсорч, өнөөгийн түвшинд хүрсэн.

Тусгаар тогтносон улсын хил болон хязгаар нутагт болж байгаа үйл явцын мөн чанар, шинж байдал, хилийн орон зайд хамаарагдах бие хүн, улс төрийн ашиг сонирхлыг хамгаалж буй төр, олон нийт, хүчний болон бусад байгууллагын үйл ажиллагааг харьцуулан судалдаг шинжлэх ухааныг томьёолж "Хил судлал" гэж нэрлэх болсон ба түүнийг шинжлэх ухааных нь хувьд дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, 1995 оны 12 дугаар сарын 6-нд Оюуны бүтээлийн Олон улсын бүртгэлийн танхимд (Международная палата интеллектуальной новизны)-д EIW 0001175 дугаартайгаар бүртгэсэн байдаг.

Монгол Улсад хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэх, түүнийг олон улсын төвшинд гаргах, ингэснээр эх орныхоо хил, хязгаар нутагт аж төрж, хөдөлмөрлөж буй хүмүүсийн үйл ажиллагаа, үзэгдлийн мөн чанарыг судалж, харилцан мэдээлэх, мэдээллийн шинэ орчныг бий болгох шаардлагад тулгуурлан Хилийн сургуулийн хэсэг багш нар санаачлан 2000 онд Монголын Хил Судлалын Үндэсний Нийгэмлэг (МХСҮН)-ийг, 2016 онд өөрчлөн зохион байгуулж Монголын Хил Судлалын Академийг байгуулсан билээ.

Энэ нийгэмлэг, академи нь Мэдээлэлжүүлэлтийн Олон Улсын Академитай холбоо тогтоохоос ажлаа эхэлж уг академийн Холбооны Хилийн Албаны Академийн хил судлал (погранология)-ын хүрээлэн, мөн БНХАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны академийн Зах хязгаар бүс нутгийн түүх, газар зүй судлалын төв зэрэг хил хамгаалалт, хилийн аюулгүй байдал, хилийн харилцаа, хилийн эрх зүй, хилийн түүхийн талаар судалгаа хийдэг байгууллагуудтай харилцаа тогтоож, хамтран ажиллаж байна[2].

Хил судлалын шинжлэх ухааны бүрэлдэхүүн хэсгүүд тодорхойлогдож системчлэгдэн, бүрэн ойлгомжтой мэдлэг хуримтлагдаж, хил судлалын шинжлэх ухаан нь цэргийн шинжлэх ухаанаас ангид, бие даасан шинжлэх ухаан болсон тул, 2010 оны 5 дугаар сарын 20-нд "Мэргэжлийн чиглэл, индекс, шинэчлэн тогтоох тухай" Монгол Улсын

[1]К.Маркс, Ф.Энгельс, соч 2-е изд. т.20. с.607. М., Политиздат. 1983.

* Хууль сахиулахуй сэтгүүлд нийтлүүлэх тул хил судлалын ухааны талаар товч ойлголт өгөхийг зорив.

[2] Хил шинжлэл сэтгүүл. УБ., 2017 он. № 1. х.3-8.

боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 235 тоот тушаал гаргуулан, шинжлэх ухааны улсын бүртгэлд бүртгүүлж мэргэжлийн ангилалд оруулан, Хил судлалын ухааны доктор, магистрын зэрэг хамгаалуулж байна.

E	F	86	25	00	Хил судлал

Хил судлалын шинжлэх ухааныг Монгол Улсад дэлгэрүүлэх, хилчид төдийгүй өргөн олон нийтийн хүртээл болгоход 2001 онд доктор, тэргүүлэх профессор Г.Давгажамцын үүсгэн санаачилсан онол-арга зүй, танин мэдэхүйн 921 тоот улсын бүртгэлийн дугаар, 14921 тоот индекс, ISBN: 978-99973-41-65-5 код бүхий “Хил судлал” сэтгүүл ихээхэн үүрэг гүйцэтгэж, хилчид, олон нийтэд хил судлалын шинжлэх ухааны шинэ мэдлэг түгээх, оюуны үнэт хөрөнгө оруулж байна.

Хил судлалын шинжлэх ухаан ОХУ болон Монгол Улсад төдийгүй олон улсад хөгжиж байгаа бөгөөд хөрш БНХАУ ч хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлсэд олон улстай хөл нийлүүлэн алхаж, өөрийн онцлогтой “Хил хамааралтын ухаан”-ыг бий болгоод байна.

Шинжлэх ухаан улам бүр нарийсан мэргэшиж буй үйл явц болох шинжлэх ухааны ялгарал хилийн шинжлэх ухааныг тойроогүй билээ. Тухайлбал: Хилийн шинжлэх ухаан нь лимологи (улсын хил зааглалтын ухаан), погранлоги (хил судлалын ухаан), границеведение (хил шинжлэхүй) хэмээн салбарлаж улам бүр нарийсан хөгжиж байна.

1. Лимология-хилийн тухай шинжлэх ухаан (Lines-хил, Logos-сургаал, ухаан эсвэл шинжлэх ухаан, түүний салбар гэсэн грек үгнээс гаралтай) нь газар зүй, түүх, улс төр судлал, социологи, олон улсын харилцаа зэрэг олон тооны шинжлэх ухааны сонирхол давхацсан шинжилгээ судалгааны талбар юм. Улсын хил зааглалын ухаан гэсэн утгаар хэрэглэх хандлага давамгайлах болсон. Лимологи нь хил орчмын нутаг дэвсгэр, түүнд болж буй үзэгдэл, үйл ажиллагаа, түүнтэй холбоотой хууль эрх зүйн орчинг судалдаг шинжлэх ухаан юм[3]. Лимологийн ухааны гол төлөөлөгчид нь Колосов В.А[4],. Мироненко Н.С [5] нар бөгөөд В.А.Колосов нь “лимологи нь улсын хилийн тухай цорын ганц шинжлэх ухаан мөн” үздэг, улс төрийн газар зүйн шинжлэх ухааны нэг салбар болон хөгжиж байна.

2. Хил судлал-погранология буюу *frontiology* гэдэг нь *пограничный*-хилийн гэсэн орос, *frontier* –хил гэсэн англи, *logos*- мэдлэг гэсэн грек

[3] Дмитриева С.И. Лимология: учебное пособие. Воронежский государственный университет. Воронеж: Издательско-полиграфический центр Воронежского государственного университета, 2008, С. 5.
[4] Колосов В.А. Теоретическая лимология: новые подходы // Международные процессы. 2012. Т. 10. № 2(29). Май-август.
[5] Колосов В.А., Мироненко Н.С. Геополитика и политическая география. М.: Аспект Пресс, 2001.

үгнээс гаралтай, тухайн улсын хилийн талаар баримтлах бодлогыг шинжлэх ухаанаар хангах, эхний ээлжинд хил хамгаалах субьектүүдийн хилийн аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэслэлийг тогтоох, хилийн асуудлын хүрээнд (пограничная сфера) явагдах үзэгдэл, үйл явц, хууль, зүй тогтлуудыг судалдаг шинжлэх ухаан юм. Пограничная наука-Хилийн шинжлэх ухааныг бид хил судлал хэмээн нэрлэж заншсан.

3. Границеведение-хил шинжлэхүй-Норвеги-Оросын их сургуулийн шинжлэх ухааны бүрэн гүйцэд боловсрогдоогүй шинэ сургаал бөгөөд улс төрийн философи, соёл, олон улсын хамтын ажиллагааны магистрын хөтөлбөр юм. Энэ нь Норвегийн Будё хотод байрладаг Нурландын их сургууль, Мурманскийн хүмүүнлэгийн ухааны их сургуулийн эрдэм шинжилгээний бааз дээр хэрэгждэг, Болонскийн тунхаглалын үзэл санаа дээр суурилдаг[6].

Улсын хил гэдэг нь бие даасан, бүрэн эрхт, үндэстэн улсуудтай нягт холбоотой ойлголт бөгөөд үндэстэн улсын статус, тодорхойлолт, түүнийг хэрхэн ангилж эрэмбэлэхтэй холбоотойгоор улсын хил гэдэг ойлголт ухагдахууны мөн чанар, агуулга улам бүр баяжин шинэчлэгдсээр байна.

Хил судлалд ерөнхийд нь онол-арга зүйн уламжлалт болон постмодернист гэсэн хоёр хандлага давамгайлж буй бөгөөд шинэ хандлагууд хуучнаа бүрэн үгүйсгэх бус харин баяжуулан төгөлдөржүүлэх замаар явж ирэв.[7]

Уламжлалт хандлагуудад түүх-газрын зургийн, типологийн, функционал, улс төрийн хандлага багтана. Түүх-газрын зураг, типологийн аргууд нь хилийн шугамыг хэрхэн тогтоож ирсэн, түүнд нийгэм, улс төр, газар зүй, эдийн засгийн хүчин зүйлс хэрхэн нөлөөлж ирснийг голчлон судалдаг бол функционал хандлага нь хилийг гол төлөв гүйцэтгэж ирсэн чиг үүрэг талаас нь судалдаг.

Энэ үүднээс авч үзвэл хил нь зааглан тусгаарлах, холбон нэгтгэх, хянан шалгах гэсэн 3 үндсэн чиг үүрэгтэй. Хилийг функционал хандлагын үүднээс судлах явдал аажмаар улс төрийн хандлагын арга буюу олон улсын харилцааны болон олон улсын хууль, эрх зүйн онолын парадигма руу хөтөлдөг зүй тогтолтой нь харагдаж байдаг.

Газар зүйн нэр нь тухайн улс, үндэстний үгсийн сангийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд соёлын (биет бус) өвийн онцгой нэгэн төрөл зүйл учир түүнийг хадгалан хамгаалах, үнэн зөв бичиж, ном товхимол,

[6] Рабочее совещание в Киркенесе 2010; Степень магистра границеведения -2012.

[7] В.А. Колосов. Теоретические подходы в изучении границ, // *Введение в исследования границ* / под ред. С.В. Севастьянова., Ю. Лайне., А.А. Киреева. – Владивосток: Дальнаука, 2016. С-36.

хэвлэл мэдээлэл, газрын зураг зэрэгт батлагдсан үнэн зөв нэрийг хэрэглэх, гадаад хэлэнд галиглах, бусад улс үндэстнүүдтэй газар зүйн нэрийг солилцох зэрэг асуудал нь төр, засгийн анхаарлын төвд байх чухал асуудлуудын нэг юм.

Үүгээр ч зогсохгүй газар зүйн нэр нь тухайн улсын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, угсаатан зүйн түүх, соёл, эдийн засаг, хүн амын суурьшил зэрэгтэй салшгүй холбоотой байдаг. Тухайлбал Монголын нууц товчоо хэмээх их хөлгөн сударт 220 гаруй газар зүйн нэр гардаг бөгөөд 120 гаруй нэр одоогийн Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаагаас 70 гаруй нэрийг илрүүлээд байна. Жишээ нь Бурхан халдун, Бүрэг эрэг гэх мэт. Түүхэн ном зохиолд гарч байгаа газар зүйн нэр нь ихэвчлэн бэлчээрийн даац сайтай, ус ургамал, ашигт малтмал ихтэй, ган зуд бага болдог газрууд байдаг нь судалгаагаар тогтоогдсон байна. Иймээс түүхэн нэрийг судлах нь эдийн засгийн хувьд ач холбогдолтой юм.

Газар зүйн нэр нь газрын зургийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Тухайлбал: 1934 онд А.В.Казакевич “Монголын газар зүйн нэр” бүтээл туурвисан байдаг. Мөн 1925 онд ЗХУ-ын /хуучнаар/ Шинжлэх ухааны академийн дэргэд Монгол газар зүйн нэрийн комисс байгуулагдаж, газар зүйн нэрийн уйгаржин-монгол бичгийг тайлах аргачлалыг боловсруулж байжээ. Үүний дүнд “Орчин цагийн Монголын газар зүйн нэр” бүтээл хэвлэгдсэн нь Монгол газар зүйн нэрийг судлахад ихээхэн чухал баримт бичиг болж үлдсэн.

Манай орон зах зээлийн харилцаанд шилжин, хүн амын суурьшилд ихээхэн өөрчлөлт гарснаар олон зуун жилийн түүхтэй уламжлалт газар зүйн нэр мартагдах болсон төдийгүй дур мэдэн шинээр нэр өгөх, өөрчлөх, хэвлэл мэдээлэл, ном товхимол, газрын зурагт янз бүрээр бичиж нийтлэх болж, газар зүйн нэрийг хамгаалах, журамлах асуудлууд орхигдох зэрэг олон сөрөг үр дагаврууд гарах боллоо. Жишээлбэл:

- Монгол улсад шарын шашин дэлгэрсэнтэй холбоотойгоор газар зүйн нэр өөрчлөх явдал маш их байсан /Богд хаан уулыг Дүнжингарав уул, Гурван цаст уулыг Цамбагарав гэх мэт/;
- Баруун аймгийн иргэд батлагдсан газар зүйн нэрийг өөрсдийн хэл рүү орчуулан нэрлэх /Баян-Өлгий аймаг/;
- Нутаг дэвсгэрийг үр тариа тариалдаг талбайн хэмжээгээр 1000-ын пооль, 60-ын хоолой, 70-ын хөндий гэх мэтээр нэрлэх /Дорнод аймгийн Халхгол сум, Сэлэнгэ аймаг/;
- Газар зүйн нэрийг өөрчлөн нэрлэх /Орхон аймгийн төвөөс баруун тийш явах авто зам дагуу байх “Залуугийн булаг” гэсэн булгийг Орос цэргүүд байнга ирж ус авдаг байсан болохоор “Оросын булаг” гэж нэрлэсэн байна/;

• Газар зүйн нэрийг өөр өөр бичих, галиглах /Булган аймгийн нутагт байх Цачиртын гол гэдэг уулын жижиг голыг Цочиртын гол, Сачиртын гол, Чочиртын гол гэх мэтээр нэрлэж бичсэн байна/

• Сүүлийн үед гар утасны сүлжээ барьдаг эсэхээр нь /Моби толгой, Скай толгой зэргээр/ нэрлэх болсон;

• Газрын тос олборлож байгаагаар 19-ийн талбай, 21-ийн талбай гэх мэт;

Монгол Улс анх 1949 онд Сайд нарын Зөвлөлийн ”Газар нутгийн нэрийг дур мэдэн өөрчлөх явдлыг хориглох тухай”, 1961 онд “Комисс байгуулах тухай” тогтоолууд гарч, газар зүйн нэрийг тодотгон тогтоох, цуглуулах талаар орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад албан даалгавар өгч байсан юм.

“Газар нутгийн нэрийг тодруулан тогтоож, журамлах зарим арга хэмжээний тухай” Сайд нарын Зөвлөлийн (хуучин нэрээр) 1980 оны 280 дугаар тогтоолоор “Улсын газар нутгийн нэрийн байнгын комисс”-ийг байгуулж, газар нутгийн нэрийг тодруулан тогтоох, газрын зураг тэмдэглэх, цаашид газар зүйн нэрийг дур мэдэн өөрчлөх явдлыг зогсоох зорилгоор улсын бүх нутаг дэвсгэрийн хэмжээнд газар зүйн нэрийг тодруулан тогтоох ажлыг Улсын геодези, зураг зүйн газарт даалгаж байжээ.

Тус тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 1980-1987 онд Улсын геодези, зураг зүйн газраас Монгол орны бүх нутаг дэвсгэрт газар зүйн нэрийн хээрийн судалгаа явуулан 242388 нэрийг тодотгон тогтоожээ.

Геодези, зураг зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлээр газар зүйн нэрийн асуудлыг хуульчилсан бөгөөд 5 дугаар зүйлийн 5.1.3-т заасны дагуу тус газар нь Монгол орны 214805 газар зүйн нэрийн жагсаалтыг гаргаж УИХ-ын 2003 оны 42 дугаар тогтоолоор батлуулсан[8].

Эрт дээр үеэс уламжлагдан нэршиж, олон зуун жилийн хугацааг даван туулж дархлаажсан, Монгол Улсын албан ёсны газрын зураг, газар зүйн болон замын сүлжээний мэдээллийн санд батлагдан хадгалагдсан газар усны нэрийг хуульчлагдсан хуулийн нэр томьёо гэж үздэг. Зайлшгүй шаардлагатай үед газар усны нэрийг өөрчлөх нь хэн нэгний дурын асуудал биш хүний нэр, овог солихтой адил хуулийн процессоор явагдах үйл явц юм.

Газар орны уламжлалт нэрийг хууль бусаар өөрчлөх нь:

[8] https://www.gazar.gov.mn/p/566-110

Монгол Улсын Геодези зураг зүйн тухай хуулийн 4.1.5. газар зүйн нэрийн жагсаалт (каталог) зохиож хөтлөх, толь бичиг, лавлах боловсруулж хэвлэх;

4.1.7. геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан бүрдүүлэх;

5.1.3. газар зүйн нэрийг батлах;

5.8.4. нутаг дэвсгэртээ хамаарах газар зүйн нэрийн хэрэглээнд хяналт тавих, шинэ нэрийн талаар санал дэвшүүлэх,

11 дүгээр зүйл.Газар зүйн нэр

11.1. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг газар зүйн албан ёсны нэрийн тухай мэдээллээр хангах, газар зүйн нэрийг зөв бичих, хэрэглэх, хамгаалах асуудлыг сум, дүүргийн Засаг дарга, геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн хамтран зохицуулна. /Энэ хэсэгт 2003 оны 6 дугаар сарын 12 өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

11.2. Газар зүйн нэрийн жагсаалт зохиох, толь бичиг, лавлах боловсруулж хэвлэх, нэрийг зөв бичих, шинээр өгсөн нэр болон нэрийн өөрчлөлтийн бүртгэл хөтлөх, газрын зурагт тусгах зэрэг ажлыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь шинжлэх ухааны болон холбогдох бусад байгууллагын санал авч хэрэгжүүлнэ. /Энэ хэсэгт 2003 оны 6 дугаар сарын 12 өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

11.3. Газар зүйн нэрэнд дараах объектын нэр хамаарна:

11.3.1. эх газар, далай, тэнгис, булан, тохой, арал, хойг, уул, нуруу, хээр, тал, говь, цөл, мөрөн, гол, нуур зэрэг физик газар зүйн объект;

11.3.2. хүний үйл ажиллагаагаар бий болсон далан, усан сан, суваг, шуудуу;

11.3.3. улс, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, тэдгээрийн доторх хөдөө аж ахуй, үйлдвэр, тээвэр, холбоо зэрэг бусад объект.

11.4. Газар зүйн хуучин нэрийг тодотгох, шинээр тогтоохдоо лавлагааны болон түүхийн эх сурвалжид үндэслэх бөгөөд аливаа эх сурвалж байхгүй бол нутгийн уугуул иргэд, мэргэжлийн хүмүүс, судлаачдын саналыг үндэслэн тогтооно.

11.5. Шинээр байгуулсан объектыг нэрлэхэд дараах зарчим баримтална:

11.5.1. тухайн объектыг нээх, судлах, барьж байгуулахад оролцсон буюу эзэмшиж байгаа хүний нэрээр нэрлэх;

11.5.2. газар зүйн хуучин нэрээр нь зүг чиг, өнгө, цаг хугацааны тодотголтой нэрлэж болох;

11.5.3. ойролцоо орших өөр төрлийн объектууд нь ижил нэртэй байж болох.

11.6. Газар зүйн нэрийг дараахь онцгой тохиолдолд өөрчилж болно:

11.6.1. адил төрлийн хэд хэдэн объектын ижил нэр нь зам, тээвэр, харилцаа холбоо, бусад байгууллагын ажилд хүндрэл учруулахаар байвал;

11.6.2. уугуул иргэд нь нэрлэж заншсан уламжлалт нэрийг сэргээх хүсэлт тавьсан;

11.6.3. тухайн объектын мөн чанарт тохирохгүй, этгээд хэллэгээр нэрлэгдсэн байвал.

11.7. Шинээр нэрлэх, өөрчлөх газар зүйн нэр дараах шаардлагыг хангасан байна:

11.7.1. хүрээлэн буй орчин, газар зүйн объектын тодорхой шинж, түүх, соёл, ахуйн онцлогийг тусгасан байх;

11.7.2. монгол хэлний бичлэг, хэллэгт тохиромжтой гурваас илүүгүй үгээс бүтсэн байх.

11.8. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хамаарах газар зүйн нэрийг Засгийн газар нэгтгэн Улсын Их Хурлаар батлуулна.

12 дугаар зүйл.Хориглох үйл ажиллагаа

12.1.3. албан ёсны баримт бичиг, арга хэмжээнд газар зүйн албан ёсны нэрийг өөрчлөн хэрэглэх, монгол хэлнээс бусад хэлээр орчуулах, бусад хэлний дуудлагаар галиглах,

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 19.16 дугаар зүйл. Хууль бусаар газар орны нэр өөрчлөх

1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хилийн цэс, газар орны нэрийг хууль бусаар албан ёсны баримт бичиг, газар зүйн зурагт өөрчилсөн бол дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Монгол Улсын зөрчлийн тухай хуулийн 9.10 дугаар зүйл. Монгол хэлний тухай хууль зөрчих

1.Монгол хэлний тухай хуулиар тогтоосон хориглосон зохицуулалт, эсхүл журам зөрчсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Монгол хэлний тухай хуулиар тогтоосон:

2.1. хот, суурин газрын гудамж, талбайн нэр, хаяг, төрийн байгууллагын нэрийг төрийн албан ёсны хэлээр бичих;

Монгол хэлний тухай хууль, 6 дугаар зүйл. Монгол хэлийг хэрэглэх

6.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт дараах үйл ажиллагаа, албан хэргийг монгол хэлээр хөтлөн явуулна:

6.1.7. газар нутаг, засаг захиргааны нэгж, гудамж, зам, талбай, хуулийн этгээдийн нэр, хаяг;

21 дүгээр зүйл.Хэлний бодлогын үндэсний зөвлөл

21.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд монгол хэлийг хамгаалах, хөгжүүлэх үндсэн үүрэг бүхий Хэлний бодлогын үндэсний зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ ажиллана.

21.7. Зөвлөл дараах үүрэг хүлээнэ:

21.7.5. энэ хуулийн 22.1-д заасан эрх бүхий судалгааны байгууллагаас боловсруулсан гадаад нэр томьёоны орчуулга, монгол хэлний үгийн санд оруулах шинэ нэр томьёог хэлэлцэн батлах;

21.7.6. газар нутаг, гудамж, зам, талбайд гадаад нэр оноох эсэх асуудлаар санал, дүгнэлт гаргаж нутгийн өөрөө удирдах байгууллагад илгээх;

22.2.4. газар нутгийн оноосон нэрийг толь бичигт оруулах, жигдлэх, олон улсын газар зүйн нэрийн тольд бүртгүүлэх талаар энэ хуулийн 21.1-д заасан эрх бүхий байгууллагад санал гаргах зэрэг хуулийн заалт зөрчиж буй онц ноцтой асуудал юм.

Монгол улсын ерөнхийлөгчийн 2017 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 186 тоот “Нутаг орны газар зүйн нэрийг хамгаалах тухай” зарлигт: Монгол Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын нутаг дэвсгэрийн газар зүйн нэрийн жагсаалт” дахь газар усны газар зүйн нэрийг албан хэрэг, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд мөрдүүлэх, тухайн орон нутагтаа ард иргэдийн дунд сэргээн хэвшүүлэх, цаашид хууль бусаар газар орны нэр өөрчлөх гэмт явдалтай хууль тогтоомжийн дагуу тууштай тэмцэхийг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай. Уул ус, газар нутгаа эрх бүхий байгууллагаас баталсан нэрээр зөв нэрлэж занших, өөрчлөн буруу нэршихээс сэргийлэх, монгол хэлнээс бусад хэлээр орчуулах буюу бусад хэлний дуудлагаар галиглахгүй байхыг Монгол Улсын нийт иргэд, байгууллагад уриалсугай гэж заасан байдаг.

Монгол Улсад газар орны уламжлалт уугуул нэрийг хадгалах, хамгаалах, өөрчлөх асуудлыг шийдвэрлэх хууль эрх зүйн орчин харьцангуй сайн бүрдсэн хэдий ч, амьдрал дээр хэрэгжүүлэх асуудал нь хэт хоцорч байна.

Газар орны уламжлалт нэрийг өөрчилнө гэдэг хилийн түүх бүдгэрэх, газар орны маргаанд хүргэх, газар нутгийн түрэмгийлэлд турхирах аюултай.

Монголчууд “Юманд учир, суманд гичир бий” гэдэг нь зүгээр нэг хэлээгүй үг билээ. Тэр тусмаа газар орны нэрийг оноон өгөхдөө тухайн газар орны онцлог, түүх, ашигт малтмал агуулж байгааг нь харгалзан өгсөн байдаг.

Энэ тухай гадаадын судлаачид ч онцлон тэмдэглэн үлдээсэн байдаг. Тухайлбал, Алдарт аялагч, эрдэмтэн Г.Н.Потанин: “Монголчууд газар усыг нэрлэх талаар гайхамшигтай мэргэшсэн аж. Тэд гол мөрнийг бүрэн

байдлыг мэдэрдэггүй юм уу гэлтэй гольдролын хэсгүүдийг хэд хэдэн нэрээр нэрлэсэн байдаг. Харин голын ойролцоо байдаг уул, түүний ойролцоох нуур, нуурыг тойрсон хээр тал ихэвчлэн голтой ижил нэртэй байдаг[9].

Аялагч Э.М.Мурзаев: “Говийнхон булаг усны бурханлаг гарал үүсэлд итгэж, түүнийг хүндэтгэлтэйгээр рашаан гэж нэрлэдэг. Азийн олон хэлээр энэ үг өөр өөр сонсогддог ч (арасан-Казахууд, арашан-Киргизүүд, нарзан-Хойд Кавказ, рашиани-Энэтхэгчүүд), “Ариун ус”-бурхдын ундаа, бал гэсэн нийтлэг утгатай[10].

“Дэлүүн болдог” уулын нэрийг өөрчлөн нэрлэчихсэн байсан бол их Чингис хааныхаа түүхтэй холбогдох газар орныг тодруулах боломжгүй болох, “Эрдэнэт”, “Оюу толгой”-н нэрийг өөрчилчихсөн бол эрдэнийн үүцээ олох, задлахад хүндрэл учрах байсныг үгүйсгэх аргагүй юм.

Хил орчмын газар орны нэрийг уламжлалт Монгол нэрээр нь нэрлэж хэвших, зохиомол нэр өгөх, уйгаржин монгол бичиг, орос эхээс зөв монголчлон буулгах, алдааг залруулах, ялангуяа баруун чиглэл Баян-Өлгий аймгийн хилийн хэсэгт казах хэлээр нэрлэн нутагшуулсан зэрэг сөрөг үзэгдэлтэй хатуу тэмцэх шаардлагатай болжээ.

Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрийн 305 уул, ус, газар нутгийн нэрийн 267 буюу 87% нь казах нэршилтэй болсон байна гэсэн түгшүүртэй судалгааг судлаач Отгонбаярын Отгон хийсэн байдаг.

Манай хилчид хилийн газар орны уламжлалт нэр, нэршлийг өөрчлөх бусармаг хэрэгт хошуучлан оролцож буй нь харамсалтай. Нэртэй газрыг нэрээр нь, нэргүй газруудыг тоот өндөрлөгөөр нь нэрлэх ёстой. Аль ч отрядын хилийн хэсэгт “Ахмадын өндөрлөг”, “Хурандаагийн овоо”, “Хилчин толгой’’,”Моби толгой”, “Хүлээхийн давлан”, “Чонын үүрт”, “Бузар даваа”, “Хоног толгой” гэх зэргээр нэрлэсэн зохиомол нэртэй газрууд бий.

Хангийн ШНБ анх байгуулахдаа “Баянбулаг” ШНБ гэж нэрлэж байсан. Хангийн салбартай андуурагдах болж газар зүйн мэдээллийн болон авто замын сүлжээнд албан ёсоор тусгагдаагүй байна.

Сыргалийн застав-Ээмэгтийн застав юм л даа. Сыргалыг үгийн үндсэн гарал нь Сыралыг гэдэг тыва үг бөгөөд өндөр гуалиг, нарийхан, тэгш, нягт шигүү ургасан модыг “сыра” гэж нэрлэдэг “сыра+лыг=сыралыг болоод ирэхээр “тийм модтой” гэсэн утгатай бөгөөд “сыра” бол унаган

[9] Г.Н.Потанин. (1883). Очерки Северо-Западной Монголии. Результаты путешествия, исполненного в 1876-1877 годах по поручению ИРГО членом-сотрудником онаго Г.Н.Потаниным. Дневник путешествия и материалы для физической географии и топографии Монголии. Вып.I, СПб.

[10] Э.М.Мурзаев. (1948). Второе Тибетское путешествие Н.М.Пржевальского // Н.М.Пржевальский. От Кяхты на истоки Желтой реки. Исследование северной окраины Тибета и путь через Лоб-нор по бассейну Тарима. М.

казак үг биш. Сыргалыг гэдэг нь тыва хэлээр “ээмэг” -тэй гэсэн утгатай. Эрт дээр үеээс тыва хүмүүс амьдарч байсан болохоор тыва нэрээр нэрлэсэн газрууд байх магадлалтай.

Идыг оек /тыва нэр/-Сэтэрт салаа-одоо казахаар Каскар дара-Чонотой салаа болчихсон байдаг. Уламжлалт монгол болон тыва нэр энэ мэтээр казах нэр болон ондоошсон жишээг олж болно. Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэн энэ хилийн салбарын нэрийг монголоор нь нэрлэн өөрчлөх үндэслэл бий, хэрэгжүүлэх ёстой. Миний хувьд, “Хотон нуурын эсвэл Хурган нуурын застав” хэмээн нэрийдэхэд болохгүй гэх газаргүй юм гэсэн саналыг дэвшүүлж, мэргэн уншигч-хилчидтэйгээ хуваалцсаар ирсэн, хуваалцаж байна. Өгүүллийг хэвлэгдэх энэ мөчид ХХЕГ-ын даргын тушаалаар Сыргалийн заставын нэрийг “Хотон нуурын застав” гэж өөрчлөн нэрлэх тушаал гарсанд таатай байна.

Тэнд казах нэртэй, нэршилтэй нэг ч газар байгаагүй, байх ч ёсгүй юм. Таван Богд хайрханыг Бес Богда, Шар нохойт голыг-Сэрий Кокойдо, Хулдын цагаан толгойг-Ялдагоя, Чонот уулыг-Алун толгой, Цагааннуурыг-Ак куль, Цагаан салаа-Аксай, Есөн харгайт-Жалангаш /Нүцгэн/ гэх мэтээр казах нэр өгсөн, Хар ямаат-Хара жамат, Шар ямаат-Сар жамат, Чихэлцэг-Чигэлчиг, Салхит-Салиг гэх зэргээр монгол нэрийг казах аялгад нийцүүлэн гуйвуулсан нэр цааш үргэлжилнэ.

Интернетэд тавигдсан иргэдийн коммент, сэтгэгдлээс ганц хоёрыг л танилцуулахад:

Алтай Таван Богд болон Монголын 400 гаруй уул усны нэрийг казакчилчаад сууж байгаа казах ахан дүүсээ! Наанадаж Монголын, цаанадаж Дэлхийн газар зүйн нэр томьёонд гар хөлөө бүү дүр! Калифорны нийслэл одоо хирнээ Сакременто гээд испани нэртэй хэвээрээ! Аляскийн хойгийн арал, тохойнууд Адаг сүүл, Атга сүх гэсэн монгол нэрээ хадгалсаар байгаа түүх түүхээрээ үлддэг юмаа. Нүүсэн, суусан газартаа хүндэтгэлтэй хандаж соёл иргэншлийн жишгээр амьдарна уу?

2019 онд ШӨХТГ-аас Баян-Өлгий аймагт монгол хэлээр нэрлэгдээгүй Засаг захиргааны нэгж, гудамж байгаа эсэхэд хяналт хийж, нэр бүхий сумуудад казах хэлээр оноосон нэр өгсөн зөрчил илэрч, зөрчлийг арилгуулсан.

Казах хэлээр оноосон нэр өгсөн гэх хэргийг цагдаагийн байгууллагаас жилийн өмнөөс мөрдөн шалгаж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа юм байна.

Энэ хэрэгт Баян-өлгий аймгийн засаг дарга асан А.Гылымхан, Аймгийн одоогийн засаг дарга Д.Баурыжан, Засаг даргын орлогч асан А.Камелият, одоогийн засаг даргын орлогч хийж байгаа С.Хонаев,

Аймгийн Улсын бүртгэлийн дарга асан С.Арман нарын аймгийн удирдлагуудыг эрүүгийн хариуцлагад татан шалгаж байна.

Дээрх албан тушаалтнууд суманд баг байгуулах тухай аймгийн иргэдийн хурлын тогтоолыг батлуулан Улаанхус, Дэлүүн, Сагсай сумуудад шинээр баг байгуулах, Баян-өлгий аймагт гудамж, талбай, уул, толгодыг Монгол хэлээр биш Казах хэлээр нэрлэж байгаа асуудал удаа дараа яригдаж байгаа бөгөөд тухайлбал МҮОНТ-ийн “Эрэн сурвалжлах нэвтрүүлгийн баг” 2019 онд Баян-Өлгий аймгаас “Нэг улс хоёр хэлний бодлого”, “Хязгааргүйн хязгаарт” гэх хоёр нэвтрүүлгийг бэлтгэн нийтэд хүргэсэн байдаг юм.

Увс аймгийн Давст сумын нутагт орших Торхилог хилийн голыг зарим зурагт Тохилогын гол, Торголык гол хэмээн орос байдлаар болон огт буруу нэрлэж тэмдэглэсэн байх жишээтэй.

Сэлэнгийн хилийн ангийн Номтын застав гэхэд л Нумт булгийн эхэнд нэгэн том нумыг тахиж байснаас “Нумт” гэж нэрлэж байсан, мөн Алтанбулагийн зүүн хойт талын уулыг бид Бүргэдэй гэж нэрлээд заншчихсан болохоос уг нь “Бүрхэтэй уул” байх жишээтэй. Уйгаржин монголоос кириллд буулгахдаа алдаа гаргасан, 1727 онд Хаант Орос-Манж чин улсын хооронд байгуулсан Буурын хилийн гэрээнд “Бүрхэтэй уул” нэрээрээ байдаг.

Төвийн бүсэд ч асуудал бий бөгөөд шилжин суурьшигчид ёстой л “бурхангүй газрын бумба галзуурна” гэдэг шиг л харагдсан үзэгдсэн газраа уугуул нутгийнхны шаардлага, уламжлалт нэрийг үл ойшоон өөрсдийнхөөрөө, өөрийн нутгийн уул, усаар нэрлэж нутагшуулсаар байдаг үзэгдэл хавтгайрах шинжтэй, анхаарах ёстой асуудал болж байна.

Түүх сөхөхөд, төмөр замын Рашаант өртөө байгаа газрын уугуул нэр нь “Ар шанд” бөгөөд төмөр зам барьж байсан оросууд “Ар шант” хэмээн дуудах болсон нь цаг хугацааны явцад сунжирч “Рашаант” хэмээн нэрийдэж өнөөг хүрсэн байх жишээтэй.

Буриад судлалын академи, түүний эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор Л.Оюунцэцэг, МҮИС-ийн Аялал жуулчлалын сургуулийн багш, доктор О.Сүхбаатар нар төрсөн нутаг усныхаа уугуул, уламжлалт нэрийг хэвээр хадгалахын төлөө зүтгэн тэмцэж, судалгааны ихээхэн ажил хийж байгаа бөгөөд Дорнод аймгийн Баяндун суманд гэхэд л 965 газар ус, 94 худгийн нэрсийг судлан тогтоож, цагаан толгойн үсгийн дарааллаар цуваажуулан жагсаан баталгаажуулсан энэ мэт сайхан эх оронч жишээг орон нутаг бүрт дэлгэрүүлмээр санагдана[11].

2017 оны 10 дугаар сард ОХУ, Буриад Улсын Улаан-Үд хотод болсон Монгол-Оросын хилийн усны комиссын хамтарсан хуралдаанд оролцож,

[11] Буриад судлал сэтгүүл. УБ., 2020. №9. х-62-78.

саналаа хэлэх боломж олдсон бөгөөд протоколд хилийн голын нэрийг Цөх-Чикой, Зэлтэр-Желтура, Онон- Шилка гэх зэргээр монгол, орос хэлээр давхар бичиж байх санал гаргасныг дэмжин баталгаажуулсан билээ.

Монгол Улсад төдийгүй Монголын эзэнт гүрний нутаг дэвсгэр байсан Монгол туургатны өлгий нутгуудад уламжлалт монгол нэрийг өөрчлөх, түүхийг бүдгэрүүлэх ажиллагаа байнга л хийгдэж байна.

“О.Т.Молчанова, Алтайн Бүгд Найрамдах Улсын 5400 газар зүйн нэрийг судлаад 423 нь монгол гаралтайг тогтоосон”[12] гэжээ.

“Алтайн нурууны Казахстанд хамаарах хэсгийн 2000 нэрний 7% буюу 140 нь монгол үг байна”[13] гэж тогтоосон байна.

Ойрадууд нутаглаж байсан Казахстаны зүүн хэсэг, Киргизстанд одоо хүртэл монгол нэрээрээ үлдсэн газар ус байсаар байна. Тухайлбал: Киргизстаны зүүн хэсэгт Джиргалан буюу Жаргалан, Дьюрбельджин буюу Дөрвөлжин (Яг ийм нэртэй суурингууд Хятад улсын ШУӨЗО-ы нутаг Тарвагатайд бий. Ц.Г.), Алтайн Бүгд Найрамдах Улсын өмнөд хэсгээр Чиндагатуй буюу Чандагатай, Усть-Улаган буюу Улаан, Онгудай гэсэн хотууд бий. Халимагууд байсан Казахстаны баруун хойд хэсэгт Чаган нуур гэх мэт монгол нэртэй газрууд бий.

Галдан бошигт хааны Или мөрний хөвөөнд байгуулсан Хайнаг, (Угалз) Гулз хийдийн суурин дээр хожим Хайнук, Кульж хот үүсжээ[14].

1718 онд Оросууд Зүүн гарын Цоржийн хийдээс холгүй орших буддын 7 сүмтэй газрыг эзэлж Семипалатинск (семь-долоо, палат-майхан) гэсэн бэхлэлт байгуулсан нь хожим хот болон өргөжсөн. Ойрадын түүхийг үгүй болгох гэж орчин үед газар усны нэрийг маш ихээр өөрчилж байна. Семипалатинскийг 2007 онд Семей, (Семиплатинскийг халимгууд одоо хүртэл Дархан Доржийн хийд гэж нэрлэдэг. Ц.Г.) мөн Алма-Ата хотыг Астана хэмээн өөрчилсөн нь ямар ч хэлэнд утга илэрхийлдэггүй зохиомол үг юм[15].

Эх орондоо, дотооддоо газар нутгийнхаа уламжлалт монгол нэрийг хадгалж, хайрлаж, хамгаалж чадахгүй байж гадаадад байдаг нь ч яамай байна гэж Монгол туургатны гал голомт, цөм нутагт амьдардаг эрдэмтэн судлаач бидний хувьд хандаж болохгүй юм.

---

[12] Бердибек Нуралдинович Бияров. Особенности Монгол-язычных топонимов Казакского Алтая. Усть-Каменогорск, Восточно-Казакстанский государственный университет им. С.А.Манжалова, 2012. С. 80-82

[13] Николай Гусейнов. Кыргызский каганат-тюркское государство на Енисее. TuranToday.com

[14] Ж.Сумъяа. Давст уул Оросын нутаг дэвсгэрт хэрхэн орсон бэ? УБ., 2018. х-161.

[15] Ж.Сумъяа. Давст уул Оросын нутаг дэвсгэрт хэрхэн орсон бэ? УБ., 2018. х-52.

Дүгнэлт

Монгол сайхан газар нутгийн уламжлалт нэр монголоороо дархлаажин үлдээх болон үлдэх, түүнийг хадгалахад хэл шинжлэл, түүх, газар зүй, хил судлалын эрдэмтэн судлаачдын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг уялдуулах зайлшгүй хэрэгцээ, шаардлага бий болжээ.

Монгол Улсын нутаг дэвсгэр дэх газар нутгийн уламжлалт нэр монголоороо дархлаажин үлдэх, газар орны уламжлалт монгол нэрийг өөрчлөхгүй байх хууль, эрх зүйн баталгаа, дархлаа бий болгох нь Үндэсний болон хилийн аюулгүй байдлыг хуулийн аргаар, эрх зүйн чадамжаар хангах үндсэн нөхцөлийн нэг юм.

- Уламжлалт Монгол газар усны нэрийг өөрчлөхийг хориглосон эрүүгийн, зөрчлийн тухай болон холбогдох хуулийн зүйл заалтыг хатуу мөрдөх нь зүйтэй байна. Энэ талаар эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч, алба, амьдрал дээрх хэрэгжилт нь тун хангалтгүй байна.

- Орон нутагт, ялангуяа хил орчмын нутаг дэвсгэрт газар орны уламжлалт монгол нэрийг өөрчлөхгүй байх, хамгаалж байгаа болон амьдран сууж буй нутаг орноороо бахархах, түүхийг нь судлуулах, мэдүүлэх чиглэсэн зорилго, чиглэлтэй хууль сурталчлах, эх оронч үзлийг төлөвшүүлэх соёл, сурталчилгаа, мэдээллийн ажлыг тусгай хөтөлбөр, бодлогоор байнга явуулж байх зайлшгүй шаардлагатай.

- Хилийн аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийн нэг нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн газар орны уламжлалт, уугуул нэрийг өөрчлөх, зохиомол нэр өгөх асуудал бөгөөд судалгааны ажлыг хил орчмын бүх нутаг дэвсгэрт эхний ээлжинд ялангуяа Баян-Өлгий аймгийн чиглэлд явуулах шаардлага нэгэнт бий болжээ.

Гэхдээ “гээндээ ч бий, гоондоо ч бий” гэдэг шиг Монгол хэлний тухай хуулийг ёсчлон хэрэгжүүлэх, монгол хэлний хэрэглээг бий болгох төрийн бодлого яах аргагүй энд үгүйлэгдэж байгааг зөвшөөрөх ёстой.

Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажил чухам л энд төвлөрөх ёстой мэт санагдана.

Казакстан, Шинжааны болон орон нутгийн казах хэл дээрх телевиз, радиогийн нэвтрүүлгийн нөлөө, далайц Монгол телевизүүдээс агуулгаараа, мэдээллийн ач холбогдлоороо, цагийн багтаамжаараа, сонирхол татахуйц шинэлэгээрээ, зорилтот чиглэлээрээ давж байгаатай маргах, зүйрлэх аргагүй юм.

- Газар орны нэрийг онцлогт нь тохируулаад өгөө л биз юун сүртэй юм, нэргүй л нэг муу толгой байсан ш дээ, ингэлээ гээд ямар аюул учраад байгаа юм гэх “хэвшмэл, хоцрогдсон” ойлголт амь бөхтэй байгаатай хуулийн аргаар л тэмцэхээс өөр сонголт алга байна.

-Хил орчмын нутаг дэвсгэрт ашигт малтмал хайх, олборлох зөвшөөрөл авч буй иргэд, аж ахуйн нэгжид үйлдвэрлэл явуулж буй газар

орондоо зохиомол нэр өгөхгүй байх, газар орны уламжлалт нэрийг хүндэтгэх, хэрэглэх талаарх санамжийг зөвшөөрлийн бичгийн ард байршуулах, зөвлөмж өгч анхааруулах зэрэг ажлыг Хил Хамгаалах Байгууллага, анги, салбараас бага, жижиг зүйл гэхгүй зохион байгуулж байх нь зүйтэй. Саяхан телевизээр Алтай таван богдод авирах уулчид хоноглодог газраа “Хоног толгой” гэж нэрийдсэнээ бахархалтайгаар байн байн л дурьдаж байх жишээтэй.

-“Мартсанаас, мал сүрэг мэнд үү” гэдэг шиг манай хууль хэрэгжүүлэх, сахиулах чиг үүрэгтэй байгууллагууд маань өөрсдөө хуулиа зөрчөөд байдаг юм биш үү? гэсэн нөхцөл байдал Монгол хэлний тухай хуулийг унших, судлах явцад төрж байгааг тодруулбал:

-Хил Хамгаалах Байгууллагын хил хамгаалах нэгж анги, салбарыг “отряд, застав” хэмээн нэрийдсээр он цагийг элээж байгаа бөгөөд орос ах нар өөрсдөө энэ нэршлээсээ татгалзаад даруй 10-аад жилийг өнгөрөөж байна. Манайд эсрэгээрээ өөрчлөн монголчлох нь атугай “...дугаар отряд, застав” хэмээн бичихийг нууцад оруулан баталгаажуулан улам бүр дархлаа тогтоох болсныг “хилийн” бид ойлгохгүй байгааг “хэлнийхэн”, “хуулийнхан” учрыг нь тайлж өгөх байх гэж найдна.

-Цагдаагийн байгууллагын хувьд байгууллагынхаа нэр, хувцасны ханцуй дээрх ялгах, онцлох тэмдгийг англиар “Police” хэмээн бичиж хэрэглэсээр байгаа нь мөн л хууль зөрчсөн үйлдэл хэмээн харж байгааг сонордуулах гэсэн юм.

“Чоно үүрэндээ өлзийтэй” гэдэг шиг нөгөө муу хэдэн казахуудаа монгол хэл хэрэглэхгүй байна, газар орны нэрийг “казахчлаад” байна гэж шүүмжлэх, муулахаасаа өмнө, өөрчлөлтийг өөрсдөөсөө эхэлмээр байна.

ХИЛИЙН ЗӨРЧЛИЙГ ШИЙДВЭРЛЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES ON DECISION MAKING FOR BORDER VIOLATION

Б.Зулбадрах
ДХИС-ийн ЭШНХ-ийн Инновацийн төвийн эрхлэгч, докторант, хурандаа.
Zulbardah.B
Ph.D candidate, Colonel, Director of the Innovation Center, the Joint Research Institute, University of Internal Affairs

Хураангуй: Хилийн эрх зүйн зөрчлийг тодорхой болгох, хуулийн зүйлчлэлийг зөв тогтоох, хуульд заасан хариуцлагыг нэгэн жигд оногдуулах зэрэг хилийн зөрчлийг шийдвэрлэхэд тулгамдсан асуудлуудыг тусгасан.

Abstract: This study explains common problems of the decision making for border violation, its classification, process and usage of the legislation.

Түлхүүр үг: Хилийн зөрчил, хилийн дэглэмийн зөрчил, хил орчмын дэглэмийн зөрчил, хилийн зөрчлийн зүйлчлэл.

Key words: Border Violation, Violations of Border Regime, Classification of Border Violations

Үндсэн хэсэг

Манай гараг дээрх юмс үзэгдэл, үйлдэл нэгэн цул цогцыг илэрхийлэх боловч түүнийг бүрдүүлэн бий болгож байгаа элементүүд тэдгээрийг хооронд нь зааглан ялгах орон зайн хил, зааг байдаг. Тухайлбал манай дэлхий бүс нутгуудын орон зайн заагуудад, харин бүс нутгийн орон зайн зааг нь тухайн бүсэд багтах улсын хилээр, улсын хил нь аймаг хот, сум дүүргүүдийн хилийн цэсүүдэд хуваагдан хиллэж, харилцан хамааралтай, шалтгаант холбоотой оршдог зүй тогтолтой. Иймд аль нэг улсын хилийн асуудал нь тухайн улсын дотоодод төдийгүй бүс нутаг, дэлхийн аюулгүй байдлын асуудал болдог. Хилийн зөрчил нь тухайн улсын дотоод асуудлаас гадна хил залгаа улсын хилийн асуудал бөгөөд цаашлаад дэлхийн олон улсын найрамдалт хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийг зөрчсөн асуудал болно.

Монгол Улсын Үндсэн хуулинд “Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна” гэж заасан нь улсын хилийн аюулгүй байдлыг цэрэг, техникийн хүчээр сахин хамгаалах, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг илрүүлэх, Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр, хууль, дэглэм, журмын дагуу шийдвэрлэж, таслан зогсоох ажиллагааны үндсэн зарчим болно. Улсын хилийн халдашгүй дархан байдал нь улсын хилийн шугам хууль бусаар өөрчлөгдөхгүй, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ зөрчигдөхгүй байх явдлаар хангагддаг.

Хилийн цэргийн анги, салбар, хилийн харуул, хилийн манаа нь ихэнх тохиолдолд хилийн зөрчлийн асуудлыг Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу бие даан шийдвэрлэдэг. Жишээлбэл, гадаадаас илт аж ахуйн зорилгоор хил зөрчиж байгаа үйлдэлд хил зөрчигчөөс буцаж явахыг шаардах, хариуллагагүй мал хил давж ирсэн тохиолдолд чиглэлээр нь буцаан гаргах, Монгол Улсын нутаг дэвсгэрт халдсан зэвсэгт өдөөн хатгалга, хорлон сүйтгэх ажиллагааг таслан зогсоох, хилчин иргэний амь нас, аюулгүй байдал, өмч хөрөнгийг хамгаалах зэргээр хилийн зөрчлийг ихэнх тохиолдолд газар дээр нь бие даан шууд шийдвэрлэдэг учир шаардлагатай тохиолдолд галт зэвсэг[1], албаны нохой, хүн нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх эрхийн хэм, хэмжээг Монгол Улсын Хилийн тухай хуульд хуульчлан зааж өгсөн.

Нийгмийн харилцааны салбаруудад өөр өөрийн онцлогийг агуулсан зөрчил гардаг бөгөөд түүнийг тухайн салбарт хамаарах хууль, эрх зүйн хүрээнд зохицуулж байдаг. Үүний нэгэн адил хилийн зөрчлийг шийдвэрлэх ажиллагаа нь хууль сахиулах, хил хамгаалах салбарт хамаарах олон улсын гэрээ конвенци, үндэсний хууль тогтоомж, эрх зүйн актуудад тусгалаа олдог. Энэ нь “Монгол Улсын Үндсэн хууль”, “хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр”, “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал”, “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс”, “Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлогын үндэс” зэрэг төрийн бодлогын тулгуур баримт бичгүүд болон “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль”, “Монгол Улсын Батлан Хамгаалах тухай хууль”, “Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хууль”, “Монгол улсын Хилийн тухай хууль”, “Монгол Улсын Гаалийн тухай хууль”, “Монгол Улсын Эрүүгийн хууль”, “Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”, “Монгол Улсын Зөрчлийн тухай хууль”, “Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль” зэрэг эрх зүйн актуудад тусгагдсан байна.

Улсын хил нь орон зайны хувьд нэг улс гүрний засаглалаа хэрэгжүүлэх эхлэл шугам, нөгөө улс гүрний засаглалаа хэрэгжүүлэх төгсгөл шугам (хязгаар) болдог. Өөрөөр хэлбэл хилгүйгээр ямар ч улс гүрэн оршин тогтнох боломжгүй. Улсын хил нь тухайн нутаг дэвсгэрийн дээд эрхийн хязгаарыг түүний мэдэлд орших байгалийн бүх баялгийн хамт зааглан тогтоодог учраас асар их нийгэм, улс төрийн ач холбогдолтой ойлголт учраас улсын хилийг зөрчилгүй байлгах нь тухайн улс үндэстний төдийгүй бүс нутгийн улсуудын аюулгүй байдлын асуудал болдог.

1

Зөрчил /диалектикийн/ -аливаа объект тогтолцооны харилцан эсрэг тэсрэг, бие биеийг үгүйсгэсэн атлаа дотоод нэгдэл, харилцан шүтэлцээнд оршиж буй талуудын харилцан үйлчлэл, өөрийн хөдөлгөөн, байгаль нийгмийн хөгжил, танин мэдэхүйн эх булаг[2]. Зөрчлийн категори эрсрэг тэсрэгийн нэгдэл тэмцлийн хуулийн мөн чанарыг илэрхийлж, диалектикт зонхилох байрыг эзэлдэг.

“Зөрчил” гэдэг нь зөрчих үйлийн нэр бөгөөд харилцан харших, үл тохирох эсрэг тэсрэг явдал[3] гэсэн утгыг агуулдаг гэж Монгол хэлний тайлбар тольд заасан.

“Эрх зүйн зөрчил” гэдэг нь хууль ёсны зан үйлийн эсрэг үзэгдэл[4] бөгөөд өөрөөр хэлбэл хуулийн эсрэг нийгмийн хор аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ. Эрх зүйн зөрчил нь дараах шинжтэй байна. Үүнд:

1. Үйлдэл, эс үйлдэхүйгээр илэрдэг. Үйлдэл нь хууль ёсны зан үйлийн эсрэг идэвхитэй үйл ажиллагаа байна. Эс үйлдэхүй нь үүрэг болгосон хийх ёстой, биелүүлэх ёстой үүргээ биелүүлээгүй эс үйлдэхүй байна.

2. Эрх зүйн хэм хэмжээний эсрэг чиглэсэн байна. Энэ нь эрх зүйгээр үүрэг болгосон хэм хэмжээг хийгээгүй эс үйлдэхүй, эсвэл хориглосон хэм хэмжээг идэвхитэй үйл ажиллагаагаар зөрчсөн үйлдэл байна гэсэн үг. Зарим үйлдэл, эс үйлдэхүй нь харахад зөрчил шиг мөртлөө эрх зүйн хэм хэмжээний эсрэг чиглээгүй байдаг тул зөрчил болдоггүй.

3. Гэм буруутай зан үйл байна. Гэм буруугийн санаатай буюу болгоомжгүй хэлбэртэй.

4. Нийгэмд хор аюултай байна.

5. Хууль тогтоомжид заасан хууль зүйн хариуцлагатай байна. Хууль тогтоомжоор эрх олгосон, үүрэг болгосон, хориглосон хэм хэмжээг хэрэгжүүлэхийн тулд хариуцлагын тогтолцоо буюу санкцыг зааж өгсөн байдаг. Хүлээх хариуцлагыг нь тодорхой зааж өгснөөр эрх зүйн зөрчилд тооцох хэм хэмжээг бүрдүүлж өгдөг.

Эрх зүйн зөрчил нь ерөнхий ойлголт бөгөөд дараах хэлбэрээр илэрч болно. Үүнд:

- гэмт хэрэг
- захиргааны эрх зүйн зөрчил
- иргэний эрх зүйн зөрчил
- сахилгын зөрчил

---

[2] Арвай Ш, Муратхан А, Нямдорж Ж, Наранжамц Н. Улсын хил судлал: онол, практикийн зарим асуудал. УБ., 2016. 16 дахь тал.

[3] Монгол хэлний их тайлбар толь. .https://mongoltoli.mn/dictionary/detail/48692

[4] Лүндээжанцан Д. Хууль ба амьдрал: хэлэлцүүлэг. Эрх зүйн зөрчил, УБ., 2013. Дугаар 3.

- бусад салбар эрх зүйн зөрчил байж болно. Хилийн зөрчил нь нэгэн адил эдгээр бүх хэлбэрээр илэрдэг. Харин хилийн эрх зүйн зөрчлийг олон улсын эрх зүйн актад тусгагдсан хэм хэмжээг зөрчиж байна уу, эсвэл үндэсний эрх зүйн актад тусгагдсан хэм хэмжээг зөрчиж байна уу гэдгээс хамаарч:

- ***Хилийн дэглэмийн зөрчил*** /олон улсын эрх зүйн актуудаар зохицуулагддаг/

Хил орчмын дэглэмийн зөрчил /үндэсний эрх зүйн актуудаар зохицуулагддаг/ гэж авч үзэж болно. Хилийн болон хил орчмын дэглэмээр хамгаалагдсан хамгийн чухал эрх ашиг бол Монгол Улсын хилийн халдашгүй дархан[5] байдал юм.

Шинжлэх ухаанд дэглэм гэсэн ойлголтыг олон янзаар тодорхойлдог. Тухайлбал: “Дэглэм гэж эдийн засаг, улс төр, хууль эрх зүй, цэргийн болон бусад журмыг агуулсан тухайн нийгмийн эрх зүйн харилцаанд оролцогч субъектүүдийн үйл ажиллагааг хуульчлан тодорхойлсныг хэлнэ”[6], ”Дэглэм гэж ямар нэгэн зорилгод хүрэхийн тулд тогтоосон хэм хэмжээ, үйл ажиллагааг зохицуулсан журмуудын нэгдэл юм”[7], ”Дэглэм гэж нийгмийн харилцааны хүрээнд аюулгүй байдлыг хангах эрх ашгийг хөндсөн хуульчлан тогтоосон үйл ажиллагаа, хэм хэмжээ юм”[8].

Хууль зүйн шинжлэх ухаанд дэглэм гэсэн ойлголт нь үндсэндээ эрх зүйн ерөнхий онолд хамаарагдах бөгөөд “эрх зүйн дэглэм” гэж нэрлэж хэвшсэн байдаг. Энэ нь тодорхой салбарын үйл ажиллагааг эрх зүйн хүрээнд зохицуулах онцлогийг илэрхийлэхэд тусалдаг ба аль нэг объектод захиргааны удирдлагын нөлөөллийг үзүүлэх эрх зүйн тусгай хэрэгсэл болдог.

Эрх зүйн дэглэм нь хүмүүсийн тодорхой үйл ажиллагааг зохицуулагч хууль зүйн хэм хэмжээгээр баталгаажсан дүрэм, журмын нийлбэр, эрх зүй-зохион байгуулалтын бүхий л арга хэрэгслээр хангагдсан ажиллагааны тодорхой төрлийг тохируулагч нийгмийн харилцааны цогцолбор[9]. Мөн эрх зүйн дэглэм гэдэг ойлголт нь эрх зүйн зохицуулалтын хатуу хэлбэр бөгөөд субъектүүдийн үйл ажиллагаанд үүрэг болгосон, хориглосон, хязгаарласан шинжийг агуулдаг.[10]

Эрх зүйн дэглэмийг олон улсын эрх зүйн дэглэм ба үндэсний эрх зүйн дэглэм гэж ангилан авч үздэг.

---

[5] Монгол Улсын Үндсэн хуулийн 4 дүгээр зүйл. Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна. Монгол Улсын хилийг хуулиар бататгана.

[6] Административно-правовые режимы, используемые в интересах охраны Государственной границы Российской Федераций Курс лекций, -Голцыно: ГВИ, 2000. –С.6

[7] Большой энциклопедический словарь. М., 1993. С.1113

[8] Единый словарь чекистской терминологий. Ч.2. –М., ВШ КГБСССР, 1988. –С.326

[9] Ж.Долгорсүрэн. Г.Буянхишиг. Монгол Улсын захиргааны эрх зүй. УБ., 2008. 66 дахь тал

[10] Алексеев С.С. Обшие дозволения и обшие запреты в советском праве. М., 1989. С.47

Олон улсын эрх зүйн дэглэм нь олон улсын аюулгүй байдлын асуудлыг хэлэлцэн тохирогч талуудтай байгуулсан гэрээ хэлэлцээр, конвенцийн хүрээнд зохицуулдаг бол үндэсний эрх зүйн дэглэм нь улс орны төрийн дотоод асуудлын хүрээнд аюулгүй байдлыг хангахад чиглэж, олон улсын болон үндэсний хууль тогтоомжоор зохицуулагдана. Хилийн дэглэм нь олон улсын эрх зүйн дэглэмд, харин хил орчмын дэглэм нь үндэсний эрх зүйн дэглэмд хамаарна.

Хилийн болон хил орчмын дэглэмийн талаар судлаачид өөр өөр байр суурийг илэрхийлдэг. ОХУ-ын доктор, профессор Д.Н.Бахрах нь "Хил орчмын дэглэм" гэсэн ойлголтын тухайд "хилийн дэглэм" гэсэн үгтэй ижил утгатай, яагаад гэвэл хил орчмын нутаг дэвсгэр гэсэн ойлголтон дор ОХУ-ын хууль тогтоомжоор Хил хамгаалах байгууллагад олгосон эрх, үүргийн дагуу үйл ажиллагаагаа явуулж буй нутаг дэвсгэрийг хэлж байгаа бөгөөд энэ бүх газарт тусгай дэглэм тогтоодог байна. Дэглэмийг зөвхөн нутаг дэвсгэрийн тодорхой газар тогтооно /хилийн бүсэд, харьяа тэнгис, дотоод далайн ус, оросын хил орчмын гол, нуур, усан сан, шалган нэвтрүүлэх боомтод/ гэжээ. Харин К.А.Бекяшева "Олон улсын эрх зүй" номондоо "хилийн дэглэм"-ийг хөрш орнуудтай тохиролцон тогтоодог, харин хил орчмын дэглэм тогтоох асуудал тухайн улсын өөрийнх нь дотоод үйл ажиллагаа гэжээ. Монгол Улсын Хилийн тухай хуульд хилийн болон хил орчмын дэглэмийн зорилго, агуулгыг тусгайлан заасан.

Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийг зөрчсөн үйлдэл нь хилийн дэглэмийн зөрчилд тооцогддог бол хил орчмын нутаг дэвсгэрт хилийн аюулгүй байдлыг хангахын тулд тогтоосон хууль, эрх зүйн хэм хэмжээг үл хүндэтгэн сахин биелүүлэхгүй байх, хориглосон тогтоосон журмуудыг зөрчих үйлдэл, эс үйлдэхүй нь улсын хил орчмын дэглэмийн зөрчилд тооцогдоно.

Уг зөрчлүүд нь хилийн дэглэмийн зөрчил байна уу, хил орчмын дэглэмийн зөрчил байна уу гэдгээс үл хамааран ямар эрх ашиг, ямар ашиг сонирхол хөндөгдөж байгаагаас шууд хамааралтайгаар гэмт хэрэг үү, аль эсвэл зөрчил үү гэдгийг тогтоодог.

Хилийн зөрчлийн талаарх ойлголт түүхийн хугацаанд өөрчлөгдсөөр ирсэн бөгөөд 1973 оны БНМАУ-ын Хил хамгаалах хуульд хилийн зөрчлийн талаар тодорхой заалтыг тусгаж өгөөгүй, харин хил зөрчигч гэж ямар үйлдэл хийсэн этгээдийг хэлэх талаар заасан.

1992 оны Монгол Улсын Хилийн тухай хуульд “Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, энэ хууль, хууль тогтоомжийн бусад акт, тэдгээртэй нийцүүлэн эрх бүхий байгууллагаас тогтоосон журам зөрчсөн үйлдлийг “***хилийн зөрчил***”-д тооцно” гэж тодорхойлсон бөгөөд энэхүү агуулгаар хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчил нь хилийн зөрчилд тооцогдож байна. Гэтэл шинэчлэн батлагдсан 2016 оны

Монгол Улсын Хилийн тухай хуулийн 22 дугаар зүйлд “**Хилийн зөрчил”-**д дараах үйлдлийг тооцно” гэж хуульчилсан. Үүнд:

- Хилийн боомт бус газраар улсын хилийг газар, ус, агаараар нэвтэрсэн, нэвтрэхийг завдсан,

- Хилийн боомтоор улсын хил нэвтрэх эрхийн баримт бичиггүй, эсхүл хүчин төгөлдөр бус баримт бичигтэйгээр нэвтэрсэн, нэвтрэхийг завдсан,

- Улсын хилийг газрын хэвлийгээр нэвтэрсэн,

- Хилийн боомт бус газраар тээврийн хэрэгсэл, эд зүйлийг хууль бусаар улсын хил нэвтрүүлсэн, нэвтрүүлэхийг завдсан гэж хилийн зөрчлийн субъектив /субъект, субъектив тал/ болон объектив шинж /объект, объектив тал/-ийг нарийвчлан зааж өгөлгүй зөвхөн объектив талын үндсэн шинж болох үйлдлүүдийг тусгасан нь учир дутагдалтай байна.

Хуулийн зохицуулалтаас харахад зөвхөн хилийн зөрчилд улсын хил нэвтрэх журмыг зөрчсөн үйлдлүүд хамаарч байгаа бөгөөд харин хил орчмын нутаг дэвсгэрт тогтоосон дэглэмийн арга хэмжээг зөрчсөн бусад үйлдэл, эс үйлдэхүй хилийн зөрчилд хамаарахгүй байна. Өөрөөр хэлбэл хилийн зөрчил нь хилийн дэглэмийн зөрчлийн зөвхөн нэг хэлбэр байхаар тодорхойлогдсон бөгөөд хил орчмын дэглэмийн зөрчил нь хилийн зөрчилд хамаарахгүй болсон. Эндээс хил орчмын дэглэмийн зөрчил гаргасан этгээдэд зөвхөн Зөрчлийн хуулиар хариуцлага тооцох эрх зүйн үндэслэлтэй байна.

Хилийн дэглэмийн зөрчил. Олон улсын эрх зүйн дэглэмийн нэг төрөл нь “*хилийн дэглэм*” бөгөөд ОХУ-ын эрдэмтэд ЗСХБНУ-ын үеийн Б.М.Клименко, А.А.Порк нарын “Хилийн дэглэм гэдэг бол Зөвлөлтийн хууль, эрх зүйн хэм хэмжээний акт эрх зүйн харилцааны үндсэн дээр паспортны болон хилийн хяналт, орох, гарах, түр оршин суух, хөдөлгөөн үйлдэх болон бусад журмыг тогтоосон эрх зүйн систем юм[11]” гэж, судлаач М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр нар “Хилийн халдашгүй дархан байдлыг хангахын тулд хил залгаа улсуудаас гэрээгээр тогтоосон хилийн тодорхой журмыг хилийн дэглэм гэнэ[12] гэж тодорхойлсон.

“*Улсын хилийн дэглэм***”**-ийг улсын хилийг зөрчилгүй байлгах, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг шийдвэрлэх, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, хил дээр ажил үйлдвэрлэл явуулах, хилийн харилцааг зохицуулах зорилгоор

[11] Клименко Б.М., Порк А.А. Территория и граница СССР, -М., Международные отношения. 1985. С.170.

[12] М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. Олон улсын эрх зүй. УБ., 1999. 72 дахь тал

хилийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээ хэлэлцээр, журмын цогц гэж ойлгож болно.

Монгол Улсын Хилийн тухай хуульд улсын хилийн дэглэмийн зорилгыг хил залгаа улстай хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн улсын хилийг тодорхой байлгах, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, хилийн асуудалтай холбогдсон бусад үйл ажиллагааг зохицуулахад оршино[13] гэж тодорхойлжээ.

Улсын хилийн дэглэмийн агуулга нь улсын хилийг арчлан хамгаалах, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх, хилийн ус, хил дамнасан байгууламжийг ашиглах, хил дээр ан агнуур, ажил үйлдвэрлэл явуулах, байгаль орчин, ан амьтныг хамгаалах зэрэг журмаас бүрддэг[14]. Эдгээр эрх зүйн харилцааг зөрчсөн зөрчлүүд нь хилийн дэглэмийн зөрчил болно.

Улсын хилийн дэглэмийн эрх зүйн үндсийг Улсын Их Хурал хуулиар тодорхойлж, Засгийн газар хил залгаа улстай байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээгээр хилийн дэглэмийг тогтоож, Улсын Их Хурал соёрхон баталдаг.

Улсын хилийн дэглэм нь хилийн халдашгүй дархан байдлыг хангах асуудлыг хил залгаа улстай байгуулсан гэрээ хэлэлцээр, конвенцийн хүрээнд зохицуулдаг.

Хил орчмын дэглэмийн зөрчил. Үндэсний эрх зүйн дэглэмийн нэг төрөл нь "*хил орчмын дэглэм*" бөгөөд ОХУ-ын Цэргийн нэвтэрхий тольд "Хил орчмын дэглэм гэдэг нь хилийн бүс, зурваст ажил үйлдвэрлэл эрхлэх, амьдрах, түр байх, хөдөлгөөн үйлдэх, орох гарах журмуудын нэгдэл гэж тодорхойлсон байдаг.[15]

"*Улсын хил орчмын дэглэм*"-ийг Монгол Улсын хил орчмын нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр төрийн эрх бүхий байгууллагаас хуульчлан тогтоосон хилийн бүс, зурваст иргэд нэвтрэх, оршин суух, шилжилт хөдөлгөөн хийх, ажил үйлдвэрлэл явуулах, түүнд хяналт тавих журмуудын нийлбэр гэж ойлгож болно. Хил орчмын нутаг дэвсгэр гэж хил залгаа улстай хиллэж байгаа сумын нутаг дэвсгэр[16]-ийг хэлнэ.

[13] Монгол Улсын хилийн тухай хуулийн 12 дугаар зүйл. Төрийн мэдээлэл. УБ., 2017. №6

[14] Монгол Улсын хилийн тухай хуулийн 13 дугаар зүйл

[15] Военный энциклопедический словарь. –М., Воениздат, 1989, С.563.

[16] Монгол Улсын 14 аймаг, 74 сумд нь хөрш улсуудтай хил залгаж байгаа бөгөөд хил орчмын нутаг дэвсгэрт манай улсын газар нутгийн 25 хувь хамарч, түүнд хүн амын 12 хувь оршин сууж, нийт малын 30 орчим хувь нь нутаглаж байна.

Улсын хил орчмын дэглэм нь хилийн дэглэмийг хангах угтвар нөхцөл, хил хамгаалалтыг зохион байгуулах, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх онцгой чухал арга хэмжээний суурь үндэс болдог.

Монгол Улсын Хилийн тухай хуульд "улсын хил орчмын дэглэмийн зорилгыг улсын хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилийн дэглэм сахиулах, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, улсын хил хамгаалах үйл ажиллагаа явуулахад оршино[17]“ гэж тодорхойлжээ.

Улсын хил орчмын дэглэмийн агуулга нь хилийн зурвас, боомт, бүсэд мөрдөх журмаас бүрддэг. Хил орчмын дэглэмийн үйлчлэл нь хилийн зурвас, боомт, бүсэд мөрдөх журмын үүрэг болгосон болон хориглосон хэм хэмжээг сахиулах, зөрчигдөх явдлаас урьдчилан сэргийлэх, хилийн дэглэмийн эсрэг чиглэсэн аливаа үйлдэл, эс үйлдэхүйг шуурхай бүрэн илрүүлэх, таслан зогсоох, буруутай хүн хуулийн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэх нөхцөлийг бүрдүүлэх явдлаар хангагдана.

Хил орчмын дэглэмийн зөрчлийг хилийн бүс, зурваст мөрдөх журмын зөрчил, хилийн боомтод мөрдөх журмын зөрчил гэж ангилж болно.

Хил орчмын дэглэмийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь улсын хилийн тэмдэг, тэдгээрийн холбоосыг бүрэн бүтэн байлгах,[18] зорчигч, тээврийн хэрэгсэл хилийн боомтод тогтоосон замаар нэвтрэх үүрэг хүлээх бөгөөд улсын хилийн тэмдэг, холбоос, инженер, техникийн байгууламжийг эвдэх, гэмтээх, хөдөлгөх, шилжүүлэх, зөвшөөрөлгүйгээр инженер, техникийн байгууламжийн цаана гарах, байгууламжийн хооронд нутаглах, улсын хилийн шугам, тэмдэг дээр очих, хилийн зурваст газар эзэмшүүлэх, өмчлүүлэх, зөвшөөрөлгүйгээр газар хагалах, хилийн усны гольдрол, түвшин, чиглэлийг өөрчлөх, урсгалыг боох, суваг, шуудуу татах, барилга байгууламж барих, тэсэлгээ хийх, урьдчилан мэдэгдэлгүйгээр цацраг идэвхт, химийн хорт бодис байрлуулах, тараах, хилийн шугамаас 2000 метрийн дотор агнуурын амьтан агнах, барих, амьтныг хөөж, хил давуулах, хариулгагүй мал байлгах зэрэг хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулахад саад учруулсан үйл ажиллагаа явуулахыг хориглодог.

Хориглолт, хязгаарлалтын ямар арга хэмжээг зөрчсөнөөс хамаарч хилийн зөрчлийн нийгэмд үзүүлэх хор аюул нь харилцан адилгүй байдаг. Нийгмийн хор аюулын шинжээс хамаарч тухайн үйлдэл нь гэмт хэрэг үү, зөрчил үү гэдгийг тогтооно. Нийгмийн хор аюулын шинж нь дэглэм

[17] Монгол Улсын хилийн тухай хуулийн 24 дүгээр зүйл
[18] 15.1

зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн хуулиар хамгаалагдсан эрх ашигт хэрхэн нөлөөлж буй сөрөг нөлөөллийн шинжээс хамааран тогтоогдоно.

Хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийн үүрэг болгосон хэм хэмжээ нь субъектүүд ойлгож, ухамсарласны үр дүнд хэрэгждэг бол харин хориглосон хэм хэмжээ нь ихэвчлэн хариуцлага тооцох арга хэлбэрийн үр дүнд өөрөөр хэлбэл уг хэм хэмжээг сахиагүй тохиолдолд зөрчсөн этгээдэд төрийн албадлагаар нөлөөлөх замаар хэрэгждэг.

Хилийн дэглэмийн зөрчилд хилийн асуудлаар байгуулсан олон улсын эрх зүйн актуудаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдлийг хамруулах бөгөөд олон улсын гэрээ, хэлэлцээрт заасны дагуу шийдвэрлэдэг.

Улсын хил орчмын дэглэм нь Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах системийн маш чухал арга хэмжээний нэг бөгөөд түүний үндсэн зориулалт нь улсын хил зөрчигчийг илрүүлэх, саатуулах, хил дамнасан гэмт хэргийг таслан зогсоох боломжийг нэмэгдүүлэх, хилийн дэглэмийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд оршдог. Хил орчмын дэглэмийн зөрчилд хилийн зурвас, боомт, бүсэд мөрдөх журмыг зөрчсөн үйлдлийг хамруулах бөгөөд үндэсний хууль тогтоомжийн дагуу уг зөрчлийг шалгаж шийдвэрлэнэ.

Монгол Улсын Эрүүгийн хуулиар зохицуулагддаг улсын хилийн дэглэмийн зөрчлийн нэг нь эрүүгийн хуулийн 19.14 зүйлд заасан ***“Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх”*** гэмт хэрэг болно.

Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх гэмт хэрэг гэдэг нь Монгол Улсын хилийг нэвтрэх эрхийн хүчин төгөлдөр баримт бичиггүй буюу эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, эсхүл залилан мэхлэх арга хэрэглэн хуурай газар, ус, агаарын орон зай, газрын хэвлийгээр улсын хил нэвтэрсэн /орсон, гарсан, дамжин өнгөрсөн/, нийгэмд аюултай, эрүүгийн хуульд заасан гэм буруутай үйлдлийг хэлнэ.

Хууль бусаар улсын хил нэвтэрч буй үйлдэл нь явган, автомашин галт тэрэг, ердийн хөсөг зэрэг ямарч хэлбэрээр нэвтэрсэн нь хэргийн зүйлчлэлд нөлөөлдөггүй онцлогтой.

Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх гэмт хэргийн ***халдлагын зүйл*** **нь** Монгол Улсын хил байна.

Объектив тал: Монгол Улсад орох, гарах хил нэвтрэх эрхийн баримт бичиггүйгээр, эсхүл хүурамч баримт бичгээр, эсхүл зохих зөвшөөрөлгүйгээр Монгол Улсын хилийг нэвтэрсэн үйлдэл болно.

ОХУ-ын хууль зүйн шинжлэх ухааны доктор С.В.Дъяков “Хууль бусаар улсын хил нэвтрэх гэдэг нь зохих паспортгүй буюу эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр улсын хил нэвтэрсэн /орсон, гарсан/ идэвхтэй үйлдэл гэж тодорхойлсон. Харин хууль зүйн шинжлэх ухааны доктор С.Жанцан “Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх гэж зохих

паспортгүй, визгүй буюу эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, эсхүл бусдын буюу хуурамч бичиг баримт ашиглах, түүнчлэн хилийн шалган нэвтрүүлэх, байцаан өнгөрүүлэх боомтгүй газраар нууцаар Монгол Улсын хилээр орж ирсэн, гарч явсан, дамжин өнгөрсөн идэвхтэй үйлдлийг хэлнэ" гэж оновчтой тодорхойлжээ.

Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны үүднээс авч үзвэл улсын хил гэдэг нь Монгол Улсын хилийн шугам хийгээд нутгийн гүнд байрших хилийн боомт гэдэг ойлголтыг аль алиныг багтаасан ухагдахуун юм. Монгол Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл нэвтрэх журам нь Монгол Улсын хилийн тухай хуульд заасан улсын хилийн дэглэмээр тодорхойлогдсон байдаг.

Монгол Улсын хилийн тухай хууль, хилийн дэглэмийн болон иргэд харилцан зорчих нөхцөлийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрт тогтоосноор тус улсын болон гадаад улсын иргэд Монгол Улсын хилийг зөвхөн нэвтрэхийг зөвшөөрсөн боомтоор нэвтрэх журамтай.

Тогтоосон орж, гарах замгүй газраар, мөн хилийн боомтгүй цэгээр, хилийн хяналт шалгалтанд хамрагдахгүйгээр хил нэвтрэх үйлдэл нь объектив шинжид нэгэн адил хамаарагдана.

Улсын хилийг тогтоосон боомтоор нэвтрэх эрх зүйн үндэс нь хууль ёсны дагуу олгосон эрхийн хүчин төгөлдөр баримт бичиг юм.

Хуурамч баримт бичгээр хил нэвтэрсэн гэж гадаадын иргэн, харьялалгүй хүн Монгол Улсын хилийг нэвтрэх зорилгоор гадаад паспорт, түүнийг орлох баримт бичиг, Монгол Улсын иргэн нь үнэмлэх, гадаад паспорт, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг дуурайлган хийж улсын хил нэвтэрснийг ойлгоно.

Монгол Улсын хилийг зохих зөвшөөрөлгүйгээр нэвтэрсэн гэж Монгол Улсад нэвтрэх талаар зохих байгууллагаас эрхийн бичиг аваагүй, эсхүл хилийн боомтгүй газраар улсын хилээр орсон, гарсан, дамжин өнгөрсөн байхыг ойлгоно.

Улсын хилийг хууль бусаар нэвтрэх нэг боломж нь усан хилээр нэвтрэх явдал юм. Өөрөөр хэлбэл гол мөрөн, нуурын мандлаар хөвөх байгууламж ашиглах, усыг гатлан сэлэх, усан доогуур шумбах төхөөрөмж хэрэглэх аргаар үйлдэгдэж болох үндэслэлтэй. Мөн улсын агаарын орон зайг зөрчих нь "Агаарын зайг нисэхэд ашиглах тухай" хуулинд зааснаар агаарын зайн зөрчилд тооцогдоод зогсохгүй, хууль бусаар улсын хил нэвтрэх гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинжийг бүрдүүлэх үндэслэл болдог онцлогтой.[19] Гадаад улсын иргэн, харьяалалгүй этгээдээс хувийн нисэх онгоц, нислэгийн төхөөрөмж /аэробус, дэржавал,

[19] Ц.Доржням "Улсын хил зөрчих гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлага, криминологийн зарим асуудал". УБ., 2012 он. 67 дахь тал

делвоплан/ ашиглан агаарын хилийн нэвтэрсэн нь дээрх гэмт хэргийн объектив талын шинжийг бүрдүүлнэ.

Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх гэмт хэрэг нь дараах ***субъектив шинжтэй*** *байна.*

Гэмт хэргийн субъект. 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн аль нь ч байж болно.

Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх гэмт хэргийн заавал байх нэг шинж бол субъектийн ухамсар, хүсэл зориг юм. Субъект нь давагдашгүй хүч, бусдын зүгээс үзүүлэх биеийн хүчний албадлагад өртөн өөрийн хүсэл зоригийн эсрэг үйлдэл хийж, эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашиг сонирхолд хохирол учруулсныг гэмт хэрэг үйлдсэн гэж үзэхгүй[20].

Субьектив тал. Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив тал нь улсын хилийг нэвтрэх талаар хууль, олон улсын гэрээгээр тогтоосон журмыг зөрчсөн гэм буруугийн санаатай хэлбэр болон түүнд өдөөсөн сэдэлт, зорилгын нийлбэр юм. Уг гэмт хэрэг нь гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ.

Улсын хилийг хууль бусаар зөрчсөн үйлдэл нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй бол Монгол Улсын Хилийн тухай хууль, тогтоомж, журам дэглэмийн зөрчилд тооцон Зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэнэ.

Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх гэмт хэргийн дараах шинжүүд нь хүндрүүлэх[21] нөхцөл болдог. Үүнд:

- Бүлэглэж үйлдсэн;
- Хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн.

Бүлэглэж үйлдсэн гэж Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх гэмт хэргийг хоёр, түүнээс олон хүн санаатай нэгдэж үйлдсэнийг ойлгоно.

Хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн гэж Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэхдээ хил хамгаалах байгууллагын алба хаагч болон бусад иргэний бие махбодид халдаж, түүний эсэргүүцлийг няцаах, эрх, эрх чөлөөг хязгаарлахаар айлган сүрдүүлсэн байхыг ойлгоно. Хохирогчийн бие махбодид халдах үйлдэл нь алгадах, цохих, өшиглөх, түлхэх, хоолойг боох зэрэг хэлбэртэй байж болно.

---

[20] ***Эрүүгийн хуулийн 19.14 дүгээр зүйлийн тайлбар.*** Хүн худалдаалах, хүн хулгайлах гэмт хэргийн хохирогч болсон, үзэл бодол, улс төрийн, шударга ёсны бусад үйл ажиллагааны улмаас хавчигдан мөшгигдсөн гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсад орогнох эрх авахын тулд Монгол Улсын хил нэвтэрсэн бол энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй.

[21] Эрүүгийн хуулийн 19.14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг

Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол онц хүндрүүлэх[22] нөхцөл болдог.

Зохион байгуулалттай гэмт бүлэг гэж гэмт хэрэг байнга үйлдэж ашиг олох зорилгоор урьдчилан нэгдсэн гурав, түүнээс олон хүний тогтвортой нэгдлийг хэлнэ.

Монгол Улсын хилийн хууль бусаар нэвтрэн гарсан Монгол Улсын иргэн хэргээ илчлэн ирсэн бол ялаас чөлөөлж болно.[23]

Монгол Улсын Эрүүгийн хуулиар зохицуулагддаг улсын хилийн дэглэмийн дараагийн зөрчил болох эрүүгийн хуулийн 19.17 дугаар зүйлд заасан ***"Улсын хилийн тэмдэг, хилийн шугам дээрх байгууламжийг устгах, гэмтээх, шилжүүлэх"*** гэмт хэрэг нь дараах объектив болон субъектив шинжтэй байна.

Улсын хилийн дэглэм нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах урьдчилсан нөхцөлийг бүрдүүлдэг учир Эрүүгийн хуулийн Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн 19.17 дугаар зүйлд "Улсын хилийн тэмдэг, хилийн шугам дээрх байгууламжийг устгах, гэмтээх, шилжүүлэх" гэмт хэргийг хуульчилсан.

Улсын хилийн тэмдэг, хилийн шугам дээрх байгууламжийг устгах, гэмтээх, шилжүүлэх гэмт хэргийн ***объектив шинж***:

Энэ гэмт хэргийн бүрэлдэхүүний ***объект нь*** Монгол Улсын хилийн дэглэм, Улсын хилийн тэмдэг, хилийн шугам дээрх байгууламжийг хамгаалах, сэргээх, хилийн дэглэмийг тогтоох талаар тогтоосон харилцаа байна. Улсын хилийн дэглэм бол хилийн халдашгүй дархан байдлыг хангах олон улсын эрх зүйн хэм хэмжээнүүдийн нийлбэр гэж ойлгож болно.

Улсын хилийн тэмдэг, хилийн шугам дээрх байгууламжийг устгах, гэмтээх, шилжүүлэх нь нэг талаар улсын хилийн шугамыг хууль бусаар өөрчилж байгаа, нөгөө талаараа хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг зөрчиж байгаа үйлдэл учир Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт тооцогдож, Эрүүгийн хуулиар хамгаалагдсан.

Улсын хилийн тэмдэг, хилийн шугам дээрх байгууламжийг устгах, гэмтээх, шилжүүлэх гэмт хэргийн ***халдлагын зүйл нь*** улсын хилийн

[22] Эрүүгийн хуулийн 19.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг
[23] Эрүүгийн хуулийн 19.14 дүгээр зүйлийн тайлбар

багана, тэмдэг, тэдгээрийн холбоос[24], хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн[25], хил дамнасан байгууламж[26] байна.

Объектив тал. Монгол Улсын хилийн тэмдэг, тэдгээрийн холбоос, хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн, хил дамнасан байгууламжийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр[27] устгасан, гэмтээсэн, шилжүүлсэн[28], улсын хилийн усны гольдролыг өөрчилсөн[29] идэвхтэй үйлдэл байна. Эдгээр үйлдлийн аль нэгийг хийснээр төгсдөг материаллаг шинжтэй гэмт хэрэг юм.

Улсын хилийн тэмдэг, хилийн шугам дээрх байгууламжийг устгах, гэмтээх, шилжүүлэх гэмт хэргийн ***субъектив шинж:***

Гэмт хэргийн субъект. 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний аль нь ч байж болно.

Субъектив тал. Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Гэмт хэрэг үйлдсэн хүн өөрийн үйлдлийг хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж, түүнийг хүсэж үйлдсэн байна. Хэргийг үйлдэхдээ чухам ямар сэдэлт, зорилготой байсан нь хэргийн бүрэлдэхүүнд нөлөө үзүүлэхгүй.[30]

Хилийн зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааны үр дүн нь тухайн зөрчлийг зөв зүйлчлэхээс шууд шалтгаалдаг. Гэмт хэрэг, эрх зүйн зөрчлүүд нь нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, үйлдлийн

---

[24] ***Улсын хилийн тэмдэг, тэдгээрийн холбоос*** гэж улсын хилийг хил залгаа улстай байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний дагуу газар дээр нь геодезийн аргаар тодорхойлж, тод харагдах, бат бэх хилийн тэмдгээр тэмдэглэсэн тэмдэглээ

[25] ***"Улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламж*** гэж хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий саад, мөр хянах зурвас, зам, гүүр, хянах цамхаг, холбоо, дохиолол хяналтын техник хэрэгсэл, замын хаалт болон бусад байгууламж" Монгол Улсын хилийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дэх хэсэг

[26] "***Улсын хил дамнасан байгууламж*** гэж улсын хилийн шугамыг дайран гарсан төмөр зам, авто зам, газрын тос болон хий дамжуулах хоолой, холбоо, цахилгааны шугам, гүүр, усны далан, хашлага болон бусад байгууламж" Монгол Улсын хилийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь хэсэг

[27] ***Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр*** гэдэгт улсын хилийн шугамыг тодорхойлох, тогтоох, өөрчлөх асуудлыг Монгол Улсын Их Хурал, хил дамнасан байгууламжийг барих, өөрчлөх, буулгах, шилжүүлэх, улсын хилийг хамтран шалгах асуудлыг Засгийн газар, хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламжийг барих, өөрчлөх, буулгах асуудлыг Улсын хил хамгаалах байгууллага хариуцах бөгөөд эдгээр байгууллагын зөвшөөрөлгүйгээр устгасан, гэмтээсэн, шилжүүлсэн идэвхтэй үйлдэл багтана.

[28] ***Монгол Улсын хилийн багана, тэмдгийг санаатай устгасан*** гэж тэдгээрийг бүрмөсөн ашиглах боломжгүй болгосон, харин ***гэмтээсэн*** гэж сэргээн засварлах шаардлагатай болгосон, ***шилжүүлсэн*** гэж байрлалыг нь өөрчилсөн идэвхтэй үйлдэл болно.

[29] ***Улсын хилийн усны гольдролыг өөрчилсөн*** гэж хилийн усыг хамгаалах, ашиглах, гольдролыг зориудаар өөрчлөхгүй байх талаар усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон улсын хил хамгаалах байгууллагаас хамтран тогтоосон журмыг зөрчсөн идэвхтэй үйлдэл байна.

[30] Г.Совд. Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2005. 144 дэх тал.

арга, учруулсан хохирлын хэмжээ, хуульд заасан бүрэлдэхүүний шинж, оногдуулж болох хууль зүйн хариуцлагын төрөл, хэмжээ, ял болон шийтгэлийг оногдуулах субъект, ял оногдуулсан, шийтгэл хэрэглэсний улмаас үүсэх эрх зүйн үр дагавар зэрэг шинжүүдээр хоорондоо ялгагдана.[31]

Академич С.Нарангэрэл “Хэргийн болж өнгөрсөн нөхцөл байдлыг бодитой бүрэн тогтоох нь гэмт хэргийг зөв зүйлчлэх чухал нөхцөл мөн. Үүний дараа эрүүгийн хуулиар хориглосон нийгэмд аюултай хэрэгт тохирох эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг сонгон авна... Дараа нь хэргийн болж өнгөрсөн нөхцөл байдал болон сонгож авсан эрүүгийн хэм хэмжээ хоорондоо нийцэж тохирч байгаа эсэхийг тогтооно. Энэ бүхний эцэст гарч буй үр дүн нь гэмт хэргийн зүйлчлэл болно гэж оновчтой тодорхойлжээ.

Хилийн зөрчлийг:

- Тус улсын нутаг дэвсгэрийг бусад улсынхаас зааглагч хилийн шугам давснаар,

- Улсын хилийн нэвтрэхээр зөвшөөрөгдсөн хилийн боомтод хүрч нэвтрэн орох, гарах эрх нээгдсэнээр төгс үйлдэгдсэнд тооцно.

Хилийн боомтоор нэвтрэхээр шалгагчид хүчин төгөлдөр бус буюу хуурамч баримт бичгээ шалгуулахаар гарган өгч буй үйлдэл нь “улсын хилийг хууль бусаар нэвтрэх” гэмт хэрэг үйлдэхээр завдаж буй үйлдэл бөгөөд энэ нь орсон, гарсан дардас дарж, хилээр нэвтэрсэн тухай тэмдэглэл хийгээгүй байгаа цаг хугацаагаар хэмжигдэнэ. Түүний энэхүү үйлдэл нь төгссөн гэмт хэрэгт тооцогдохгүй бөгөөд харин завдалт гэж үзэх эрх зүйн үндэс болно.

Хууль бусаар хил нэвтрэх гэмт үйлдэл нь Монгол Улсын хилээр хууль бусаар орох, гарах, нэвтрэх үйлдэл хийж хилийн дархан байдалд халдсанаар бүрдэл төгсдөг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байхаар эрүүгийн хуульд хуульчлагдсан тул бодит үр дагавар шаарддаггүй онцлогтой. Өөрөөр хэлбэл улсын хилийн шугам давсан байх шаардлага тавигдахгүй бөгөөд хилийн боомтын хяналтын шугамыг давах эрх нээгдсэнээр төгссөн үйлдэлд тооцогдоно.

Уг гэмт хэргийн субъектив талын шинж нь гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Гэм буруугүйгээр байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас /цасан болон шороон шуурга/ төөрч улсын хил нэвтэрсэн нь гэмт хэрэг биш харин хилийн дэглэмийн зөрчил болно. Улсын хилийн мөр хянах зурвас, хилийн инженерийн төхөөрөмж байхгүй хилийн хэсгээр мал маллаж байсан малчин хайхрамж, болгоомжгүй байдлаас улсын хил зөрчсөн үйлдэл нь гэмт хэрэгт тооцогдохгүй. Мөн түүнчлэн сэтгэцийн эмгэг, оюун ухааны хомсдлын улмаас өөрийн үйлдлийн бодит шинж

[31] С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. УБ., 2009. 212 дахь тал

чанар, аюултай байдлыг ухамсарлах, удирдан жолоодох чадваргүй этгээд хууль бусаар улсын хил нэвтэрсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй. Учир нь хэрэг хариуцах чадваргүй этгээдийг нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж үзэж болохгүй. Хүн оюун санаа, хүсэл зоригийн хувьд чөлөөтэй байж улмаар өөрийн хийх гэж үйлдлийн нийгэмд хортой шинжийг ухамсарлан ойлгож, өөрийн зөв гэсэн хувилбарыг сонгон авах чадвартай байхдаа хийсэн үйлдлийнхээ төлөө л хариуцлага хүлээнэ.

Хилийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээнд хил зөрчиж, саатуулагдсан гадаадын иргэнийг тухайн улсын бусад хууль тогтоомжийг зөрчөөгүй тохиолдолд нөгөө талдаа аль болох богино хугацаанд буцаан шилжүүлэх талаар заасан нь санамсар, болгоомжгүй хэлбэрээр үйлдэгдсэн хилийн зөрчлийг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт юм.

Гэм буруутай этгээдийн удирдлага болгосон сэдэлт, зорилго нь гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талын шинжийг бүрдүүлээд зогсохгүй ялыг хүндрүүлэх нөхцөл байдал болдгоороо гэмт хэргийн нийгэмд аюултай байдлын хэр хэмжээг эрс нэмэгдүүлдэг.[32] Тухайлбал, Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэхдээ бүлэглэж, хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн, зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол эрүүгийн хуулийн 19.14 зүйлийн 2, 3 дахь хэсэгт зааснаар онц хүндрүүлэх нөхцөл болно.

Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх гэмт хэргийн гэм буруугийн онцлог нь улс төрийн зорилго, сэдэлтгүй байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын хилийг зөрчихдөө улсын тусгаар тогтнол, бүрэн эрхэт байдал, нутаг дэвсгэрийн халдашгүй дархан байдалд халдаж, дайсагнасан үйлдэл хийх зорилгогүйгээр эөвхөн оршин суух, ажиллаж амьдрах сэдэлтэй байна. Үүгээрээ эх орноос урвах, тагнуул хийх гэмт хэргүүдээс ялгагдана. Уг гэмт хэргийн гэм буруугийн зорилго нь ихэвчлэн ах дүү, төрөл садан, танил нөхөдтэйгээ уулзах, наймаа, арилжаа хийх зэрэг хэлбэртэй байхын хамт хулгай хийх, ан агнах, өвч ургамал түүх зэрэг зорилго агуулсан байдаг.[33]

Монгол Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэхдээ Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтэрсэн бол эрүүгийн хуулийн 18.5, 19.14 дүгээр зүйлээр давхар зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Хулгайлсан малаа Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрүүлэн гадаадын иргэнд худалдаалсан бол эрүүгийн хуулийн 17.12, 19.14 дүгээр зүйлээр давхар зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэхдээ хилийн тэмдэг, хил хамгаалалтын зориулалттай байгууламжийг гэмтээсэн бол эрүүгийн

[32] С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүй. УБ., он 195 дахь тал
[33] Г.Совд. Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2005 он, 143 дахь тал

хуулийн 19.14, 19.17 дугаар зүйлээр давхар зүйлчилнэ. Монгол Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэхдээ Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтэрсэн, хилийн тэмдэг, хил хамгаалалттын зориулалттай байгууламжийг устгаж гэмтээсэн бол эрүүгийн хуулийн 19.14, 19.17, 18.5 дугаар зүйлээр давхар зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Эрүүгийн хуулийн 19.17 дугаар зүйлд заасан “Улсын хилийн тэмдэг, хилийн шугам дээрх байгууламжийг устгах, гэмтээх, шилжүүлэх” гэмт хэрэг нь зөрчлийн тухай хуульд заасан “Монгол Улсын Хилийн тухай хууль тогтоомж зөрчих” зөрчлөөс учруулсан нийгмийн хор аюулын хэр хэмжээгээрээ ялгаатай. Хилийн тэмдэг тэдгээрийн холбоос, хил хамгаалалтын зориулалттай байгууламжийг хувийн болон нийтийн өмч гэж үзэхгүй.

Улсын хилийн дэглэмийг зөрчиж хууль бусаар улсын хил нэвтэрсэн үйлдэл нь Монгол Улсын хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээг зөрчиж, улсын хилийн халдашгүй дархан байдалд халдаж байгаагаараа нийгмийн хор аюулын[34] хувьд их юм. Тийм учраас уг үйлдэл нь эрүүгийн хуулийн тусгай ангийн 19.14 дүгээр зүйлд заасан “Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх” гэмт хэрэг болно.

Мөн хил орчмын нутаг дэвсгэрт тогтоосон хязгаарлалт, хориглолтын арга хэмжээг зөрчиж улсын хилийн тэмдэг, тэдгээрийн холбоос, хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламжийг эвдэх, гэмтээх, хөдөлгөх, шилжүүлэх үйлдэл нь Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдал[35]-д халдаж байгаа тул эрүүгийн хуулийн 19.17 дугаар зүйлд заасан “Улсын хилийн тэмдэг, хилийн шугам дээрх байгууламжийг устгах, гэмтээх, шилжүүлэх” гэмт хэрэг болно.

[34] Г.Совд “Гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар гэдэг нь гэмт үйлдэл, эс үйлдэхүйд эрүүгийн хуулийн хамгаалалтад авагдсан эрх, ашиг сонирхлын мөн чанар, үнэ цэнийг илэрхийлэх хууль цаазын үнэлэмж юм.

[35] Улсын хилийн халдашгүй дархан байдал нь хууль бусаар улсын хилийн шугамыг өөрчлөгдөөгүй, хилийн асуудлаар байгуулсан олон улсы гэрээ, хэлэлцээр зөрчигдөхгүй байх явдлаар болон тусгаар тогтнолын баталгаа нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, хил орчмын иргэд аюулгүй байх явдлаар хангагдана.

Дүгнэлт

Хил хамгаалах байгууллагаас хилийн зөрчлийг таслан зогсоох, бууруулахын тулд хил зөрчигчийг илрүүлэх, баривчлах, саатуулах чиглэлээр судалгааны ажил гүйцэтгэж, техник хэрэгсэл, хамгаалалтын саад байгууламжийг нэмэгдүүлж, арга тактикаа өөрчилж, олон талын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн боловч зарим төрлийн хилийн зөрчлүүд буурахгүй харин ч даамжрах хандлагатай байгаа нь хилийн зөрчлийг шийдвэрлэх талаар анхаарал хандуулахгүй хууль, тагнуулын байгууллагад шилжүүлээд орхидогтой шууд холбоотой.Аливаа зөрчлийг таслан зогсоох, бууруулах арга хэмжээнүүдээс хамгийн чухал нь тухайн зөрчлийг үнэн зөвөөр шийдвэрлэх, тохирсон хариуцлага оногдуулах явдал байдаг. Гэтэл хилийн зөрчлийг алдаатай шийдвэрлэдэг улмаар зарим этгээд удаа дараа хилийн зөрчил гаргасан ч ял шийтгэл хүлээдэггүй, нэг төрлийн хилийн зөрчилд тооцох хариуцлагыг харилцан адилгүй оногдуулдаг асуудал байгаа нь хилийн зөрчил даамжрах, зохион байгуулалтын хэлбэрт шилжих аюулыг дагуулж байна.

Хилийн зөрчил нь хилийн эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн, нийгэмд хор аюултай, холбогдох хууль тогтоомжид хариуцлага хүлээлгэхээр тусгагдсан, эрх зүйн чадамжтай этгээдийн гэм буруутай, үйлдэл, эс үйлдэхүй бөгөөд хилийн зөрчлийг дараах шалгуураар ангилж болно.

1. Хилийн эрх зүйн зөрчлийг үйлдэгдэж буй орон зай, эрх зүйн зохицуулалтаас нь хамааруулж:

- Хилийн дэглэмийн зөрчил
- Хил орчмын дэглэмийн зөрчил

2. Хилийн зөрчлийг гаргаж буй гэмт үйлдэл чиглэсэн талаас нь:

- Улсын хилийн дэглэмийн эсрэг чиглэсэн зөрчил
- Улсын хил орчмын дэглэмийн эсрэг чиглэсэн зөрчил
- Улсын хилийн зурваст мөрдөх журмын эсрэг зөрчил
- Улсын хилийн бусад мөрдөх журмын эсрэг зөрчил
- Улсын хилийн боомтын журмын эсрэг чиглэсэн зөрчил
- Хилийн алба хаах журмын эсрэг зөрчил

Хилийн тухай хуулинд хилийн зөрчлийн субъектив /субъект, субъектив тал/ болон объектив шинж /объект, объектив тал/-ийг нарийвчлан зааж өгөлгүй зөвхөн объектив талын үндсэн шинж болох үйлдлүүдийг тусгасан нь хилийн зөрчлийг шийдвэрлэхэд нөлөөлдөг. Иймд хилчдэд хилийн зөрчлийг шалган шийдвэрлэх талаар мэргэжлийн гарын авлага боловсруулан сургалт явуулах, Хил хамгаалалтын дүрэмд тусгаж мөрдлөг болгох шаардлагатай үүсэж байна.

Ашигласан эх сурвалж

1. “Монгол Улсын үндсэн хууль”. УБ., 1992 он.
2. “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”. УБ., 2011 он.
3. “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”. УБ., 2010 он.
4. “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого”. УБ., 2002 он.
5. “Эрүүгийн хууль”. УБ., 2015 он.
6. Гэмт, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль. УБ. 2019 он.
7. Хилийн асуудлаар байгуулсан Монгол улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийн жагсаалт. УБ. 2011 он.
8. Төрийн мэдээлэл. Монгол Улсын Хилийн тухай хууль. УБ., 2017.
9. Арвай.Ш., Наранжамц.Н., Муратхан.А., Нямдорж.Д., “Хил судлалын шинжлэх ухааны онол, практикийн зарим асуудал”. УБ., 2016 он.
10. Жанцан.Ц., “Улсын хилийн болон хил орчмын нутаг дэвсгэр дэх дэд бүтэц, нийгэм эдийн засгийн хөгжлийг цогцоор шийдвэрлэх нь хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл мөн”, Улсын хилийн аюулгүй байдал ба хамтын ажиллагаа. УБ., 2012 он.
11. Нямсүрэн.Ч, Чулуунбат.Ш., “Улсын хилийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулж буй олон улсын эрх зүйн зохицуулалтад хийсэн дүн шинжилгээ”, Хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн орчин судалгааны төсөлт ажлын тайлан. УБ., 2018 он.
12. Ч.Мягмарбаяр., “Монгол Улсын хилийн дэглэмийн зөрчлийн бүрэлдэхүүн, зүйлчлэлийн зарим асуудал” эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл. УБ., 2020 он.

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ ТУСГАЙЛСАН ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИНТОЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

COMPARATIVE STUDY BETWEEN BORDER PROTECTION ORGANIZATION'S LEGISLATION AND LEGISLATION OF ORGANIZATIONS OF SPECIAL PURPOSES

М.Ганбаатар
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан-багш, дэд хурандаа
Эрдэм шинжилгээний удирдагч: Ц.Ганболд
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан, доктор, профессор, хурандаа
Ganbaatar.M
Senior Officer, Institute for Border Security Studies, The Joint Research Institute, University of Internal Affairs, Ph.D Candidate, Lieutenant Colonel
Ganbold.Ts
Researcher, Institute for Border Security Studies, The Joint Research Institute, University of Internal Affairs, Ph.D, Professor, Colonel

Хураангуй: Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчны өнөөгийн байдал, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын эрх зүйн орчинтой харьцуулсан судалгаа

Abstract: This comparative study explores legislation environments of Border Services and Organizations for Special Purposes and current conditions of legal environment of Border Services.

Түлхүүр үгс: Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, хилийн тухай хууль, хилийн талаар байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр, батлан хамгаалахын холбогдолтой хууль тогтоомж.

Key words: The State Policy on Border of Mongolia, the Law on Border, International Agreements on Border, Legislation for Defense

Хил хамгаалах ерөнхий газар нь Монгол Улсын Хилийн тухай хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, Төрөөс хилийн талаар баримтлах бодлого зэрэг баримт бичгийг удирдлага болгон 1962 оны Монгол-Хятадын хилийн гэрээ, 2010 оны Монгол-Хятадын хилийн дэглэмийн гэрээ, 1958, 1976 оны Монгол-Оросын хилийн гэрээ, 2006 оны Монгол-Оросын хилийн дэглэмийн гэрээ, хилийн асуудлаар байгуулсан хэлэлцээр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан "Монгол Улсын Хил хамгаалалтын дүрэм", "Улсын

хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам” бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлдэг.

Монгол Улсын Хил хамгаалах байгууллага Монгол Улсын олон улсын 50 гаруй гэрээ, хэлэлцээр, үндэсний 200 орчим хуулийн заалтыг мөрдөж, мөрдүүлж үйл ажиллагаагаа явуулдаг.

Хилийн цэрэг, Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааны олон талт цогц асуудлуудыг шийдвэрлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, эрх зүйн зохицуулалтыг хийх, эрх зүйн харилцааг боловсронгуй болгоход “Хилийн тухай хууль” ихээхэн үүрэг гүйцэтгэсэн.

1973, 1993, 2016 оны Хилийн тухай хуулиудад Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлууд цаг үеийн өөрчлөлт, хөгжлийн зүй тогтолтой уялдан, эрх зүйн орчин, харилцаа хуульчлагдан шинэчлэгдсээр ирсэн.

Аливаа хуулийн хэллэг, нэр томьёо агуулгын хувьд хоёрдмол утга санаагүй, тодорхой, оновчтой томьёологдсон байх ёстой.

Хил хамгаалах байгууллагын өсөн нэмэгдэж, хөгжин хувирч буй олон талт харилцааг зохицуулахад дөнгөж саяхан батлагдан мөрдөгдөж байгаа ч, хамаг зүйлийг хамаад оруулчихсан “Хилийн тухай” хууль маань хилийн, хил хамгаалах байгууллагын хөгжилд тус нэмэр болохоосоо тушаа чөдөр болох тал нь давамгай байна. Ижил төст хөгжиж буй ОБЕГ, БХЯ зэрэгтэй харьцуулахад тэдний давуу тал нь эрх зүйн орчноо бүрдүүлж, салбарын үйл ажиллагааг бүрэн тодорхойлсон хэд хэдэн хуультай байгаа нь ихээхэн түлхэц өгч байна гэж харж байгаа.

2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Их хурлаар батлагдаж, Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2017 оны №6-д нийтлэгдсэн “Монгол Улсын хилийн тухай” хуулийн зарим заалтуудын нэр томьёо, түүний агуулга, найруулгыг авч үзье. Тухайлбал:

3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

3.1.11. “Улсын хил хамгаалах байгууллага” гэж Монгол Улсын хэмжээнд улсын хил хамгаалалтыг зохион байгуулах, удирдах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, түүний харьяа хилийн цэргийн анги, салбарыг;

34.2. Улсын хил хамгаалах байгууллага нь тэргүүн дэд дарга бөгөөд хилийн цэргийн штабын дарга, дэд дарга нартай байна.

38.2. Улсын хил хамгаалах байгууллагын дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга нар нь цэргийн дээд цолтой байна гэж хуульчилжээ.

Хил хамгаалах байгууллагын харьяа хилийн цэргийн анги, салбар Улсын хил хамгаалах байгууллага юм бол хилийн отряд, заставын дарга, орлогч нар нь 38.2-т заасанчлан цэргийн дээд цолтой байх ёстой байхаар ойлгогдож байгаа ч юм шиг харагдаж, ойлгогдож байна.

3.1.11. “Улсын хил хамгаалах байгууллага” гэж Монгол Улсын

хэмжээнд улсын хил хамгаалалтыг зохион байгуулах, удирдах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага гэсэн нь Хил хамгаалах байгууллагын цэргийн албан хаагчид төрийн тусгай албан хаагч гэж ойлгогдохгүй, ТТ ангиллаар цалинжихгүй мөн Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйл, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага заалттай зөрчилдөж байна.

Хилийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11-д “хил хамгаалах байгууллага” гэж Монгол Улсын хэмжээнд Улсын хил хамгаалалтыг зохион байгуулах, удирдах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, түүний харьяа хилийн цэргийн анги, салбарыг хэлнэ гэжээ.

Энэхүү тодорхойлолтод орсон “Төрийн захиргааны байгууллага” гэж чухам ямар байгууллагыг хэлэх талаар хуульд тодорхой тусгаагүй байна.

Тус хуулийн 34 дүгээр зүйлд Улсын хил хамгаалах байгууллагын тогтолцоо гэсэн “Хил хамгаалах байгууллагын үндсэн хүч хэрэгсэл хилийн цэрэг байх бөгөөд хилийн цэрэг нь үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хилийн цэргийн штаб, анги, салбар, зэвсэглэл, техник, ар тал, хангалт, эмнэлэг, соёл урлаг, спорт, боловсрол, эрдэм шинжилгээний болон бусад нэгжтэй байна” гэсэн байгаа гэвч тэр “Төрийн захиргааны байгууллага” чухам хаана байна вэ?

26.1. “Улсын хилийн дэглэмийг сахиулах, улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албыг зохион байгуулах, хилийн инженер, техникийн байгууламж барих зориулалтаар улсын хилийн шугамаас дотогш 15 км-ээс илүүгүйгээр тусгай журам тогтоосон нутаг дэвсгэрийг улсын хилийн зурвас гэнэ” гэсэн заалт бол өмнөх хуулийн заалтуудаас ухралт хийсэн, хуулиар хилийн зурвас газраас хулгай хийх боломжийг олгосон, хил хамгаалалтад хүндрэл учруулсан заалт болох нь хил хамгаалалтын практик дээр илэрсээр байна. Зарим ашигтай чиглэл, хэсэгт хилийн зурвас 40 метрээс 9 км хүртэл болж шулагдсан байгаагийн хариуцлагыг хэн хүлээх бэ? “Илүүгүйгээр” гэдэг увайгүй улс төрчдийн бодлогоор шургуулсан ганц үгийн хор хохирлыг хилчид л үүрч байна.

“Хуулийн хулгайтай тэмцэнэ” гэсэн сонгуулийн уриа дэвшүүлж миний бие зүгээр ч нэг УИХ-д нэр дэвшээгүй. Ямар ч хувь хүн хуулийн хийдэл, системд хулгай хийх боломжгүй, тийм эрүүл бөгөөд ил тод, тийм хяналттай бөгөөд хариуцлагатай ажиллах эрх зүйн орчинг бий болгохыг зорьж, хууль тогтоогч болъё гэж шийдсэн. *УИХ-ын гишүүн Б.Энхбаяр*

Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого[1] нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд үндэслэсэн улсын хил, хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын талаарх

[1] Монгол Улсын Их Хурлын тогтоол. 2002 оны 05 дугаар сарын 16-ны өдөр. Дугаар 20.

Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрийн үндэс болсон залгамж чанартай тулгуур баримт бичиг юм.

Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах, түүнийг хэрэгжүүлэх нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх талаар эрх зүйн бичиг баримтууд дээр дурдсанчлан цогц байдлаар хуульчлагдан батлагдсан боловч амьдрал, практикт хэрэгжих тал дээр хангалтгүй, уялдуулан зангидах зохицуулах үүрэгтэй төрийн институци огт ажиллахгүй, чиг чигээ харсан байдалтай бөгөөд хамтран ажиллаж үр дүнд хүрэх байтугай хуульд заасан үндсэн үүргээ ч биелүүлж чадахгүй байгын шүүмжлэлд өртөж, иргэдийн зүгээс тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаанд итгэх итгэл алдагдсаар байгаа нь нууц биш билээ.

Бидэнд хамгийн ойр, хэрэгжилт, үр дүнг нь байнга хүлээж байдаг Төрөөс хилийн талаар баримтлах бодлого бичиг баримт-үзэл баримтлалын хэрэгжилтийн талаар л гэхэд батлагдаад 20 жил болсон хэдий ч дорвитой хэрэгжихгүй байна.

Жил бүр Улсын Их Хуралд хэрэгжилт, биелэлтийг нь гарган тайлагнаж, хэрэгжилтэд шаардах төсөв, хөрөнгийг нэмэлтээр шийдвэрлүүлж байх, үүсэн бий болсон бодит нөхцөл байдалтай уялдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах, тодотгол хийж байх шаардлагатайг заасан байдаг ч аль нь ч хэрэгжээгүй өнөөг хүрсэн.

Хил хамгаалах байгууллага 2018 онд “Төрөөс хилийн талаар баримтлах бодлого” баримт бичгийг 2014-2018 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг гаргаж МУ-ын УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлсэн байдаг. “Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-д нийт 3 зорилтын 23 арга хэмжээнээс биелсэн 22, Хил хамгаалах байгууллагын чиг үүрэгт 1 арга хэмжээ хамаарахгүй тул “Үнэлэх боломжгүй”, биелэлт 100 хувьтай дүгнэгдэв гэжээ.

Чиг үүрэгт хамаарахгүй гэсэн заалт нь агаарын хилийн хамгаалалтын асуудал боловч үндэсний болон хилийн аюулгүй байдлын тогтолцоо талаасаа харвал хамаатайгаар барахгүй, Хил хамгаалах байгууллагын анги, салбар нь хил орчмын нутаг дэвсгэрт агаарын орон зайд өөрийн хүч хэрэгслээр хяналт тавих, харилцан ажиллах үүрэгтэй.

Биелэлтийг гаргахдаа зүйл заалтад тааруулан хийсэн ажлаа тоочин бичсэн бөгөөд ямар нэг дүн шинжилгээ хийгээгүй, дутагдалтай, анхаарлаа хандуулах асуудлын талаар юу ч дурдаагүй, бүх юм сайн сайхан байгаа байдлаар гаргажээ.

Мэдээж, газрын хэвлийн хамгаалалт бол Хил хамгаалах байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэгт байж л байгаа. Энэ тал дээр хийсэн байтугай хийхийг ч бодсон асуудал байхгүй байгаа болон хамгаалалтад авагдаагүй хэсэг, чиглэл байсаар байгааг хүн болгон л мэдэж байгаа.

Хилийн хяналт шалгалтын байгууллагуудын үйл ажиллагаандаа мөрдөж буй эрх зүйн хэм хэмжээний актуудын талаар судалсан бөгөөд өнөөдрийн байдлаар хилийн боомтод хилийн хяналтын байгууллагууд үйл ажиллагаандаа олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенц, үндэсний хууль, дүрэм, Засгийн газрын тогтоол, харьяа яамдуудын сайдын тушаал, агентлагийн даргын тушаал, журам, заавар зэрэг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нийт 207 гаруй эрх зүйн хэм хэмжээний актууд байгааг харьцуулан судалж, нэгтгэсэн болно.

Үүнээс үзэхэд хилийн боомтын үйл ажиллагаанд хил хамгаалах байгууллагаас нийт 92, гаалийн байгууллагаас нийт 138, хилийн мэргэжлийн хяналтын байгууллагаас нийт 72, гадаадын иргэн харьяатын газраас нийт 101 хууль тогтоомжуудын мөрдөн ажиллаж байгаа нь судалгаагаар харагдаж байна. Ийм олон журам, зааврыг мөрдөн, мөрдүүлэн ажиллах, гүйцэтгэлийн хяналт, биелэлтийг гарган ажиллахад хүндрэлтэй бөгөөд бүлэглэх, нэгтгэх, давхцалыг арилгах зэргээр аль болохоор цөөлөх шаардлагатай байна.

Монгол Улс нь 1969 онд олон улсын гэрээний эрхийн асуудлаар Венад байгуулсан Конвенцод 1986 онд нэгдэж орсон байдаг. Олон улсын гэрээ, хэлэлцээрийг “зөв, найдвартай газар”-т буюу НҮБ-д хадгалуулбал аюулгүй байдлын болон бусад баталгаа нэмэгддэг жишгийг олон улс дагах болжээ.

1962 оны 12 дугаар сарын 26-ны өдөр гарын үсэг зурсан “БНМАУ ба БНХАУ-ын хилийн гэрээ” нь НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газарт бүртгэгдсэн олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн 14375 тоот бүртгэлд 1975 оны 10 дугаар сарын 9-нд бүртгэснээр Монгол Улсын өмнөд хил олон улсын хэмжээнд баталгаажсан байна.

Монгол Улсын бүх хууль нэг хэв загварт орсон, хэвшмэл нэг хэллэгтэй бөгөөд тэр нь “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэсэн томьёолол юм. Монгол Улсын Үндсэн хууль, үндэсний, үндэстний эрх ашгаас ухарсан энэ томьёоллоос татгалзах ёстой.

Саяхан 2020 оны 7 дугаар сарын 1-нд шинэчлэн баталсан Оросын Холбооны Улсын Үндсэн хуульд орсон өөрчлөлтөөр бол манайхаас эсрэгээр буюу “Олон улсын гэрээ, хуулиуд манай хуулиудтай зөрчилдсөн тохиолдолд Оросын Үндсэн хуульд зааснаар шийдэх буюу дотоодын хууль давуу эрх эдэлнэ” гэж үндэсний, үндэстний эрх ашгаа дээдлэн хуульчилсан байгаа зэргээс харахад олон улсын гэрээнд заасан заалтыг дагаж мөрдөх биш өөрийн хууль, тогтоомжийг удирдлага болгох талаар Оросын холбооны улс мөрдөөд эхэлсэн байна.

ЗЭВСЭГТ ХҮЧИНД МӨРДӨГДӨЖ БАЙГАА ХУУЛИЙН ЖАГСААЛТ

1.Батлан хамгаалах тухай 2016.09.01
2.Зэвсэгт хүчний тухай 2016.09.01
3.Дайны байдлын тухай 1998.05.15
4.Дайчилгааны тухай 1998.05.15
5.Гадаадын цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай 1998.01.08
6.Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай 2016.09.01
7.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай 1994.06.13
8.Цэргийн албан хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай 2002.06.13
9.Цэргийн албаны тухай 2016.09.01
10.Дайн бүхий байдлын тухай 1998.01.08
11.Дотоодын цэргийн тухай 2017.02.09
12.Онц байдлын тухай 1995.11.14
13.Орон нутгийн хамгаалалтын тухай 2018.06.27
14.Төрийн албаны тухай 2017.12.07
15.Төрийн тусгай хамгаалалтын тухай 1995.04.27
16.Батлан хамгаалах төрийн бодлогын үндэс
17.Цэргийн нийтлэг дүрмүүд
18.Үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай
19.Зэвсэгт хүчний хөгжлийн тухай
20.Үндэсний аюулгүй байдлын тухай

ЦАГДААГИЙН АЛБАНД ХЭРЭГЖИЖ БУЙ ХУУЛИЙН ЖАГСААЛТ

1.Цагдаагийн албаны тухай 2017.02.09
2.Эрүүгийн хууль 2015.12.03
3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай 2017.05.18
4.Зөрчлийн тухай 2017.05.11
5.Гүйцэтгэх ажлын тухай 1997.12.19

ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНД ХЭРЭГЖИЖ БАЙГАА ХУУЛИЙН ЖАГСААЛТ

1.Онцгой байдлын тухай 1995.11.14
2.Гамшгаас хамгаалах тухай 2003.06.30
3.Галын аюулгүй байдлын тухай 1999.05.28
4.Улсын нөөцийн тухай 2007.07.05

Дүгнэлт

Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого бичиг баримтыг шинэчлэн боловсруулах, Хууль санаачлах, боловсруулах эрх бүхий субъектийг оролцуулах, чиглэл чиглэлийн мэргэжилтэн оролцуулсан ажлын хэсэг ажиллуулах;

Монгол Улсын Хилийн тухай хууль хэрэгжээд удаагүй ч хуулийн боловсруулалт хангалтгүй, томьёолол ойлгомжгүй, хоёрдмол агуулгатай зүйл заалтуудтай, хуулийн цоорхой, хийдэлтэй, олон асуудлыг бөөгнүүлэн тусгасан байдлыг залруулах, өөрчлөлт оруулах;

Хилийн боомтын тухай хууль, Хилийн албаны тухай хууль зэрэг ХХБ-ын олон талт үйл ажиллагааг зохицуулсан бие даасан органик хуулиудыг боловсруулан баталгаажуулах;

Батлан хамгаалах, Онцгой байдал, Цагдаагийн байгууллагад хэрэгжиж буй хуулиудын харьцуулсан судалгааг хавсаргав;

Хилийн тухай хуулийн агуулгад нийцүүлэн “Хилийн албаны дүрэм”-үүдийг боловсруулан баталгаажуулах ажлыг эрчимжүүлэх;

Аливаа хууль боловсруулах ажлын хэсэгт Хэлний бодлогын үндэсний зөвлөл, ШУА-ын Хэл зохиолын хүрээлэнгийн монгол хэл шинжлэлийн болон хуульч эрдэмтдийн идэвхтэй оролцоо, мэргэжлийн туслалцаа, зөвлөмж нэн чухал байна.

ХИЛ СУДЛАЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ НЭР ТОМЬЁО, ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ АСУУДАЛ

ASPECTS OF TERMS AND TERMINOLOGIES OF FRONTIER STUDIES SCIENCE AND THEIR SUITABLE USAGE

Ж.Болормаа
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, ахмад
Эрдэм шинжилгээний удирдагч: Ц.Ганболд
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн судлаач, доктор, профессор.
Bolormaa.J
Researcher, Institute of Border Security, Joint Research Institute of Internal Affairs University, captain
Ganbold.Ts
Researcher, Institute of Border Security, Joint Research Institute of Internal Affairs University, Doctor, professor,

Хураангуй: Энэхүү нийтлэл нь хил судлалын шинжлэх ухааны гол нэр томьёоны талаар ойлголт өгөх, судалгааны үр дүнгээс Монгол сэтгэлгээний арга зүйг хангасан, ойлгомжтой нутагшсан нэр томьёог гаргаж, хэрэглэх саналыг дэвшүүлэхэд чиглэсэн болно. Даяаршлын нөлөөгөөр Монгол Улсын гадаад харилцаа, түүний хилийн хамтын ажиллагаа өргөжиж, хил хамгаалалтад шинэ техник, технологи нэвтэрч буй боломжуудтай зэрэгцэн хил судлалын салбарт шинэ үг хэллэг, нэр томъёо, ойлголтуудыг авч, нутагшуулахтай холбоотой асуудалд зарим хүндрэл гарч байна.

Хил шинжлэлийн ухаан нь арга зүйн хувьд ерөнхий онолын шинжлэх ухаан болох философи, математик, системчлэлтэй холбоотой бол, түүний салбар болох хил хамгаалал, гаальтай тусгай судлалын ухааны хамааралтай юм. Улс төр, эдийн засаг, үндэсний аюулгүй байдал, түүх судлал, хууль эрх зүй, технологи, сэтгэл судлал болон сурган хүмүүжүүлэх зэрэг бусад салбар, шинжлэх ухаантай холбогдохдоо өөрийн өвөрмөц онцлог байдлаа маш ойлгомжтойгоор хадгалсан шинжлэх ухааны хэл буюу нэр томъёотой байх нь чухал.

Судалгааны ажлаар салбартаа шинэ нэр томьёонуудыг нэвтрүүлэх, түүнчлэн өмнө нь гарсан зарим нэр томьёонуудын ойлгомжгүй байдлыг залруулах, мөн Монгол Улсын хил судлалын салбарт нэвтэрч буй шинэ ойлголт, гадаад нэр томьёог гадаад агуулгаар нь эсвэл бүрэн нутагшуулахдаа дэлгэрэнгүй жишээ тайлбартайгаар ойлгомжтой гаргахыг зорьж байна. Энэ нь хил судлалын хүмүүст үндэсний болон гадаад хил

дээр ажлаа явуулах, судалгааны бүтээл гаргахдаа нэр томьёог зөв, үр дүнтэй хэрэглэх, ойлголтын зөрүү гаргахгүй байхад туслах явдал юм.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөлөөгөөр цаашид хилийн албыг уламжлалт байдлаар зохион байгуулж, явуулах боломжгүй бөгөөд нилээдгүй хүндрэлүүдийг дагуулж байгаа нь хилийн асуудлыг бусад салбарын хүчин зүйлтэй нэгтгэн судлах, шинэ ойлголтуудыг бий болгохыг биднээс шаардаж, энэ асуудлыг өргөн хүрээнд авч үзэх, судалгааг эрчимжүүлэх шаардлагатай.

Түүнээс гадна даяаршлын нөлөөгөөр бий болсон худалдаа, харилцаагаар улс орнууд, хүмүүс олон улсын хил хязгаарын орон зайд гарч, чөлөөтэй харилцах, үйл ажиллагаагаа нээлттэй явуулах нөхцөлийг бий болгосон бол, энэхүү Ковид-19 халдварт цар тахал нь эргээд улс орнуудыг аль болох олон улсын нээлттэй хилийн харилцаанаас зайлсхийх, тэр байтугай улс дотроо бүс нутгаараа, үндэсний цөөнх, бүлэг, хэсгээрээ бусдаас тусгаарлах хэв маягийг эрмэлзсэн дүрэм журмыг янз бүрээр гаргах, тусдаа аюулгүй амьдрах, үй ажиллагаа явуулах гэсэн сонирхлын бүс, хаалттай орчныг үүсгэн хязгаарыг тогтоох гэсэн оролдлогууд нь даяаршлын бүр эсрэг үзэгдэл бий болохыг харууллаа.

Abstract: This article provides overview on the essential terms and terminologies in the Science of Border Studies. Research assessment, findings and recommendation has been focused on clarity and domestication (Mongol-think methodology) of related terminologies.

Through globalization, the foreign relationship of Mongolia and its border cooperation has been greatly expanded with challenges and opportunities having new technology and equipment in border security resulting to domesticate and adopt new terms and terminologies required for related studies.

The Science of Border Studies has relationship with the general theoretical science as philosophy, mathematics and systematizations in methodology, and with its branches of border protection and customs in specified studies. Its relationship with other studies and fields should be comprehensive on exclusive features and specific interpretations as it is interlinked with numerous fields of studies associated to politics, economics, national security, history, laws, technology, psychology and pedagogics.

Outcome of this study will add on new terms and terminologies as well as clarify the existing vague terminologies in the field covering new concepts with exemplary description of domesticated and foreignized terms on related field of study in Mongolia. Thus, it will help scholars to improve on research avoiding misinterpretation into native and foreign languages. Hence researcher has tried to enable and bring out effective and correct use of terms related to the field of

pogranology.

Acquainting and understanding on some new concept of the modern frontier studies has emerged. Although frontier studies have been an important field of studies and in last two decades it has expanded into plethora of areas related with culture, history, geography, geopolitics, technology, national capacity, regionalism, demography and many more. The global pandemic has stressed and compelled nations to rethink on the regulation of borders beyond the conventional setting of border management.

Besides the globalization of trade and commerce had brought countries and citizens beyond the international border, however the COVID-19 pandemic has pressed on the Nations for isolationism hence creating border within the state down to the level of small community itself far from the international border.

Түлхүүр үгс: Хил судлал, лимология, погранология, границеведение, цессия, анклав.

Keywords: border studies, limalogy, pogranology, frontier science, concessions, enclaves

Хил судлалын шинжлэх ухаан арга зүйн хувьд философи, математик, системчлэл (системийн онол) зэрэг шинжлэх ухааны ерөнхий онол, хил хамгаалалтын, гаалийн гэх мэт тусгай онол, чиглэлийн хувьд улс төр, цэрэг, эдийн засаг, аюулгүй байдлын ерөнхий онол, улс төр судлал, түүхийн, хууль зүй, техникийн ухаан, сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухаан зэрэг хилийн асуудалд дам холбогддог шинжлэх ухаан дээр тулгуурласан байдгаас өөрийн онцлогтой нэр томьёо, ойлголтуудтай.

Дэлхий даяаршин Монгол Улсын гадаад харилцаа тэр тусмаа хилийн харилцаа өргөжин хөгжих, улсын хил хамгаалалтад шинэ техник, технологи нэвтрэхийн хирээр хил судлал, хилийн эрх зүйн шинжлэх ухаанд шинэ нэр томьёо нутагшин орж ирэх болов.

Цэргийн болон хил судлалын нэр томьёог тайлбарласан бүтээл туурвилууд байгаа бөгөөд тухайлбал, Ч.Алтангэрэл, М.Лхагвасүрэн нарын 2003 онд туурвисан “Монгол улсын хилчний тайлбар толь” нь хил тогтоож, хамгаалж ирсэн түүх уламжлал, хил хамгаалалтын талаар төр засаг /хаад/-аас авч хэрэгжүүлж байсан ба хэрэгжүүлж байгаа төрийн бодлого, авсан арга хэмжээ, улсын хил хамгаалалтын ба цэргийн шинжлэх ухааны онол, практикийн асуудлууд, орчин үеийн байлдааны болон хил хамгаалалтын зэвсэг, техник, байгаль экологийн үзэгдэл, үйл явц, Монголын их түүхийн хил, хилчидтэй холбоо бүхий асуудлууд, хил залгаа орон, мужууд, хилийн аймаг сумдын товч тойм болон хилийн бүсэд оршсоор ирсэн хүн төрөлхтөний түүх, соёл иргэншлийн дурсгалууд, нэн ховор ба ховор амьтад, улсын үндэс болох газар нутаг түүний хил

хязгаарын асуудлыг шийдвэрлэж байсан ба хамгаалалтад оройлон оролцсон, оролцож буй хүмүүсийн товч намтар зэрэг 3000 орчим тайлбар багтаасан 390 хуудастай тайлбар толь, М.Ганболдын 2010 онд бичсэн “Хилийн нэр томьёоны тайлбар толь” нь 2500 шахам нэг томьёо, үг хэллэг орсон, тэдгээрийн 90 орчим хувь нь улсын хил, түүний хамгаалалт, хил судлалын шинжлэх ухаантай холбоотойгоос гадна хөрш зэргэлдээ орнуудын хил хамгаалах албадын нийтлэг хэрэглэдэг зарим нэр томьёо, үг хэллэгийг тайлбарласан тайлбар толь, Ж.Өвгөнбүргэд, В.Жавхланцогт нарын 2017 онд түүвэрлэн эмхэтгэсэн “Хилийн албанд ашиглагдах зарим нэр томьёоны тайлбар толь” нь хил хамгаалалт, цэргийн сургалт, албаны бэлэн байдал, ар тал хангалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зайлшгүй хэрэглэгдэх нэр томьёоны 8 бүлэг бүхий 160 хуудастай тайлбар толь, Ш.Паламдорж редактортой Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтдийн багийн 2014 онд туурвисан “Цэргийн нэр томьёоны тайлбар толь” нь цэргийн олон төрөл, мэргэжлийн онцлогийг харгалзаж, нийтлэг хэрэглэгддэг цэрэг-улс төр, зэвсэгт хүчний байгуулалт, цэргийн урлаг, зэвсэг, цэргийн техникийн түгээмэл нэр томьёоны жагсаалтыг давхардал, адил төстэй талуудыг харгалзан гаргаж, тайлбар тодорхойлолтыг хийсэн 700 хуудастай тайлбар толь хэрэглэгдэж байна.

Миний судалгааны энэхүү ажлын үр дүнгээр ямар нэг хэмжээний хил судлалын шинэ нэр томьёог тайлбарласан “Тайлбар толь” гарна гэсэн төсөөлөл, таамаглалтай байгаа ба эдгээр толь бичгүүдээс давхцуулан авч хэрэглэхгүй, оруулахгүй, доор жишээ татсан шинэлэг нэр томьёо, үзэл баримтлалуудыг тайлбарлан оруулах бодомжийг агуулж байгаа болно.

Энэ судалгааны ажлаар Хил судлалын ухаанд нийтлэг хэрэглэгддэг олон улсын олон нэр томьёо, ойлголтыг монгол хилчид, судлаачдын сонорт хүргэх, оновчтой орчуулагдан өөрийн байр суурыа эзлэхэд, өнөө хэрэглэж буй гадаад нэр томьёо оновчтой нэрээ олоход, монгол хэл цэвэр тунгалагаараа оршиход ихээхэн тус болно гэж үзэж байгаа болно.

Хамгийн энгийн жишээ, нэр томьёоноос эхэлье.

✓ 1953 онд өмнөд хилд БНХАУ-ын хилийн төлөөлөгчтэй хийсэн нэгэн уулзалтын үед “нот”[1] /I-”тэмдэг, тэмдэглэх” гэсэн утга бүхий латин үг, II-нэгэн улсын засгийн газраас нөгөөд явуулах дипломат бичиг, III-уг зөв хэлбэр нь нут, нухац гэдэгтэй язгуур нэг, бат нут, нуталгаа бүхий, бат нот хоршоо үг хэмээн тайлбарласан байна/ гэдэг нэр томьёог анх хэрэглэсэн байдаг бөгөөд харамсалтай нь түүнийгээ хятадын талд ойлгуулах гээд бүтэн өдрийг барж, энэ уулзалт амжилтгүй өнгөрсөн гашуун түүх бидэнд

[1] Я.Цэвэл 2013 он “Монгол хэлний товч тайлбар толь”

байдаг.[2]

✓ Хил Хамгаалах Байгууллагын хил хамгаалах нэгж анги, салбарыг “отряд /угтаа *салаа, салбар* гэсэн утгатай орос үг бөгөөд нэг мэргэжлийн бүлэг цэрэг буюу хүмүүс/, застав” хэмээн нэрийдсээр он цагийг элээж байгаа бөгөөд орос ах нар өөрсдөө энэ нэршилээсээ татгалзаад даруй 10-аад жилийг өнгөрөөж байна. Манайд эсрэгээрээ өөрчлөн монголчлох нь атугай...дугаар отряд, застав хэмээн бичихийг нууцад оруулан баталгаажуулан улам бүр дархлаа тогтоох болсныг өөрчлөх шаардлагатай гэж үзэж байгаа юм.

✓ “Үндсэн хүч хэрэгслээ төвлөрүүлэх хэсэг, чиглэл”[3] (основное сил и средства) гэдэг томьёоллыг өөрчилсөн “Үндсэн чармайлтаа төвлөрүүлэх хэсэг, чиглэл” (“чармайх”-мэрийх, зүтгэх, шамдах, чарайх, “чармайлт”-чармайх үйлийн нэр (основное усилие) хэмээх ойлголт, хэллэг, томьёоллыг хил хамгаалалтын албан бичиг баримтууд, удирдамж, тушаал шийдвэрт хэрэглэх болсон. Энэ нь стратеги, оперативын түвшний цэргийн удирдлагын байлдааны ажиллагааны үед хэрэглэгддэг /нэг удаа л ашиглах агуулгыг илэрхийлдэг/ томьёолол бөгөөд хил хамгаалалтад ашиглах нь оновчтой биш юм.

✓ Улсын хилийн онолын үндсэн ойлголт, төрөлд улсын хил, хуурай газрын хил, усан хилийг тогтооход делимитац-delimitation (тодорхойлох), демаркац-demarcation (тогтоох), редемаркац-redemarcation (тодотгох), денонсаци (цуцлах), ратификац (батлах), ректификац (засвар оруулах), пролонгаци (гэрээ хэлэлцээрийн хугацааг сунгах, автоматаар сунгагдаж болдог), парафировани (эцэслэн зөвшилцсөн гэрээ, хэлэлцээрийн хувилбарт урьдчилан гарын үсэг зурах ажиллагаа) зэрэг олон улсын харилцаа, олон улсын эрх зүйд нийтлэг хэрэглэгддэг нэр томьёонууд хэрэглэгдэж байна. Оновчгүй үгээр орчуулснаасаа илүү энэ олон улсын хэллэгээрээ хэвшүүлэх нь зүйтэй мэт санагддаг.

Нутаг дэвсгэрийн зааглал, харьяалал, өөрчлөлтийн талаар олон улсын эрх зүйн хэм хэмжээг тодорхойлсон олон нэр томьёо, үзэл баримтлал байдаг бөгөөд гадны орнууд өөрсдийн бусдын нутагт санаархсан өнгөлзлөгөө үүгээр хаацайлан, хууль ёсных юм шиг харагдуулдаг. Тухайлбал:

✓ Цессия гэдэг нь олон улсын эрх зүйд аль нэг улс өөрийн нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг, тодорхой гэрээгээр өөр улс оронд найр тавин өгөх, түрээслэх, бэлэглэх, худалдах, худалдан авахыг хэлдэг. Тухайлбал, БНХАУ нь 2011 оны 01 дүгээр сард Таджикстан улстай 1877 оноос хойш тодорхойгүй байсан Памирын уулсын бүс дэх хилийн

[2] ТЕГ-ын тусгай архив. 1953 он
[3] Ер.ред Ш.Паламдорж 2014 он. “Цэргийн нэр томьёоны тайлбар толь”

зурвасын асуудлыг өрийн асуудалтай уялдуулан шахалт үзүүлсэний үр дүнд 1358 хд.км газар буюу маргаантай газар нутгийн 5.5 хувийг өөрийн харьяанд оруулж авсан түүхтэй.[4]

✓ Анклав- (лат. Inclavare-запирать на ключ-түлхүүрдэн цоожлох) гэдэг нь тухайн улсын нутаг дэвсгэрийн нэг хэсэг бүх талаараа өөр улсын нутаг дэвсгэрээр хүрээлэгдэхийг хэлнэ. Жишээ, Сонгодог утгаараа Италийн нутаг дэвсгэр дээрх Ватикан улсын, мөн ОХУ-ын Калининград мужийг нэрлэж болно. Өөр нэг хувилбар нь улс доторх улс – государства в государстве – imperium in imperio – нь хэсэг бүлэг хүмүүс, байгууллага, компани өөрсдийгөө тусгай нөхцөл байдалд тавин тухайн улсын төрөөс тогтоосон нийтийн дагаж мөрдөх хууль журамд захирагдахгүй байхыг хэлнэ[5].

Энд Ливи зэрэг улсын нутагт үйл ажиллагаа явуулдаг Хезболло бүлэг, Исламын улс бүлэглэл зэргийг дурьдаж болно. Сүүлийн үед улс болон тоглогч бүлэг, улс бус субьект зэрэг нэршил бий болсон.

Төв болон Өмнөд Америкийн олон улсад улс доторх улс гэж United Fruit Company-ийг хэлдэг ба тэд өөрсдийн эдийн засгийн их нөөц боломж, ганцаар өрсөлдөгчгүй давуу байдал, үйл ажиллагаа явуулж буй орныхоо эдийн засгаас давсан хөрөнгөтэй байдалдаа эрдэн тусгаар улс мэт дураар аашилдаг.

✓ Мэдээллийн гэх тодотголтой XXI зуунд шинжлэх ухааны үндсэн хэл нь англи хэл болж байна. Шинжлэх ухааны нэр томьёо бүхэн өөрийн гэсэн онцлогтой, үүсэлтэй, түүхтэй.

Монголын геополитикийн орчин зарчмын хувьд үндсэндээ өөрчлөгдөж, далайд гарцгүй (land-locked), цөмийн зэвсгээр хүрээлэгдсэн (nuclear-locked), хоёр их гүрний дунд хашигдсан (power-locked), мөн монгол угсаатнаараа хүрээлэгдсэн (mongols ethno-locked) харьцангуй сул бүрхүүлтэй цоо шинэ нөхцөл байдал буй болов.[6] Монгол Улс хоёр гүрний хооронд хавчуулагдсан sandwich улс[7].

✓ Хоёр эзэнт гүрний хооронд удаан хугацаагаар хил тогтоогдоогүй, харьяалалгүй газар нутаг оршсоор ирсэн бөгөөд үүнийг “лимитроф” гэж нэрлэх ба энд Монгол улсын нутаг дэвсгэр багтаж байжээ[8].

Лимитроф-(лат. limitrophus-пограничный-хилийн, хязгаарын) гэдэг нь 1917 оноос хойш Хаант Оросын нутаг дэвсгэр дээр бий болж,

[4] Курбонова З.М. Политические аспекты процесса урегулирования государственной границы между Тажикстаном и Китаем. М., 2009.
[5] БМС.1998, С-134.,ШЭФ 2001, 5-С-58.,БТС, с-223., В.М.Мокиенко.,Т.Г.Никитина. Большой словарь русских поговорок. М:Олма Медиа Групп, 2007.
[6] Олон улс сэтгүүл. ШУА-ын Олон улс судлалын хүрээлэн. УБ., 2015. №1. х-7
[7] Олон улс сэтгүүл. ШУА-ын Олон улс судлалын хүрээлэн. УБ., 2015. №1. х-7
[8] Аюшиева.И.Г.Современная концепция внешней политики Монголии-попытка преодоления буферного характера государственности/Вестник Томского государственного университета. 2008. №16.

бүрэлдэхүүнд нь багтаж байсан болон дараа нь 1990-ээд оны эхээр ЗХУ-ын бүрэлдэхүүнд нь байсан улсуудыг багтаан нэрлэсэн томьёолол юм[9].

Мөн олон эрдэмтдийн үздэгээр эртний Римийн хил хамгаалах цэргийн байрлалыг тэмдэглэж байсан грек үг бөгөөд лимес-граница-хил, трофос-питающий-хангагч гэсэн үг бөгөөд хил хамгаалж буй цэргийг хоол хүнс, зэр зэвсгээр хангах ёстой байснаас үүдэлтэй.

XX зууны сүүлээр В.Цымбурский “Лимитроф”-ыг гео улс төрийн нэр томьёонд анх удаа оруулж ирсэн байдаг.

✓ XX зууны эхээр Лорд Джордж Натаиэл Керзон гэдэг Английн төрийн зүтгэлтэн 1909 онд бичсэн “Положение Индии в империи” бүтээлдээ “Буферное государство-Бамбай улс”, харин Кеннет Эварт Боулдинг хэмээх Америкийн эдийн засагч, яруу найрагч “Конфликт и оборона: общая теория” гэдэг 1962 бичсэн бүтээлдээ “разновидность критических границ-аюултай хилийн нэг хэлбэр” гэсэн томьёололтой утга ойролцоо гэж үзэх эрдэмтэн судлаачид байдаг.

Бамбай улс (Буфер) гэдэг нь тогтоогдсон хил хязгаартай улс орон боловч, голлон тоглогч хүчтэй улс гүрэн нь бамбай улс орны газар нутгийг түшиц газар болгон өрсөлдөх дайсантай хүний газар нутаг дээр зэвсэгт тэмцэл явуулж, өөрийн ашиг сонирхлынхоо хил хязгаарыг тэлэх зорилготой байдаг гэж судлаачид үздэг.

Ер нь дэлхийд хүний нийгэм байгуулагдсан цагаас өнөөг хүртэл “амьдрах орчин”-ы төлөө тэмцэлгүй нэг ч өдөр байгаагүй гэхэд болно. Хүн төрөлхтөн соёлжин боловсрохын хирээр улс үндэстнүүдийн “амьдрах орчин” болсон газар нутаг, түүний хил заагийг хэрхэн тогтоох нь илүү найдвартай, оновчтой бат бэх байх талаар орон орны эрдэмтэн, судлаачид янз бүрийн онолын үзэл баримтлалуудыг боловсруулж хэрэгжүүлэхийг оролдож ирсэн байдаг.

Байгалийн буюу бодит хилийн онол, Олон улсын хил (“Хил гэтлэх онол”)-ыг барууны онолчид 1990-ээд оноос дэвшүүлэн тавих болсон бөгөөд энэ онолоор бол орчин үеийн шинжлэх ухаан, техникийн хувьсгалыг түргэн нэвтрүүлж, улс үндэстнүүдийн хөгжин дэвших явдалд “Хатуу” хяналт шалгалттай “Хаалттай” улсын хил саад болж байна. Иймд энэхүү хаалт саадыг арилгаж, улс бүр хил хязгаартаа чөлөөтэй нэвтрүүлдэг болох хэрэгтэй гэсэн номлол юм. “Ашиг сонирхолын хүрээний хилийн онол”-ын мөн чанар нь дэлхийн нөлөө бүхий орнууд хил залгаж буй эсэхээс үл хамааран дэлхийн хаана тэдний болон холбоотнуудын нь эрх ашиг хөндөгдөнө, тэнд эрх ашгаа зэвсгийн болон бусад бүхий л аргаар хамгаална гэсэн гол үзэл баримтлалыг баримталдаг. Эдийн засгийн хил,

[9]ru. Wikipedia.org.

Үндэстний хилийн онол (Германд пангерманизм, Америкийн Нэгдсэн Улсад Панамериканизм, Монгол үндэстнүүдийн хувьд Панмонголизм, Израильд Сионизм, Исламын орнууд болон Дундад Азийн орнуудад Панисламизм, Арабын ертөнцөд Панарабизм, Туркийн нөлөөний орнуудад Пантуркизм) гэх мэтийн үндсэрхэг болон шашны үзэл дээр суурилж туйлширсан номлолуудыг буй болоход гол суурь дэвсгэр болсон юм.

Күнзийн үзэл баримтлал, хятад төвтэй (китаецентризм) болон реконкист (өөрийн нутгийг эргүүлж авах) онол. Одоо Хятадууд Манж Чин улсын харьяаны бүх нутгийг өөрийн газар хэмээн үзэж байдаг ба энэ шалтгаан нь Хятадын эртний Күнзийн үзэл баримтлалаар Хятад хүний (аянчин, элч төлөөлөгч, худалдаачид, цэрэг г.м.) хөл хүрсэн газар бүхэн Хятад улсынх байх ёстой гэсэн үзлээс үүдэлтэй. Хятадын цагаачдад энэ санаа бодол олон зууны турш нэвт шингэж “Байлдан эзэлж эзэн суувал хэврэг, байгалийг нь эзэмшиж амьдран суувал мөнх” гэсэн геополитикийн бодлого баримталж дэлхийн өнцөг булан бүрт тархан суурьшсан хятад хүний толгой дээр наран үл шингэж байна[10].

Хятадууд “хятад төвтэй” (китаецентризм) үзэл баримтлалтыг өргөн хэрэглэдэг бөгөөд энэ үзлээр бол Хятадын харьяанд хэзээч орж байгаагүй болон ямар нэгэн байдлаар хамааралтай байсан газар нутгийг өөрийн нутаг дэвсгэрийн нэг хэсэг гэж үздэг. Түүхэн хөгжлийн явцад газар нутаг бие даасан байдалтай болон аль нэг улсын харьяанд орохыг тэд “алдагдсан газар нутаг“ гэж үздэг[11].

✓ Өнөөдөр Хятад улс дэлхийн хоёрдогч том гүрний байр суурийг эзлэхийн төлөө “Реконкист” онол буюу “өөрийн нутгийг эргүүлж авах” бодлогыг алсын зорилго, чиглэлтэйгээр тасралтгүй, олон янзын хувилбартайгаар явуулж байдаг[12].

БНХАУ нь “Цэргийн номлол”-доо 2000 онд өөрчлөлт оруулж, “Хятад Улс, Хятад иргэдийнхээ эрх ашгийг хамгаалахын тулд дэлхийн аль ч өнцөгт зэвсэг хэрэглэнэ” гэсэн заалт оруулсан юм.

Бид эдгээр нэр томьёо, онол, үзэл баримтлал, бодлоготой холбогдуулан хуулийн хүрээнд, хуулийн аргаар хариу арга хэмжээ авч, холбогдох эрх зүйн актыг боловсруулах шаардлагатай болж байна.

Аливаа хуулийн хэллэг, нэр томьёо агуулгын хувьд хоёрдмол утга санаагүй, тодорхой, оновчтой томьёологдсон байх ёстой.

Гадарладаг ганц хууль болох 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Их хурлаар батлагдаж, Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2017

[10] Ж.Сумъяа. Давст уул Оросын нутаг дэвсгэрт хэрхэн орсон бэ?. УБ., 2018. х-206-207.
[11] А.Д.Воскресенский. Китай и Россия: теория и история межгосударственных отношений (XII-сер XIX в). Хабаровск., 1986. С. 48.
[12] Сергей Басаев. Вырвется ли Россия из лап китайского дракона? Новая Бурятия. 2016.№37 (338). www. newbur.ru

оны №6-д нийтлэгдсэн “Монгол Улсын хилийн тухай” хуулийн зарим заалтуудын нэр томьёо, түүний агуулга, найруулгыг авч үзье. Тухайлбал:

3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

3.1.11. “Улсын хил хамгаалах байгууллага” гэж Монгол Улсын хэмжээнд улсын хил хамгаааалалтыг зохион байгуулах, удирдах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, түүний харьяа хилийн цэргийн анги, салбарыг;

34.2. Улсын хил хамгаалах байгууллага нь тэргүүн дэд дарга бөгөөд хилийн цэргийн штабын дарга, дэд дарга нартай байна.

38.2. Улсын хил хамгаалах байгууллагын дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга нар нь цэргийн дээд цолтой байна гэж хуульчилжээ.

Хил хамгаалах байгууллагын харьяа хилийн цэргийн анги, салбар-Улсын хил хамгаалах байгууллага юм бол дарга, орлогч нар нь 38.2-т заасанчлан цэргийн дээд цолтой байхаар ойлгогдож байгаа юм.

3.1.11. “Улсын хил хамгаалах байгууллага” гэж Монгол Улсын хэмжээнд улсын хил хамгаааалалтыг зохион байгуулах, удирдах үүрэг бүхий төрийн **захиргааны** байгууллага гэсэн нь Хил хамгаалах байгууллагын цэргийн албан хаагчид ТТ ангиллаар цалинжихгүй мөн Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйл, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага заалттай зөрчилдөхөд хүргэж байна.

Монгол Улсын бүх хууль нэг хэв загварт орсон, хэвшмэл нэг хэллэгтэй бөгөөд тэр нь “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэсэн томьёолол юм. Монгол Улсын Үндсэн хууль, үндэсний, үндэстний эрх ашгаас ухарсан энэ томьёоллоос татгалзах ёстой.

Саяхан шинэчлэн батлагдсан Оросын Холбооны Улсын Үндсэн хуульд орсон өөрчлөлтөөр бол манайхаас эсрэгээр буюу “ОХУ-ын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр бол ОХУ-ын хуулийн заалтыг дагаж мөрдөнө” гэж үндэсний эрх ашгаа дээдлэн хуульчилсан байдаг.

Монгол Улсын Хил хамгаалах байгууллага Монгол Улсын олон улсын 50 гаруй гэрээ, хэлэлцээр, үндэсний 200 орчим хуулийн заалтыг мөрдөж, мөрдүүлж үйл ажиллагаагаа явуулдаг.

Аливаа хууль боловсруулах ажлын хэсэгт Хэлний бодлогын үндэсний зөвлөл, ШУА-ын Хэл зохиолын хүрээлэн, Монголын хэл шинжлэлийн нийгэмлэгийн монгол хэл шинжлэлийн эрдэмтдийн идэвхтэй оролцоо, мэргэжлийн туслалцаа, зөвлөмж нэн чухал байна.

Олон улсад хэрэглэгддэг түгээмэл, нийтлэг нэр томьёог зөв оновчтой орчуулан нутагшуулахад болон Олон улсын эрх зүйгээр мэргэшсэн, тэр тусмаа далай тэнгисийн, агаарын, нутаг дэвсгэрийн, ашигт малтмалын

/Монгол Улсын нутаг дэвсгэрийг дэлхийн 23 орон 1674 лицензээр эзэмшиж, зөвхөн БНХАУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай Моэнко, Чайна инвестмэнт 2 компани гэхэд л 220.452 га газар буюу Говь-Сүмбэр аймгийн нутаг дэвсгэрээс 3 дахин том газрыг эзэмшиж байх жишээтэй/, олон улсын гэрээний эрх зүйгээр мэргэшсэн үндэсний хуульч, мэргэжилтнийг бэлтгэх нь өнөө цагийн төдийгүй Монгол Улсын ирээдүйн хувь заяа, эрх ашгийг олон улсын тавцанд хамгаалах гол зэвсэг, хөшүүрэг болох нь Монгол Улс олон улсын арбитрын шүүхэд дуудагдсан олон жишээнээс харж болох юм.

Сүүлийн үед орчин цагийн хил судлал дахь хилийн талаарх ойлголтуудад зарим өөрчлөлтүүд гарч шинэ ойлголт, түүнтэй холбоотой нэр томъёонуудыг тодорхойлон гаргах болсон. Үндсэндээ хүйтэн дайны төгсгөл, ялангуяа хуучин Зөвлөлт Холбоот Улсын коммунист системийн задралаас хойш, манайд ардчилсан тогтолцоонд шилжсэн үеэс хил шинжлэлийн ухаан нь үйл ажиллагааны хувьд олон улсын харилцаагаар илүү өргөжиж, чухал байр суурь эзлэх болсон бөгөөд бусад салбар шинжлэх ухаан, судлалтай улам бүр уялдаа, харилцан хамааралтай болж, тэдгээрийг нэгтгэн судлах шаардлагыг бий болгож байна. Хил судлалын цар хүрээ нь зөвхөн түүх, соёл, газар зүй, цэрэг, улс төр, шашин, хүн ам зүй, технологи, олон улсын харилцаа зэргээр хязгаарлагдахаа больж, аливаа улс, үндэстний чадавхтай холбогдох бүхий л чиглэлтэй хамаатуулан судлах болсон ба энэ нь үндэсний аюулгүй байдлын цөм асуудал болж байна.

Хэдийгээр өнөө цагт бидэнд тулгараад буй халдварт цар тахал нь эрүүл мэндийн салбарын үндсэн асуудал мэт боловч аюулгүй байдлын хувьд мөн түүнчлэн олон улсын харилцаанд гарч буй өөрчлөлт, өнгөрсөн жил гаруйн хугацааны туршлага, сургамжаас харахад хил судлалд зайлшгүй оруулж ирэх, хамааруулан хөндөх сэдвүүдийн нэг болоод байгаа юм.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөлөөгөөр цаашид хилийн албыг уламжлалт байдлаар зохион байгуулж, явуулах боломжгүй бөгөөд нилээдгүй хүндрэлүүдийг дагуулж байгаа нь хилийн асуудлыг бусад салбарын хүчин зүйлтэй нэгтгэн судлах, шинэ ойлголтуудыг бий болгохыг биднээс шаардаж, энэ асуудлыг өргөн хүрээнд авч үзэх, судалгааг эрчимжүүлэх шаардлагатай.

Түүнээс гадна даяаршлын нөлөөгөөр бий болсон худалдаа, харилцаагаар улс орнууд, хүмүүс олон улсын хил хязгаарын орон зайд гарч, чөлөөтэй харилцах, үйл ажиллагаагаа нээлттэй явуулах нөхцлийг бий болгосон бол, энэхүү Ковид-19 халдварт цар тахал нь эргээд улс орнуудыг аль болох олон улсын нээлттэй хилийн харилцаанаас

зайлсхийх, тэр байтугай улс дотроо бүс нутгаараа, үндэсний цөөнх, бүлэг, хэсгээрээ бусдаас тусгаарлах хэв маягийг эрмэлзсэн дүрэм журмыг янз бүрээр гаргах, тусдаа аюулгүй амьдрах, үй ажиллагаа явуулах гэсэн сонирхлын бүс, хаалттай орчныг үүсгэн хязгаарыг тогтоох гэсэн оролдлогууд нь даяаршлын бүр эсрэг үзэгдэл бий болохыг харууллаа.

Түүнчлэн халдварт цар тахалтай тэмцэж өнгөрөөсөн богинохон хугацаанд улс орнуудын улс төрийн байр суурь, бодлогууд янз бүрээр өөрчлөгдөж, улс төрчид улс орныхоо аюулгүй байдал, түүнчлэн хилийн асуудлаа шийдвэрлэхдээ цар тахлыг янз бүрийн түвшинд ашиглаж байгаа нь ажиглагдлаа. Тухайлбал Европын орнууд нээлттэй байсан хил хязгаараа бүрэн хааж, цагаачлал, аялал жуулчлалын хөдөлгөөнд хатуу чанга бодлого явуулах, зарим хамааралтай байдаг эдийн засгаа сэргээх оролдлого, гэмт хэрэгтэй тэмцэх, хилийн үйл ажиллагааг бэхжүүлэн чангатгах, хилийн төхөөрөмжүүдийг шинэчлэх, сайжруулахыг эрмэлзсээр байна.

Бусад улсын адил манай улс ч гэсэн цар тахалтай холбоотойгоор хилийн гадна болон дотооддоо баримтлах бодлого, үйл ажиллагааг янз бүрийн түвшинд тодорхойлж, хэрэгжүүлсэн ба үүнийг хил судлалд хэрхэн тодорхойлж, цаашид хамааруулан судлахад бидний оролцоо нэн чухал байх нь гарцаагүй.

ГАЗАР, ГАЗРЫН ХЭВЛИЙН ХИЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ЗАРИМ АСУУДАЛ

UNDERSTANDING OF THE LAND, SUBSOIL BORDER ON THE LAW ON STATE BORDER

Б.Амармэнд
Дотоод хэргийн их сургуулийн эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн хил судлалын ухааны докторант
Эрдэм шинжилгээний удирдагч: Ц.Ганболд
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн судлаач, доктор, профессор, хурандаа
Amarmend.B
Ph.D candidate, Institute for Border Security Studies, The Joined Research Institute, University of Internal Affairs
Ganbold.Ts
Researcher, Institute for Border Security Studies, The Joint Research Institute, UIA Ph.D, Professor, Colonel

Хураангуй: Энэхүү өгүүллээр газар, газрын хэвлий, хэвлийн хилийн тухай ойлголтыг авч үзэж, газрын хэвлийн хилийн зөрчиж буй гадаадын зарим улс орнуудыг судалж, Монгол Улсын газрын хэвлийн хилийн өнөөгийн байдал, түүнд нөлөөлж байгаа зарим асуудлыг судалсан болно.

Abstract: This study exams current conditions of the subsoil border of Mongolia, its definition and understanding based on experiences of foreign countries.

Түлхүүр үгс: Газар, газрын хэвлийн хилийн тухай ойлголт, онол эрх зүй, гадаадын зарим улсад газрын хэвлийн хилийг зөрчсөн үйлдэл, зарим асуудал.

Keywords: the Land, an Understanding of Subsoil Border, Theories and Legislation

Дэлхийн улс орнууд хил хязгаарынхаа хүрээнд төрөөс тодорхой чиглэлийг баримталж, хилийн аюулгүй байдлыг хангах системийг нэвтрүүлэн шинжлэх ухааны үндэстэй хилийн бодлого, стратегийг хэрэгжүүлж байдаг.

Монгол Улс газар зүйн байршлаараа дэлхийн геополитикийн сонирхолд багтсаар ирсэн. Монгол Улс “Атлантаас Номхон далай хүрэх” геополотикийн шугам, “Дэлхийн зүрхэн газар” Ази тивийн геостратегийн чухал түшиц нутаг, их гүрнүүдийн геополитик, эдийн засаг, соёл иргэншлийн ашиг сонирхлын уулзвар, цэрэг, стратегийн бодлого, дэлхийн том шашнуудын нөлөөллийн зах нийлсэн бүсэд оршиж байна.

Ази, Номхон далайн бүс нутагт олон улсын харилцааны шинж чанар, уур амьсгал нааштайгаар өөрчлөгдөж хилийн аюулгүй байдлын хамтын тогтолцоо бүрэлдэн бий болсон ч газрын хэвлийн хилийн аюулгүй байдлын талаар нэгдсэн ойлголт дутмаг байгаагаас ашиг сонирхлын бүлэглэлүүд улс хоорондын газрын хэвлийн хилийг зөрчих асуудал гарсаар байна.

Монгол Улс нь өөрийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, улсын хилийн аюулгүй байдлыг хангаж үндэсний язгуур эрх ашгаа урьтал болгосон, тогтвортой хөгжлийн асуудлаа шийдвэрлэх бие даасан бодлого баримталдаг боловч дэлхий дахинд эдийн засаг, хүн ам, техник технологи, цэрэг техникийн хүчээр тэргүүлэх хэмжээний хоёр их гүрний дунд оршдог геополитикийн өвөрмөц онцлогтой. Тиймээс хил залгаа улстай тэгш эрхтэй харилцан ажиллаж, улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг хангах орчин үеийн шинэ техник, технологийн ололтыг тухай нийгмийн хөгжилд нийцүүлэн нэвтрүүлж, хил хамгаалалтыг боловсронгуй болгох, хилийн аюулгүй байдлыг найдвартай хангах үндсэн үүргийг хэрэгжүүлж байгаа ч газрын хэвлийн хилийг хамгаалах, бүрэн бүтэн байдлыг нь хангах асуудал дутмаг байгаа нь зайлшгүй судлах шаардлагыг үүсгэж байна.

“Чухам энэ үүднээс улс орон бүр хил хязгаарын аюулгүй байдалдаа онцгой анхаарч төрийн бодлогодоо хилийн асуудлыг тусгайлан авч үзэж, НҮБ-аар хил хязгаараа баталгаажуулан, улс орныхоо хаяа хатавчийг сахин хамгаалж ирсэн бөгөөд тусгаар байх, бүрэн эрхт байдалд учирч болох аюул заналыг улс орон бүр янз бүрийн түвшинд авч үздэг. Нэгэнтэй хил хязгаарын бүрэн бүтэн халдашгүй байдал түүнтэй холбогдох олон талт асуудлыг бүхэлд нь авч үзэж буй “Хилийн аюулгүй байдал” хэмээх ухагдахууныг дийлэнх улс орнууд хүлээн зөвшөөрч үндэсний аюулгүй байдлынхаа нэгэн чухал асуудал болсон”[1] ч газрын хэвлийн хил гэдэг ойлголтыг шинжлэх ухааны түвшинд судлан эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх, газрын хэвлийд буюу хил дамнасан байгалийн баялгийг хамгаалах түүнд хяналт тавих, газрын хэвлийн хил зөрчигдөхгүй байхад анхаарах нь өнөө үед тулгамдаж байгаа асуудал мөн болно. “Улсын хил хамгаалалт нь үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний салшгүй хэсэг”[2] мөн бөгөөд газрын харилцаатай холбоотой манай улсын хуульд доорх байдлаар газрын хэвлийг тодорхойлсон байна. Үүнд:

Газрын хэвлийн тухай хуульд: “Хөрснөөс доош газрын гүн рүү үргэлжлэх орон зай, түүний эзлэн орших материаллаг бүх зүйлс /бүх

[1] Н.Наранжамц “Хил судлал сэтгүүл”., УБ., 2019 он. 8 дахь тал
[2] Монгол Улсын Хилийн тухай хууль. УБ., 2016.

төрлийн чулуулаг, ашигт малтмал болон геологийн бусад биет, түүнчлэн барилга байгууламж/-ийг газрын хэвлий гэнэ[3].

Газар болон газрын харилцаатай холбоотой Газрын тухай[4], Газрын хэвлийн тухай[5], Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай[6] зэрэг хуулиуд батлагдан гарч Монгол Улсад газрын эрх зүйн харилцаа бэхжсэн гэж үзэж болохоор байна. Гэвч зах зээлийн эдийн засагт эргэлт буцалтгүй орсон манай улсын хувьд газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, байгалийн баялгаа ашиглах зэрэг газартай холбоотой олон талт үйл ажиллагаа явагдаж эхэлсэн бөгөөд үүнтэй холбоотойгоор сүүлийн жилүүдэд хилийн бүс, зурваст байгалийн баялаг олборлох зорилго бүхий аж ахуйн нэгж байгууллага, уул уурхай, нефть боловсруулах үйлдвэрүүд нэмэгдсээр байна.

Цаашид ашигт малтмалын орд газар эрчим хүчний нөөцийг ашиглах, газар доор барилга байгууламж барих, үйлдвэрийн хаягдал, нефть, хий бусад бүтээгдэхүүнийг хаях, булах, хадгалах, дулааны шугам сүлжээ байгуулах зэргээр хоёр улсын аж ахуйн нэгж байгууллага, уул уурхайн компани, нефть боловсруулах үйлдвэрүүд төрөл бүрийн зориулалтаар үйл ажиллагаа явуулсны улмаас газрын хэвлийн хилийг зөрчих, зөрчил гарч болзошгүй тул газрын хэвлийг хамгаалах, гарч байгаа зөрчлийг илрүүлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тусгайлан авч судлах, онол, практикийн хэрэгцээ шаардлага байна.

Газрын тухай ойлголт: Шинжлэх ухаанд газрын ертөнц буюу газрын бүрхэвч бүхий нутаг дэвсгэр, ертөнцийн гадаргуу буюу хөрс гэсэн 3 хэсэгт хуваж үздэг. Газар нь байгалийн бусад нөөцийн дотор бие даасан өвөрмөц байдалтай бөгөөд өөрийн шинжүүдээрээ экологи, нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, ёс суртахууны чиг үүргийг биелүүлдэг байна.

Газрыг шинжлэх ухааны үүднээс: Газрын хэвлий, дээд давхарга, газрын ертөнц, газрын бүрхэгч**,** бүхий л нутаг дэвсгэр**,** ертөнцийн гадаргуу буюу хөрс гэсэн утгыг агуулдаг бөгөөд газрын хэвлийн тухай ойлголт буюу түүнийг судлахдаа агаар мандлын дээд хязгаарыг газрын гадаргаас эгц дээш 100-110 км гэж үздэг бол байгалийн чухал бүрэлдэхүүн, газрын гадаргуугийн суурь хэсэг нь газрын хэвлий юм. “Дэлхийн хамгийн гадна талын давхарга үе бол царцдас бөгөөд царцдас нь хүрмэн чулуулгийн үе буюу /суурилаг чулуу/, боржин чулуулгийн үе буюу /хүчиллэг чулуу/, тунамал чулуулгийн үе буюу /тунаж хуримтлагдаж бий болсон чулуу/ гэсэн 3 үеээс тогтож бүрэлдсэн эх газраас доош чулуулаг бүрхүүл нь газрын хэвлий рүү 25-70 км үргэлжилдэг өөрөөр хэлбэл газрын гүний үргэлжлэх

[3] Монгол Улсын газрын хэвлийн тухай хууль. УБ., 1988.
[4] Төрийн мэдээлэл. 2016. № 12
[5] Төрийн мэдээлэл. 2015. № 9
[6] Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль. УБ., 2002.

орон зайг газрын хэвлий гэж ойлгож болох бөгөөд түүнд байгалийн төрөл бүрийн элементүүдээс тогтсон эрдэс чулуулгаас бүрдсэн эрчим хүчний болон байгалийн бусад нөөцөөс гадна хүний эрүүл мэндэд хэрэгтэй эмчилгээний зориулалт бүхий элемент, түүх соёлын дурсгалт зүйлүүд хадгалагдаж байна. Монгол орны хэмжээнд чулуулаг бүрхүүлийн зөвхөн дээд өнгөн хэсгийг сайн судлагдаж түүний гүнд орших хэсгийг геофизикийн тандалт, судалгааг одоог хүртэл хийсээр байгаа”[7] “Газрын хэвлий” гэж шимт хөрснөөс доош, шимт хөрс байхгүй тохиолдолд газрын гадарга, нуур, голын ёроолоос доош үргэлжлэх орон зайд орших бүх төрлийн байгалийн тогтоц, барилга байгууламжийг хэлдэг бөгөөд газрын хэвлий нь түүний ашиглаж байгаа эсэхээс үл хамааран улсын нэгдмэл санг бүрдүүлдэг.

Газрын хэвлийн агуулга, бүтэц

Дэлхийн дотоод тогтоц: Геофизикийн тухайлбал, чичирхийллийн (сейсмийн) аргыг ашиглан (өөрөөр хэлбэл дагуу P ба хөндлөн S долгионоор) дэлхийн дотоод тогтоц нь бүслүүрлэг болохыг тогтоосон. Энэ нь ямарваа нэгэн долгион физикийн нэг биеийн дотор жигд хурдтайгаар тархах бөгөөд хоёр биетийн зааг дээр хугарч задран зарим нь цааш нэвтэрч бусад нь буцдаг. Үүнийг ашиглан тайлбарласан.

Газрын гадаргаас тархсан дагуу долгион 6.5-аас 7.5 км/с, хөндлөн долгион 3.7-3.8 км/с хурдтайгаар чулуулаг дундуур нэвтрэх бөгөөд дунджаар 33 км яваад эрс өсч долгионы хурд 7.9 км/с, заримдаа 8.2-8.3 км/с, хөндлөн долгионы хурд 4.7 км/с хүрдэг. Энэ нь чулуулаг бүрхүүлийг дээд мантиас зааглаж буй хил бөгөөд анх Югославын геофизикч С.Мохоровичич тогтоосон учир Мохын хил гэж нэрлэдэг. Энэ нь дэлхийн царцдас (земная кора) болон мантийн зааг болно. Дагуу долгион цааш 2900 км гүн хүртэл 7.9-өөс 13.8 км/с хүртэл өсөх бөгөөд эндээс долгионы хурд эрс өөрчлөгдөж 7.4 км/с болтлоо буурч хөндлөн долгион тархахгүй болно. Энэ нь манти цөм хоёрын зааг болно. Геофизикийн энэ судалгаагаар манти цөм хоёр нь хоёр хуваагддаг болох нь тогтоогдсон бөгөөд мантийг дээд доод, цөмийг дотоод гадаад гэж ангилсан. Тэдгээрийн зааг нь 900-1000 км, 5100 км болно[8].

[7] Б.Лувсанданзан., “Геологийн үндсүүд”., УБ 2011 он

[8] “Газрын хэвлийн геофизик”

Зураг 1. Дэлхийн дотоод бүтэц



Хүснэгт 1. Газрын давхаргын ангилал

Газрын давхарга
Дэлхийн хамгийн гадна талын бүрхэвчийг газрын давхарга гэнэ.

Газрын давхарга	
Эх газрын давхарга 65 хувь	Далайн давхарга 35 хувь

Эх сурвалж: Дэлхийн үүсэл хөгжил-2004

Эх газрын давхарга нь: дэлхийн гадаргын 65%-ийг бүрхэнэ. Зузаан нь дунджаар 10-70 км, газрын давхаргад O 2, Si, Al, K, Na нилээд хувийг эзлэх ба нягтрал багатай хөнгөн, цайвар өнгөтэй чулуулгаас тогтоно.

Хүснэгт 2. Чулуулаг үелэлийн ангилал.

Чулуулаг үелэл		
Тунамал 15-20 км	Боржин 40 км	Хүрмэн 15-35 км

Эх сурвалж: Дэлхийн үүсэл хөгжил-2004

Газрын давхарга мантиас /Мохын гадарга/-аар тусгаарлагдана. 1909 онд Югославын физикч А.Мохоровичич нь газар хөдлөлтийн сейсмисийн бичлэгийг судалж 50 км орчим гүнд долгионы хурд эрс өсөж 8 км/с хүрдгийг тодорхойлсноор газрын давхаргын бодисууд мантиас бага нягттай болохыг баталсан.

Монгол Улсын газрын хэвлийн хилийн тухай онол эрх зүй.

Газрын тухай хуульд Монгол Улс тусгай хэрэгцээний газартай байна. Улсын тусгай хэрэгцээний газарт улсын хилийн зурвас газар хамаарна. Хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдалд харшлах, байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй байна[9].

Ашигт малтмалын тухай хуульд эрх бүхий байгууллагаас улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авч ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон газрыг тусгай хэрэгцээний газарт тооцно[10] гэж заасан байна. Дээрх хуулиудад дурдагдсан ашигт

[9] Газрын тухай хууль. УБ., 2002
[10] Ашигт малтмалын тухай хууль. УБ., 2006

малтмал эрэх, хайх, олборлох, ашиглахыг хязгаарласан дараах тусгай хамгаалалтай 13 газрыг нэрлэж тусгасан. Үүнд:

- улсын хилийн зурвас;
- хилийн боомтын бүс;
- чөлөөт бүсийн газар;
- батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар;
- гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар;
- цөмийн төхөөрөмж барих, ашиглах зориулалтаар олгосон газар;
- үндэсний бүтээн байгуулалт, дэд бүтцийг хэрэгжүүлэх газар;
- аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар;
- бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуул хийх газрын тосны талбай;
- цаг агаарын төлөв байдлын байнгын ашиглалтын талбай;
- бичил уурхайн зориулалтаар олгосон газар;
- улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай;
- аймаг дундын отрын бэлчээр тус тус ордог байна.

Хилийн орон зайд төр, нийгэм, иргэдийн амин чухал эрх ашгийг хангах асуудал учир Монгол Улсын хувьд хилийн орон зайн улсын хилийн шугамаас хуулиар тогтоосон газар нутгийн гүний хязгаар түүний агаар мандал, хэвлийн хэсгийг хил залгаа улсын хил орчмын нутаг дэвсгэрийн /агаар, газрын хэвлий/ хамт хамтатган авч үздэг орон зай юм.

Өнөөдөр олон улс, бүс нутгийн түвшинд иргэний дайн, дүрвэгсэд хууль бус цагаачлал, салан тусгаарлагчид болон зэвсэгт бүлэглэл, хар тамхи мансуурах бодисын худалдаа, зэвсэг галт хэрэгсэл, хүний наймаа, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, газар нутгийн маргаанаас үүдэлтэй хилийн зөрчил будлиан гарсаар байна. Энэхүү аюул занал нь Монгол Улсын хувьд анхааранд зогсохгүй зохих бэлтгэлтэй байхыг шаарддаг. Монгол Улсын хилийн аюулгүй байдалд учирч байгаа аюул занал болох зэвсэг галт хэрэгсэл хууль бусаар хил нэвтрүүлэх, хар тамхи, мансууруулах бодис хил нэвтрүүлэх, зөөвөрлөх, улмаар хадгалах, худалдаалах түүний хэрэгцээ хэрэглэгчийн тоо өсөн нэмэгдсээр байна[11].

“Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна” гэсэн суурь ойлголтоор улсын хил ба хил хамгаалалтын агуулгатай холбогдоно”[12]. Улсын хил гэсэн ойлголтыг *“Монгол Улсын нутаг дэвсгэрийн зах хязгаарыг газрын гадаргуу, усны мандал дээр хил залгаа улсын нутаг дэвсгэрийн хязгаараас зааглаж, Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлж, тогтоосон шугамыг*

[11] Н.Наранжамц “Хил судлал сэтгүүл”., УБ., 2019 он. 11 12 дахь тал
[12] О.Үржин “Хил судлал сэтгүүл”., УБ., 2019 он. 34 35 37 дахь тал

Монгол Улсын хил /цаашид "улсын хил" гэх/ гэнэ. Уг шугамаас эгц дээш агаарын, мөн шугамаас эгц доош газрын хэвлийн хил байна."[13] гэж хуульчилсан байдаг.

Энэ тодорхойлолтыг системийн хандлагын өнцгөөс шинжилбэл улсын хил гурван бүрэлдэхүүн хэсэг, тэдгээрийн хоорондын хамаарлаас тогтсон бүтцийн систем болохыг харж болно. Улсын хил хамгаалалтын систем буюу цогц байдлын зургаар илэрхийлбэл дараах байдалтай байна.

Хүснэт 3. Улсын хилийн системийн зураглал



Эх сурвалж: "Хил судлал сэтгүүл"-2019.

Улсын хил хамгаалалт зөвхөн газрын гадаргуун хилийн шугамын уртаар хязгаарлагдах бус, харин түүнээс эгц дээш болон эгц доош үргэлжилсэн босоо хавтгайн талбайн хүрээнд яригдана.[14].

Газрын хэвлийн хил нь хуурай газрын болон усан хилийн шугамаас эгц доош орших бөгөөд түүний гүний хэмжээг тогтоосон олон улсын эрх зүйн баримт бичиг гараагүй. Монголчууд хил хязгаарын тухай уламжлалт мэдлэг, ойлголт, нэр томьёо байсан ба түүнийг хэрэглэж баримталж ирсээр одоог хүрсэн.

Монгол Улсын газрын хэвлийн хилийн өнөөгийн байдал: Монгол Улс газрын хэвлий буюу газар доор 80 гаруй төрлийн батлагдсан ашигт малтмал эрдэс баялагтай, үүнд нүүрс, зэс, вольфрам, флор, алт, мөнгө, молиблени, хөнгөн цагаан, тугалга, төмөр, хар тугалга, цайр, уран, манган, фосфор, давс, газрын тос гэх мэт. Түүнчлэн нүүрсний нөөц ойролцоогоор 50-152 тэрбум тонн байдаг. Түүнчлэн флорын нөөц ойролцоогоор 8сая тонн, төмрийн нөөц 2 тэрбум тонн, фосфорын нөөц 200 сая тонн, зэсийн нөөц 8 сая тонн, молибдены нөөц 240000 тонн, цайрын нөөц 60000 тонн, алтны нөөц 300 тонн, мөнгөний нөөц 700 тонн, газрын тосны нөөц 1.5 тэрбум тонн байна. Эрдэнэтийн 3эс молибденын

[13] Монгол Улсын хилийн тухай хууль. УБ., 2016, 4.1 дүгээр заалт





уурхай нь дэлхийн хэмжээний зэс молиблены 10 том уурхайн нэгд зүй ёсоор тооцогддог бөгөөд түүний зэрэглэл нь Азийн хэмжээнд ижил төрлийн үйлдвэрлэлүүдийн нэгдүгээрт бичигддэг. Ойн бүс 18.3 сая га, нийт газар нутгийн хэмжээнд ойн эзлэх харьцаа 8.2%, ургаж байгаа ойн сангийн эзлэхүүн нь 1.2 куб метр байна.

ОХУ нь дэлхийн байгалийн хийн нөөцийн 26,7%, олборлолтын 22,1%, экспортын 29%, газрын тосны нөөцийн 6%, олборлолтын 11,4%, экспортын 9,3% эзэлдэг томоохон нийлүүлэгч бөгөөд эдүгээ эрчим хүчний дипломат бодлого явуулж байна. Стратеги бодлогын хүрээнд Монгол Улстай хиллэдэг хэсгийн газар орон, газрын хэвлийд байгалийн баялаг ихээр олборлох нь сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байгаа юм.

Мөн Хятадын эрчим хүчний болон аж үйлдвэрийн түүхий эдийн импорт жилээс жилд өссөөр байна. БНХАУ-ын статистикийн мэдээгээр тус улс жилд 2.19 тэрбум тонн нүүрс, 181 сая тонн төмрийн хүдэр, 352 сая тонн ган, 16.3 сая тонн төрлийн өнгөт төмөрлөг олборлодог, харин 126,8 сая тонн газрын тос, 275.2 сая тонн төмрийн хүдэр, 4.58 сая тонн марганцын хүдэр, 3.02 сая тонн хром, 4.06 сая тонн зэсийн хүдэр импортоор авсан байна. Тиймээс эрчим хүч болон аж үйлдвэрт нэн шаардлагатай түүхий эдийн найдвартай эх үүсвэр олох, улс орноо тогтвортой хангах Хятадын төрийн бодлогын томоохон зорилтуудын нэг, улс орон нь эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой амин чухал эрх ашиг болоод байна.

“Улсын хил хамгаалалт нь үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний салшгүй хэсэг мөн. Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, Монгол Улсын хилийн хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн зурвас, боомт, бүс, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, цэргийн, инженер-техникийн, мэдээлэл технологийн, тагнуулын, хилийн төлөөлөгчийн арга хэмжээг хослуулан явуулж байгаа үйл ажиллагааг улсын хил хамгаалалт гэнэ.

“Газар, усан дээрх улсын хилийг Хил хамгаалах байгууллага, агаарын хилийг зэвсэгт хүчний агаарын цэрэг хамгаална”[15], Хил хамгаалах байгууллагын үүрэгт “агаарын хилийг зөрчсөн байж болзошгүй нисгэгчтэй болон нисгэгчгүй нисэх хэрэгслийн талаарх мэдээллийг зэвсэгт хүчний агаарын цэргийн анги, салбарт шуурхай дамжуулах”[16] гэсэн эрх зүйн зохицуулалтын өнцгөөс харвал газрын хэвлийн хил хамгаалалт ямар ч

[15] Монгол Улсын хилийн тухай хууль. УБ., 2016, 31 дүгээр зүйл.

[16] Монгол Улсын хилийн тухай хууль. УБ., 2016,35.1.9 дүгээр зүйл.

зохицуулалтгүй, хариуцах эзэнгүй байгааг харж болно. “Харин хилийн тухай хуулийн “хилийн зөрчил”-ийн жагсаалтад “улсын хилийг газрын хэвлийгээр нэвтэрсэн”[17] гэсэн заалт байгаа нь газрын хэвлийн хилийн хамгаалалт зарим талаар Хил хамгаалах байгууллагын үүрэгт хамаарах ойлголтыг бий болгож байна.

Монгол Улс нь газрын хэвлий дэх баялгаараа хэмжээлшгүй их бөгөөд алт, хүдэр, уран, мөнгө, газрын тос зэрэг нь хилийн зурвас болон хоёр улсын хил дамнасан газрын хэвлийд оршин байгаа байгалийн баялаг болох судалгаагаар тогтоогдсон бөгөөд хэтийн төлвийн судалгаа хийхэд одоогийн байдлаар 13 компани газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээрийн 33% нь Монголын аж ахуйн нэгжүүд, 39% нь БНХАУ-ын компани, 28% нь бусад орны компаниуд байна .Үүнээс газрын тосны үйл ажиллагаа явуулж байгаа БНХАУ-ын төрийн өмчит компани болох “Петрочайна дачин тамсаг” ХХК үйл ажиллагааг авч үзвэл.

Зураг 2. Газрын тосны байршлын зураг.



Эх сурвалж: ”Газрын тосны хэрэг эрхлэх газрын тайлан”-2017

Тамсагийн Сав Газар дахь Гэрээт Талбай 19-н гидрогеологийн судалгааны төслийн ажиллагаа нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн зүүн хэсгийн тал нутагт явагдах бөгөөд энэ нь засаг захиргаа нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу бол Монгол Улсын Дорнод аймагт харъяалагддаг. Энэ нь Монгол Улсын зүүн захын аймгийн төв Чойбалсан хотоос баруун зүгт 180 км, Өвөр Монголын Өөртөө Засах Орны Гсинбархүзүо сууринаас зүүн хойд зүгт 200 км, Өвөр Монголын өөртөө Засах Орны Донгвүжүмүкин сууринаас өмнө зүгт 160 км-т байрлана. Газар зүйн координат: 116˚04'34"-116˚21'34"E, болон 46˚50'01"-47˚04'17"N, бөгөөд төслийн бүсэд хамаарах нутаг дэвсгэр нь 381 км^2 талбай байна. Судалгаагаар 300-1300 метрийн гүнтэй 524 цооног, 30 метрийн гүнтэй 3 цооногоос газрын тос татан авч, цооног хоорондын зай 500-2000 метр, 1 цооног нь 500-1500 метрийн

[17] Монгол Улсын хилийн тухай хууль. УБ., 2016, 22.1.3 дугаар заалт.

радиусыг хамардаг байна.

Зураг 3. Улсын хилийн шугамд тулсан газрын тосны цооногийн байршлын зураг





Эх сурвалж: Судалгааны ажлын хүрээнд хийсэн судалгаа

Газрын тосны цооногууд нь Монгол Улсын хилийн шугамаас 1200 метрт, БНХАУ-ын хилийн шугамаас 100-500 метрт байрладаг байна. Үүнээс үзэхэд “Петрочайна дачин тамсаг” ХХК-ны газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа газар нь хоёр улсын газрын хэвлийн сав газрын байгалийн баялаг юм.

БНХАУ дотоодынхоо нөөц бололцоог нэмэгдүүлэхийн зэрэгцээ эрдэс түүхий эдийн гадаад эх үүсвэрээ бэхжүүлэх талаар идэвхитэй ажиллаж байна. Эрчим хүч, түүхий эдийн нөөц баялаг ихтэй орнууд тухайлбал, Монгол Улсаас гадна ОХУ, Казакстан, Чили, Саудын Араб, Иран, Нигери, Венесуэл зэрэг орнуудтай харилцаагаа идэвхжүүлж байна. БНХАУ нь Монгол Улстай хиллэдэг хэсгийнхээ хилийн чанад дахь эдийн засгийн үйл ажиллагаагаа идэвхжүүлэх, томоохон компани болон уул уурхай, газрын тос, хийн том ордуудыг оруулах талаар тууштай ажиллаж байна.

Зураг 4. Хятад улс: Түлш, эрчим хүч, эрдэс баялагийн тойм зураг



БНХАУ-ын “Доншэн газрын тос” компани Монгол-Австралийн “Рок Ойл” компанийг 2003 оны гуравдугаар сард, АНУ-ын “Соко Тамсаг Монголиа ЛЛС” компанийн гэрээлэгчийн эрхийг БНХАУ-ын “Петро Чайна-Дайчин Тамсаг”-д 2005 оноос 100% шилжүүлэн өгсөн тодорхой хэмжээний газар нутаг түүний асар их баялгийг манай нутагт ажиллаж байгаа гадаадын иргэд, компанид өмчлүүлэх нь Монгол төрийн бодлого мөн эсэх нь тодорхойгүй. Ингэснээр Монголын газрын тосны идэвхтэй хайгуул, олборлолт хийж буй орд газрууд бүгд Хятадын компанийн мэдэлд орсон байна.

Мөн Монгол Улсын хөгжлийн бодлогод чухал ач холбогдол бүхий 15 орд бий. Эдгээрийн нэг болох Асгатын мөнгө, холимог металлын орд нь Монгол орны баруун хэсэгт, Баян-Өлгий аймгийн Ногоон нуур сумын нутагт, ОХУ-ын Алтайн хязгаартай хиллэн оршдог. далайн түвшинээс дээш 2500-3500 метр хүртэл өргөгдсөн. Монросцветмет компани Асгатын ордын дөрвөн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг байна.

Зураг 5. Асгатын мөнгөний ордны байршлын зураглал.



Эх сурвалж: “Монголросцветмет ХХК-ны Улсын Их Хуралд хийсэн танилцуулга”-2018.

Асгатын орд газрыг ашиглах талаар багагүй хүчин чармайлт гаргаж байсан бөгөөд тухайлбал, 1992 онд Асгат ХК, 1996 онд АНУ-ын “АПЕКС Силвер майнинг” компанитай хамтарсан “Асгат мөнгө” ХХК, 2004 онд ОХУ-ын Алтайн Бүгд Найрамдах Улстай хамтарсан ЭМ-ЭС “Асгат” ХХК, ОХУ-ын Шинжлэх, ухаан үйлдвэрлэлийн “Полиметалл” нэгдэлтэй хамтарсан “Асгатполиметалл” зэрэг компаниуд байгуулж байсан хэдий ч Асгатын орд газрын байршил, уул геологийн хүнд нөхцөл, дэд бүтэц хөгжөөгүй зэргээс болж өнөөг хүртэл бодит ахиц гараагүй байна. Геологи эрдэс баялгийн яамны сайдын 1993 оны наймдугаар сарын 16-ны өдрийн 111 тоот тушаалаар “Асгат” ХК-ийн хөрөнгийг хүлээн авч “Монголросцветмет” ХХК Асгатын уулын үйлдвэрийг байгуулан газрын гүнд 4 нүх ухаж туннель хийн ашигт малтмалыг олборлох талаар үйл ажиллагаа явуулсан байдаг.

Зураг 6. Асгатын мөнгөний ордны туннелийн зураг /Монголын тал/



Эх сурвалж: “Монголросцветмет ХХК-ны Улсын Их Хуралд хийсэн танилцуулга”-2018.

Энэ мөнгөний орд нь хоёр улсын хил дамнасан байгалийн баялаг бөгөөд манай улс нь ашиглах үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд ОХУ нь өөрийн талаас хоёр нүхэн туннель гарган ашиглаж дууссан гэх албан бус мэдээлэл байгаа нь тухайн уурхайн туннелийн гүний хэмжээ, ашиглалтын байдал тодорхой бус ашиглалт хийгдэж дууссан бол газрын хэвлий хилийг зөрчсөн эсэх асуудал урган гарч ирж байна.

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК болон Асгатын мөнгөний орд буюу энэ хоёр компанийн үйл ажиллагаанаас гадна цөөнгүй уул уурхай, ашигт малтмалын компаниуд хилийн зурваст үйл ажиллагаа явуулах мөн БНХАУ-ын талаас хилийн дагуу газрын тос болон уул уурхай, ашигт

малтмал олборлох үйл ажиллагаа нэмэгдсээр байгаа нь судалгааны үр дүнд харагдаж байна.

Газрын хэвлийн хилийг зөрчсөн болон зөрчиж болзошгүй нөхцөл байдал, шийдвэрлэвэл зохих зарим асуудлууд

Газрын хэвлийн хилийг зөрчсөн үйлдлүүд: Газрын хэвлийн хилийг зөрчих асуудлыг олон улсын хил хязгаарын зөрчлөөс авч үзэхэд АНУ болон Мексик улс хоёрыг зааглагдаг хил нь Мексикийн хойд хэсэгт оршдог бөгөөд 3,169 км үргэлжилдэг энэхүү хилээр жилд 250 сая хүн орж гардаг тул Дэлхийн хамгийн олон хүн зорчдог хилд тооцогддог хяналт султай хилийн бүс нутагт зүй ёсоор ордог. Мексикийн зэвсэгт хүчин АНУ-ын хилийн орчимд хар тамхи зөөвөрлөдөг туннелийг 2009 онд илрүүлсэн бөгөөд газарт 20 метрийн гүнд 230 метр үргэлжлэх энэ суваг нь Мексикийн Сан-Луис хотын цэвэр усны дэлгүүрийг Аризона мужийн мөн цэвэршүүлсэн усны дэлгүүртэй холбосон байсан бөгөөд туннелийг цахилгаан болон агааржуулах системээр тоноглон, тэр ч бүү хэл хар тамхи зөөвөрлөх жижиг тэрэг хүртэл тавьсан нь газрын хэвлийг ухаж хэвлийн хилийг зөрчсөн байна. АНУ-ын Засаг захиргаа 1990 оноос хойш 150 гаруй ийм төрлийн хэвлийн хилийг зөрчсөн туннелийн сувгийг илрүүлээд байгаа юм.









Мөн Израйль газын зурвасын Египтдээ /Синайн хойг/ хиллэдэг хэсгээр хууль бусаар газрын хэвлийд туннель байгуулан түүгээр зэр зэвсэг, тэсрэх бодис орж ирдэг хэмээн АНУ, Англи, Франц зэрэг улстай хамтран Америкийн тусламжтайгаар Египтчүүдээр 2009 онд хилийн дагуу хамгаалалтын хана босгуулж эхэлсэн. Энэ төмөр ханын өндөр нь 18 метр, урт нь хилийн дагуу 11 км, газрын гүн рүү 4.5 метр хийгдсэн бөгөөд цаашид шаардлагатай гэж үзвэл бусад газрын хэвлийд болон усан доогуур хамгаалалтын хана туннель бий болгох талаар шийдвэрлэсэн байна.





Өмнөдийн газрын туннель нь Бүгд Найрамдах Солонгос Ардчилсан Бүгд Найрамдах Солонгос Улсыг дайран довтлох зорилгоор барьсан цэргийн туннель юм. Туннелийг байгуулахдаа газрын хэвлийн хилийг зөрчсөн бөгөөд 1997 онд АНУ-ын Тэнгисийн Корпорациас хэвлэгдсэн "Хойд Солонгос гарын авлага"-аас үзэхэд өмнөдөд буух туннельд нийтдээ 20 орчим байна гэж тооцоолсон байна. Газрын хэвлийд нүхэн гарц буюу туннелийн байгууламж хийж зорилго нь Өмнөд солонгосын эзлэх байлдааны арга тактикийн томоохон байгууламж байсан бөгөөд үнэндээ газар доорх хонгил дэлхийн дайны түүхэн дэх нэгэн төрлийн стратеги юм. 1904 оны Орос-Японы дайны үед зургаан том газар доорх нуувч ухан Манжид нэвтрэх бэлтгэл хийсэн. Вьетнамын дайнд алдартай газар доорх агуй битконы ялалтын гол хэрэглэгдэхүүн байлаа. 2500000 км газар доорх хонгилоор дайтсаны үр дүнд биткончууд америкчуудыг үлдэн хөөж, төсөөлшгүй ялалтад хүрсэн билээ. Газар доорх хонгилын стратегийн ялалт байлаа[18].

Солонгосын дайны үед Америкийн дайралтаас газар доорх суваг ухаж амь гарсан Ким Илсон нь газар доорх суваг буюу хонгил хэрэгтэйг мэдсэн бөгөөд Вьетнамын дайны үед дайны талбарт очиж газар доорх сувгийн талаар өөрийн биеэр танилцсан байна. Тэгээд Ким Илсон дайны гал зогссон тайван байдлыг ашиглан газар доорх суваг ухахаар шийдсэн

[18] https://www.aladin.co.kr/m/mproduct.aspx?ItemId

байна.

Нэгдүгээр туннель нь 1974 оны арваннэгдүгээр дүгээр сард Кёнги мужийн өмнөд хэсэгт нээгдсэн бөгөөд өглөө цэрэггүй бүсийг шалгаж явсан 25-р салааныхан сонин үзэгдэлтэй тулгарлаа. -6 хэмд хогийн ургамал ургасан байхыг хараад ухаж эхэлснээр газар доорх сувгийг илрүүлэв. Харин ухаж байсан цэргүүд хоолоо ч идэлгүй, хонгил ухаж байсан техник төхөөрөмжөө тэр чигт нь хаяад зугтацгаав. Тэдний үлдээсэн ул мөр нь хэр удаан, төлөвлөгөөтэйгөөр хонгил ухаж ирснийг илтгэсэн байна.

Хоёрдугаар туннель нь 1975 оны гуравдугаар сард Гангвон хотод байрладаг Cheongwon-gun хотын Gongdong талбайд нээгдсэн. Газар доорх сувгийг олох тийм ч амар байсангүй “Шөнийн загасчлал” нэртэйгээр эхэлж, тухайн орчинд ямар нэгэн онцгой шинж тэмдэг илэрвэл газрыг өрөмдөж байсан. Ингээд 1975 онд 45 газар өрөмдлөгө хийн шалгах явцад 10 дугаар өрөмдлөгийн хэсгээс дулаан уур болон утааны үнэр гарч, мөн өрөмдлөгийн үед өрмөнд чулуулаг наалддаг бөгөөд тухайн өрөмний үзүүрт 1 метр орчим юу ч байхгүй хоосон байв. Ингээд камер суурилуулсан өрмөөр шалгаж эхлэхэд камер 58 метр доошлоход эргэн тойрон цагаан харагдсан энэ нь чулуулгаар дүүрэн байсан ба 59 дэх метрээс эхлэн харлаж эхэлжээ. Ингээд 61 дэх метрт хүрэхэд хоосон орон байгааг илтгэж байсан. Ийнхүү газар доорх хонгилын хажуу талаас нь угтаж ухаж эхэлсэн бөгөөд 20 өдрийн дараа газар доорх сувагтай холбогдов. Сувгийн өргөн хоёр метрээс их, өндөр нь хоёр метр гаруй бөгөөд хилийн зурвас нэг км орчим нэвтэрсэн байв. Ийм хонгилоор цагийн дотор 30,000 цэрэг мөн танк болон цэргийн зориулалтын автомашиныг нэвтрүүлэх боломжтой байв.

Гуравдугаар туннель нь 1978 оны аравдугаар сард Гёнги муж улсын Паван хотод Жандан-Яне хотод нээгдсэн бөгөөд уг туннель нь Сөүлийн ойролцоо бөгөөд 435 метр хүртэл урагшаа чиглэсэн байсан. Уг сувгийн өргөн хоёр метр, өндөр хоёр метр, урт нь 1530 метр том хэмжээтэй байлаа. Гуравдугаар суваг нь Хойд солонгосоос Өмнөд солонгос руу 300,000 цэргийг цагийн дотор нэвтрүүлэх маш аюултай газар доорх суваг байлаа. Энэ суваг нь Панмүнжомоос баруун тийш дөрвөн км-т цэрэггүй бүсэд хилийн зурвасаас 435 метр нэвтэрсэн бөгөөд энэ байршил нь Сөүл рүү орсон зам байсан. Сөүлээс 52 км зайтай бөгөөд автомашинаар 40 минутанд Сөүлд орж ирэх маш ойрхон газар доорх суваг байсан юм.

Дөрөвдүгээр туннель нь 1990 оны гуравдугаар сард Ганвон мужийн Yanggu-gun арлын эрэг дээр байгуулагдсан зэрэг 20 орчим туннелийн гарцыг бий болгож байсан бөгөөд 1974 онд дайны чиглэлээр байгуулсан туннель нь Өмнөд Солонгос Улсын хил рүү нэвтрэн орж дөрвөн км ухсан цагт 30-40 мянган цэрэг зэвсэглэн орох хэмжээний том туннель бөгөөд

тухай үеийн цэргийн удирдагч нь Ким Илсон байсан[19].

Зураг 7. Бүгд Найрамдах Солонгос Ардчилсан Бүгд Найрамдах Солонгос Улсыг дайран довтлох зорилго бүхий туннелийн схем зураг





Эх сурвалж: "http://korea318.com/client/board/view.asp?sEtpnum

Газрын хэвлийн хилийг зөрчиж болзошгүй нөхцөл байдал: Манай улсад голчлон хууль бусаар газрын хэвлийг ашиглах, газрын хөрсийг гэмтээх хэргүүд өсөн нэмэгдэх хандлагатай байна. Хүн амын амьжиргааны түвшин доройтохын хэрээр байгаль дэлхийн нөөц баялаг руу халддаг зүй бус үзэгдэл газар авч байгаа ч газрын хэвлийн хилийг байгалийн баялаг ашиглах зорилгоор зөрчсөн үйлдэл гараагүй байна.

Хэдийгээр манай улсын газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар баримтлах үндэсний бодлого, хөтөлбөрүүдийг батлан гаргаж хэрэгжүүлж эхэлсэн гэх боловч бодит амьдрал дээр төдийлөн өөрчлөлт гарахгүй байна. Тухайлбал, 1997 онд төрөөс экологийн талаар баримтлах бодлого", 2002 онд "Байгалийн нөхөн сэргээлт боловсронгуй болох хөтөлбөр" "экологийн боловсролын үндэсний хөтөлбөр" 2004 онд "Газрын хэвлий зөв зохистой ашиглах хөтөлбөр" зэргийг батлан хэрэгжүүлж байгааг дурдаж болно. Хамгийн сүүлд л гэхэд 2006 оны арванхоёрдугаар сард Монгол, Германы техникийн хамтын ажиллагааны хүрээнд уул уурхайн салбарт байгаль орчныг хамгаалах төсөл 2015 оноос хэрэгжиж эхэлсэн билээ. Уг төсөлд газрын хэвлий түүний нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг сайжруулах, техник хангамжийг нэмэгдүүлэх, хяналтын тогтолцоог сайжруулах зэрэг ажлыг зохион байгуулж байна.

Сүүлийн үед хилийн зурваст байгалийн баялагтай холбогдуулан ихээхэн хэмжээний газар нутагт лиценз олгосон нь цаашид газрын хэвлийн хилийг зөрчин байгалийн баялгийг нууцаар боловсруулах, хулгайлах, гаргаж авсан эрдэс, түүхий эдийг хууль бусаар ашиглах, газрыг эвдэх, хөрсийг гэмтээх, экологийн аюултай хог хаягдал авчирч булах,

[19] Солонгос улсын түүх "http://korea318.com/client/board/view.asp?sEtpnum"

газрын гүнд аюултай техник, технологийг ашиглах их хэмжээгээр үйлдвэрлэл явуулах зэрэг үйлдлүүд гарах хандлагатай байна.

Дүгнэлт, санал

1.Монгол Улс нь нүүдэлчдийн анхны төр улс Хүннү улсын нутаг дэвсгэрээс эхлэн газар нутаг, хил хязгаарын бүрэн бүтэн байдлын төлөө тэмцэж, өнөөдрийн Монгол Улсын газар нутаг, хил хязгаарыг тогтоон олон улсад баталгаажуулсан бөгөөд нийгэм, эдийн засаг хурдацтай хөгжихийн хэрээр газрын хэвлийд байгаа байгалийн баялгийг ашиглах нь ихэсч байна. Үүнтэй зэрэгцэн газрын хэвлийн хилийн асуудал хөндөгдөж, хэвлийн гүнийг ямар байх, хэр хэмжээтэй байх нь олон улсын хэмжээний ойлголтод одоог хүртэл хүрээгүй байна.

2.Монгол Улс нь 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиудад газрын харилцаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг хууль тогтоомжид тусгайлан заасан бөгөөд нийгэм, эдийн засаг хурдтай хөгжихийн зэрэгцээ хууль тогтоомжийн заалт суларч, шинийг илэрхийлэх болсон бөгөөд газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын ажлын хэсэг уул уурхайн яамны стратегийн бодлого төлөвлөлтийн газраас томилогдон ажиллаж байгаатай холбогдуулан газрын хэвлийн хилийн талаарх холбогдох заалтуудыг судлан тусгах шаардлага гарч байна.

3.Газрын хэвлийн хил нь хуурай газрын болон усан хилийн шугамаас эгц доош орших бөгөөд түүний гүний хэмжээг тогтоосон олон улсын эрх зүйн баримт бичиг гараагүй. Монголчуудын хил хязгаарын тухай уламжлалт мэдлэг, ойлголт, нэр томёо байсан ба түүнийг хэрэглэж баримталж ирсээр одоог хүрсэн байна.

4.Хилийн тухай хуулийн 1 дүгээр бүлгийн 4.1 дүгээр заалтыг хэрэгжүүлэх зорилгоор газрын хэвлийг хамгаалах, түүнд тавих хяналт, тандалтыг зохих түвшинд явуулах шаардлага зүй ёсоор гарч байна.

5.Монгол Улсын Хилийн тухай хуулийн 22.1.3-т “Улсын хилийг газрын хэвлийгээр нэвтэрсэн” гэсэн заалт байгаа ч газрын хэвлийн хилийг зөрчсөн тохиолдолд түүнийг шийдвэрлэх талаар эрх зүйн зохицуулалт байхгүй байгаад дүгнэлт хийж, шийдвэрлэх талаар холбогдох хуульд өөрчлөлт оруулах.

6.Монгол Улсад газрын тос олборлож байгаа компаниуд нь 2500-3000 метрт чөлөөтэй өрөмдөх, өрөмдлөгийн угаас цацраг байдлаар хэд хэдэн цооног өрөмдлөг хийх хүчин чадал бүхий техник хэрэгсэлтэй байгаа нь газрын хэвлийн хилийг зөрчиж газар доорх баялгийг татан авч байх магадлал өндөр байна.

7.Монгол Улсын хилийн зурвас, хоёр улсын хил дамнасан байгалийн баялаг олборлох уул уурхай, ашигт малтмалын үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд газрын доор далд малталт, тунель байгуулан ашгийн төлөө газрын хэвлийн хилийг зөрчих магадлал гарч болзошгүй байна.

8.Бусад орнуудын баримт болон бодит үйлдлүүдээс харахад түүхэн он жилүүдэд газрын хэвлийн хилийг дайн байлдааны зориулалтаар, мөн хууль бус наймаа хийх зорилгоор газар доор туннель байгуулан хэвлийн хилийг зөрчих асуудал гардаг нь цаашид анхаарах асуудал гэж үзэж байна.

9.Дэлхийн хөгжингүй улс орон хөрш хөгжил буурай, хил хязгаарын хамгаалалт сул бүс нутагт газрын хэвлийн хил зөрчин туннель байгуулж химийн хорт бодис түүнтэй нийцүүлсэн химийн хаягдал зэргийг хаях, булах асуудал гарах магадлал өндөр байна.

10.Хил залгаа улстай шинээр байгуулах хилийн дэглэмийн гэрээнд газрын хэвлий асуудлыг тусгайлан хэлэлцэж тусгах.

11.Газрын хэвлийн тухай хуулийн шинэчлэсэн найруулгын ажлын хэсэгт ХХБ-аас комисс томилон хамтран ажиллуулах /хуулийг шинэчлэх тохиолдолд газрын хэвлийн хилийн талаар холбогдох заалтуудыг судлан тусгах/.

12.Хил хамгаалах байгууллагаас мэргэжлийн байгууллагатай хамтран ажлын хэсэг томилон хилийн зурваст олборлолт явуулж байгаа хэсгүүдэд газрын гүний тандалт зохион байгуулж, шалгах.

13.Газрын хэвлийн хилийг зөрчигдөж байгаа үйлдлийг илрүүлэх шинэ техник, технологийг Хил хамгаалах байгууллагад нэвтрүүлэх.

14.Хилийн тухай хуулийн 4.1 дүгээр заалтыг хэрэгжүүлэх, газрын хэвлийн хилийг хамгаалах, хяналт тавих, тандалт хийх зорилгоор Өмнөд, Хойд хилийн газрын хэвлийн хил хариуцсан шинэ орон тоо гаргах мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, /геологи, геофизикийн мэргэжлийн сургууль төгссөн байх/.

15.Газрын хэвлийн хилийн тухай хил судлалын ухааны судалгаа, шинжилгээний чиглэлийг бий болгож, гүнзгийрүүлэн судлах зүй ёсны шаардлага гарч байна.

16.Шинээр боловсруулагдаж байгаа хил хамгаалалтын дүрэмд газрын хэвлийн хилийг хамгаалах, хяналт тавих талаар холбогдох заалтуудыг тусган оруулах.

17.Улсын хил, түүний бүрэлдэхүүн хэсэг /агаар, газар, ус, газрын хэвлий/-ийн хилийг цогц байдлаар судлах, улс орны хэмжээнд улсын хил хамгаалалтын бодлого үйл ажиллагааг чиглүүлсэн нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, хуулиар хүлээсэн эрх бүхий байгууллагуудын харилцан хамаарал, үйл ажиллагааг сайжруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Ашигласан эх сурвалж

Нэг. Хууль болон эрх зүйн актын эмхтгэл:

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992 он
2. Монгол Улсын Хилийн тухай хууль. УБ., 2016 он
3. Монгол Улсын газрын хэвлийн тухай хууль. УБ., 1988 он
4. Ашигт малтмалын тухай хууль. УБ., 2006 он
5. Газрын тухай хууль. УБ., 2002 он
6. Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. УБ., 2017 он
7. Монгол Улсын Иргэнд газар өмчлүүлэх тухай хууль. УБ., 2002 он
8. Монгол Улсын Эрүүгийн хууль. /Төрийн мэдээлэл. 2002. №6.
9. Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хууль. /Төрийн мэдээлэл. 2003. №2.
10. Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль. УБ., 1994 он
11. Монгол Улсын Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль. УБ., 2004 он
12. Төрийн мэдээлэл. 2016. № 12
13. Төрийн мэдээлэл. 2015. № 9

Хоёр. Онолын сурах бичиг, гарын авлага:

14. Б.Лувсанданзан. “Геологийн үндсүүд”., УБ., 2011 он
15. З.Болдбаатар, Т.Намсрай, А.Сүхбаатар. “Геополитикийн үндэс”. УБ., 2010 он
16. Н.Наранжамц “Бүс нутаг-Хил хамгаалалтын үзэл баримтлал”. УБ., 2012 он
17. Ч.Дашдэлэг. “Хилийн асуудлууд”. УБ., 2008 он
18. Г.Төртогтох. “Улсын хилийн аюулгүй байдал”. УБ., 2004 он
19. А.Сүхбаатар “Аюулгүй байдал, батлан хамгаалах, цэргийн стратеги, гадаад, дотоод бодлогын үндсэн асуудал”. УБ., 2014 он
20. А.Сүхбаатар. “Олон улсын эрх зүй ба дайн. УБ., 2009 он
21. Б.Цэдэн-Иш. “Монгол Улсын хил бүрэлдэн тогтсон түүхээс”. УБ., 1997 он
22. Ш.Арвай. “Улсын хилийн тухай /Дурсамж, үзэл бодол/. УБ.,2005 он
23. Б.Цэдэн-Иш. “Монгол Улсын хил бүрэлдэн тогтсон түүхээс”. УБ., 1997 он
24. Ж.Баясах. “Хятадын товч түүх” УБ., 2002 он
25. Монголын түүх.I боть 83 тал
26. А.Сүхбаатар, З.Болдбаатар. “Эртний улсуудын гадаад бодлого, орчин цагийн олон улсын аюулгүй байдал”.

27. УАДЭХ цэргийн байлдааны жижүүрлэлтийн заавар. УБ.,1974 он
28. Зэвсэгт хүчний АДХЦ-ийн байлдааны жижүүрлэлтийн нэгдсэн дүн. УБ, 2014 он
29. Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэргийн заавар УБ.,1974 он
30. Агаарын довтолгооноос хамгаалах цэрэг УБ., /БХЭШХ/ 2004 он
31. Д.Лхагважамц Агаар тэнгис сансарын операци УБ., 2013 он
32. Агаараас эсэргүйцэх хамгаалалт УБ., 1977 он
33. Т.Балжинням. Монгол орны газарзүй. УБ., 2009 он

Гурав. Эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл:

34. Н.Наранжамц “Хил судлал сэтгүүл”., УБ., 2019 он. 16 дахь тал
35. Ц.Одбаяр. “Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэлтгэл.УБ.,2018. 157 дах тал
36. Монгол-Орсын харилцаа. ШУА-ийн ОУСХ, 2005.
37. Н.Наранжамц “Хил судлал сэтгүүл”., УБ., 2019 он. 11 12 дахь тал
38. Ж.Өвгөнбүргэд “Хил судлал сэтгүүл”., УБ., 2019 он. 20 22 дахь тал
39. О.Үржин “Хил судлал сэтгүүл”., УБ., 2019 он. 34 35 37 дахь тал

Цахим эх сурвалж

40. БНХАУ-ын 8 дугаар хуралдааны тус улсын Ардын төлөөлөгчдийн их хурлын 5 дугаар хурадаааанаас 1997 оны 03 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан БНХАУ-ын эрүүгийн хуулийн 17 дугаар зүйл.
41. 1996 оны 06 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан ОХУ-ын Эрүүгийн хуулийн 4 дүгээр бүлэг, 20 дугаар зүйл. Уголовный кодекс РФ (УК РФ)от.
42. http://bpo.gov.mn/frontier/101/1206270003/detail
43. http://baavar.mn/t/afrik-iin
44. http://korea318.com/client/board/view.asp?sEtpnum
45. https://ko.m.wikipedia.org/wiki/
46. https://www.youtube.com

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ИРГЭДИЙН ТӨСӨӨЛӨЛ

CIVILIAN PRESPECTIVE ON THE ACTIVITIES OF THE ORGANIZATION RESPONSIBLE FOR THE EXECUTION OF COURT DECISIONS

Б.Алтангэрэл
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрхлэгч, хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор, хурандаа
Altangerel.B
Head of the Center for decision execution studies, University of Internal Affers, doctor of law (Ph.D) professor, colonel

Хураангуй: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн ойлголт, төсөөлөл болон шүүхээс гарсан шийдвэрийн хэрэгжилтэд өгч буй үнэлгээний талаар судалхыг зорисон болно.

Abstract: The aim is to study the perceptions and perceptions of citizens about the activities of the Judicial Decision Enforcement Agency and their assessment of the implementation of court decisions.

Түлхүүр үгс: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, шүүхийн шийдвэр, хорих байгууллага, хоригдол, ялтан, төлбөр төлөгч, авагч

Keywords: Enforcement agencies, court decisions, prisons, prisoners, convicts, payers and recipients

Удиртгал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хуулиар хүлээсэн олон талт чиг үүрэг, түүний үр дүнгийн талаар иргэд төдийлөн ойлголт, мэдээлэл багатай байдаг билээ. Нийгмийн амьдралд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын талаар төлбөр төлөгч, төлбөр авагч, ялтан, хоригдол болон тэдний хамаарал бүхий хүмүүс л тодорхой хэмжээний мэдээлэлтэй байдаг гэсэн ойлголт олон жил байсаар ирсэн.

Энэхүү өгүүллийн хүрээнд энэхүү байгууллагын үйл ажиллагааны талаар дээр дурдсан хамааралгүй иргэдээс ямар мэдээлэлтэй байдаг, тус байгууллагын олон нийтэд чиглэсэн мэдээллийн эх сурвалжийн чанар, хүртээмжийн талаар судлахыг зорьсон болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 257.1-д Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага мөн гэжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дараахь ажиллагаа хамаарна:

1.иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа;

2.захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа;

3.зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа;

4.эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа зэрэг болно.

Дээрхээс харахад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Монгол Улсын хэмжээнд шүүхээс гарч буй бүхий л төрлийн шийдвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэх үүрэг бүхий төрийн тусгайлсан чиг үүрэг байгууллага байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь аймаг, нийслэл, зарим томоохон сумдад шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих байгууллагын нэгжээрээ дамжуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хуулиар тогтоосон чиг үүргийн хэрэгжилтийг хөндлөнгийн байр сууринаас үнэлэх, үнэлгээний үр дүнд суурилан үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулах санал, зөвлөмж боловсруулах зорилгоор 2017 онд “Жи Би Эм” ТББ, 2018 онд “Мянганы өглөө” ТББ, 2019 онд “Ажиглалт” ТББ, 2020 онд Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн судлаачдаар тус тус хэрэглэгчийн үнэлгээ хийлгэж, үр дүнг байгууллагын үйлчилгээ, үйл ажиллагаанд тодорхой түвшинд тусгаж иржээ.

Энэхүү судалгааны ажлыг хийхэд анкетын, ярилцлагын болон харьцуулалтын аргыг ашигласан бөгөөд ШШГЕГ-ын олон нийттэй харилцах сурталчлах чиглэлээр хийгдсэн тайлан мэдээг ашигласан болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын цахим сайт, түүний хандалт:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын www.cd.gov.mn цахим сайтад 2015-2020 оны байдлаар нийт 874, фейсбүүк хуудаст 775, дотоод мэдээллийн самбарт 542 удаа тус тус мэдээ, мэдээлэл байршуулан ажиллажээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын www.cd.gov.mn цахим сайтад иргэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын талаар мэдээлэл авах боломжид судалгаа хийж үзэхэд:

Хүснэгт 1. ШШГБ-ын талаар мэдээлэл авах боломжийн судалгаа

д/д	Огноо	Нийт хандалтын тоо	Нэг өдрийн хандалтын тоо /дунджаар/
1	2016	250213	686
2	2017	235021	644
3	2018	276504	758

4	2019	265048	726
5	2020.05.25	103427	713

Хэдийгээр цахим сангийн хандалтын тоо их мэт боловч байгууллагын алба хаагчдаас ихэвчлэн ханддаг байдал байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн өгсөн үнэлгээ:

Судалгааны ажлын хүрээнд 21 аймаг тус бүрээс 100 иргэн, Улаанбаатар хотоос 200 иргэн нийт 2300 хүнээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн төсөөлөл, үнэлгээний талаарх судалгаа авлаа.

Дээрх судалгаанд оролцсон иргэдийн асуултад хариулсан байдал, үнэлгээг асуулт тус бүрээр нь судлан авч үзье.

1.“Та шүүхээс гарсан шийдвэрийн хэрэгжилт ямар түвшинд хэрэгждэг гэж үздэг вэ” гэсэн асуултад 785 буюу 34% нь сайн хэрэгждэг, 951 буюу 41% нь дунд зэрэг хэрэгждэг, 406 буюу 18% нь муу хэрэгждэг, 158 буюу 7% нь огт хэрэгждэггүй гэж хариулжээ.



Судалгааны дүнгээс харахад 659 буюу 66% нь дунд ба түүнээс доогуур хэрэгждэг гэсэн үнэлгээ өгсөн нь иргэд шүүхийн шийдвэрийн хэрэгжилтэд сэтгэл хангалуун бус байгааг харуулж байна.

2. “Та шүүхийн шийдвэрийг хэрэгжилтийг нэмэгдүүлэхэд юун дээр анхаарах нь зүйтэй гэж үздэг вэ” гэсэн асуултад 734 буюу 32% нь шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх, 632 буюу 28% нь хууль, эрх зүйн орчныг сайжруулах, 305 буюу 13% нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, 376 буюу 16% нь иргэдийн эрх зүйн ухамсрыг дээшлүүлэх, 253 буюу 11% нь шүүхээс гарч буй шийдвэр нь бодитой, хэрэгжих боломжтой байх гэж хариулжээ.



3. “Та Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар үйлчлүүлж байсан уу” гэсэн асуултад 1220 буюу 53% нь тийм, 1080 буюу 47% нь үгүй гэж хариулжээ.

Энэ нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч болоогүй тохиолдолд тус байгууллагаар үйлчлүүлэх нь хязгаарлагдмал байгааг харуулж байна.

4. “Та Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын иргэдэд үзүүлж буй үйлчилгээг хэрхэн үнэлж байна вэ” гэсэн асуултад 1021 буюу 45% нь сайн, 1011 буюу 44% нь дунд, 258 буюу 11% муу гэж хариулжээ.



5. “Та Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын талаар ямар төсөөлөлтэй вэ” гэсэн асуултад 559 буюу 24% нь хорих байгууллага, 551 буюу 24% нь өр төлбөр барагдуулдаг байгууллага, 950 буюу 41% нь шүүхээс гаргасан шийдвэрийг гүйцэтгэдэг байгууллага, 250 буюу 11% нь сайн мэдэхгүй гэж хариулжээ.



6. “Та хорих ангид ял эдэлж буй хоригдол нийгэмшиж буй байдлыг хэрхэн үнэлдэг вэ” гэсэн асуултад 853 буюу 37% нь сайн нийгэмшиж, хүмүүждэг, 1102 буюу 48% нь дунд зэрэг, 345 буюу 15% нь огт нийгэмшиж, хүмүүжихгүй байна гэж хариулжээ.



7. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас төлбөр, хохирол барагдуулж буй үйл явцыг та хэрхэн үнэлэх вэ” гэсэн асуултад 815 буюу 36% нь сайн, 1180 буюу 51% нь дунд, 305 буюу 13% нь муу гэж хариулжээ.



8. “Хорих байгууллагад хүний эрхийг хэрхэн хангадаг гэж та боддог вэ” гэсэн асуултад 1017 буюу 44% нь сайн, 980 буюу 43% нь дунд, 303 буюу 13% нь муу гэж хариулжээ.

9. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын талаарх мэдээллийг та мэдээллийн аль эх сурвалжаас авдаг вэ” гэсэн асуултад 637 буюу 28% нь телевизийн мэдээ, 305 буюу 13% нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын вебсайт, 291 буюу 13% нь facebook, 325 буюу 14% нь



интернет орчин, 230 буюу 10% нь сонин, хэвлэл, 395 буюу 17% нь хүмүүсийн яриа, 117 буюу 5% нь мэдэхгүй гэж хариулжээ.



10. “Шүүхээс гарсан шийдвэр нь бүрэн биелэгдсэнээр ямар ач холбогдолтой гэж та үзэж байна вэ” гэсэн асуултад 477 буюу 21% нь хүний зөрчигдсөн эрх сэргээгдэнэ, 370 буюу 16% нь гэм буруутай хүнийг цээрлүүлнэ, 736 буюу 32% нь хохирсон хүн хохирлоо барагдуулна, 449 буюу 19% нь нийгэмд шударга ёс тогтоно, 268 буюу 12% нь мэдэхгүй гэж хариулжээ.



11. “Танд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл авах боломж хэр зэрэг байдаг гэж боддог вэ” гэсэн асуултад 650 буюу 28% нь сайн, 1036 буюу 45% нь дунд, 328 буюу 14% нь муу, 286 буюу 13% нь мэдэхгүй гэж хариулжээ.



Дүгнэлт, санал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн ойлголт, үйл ажиллагаанд өгч буй үнэлгээний талаарх судалгааны дүнд дүгнэлт хийж үзвэл, тус байгууллага нь хэдийгээр олон нийтэд сурталчлах ажлыг явуулж буй хэдий ч хүртээмж муутайгаас үндсэн үйл ажиллагаа, чиглэл, үр дүнгийн талаарх мэдээлэл багатай байна. Иймд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн мэдээллийг сайжруулах хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна.

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх бүхий л төрлийн ажиллагаанд, тухайлан ял эдлүүлэх, нийгэмшүүлэхэд төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага өөрийн үйл ажиллагаагаа сурталчилсан телевизийн нэвтрүүлэг, контент бэлдэх зэрэг болно.

ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ АЛБАДАН СУРГАЛТЫН ҮР НӨЛӨӨНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ /*Судалгааны тайлангаас*/

ANALYSIS ON THE EFFECTS OF BEHAVIOR INFLUENCING COMPULSORY COURSES /*From the research report*/

А.Жаргалзаяа
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, ахмад
Jargalzaya.A
Captain, Researcher, Center of Court Decision Enforcement Studies, Integrated Research Institute, University of Internal Affairs

Хураагуй: Баривчлах шийтгэл эдлэж буй этгээдүүдийн дунд зохион байгуулах зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр дүнд шинжилгээ хийж, практикт тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн санал гаргах

Abstract: Analyze the outcomes of behavior influencing compulsory courses for detainees, identify practical challenges, and submit a proposal to improve (enhance) its effect.

Түлхүүр үгс: Баривчлах шийтгэл, Зан үйл, Баривчлах төв, Албадлагын арга хэмжээ, Албадан сургалт

Key words: Punishment of Arrest, Behavior, Arrest Center, Coercive Measures, Compulsory courses

Үндсэн хэсэг

Ял шийтгэлийн зорилгыг өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуульд Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино, Зөрчлийн тухай хуульд Шийтгэлийн зорилго нь хүн, хуулийн этгээдийг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, зөрчил үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх, шударга ёсыг тогтооход оршино гэж хуульчилсан байна.

Зөрчлийн тухай хуулийн 4.5 дугаар зүйлд шүүх баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэн хүнд албадан сургалтад хамруулах албадлагын арга хэмжээг хэрэглэх ба албадан сургалтыг баривчлах шийтгэлийг эдэлж байх хугацаанд эрх бүхий байгууллагаас албадан сургалт арван цагаас тавин цагийн хугацаатайгаар зохион байгуулна.

Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 189.2д зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан хүнд шийдвэр гүйцэтгэгч зан үйлд нөлөөлөх

сургалтын агуулга, хөтөлбөрийг танилцуулан сургалтыг зохион байгуулна гэж тус тус заасан байна.

Баривчлах шийтгэл эдлүүлэх ажиллагааны үндсэн онцлог нь баривчлах байр, төв буюу баривчлагдсан этгээдийн дунд явуулах нийгэмшүүлэх ажил нь зан үйлд нөлөөлөх сургалт болон сэтгэл зүйн үйлчилгээ гэсэн үндсэн чиглэлийн хүрээнд явагдана.

Баривчлах байрны дотоод журамд зааснаар баривчлах төв /байр/ нь сургалтын танхимтай байх бөгөөд шүүх баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэн хүнд албадан сургалтад хамруулах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно. Албадан сургалтыг баривчлах шийтгэлийг эдэлж байх хугацаанд эрх бүхий байгууллага хэрэгжүүлдэг бөгөөд 10-15 цагийн хугацаатай байна. Баривчлах байр нь баривчлагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулна[1].

ШШГЕГ-ын харьяа Баривчлах төв Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн А/73 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр”, “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам”-ын хүрээнд баривчлах байранд албадан сургалтыг зохион байгуулж байна.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулах эрх зүйн үндэслэл нь дараах хууль тогтоомж, эрх зүйн актын хүрээнд зохицуулагдаж байна. Үүнд:

1. Зөрчлийн тухай хууль[2] /4.5 дугаар зүйл. Албадан сургалт/

2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль[3] /44 дүгээр зүйл. Зан үйлд нөлөөлөх сургалт/

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль[4] /189 дүгээр зүйл. Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, 222 дугаар зүйл. Хорих анги дахь албадан сургалт/

4. Хууль зүй, дотоод хэргийн сайд /ХЗДХС/-ын 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/73 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр”, “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам”

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар /ШШГЕГ/-ын даргын 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/103 дугаар тушаалаар баталсан “Зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулах журам” зэрэг болно.

Улсын хэмжээнд зан үйлээ засах сургалтад хамрагдах үүрэг

[1] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 147 дугаар зүйлийн 147.5
[2] 2017 оны 05 дугаар сарын 11-ны өдөр батлагдсан
[3] 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан
[4] 2017 оны 06 дугаар сарын 09-ны өдөр батлагдсан

хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан 2018 оны үлдэгдэл 426 этгээд 2019 онд шинээр 704 этгээдийг шүүхээс хүлээн авч, нийт 1130 этгээд бүртгэл хяналтад орсноос нас барсан 7, дахин гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн 18, эрэн сурвалжилж байгаа 2, бусад үндэслэлээр 3 хасагдаж, зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамрагдвал зохих 1100 этгээд байгаагаас 776 нь насанд хүрсэн, 324 нь өсвөр насны этгээд байна.

Зан үйлд нөлөөлөх сургалт явуулах эрх бүхий эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч, хорих ангийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд эрх зүйн, харилцааны чиглэлээр 146 удаагийн 297 цагийн сургалтыг зохион байгуулан ажилласан байна. Мөн хорих ангиас 2191 хоригдол шүүгчийн захирамжаар хугацаанаас өмнө суллагдаж, хяналтад орсон ба үүнээс 91 хоригдолд зан үйл засах албадан сургалтад хамруулах шийдвэр гарчээ. Уг шийдвэрийн хүрээнд эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нар бүртгэл хяналтад авч сургалтыг зохих журмын дагуу зохион байгуулан ажилласан байна.

График №1 2019 оны байдлаар зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийн судалгаа



Зан үйл засах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд зохион байгуулах сургалтыг

-Нийслэлд дүүргүүдийн цагдаа, прокурорын газар, хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн төв, сэтгэцийн эрүүл мэндийн төв, албан бус насан туршийн боловсролын төв зэрэг төрийн байгууллагатай, “Шалом төв”,

“Эрчүүдийн гэр бүл хөгжлийн төв”, “Монгол халамж”, “Талын Монголын цуурай, увдис”, “Монгол өрх”, “Амжилтын аваргууд” зэрэг төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулдаг бөгөөд 2019 онд 18 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 2076 этгээдийг;

-Хорих ангитай шийдвэр гүйцэтгэх газруудад тус ангийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар сургалтыг явуулахаас гадна сургалт явуулах эрх бүхий эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах бөгөөд 2019 онд давхардсан тоогоор 1280 этгээдийг;

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсүүд сургалт явуулах эрх бүхий эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч болон орон нутгийн хууль хяналтын байгууллага, хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн төв, насан туршийн боловсролын төвийн багш, алба хаагчдыг урьж давхардсан тоогоор 1552 этгээдийг сургалтад хамруулсан байна.

Баривчлах төвөөс “Эрчүүд, гэр бүл хөгжлийн нийгэмлэг”, “Ивээлийн үйлчлэл”, “Help International”, “Өөрчлөлтийн хөтөч, донтолтоос эдгээх сургалт зөвлөгөөний институт”, “Хорихын үйлчлэлийн нэгдсэн төв” зэрэг төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааны гэрээг шинэчлэн байгуулж, 2019 оны жилийн эцсийн байдлаар сэтгэл зүйч, нийгмийн ажилтан нар танхимын сургалтаар 6892 баривчлагдсан этгээдэд 13784 цаг, ганцаарчилсан сургалтаар 302 этгээдэд 302 цаг, бие даалтаар 41153 цаг, хөгжим /зарлан мэдээлэх систем/ ашиглан 75804 цагийн сургалтыг, төрийн болон төрийн бус байгууллагын сургагч багш нар 4985 баривчлагдсан этгээдэд 9970 цагийн танхимын сургалтыг зохион явуулж тэдэнд гарын авлага, материал тарааж сургалтыг үр дүнтэй зохион байгуулсан байна.

7729 баривчлагдсан этгээдийн шүүхээс оногдуулсан албадан сургалтад хамруулах хугацааг /дунджаар/ 20 цагаар тооцоход 154,580 цагийн албадан сургалтыг зохион байгуулах тооцоолол гарч байгаа ба тайлангийн хугацаанд сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, төрийн болон төрийн бус байгууллагаас 220,212 цагийн албадан сургалтыг ганцаарчилсан болон бүлгээр зохион байгуулсан нь гүйцэтгэлээ 42 хувиар давуулан биелүүлсэн үзүүлэлт харагдаж байна.

Улсын хэмжээнд зан үйл нөлөөлөх сургалтад хамрагдвал зохих 1100 этгээдийг сургалтад хамруулсан байгаа бол хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан оны үлдэгдэл 230 этгээд, 2019 онд шинээр 406 этгээдийг шүүхээс хүлээн авч нийт 636 этгээд бүртгэл хяналтад орсноос нас барсан 4, дахин гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн 13, эрэн сурвалжилж байгаа 2, бусад үндэслэлээр 1 хасагдаж, тайлангийн хугацаанд хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдвал зохих насанд хүрсэн 415, өсвөр насны 201 нийт

616 этгээд байгаагаас 382 этгээдийг 20 гаруй төрлийн мэргэжлээр хөдөлмөрлөх дадал чадвар эзэмшүүлэн шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлж, 109 этгээд мэргэжлийн сургалтад хамрагдаж байгаа бол 125 этгээд сургалтад хамрагдаагүй байна. Мөн зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулах эрх бүхий эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч, хорих ангийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран тус этгээдүүдэд эрх зүйн болон харилцааны чиглэлээр 146 удаагийн 297 цагийн сургалтыг зохион байгуулсан байна.

2020 оны эхний хагас жилд шүүхээс зан үйлээ засах сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэсэн 961 этгээд үүнээс насанд хүрсэн 695, өсвөр насны 266 этгээдэд сургалт зохион байгуулахаас тайлангийн хугацаанд насанд хүрсэн 360 этгээд, өсвөр насны 142 этгээдийг сургалтад хамруулсан ба бусад этгээдүүдийн хувьд цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж сургалтыг түр хугацаагаар хойшлуулах тухай шийдвэрийн хүрээнд сургалт зохион байгуулаагүй. 459 этгээдийг сургалтад хамруулаагүй байна.

График №2 2020 оны эхний хагас жилд зан үйлээ засах сургалтад хамрагдсан этгээдүүдийн судалгаа



2020 оны эхний хагас жилд Зөрчлийн тухай хуулийн баривчлах шийтгэл оногдуулах 9 зөрчилд холбогдон Нийслэлийн 9 дүүргийн шүүхээс 7-30 хоногийн баривчлах, 10-15 цагийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулахаар нийт 4689 этгээд баривчлагдсанаас эрэгтэй 4475, эмэгтэй 192, насанд хүрээгүй хүүхэд 22, гадаад улсын харьяат 3 иргэн /БНХАУ, ӨМӨЗО, ОХУ/ байна. Баривчлагдсан этгээдүүдийг холбогдох хууль, журмын дагуу хүлээн авч нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид ганцаарчлан уулзаж, Эрүүгийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Баривчлах байрны дотоод журам, зааврыг танилцуулан, сургалтыг

батлагдсан төлөвлөгөөний дагуу гаргасан зөрчилд нь тохируулан ганцаарчилсан болон танхимын, зарлан мэдээллэх систем ашиглан зохион байгуулсан. Үүнд:

-Зөрчлийн тухай хуулийн 5.1.3 дахь заалт буюу мансуурах зөрчил гаргасан 72 этгээдэд 35 удаа 62 цагийн;

-Зөрчлийн тухай хуулийн 5.2.1 дэх заалт буюу танхайрах зөрчил гаргасан 278 этгээдэд 46 удаа 88 цагийн;

-Зөрчлийн тухай хуулийн 5.4.4 дэх заалт буюу гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 3396 этгээдэд 217 удаа 199 цагийн;

-Зөрчлийн тухай хуулийн 8.6.1 дэх заалт буюу хулгайлах зөрчил гаргасан 338 этгээдэд 59 удаа 112 цагийн;

- Зөрчлийн тухай хуулийн 14.7.5 дахь заалт буюу согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил гаргасан 600 этгээдэд 45 удаа 84 цагийн ганцаарчилсан болон танхимын, нийт 402 удаа 545 цагийн сургалтыг;

-Мөн Зөрчлийн тухай хуулийн 6.26.1 дэх заалт буюу бэлгийн дарамт учруулах зөрчил гаргасан 2 этгээд 5.13.2 дахь заалт буюу гамшгаас хамгаалах тухай хууль зөрчсөн 1 этгээдэд ганцаарчилсан сургалтыг 7 хоногт 3 удаа;

-Зарлан мэдээллэх систем ашиглан 7 хоногт 3 удаа 15-18 цагаар сургалт тус тус зохион байгуулсан байна.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын чанар, үр нөлөөг тодорхойлох зорилгоор дараах судалгаануудыг авсан. Энэ нь:

1. Хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн зан үйлд нөлөөлөх сургалтыг хэрэгжүүлж буй 61 алба хаагчаас эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт, үр дүн, сайжруулах шаардлагын талаар санал асуулга[5] авахад зан үйлд нөлөөлөх сургалтын эрх зүйн орчинг сайжруулах шаардлага байна гэсэн дүгнэлтэд хүрсэн.

2. Төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог тодорхойлох судалгааг[6] хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан 60 шийдвэр гүйцэтгэгчээс авч, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд дан ганц шийдвэр гүйцэтгэгч бус мэргэжлийн байгууллага, албан хаагч /сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, багш, цагдаа/, иргэдийн оролцоо маш чухал байна. Мөн нөгөөтэйгүүр эрүүгийн ял, хариуцлага нь гэмт хэрэг үйлдэж албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийг нийгэмшүүлж, засрал хүмүүжлийг олгож, өөрийн гэсэн мэргэжил мэдлэгтэй болоход нь туслах зорилгыг агуулж байгаа бол түүний эргэн тойронд байгаа хүмүүсийн

[5] “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөнд хийсэн шинжилгээ” судалгааны тайлан.УБ.,2020.88-89 дэх тал.

[6] “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөнд хийсэн шинжилгээ” судалгааны тайлан.УБ.,2020.107-111 дэх тал.

харилцаа хандлага, олон нийтийн оролцоог маш нарийн хууль журмаараа зохицуулж өгөх ёстой. Энэ ажилд оролцож байгаа иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагыг хэрхэн урамшуулах, тэдэнд эрхэлж буй ажил, албанд нь ямар хөнгөлөлт эдлүүлэх зэргийг хууль, журамд тодорхой тусгах нь зүйтэй гэсэн дүгнэлтийг хийсэн.

3. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөө, хэрхэн зохион байгуулах, сайжруулах арга замын талаар 452 баривчлагдсан этгээд, 61 алба хаагчаас авсан судалгааны[7] үр дүнд зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр дүн хангалтгүй байна. Иймд хөтөлбөр, удирдамжийг сайжруулах, багшлах хүний нөөцийг чадавхжуулах, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, төсөв, санхүү, удирдлагын дэмжлэгийг нэмэгдүүлэх замаар сайжруулах боломж байна гэсэн дүгнэлтийг гаргасан.

4. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх газрын нийгмийн ажилтан нь зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг зохион байгуулах голлох албан тушаалтан бөгөөд 2015-2020 онд хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд ажилласан мэргэжлийн нийгмийн ажилтны судалгаанаас үзэхэд мэргэжлийн нийгмийн ажилтны тоо төдийлөн хангалттай бус байгаа тул нэмэгдүүлэх шаардлага байсаар байна.

5. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг зохион байгуулахад мэргэшсэн хүний нөөцөөс гадна сургалт явуулах орчин, техник хэрэгслийн хүчин чадал зайлшгүй чухал юм. Хорих анги, шүүхийн шийдвэр газар дахь сургалтын орчныг судлан үзэхэд 21 хорих ангийн 6 хорих анги сургалт явуулах зориулалтын танхимгүй, хоолны заал, бясалгалын танхим, номын сан зэрэгт сургалт зохион байгуулдаг, үлдэх хэсэг нь зориулалтын танхимтай хэдий ч техник, тоног төхөөрөмж хангалтгүй байдаг байна. Иймд сургалтын орчин нөхцөл, техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх шаардлага байна.

Дүгнэлт, санал

Улсын хэмжээнд 2015 онд 13174, 2016 онд 5380, 2017 онд 11345, 2018 онд 10981, 2019 онд 15296, 2020 оны 11 дүгээр 01-ний байдлаар 15620 хүн баривчлагдсан нь шүүхээс баривчлах шийтгэл ногдуулах байдал жил ирэх тусам өсч байгааг харуулж байна. Тэгвэл ШШГЕГ-ын харьяа Баривчлах төвд шүүхээс оногдуулсан баривчлах шийтгэл эдлүүлсэн хүний тоог авч үзвэл 2015 онд 6278, 2016 онд 3031, 2017 онд 5159, 2018 онд 4356, 2019 онд 7815, 2020 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар 5584 этгээд байна.

ШШГЕГ-ын харьяа Баривчлах төв нь 2015-2020 онд Захиргааны хариуцлагын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль,

[7] “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөнд хийсэн шинжилгээ” судалгааны тайлан.УБ.,2020.111-113 дахь тал.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хуулиудад заасан зөрчил гарган шүүхээс баривчлах шийтгэл оногдуулсан 32223 этгээдэд 7-30 хоногийн баривчлах шийтгэлийг эдлүүлсэн байна. Эдгээр этгээдүүдэд зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хөтөлбөр, журмын дагуу зохион байгуулж ирсэн

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын чанар, үр нөлөөнд хийсэн судалгааны дүнгээр тус сургалтын үр нөлөө төдийлөн хангалттай бус байгаа бөгөөд эрх зүйн зохицуулалт, хөтөлбөрийг сайжруулах, багшлах хүний нөөцийг нэмэгдүүлэх, чадавхжуулах, сургалтын танхим, материаллаг баазыг сайжруулах, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтын ажиллагаа, төсөв санхүү, удирдлагын дэмжлэгийг нэмэгдүүлэх нь нэн шаардлагатай байна гэсэн дүгнэлтэд хүрсэн.

Үүнээс дараах саналыг дэвшүүлсэн. Энэ нь:

-Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийг эрх зүйн болон сэтгэл зүйн гэсэн жишиг хөтөлбөр болгон боловсруулж, сургалтад ашиглах;

-Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөг сайжруулах чиглэлээр мэргэшсэн сургалтын байгууллага, багш нараар түлхүү заалгах, сургалтын орчин үеийн арга хэлбэрийг ашиглан сургалтын чанарыг сайжруулах зэрэг болно.

ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ХОРИГДЛЫН ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

ПРЕДУПРЕЖДЕНИЕ ОТ СОВЕРШЕНИЕ ПРЕСТУПЛЕНИЯ ЛИЦ, ОТБЫВАЮЩИХ НАКАЗАНИЕ ЛИШЕНИЯ СВОБОДЫ

Ч.Батболд
Дотоод хэргийн их сургуулийн докторант, хошууч
Ч.Батболд
Докторант, университета внутренних дел Монголии, майор

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 267 дугаар зүйлийн 267.2.2 дахь хэсэгт хорих ангийн үндсэн чиг үүргийг *“Хоригдлын аюулгүй байдлыг хангах, тэдний дунд хууль ёс, дэг журмыг сахиулах, хоригдол бусад этгээдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх”* гэж заасны дагуу хорих ял эдлүүлэх явцад үйлдэгдэж буй гэмт явдал буюу олон улсын хэллэгээр “Пенитенциар” гэмт явдлаас урьдчилан сэргийлэх санал, дүгнэлтийг гаргасан болно.

Аннотация: В данном повествовании упоминается что в3 п2 ч2 статья 267 Закона об Исполнении судебных решении указано объязанность органов, испольняющих судебных решении “обеспечить безопасность заключенных и законность, правопорядок среди них, а также предпринимать меры направленно на причинении вреда друг на другом”, поэтому сделал вывод о том что совершение преступления на период отбывании наказании.

Түлхүүр үгс: Хорих ял эдлүүлэх ажиллагаа, чиг үүрэг, Пенитенциар гэмт явдал, үзлэг, нэгжлэг, хориотой эд зүйл, хоригдлын зөрчил, сахилгын шийтгэл.

Ключевые слова: Отбывание наказание, объзанности, пенитенциарное преступление, осмотр, досмотр, запрещённые предметы, правонарушение, взыскание.

Үндсэн хэсэг:

Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь эрүүгийн ялын бодлого, зорилгыг хангахад чиглэх ба эрүүгийн ялын бодлого нь тухайн улс орны хөгжлийн шат дахь нийгэм, эдийн засаг, улс төр, эрх зүйн хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн дэг журмыг хангах, хүний эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалах чиг үүрэг хэрэгжүүлэхэд төрөөс баримталж буй чиглэл бөгөөд төр эрүүгийн ялын бодлогоо эрүүгийн хариуцлагын оновчтой төрөл, тогтолцоог бий болгох, оногдуулах үйл ажиллагааг

боловсронгуй болгох, түүгээр дамжуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зэрэг арга хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлж байдаг[1].

Хорих байгууллага нь хорих ял эдэлж буй хоригдол, цагдан хоригдож буй хоригдогсдын дотроос гэмт хэрэг үйлдэх, нийгэм, иргэдийг гэмт халдлагад өртөхөөс хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага юм. Хорих ял эдлүүлэх явцад хоригдол дахин гэмт хэрэг үйлдэх магадлал өндөр байдаг.

Хорих ял эдлүүлэх явцад үйлдэгдэж буй гэмт явдал буюу олон улсын нэр томьёоллоор “Пенитенциар” гэмт явдал бөгөөд хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад алба хаагч, хоригдол, хоригдогсдын зүгээс холбогдох хууль тогтоомж, хорих ангийн дотоод журам зөрчсөн гэмт хэргүүдийн цогц гэж үзэж болох юм.

Пенитенциар (хорих газар үйлдэгдэх) гэмт явдал гэж эрүүгийн ял эдлүүлэх тогтолцоо, хорих газруудад үйлдэгдэж байгаа гэмт хэргийн цогц гэж ойлгож болно. Криминологийн толь бичгүүдэд “пенитенциар[2] гэмт явдал” гэж “хорих газрын (шоронгийн), өөрөөр хэлбэл үйлдэгдэх газраар тодорхойлогдож байгаа гэмт явдал” гэжээ.

Толь бичиг зохиогчдын үзэж байгаагаар энэ гэмт явдлын онцлог нь пенитенциар тогтолцооны байгууллагын өвөрмөц нөхцөл, хоригдлын нийгмийн онцгой орчноор тодорхойлогдож байгаа юм[3]. Энэхүү гэмт явдал нь хоёр төрлийн субъекттэй. Үүнд:

1. Хорих газар ял эдэлж байгаа хоригдлууд;

2. Эрүүгийн ял эдлүүлэх тогтолцооны байгууллага, албан газрын удирдах ажилтнууд, үйлдвэрлэл-техникийн, эмнэлэг, сурган хүмүүжүүлэх бүрэлдэхүүн, мөн түүнчлэн тухайн байгууллагуудын энгийн ажилтнууд зэрэг субъектийг авч үзнэ.

Мөн доктор (Ph.D) Ц.Очгэрэл бүтээлдээ хорих байгууллагын аюулгүй байдлын төрлийг Монгол Улсын дотоод аюулгүй байдлыг хангахад гүйцэтгэх оролцооны шинжтэй уялдуулан дараах байдлаар ангилжээ. Үүнд:

1. Хорих байгууллагын үйл ажиллагааны аюулгүй байдал;
2. Ажилтан алба хаагчийн аюулгүй байдал.
3. Хоригдогч, ялтан бусад хүмүүсийн аюулгүй байдал;

---

[1] Б.Алтангэрэл. “Хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад үйлдэгдэж буй гэмт хэрэг, түүнийг судлах нь” эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл. 2014 он.

[2] “Пенитенциар”гэсэн нэр томъёо нь латины poenitentia-гэмээ наманчлах гэсэн үгнээс гаралтай; пенитенциар нь (XIXзууны дунд үе) шоронгийн хэв маяг бүхий засан хүмүүжүүлэх байгууллагад хамаарах бөгөөд, ийм байгууллагыг анх засан хүмүүжүүлэх асуудалтай холбоотойгоор байгуулагджээ.

[3] См.: Российская криминологическая энциклопедия/ Под общ.ред.А.И.Долговой. М., 2000. С.596.

- Бусад хүмүүс гэдэгт хоригдогч ялтны зүгээс үйлдэж болзошгүй гэмт халдлагад өртөж болзошгүй иргэд, нийгмийн бусад төлөөлөл, хорих ангийн бүс, байрлалд түр хугацаагаар нэвтэрч байгаа тодорхой ажил гүйцэтгэж байгаа албан тушаалтан, иргэдийг хамруулж ойлгоно.

4. Хорих анги, цагдан хорих, баривчлах байр, байгууламж, техник хэрэгслийн аюулгүй байдал[4].

Пенитенциар гэмт явдал нь: Хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журам ба нийгмийн аюулгүй байдал, хүн амын эрүүл мэнд, захиргааны журмын эсрэг, өмчийн болон шүүн таслах ажиллагааны эсрэг болон бусад олон төрлийн гэмт хэргээс бүрдэнэ.

Судалгаанаас үзэхэд Монгол Улсад 2007-2010 онд нийт **31393** хүн ял шийтгүүлснээс **23193** хүнд хорих ял оногдуулсан[5] нь нийт ял шийтгүүлэгчдийн 60-аас дээш хувийг хорих ял шийтгүүлэгчид эзэлж байсан байна.

Монгол Улсад сүүлийн 50 жилд үйлдэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтэд судалгаа хийж үзэхэд 1968 онд-3436, 1978 онд-4251, 1988 онд-6614, 1998 онд-22737, 2008 онд-20704, 2018 онд-36620 гэмт хэрэг улсын хэмжээнд бүртгэгдсэн судалгаа байна. Дээрх тоо баримтаас харахад сүүлийн 50 жил гэмт хэрэг 10 дахин өссөн үзүүлэлттэй байна.[6]

Харин хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад 2003-2020 оны хооронд хоригдлоос 441 гэмт хэрэг үйлдэгдсэн[7] нь хорих ял эдлүүлэх явцад үйлдэгдэж байгаа гэмт хэргийн талаар шинжлэх ухааны үндсэн дээр судлах, урьдчилан сэргийлэх тусгай арга зүйг боловсруулах шаардлага урган гарч байна.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хэмжээнд төвлөрсөн хорих анги 21 үүнээс нээлттэй хорих анги 7, хаалттай хорих анги 5, нээлттэй, хаалттай хорих анги 5, өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага 1, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг 2, эмэгтэйчүүдийн хорих анги 1, баривчлах төв, байр тус бүр 1, Нийслэлд цагдан хорих төв 1, орон нутагт 25 цагдан хорих байр үйл ажиллагаа явуулж, 2020 оны жилийн эцсийн байдлаар нээлттэй хорих ангид **3126**, хаалттай хорих ангид **1336**, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан **1132** нийт **5594** хоригдол, хоригдогчид[8] харуул хамгаалалтын хяналтыг тасралтгүй тавин ажилласан байна.

---

[4] Ц.Очгэрэл. “Хорих байгууллагын аюулгүй байдал”. УБ., 2017 он. 91 дэх тал.
[5] Гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт. УБ., 2013. 145 дахь тал
[6] Б.Алтангэрэл, Ч.Мөнх-Эрдэнэ нар. Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ 2003-2018.УБ., 2019 он. 30 дахь тал
[7] Б.Алтангэрэл, Ч.Мөнх-Эрдэнэ нар. Дурдсан зохиол 2019 он. 92 дахь тал
[8] Хорих ял эдлүүлэх албаны 2020 оны жилийн эцсийн тайлан.

Хорих ял эдлэгсдийг үйлдсэн гэмт хэргээр ангилж үзвэл 1134 /25.2 хувь/ нь хүнийг алах /ЭХТА-н 10,1/, 775 /16.8 хувь/ нь хүчиндэх /ЭХТА-н 12.1/, 256 /5.7 хувь/ нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах /ЭХТА-н 20.7/, 1229 /27.3 хувь/ хулгайлах гэмт хэрэг үйлдсэн бол үүнээс 221 буюу 4.9 хувь нь мал хулгайлах гэмт хэрэг үйлджээ. ЭХТА-д заасан бусад төрлийн гэмт хэрэгт ял эдлэгсэд 25.8 хувийг эзэлж байна[9].

Хоригдлын аюулгүй байдлыг хангах, өөрийн болон бусдын бие эрхтэнд гэмтэл учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны жилийн эцсийн байдлаар хоригдол, хоригдогчийн бие, эд зүйл, хорих байр, хамгаалалтын бүс, түүнчлэн хоригдол хөдөлмөр эрхэлж байгаа хэсэг салбар, тээврийн хэрэгсэл, хорих байгууллагад нэвтэрч буй этгээдийн бие, эд зүйлд төлөвлөгөөт үзлэг, нэгжлэг **5326,** төлөвлөгөөт бус үзлэг, нэгжлэг **6941** удаа хийж, хөдөлгөөнт утас 20 ширхэг, бэлэн мөнгө 106150 төгрөг, зэвсгийн чанартай ашиглаж болохуйц эд зүйл 432 ширхэг, бусад эд зүйл /*тамхи, асаагуур, эмчийн зөвшөөрөлгүй эм, садар самуун сурталчилсан сонин, сэтгүүл гэх мэт*/ 4521 ширхэг, нийт **6** нэр төрлийн **4973** хориотой эд зүйлийг хураан авч зохих журмын дагуу шийдвэрлэжээ[10].

Хоригдлын дунд хууль ёс, дэг журмыг сахиулах, хоригдлоос нийгэм, иргэдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх үүднээс хорих ангийн дотоод журам зөрчсөн **25**, хоорондоо маргалдаж, бусдыг доромжилсон **15**1, алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлага биелүүлээгүй, эсэргүүцсэн **64**, хөдөлгөөнт утас ашигласан **20**, хориглосон эд зүйл хадгалсан **24** зөрчил гаргасан хоригдол, хоригдогч нарт хорих анги, байгууллагын даргын тушаалаар түр болон удаан хугацааны уулзалтын эрх хасах **22**, утсаар ярих эрх хасах **55**, сахилгын байранд хорих **115**, шагналын хоног хасах **51** сахилгын шийтгэлийг тус тус оногдуулсан байна[11].

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд сүүлийн 5 жилд нийт 19 гэмт хэрэг гарсан ба үүнийг өнгөөр нь авч үзвэл оргох 12 буюу 63.2 хувь, хүний биед гэмтэл учруулсан 6 буюу 31.6 хувь, бусад гэмт хэрэг 1 буюу 5.2 хувийг тус тус эзэлж байна.

[9] Хорих ял эдлүүлэх албаны 2020 оны жилийн эцсийн тайлан.
[10] Хорих ял эдлүүлэх албаны 2020 оны жилийн эцсийн тайлан.
[11] Хорих ял эдлүүлэх албаны 2020 оны жилийн эцсийн тайлан.



Сүүлийн 5 жилд нийт 1733 зөрчил гарсныг өнгөөр нь авч үзвэл гар утас ашигласан 531 буюу 30.7 хувь, архи уусан 52 буюу 3 хувь, албан хаагчийн хууль ёсны шаардлага эсэргүүцсэн, хорих ангийн дотоод журам зөрчсөн 466 буюу 26.9 хувь, бусдыг дарамталсан, хоригдол хоорондоо маргасан зодолдсон 566 буюу 32.6 хувь, хориотой тоглоом тоглосон, хориотой эд зүйл нэвтрүүлсэн, хадгалсан 118 буюу 6.8 хувийг тус тус эзэлж байна.



2020 онд гарсан зөрчлийг 2019 онд гарсан зөрчилтэй харьцуулахад нийт зөрчил 17-оор буюу 5,9 хувиар өссөн дүнтэй байгаа нь 2019 онд хоригдож байсан хоригдол, хоригдогсдын тоо 408-аар буюу 7,8 хувиар өссөнтэй холбоотой байна.

Хорих байгууллагад үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн тоо хэдийгээр буурч байгаа боловч таслан зогсоогдохгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Хорих ангид ял эдэлж буй хоригдлоос байгууллагын дотоод журам зөрчих, гэмт хэрэг зөрчих зэрэг ноцтой үйлдэл гаргадаг байна. Хоригдлын дундаас дотоод дэг журам зөрчих гэмт хэрэг үйлдэх, зөрчил гаргах гэх мэт харш үйлдэл, гэмт санаа бодлыг урьдаас мэдэж, бэлтгэл, завдалтын шатанд таслан зогсоох нь хорих ангид гэмт хэрэг гаргуулахгүй байх нь чухал юм. Доктор (Ph.D), профессор Д.Даваа-Очир бүтээлдээ хорих ангид гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд сэтгэл зүйч, эмч болон эмнэлгийн үзлэгт хамруулж байх нь чухал ач холбогдолтой гэж бичжээ. Хоригдлын дундаас гарч байгаа хэрэг, эрх зүйн зөрчлийн хэлбэр агуулга, шинж чанар, нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг нэг бүрчлэн

судалж, урьдчилан сэргийлэх ажлын чиглэлийг тогтоох явдал ихээхэн ач холбогдолтой юм[12].

Хорих ангийн харуул хамгаалалтын нөхцөл байдлыг судалж үзэхэд хорих ангийн аюулгүй байдалд хохирол учруулах, хэвийн үйл ажиллагааг алдагдуулах талаарх хоригдлуудын зүгээс явуулж буй сөрөг үйл ажиллагааг авч үзвэл:

-хорих ангийн газар зүйн байршил, албан хаагчдын тоо, хамгаалалтын бүсийн талаар судлах;

-хамгаалалтын тоног төхөөрөмжийг гэмтээх, ажиллагаагүй болгох талаар судлах;

-өөрийн хань хамсаатантай холбоо харилцаа тогтоохыг оролдох;

-хорих байгууллагын ажилтан, албан хаагчдыг өөрийн үйл ажиллагаандаа ашиглахаар сонирхох, энэ талаар идэвхтэй байдлаар ажиллах;

-хорих байгууллагын хэвийн үйл ажиллагаанд гаднаас халдах, үйл ажиллагааг алдагдуулахыг оролдох /хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон эрх чөлөөтэй байгаа хань хамсаатнаар дамжуулан/;

-хамт ял эдэлж буй хоригдлуудаас өөрийн “гал” бүлэглэл бий болгох, шаардлагатай тохиолдолд тэдгээрийг ашиглах, өөрийн гэмт ажиллагаанд татан оролцуулах, айлган сүрдүүлэх, дарамтлах, өдөөн турхирах, зорилготойгоор гал хам гэсэн халхавчтайгаар эрхшээлдээ байлгах;

-ял эдлэхээс зайлсхийх зорилготойгоор хорих ангиас оргон зайлах;

-ял эдлэхээс зайлсхийх зорилготойгоор амиа хорлох;

-урьд үйлдсэн гэмт хэрийг нуун дарагдуулах, худал ташаа зүйл ярих, төөрөгдүүлэх;

-өөрт ашигтай шийдвэр гаргуулах зорилгоор бие эрхтэндээ гэмтэл, учруулах, гэмтэл учруулахаар заналхийлэх;

-хорих ангид мөрдөгдөх хууль, журам зөрчсөн орчин нөхцөл бий болгохыг санаархах;

-нийгэмд өрнөж байгаа зарим хөдөлгөөн, тэмцлийг хууль хэлбэрээр дэмжих, дэмжихийг уриалах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болгох;

-хорих ангийн үйл ажиллагаанд ноцтойгоор нөлөөлөх сөрөг цуурхал дэгдээх, мэдээлэл тараах;

-бусдыг өдөөн турхирах;

-ял эдэлж байгаа ялтнууд нь алба хаагчдыг ашиглан өөрсдийн гэмт үйлдэл болон гадна байгаа гэмт хэргийн оролцогч, бусад этгээдүүдтэй холбоо тогтоох, хорих ангиас гэмт хэрэг удирдан зохион байгуулах, гэмт

[12] Д.Даваа-Очир. “Хорих ангийн ахуй дэглэмийн байцаагчийн гарын авлага”. УБ., 2010 он

хэргийн хохирогч нарыг дарамтлах, гэмт хэргийн ул мөрийг баллах, хууль бусаар олж авсан эд хөрөнгийг нуух гэх мэт хэлбэрээр явуулж байдаг[13].

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал нь гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд нийгмийн аюулгүй, амгалан тайван, тогтвортой байдал болон иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хангахад чиглэгдсэн байдаг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг түвшингөөр нь ерөнхий ба тусгай арга хэмжээ гэсэн өөр хоорондоо уялдаа бүхий хоёр хэсэгт хуваадаг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ гэдэгт гэмт хэргийг тэжээж тэтгэж байдаг хямрал болон тогтворгүй байдлыг нийгмийн амьдралаас арилгахад чиглэгдсэн, нийгмийн эерэг хөгжлийг бүхэлд нь ойлгоно. Гэхдээ энэ төрлийн арга хэмжээ нь гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгахад шууд чиглэгдэхгүй, харин нийгмийг бүхэлд нь хөгжүүлэх, эрүүлжүүлэх зорилго бүхий илүү өргөн цар хүрээтэй зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байдаг тул гэмт хэрэгт дам нөлөөлдөг онцлогтой[14].

Хорих ял эдлэгсдийн криминологи шинжийн гол элемент болсон бие хүний судалгаанд онцгой анхаарал хандуулах нь тэдний зүгээс үйлдэх гэмт явдлын шалтгаан нөхцөлийг тогтоох, үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийг цаг хугацаанд нь илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулах урьдчилсан нөхцөл болдог.

Монгол Улсын гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор С.Жанцан бүтээлдээ хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад ялтан бие хүнийг судлах нь томоохон байр, суурь эзэлдэг, чухал зангилаа асуудал билээ. Ялтан бие хүнийг төлөвшсөн онцлогийг судлахгүйгээр гэмт хэргийн шалгаан, нөхцөлийг илрүүлж, арилгах, хүнийг хүмүүжүүлэх, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх асуудлыг шийдвэрлэх боломжгүй юм. Гэмт хэрэгтэн бие хүнийг судлах судалгааны зорилго бол амьдралын тодорхой нөхцөлд тухайн хүний зан төрхийн онцлогт тохирсон шийдвэр гаргаж, түүнд эерэг байдлаар нөлөөлөх, гэмт зан төлөв үүсэх буюу төлөвшин тогтох, бие хүн түүний орчны харилцан үйлчлэлийн механизмыг олж илрүүлэх, улмаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөв чиглэлийг тодорхойлоход оршино [15].

Бие хүний сэтгэл зүйг ойлгохгүйгээр нийгмийн сэтгэл зүйн үзэгдэл, үйл явдлын шалтгааныг сэтгэл зүйн механизмын мэдлэггүйгээр гэмт этгээдийн бодол үйлдлийг ойлгох боломжгүй.Сэтгэл зүйн зүй тогтлын мэдлэгийг хэрэглэснээр хууль хамгаалах байгууллагын ажилтан хөдөлмөрөө хөнгөвчилж сонирхол татаж буй хүмүүстэй харилцах илүү

[13] Р.Уганбаяр “Хорих байгууллагад үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагаа” магистрын дипломын ажил., 2014 он, 21-22 дахь тал.
[14] Н.Жанцан “Криминологи” сурах бичиг, УБ, 2004, 68 дахь тал
[15] Н.Жанцан “Криминологи” сурах бичиг, УБ, 2004, 57 дахь тал

гүнзгий харилцах бодит байдлыг танин мэдэх хүмүүсийн биеэ авч яваа байдлын шалтгааныг гүнзгий ойлгох, зөв үнэлэх, гэмт хэрэгтэй тэмцэх ажилд олсон мэдээллээ зөв үр дүнтэй ашиглах боломж олдог нь[16] хорих ангид сэтгэл зүйч нарыг түлхүү ажиллуулж ял эдэлж байгаа гэмт хэрэгтнүүдийн сэтгэл зүйд нөлөөлж, тэдний гэмт санаа бодлыг эерэг зүйлд хандуулж байх явдал юм.

Пенитенциар гэмт явдал гэдэг нь хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад албан хаагч, хоригдол, яллагдагчийн зүгээс холбогдох хууль тогтоомж, хорих ангийн дотоод дүрэм, журмыг зөрчсөн гэмт хэргүүдийн цогц гэж үзэж болох юм[17].

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх хорих байгууллагын үндсэн чиг үүргээс харахад пенитенциар гэмт явдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хорих анги, байгууллагаас хэрэгжүүлж буй янз бүрийн чиглэл цар хүрээ, зохион байгуулалтаас бүрдэж байгаа нийгмийн цогц ажиллагаа гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Пенитенциар гэмт явдал, түүний зүй тогтлыг судалснаар хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад үйлдэгдэж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулах, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, практик ажилтнуудаас гэмт хэрэгтэй тэмцэхэд туйлын ач холбогдолтой юм.

Дүгнэлт, санал:

1. Хорих анги, байгууллагын биечилсэн харуул хамгаалалт сул, хүн хүчний хүрэлцээ муугаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд сүүлийн 5 жилд нийт 19 гэмт хэрэг гарсан ба үүнээс оргох гэмт хэрэг 12 буюу 63.2 хувийг эзэлж байгаагаас харагдаж байна.

Техник, технологи өндөр хөгжсөн гадаад улсын практик туршлагыг судлан үзэхэд ХБНГУ, БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс Хонг-Конгийн хорих байгууллагад телехяналтын систем өргөн нэвтэрсэн хэдий ч хүний хүчин зүйл, биечилсэн хяналтыг орхигдуулалгүй 1 харуул хамгаалалтын ажилтан 6-8 хоригдолд биечилсэн хяналт тавин ажилладаг байна.

Хорих байгууллага нь нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгэгдсэн хүмүүсийн бөөгнөрөл тул тэдний зүгээс гэмт хэрэг үйлдэх магадлал өндөр байдаг. Батлагдсан орон тоогоор хамгаалалтын ажилтны тоо их харагдаж байгаа боловч ШШГБ-ын хэмжээнд 24 цагийн жижүүрлэлтэд **200-230** харуул хамгаалалтын ажилтан хоригдолд тавих биечилсэн хяналт, харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж, бусад

[16] Ш.Мягмарцэрэн, З.Төрмандах, Б.Наранбаатар “Гүйцэтгэх ажлын сэтгэл зүй” УБ.2004.4 дахь тал

[17] Б.Алтангэрэл. “Хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад үйлдэгдэж буй гэмт хэрэг, түүнийг судлах нь” эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл. 2014 он.

хамгаалалтын ажилтан нь хорих ангийн гадна хамгаалалт, нэвтрэх хэсэг, хуяглан хүргэх ажиллагаа, үйлдвэрлэлд үүрэг гүйцэтгэдэг тул “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив”[18]-д зааснаар хамгаалалтын ажилтны орон тоог нэмэгдүүлэх;

2. Хорих ял эдлэгсэдээс үйлдэж буй зөрчил, гэмт хэрэг бүгдийг цаг алдалгүй илрүүлэн таслан зогсоож хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг шуурхай явуулан шийдвэрлэж зөрчлийн болон хоригдлын хувийн байдалд нь тохирсон хариуцлагыг эргэлт буцалтгүй заавал оногдуулах механизмыг нэг мөр төлөвшүүлэх.

Учир нь хорих байгууллагад бүртгэгдсэн зөрчлийн мэдээнд гэмт хэргийн шинжтэй зарим үйлдлийг сахилгын төрөлд тооцон хариуцлага хүлээлгэдэг практик түгээмэл байна. /жишээ нь: хорих ангийн байрлалыг дур мэдэн орхиж явах, бусдын биед гэмтэл учруулах, танхайрах, хулгайлах гэх мэт/;

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 208 дугаар зүйлийн 208.3 дахь хэсэгт “*Анх удаа ял эдэлж байгаа хоригдлыг дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос, засарч хүмүүжиж байгаа хоригдлыг засарч, хүмүүжихгүй байгаа хоригдлоос, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг үйлдсэн хоригдлыг энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос, түүнчлэн эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн болон зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн гишүүнд тооцогдож ял шийтгүүлсэн хоригдлыг тусад нь ял эдлүүлнэ*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлэх зэрэг болно.

Ашигласан эх сурвалж

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017 он

2. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль. 1999 он

3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль. 2019 он

4. Н.Жанцан “Криминологи” сурах бичиг. УБ., 2004 он.

5. Д.Даваа-Очир. “Хорих ангийн ахуй дэглэмийн байцаагчийн гарын авлага”. УБ., 2010 он

6. Ц.Очгэрэл. “Хорих байгууллагын аюулгүй байдал”. УБ., 2017 он.

7. Б.Алтангэрэл, Ч.Мөнх-Эрдэнэ нар. Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ 2003-2018.УБ., 2019 он.

8. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном. 2016 он.

9. Хорих ял эдлүүлэх албаны тайлан. 2016-2020 он.

10. Гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт. УБ., 2013 он.

[18] Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны А/247, А/167, 303 дугаар хамтарсан тушаал

11. А.И.Долгова. Российская криминологическая энциклопедия/ Под общ. ред. М., 2000.

12. Р.Ууганбаяр “Хорих байгууллагад үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагаа” магистрын дипломын ажил., 2014 он

ПРОБАЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОЙЛГОЛТ, ОНЦЛОГ

UNDERSTANDING AND FEATURES OF PROBATION ACTIVITIES

Д.Буяннэмэх
Дотоод хэргийн их сургуулийн докторант, ахмад
D.Buyannemekh
Captain Ph.D Student, University of Internal Affairs

Хураангуй: Эрдэм шинжилгээний өгүүлэлд олон улсад өргөн хэрэглэгдэж буй Пробацийн үйл ажиллагааны үүсэл хөгжил, нэр томъёо болон ойлголтын талаар талаар дүн шинжилгээ хийж, онцлог шинжийг тодорхойлохыг зорьсон болно.

Abstract: The aim of the research article is to analyze the origins, development, terminology and concepts of probation, which are widely used internationally, and to identify their features.

Түлхүүр үгс: Пробаци, хоригдол, ял, гэмт хэрэг, батлан даалт.
Keywords: Probation, imprisonment, conviction, crime, parol.

Удиртгал

Дэлхийн зарим улс орны эрх зүйн практикт гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр хяналт, хязгаарлалт тогтоох замаар ял эдлүүлэх нь хамгийн түрүүнд сонгон хэрэглэвэл зохих ял шийтгэлийн үндсэн хэлбэр гэж үзэж байгаа бөгөөд хорих ялыг зөвхөн хохирогчийн аюулгүй байдалд заналхийлсэн, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн зэрэг цөөн тооны тохиолдолд хэрэглэх учиртай гэсэн үзэл, зарчим давамгайлж байна.

Ял эдлүүлэх ажиллагааны үр дүнд дүн шинжилгээ хийж үзвэл хорих ял эдлүүлэх ажиллагаа нь өндөр хэмжээний зардлыг үүсгэж байгаагийн зэрэгцээ хорих ял эдлээд суллагдсан хүмүүс нийгмийн орчинд буцаж очих, дахин гэмт хэрэг үйлдэхээс үл эмээх хандлагатай байгаагаас үүдэн хорих ял хамгийн үр дүн багатай ялын төрөл хэмээн тооцогдож байна.

Хүн төрөлхтний түүхэн хөгжлийн явцад нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт хэрэг, түүнийг төрүүлдэг шалтгаан, нөхцөл, тэдгээрийн үйлчлэлийг хэрхэн саармагжуулах талаар гүн ухаантан, хуульч, нийгэм судлаач, хүн судлаач, криминологчидын олон жилийн турш боловсруулан хөгжүүлсэн эрүүгийн эрх зүй, криминологийн шинжлэх ухааны онолын сэтгэлгээ, сургаал, номлол нь гэмт хэрэг, ялын мөн чанар, тэдгээрийн нийгмийн учир холбогдол, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг түүхийн

үүднээс танин мэдэхэд онол, практикийн гүн гүнзгий ач холбогдолтой[1] хэмээн тодорхойлжээ.

Дэлхийн олон улсад өргөн хэрэглэгдэж буй пробацийн үйл ажиллагааны ойлголт, тогтолцоонд шилжиж гэмт хэрэгтнийг нийгмээс тусгаарлахгүйгээр зохих шийтгэл хүлээх, хяналтад байх, өөрийн үйлдсэн гэмт хэргийн хор уршгийг арилгах боломжийг нэвтрүүлэх арга замыг тодорхойлох, олон улсын туршлагыг судлахыг зорилоо.

Үндсэн хэсэг

Пробаци (probation) гэсэн нэр томьёо нь “probation” гэсэн латин үгнээс гаралтай, туршилт, ажиглалт явуулах үндсэн зорилгоос үүдэлтэй гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шүүхийн шийдвэрээр засаж, залруулах хугацаа юм.

Дундад зууны Англиийн эрүүгийн хуулиас Пробацийн үүсэл, хөгжлийг харж болно. Насанд хүрсэн болон насанд хүрээгүй этгээдийг ноцтой шинж чанартай биш гэмт хэрэгт хатуу шийтгэл оногдуулдаг байв. Нутаг заах, хорих, ташуурдах, зэрэмдэглэх, цаазаар авах ял оногдуулдаг байсан байна. Жишээлбэл VIII Генрих хааны үед 200-аас доошгүй гэмт хэрэгт цаазаар авах ял оноодог байсны ихэнх нь хөнгөн гэмт хэрэг байжээ.

Түүний энэ хатуу байдал эцэстээ шударга ёсны тогтолцооны хувьсал гарахад нөлөөлсөн бөгөөд Англиийн нийгмийн дэвшилтэт хэсгийн дургүйцлийг ихээхэн хүргэж эдгээр хүнлэг бус шийтгэлийг хөнгөвчлөхийн тулд аажмаар боловч шийдэмгий байдлаар олон янзын арга хэмжээг боловсруулж хааны өршөөлийг яллагдагч этгээд худалдаж авах боломж олгодог байсан.

Англи Улсын шүүх хулгайлагдсан эд хөрөнгийг үнэлэх аргачлалыг боловсруулж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг үнийн дүнгээр яллах, лам хуврагын тусламжтай хөдөлмөр хийлгэх, ажлаас халах зэрэг аргууд нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хатуу ял оногдуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ болж байв.

Эцэст нь шүүх "сайн зан авирыг заавал дагаж мөрдөх" практикийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ хугацаанд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд өршөөл үзүүлэх эсвэл хөнгөн ял оногдуулах арга хэмжээ авч маргаантай байгаа гэмт хэргийн ялыг хойшлуулж эхэлсэн нь пробациын үйл ажиллагаа үүсэх гол шалтгаан болж өгчээ.

Англиийн Улсын иргэн гутлын үйлдвэрийн эзэн Жон Августус 1841 онд өөрийн гутлын үйлдвэрт архинд донтох өвчтэй, архийг хэтрүүлэн хэрэглэдэг этгээдүүдийг 3 долоо хоногийг хугацаатайгаар батлан даалтаар авч ажиллуулан шүүхэд хүлээлгэн өгсний дараа архинд донтох өвчтэй этгээдүүдийн гадна төрх, зан авир өөрчлөгдөж эерэг үр дүн өгч

[1] С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол УБ., 2009.910 дахь тал

байсан тул энэхүү үйл ажиллагааг 18 жилийн хугацаанд олон зуун эрэгтэй, эмэгтэй, насанд хүрээгүй этгээдэд туршиж батлан даалтаар хариуцан еерэг зан үйл гарч буй этгээдүүдийг ар гэрт нь хүлээлгэн өгдөг байсан нь Пробацийн үйл ажиллагааны үндэс суурь болж дэлхийн улс орнууд хэрэгжүүлж эхэлсэн байна.

АНУ-ын Массачусетс мужид 1859 онд анхны Пробацийн журам батлагдаж Пробацийн үйл ажиллагаа нь АНУ даяар аажмаар тархаж Английн хуульч Мэттью Дэвенфорт Хилл нь орчин үеийн пробацийн хөгжилд хувь нэмэр оруулсан гэж түүхэнд тэмдэглэгдэн үлджээ.

Пробацийн ажилтнууд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн амьдралыг шинэчлэх, өөрчлөх, өөрчлөн байгуулах, сайн сайхан, шударга, иргэдийн дагаж мөрдөх хуулийг өөрийн улс орны нийгэм, эдийн загийн хөгжилд тохируулан гаргаж дэлхийн 2 дугаар дайны дараа АНУ, Европ тивд өргөн тархаж гэмт хэрэг үйлдсэн хүнд тэнсэн харгалзах ялыг оногдуулж эхэлсэн нь орчин үеийн хөгжилд хүргэх алхам хийгджээ.

1950 оноос пробацийн ажилтнууд бусад арга,техникийг ашиглаж, үүнд бүлгийн ажил, олон нийтийн ажил, даалгавартай ажил, гэр бүлийн эмчилгээ, зан үйлийн гэрээ, бодит байдал эмчилгээ, зан үйлийг өөрчлөх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг хорихгүйгээр, зохих шийтгэл оногдуулж, нийгмийн дунд хүмүүжүүлэх ажил 1960-аад гэхэд өргөжин тэлсээр хамгийн дээд цэгтээ хүрч үр дүнгээ өгч байсан байна.

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1990 оны 10 дугаар сарын 14-ний хуралдаанаар хэлэлцэн баталсан “Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм” (Токиогийн дүрэм)-ийн 1.5 дугаар зүйлд “Гишүүн орнууд нь хорих ялыг хэрэглэх явдлыг багасгах замаар бусад боломжийг хангах, эрх зүйн зөрчил гаргагчийг хэвийн амьдралд эргэж орох хэрэгцээ, нийгмийн шударга ёсны болон хүний эрхийг хангах зайлшгүй шаардлагыг харгалзан эрүүгийн байцаан шийтгэх салбар дахь бодлогыг оновчтой болгох зорилгоор өөрийн эрх зүйн системийн хүрээнд хорихоос өөр төрлийн арга хэмжээг боловсруулна”[2] хэмээн пробацийн үйл ажиллагааг хэлбэршүүлэн тунхагласан байна.

Токиогийн дүрмийг хэрэгжүүлэх нь зөвхөн тэнсэн харгалзах ял оногдуулж байгаа улс орнуудад төдийгүй ийм системийг сонирхдог улс орнуудад Токиогийн дүрмийг хэрэгжүүлэхэд улс орнуудад туслах зорилгоор НҮБ-ын Гэмт хэрэг, шударга ёсны судалгааны хүрээлэнгээс 1998 оны 3 дугаар сард “Пробацийн үйл ажиллагааны гарын авлага”-ыг гаргасан.

[2] Д.Баярсайхан, Т.Золбоо. Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл. 2012., Уб. 159 дэх тал.

Дэлхийн улс орнуудын эрх зүйн практикт Пробацийн үйл ажиллагааг хорих ял эдлүүлэх үйл ажиллагааны явцад гэмт хэрэгтэн бие хүн болж өөрчлөгдөхөөс урьдчилан сэргийлэх, улмаар нийгмийн харилцаанаас тусгаарлахгүйгээр гэмт зан үйлийг өөрчлөх, нийгмийн амьдралд дасан зохицох, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх үйл явц гэж тодорхойлж болохооор байна. Олон улсад (Probatian and Parol) буюу туршилтийн хугацаа, тэнсэн харгалзах, батлан даалт гэсэн нэршлээр томьёолдог.

Пробацийн үйл ажиллагааны Зорилго нь

- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр шийтгэх, хянах,
- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн хор уршгийг ойлгуулах, учирсан хохирлыг барагдуулах,
- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмийн амьдралд дасан зохицоход тусламж үзүүлэх,
- Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шоронд хорихгүйгээр шийтгэх нь хүмүүнлэг нийгмийг бүтээх,
- Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг албадан хөдөлмөрлүүлж нийгмийн хөгжилд хувь нэмрийг оруулах,
- Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хорихоос өөр төрлийн ял оногдуулах нь хорих ял оногдуулахаас эдийн засгийн хувьд харьцангуй бага зардал гарах,
- Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хорихгүй байснаар хорих байгууллагын төвлөрөл, хорих ангийн тоо буурах зэрэг зорилгыг дурдаж болохоор байна.

Дэлхийн улс орнууд өөрийн эрх зүйн тогтолцоо, нийгмийн хөгжлийн онцлогт нийцүүлэн пробацийн албыг нэршил, чиг үүрэг харьяаллын хувьд өөр өөр хэлбэрээр байгуулан ажиллуулж байна, Тухайлбал АНУ, Анли, Швед, Латви, Гүрж, гэх мэт улсад Пробацийн алба, Норвеги, Финлянд, Дани, Япон, Финлянд, Норвеги, Чех, Стони зэрэг улсад пробацийн алба нь хууль зүйн яаманд АНУ, Герман, Унгар зэрэг улсад шүүхэд Голланд улсад прокурорын байгууллагад, Швед, Казакстан зэрэг улсд хорих байгууллагад Сингапур улсад спорт, нийгмийн хөгжлийн яаманд тус тус харьяалагддаг байна.[3]

Өндөр хөгжил бүхий орнууд Пробацийг үйл ажиллагааг судлан үзэхэд нийгэм, эдийн засгийн хөнжилд тохируулан дараах 3 хэлбэрээр зохион байгуулж байна. Үүнд:

[3] Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа харьцуулсан судлал. 2018., Уб. 188 дах тал

1. Гэмт хэрэг сэжиглэгдэж эхлэх үеэс тусламж үзүүлэх хэлбэр, /гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдлыг тодорхойлох, хууль зүйн туслалцаа үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдох хүртэл ар гэр, хамт олны батлан даалтад авах гэх мэт/

2. Нийгмийн хяналтын хэлбэр /гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорихгүйгээр нийгэмд дахин засаж, хүмүүжүүлж болдог, ар гэр, хамт олны нөлөөгөөр тодорхой хугацаанд хяналтад авах, чөлөөтэй зорчин явах эрхийг хязгаарлах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах гэх мэт/

3. Нийгмээс тусгаарлагдаж хорих эдэлсэн этгээдийг нийгмийн хэвийн амьдрал ороход туслалцаа үзүүлэх, нийгмийн хариуцлагын хүрээнд аж ахуй нэгж, байгууллагаар дамжуулан ажилд зуучлах, орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран түр амьдрах орон байраар хангах гэх мэт/

Гадаадын улс орнуудад Пробацийн үйл ажиллагааг хэрэгжүүлж буй туршлагыг авч үзвэл. Үүнд:

Тус албаны үйл ажиллагааны талаарх эрх зүйн зохицуулалтаар жишиг болохуйц Япон, Англи, Америк зэрэг орны туршлага нь хорих ял эдлүүлэх ажиллагаанд гарах зардлыг хэмнээд зогсохгүй дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх нийгэмшүүлэх ажилд тулгамдаж буй олон сөрөг асуудлыг шийдвэрлэж чадсан байна.

Япон Улсын Пробацийн үйл ажиллагааны талаар:

Япон улсад ял шийтгэсэн шүүхийн тогтоолыг хойшлуулах бүтэц институц үйлчилдэг. Хэд хэдэн үндсэн нөхцөл хамаарагдах ба шүүгдэгч хөдөлмөрт албадан татан оруулахаар 3 жилээс илүүгүй хугацаагаар хорих, 500.000 иенээр торгох ялаар шийтгэгдсэн байх, эсвэл өмнө нь албадан хөдөлмөрт татан оролцуулах хорих ялаар болон түүнээс хүнд ял шийтгэгдсэн, ял эдэлсний дараа 5 жилийн турш дахин гэмт хэрэг үйлдэж, шийтгэгдэж байгаагүй байх ёстой. Хянан харгалзах хугацаа 1-5 жил байна. Арга хэмжээний биелэлтийг цагдаагийн байцаагч хэрэгжүүлдэг байна.

Энэхүү албаны чиг үүргийг товч байдлаар авч үзвэл:

Нөхөн сэргээх ажиллагаа явуулж гэмт хэрэгтэнтэй зохистой харьцах, насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг арилгах хөтөлбөр хэрэгжүүлдэг.

Тэнсэн харгалзах алба нь орон нутгийн шүүхийн судал бүр дээр байгуулж, нийгмийн нөхцөл байдлыг зохицуулах, яаралтай шийтгэл хүлээлгэх, уучлал хүсэх өргөдөл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, нөхцөл байдлын улмаас ноцтой тохиолдлуудыг үүсгэсэн хүмүүсийг олон нийтэд түшиглэсэн эмчилгээ, гэмт хэрэгтнүүдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад чиглэсэн алба юм.

Сайн дурын туслалцаа, дэмжлэг туслалцаа үзүүлж буй хуулийн этгээдүүд,

Нөхөн сэргээлтийг тусламжийн эмэгтэйчүүдийн холбоо,

Нөхөн сэргээлтийн тусламжийн холбоо,

Батлан даалтаар суллах,

Тэнсэн харгалзах,

Ялтны нөхөн сэргээлтийн үндэсний төв

Суллагдсан хоригдолд туслалцаа үзүүлэх төв

Ажлын байрны туслалцаа үзүүлэх,

Өршөөл үзүүлэх,

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төв зэрэг байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлдэг байна.[4]

Англи Улсын Пробацийн үйл ажиллагааны талаар:

Англи Улсын Пробацийн алба нь 2001-2006 оны хугацаанд Дотоод хэргийн яамны бүтцэд ажиллаж байгаад өнөөдрийн байдлаар “Эрх зүйн зөрчил гаргасан этгээдтэй харилцах үндэсний алба” /NOMS/ болон өөрчлөгдөн зохион байгуулагдсан байна. Англи улсын хэмжээнд 42 алба, 7000 орчим ажилтантайгаас нийт 30 гаруй хувь нь тусламж, үйлчилгээний чиглэлийн чиг үүрэг хэрэгжүүлдэг.

Нийт ажилтан, сайн дурын ажилтны 44 орчим хувийг эмэгтэй ажилтнууд эзэлж байна. Ажилтнуудын дийлэнх хувийг хуульч болон сэтгэл зүйч мэргэжлийн ажилтнууд эзэлдэг ба нэг ажилтанд дунджаар 15 хүн ногддог байна.

Энэхүү албаны чиг үүргийг товч байдлаар авч үзвэл:

Төрийн болон хувийн гэсэн хоёр үндсэн чиглэлд хуваагдан үйл ажиллагаа явуулдаг байна.

Төрийн пробаци нь бэлгийн хүчирхийлэл бүхий гэмт хэрэг үйлдсэн этгээдэд болон 12 сараас дээш хугацаагаар ял шийтгэгдсэн, хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хяналт тавьдаг.

Пробацийн үйл ажиллагаа нь аливаа хүн гэмт хэрэгт сэжиглэгдсэн цагаас эхлэн шүүн таслах ажиллагаа хүртэл хууль зүйн туслалцаа үзүүлдэг байна.

Оногдуулах ял шийтгэлийн талаар зөвлөмж бэлтгэж шүүхэд танилцуулдаг.

Хорих ял эдлээд суллагдсаны дараах үйлчилгээ, дэмжлэгийг үзүүлэн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг энгийн амьдралд шилжихэд туслалцаа үзүүлэх үүргийг хэрэгжүүлдэг. Энэ ажлын хүрээнд суллагдсан иргэнд үзүүлэх нөлөөллийн ажил буюу олон нийтийн оролцоог хангах, бусад ахуй

[4] Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа харьцуулсан судлал. 2018., Уб. 210 дах тал

нөхцөлийг тогтворжуулах, дэмжлэгийг үзүүлдэг бөгөөд тус чиг үүргийг хэрэгжүүлэх үндэсний комисс хэлбэрийн бүтэц ажилладаг байна.[5]

АНУ-ын Пробацийн үйл ажиллагааны талаар:

Америкийн Нэгдсэн Улс бол олон муж улсыг өөртөө нэгтгэсэн холбооны төрийн байгууламжтай /төрөлжсөн эрүүгийн хуульгүй/ бие даасан эрх зүйн тогтолцоо бүхий орон бөгөөд Англиийн нийтлэг эрх зүйн уламжлал нөлөөнд тулгуурлан хөгжиж иржээ.

Энэхүү албаны чиг үүргийг товч байдлаар авч үзвэл:

Пробацийн алба нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн байнгын хяналтад авч зориулалтын байранд байлгах,

Архи болон мансууруулах зүйлд донтсон этгээдийг эрх чөлөөг хязгаарлаж, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авч байнгын хяналтад байлгах,

Батлан даалт тогтоох замаар гэрийн хорионд байлгах,

Албадлагын боловсролын хөтөлбөрт хамруулах,

Албадан хөдөлмөрлүүлж, хохирол төлбөрийг барагдуулах,

Торгууль оногдуулах,

Муж улс болгон өөрийн бүтэц, зохион байгуулалтын болон эрх зүйн зохицуулалтын онцлогт нийцүүлэн нэгдмэл байдлаар зохион байгуулдаг байна.[6]

Монгол Улсын ял эдлүүлэх ажиллагааны өнөөгийн байдлыг авч үзвэл:

Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 19 дүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц нийгэм, эдийн засаг, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна[7] гэж заажээ.

Монгол Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн судалгаагаар нийт 2017 онд 2942, 2018 онд 3522, 2019 онд 3933, 2020 онд 4489 хоригдол тус тус ял эдэлж байсан.

Анх удаагийн ял шийтгүүлсэн 2017 онд 1653, 2018 онд 1908, 2019 онд 2023, 2020 онд 2115 хоригдол,

2 удаа ял шийтгүүлсэн 2017 онд 563, 2018 онд 730, 2019 онд 830, 2020 онд 1008 хоригдол,

3 удаа ял шийтгүүлсэн 2017 онд 288, 2018 онд 357, 2019 онд 433, 2020 онд 548 хоригдол,

4 удаа ял шийтгүүлсэн 2017 онд 182, 2018 онд 221, 2019 онд 239, 2020 онд 299 хоригдол,

[5]Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа харьцуулсан судлал. 2018., Уб. 190 дэх тал
[6] Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа харьцуулсан судлал. 2018., Уб. 86 дах тал
[7] Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл. 2002.№5

5 удаа ял шийтгүүлсэн 2017 онд 105, 2018 онд 141, 2019 онд 187, 2020 онд 205 хоригдол,

6 удаагийн ял шийтгүүлсэн 2017 онд 76, 2018 онд 80, 2019 онд 111, 2020 онд 144 хоригдол,

7 удаагийн ял шийтгүүлсэн 2017 онд 34, 2018 онд 40, 2019 онд 48, 2020 онд 79 хоригдол,

8 удаагийн ял шийтгүүлсэн 2017 онд 18, 2018 онд 18, 2019 онд 26, 2020 онд 43 хоригдол,

9 удаагийн ял шийтгүүлсэн 2017 онд 13, 2018 онд 15, 2019 онд 24, 2020 онд 24 хоригдол,

10 удаагийн ял шийтгүүлсэн 2017 онд 6, 2018 онд 7, 2019 онд 3, 2020 онд 11 хоригдол,

10 дээш удаа ял шийтгүүлсэн 2017 онд 4, 2018 онд 5, 2019 онд 9, 2020 онд 10 хоригдол тус тус ял эдэлж байна.

Хорих ял эдэлж суллагдсан 2017 онд 1800, 2018 онд 1813, 2019 онд 2600, 2020 онд 2794 хоригдол тус тус суллагдсан байна[8].

Дээрх судалгаанаас үзэхэд, дунджаар нийт ял шийтгүүлэгчдийн 60-70 орчим хувь нь хорих ял эдэлж, 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 4489 хоригдлын 2371 давтан гэмт хэрэг үйлдсэн байгаа нь хорих ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, хоригдлыг суллахад бэлтгэх ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, Пробацийн үйл ажиллагаанд шилжих шаардлагатай байгаа болох нь харагдаж байна.

Дүгнэлт

Монгол Улсад хорих ял эдлэгсэдийн тоо буурахгүй, давтан гэмт хэрэг үйлдэгсэд яд эдлэгсэдийн талаас илүү хувийг эзэлж байгаа нь хорих ялын гүйцэтгэлийн бодлогыг өөрчлөх, хоригдлыг суллахад бэлтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх шаардлага урган гарч ирж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно”.

“Ялын бодлогыг нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулах, ялтныг хөдөлмөрлөх нөхцөлөөр хангах замаар гэмт хэргийн улмаас учирсан хохирол барагдуулалтыг нэмэгдүүлнэ”.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт

[8] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх албаны 2017-2020 оны жилийн эцсийн тайлан

хугацааны хөгжлийн баримт бичигт “Ял шийтгэгдсэн хүнийг нийгэмшүүлэх, суллагдахад бэлтгэх, нийгмээс тусгаарлахгүйгээр ялын бодлогыг хангах зорилгоор “Цахим хяналтын төв”-ийг байгуулж, пробацийн тогтолцоог хөгжүүлнэ” хэмээн тус тус зорилт дэвшүүлсэн.

Ихэнх улс орны баримталж буй ял эдлүүлэх ажиллагаандаа баримталж буй үзэл баримтлал нь аль болох хорих ял оногдуулахаас зайлсхийн ялын өөр төрлийг сонгон хорих ял эдлэх хугацаанд нь нийгэмшүүлэх, ажлын байраар хангах, суллагдаад дахин гэмт хэрэг үйлдэхгүй зан төлөв, нийгмийн орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэж байна.

Монгол Улсын хэмжээнд хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажил, сэтгэл зүйн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлт, хоригдлыг суллах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр судалгааны ажил хийж пробацийн үйл ажиллагааг гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цагдан хоригдсон үеэс нь эхлэн хэрэгжүүлж хорих болон хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд нэгдсэн хэлбэрээр нэвтрүүлэх хувилбарыг сонгох нь зайлшгүй шаардлагатай болохыг дээрх судалгааны үр дүн харуулж байна.

Ашигласан эх сурвалж

1. “Монгол Улсын үндсэн хууль” 1992 он.
2. Эрүүгийн хууль 2015 он.
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он.
4. Б.Алтангэрэл, Ц.Очгэрэл, Г.Галсанжамц “Дэлхийн зарим улс орны хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны зүй тогтол, арга зүй, эрх зүйн зохицуулалт, чиг хандлагын харьцуулсан судалгааны ажил”. Уб.,2018 он.
5. С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол УБ., 2009 он,
6. Д.Баярсайхан, Т.Золбоо. “Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл”. 2012 он.
7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх албаны 2017-2020 оны жилийн эцсийн тайлан
8. Probation anf probation service: A European Perspevtiv /ed by Avan Kalmthout & Derks
9. www.legilatonline.org
10. www.english.gov.cn
11. www.mps.gov.cn

ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ АЛБАДАН СУРГАЛТЫН ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES TO IMPROVE THE EFFECT OFCOMPULSIVE TRAINING ON BEHAVIOR

Г.Балжмаа
Дотоод хэргийн их сургуулийн Гэмт явдал судлал-Эрх зүйн ангийн докторант, ахлах дэслэгч
Baljmaa.G
Senior lieutenant, University of Internal Affairs Doctoral student, in the Department of Grime Studies-Law

Хураангуй: Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулж буй зан үйл засах үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ болон албадан сургалтын чанар, хүртээмж үр дүн хангалтгүй байгаа талаар хийгдсэн судалгаа дүн шинжилгээг үндэслэн сургалтын үр нөлөөг дээшлүүлэхэд мэргэжлийн сэтгэлзүйч, нийгмийн ажилтны орон тооны хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг харуулахыг зорьсон болно.

Abstract: The aim is to highlight the needs and importance of professional psychologists and social workers in improving the effectiveness of training based on research and analysis of the guality and accessibility of compulsory training and the coercive measures imposed by the courts on offenders.

Түлхүүр үгс: Албадлагы арга хэмжээ, нийгэмшүүлэх ажил, нийгмийн ажилтан, сургалтын үр нөлөө дээшлүүлэх, ач холбогдол

Key words: Coercive measures, social work, psychology, effect, importance.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, хорих анги нь гэмт хэрэг, зөрчил дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх ажлын хүрээнд зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулж ирснээс хойш нилээдгүй хугацаа өнгөрчээ.

Энэхүү сургалтын агуулга, хэлбэр, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт, үр нөлөөнд дүн шинжилгээ хийгдсэн судалгааны тайлан, хяналт тавих эрх бүхий байгууллагын ажилтны санал, зөвлөмжийг үндэслэн тулгамдсан асуудал, хүндрэл бэрхшээлийг харуулах, тодорхой санал дэвшүүлэх зорилго агуулж, сургалтын үр нөлөөг дээшлүүлэхэд мэргэжлийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтны хэрэгцээ шаардлагыг харуулах зорилт дэвшүүлэн энэхүү өгүүллийг бичихийг зорилоо.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад зан үйлд нөлөөлөх албадан сургалтын талаар

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хорих анги нь зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг:

1-рт: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 222 дугаар зүйлийн 222.1-д зааснаар хорих ял эдэлж байгаа хоригдлын зан үйлд нөлөөлөх .

2-рт: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 189 дүгээр зүйлд заасны дагуу хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд шүүхээс оногдуулсан зан үйлээ засах үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд

3-рт: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 147 дугаар зүйлийн 147.5-д зааснаар баривчилсан этгээдийн зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулна.

Хорих ял эдэлж байгаа хоригдлын зан үйлд нөлөөлөх албадан сургалт:

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын талаар дурдахын өмнө Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага буюу хорих ангийн нийгмийн ажилтны ажил үүргийн талаар зайлшгүй дурдах нь зөв байх.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 2017 оны шинэчилсэн найруулгад хорих ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр зарчмын шинжтэй томоохон өөрчлөлтүүд орсон ба тухайлбал, хорих ял эдлүүлэх төрөл, дэглэм, зэрэглэлийг шинээр тогтоон нээлттэй, хаалттай хорих анги, энгийн ба тусгай зэрэглэл, хоригдлыг нийгэмшүүлэх болон аюулгүй байдлыг хангахтай холбоотой болон бусад асуудлуудыг шинээр хуульчилж өгсөн байна[1].

Энэ хүрээнд хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын мэргэшсэн нэгжийн нийгмийн ажилтан болон нийгмийн ахлах ажилтан нь хоригдлыг хорих анги, байгууллагад хүлээн авмагц нийгэмшүүлэх ажлын чиглэлээр мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, суллагдан гараад нийгмийн харилцаанд ухамсартайгаар оролцоход нь дэмжлэг үзүүлэх, хорих анги байгууллагын онцлогт тулгуурлан нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх замаар хоригдлыг нийгмийн ажлын үйлчилгээнд тасралтгүй хамрагдах боломжийг нэмэгдүүлэх чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулж ирсэн байна[2].

---

[1] Б.Алтангэрэл. Хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажлын өнөөгийн байдал, чиг хандлага.-// “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны эрх зүйн шинэтгэл” ЭШХ-ын эмхтгэл. УБ.,2021.т.89

[2] Б.Алтангэрэл. Хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажлын өнөөгийн байдал, чиг хандлага.-// “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны эрх зүйн шинэтгэл” ЭШХ-ын эмхтгэл. УБ.,2021.т.89

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 222 дугаар зүйлийн 222.1-д зааснаар Хорих анги нь монгол хэлээр уншиж, бичиж чадахгүй Монгол Улсын иргэн-хоригдолд монгол хэл, бичиг үсэг эзэмшүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай хоригдлын зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулна гэж заасан байна.

Хорих ял эдлэгсдэд явуулж буй зан үйлд нөлөөлөх албадан сургалтын онцлог нь нэг талаас хоригдогч нөгөө талаас нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн хоорондын харилцаа, нөлөөллийн ярилцлага, сургалтыг чанартай, хүртээмжтэй явуулсны үндсэн дээр дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэмт зуршлаас нь татгалзуулах чухал үүрэг гүйцэтгэх юм. Өөрөөр хэлбэл хорих ангийн нийгэмшүүлэх ажлын нэг гол үзүүлэлт гэж ойлгож болох юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд сүүлийн 4 жилийн байдлаар 2017 онд-58, 2018 онд-58, 2019 онд-60, 2020 онд-62 нийгмийн ажилтан нийгэмшүүлэх ажлын чиглэлээр үйлчилгээ үзүүлсэн бол 2017 онд -2942, 2018 онд-3525, 2019 онд-3751, 2020 онд-4372 хоригдол ял эдэлсэн байна.[3]

Мөн хугацаанд хорих ял эдэлсэн хүмүүсээс 2017 онд 1289 буюу 9.8%, 2018 онд 1614 буюу 45,7%, 2019 онд 1910 буюу 48.5%, 2020 онд ..... тус тус давтан гэмт хэрэг үйлдэж ял эдэлсэн тоон үзүүлэлтээс хорих байгууллага дахь нийгэмшүүлэх ажлын буюу зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөө хангалтгүй байгааг харж болохоор байна.[4]

Хэрэв хорих ял дээр нэмж шүүхээс зан үйлээ засах сургалтанд хамрагдах үүрэг хүлээлгэсэн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч шүүхээс шүүхийн шийдвэр, гүйцэтгэх хуудсыг хүлээн авсан даруйд ял эдэлж байгаа хорих ангид тухайн хоригдолд явуулах хугацаа, хуваарь бүхий мэдэгдлийг хүргүүлж, хяналт тавьж ажиллана.

<u>Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ авагдсан болон шүүхээс зан үйлээ засах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд явуулах албадан сургалтын талаар</u>:

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, болон нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны хуулийн онцлог нь хорих ял биечлэн эдлүүлэх явдлыг багасгах, хохирол нөхөн төлүүлэх чиглэлд анхаарч, хорихоос өөр төрлийн ялыг түлхүү оноох, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд

[3] Б.Алтангэрэл, М.Хүрэлбат, А.Жаргалзаяа “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөнд хийсэн шинжилгээ” судалгааны тайлан. УБ.,2020

[4] Д. Дамдинцэрэн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй зарим асуудал.-// “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны эрх зүйн шинэтгэл” ЭШХ-ын эмхтгэл. УБ.,2021.т.14

оногдуулах ялыг хөнгөрүүлэх, албадлагын арга хэмжээ хэрэглэх зэрэг өсвөр насны хүнд болон хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх өөрчлөлтүүдийг тусгасан[5].

Зан үйлээ засах сургалтанд хамрагдах үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хэлтсийн Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгч, нийгмийн ажилтан сэтгэл зүйч нар Эрүүгийн хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.2.2 дахь заалт, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2017 оны А/73 дугаар тушаалаар батлагдсан “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журам”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын даргын 2020 оны А/103 дугаар тушаалаар батлагдсан “Зан үйлд нөлөөлөх албадан сургалт зохион байгуулах журам”-ыг удирдлага болгон явуулна.

Зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга баталсан хөтөлбөрийн хүрээнд, батлагдсан төлөвлөгөөний дагуу хорих анги бүхий шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, тус орон тоо батлагдаагүй байгууллагад удирдлагын шийдвэрээр тухайн чиг үүргийг хариуцан гүйцэтгэх алба хаагч, эсхүл төрийн болон төрийн бус байгууллагын сургалтын багш явуулахаар тусгасан байна.

Сургалтанд оролцогчийн талаарх нэгдсэн бүртгэлийг орон нутгийн хэмжээнд тухайн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс улсын хэмжээнд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба хариуцан хөтөлнө, сургалтын талаарх тайланг Хорих ял эдлүүлэх албаны сургалт, нийгэм, сэтгэл зүйн ажил хариуцсан нэгжид хүргүүлж, нэгдсэн тайланг тус газар нь Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны даргад хүргүүлэхээр зохицуулагдсан байна[6].

Сургалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу газар хэлтсийн дарга гэрээ байгуулснаар зөвшөөрөл бүхий төрийн болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно гэж заасан хэдий ч сургалтын зардал төсөвт тусгагдаагүйгээс тэр бүр мэргэжлийн үр нөлөө өндөртэй байгууллагаас сургалт авах асуудал хязгаарлагдмал байсаар байна.

Хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс нь оролцогчийн хувийн байдал, үйлдсэн гэмт хэргийн шинж, хяналт тогтоосон хугацаанаас хамаарч сургалтыг ялгамжтай байдлаар зохион

[5] “Монгол улсын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа: уламжлал, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт”судалгааны тайлан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төв УБ.,2017.т.19

[6] Б.Алтангэрэл, М.Хүрэлбат, А.Жаргалзаяа “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөнд хийсэн шинжилгээ” судалгааны тайлан. УБ.,2020 т.66-68

байгуулах сургалтын орчинг бүрдүүлэхээр хуульд тусгагдсан боловч сургалт явуулах орчин нөхцөлийн талаар улсын хэмжээнд хийгдсэн судалгаа дүн шинжилгээнд сургалтын танхим, техник хэрэгсэл дутмаг, сургалтын орчинг сайжруулах шаардлагатай гэсэн дүгнэлт гарсныг энд дурдах нь зөв байх.

2017-2020 оны хооронд жилийн эцсийн байдлаар Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ авагдсан ялтан, этгээдүүдийн тоон судалгааг авч үзвэл:

Хорихоос өөр төрлийн ял 2017 онд-2317, 2018 онд-9652, 2019 онд-11840, 2020 онд-12158 хүн эдэлсэн бол албадлагын арга хэмжээ 2018 онд-3812, 2019 онд-7529% 2020 онд-8776 этгээд авагдсан байна. Тоон үзүүлэлтийг харьцуулбал жил бүр өссөн үзүүлэлттэй байгааг харж болохоор байна.

Аймаг нийслэл дэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хэлтэст 2020 оны байдлаар нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн орон тоотой хорих 413, 419, 423, 425, 437, 445, 457, Говь-Алтай, Завхан, Сэлэнгэ, Хөвсгөл аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хорих анги хариуцсан 11 нийгмийн ажилтан, сэтгэл зүйч байгаа бол Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Дорноговь, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Налайх, Багахангай, Багануур дүүрэг дэхь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар сургалт хариуцсан албан хаагчтай, Замын-Үүд, Завхан аймаг Тосонцэнгэл, Сэлэнгэ аймаг дахь Сайхан сум, Төв аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нийгмийн ажилтан, сэтгэлзүйчийн орон тоогүй, шийдвэр гүйцэтгэгч нар сургалтыг зохион байгуулан явуулж байсан байна.

Хорихоос өөр төрлийн шийдвэр гүйцэтгэгч нараас “Багшлах эрхийн” сургалтанд хамрагдсан 39, хамрагдаагүй 10 албан хаагч байсан байна[7].

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх мэргэжлийн нэгжтэй байхаар заасан боловч өнөөдрийн байдлаар хорих анги хариуцсан нийгэм сэтгэлзүйн нэгж хариуцан явуулж байгаа нь орон тоо төсөв санхүү хүндрэлтэй үед сайшаалтай мэт боловч зан үйлээ засах албадан сургалтанд хамруулах албадлагын арга хэмжээ төдийгүй хорих ангийн нийгэмшүүлэх ажлыг давхар хүртээмжгүй, үр нөлөөгүй болгож байна.

2020 оны байдлаар 945 насанд хүрсэн, 349 өсвөр насны, нийт 1294 этгээд зан үйлээ засах сургалтанд хамрагдах үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан байна. 2019 оны мөн үетэй харьцуулахад 15 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан байна.

[7] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Сургалт нийгэм сэтгэлзүйн хэлтсийн ажлын тайлан УБ.,2020

Зан үйл засах албадан сургалтыг хэрэгжүүлэхэд нийгмийн ажилтан, сэтгэл зүйчээс гадна улсын хэмжээнд нийт эрүүгийн 16 ахлах шийдвэр гүйцэтгэгч, 47 шийдвэр гүйцэтгэгч ажиллаж байгаа нь өнөөгийн практикт эрүүгийн хариуцлага гарцаагүй биелэгдэх зарчмыг хангахад хүний нөөцийн бодлогын хувьд хангалтгүй байгаа талаар хяналт тавих эрх бүхий байгууллагын ажилтны илтгэлд дурдагдсаныг судлаачийн хувьд дурдах нь зөв байх[8].

Баривчлагдсан этгээдүүдийн дунд явуулах зан үйлд нөлөөлөх албадан сургалтын талаар:

Өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжоор зөрчил үлдсэн хүн хуулийн этгээдэд торгох, баривчлах, эрх хасах шийтгэл оногдуулж байгаа бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах, хохирол төлбөр гаргуулах, албадан эмчлэх, албадан сургалт гэсэн албадлагын арга хэмжээний төрлүүдийг тус тус оногдуулж байна.

Энэхүү хуульд заасан албадлагын арга хэмжээний нэг төрөл болох албадан сургалтанд баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэн хүнд хэрэглэж болно.

Баривчлагдсан этгээдүүдийн дунд явуулах зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг үйлдсэн зөрчлийн шинж, хувийн онцлогийг нь харгалзан явуулахаар тус тус заасан байна

Албадан сургалтыг баривчлах шийтгэлийг эдэлж байх хугацаанд эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ. Албадан сургалт арван цагаас тавин цагийн хугацаатай байна гэсний дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 147 дугаар зүйлийн 147.5-д Баривчлах байр нь баривчлагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/73 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр”, “ Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам”-ын дагуу ганцаарчилсан болон бүлгээр зарлан мэдээлэх систем ашиглан “Ивээлийн үйлчлэл”, “Эрчүүд, эрүүл гэр бүл хөгжлийн нийгэмлэг”, “Хорих байгууллагын нөхөрлөл” төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах гэрээний дагуу сургалтыг зохион байгуулан явуулсан байна.

Баривчлагдсан этгээдүүдийн дунд явуулах нийгэмшүүлэх ажил нь зан үйлд нөлөөлөх сургалт болон сэтгэлзүйн үйлчилгээ гэсэн үндсэн чиглэлийн хүрээнд явагдана.

[8] Ц.Мөнхбат. Прокурорын хяналтын эрүүгийн албадлагын арга хэмжээ: Эрх зүйн тулгамдсан ба шийдвэрлэх асуудал. ”Албадлагын арга хэмжээнд тавих хяналтын тогтолцоо: хэрэгжилт, чиг хандлага” ЭШХ-ын эмхтгэл. УБ.,2018.т.25

Зан үйлд нөлөөлөх албадан сургалт нь сэтгэлзүйн болон эрх зүйн сургалт гэсэн төрөлтэй байна.

Сэтгэлзүйн сургалт: Сэтгэлзүйн үйлчилгээний удиртгал, архины шалтгаант зан үйлийг өөрчлөх, харилцааны чадвар сайжруулах, хүчирхийлэл үйлдэх зан үйлийг өөрчлөх, уур бухимдлаа зохицуулах, өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх, бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлийг өөрчлөх гэсэн чиглэлээр хөтөлбөр боловсруулж, ямар хөтөлбөрт хэн хамрагдах шаардлагатай байгааг үнэлгээ хийж сургалтанд хамруулна.

Эрх зүйн сургалт: Гэр бүлийн тухай болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн болон хүүхэд хамгааллын тухай хууль, Зөрчлийн тухай болон Эрүүгийн хууль, шаардагдах бусад хуулиудаар сургалт ордог.

Эрх зүйн сургалтын агуулга нь зөвхөн хуулийг зааж, мэдүүлэх гэхээсээ илүү, тухайн хуулийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, учирч болох эрх зүйн сөрөг үр дагаврыг ухамсарлуулан ойлгуулахад оршдог байна.

За мөн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид тусгай хөтөлбөрийн дагуу сэтгэл зүйн, бясалгалын төрлөөр ганцааарчилсан, бүлгийн гэсэн хэлбэрээр албадан сургалтыг зохион байгуулан явуулж байгаа боловч мэргэжлийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтны дутагдалаас сургалтын үр нөлөө хангалтгүй, хүртээмжгүй байна.

Тухайлбал 2020 оны 8520 шийтгэлийн 7420 нь буюу 87 % нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчсөн /ЗТХ-5.4.4/ шийтгэл дангаараа эзэлж байгаа нь мөн л анхаарал татсан асуудлын нэг юм.

Мөн сүүлийн 7 жилийн байдлаар 2017 онд-5159, 2018 онд-4356, 2019 онд-7815, 2020 онд-8520 тус тус баривчлагдсан этгээдүүдийн тоог нийт нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлсэн албан хаагчдын тоотой харьцуулж үзвэл жишиг нормативаас хэд дахин илүүл ачаалалтай ажилласан нь албадан сургалтыг чанаргүй, хүртээмжгүй, үр нөлөө хангалгүй ажиллах нэг шалтгаан болсныг дурдаж болохоор байна. баривчлах төвд 2017 онд-5159, 2018 онд-4356, 2019 онд-7815, 2020 онд-8520 хүн тус тус шийтгэл эдэлсэн байна.[9]

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөнд хийсэн шинжилгээ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд болон зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөнд тус байгууллагын болон “Каритас Монгол”ТББайгууллагын захиалгаар 2020 онд зан үйлд нөлөөлөх

[9] Б.Алтангэрэл, М.Хүрэлбат, А.Жаргалзаяа “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөнд хийсэн шинжилгээ” судалгааны тайлан. УБ.,2020

албадан сургалтын эрх зүйн орчин, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо, сургалтын үр дүн, сургалт явуулах хүний нөөц, сургалтын орчны талаар хийсэн судалгааны тайланд сургалтын үр нөлөөнд хийсэн шинжилгээний талаар дэлгэрэнгүй дурдсаныг иш татвал:

Хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн зан үйлд нөлөөлөх сургалтыг хэрэгжүүлж буй 61 алба хаагчаас зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтад өгөх таны үнэлгээ гэх асуултад хангалттай сайн-14, хангалтгүй-5, сайжруулах шаардлагатай-34, мэдэхгүй-8 гэж хариулсан байна.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг шинээр хуульчилж өгсөн нь хэр оновчтой вэ? Гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 23 буюу 38.3 хувь нь цаг үеэ олсон, 2 буюу 3,3 хувь нь цагаа олоогүй буруу, 35 буюу 58.3 хувь нь зөв боловч бэлтгэл ажил хангагдаагүй гэж хариулсан байна.

Шүүхээс оногдуулсан зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилтийг хэрхэн үнэлдэг вэ? гэсэн асуултад судалгаанд оролцсон албан хаагчдын 12 буюу 20 хувь нь хэрэгжилт сайн, 48 буюу 80 хувь нь учир дутагдалтай хэрэгждэг гэж хариулжээ[10].

Зан үйл засах албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцох төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны талаарх эрх зүйн зохицуулалтыг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуултанд 6 буюу 10 хувь нь сайн, 10 буюу 16.7 хувь нь сул, 26 буюу 43.3 хувь нь сайжруулах шаардлагатай, 17 буюу 28.3 хувь нь тодорхойгүй, 1 буюу 1.7 хувь нь сайн боловч сайжруулах шаардлагатай гэж хариулсан байна.

Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллахад ямар бэрхшээл тулгардаг вэ? гэсэн асуултад 14 буюу 23.3 хувь нь сургалтын зардал байхгүй, 11 буюу 18.3 хувь нь хүн хүч, 5 буюу 8.3 хувь нь хамтран ажиллах байгууллага байхгүй, 1 буюу 1.7 хувь нь бусад, 5 буюу 8.3 хувь нь сургалтын зардал, хүн хүч, техник хэрэгсэл, хамтран ажиллах байгууллага байхгүй гэж хариулсан байна.

2017-2020 оны хооронд зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хариуцан явуулж буй нийгмийн ажилтан нь мэргэжлийн эсэхэд судалгаа явуулахад 2017 онд 58 албан хаагчаас 12 мэргэжлийн , 46 мэргэжлийн бус, 2018 онд 60 албан хаагчаас 15 мэргэжлийн 45 мэргэжлийн бус, 2020 онд 62 албан хаагчаас 15 мэргэжлийн 47 мэргэжлийн бус байв.

Сургалтын орчны талаар судалгаа авахад нийт 21 хорих ангиас сургалтын танхимгүй 6, сургалтын танхимтай боловч техник хэрэгсэл хангалтгүй 15 хорих анги байв.

[10] Б.Алтангэрэл, М.Хүрэлбат, А.Жаргалзаяа “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөнд хийсэн шинжилгээ” судалгааны тайлан. УБ.,2020 т.88-89

Судалгаанд хамрагдсан 452 этгээдээс Баривчлах байрнаас зохиож буй албадан сургалтын үр нөлөөг та хэрхэн үнэлж байна бэ? асуултад 123 нь буюу 27,2% нь үр нөлөө сайтай, 202 нь буюу 44.6% нь хангалтгүй, 28% нь ямар ч үр нөлөөгүй гэж хариулжээ[11].

Уг судалгааны ажлын явцад оролцогчдоос зан үйл засах албадан сургалтыг үр дүнг сайжруулах чиглэлээр зардлыг шийдвэрлэж төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, мэргэшсэн боловсон хүчинтэй болох орон тоог нэмэгдүүлэх, сургалтын орчин техник хэрэгслээр хангах, одоо ажиллаж байгаа нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарыг сургалтанд хамруулах гэсэн саналуудыг гаргасныг тайланд тусгасан байна[12].

Дүгнэлт

Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулсан эрүүгийн хариуцлага болон шийтгэлийг эдлүүлэхдээ дахин гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байх үүднээс сэтгэлзүйн болон нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлж зан үйл засах албадан сургалтанд хамруулдаг талаар дээр дурдсан байгаа.

Хорих байгууллагын хэмжээнд нийт хорих ял, хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийн дийлэнх хувь нь Монгол улсад гарч буй тодорхой төрлийн, тогтмол, өндөр үзүүлэлттэй бүртгэгдэж буй хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, өмчлөх эрхийн эсрэг, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг зэрэг гэмт хэрэг үйлдсэн байдаг бол 2020 оны жилийн эцсийн байдлаар баривчлах төвд баривчлагдсан 8520 этгээдийн 7420 буюу 87 хувь нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчсөн байдал нь сүүлийн үед анхаарал татсан асуудлуудыг нэг болоод байна. Мөн давтан гэмт хэрэг үйлдсэн ял эдлэгсдийн тоон судалгаанаас нийгэмшүүлэх ажлын үр нөлөө хангалтгүй байгааг байгууллагын удирдлага болон бусад албадан сургалтын үр нөлөөнд хийсэн судалгаа шинжилгээ, судлаачдын дүгнэлтээс харж болохоор байна.

Үүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар эрдэмтэн судлаачид болон практик ажилтнууд өөрсдийн дүгнэлт, санал санаачлагыг нилээдгүй илэрхийлсэн байдаг.

Судалгааны тайланд үндэслэж энэхүү өгүүллээ бичихдээ тулгамдаж буй асуудлын хүрээнд зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулж бүй мэргэжлийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх ,

[11] “Б.Алтангэрэл, М.Хүрэлбат. “Баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хийсэн дүн шинуилгээ”судалгааны тайлан УБ., 2020. 64 дэх тал

[12] Б.Алтангэрэл, М.Хүрэлбат, А.Жаргалзаяа “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөнд хийсэн шинжилгээ” судалгааны тайлан. УБ.,2020 т.113-117

тэднийг чадавхжуулах талаар хүний нөөцийн бодлогын асуудал болон гадны байгууллагаас сургалт явуулахад шаардлагатай төсөв хөрөнгө, зардалтай холбоотой асуудлуудтай санал нэг байгаа болно. Түүнээс гадна тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замын хүрээнд хичнээн ч зорилтод бүлэгт чиглүүлсэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн мэргэжлийн ажилтны дутагдалтай байдлаас шалтгаалж уг хөтөлбөр үр дүнгүй болох талтай юм. Иймд дараах саналуудыг дэвшүүлж байна:

Зардал, санхүүгийн тулгамдсан асуудлын хүрээнд:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 189 дүгээр зүйлийн 189.13-т “Албадлагын арга хэмжээ авагдсан хүний зан үйлд нөлөөлөх сургалтыг зөвшөөрөл бүхий төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болго” гэж заасан хэдий ч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 299 дүгээр зүйлийн 299.5-д “Энэ хуулийн 169.1-д зааснаас бусад тохиолдолд захиргааны, зөрчлийн, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг газар, хэлтсийн төсөвт тусгаж, олгохгүй байгаа нь ял, албадлагын арга хэмжээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байгаа тул төсөвт тусгуулах. Мөн ковид цар тахал нүүрлэсэн энэ үед сургалтыг цахим хэлбэрээр явуулж шүүхийн шийдвэрийг тасалдуулахгүй, завшуулахгүй явуулахын тулд сургалтын орчныг бүрдүүлэхэд шаардлагатай техник хэрэгслээр хангах.

Мэргэжлийн боловсон хүчин, хүний нөөцийн тулгамдсан асуудлын хүрээнд:

Хорих ангийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарын нийгэмшүүлэх ажлын үр дүн мөн жишиг нормативаас даруй 2-3 дахин их хоригдол хариуцан ажиллаж байгаа талаарх тоо баримтыг зориуд дурдсан болно.

Гэтэл түүний хажуугаар Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд давхар зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хариуцан явуулж байгаа нь аль алинд нь хүртээмжгүй, чанаргүй нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлж албадан сургалтын үр нөлөөг бууруулж байгаа нэг гол шалтгаан юм.

Шүүхээс Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг түлхүү оноож байгаа өнөө үед Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дэргэд тусдаа нийгэм сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлэх нэгжтэй болох туйлын хэрэгцээ шаардлага байгааг анхаарч үзэх хэрэгтэй юм.

Мэдээж хэрэг орон тоо нэмэгдүүлэх асуудал нь төсөв санхүүтэй холбоотойгоос гадна Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдлагын эрх хэмжээний асуудлаас давсан асуудал боловч, хууль эрх зүйн хүрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, санал санаачилга гаргах эрхтэй гэж бодож байна.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дэргэд нийгэм, сэтгэл зүйн нэгжтэй болсноор бүтэц орон тоо, хүний нөөцийн бодлогын маш

чухал асуудал шийдэгдэж, зөвхөн зан үйлд нөлөөлөх албадан сургалт төдийгүй хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж, Монгол улсад үйлдэгдэж буй тодорхой төрлийн тогтмол үйлдэгдэг гэмт хэрэг, зөрчил тэр дундаа нийгмийн анхаарлыг ихээр татаад бүй гэр бүлийн хүчирхийллийг бууруулахад чухал ач холбогдолтой юм.

Боловсон хүчин, хүний нөөцийн хувьд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын захиалгаар Дотоод хэргийн их сургуулийн харьяа Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль нь энэ төрлийн чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин бэлтгэж байгаа нь сайшаалтай хэдий ч энэ чиглэлээр бэлтгэгдэж төгссөн 2021 онд нийт 11 төгсөгч нараас гурав нь ажлын байранд хуваарилагдаж үлдсэн найман төгсөгч нар одоогийн байдлаар нөөцөд бүртгэгдэж үлдсэн тун харамсалтай байна. Гэтэл практикт мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээ шаардлага нэн чухал байгааг илэрхийлмээр байна.

Түүнээс гадна “Эрх зүйн эдийн засгийн дүн шинжилгээний орчин үеийн чиг хандлага” сэдэвт дэлхийн тэргүүлэх эрдэмтдийн цуврал илтгэлд эрх зүй ба эдийн засгийн ухааныг салангид биш нэгдмэл хүрээнд, харилцан уялдаанд авч үзэх хандлага дэлхий нийтэд түгээмэл болж, хөгжиж буй орнуудын хувьд аливаа хууль тогтоох үйл ажиллагаанд эдийн засгийн дүн шинжилгээний арга барил, үр ашгийн тооцооллыг заавал нэвтрүүлж, зөв тусгах нь чухал юм.

Ингэснээр батлан гаргаж буй хуулиуд, төрийн бодлого нь оновчтой байж бүх шатны байгууллагад эдийн засгийн эерэг үр нөлөө үзүүлэх юм гэжээ.

Мөн дэлхий нийт технологийн их өгөгдлийн эринд ажиллаж амьдарч байгаа өнөө үед дата анилизыг хуулийн төсөл боловсруулах, хэлэлцэх, батлах үйл явцад ашиглахыг чухалчилж байна.

Өөрөөр хэлбэл дата анализ урьдчилан цуглуулж хуулийн төсөл боловсруулах гэдэг нь тухайн санаачилж буй хуулийн ирээдүйд өгөх эдийн засгийн үр өгөөжийг тооцож, цуглуулсан дата анаализуудийн үр дүн нь тухайн хуулийг батлагдахад гарсан зардлаас илүү гарсан эдийн засгийн үр өгөөж өгөх нь тодорхой байх нь хууль батлагдах гол шалгуур нь болно гэжээ.

Үүнийг жишээ нь дээр тайлбарлавал:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 189 дүгээр зүйлийн 189.11-д *“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зан үйлээ засах сургалтанд хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан хүний зан үйлд нөлөөлөх сургалт явуулах мэргэжлийн нэгж, сургалтын хөтөлбөртэй байна” гэсэн заалтад “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дэргэд”* гэдэг өгүүлбэрийг нэмж ***“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх***

байгууллагын харьяа Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дэргэд зан үйлээ засах сургалтанд хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан хүний зан үйлд нөлөөлөх сургалт явуулах мэргэжлийн нэгж, сургалтын хөтөлбөртэй байна”-гэж нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагын цаана нь Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дэргэд нийгэм сэтгэлзүйн нэгжтэй болох юм.

Энэ нэгжийг шинээр байгуулахад хичнээн хэмжээний зардал гарах, ирээдүйд бий болох хууль эрх зүй, эдийн засгийн үр өгөөжийг тооцох зэрэг аргаар дата анализийг бие болгож хуулийн төсөл боловсруулах юм.

Эцсийн үр дүн нь зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөг дээшлүүлснээр нийгэм, сэтгэлзүйн үйлчилгээ хүртээмжтэй, чанартай, үзүүлж гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дахин гэмт хэрэг зөрчилд холбогдуулахгүй байх, нийгмийн анхаарал татсан асуудлын нэг болох гэр бүлийн хүчирхийллийг буруулах хууль зүйн сайн үр дагаврыг бие болгох юм.

Монгол улсад гарч буй гэмт хэргийн гаралтыг буруулахад Цагдаагийн байгууллагаас гадна бусад төрийн байгууллагын үүрэг оролцоо, хамтын ажиллагаа маш чухал юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хувьд зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулахад тулгарч буй хүний нөөцийн хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэж, сургалтын үр нөлөөг дээшлүүлснээр бидний хүсээд буй гэмт хэрэггүй, амар тайван нийгмийг бүтээхэд оруулж байгаа хувь нэмэр гэж ойлгож байна.

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ НЭР ТОМЪЁОНЫ ОНОЛ, ПРАКТИКИЙН АЧ ХОЛБОГДОЛ

THEORETICAL AND PRACTICAL VALUE OF THE CONCEPTUAL AND TERMINOLOGICAL OF FORENSIC EXAMINATION

З.Сүлд
Шинжлэн магадлахуй судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан-багш, хууль зүйн докторант, цагдаагийн хошууч
Z.Suld
Senior researcher-teacher of Forensic Science center, law science doctoral, Police major

Хураангуй: Уг илтгэлд шүүхийн шинжилгээний мэдлэгийн салбарт болон үйл ажиллагаанд ойлголт, томъёоны эзлэх байр суурь, үүрэг, ач холбогдлыг үндэслэлтэйгээр тодорхойлохыг зорив.

Abstract: The article discusses issues related to the role and meaning of the conceptual and terminological of forensic examination

Түлхүүр үгс: шүүхийн шинжилгээ; шүүхийн шинжилгээний үйл ажиллагаа; шинжээчийн дүгнэлт; шинжлэх ухааны хэл; мэргэжлийн хэл; ойлголт, нэр томъёоны хэрэглэгдэхүүн.

Key words: forensic examination; forensic activity; conclusion of examination; language of science; professional language; conceptual and terminological apparatus.

Өнөөгийн техник, технологийн үсрэнгүй хөгжлийг дагаад нийгмийн харилцааны бүхий л салбарт шинэ үг нэвтэрсээр байгаа бол, уг үйл явцтай зэрэгцээд зарим ойлголт, нэртомъёо хуучирч, хэрэглээнээс түрэгдэн гарсаар байна. Үүний нэг нь шүүхийн шинжилгээний салбар юм.

Шинжилгээний ойлголт, нэр томъёо нь тухайн мэдлэгийн салбараас гадна хууль зүй, философи, анагаах ухаан, техник, физик, хими, эдийн засаг зэрэг олон шинжлэх ухааны салбартай нягт холбоотой байдаг. Учир нь шинжилгээ хийх болон шинжээчийн дүгнэлт боловсруулах үйл явц олон салбарын мэдлэг шаардсан нарийн бөгөөд хариуцлагатай ажиллагаанд тооцогддог.

Иймд уг ажиллагаанд хэд хэдэн чухал шаардлага тавигддаг. Үүний нэг нь ойлголт, нэр томъёоны асуудал юм. Ойлголт, нэр томъёоны боловсруулалтын түвшингээр тухайн шинжлэх ухааны салбарын хөгжил болон үйл ажиллагаа хэр зэрэг жигдэрснийг тодорхойлох боломжтой гэж үздэг. Учир нь ойлголт, нэр томъёонд тулгуурлан тухайн мэдлэгийн салбарын буюу мэргэжлийн хэл төлөвшдөг. Мэргэжлийн хэлээр дамжуулан тухайн салбарын үйл ажиллагааг гардан хэрэгжүүлж буй субъектууд болох шинжээч, мэргэжилтэн болон эрдэмтэн, судлаач, багш,





суралцагчид өөр хоорондоо харилцах, мэдлэг болон мэдээлэл солилцох, түгээх, бодол санаагаа оновчтой, ойлгомжтой илэрхийлэх, асуудал боловсруулж, түүнд дүн шинжилгээ хийх замаар үндсэн чиг үүргээ хэрэгжүүлдэг.

ХХ зууны төгсгөлд ОХУ-ын хэсэг эрдэмтэд шүүхийн шинжилгээний нийтлэг онолыг боловсруулсанаар тус мэдлэгийн салбар бие даасан шинжлэх ухаан болж хөгжих эхлэл тавигдсан. Монгол Улсын хувьд тус мэдлэгийн салбарын онол, арга зүйд тулгуурлан шүүхийн шинжилгээний үйл ажиллагааг нэгдмэл тогтолцоонд оруулсан цөөн орны нэг юм. Хэдийгээр тухайн мэдлэгийг практикт нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд байгаа ч онолын хүрээнд шийдвэр хүлээсэн олон тулгамдсан асуудал хуримтлагдаад байна. Үүний нэг нь тус мэдлэгийн салбарын хэлийг бүрдүүлж буй шинжилгээний ойлголт, нэр томъёотой холбоотой асуудал юм.

Иймд уг тулгамдсан асуудлыг илтгэлийн сэдвийн хүрээнд, нэгд, шинжилгээний ойлголт, нэр томъёог хэрхэн оноон тогтоож буй байдал, хоёрт, тэдгээрийг хэр оновчтой хэрэглэж буй байдал гэсэн хүрээгээр зааглан авч үзсэн болно. Үүний үндсэн дээр шинжилгээний ойлголт, нэр томъёоны онол, практикийн ач холбогдлыг тодорхойлохыг зорив.

а) *<u>Онолын хүрээнд</u>*

Нэр томъёог оноож тогтооход хэд хэдэн чухал шаардлага тавигддаг. Тухайлбал, *шинжлэх ухааны үндэстэй, нэгдмэл хэв шинжтэй, эмх цэгцтэй, дан утгатай, товч бөгөөд тодорхой, тогтвортой байх* г.м. Эдгээр шаардлага шинжилгээний нэр томъёонд мөн адил хамаарна. Учир нь оновчгүй нэр томъёогоор илэрхийлсэн утга, санаа алдаатай шийдвэр гаргахад хүргэдэг. Үүнийг, ялангуяа, шинжээчийн дүгнэлт боловсруулах явцад хэрхэвч гаргаж болохгүй.

Түүнчлэн шинжээчийн дүгнэлтийн боловсруулсан байдлаар тухайн шинжээчийн мэргэжлийн ур чадвар, мэдлэгийн түвшинг тодорхойлох боломжтой гэж үздэг.

Шинжилгээний хэл болон ойлголт, нэр томъёоны эзлэх байр суурь болоод онол, практикийн ач холбогдлыг талаар тус салбарын гадаад, дотоодын эрдэмтэд дараах байр суурийг илэрхийлсэн байдаг. Тухайлбал, ОХУ-ын эрдэмтэн А.И.Винберг, Н.Т.Малаховская нар, шүүхийн шинжээчийн хэл нь шинжлэх ухааны хэлний нэгэн адил тодорхойлолт болон тэмдэг, тэмдэглэгээ (нэр томъёогоор)-гээр илэрхийлсэн ойлголтуудын *нэгдмэл тогтолцоо* [4] гэсэн бол Р.С.Белкин, криминалистикийн хэл гэдгийг зөвхөн тухайн салбарын мэргэжилтнүүдэд зориулагдсан ямар нэгэн өвөрмөц ойлголт, нэр томъёоны хэрэглэгдэхүүн хэмээн явцуу утгаар ойлгох ёсгүй. Ийм хэл гэж байхгүй, байх ч учиргүй. Иймд уг асуудлыг, нэгд, энгийн хэрэглээний ба нийтлэг шинжлэх ухааны

шинжтэй, хоёрт, тухайн мэдлэгийн салбарт нийцсэн криминалистикийн хэлний бүтцэд хамаарах ойлголт, нэр томъёоны *нэгдмэл тогтолцоо* хэмээн өргөн хүрээнд авч үзэх хэрэгтэй [3] гэжээ. Тэгвэл В.А.Юматов, О.А.Нестеров нарын хувьд шүүхийн шинжилгээний хэл бол шинжлэх ухааны хэллэгт зүй ёсоор тооцогдоно. Учир нь уг хэл нь шинжлэх ухааны үндэслэлтэй, түүний ололт амжилтад тулгуурласан байхын зэрэгцээ шинжилгээг *давхар утгагүй, энгийн, оновчтой хэлээр* боловсруулсан байх учиртай гэжээ [13].

АНУ-ын эрдэмтдийн хувьд тус мэдлэгийн салбарт *эмх цэгцтэй тогтолцоог* бүрдүүлэхээр зорьж буй орны нэг юм. Энэ хүрээнд 2009 онд тус улсад зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний хурал дээр “Шинжлэн магадлах үйл ажиллагааг сайжруулах нь: урагшлах зам” сэдвийн хүрээнд хийсэн судалгааны ажлын үр дүнг тайлагнасан. Тус илтгэлд уг чиглэлд авч хэрэгжүүлэхээр нийт 13 арга хэмжээг төлөвлөж, холбогдох зөвлөмжийг гаргасан. Уг зөвлөмжид “...нэг стандартын үг хэллэгийг бий болгож шинжээчийн дүгнэлт болон шүүхийн практикт ашиглах, шинжээчийн дүгнэлтийн найдвартай байдал, мэдээлэл солицох болон шинжилгээг үр дүнтэй болгох арга хэрэгслийг боловсруулах…[14] гэсэн асуудлыг тусгажээ.

Монгол Улсын хувьд, тухайлбал, хууль зүйн доктор Ж.Хурцгэрэл, ойлголт ба тодорхойлолт, тэдгээрийг илэрхийлдэг нэр томьёо, тэмдгийн *системийг* криминалистикийн хэл гэнэ [10] гэсэн бол профессор Б.Бат-эрдэнэ, криминалистикийн хэл гэдэг нь шинжлэх ухааны агуулгыг оновчтой илэрхийлж чадах ойлголт, тодорхойлолт, нэр томьёо, таних тэмдгийн *тогтолцоо* [2] гэжээ. Хууль зүйн доктор Б.Лхагвасүрэн, шинжилгээний хэл нь байцаан шийтгэх ажиллагаа болон криминалистикийн шинжилгээний орчинд нэг утгаар ойлговол зохих оновчтой, тодорхойлолт, нэршил, таних тэмдэгийн *тогтолцоо* [6] гэсэн байдаг.

Дээрх байдлаас үзэхэд, эрдэмтдийн байр суурь бага зэрэг зөрүүтэй байгаа хэдий ч үндсэн санаа нь шүүхийн шинжилгээний ойлголт, нэр томъёог эмх цэгцтэйгээр нэгдсэн тогтолцоонд оруулахад чиглэлсэн нь харагдаж байна. Иймд шинжилгээний нэр томъёонд тавигдаж буй дээрх шаардлагыг нарийн чанд сахиж мөрдсөнөөр шинжээчийн мэргэжлийн хэлийг төлөвшүүлэх, ойлголт, нэр томъёог *эмх цэгцэд оруулж, хэлбэршүүлэх,* цаашлаад *нэгдсэн тогтолцоонд* оруулах боломж бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, тухайн мэдлэгийн салбар болон шүүхийн шинжилгээний үйл ажиллагаа шинжилгээний ойлголт, нэр томъёоны нэгдсэн хэрэглэгдэхүүнтэй болох үндэс суурь тавигдана гэсэн үг юм.

Уг тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд, юуны өмнө, энэ чиглэлд тухайн салбарын эрдэмтдийн үзэл бодол, байр суурийг нэгтгэх,

эрдэмтэн, судлаачдын идэвхи санаачлагыг төрүүлж, бүх талаар дэмжих, хийж буй судалгаа, шинжилгээний ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэх зэрэгт анхаарал хандуулах хэрэгтэй. Чухамхүү үүнд шүүхийн шинжилгээний ойлголт, нэр томъёоны онолын ач холбогдол оршино.

б) Практикийн хүрээнд

Шинжилгээний ойлголт, нэр томъёоны практик ач холбогдлыг үндэслэлтэйгээр тодорхойлохын тулд, юуны өмнө, тэдгээрийг хэрэглэх явцад тулгарч буй хүндрэл бэрхшээлийг нээн илрүүлж, тэдгээрийн хэрхэн шийдвэрлэх арга замыг эрэлхийлсэн байх учиртай. Энэ хүрээнд дараах тулгамдсан асуудлыг онцлох нь зүйтэй гэж үзлээ. Тухайлбал:

- шинжилгээний ойлголт, нэр томъёог зориулалтын бусаар хэрэглэх;
- хуучирч, хэрэглээнээс гарсан нэр томъёог хэрэглэх;
- оновчгүй нэр томъёо сонгож хэрэглэх; ойлголт нэр томъёоны оноолтын болон хэрэглээний зарчим өөр хоорондоо зөрчилдөх г.м. [11]

Эдгээрийг харгалзан шинжилгээний ойлголт, нэр томъёог Монгол Улсын практикт хэрхэн оноон тогтоож, хэрэглэж буй байдалд дүн шинжилгээ хийхэд дараах нөхцөл тогтоогдож байна.

Хууль зүй салбарын дээд боловсролын байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны нэгж болон судлаач, эрдэмтдийн хувьд тус мэдлэгийн салбарыг *шинжлэн магадлахуй, шинжлэн магадлах ухаан, шүүхийн шинжилгээ, шүүх шинжилгээ*, харин шинжилгээ хийхтэй холбоотой үйл ажиллагааг *шүүхийн шинжилгээ, шүүх шинжилгээ, магадлах шинжилгээ, шинжлэн магадлах үйл ажиллагаа* гэх зэргээр олон хувилбараар оноон нэрлэж байна.

Тэгвэл практик байгууллагууд болон хууль тогтоомжийн хүрээнд, гол төлөв, “шүүхийн шинжилгээ”, “шүүх шинжилгээ” гэсэн оноолтыг хэрэглэж байна. Тухайлбал, 2010 онд батлагдсан “Шүүхийн шинжилгээний тухай” Монгол Улсын хуульд шүүхийн шинжилгээтэй холбоотой эдгээр ойлголт, нэр томъёог хуульчлан оноож, тэдгээрийн утгыг тайлбарласан байдаг [1].

Дээрх байдлаас үзэхэд тус мэдлэгийн салбарын нэрийн оноолт, өнөөг хүртэл нэг мөр жигдрээгүйн дээр шинжлэх ухаан нэр томъёо дан утгатай, товч бөгөөд тодорхой, нэр үгээр оноосон байна гэсэн зарчмын шаардлага тэр бүр мөрддөгүй болох нь харагдаж байна.

“Шинжлэн магадлахуй” гэсэн оноолтыг Б.Бат-Эрдэнэ, Б.Жаргалсайхан, Т.Бямбаа, Б.Лхагвасүрэн, Т.Очирбат зэрэг эрдэмтэд санал болгосон. Тухайлбал, хууль зүйн доктор Б.Жаргалсайханы үзэж байгаагаар, Шүүхийн шинжилгээний тухай хуулийг батлан гаргахдаа хууль тогтоогч монгол хэлний “шүүх” гэдэг үгийн “ялгах, шийдэх” гэсэн утгыг үл хэрэглэн “шүүхийн шинжилгээ” гэж нэрлэснийг хэл шинжлэлийн үүднээс авч үзэж, залруулах шаардлагатай бөгөөд цаашид 1930-аад онд хэрэгдэж байсан “шинжлэн магадлахуй” гэсэн нэрээр оноох нь оновчтой гэжээ [5].

Хууль зүйн ухааны доктор Б.Цолмонгийн хувьд тус мэдлэгийн салбарыг “шинжлэн магадлах ухаан” гэж нэрлэх талаар санал дэвшүүлсэний дээр “шүүх шинжилгээ” гэсэн оноолтын хувьд дараах тайлбарыг хийжээ. Тэрээр, шинжилгээ хийх ажиллагааны зорилго, зориулалт, чиг үүргийг тодотгосон “*шүүхийн*” (латинаар – *forencic*, оросоор – *судебный*) гэсэн тэмдэг нэрийг үйл үгээр орлуулах, цаашлаад харъяалал буюу хамаарал мэтээр буруу ташаа ойлгож, тайлбарлах хандлага ажиглагдсаар байна. Угтаа орос хэлний дүрмэнд нийлмэл нэр үгнээс хоршоо үг үүсгэхийн тулд, тэдгээрийг хооронд нь холбох зураасаар тусгаарлан товчилж болно гэсэн заалт бий. Уг дүрмээр, тухайлбал, “*судебная экспертная деятельность*” гэснийг “судебно-*экспертная деятельность*” гэж, “*научный технический процесс*” гэснийг “*научно-технический процесс*” гэх зэргээр хоршоо үг үүсгэдэг. Гэтэл эдгээр товчилсон үгийг монгол хэлнээ шууд утгачлан орчуулах, түүнчлэн “шүүх” гэсэн үгийн үйл үгээр илэрхийлсэн хувилбарыг сонгож хэрэглэх нь практикт төдийгүй тухайн мэдлэгийн салбарт сөрөг эрсдэлийг дагуулна [12] гэсэнтэй санал нэг байна.

Тэрээр цааш нь тус мэдлэгийн салбарын нэрийг хэрхэн оноож, хэрэглэх талаар мэтгэлцээн болон судалгааны үндсэн дээр эрдэмтэн, мэргэд өөрсдийн байр суурийг илэрхийлж, тодорхой санал дэвшүүлж байгаа нь талархууштай. Гэхдээ уг асуудалд хэтэрхий өнгөц хандах, улмаар бодол санаагаа бусдад тулгах гэсэн аливаа оролдлогыг өнөөгийн нөхцөлд хэрхэвч гаргаж болохгүй [12] гэжээ.

Эрдэмтний энэхүү байр суурийг тодруулбал, аливаа мэдлэгийн салбарыг бие даасан шинжлэх ухаан болохыг албан ёсоор хүлээн зөвшөөрөхийн тулд, юуны өмнө, түүний онол (нийтлэг болон тусгай онол), арга зүй, аргачлал (технологи) гэсэн бүтцийн үндсэн хэсгүүд бүрдсэн байх учиртай. Гагцхүү үүнийг үндэслэн тухайн шинжлэх ухааны нэрийг эцэслэн оноох ёстой. Энэхүү шаардлага шүүхийн шинжилгээнд мөн адил хамаарна. Гэтэл тухайн мэдлэгийн салбарын үндэслэгчдийн үзэж байгаагаар, өнөөгийн нөхцөлд, зөвхөн шүүхийн шинжилгээний нийтлэг онол боловсрогдсон бөгөөд харин түүний тусгай онол, арга зүй болон тодорхой төрлийн шинжилгээ хийх арга, аргачлал, технологитой холбоотой хэсэг боловсролтын шатанд байна гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Угтаа эдгээрийг нэг мөр эмхэлж цэгцэлсний эцэст буюу тус мэдлэгийн салбарыг бие даасан шинжлэх ухаан гэж хүлээн зөвшөөрсөн тохиолдолд түүний нэрийн оноолттой холбоотой асуудал зүй ёсоор хөндөгдөх учиртай. Иймд тухайн мэдлэгийн салбарын нэрийг дээрх зүй тогтлоос урьдаж оноох гэсэн оролдлого төдийлөн ач холбогдолгүй зүйл юм.

Гэхдээ тухайн мэдлэгийн салбарын нийтлэг онол нэгэнт боловсрогдож, хүлээн зөвшөөрөгдсөн тул тус салбарын эрдэмтэн,

судлаач, мэргэжилтний хувьд түүний үндсэн хэсгийн нэг болох шинжээчийн мэргэжлийн хэл, түүнийг бүрдүүлж буй ойлголт, нэр томъёотой холбоотой асуудлыг зайлшгүй судлавал зохино. Тухайлбал, энэ талаар, тус мэдлэгийн салбарын онолын үндэслэгчдийн нэг болох Т.В.Толстухина, аливаа шинжлэх ухааны онолын нэгэн адил шүүхийн шинжлгээний нийтлэг онол дан утгатай, ойлгомжтой, оновчтой оноосон шинжлэх ухааны ойлголт, нэр томъётой байх учиртай. Үүнд тулгуурлан бусад салбарын нийтлэг хэрэглээний онол, практикийн ач холбогдол бүхий нэр томъёонуудыг тус салбарын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн боловсруулах хэрэгтэй хэмээн зөвлөжээ [9].

Шинжилгээний ойлголт, нэр томьёог эмхэлж цэгцлэх, нэгдсэн тогтолцоонд оруулах, цаашлаад тэдгээрийг практик хэрэглээнд нэг мөр тогтож оруулахад толь бичиг болон тайлбар толь чухал үүрэгтэй. Энэ хүрээнд хууль зүйн доктор Б.Цолмонгийн боловсруулсан “Шүүхийн мөр судлалын шинжилгээний нэр томьёоны орос-монгол тайлбар толь бичиг”-ийг эс тооцвол өөр дорвитой бүтээл [7] хараахан байхгүй байна.

Үүнээс гадна аливаа шинжлэх ухааны нэр томъёог практик хэрэглээнд үр дүнтэй нэвтрүүлэхийн тулд, юуны өмнө, тухайн үг болон ойлголтын гарал үүслийг сайтар нягталж, нэг мөр тогтоох шаардлагатай. Учир нь практикт зарим ойлголт, нэр томъёог гадаад хэлнээс тэр хэвээр нь зээлдэн авч хэрэглэх шаардлагатай тулгардаг. Энэ тохиолдолд тухайн нэр томъёог монгол хэлний дүрмэнд нийцүүлэн хэр оновчтой буулгах асуудал зайлшгүй хөндөгдөх учиртай.

Эдгээр тулгамдсан асуудал, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх арга замыг тууштай эрэлхийлж нээснээр тухайн салбарын шинжилгээний ойлголт, нэр томъёоны практик ач холбогдлыг болитой тодорхойлох боломжтой гэж үзлээ.

Дүгнэлт

Шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн шүүхийн шинжилгээний хэл, түүнийг бүрдүүлж буй ойлголт, нэр томъёог эмхэлж цэгцлэх, хэлбэршүүлэх, нэгдсэн тогтолцоонд оруулах асуудал тус салбарын эрдэмтэн, судлаач болон шинжээч, мэргэжилтний хойшлуулшгүй зорилтын нэг байх учиртай.

Дээрх тулгамдсан асуудлыг шийдвэрлэснээр, нэгд, шинжээчийн дүгнэлтийн чанар, үр нөлөө болон нотолгооны үнэлэмж, ач холбогдол дээшилж, улмаар шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ахиц гарна. Хоёрт, шүүхийн шинжээч, мэргэжилтэн болон хууль зүйн бусад салбарын ажилтан, алба хаагчдын ажил мэргэжлийн болон хамтын ажиллагааны арга хэлбэр сайжирч бэхжинэ. Гуравт, сургалтын болон эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чанар, үр дүн дээшилнэ гэж үзлээ.

Санал

Дээрх байдалд тулгуурлан шүүхийн шинжилгээний ойлголт, нэр томъёоны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, тэдгээрийн онол, практикийн ач холбогдлыг дээшлүүлэхийн тулд дараах саналыг дэвшүүлэв. Үүнд:

- шүүхийн шинжилгээний ойлголт, нэр томъёог оноож тогтоох, нэгдсэн хэрэглэгдэхүүн боловсруулах ажилд тухайн салбарын эрдэмтэн, судлаач, практик ажилтнуудаас гадна нэр томъёо шинжлэлийн мэргэжилтэн нарыг татан оролцуулах замаар хийж гүйцэтгэдэг байх тогтолцоонд шилжих;
- Дотоод хэргийн их сургууль төдийгүй хууль зүйн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхэлж буй бусад их, дээд сургуулийн хичээлийн хөтөлбөрт “Мэргэжлийн харилцааны соёл, төлөвшил” нэртэй хичээлийг тусгайлан тусгаж, суулгах;

Дотоод хэргийн их сургууль, эсвэл Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн дэргэд (эсвэл бүтцэд) шинжилгээний ойлголт, нэр томъёонд дүн шинжилгээ болон судалгаа хийх ажлыг хариуцсан бие даасан нэгж байгуулах зэрэг болно.

Дээрх нэгжийг байгуулахын тулд дараах үндэслэл болон гарц гаргалгааг харгалзах боломжтой. Тухайлбал:

1) Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 37.4 дэх хэсэгт: “Шүүхийн шинжилгээний төв байгууллага нь дэргэдээ сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны нэгжтэй байж болно” гэж заасан бол, УИХ-аас батлсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 баримт бичигт тусгагдсан стратеги зорилтын хүрээнд “Шүүхийн шинжилгээний байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр” боловсрогдсон бөгөөд түүнд “Монгол Улсын хэмжээнд шинжлэн магадлах үйл ажиллагааг цогц хэлбэрээр хөгжүүлэх”-ээр заажээ. Үүнтэй уялдаад шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн дэргэд орон тооны бус шинжээч ажиллуулах, дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулахаа болсон. Иймд дээрх хууль тогтоомжийн холбогдох заалт болон стратеги зорилтын дагуу тус байгууллагын дэргэд шинжилгээний нэр томьёо хариуцсан (орон тооны бусбайж болно) нэгж байгуулах боломжтой;

2) АШУҮИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэд Нэр томъёоны зөвлөл ажилдаг. Иймд тус их сургуулийн туршлагыг судалж, Дотоод хэргийн их сургуулийн Эрдмийн зөвлөлийг түшиглэн нэр томьёоны зөвлөл байгуулах боломжтой.

Ашигласан эх сурвалж

1. Шүүхийн шинжилгээний тухай хууль. Уб. 2009.
2. Бат-эрдэнэ Б. Криминалистик. Уб. 2003.
3. Белкин Р.С. Курс советской криминалистики Т. II. М., 1978.

4. Винберг А.И., Малаховская Н.Т.Судебная экспертология (шүүхийн шинжилгээний нийтлэг онолын болон арга зүйн тулгамдсан асуудал) Б.А. Викторовын хянан тохиолдуулсан сургалтын гарын авлага. Волгоград. 1978. – 14 дэх тал.

5. Жаргалсайхан Б. Монгол Улс дахь криминалистикийн үнэр судлалын хөгжлийн онол, арга зүйн асуудал. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. Уб. 2015.

6. Лхагвасүрэн Б. Хүний эрхэд суурилсан шинжлэн магадлах үйл ажиллагаа: онол, арга зүйн асуудал. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. Уб. 2017.

7. Майлис Н.П., Цолмон Б. “Шүүхийн мөр судлалын шинжилгээний гол нэр томъёоны орос-монгол тайлбар толь”. – М.: Изд-во МоУ МВД России. 2019.

8. Очирбат Т. Шинжлэн магадлахуйн онол, эрх зүй, зохион байгуулалтын асуудал. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. Уб. 2019.

9. Толстухина Т.В. Современные тенденции развития судебной экспертизы на основе информационных технологий: Автореф. дисс. … д-ра юрид. наук. - М. 1999. - С. 16.

10. Хурцгэрэл Ж. Криминалистик. Уб. 2002.

11. Цолмон Б. Информационное обеспечение судебно-экспертной деятельности в Монголии Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. М., 2014.

12. Цолмон Б. Сүлд З. Шинжлэн магадлах ухааны хэл: тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам /Эрдэм шинжилгээний өгүүлэл. Хууль сахиулахуй сэтгүүл. Дугаар 4. Уб. 2017.

13. Юматов В.А., Нестеров О.А. Язык криминалистики и судебной экспертизы. Современное состояние и перспективы развития. // Н.И. Лобачевскийн нэрэмжит Нижегородын их сургуулийн сэтгүүл 2012. Дугаар 1. – 254-258 дахь тал.

14. Committee on identifying the needs of the Forensic Science Community, Strengthening Forensic Science in the United States :A.Path Forward. 2009. Washington.

ХЭТ ЯГААН ТУЯАНД СУУРИЛСАН АРГА, ХЭРЭГСЛИЙГ ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГТ АШИГЛАЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

CURRENT STATUS OF USING UV-BASED METHODS AND INSTRUMENTS FOR CRIME SCENE INSPECTION

Г.Ганхүлэг
Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Нийслэлийн шүүхийн шинжилгээний газрын ахлах шинжээч, цагдаагийн хошууч
Gankhuleg G.
Police Major, Senior expert, Capital Forensic Science Department, National Institute of Forensic Science, doctoral candidate, University of Internal Affairs

Хураангуй: Хэт ягаан туяанд суурилсан арга, хэрэгслийг хэргийн газрын үзлэг хийхэд ашиглаж байгаа өнөөгийн байдлыг судалж, цаашид дээрх арга хэрэгслийг криминалистикийн практикт хэрхэн ашиглах, хэрэглээг нэмэгдүүлэх боломжийн талаар авч үзсэн болно.

Abstract: The current situation with the use of UV-based methods in crime scene inspection is examined, as well as how to use these tools in forensic practice and the possibility of increasing their use.

Түлхүүр үгс: Хэт ягаан туяа, хэргийн газрын үзлэг, ул мөр, эд мөрийн баримт.

Keywords: Ultraviolet light, crime scene inspection, evidence, physical evidence.

Материаллаг ертөнцийн эд юмс, үйл явдал, үзэгдлүүд түгээмэл холбоотой байж, бие биенээсээ харилцан шалтгаалж байдаг тухай диалектик ерөнхий хууль ёсоор гэмт явдал нь бодит үнэний нөхцөлд үйлдэгдэж, тодорхой хэлбэрээр хүрээлэн буй орчинтойгоо холбоотой байж түүнд заавал тусгалаа /мөр/ үлдээдэг. Тэрхүү тусгалыг хууль зүйн үүднээс үнэлэхэд ихээхэн бэрхшээлтэй, зарим үед үнэлэх боломжгүй ye ч бас бий. Төр, нийгмийн амьдралын бүхий л хүрээ даяаршиж, шинжлэх ухаан, технологийн хөгжлийг дагаад шинэчлэгдэж буй нийгэм-улс төр, эдийн засгийн суурь өөрчлөлтүүд бүхий орчин үеийн нөхцөлд нийгмийн сөрөг үзэгдэл буюу гэмт явдалтай тэмцэхэд аливаа шинжлэх ухааны үр дүнтэй арга, хэрэгслийн хэрэгцээ эрс нэмэгдэж байна.

Хэргийн газрын үзлэг болон криминалистикийн шинжилгээнд байгаль, техникийн шинжлэх ухааны ололтыг өргөн ашиглах болсон нь криминалистикийн уламжлалт аргаар шийдвэрлэх боломжгүй байсан олон асуудлыг шийдвэрлэх боломжийг нээж өгсөн.[1] Тэр дундаа шинжлэн магадлах техник хэрэгслийн системд физикийн судалгааны аргууд

[1] Доржготов А. Хүний болон амьтны үсээр гэмт хэрэг илрүүлэх асуудал. Дэд эрдэмтний зэрэг горилсон бүтээл. Уб., 1995. 18 дахь тал

тэргүүлэх байр суурь эзэлдэг бөгөөд үүнд цахилгаан соронзон спектрийн судалгаа ордог.

Цахилгаан соронзон долгион бол цахилгаан соронзон хэлбэлзлийн орон зай дахь тархалт бөгөөд энэхүү долгионоор энерги дамжуулагддаг ба орон зайд ямар ч бодис зөөгчгүйгээр тархдаг. Мөн цахилгаан соронзон долгион нь вакумд тархах чадвартай бөгөөд вакум дотор болон агаарт ойролцоогоор секундэд 300,000 километрийн хурдтай тархдаг. Тиймээс цахилгаан соронзон долгион бол хөндлөн долгион бөгөөд бусад долгионы адил давтамж болон долгионы урттай байна. Давтамж нь орон зайн тодорхой цэг дээрх цахилгаан болон соронзон орны хүчлэгийн хугацааны өөрчлөлтийг илэрхийлнэ. Харин долгионы урт нь цахилгаан болон соронзон орны хүчлэгийн бүтэн долгионы багцын уртыг илэрхийлдэг.[2]

Цахилгаан соронзон долгионы давтамжийг герц /гц/ гэсэн нэгжээр илэрхийлдэг. Энэхүү нэгж нь цахилгаан соронзон долгион байдгийг анхлан баталсан эрдэмтэн Генрих Рудольф Герцийн нэрээр нэрлэгдсэн юм. Герц нь үелэн тохиолдож буй үзэгдлийн 1 секундэд тохиох давтамжийн тоогоор тодорхойлогддог.[3] Өөрөөр хэлбэл х герцийн давтамжтай гэдэг нь тухайн үзэгдэл 1 секундэд х удаа давтагдаж байгаа гэсэн үг. Жишээ нь: 1 герцийн давтамжтай гэдэг нь 1 секундэд 1 удаа давтагдаж байгаа гэсэн үг.

Цахилгаан соронзон долгионы уртыг нанометр /nm/ гэсэн хэмжих нэгжээр илэрхийлдэг. Нано гэдэг үг нь миллиардын нэг гэсэн утгатай ба нэг нанометр /nm/ нь 1/ 1,000,000,000 метртэй тэнцүү. Өөрөөр хэлбэл 1 нм = 0.000000001 метр юм. Үүнээс үзвэл нанометр нь маш жижигхэн юмыг хэмждэг хэмжигдэхүүн юм.

Бидний нүдэнд үзэгдэх гэрэл нь цахилгаан соронзон долгион, буюу цахилгаан соронзон спектрийн нэг хэсэг нь юм. Өөрөөр хэлбэл цахилгаан соронзон долгион тигээс хязгааргүй хүртэл ямар ч давтамжтай байж болно. Цахилгаан соронзон долгионыг давтамжаар нь ялгасныг цахилгаан соронзон долгионы спектр гэнэ.[4] Цахилгаан соронзон спектр нь долгионыхоо давтамжаас хамааран хэд хэдэн төрөлд хуваагдана. Үүнд:

- радио долгион
- бичил долгион
- хэт улаан туяа
- үзэгдэх гэрэл
- хэт ягаан туяа
- рентген туяа /X-ray/
- гамма туяа

[2] Физик. ДиДо. Монсудар. Уб., 2019. 255 дахь тал.
[3] https://mn.wikipedia.org
[4] Цэрэн Ч., Инжинааш Ц. Физик ба түүний нөхөд. Уб., 2011. 93 дахь тал.

Янз бүрийн урт болон давтамжтай цахилгаан соронзон долгионыг төрөл бүрийн зориулалтаар ашиглаж болно.

Зураг 1: Цахилгаан соронзон долгионы спектр



Хүний нүд цахилгаан соронзон долгионы $4,3*10^{14}$-$7*10^{14}$ гц хүртэл давтамжтай, 390-750 нм-ийн урттай гэрлийг мэдэрч чаддаг. Үүнийг үзэгдэх гэрэл буюу цагаан гэрэл гэнэ. Цагаан гэрэл нь маш олон төрлийн өөр өөр өнгийн гэрлийн цуглуулга юм. Цагаан гэрэл призм дундуур ороход хугарал үүсч олон тооны өнгө бүхий өнгийн тууз үүсэх ба үүнийг спектрийн өнгөнүүд гэдэг. Үүнийг бид солонго гэж нэрлэдэг бөгөөд энэхүү үзэгдлийг Английн эрдэмтэн Исаак Ньютон нээсэн байдаг. Гэрлийн давтамж болон долгионы урт нь үзэгдэх гэрлийн өнгийг тодорхойлдог.[5] Өөрөөр хэлбэл янз бүрийн урттай үзэгдэх гэрэл өөр өөр өнгөтэй байна. Үзэгдэх гэрэл буюу цагаан гэрэл янз бүрийн өнгөтэй гэрэл болж задрахыг өнгийн задрал буюу дисперс гэнэ. Цагаан гэрэл нь улаан, улбар шар, шар, ногоон, хөх, ягаан зэрэг спектр өнгөнүүдээс бүтдэг. Спектр өнгөнүүдийн гэрэл цааш задрахгүй ба бүх өнгө нийлэхэд эргээд цагаан гэрэл үүсдэг.

Спектрийн өнгө тус бүр бусад долгионы адил давтамж болон долгионы урттай бөгөөд давтамж, долгионы урт нь үзэгдэх гэрлийн өнгийг тодорхойлдог.

Хүснэгт 1: Гэрлийн спектрийн өнгөний долгион ба урт

ГЭРЛИЙН ТӨРӨЛ	ДОЛГИОНЫ ДАВТАМЖ /ГЦ/	ДОЛГИОНЫ УРТ /НМ/
Хэт улаан	**$0,1-3,8*10^{14}$**	**30,000-780**

[5] Физик. ДиДо. Монсудар. Уб., 2019. 313 дахь тал.

Үзэгдэх гэрэл	Улаан	$3,8\text{-}4,8*10^{14}$	780-620
	Улбар шар	$4,8\text{-}5*10^{14}$	620-600
	Шар	$5\text{-}5,3*10^{14}$	600-570
	Ногоон	$5,3\text{-}6,1*10^{14}$	570-490
	Цэнхэр	$6,1\text{-}7*10^{14}$	490-430
	Ягаан	$7\text{-}7,7*10^{14}$	430-390
	Хэт ягаан	**$7,7\text{-}300*10^{14}$**	**390-10**

Аливаа биет дээр туссан гэрлийн нэг хэсэг нь ойж, нэг хэсэг нь шингэж, нөгөө хэсэг нь нэвтэрдэг. Биет нь тусаж байгаа бүх гэрлийг шингээж байвал хар өнгөтэй харагддаг. Харин цагаан гэрлээр гэрэлтүүлэгдсэн буюу бүх спектрийн өнгөнүүдийг ойлгож байвал цагаан өнгөөр харагддаг. Иймээс биет нь түүн дээр ойсон эсвэл нэвтэрсэн гэрлийн хольцоос үүсэх өнгөтэй байна.[6]

Гэрлийн спектр, хүний нүдэн дэх гэрэл мэдрэгч эстэй харилцан үйлчлэлцсэнээр өнгө үүсдэг буюу өнгө гэдэг нь хүнд харагдаж буй мэдрэмж юм. Бидний мэдэрч буй биетийн өнгө нь гэрлийн эх үүсвэр ба гэрэл тусаж буй объект, материалын физик шинж чанараас, өөрөөр хэлбэл тухайн материалын гэрэл шингээлт, ойлголт зэргээс хамаарч өөр өөр өнгөөр харагддаг байна.

Үзэгдэх гэрлийн спектр нь улаанаас ягаан хүртэл байдгийг дээр дурдсан. Тэгвэл үзэгдэх гэрлийн гадна талд хүний нүдэнд үзэгдэхгүй гэрэл байдаг бөгөөд үүнийг хэт улаан /инфра улаан/ болон хэт ягаан /ультра ягаан/ гэрэл гэж нэрлэдэг. Хэт улаан гэрэл нь үзэгдэх гэрлээс илүү бага давтамжтай ба долгионы урт нь илүү их байна. Харин хэт ягаан гэрэл нь үүний эсрэгээр үзэгдэх гэрлээс илүү их давтамжтай ба бага долгионы урттай байдаг. /Хүснэгт 1/

Үүнээс хэт ягаан туяаны талаар дэлгэрэнгүй авч үзье. Хэт ягаан туяа гэдэг нь "ягаанаас илүү" гэсэн утгатай үг юм. Анх 1801 онд Германы физикч Johann Wilhelm Ritter хэт ягаан туяаны цацрагийг олж илрүүлсэн. Тэрээр цацраг туяанаас химийн идэвхжилтэй холбоотой үл үзэгдэх гэрлийг "исэлдүүлэх туяа" гэж нэрлэж байсан. Ихэнх хүмүүс 19-р зууны төгсгөл хүртэл "химийн туяа" гэсэн нэр томьёог хэрэглэж байсан бөгөөд "халууны цацраг" хэт ягаан туяа, "химийн туяа" гэж нэрлэж байгаад хэт ягаан туяаны цацраг болжээ.[7]

Хэт ягаан туяа буюу UV туяа нь үзэгдэх гэрлээс богино, рентген туяанаас урт долгионы урттай цахилгаан соронзон цацрал юм. Хэт ягаан

[6] Физик. ДиДо. Монсудар. Уб., 2019. 325 дахь тал
[7] https://mn.eferrit.com/

туяаны долгионы урт нь 10-400 нм, давтамж нь үзэгдэх гэрлээс өндөр давтамжтай буюу $5*10^{17}$ гц хүртэл үргэлжилнэ.[8]

Хэт ягаан туяаны фотонууд үзэгдэх гэрлээс илүү их энергитэй байдаг бөгөөд ионжуулдаг цацрагтай тул молекулд химийн урвалыг өдөөж , олон бодисыг гэрэлтүүлдэг буюу зарим материалыг флюресцент[9] эсвэл фосфоресц үүсгэхэд хүргэдэг.

Аливаа хангалттай халуун бие нь хэт ягаан туяа (хар биений цацраг) ялгаруулдаг. Тиймээс нар нь хэт ягаан туяаны гол үүсгүүр[10] буюу их хэмжээний дулаан ялгаруулдаг бусад процессоос хэт ягаан туяа нь үүсдэг. Мөн хэт ягаан туяа нь хар гэрэл , мөнгөн усны уур, чийдэнгийн технологиор үйлдвэрлэгддэг.

Нарны гэрлийг 100% гэж үзвэл дэлхийн агаар мандалд ороход 50% нь хэт улаан туяаны цацраг, 40% нь гэрлийн тусгал, 10% нь хэт ягаан туяаны цацраг байдаг. Гэсэн хэдий ч нарны хэт ягаан туяаны 77% нь богино долгионы урттай байдаг. Нарны хэт ягаан туяа нь хамгийн бага энерги хүртэл гурван ангилалд хуваагддаг.

- UV-A: 320-400 нм-ийн хоорондох долгионы урт
- UV-B: 290-320 нм-ийн хоорондох долгионы урт
- UV-C: 220-290 нм-ийн хоорондох долгионы урт

Дэлхий дээр ирдэг нарны хэт ягаан туяаны дийлэнх хэсэг нь хэт ягаан туяаны цацраг туяа, бусад цацраг туяа нь агаар мандалд озоноор шингэдэг буюу агаар мандалд хүчилтөрөгчөөр хаагддаг бөгөөд дэлхийн гадаргуу дээр хүрдэггүй. 280-315 нм-ийн хоорондох хэт ягаан туяа нь озоны давхаргад хаагдаж, амьд организмд учрах хохирлоос сэргийлдэг. Нарны хэт ягаан туяаны дөнгөж 3% нь дэлхий дээр ирдэг.

Хэдийгээр хэт ягаан туяа нь хүний нүдэнд үл үзэгдэх боловч нарны туяанд удаан хугацаагаар өртсөнөөс болж шарах, түлэгдэх үед бид түүний арьсанд үзүүлэх нөлөөг мэдэрдэг. Хэт ягаан туяаны бусад хортой нөлөө нь хорт хавдар, ялангуяа арьсны хорт хавдар үүсгэх явдал юм. Гэсэн хэдий ч хүн ба бүх амьд организмд Д аминдэмийг үүсгэдэг 295-297 нм-ийн хүрээнд хэт ягаан туяа хэрэгтэй байдаг.

Олон улсын ISO-21348 стандартын дагуу хэт ягаан туяа нь хэд хэдэн мужид хуваагддаг.[11]

[8] Цэрэн Ч., Инжинааш Ц. Физик ба түүний нөхөд. Уб., 2011. 94 дэх тал.
[9] Флюресценц бол эрчим хүчийг цахилгаан соронзон цацраг, хэт ягаан туяаны гэрэлд нийлүүлдэг тохиолдолд үүсдэг гэрэлтэлт юм.
[10] ШУТИС. Физик 2. Уб., 2015. 190 дэх тал
[11] https://mn.eferrit.com/

Хүснэгт 2: Хэт ягаан туяаны муж

Нэр	Товчлол	Долгионы урт (nm)	Photon Energy (eV)	Бусад нэрс
А хэт ягаан туяа	UVA	315-400	3.10-3.94	урт долгион, хар гэрэл (озоноор шингээгүй)
В хэт ягаан туяа	UVB	280-315	3.94-4.43	дунд зэрэг (ихэнхдээ озоноор шингээгдсэн)
С хэт ягаан туяа	UVC	100-280	4.43-12.4	богино долгион (бүрэн озоноор шингээж авдаг)
Хэт ягаан туяаны ойролцоо	NUV	300-400	3.10-4.13	загас, шавьж, шувуу, зарим хөхтөн амьтдын харагдах байдал
Дундаж хэт ягаан туяа	MUV	200-300	4.13-6.20	
Алс хэт ягаан туяа	FUV	122-200	6.20-12.4	
Лайман - фаулын устөрөгч	H Lyman-α	121-122	10.16-10.25	121.6 нм-ийн устөрөгчийн спектрийн шугам; богино долгионы уртад иончлох
Вакуум хэт ягаан туяа	VUV	10-200	6.20-124	Хүчилтөрөгчөөр шингэсэн боловч 150-200 нм нь азотоор дамжин өнгөрч болно
Хэт хэт ягаан туяа	EUV	10-121	10.25-124	Үнэндээ ионжуулдаг цацраг нь агаар мандалд шингэсэн байдаг

Хэргийн газраас нотлох баримт цуглуулах явдал нь аливаа гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагааны тэргүүлэх чиглэл юм. Гэмт хэргийг илрүүлэхийн тулд түүнтэй шалтгаант холбоотой биет нотлох баримтууд буюу ул мөр, эд мөрийн баримтуудыг хэргийн газрын үзлэгээр хуулийн хүрээнд бүрэн цуглуулах шаардлагатай байдаг. Энэ нь эд мөрийн баримт илрүүлэх, бэхжүүлэх техник хэрэгсэл, тэдгээрийг хэрхэн ашиглахаас ихээхэн шалтгаална.

Ямар нэгэн үйлдлийн улмаас тухайн орчинд бий болсон бүх төрлийн өөрчлөлт, хөдөлгөөнийг мөр гэж ойлгох ба тухайн орчинд шинээр бий болсон, тэндээс алга болсон, байсан зүйл солигдсон гэх мэт хэлбэрээр илэрч болно. Аливаа юмс жирийн үйлдэл, хөдөлгөөнийхөө үр дүнд хаана ч, хэзээ ч мөрөө үлдээдэг.

Гэмт үйлдлийн мөр гэдэг нь нийгэмд аюултай үйлдлийн улмаас бий болсон, тухайн хэргийг нотолж, шийдвэрлэхэд ач холбогдолтой бүхий л зүйлийг хэлнэ[12]. Гэмт үйлдлийн мөр нь хэргийн газар хамгийн түгээмэл байдаг бөгөөд түүнчлэн сэжигтэн, хохирогчийн бие, хувцас, ачаа, тээврийн хэрэгсэл, орон байр, компьютерийн төхөөрөмж, санах ой зэрэгт үүсдэг.

Онолын хувьд хэргийг газар үүссэн мөрийг мэдрэгдэх түвшинээр нь үзэгдэх мөр, бүдэг үзэгдэх мөр, үл үзэгдэх мөр гэж ангилдаг. Үзэгдэх мөр гэж илрүүлэхэд тусгай барил шаардлагагүй, энгийн нүдэнд ажиглагдах мөр, бүдэг үзэгдэх мөр гэж дэвсгэр өнгөнд далдлагдсан эсвэл жижиг хэмжээтэй мөр, үл үзэгдэх мөр гэж илрүүлэхийн тулд тусгай барил, хэрэгсэл шаардагдах далдлагдсан эсвэл хэт жижиг мөр[13]-ийг ойлгодог.

Практикаас ажиглахад хэргийн газар ихэвчлэн бүдэг болон үл үзэгдэх мөр тохиолддог бөгөөд хэргийн газар ажиллаж буй шинжээч мэргэжилтэн нь ул мөр, эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлэхэд тохирсон техник хэрэгслийг ашиглах шаардлага гардаг. Гэвч өнөөдрийн бодит байдалд ихэвчлэн энгийн цагаан гэрлийн тусгал, чиглэлийг өөрчлөх замаар болон хэрэглэж дадсан уламжлалт аргуудыг ашиглан ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж бэхжүүлж байна.

Орчин үед аливаа шинжлэх ухаан шийдвэрлэх асуудлынхаа хүрээнд судалгаа, шинжилгээ шаардсан томоохон асуудлыг дангаараа бие даан шийдвэрлэх боломжгүй бөгөөд хэд хэдэн төрлийн шинжлэх ухааны ололт амжилтыг ашигласнаар сая шийдвэрлэх боломжтой болдог. Үүний адил криминалистикийн шинжлэх ухааны онол ёсоор байгаль, техник ба нийгэм судлалын шинжлэх ухаануудын ололтыг ашиглан нотлох баримт цуглуулах, шинжлэх, ашиглахад хэрэглэж байгаа криминалистикийн хэрэгсэл, тактикийн арга барил, арга зүйн зөвлөмжийг улам сайжруулж шинийг боловсруулах нь криминалистикийн шинжлэх ухааны тусгай зорилгуудын нэг хэсэг юм. Энэ талаар анх Австрийн хуульч Гансс Гросс өөрийн бүтээлдээ криминалистик бол физик, хими, биологи зэрэг суурь шинжлэх ухааны зайлшгүй холбоог нотлон гэмт хэргийг илрүүлэх, нотлох шинжлэх ухааны шинэ арга, чиглэл мөн[14] гэж өгүүлжээ.

19 дүгээр зууны эхэн үед Францын эрдэмтэн Ж.Леконт спектрийн хэт улаан туяаны мужид ажиллах шингээлтийн шинжилгээг онцгой ирээдүйтэй гэж үзэж хэт ягаан туяаны спектр нь юуны өмнө молекулын спектр мөн. Энэ нь молекулын бүтцийн өчүүхэн өөрчлөлтийг тусгадаг. Ийм учраас өөр хоорондоо атомынхаа ялгаагаар ялгагддаг нэгдлүүдийг адилтгахад

[12] Лхагвасүрэн Б. Мөр.УБ., 2015. 7 дахь тал
[13] Лхагвасүрэн Б. Мөр.УБ., 2015. 10 дахь тал
[14] Доржготов А. Хүний болон амьтны үсээр гэмт хэрэг илрүүлэх асуудал. Дэд эрдэмтний зэрэг горилсон бүтээл. Уб., 1995. 15 дахь тал

сонирхолтой бөгөөд хүчирхэг арга юм[15] гэж дүгнэсэн байна. Мөн ОХУ-ын Криминалистикийн лабораторид анх удаа физикийн аргыг ашиглан захидалд шинжилгээ хийж эхэлсэн.[16]

Нотлох баримтыг судлахад хэт ягаан туяаг ашиглах санааг анх Америкийн физикч, Балтимор хотын их сургуулийн профессор Роберт Уильямс Будд гаргасан бөгөөд 1906 онд баримт бичгийг хэт ягаан туяанд буулгах аргыг боловсруулж хэвлүүлжээ. Үүний дараа 1914 онд С.М.Потапов, А.Г.Кегель нарын эрдэмтэд баримт бичгийн шүүх шинжилгээнд хэт ягаан туяан дахь люминесценцийн анализыг ашиглах туршилтынхаа талаар мэдээлэлж байсан бөгөөд 1915-1963 онуудад хэт ягаан туяаг гэмт хэрэг мөрдөн шалгах практикт ашиглах боломжийн талаар хэвлүүлж байжээ.[17]

1943 оноос криминалистик өндөр хөгжсөн орны шинжээчид бодисын люминесценцээр, өөрөөр хэлбэл зарим бодисын хэт ягаан, хэт улаан цацрагийн үйлчлэлээр гэрэлтэх шинжээр нь хэргийн газрын үзлэгээр ул мөр илрүүлэх болон шинжилгээ хийхэд ашиглаж иржээ.[18]

Өнөөдрийн байдлаар олон улсад зөвхөн гэмт явдалтай тэмцэхэд төдийгүй хууль сахиулах бүхий л үйл ажиллагаанд шинжлэн магадлахуйн олон чиглэлээр гэрлийн спектрт үндэслэсэн /хэт ягаан туяанд суурилсан арга хэрэгсэл/, техник тоног төхөөрөмжийг ашиглаж байна. Энэ төрлийн судалгаа, шинжилгээг хийж, гэрлийн спектрийн чиглэлийн дагнасан техник, хэрэгсэл, программ хангамж зохион бүтээдэг байгууллагууд ажиллаж байна. Тухайлбал: Их Британи, Швейцар, Канад, АНУ-д “Fusion Forensics”, “Forensic Technology”, “Ultra Electronics Forensic Technology” зэргээр шинжлэх магадлах технологийн чиглэлээр дагнасан үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудыг дурдаж болохоор байна.

Гадаад орны дээрх туршлагаас харахад хэргийн газрын үзлэг болон магадлах шинжилгээнд байгаль, техникийн шинжлэх ухаан тэр дундаа физикийн шинжлэх ухааны /цахилгаан соронзон спектрийн/ ололт амжилтыг өргөн хүрээтэй ашиглах болсон нь өмнө нь бидний шийдвэрлэх боломжгүй байсан олон асуудлыг шийдвэрлэх боломжийг нээж өгчээ.

Манай улсын хувьд анх 1975 онд БНАГУ /хуучин нэрээр/-ын тусламжтайгаар физик, хими, биологийн лаборатори байгуулагдаж эдгээр лабораторид атомын цацралын спектрийн задлан шинжилгээ, молекулын шингээлтийн спектрийн задлан шинжилгээ, лазерын бичил спектрийн

[15] Мөн бүтээл. 16 дахь тал
[16] Терзиев Н.В., Киричинский Б.Р., Эйсман А.А., Геркен Е.Б. Физические иследования в криминалистике. М.,1948
[17] https://www.dissercat.com/
[18] Авидхүү Д. Мөр илрүүлэхэд гэрлийн спектрийн ашиглалтын нэмэгдүүлэх нь. Хууль зүйн магистрын зэрэг горилсон бүтээл. Уб., 2013. 18 дахь тал.

задлан шинжилгээ, хий, шингэн, нимгэн үеийн хроматографи, электрофорез, хэт улаан болон нил ягаан туяаны шинжилгээ, төрөл бүрийн зориулалттай оптик дуранбай, криминалистикийн шинжилгээнд зориулсан тусгай багаж, хэрэгсэл зэрэг өндөр мэдрэх чадвартай шинжилгээний аргыг нэвтрүүлсэн юм.[19] Энэ нь манай улсад анх удаа гэрлийн спектрийг ашиглаж магадлах шинжилгээ хийх боломжийг бүрдүүлсэн байна. Сүүлд 2008 онд ШШҮХ-ийн Бичиг техник, бичиг судлалын лабораторид Швейцар улсаас “Projectina” олон төрлийн гэрлийн спектр бүхий төхөөрөмжийг оруулж ирсэн бөгөөд өнөөдрийг хүртэл криминалистикийн шинжилгээнд ашиглаж байна.

Харин 2012 онд БНХАУ-аас ШШҮХ-д “KY-55XD7” маркийн олон төрлийн гэрлийн долгионт гэрэл үүсгэгч, улбар шар болон улаан өнгийн гэрэл шүүгч нүдний шил болон линз, гэрэлд өдөөгддөг 4 өнгийн нунтаг, багс бүхий хэргийн газрын үзлэгийн цүнх бэлэглэсэн ба үүнийг ШШҮХ-ийн Криминалистикийн шинжилгээний хэлтэс, нийслэлийн 9 дүүргийн криминалистикийн шинжилгээний лаборатори, 21 аймгийн шүүхийн шинжилгээний албадад тус бүр нэг нэгийг өгсөн нь криминалистикийн шинжээч, мэргэжилтнүүд хэргийн газрын үзлэгт олон төрлийн гэрлийн долгионы тусгалыг ашиглан ул мөр, эд мөрийн баримт илрүүлэх техникийн боломжийг бүрдүүлж өгсөн юм.[20]

Аливаа хэргийн газраас нотлох баримтыг илрүүлэх хамгийн чухал аргын нэг бол зохих гэрэлтүүлэг ашиглах явдал юм. Ихэнх хэргийн газар ул мөр, эд мөрийн баримтыг цагаан гэрэлд, энгийн нүдээр хайх замаар илрүүлдэг. Хэргийн газар гэрэлтүүлгийн өөр өөр эх үүсвэрийг ашиглах нь ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлэхэд чухал ач холбогдолтой ба үр дүнтэй арга, хэрэгсэл болдог.

Хэргийн газрын үзлэгт ашигладаг гэрлийн эх үүсвэрүүд ихэвчлэн цагаан гэрлээс бүрддэг бол нүдэнд үл үзэгдэх ул мөрийг илрүүлэхийн тулд тодорхой гэрлийн эх үүсвэр бүхий тусгай төхөөрөмжүүдийг ашиглаж болно.

Зарим төрлийн ул мөрийг илрүүлэхэд хэт ягаан туяаг ашиглах нь ихээхэн үр дүнтэй. Тухайлбал: будаг, утаслаг материал, хөрс, барилгын материал, эрдэс чулуулаг, шил, төрөл бүрийн химийн бодис, шатах, тослох материал зэргийн бичил хэсгүүд, шүлс, хөлс болон биологийн гаралтай бусад ялгадас зэргийг илрүүлэхэд хэт ягаан туяа чухал нөлөөтэй.[21] Тиймээс хэт ягаан туяаны физик шинж чанар, бусад биет

[19] Доржготов А. Хүний болон амьтны үсээр гэмт хэрэг илрүүлэх асуудал. Дэд эрдэмтний зэрэг горилсон бүтээл. Уб., 1995. 18 дахь тал

[20] Авидхүү Д. Мөр илрүүлэхэд гэрлийн спектрийн ашиглалтын нэмэгдүүлэх нь. Хууль зүйн магистрын зэрэг горилсон бүтээл. Уб., 2013. 25 дахь тал.

[21] Мөн бүтээл. 53 дахь тал.

болон бодист үзүүлэх нөлөө зэргийг харгалзан энэ төрлийн техник хэрэгслийг хэргийн газрын үзлэгт өргөнөөр ашиглах бүрэн боломжтой юм.

Манай улсад шинжлэн магадлах ухааны чиглэлээр бичигдсэн ном, сурах бичиг, бүтээлүүдэд хэргийн газар болон шинжилгээнд аливаа мөртэй ажиллахад төрөл бүрийн гэрэлтүүлэх хэрэгсэл ашиглаж болох талаар цухас дурдсаныг эс тооцвол төрөл бүрийн гэрлийн спектрийн онцлог, төрөл, бусад биет болон бодист үзүүлэх нөлөө, тэдгээрийн ач холбогдол зэрэг физик, химийн шинж чанар, мөртэй ажиллахад гэрлийн спектрийг ашиглах арга зүй, анхаарах асуудлын чиглэлээр хийгдсэн дорвитой судалгаа байхгүй байна.

Хэргийн газрын үзлэг хийхэд хэт ягаан туяанд суурилсан арга хэрэгслийг хэрэглэж байгаа өнөөгийн байдлыг бодитой судлах зорилгоор ШШҮХ-ийн харьяа нэгжүүд болох Криминалистикийн шинжилгээний газар, Нийслэлийн шүүхийн шинжилгээний газар, Шүүх эмнэлгийн газар, Тусгай шинжилгээний газар, аймгийн шүүхийн шинжилгээний албадад ажиллаж байгаа нийт 90 шинжээч, мэргэжилтнээс хэргийн газар үзлэг хийхдээ хэт ягаан туяаны гэрэл хэрэглэж ул мөр, эд мөрийн баримт илрүүлж байгаа байдал, хэт ягаан туяаны гэрлийн талаарх ойлголт зэргийг тодруулж судалгаа авч нэгтгэв.

Судалгаанд оролцогчдын 81,1%-нь криминалистикийн шинжээч, 8,9%-нь шинжээч эмч, 10%-нь бусад буюу тусгай чиглэлийн /химич, физикч гэх мэт/ мэргэжилтэй байсан бөгөөд 70 орчим хувь нь Нийслэлийн шүүхийн шинжилгээний газар болон аймгийн шүүхийн шинжилгээний албадад, 21,1%-нь Криминалистикийн шинжилгээний газарт, 8,9%-нь бусад нэгжид ажилладаг ба ихэвчлэн 5-15 жил ажиллаж байгаа албан хаагчид судалгаанд хамрагдсан байна.

Дээрх оролцогчид нь бүгд хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцдог албан хаагчид байсан ба тал хувь нь буюу 54,4%-нь байгууллагаас албан хэрэгцээнд хангалтаар өгсөн хэргийн газрын үзлэгийн цүнхийг, 20%-ны хувиараа бэлтгэсэн хэргийн газрын үзлэгийн цүнхийг, 25,6%-нь албаны болон хувийн хэргийн газрын үзлэгийн цүнхийг үүрэг гүйцэтгэхдээ ашиглаж байна.

Судалгаанд оролцогчид хэргийн газарт үзлэгийн цүнхэндээ /давхардсан тоогоор/ 93,3%-нь цагаан гэрэлтэй, 51,1%-нь хэт ягаан туяаны гэрэлтэй, 2,2% нь хэт улаан болон олон төрлийн гэрлийн долгион үүсгэгч төхөөрөмжтэй гэсэн хариултыг өгсөн бөгөөд хэргийн газрын үзлэг хийхэд хэт ягаан туяаны гэрлийг 8,9% нь тогтмол хэрэглэдэг, 68,9%-нь хааяа хэрэглэдэг, 22,2%-нь огт хэрэглэдэггүй гэсэн байна.

Мөн судалгаанаас хэт ягаан туяаны гэрлийг хэргийн газарт ихэвчлэн биологийн гаралтай ул мөр, эд мөрийн баримт илрүүлэхэд ашигладаг ба

гарын мөр болон бусад төрлийн мөрийг илрүүлэхэд хамааяа ашигладаг гэсэн үр дүн харагдаж байв.

Судалгаанд оролцогчид буюу шинжээч, мэргэжилтнүүдийн хэт ягаан туяаны гэрлийн тухай ерөнхий ойлголт, хэргийн газар мөртэй ажиллахад хэт ягаан туяаны гэрлийг ашиглах ач холбогдлын талаарх байр суурийг тодруулахад хэргийн газрын үзлэгт хэт ягаан туяаны гэрэл хэрэглэснээр ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлэх боломж нэмэгдэнэ гэж дийлэнх хэсэг буюу 77,8% нь хариулсан бол, бусад хэсэг нь буюу 22,2% нь боломж муутай буюу энэ талаар огт мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн байна. Мөн хэргийн газрын үзлэг хийхэд өөрсдийн ашигладаг хэт ягаан туяаны гэрлийн долгионы уртыг 73,3% нь мэдэхгүй байна, 8-9% нь 10-100 нм, 100-280 нм, 315-400 нм-ий урттай гэж хариулсан байна.

Эцэст нь хэргийн газрын үзлэгт хэт ягаан туяаны гэрлийн хэрэглээг нэмэгдүүлэх талаарх саналыг асуухад судалгаанд оролцогчдын 34,4% нь энэ төрлийн судалгааг хийх шаардлагатай, мөн дээрх чиглэлээр сургалт явуулсны үндсэн дээр хэт ягаан туяаны гэрлийг хангалтаар өгч, аливаа мөртэй ажиллахад хэт ягаан туяаны гэрлийн долгионыг ашиглах хэрэглээг нэмэгдүүлэх нь зүйтэй гэсэн саналыг өгсөн байна.

Дээрх судалгаанаас дүгнэхэд бид хэргийн газрын үзлэг хийж ул мөр, эд мөрийн баримт илрүүлж, бэхжүүлэх буюу мөртэй ажиллахдаа ихэвчлэн цагаан гэрлийн ашигладаг бөгөөд бусад гэрлийн спектр болон долгионыг өргөн хүрээтэй ашиглахгүй байна. Энэ нь нэгдүгээрт: мөртэй ажиллахад гэрлийн спектрийг ашиглах арга зүй, анхаарах асуудлын чиглэлээр хийгдсэн дорвитой судалгаа байхгүйгээс, хоёрдугаарт: хэргийн газар мэргэжилтнээр ажиллаж байгаа шинжээчийн гэрлийн долгион, түүний төрөл, ашиглах боломж, хэрэглэх мэдлэг чадвар дутмаг байдлаас, гуравдугаарт: энэ төрлийн судалгаанд үндэслэж хийгдсэн арга аргачлалгүй, мэдлэгийн суурь хичээл болон албаны сургалтын үйл ажиллагаа байдаггүй, дөрөвдүгээрт: шаардлага хангасан техник хэрэгслийн хангалт байдаггүй буюу тогтмол хэрэглэдэггүй зэрэг хэд хэдэн шалтгааны улмаас хэргийн газар төдийгүй бүх төрлийн мөртэй ажиллах, шинжилгээ хийхэд хэт ягаан туяанд суурилсан арга, хэрэгслийг ашиглаж чадахгүй байна.

Хэдийгээр харилцан адилгүй орчинд аливаа эд зүйл, бодис, материалын онцлог буюу физик болон химийн шинж чанар, төлөв байдал, хэмжээ, гэрлийн долгионыг шингээх, ойлгох чадвар, мөн тусгаж буй гэрлийн долгионы онцлог, давтамж, урт зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж тухайн ул мөр, эд мөрийн баримт илүү тодорч буюу илрэх бүрэн боломжтой байдаг. Энэ нь мөрийг гэрлийн спектрийн тусламжтайгаар илрүүлэх нь нарийн төвөгтэй, мэдлэг чадвар, цаг зав, уйгагүй хөдөлмөр, туршилт судалгаа, арга шаардсан ажиллагаа юм.

Дүгнэлт

Олон улсад зөвхөн гэмт хэргийн газрын үзлэг хийхэд төдийгүй шинжлэн магадлах бүхий л үйл ажиллагаанд хэт ягаан туяанд суурилсан олон арга, хэрэгслийг өргөн хүрээтэй ашиглаж байна.

Шинжлэх ухаан техник, технологийн хөгжлийг дагаад хэт ягаан туяаг ашиглах техникийн дэвшил ихээхэн өөрчлөгдөж, хэт ягаан туяаг ашиглах шинэ аргууд гарч ирсэн төдийгүй энэ ангиллын техник, шинжлэн магадлах арга хэрэгсэл, арга барилд хандах хандлага өөрчлөгдсөөр байна.

Криминалистикийн шинжлэх ухааны онол ёсоор байгаль, техник ба нийгэм судлалын шинжлэх ухаануудын ололтыг ашиглан нотлох баримт цуглуулах, шинжлэх, ашиглахад хэрэглэж байгаа криминалистикийн хэрэгсэл, тактикийн арга барил, арга зүйн зөвлөмжийг улам сайжруулж шинийг боловсруулах нь криминалистикийн шинжлэх ухааны тусгай зорилгуудын нэг хэсэг юм. Энэ зорилтын хүрээнд физикийн шинжлэх ухааны ололт амжилтын /цахилгаан соронзон долгионы спектрийн/ нэг төрөл болох хэт ягаан туяанд суурилсан арга, хэрэгслийг хэргийн газрын үзлэгээр ул мөр, эд мөрийн баримт илрүүлэх буюу аливаа мөртэй ажиллахад ашиглах шаардлагатай байна.

Хэргийн газрын үзлэг хийж ул мөр, эд мөрийн баримт илрүүлж, бэхжүүлэх буюу аливаа мөртэй ажиллахад ихэвчлэн цагаан гэрлийн ашигладаг бөгөөд бусад гэрлийн спектрийн долгионыг буюу хэт ягаан туяанд суурилсан арга, хэрэгслийг бараг ашиглахгүй байна. Үүнийг судлаачийн зүгээс дараах байдлаар дүгнэж байна.

- нэгдүгээрт: мөртэй ажиллахад гэрлийн спектрийг ашиглах арга зүй, анхаарах асуудлын чиглэлээр хийгдсэн дорвитой судалгаа байхгүй,
- хоёрдугаарт: хэргийн газар мэргэжилтнээр ажиллаж байгаа шинжээчийн гэрлийн долгион, түүний төрөл, ашиглах боломж, хэрэглэх мэдлэг, чадвар дутмаг байдал,
- гуравдугаарт: энэ төрлийн судалгаанд үндэслэж хийгдсэн арга аргачлалгүй, мэдлэгийн суурь хичээл болон албаны сургалтын үйл ажиллагаа байдаггүй,
- дөрөвдүгээрт: шаардлага хангасан техник хэрэгслийн хангалт байдаггүй буюу тогтмол хэрэглэдэггүй,

зэрэг хэд хэдэн шалтгааны улмаас хэргийн газар төдийгүй бүх төрлийн мөртэй ажиллахад, шинжилгээ хийхэд хэт ягаан туяанд суурилсан арга, хэрэгслийг ашиглаж чадахгүй байна.

Манай улсад шинжлэн магадлах ухааны чиглэлээр бичигдсэн ном, сурах бичиг, бүтээлүүдэд хэргийн газар болон шинжилгээнд аливаа мөртэй ажиллахад төрөл бүрийн гэрэлтүүлэх хэрэгсэл ашиглаж болох талаар цухас дурдсаныг эс тооцвол төрөл бүрийн гэрлийн спектрийн

онцлог, төрөл, бусад биет болон бодист үзүүлэх нөлөө, тэдгээрийн ач холбогдол зэрэг физик, химийн шинж чанар, мөртэй ажиллахад гэрлийн спектрийг ашиглах арга зүй, анхаарах асуудлын чиглэлээр хийгдсэн дорвитой судалгаа байхгүй байна. Тиймээс шинжлэн магадлах ухааны ном зохиол, сурах бичиг, бүтээлүүд дээрх хэт ягаан туяаг мөртэй ажиллах болон магадлах шинжилгээнд ашиглах тухай одоо байгаа боломжуудыг нэгтгэн дүгнэж, хэт ягаан туяанд үндэслэсэн техникийн болон шинжлэн магадлах арга, хэрэгслийг судлах, хөгжүүлэх, цаашдын төлөвийг тодорхойлох шаардлагатай байна.

Мөн хэт ягаан туяаг криминалистикийн практикт нотлох баримтын материаллаг эх үүсвэрийг цуглуулах, шинжлэх, мөрдөн шалгах, гэмт хэргийг хөдөлшгүй нотлох баримтаар тогтоох, урьдчилан сэргийлэх зорилгоор зэрэг өргөн хүрээтэй ашиглах бүрэн боломжтой юм.

Санал

Дээрх дүгнэлтэд үндэслэн хэт ягаан туяанд суурилсан арга хэрэгслийг хэргийн газрын үзлэгт ашиглах талаар дараах саналын дэвшүүлж байна.

1. Шинжлэн магадлах ухааны ном зохиол, сурах бичиг, бүтээлүүд дээрх мөртэй ажиллах болон магадлах шинжилгээнд хэт ягаан туяаг ашиглах тухай одоо байгаа боломжуудыг нэгтгэн дүгнэж, хэт ягаан туяанд үндэслэсэн техникийн болон шинжлэн магадлах арга, хэрэгслийг судлах.
2. Хэргийн газар мэргэжилтнээр оролцож байгаа шинжээчдэд гэрлийн долгион, түүний төрөл, ашиглах боломж, хэрэглэх мэдлэг чадварыг олгох, нэмэгдүүлэх үүднээс криминалистикийн шинжээч мэргэжлээр суралцагч нарт суурь мэдлэгийн буюу судлах хичээлийн хэлбэрээр, албан хаагчдад албаны сургалт, арга зүйн зөвлөмж хэлбэрээр сургалт зохион байгуулах.
3. Бусад улс оронд хэргийн газрын үзлэгт үр дүнтэй ашиглаж байгаа хэт ягаан туяанд суурилсан гэрлийн үүсгүүр бүхий шаардлага хангасан техник хэрэгслийг судалж, практик үйл ажиллагаандаа нэвтрүүлэх буюу тогтмол хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх.
4. Байгууллагын хэмжээнд байгалийн шинжлэх ухааны чиглэлээр мэргэжил эзэмшсэн боловсон хүчнийг нэмэгдүүлэх зэрэг болно.

Ашигласан эх сурвалж

Ном сурах бичиг

1. Физик. ДиДо. Монсудар. Уб., 2019 он
2. Цэрэн Ч., Инжинааш Ц. Физик ба түүний нөхөд. Уб., 2011 он
3. ШУТИС. Физик 2. Уб., 2015 он
4. Лхагвасүрэн Б. Мөр.УБ., 2015 он

5. Терзиев Н.В., Киричинский Б.Р., Эйсман А.А., Геркен Е.Б. Физические иследования в криминалистике. М.,1948

Эрдэм шинжилгээний бүтээл

6. Доржготов А. Хүний болон амьтны үсээр гэмт хэрэг илрүүлэх асуудал. Дэд эрдэмтний зэрэг горилсон бүтээл. Уб., 1995 он

7. Авидхүү Д. Мөр илрүүлэхэд гэрлийн спектрийн ашиглалтын нэмэгдүүлэх нь. Хууль зүйн магистрын зэрэг горилсон бүтээл. Уб., 2013 он

Цахим хуудас

8. https://mn.wikipedia.org
9. https://mn.eferrit.com/
10. https://www.dissercat.com/
11. https://www.horiba.com

ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ АВРАГЧ-ХИМИЧНИЙ ОСЛЫН ГОЛОМТОД ҮҮРЭГ ГҮЙЦЭТЭХ ЧАДВАХИ, ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

MISSION, ABILITY AND CHALLENGES OF EMERGENCY SERVICE RESCUER-CHEMIST IN CENTER OF ACCIDENT

Б.Ганзагас
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Гамшиг судлалын төвийн эрдэм шинжилгээ, туршилт судалгааны ажилтан-багш, дэслэгч
Ganzagas.B
Lieutenant, Researcher, Disaster Risk Studies Center, Integrated Scientific Research Innstitute, University of Internal Affairs

Хураангуй: Монгол улсын нутаг дэвсгэрт уул уурхайн аваар, гүний уурхайд тохиолдох хорт хийн осол гарсан үед эх үүсвэр, голомтыг илрүүлэх, хордолтын зэрэг, хил хязгаар тогтоох, хор хөнөөлийг аюулгүй болгох үйл ажиллагаа явуулдаг аврагч-химичидийн мэдлэг, мэргэжлийн ур чадварыг үнэлэх, тэдний үүрэг гүйцэтгэх үеийн тулгамдаж буй зарим асуудалд судалгааны үндсэн дээр дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг судална.

Abstract: To explore opportunities for collaboration with relevant organizations and analyze on a case-by-case based on the knowledge and professional skills with service rescue-chemical accident responsibility and some challenges. Who is identify sources of toxic gas accidents in the territory of Mongolia in the event of a mining accident and underground mine, and determine the degree of poisoning, demarcation, and safety of harm.

Түлхүүр үгс: Аврагч химичин, цацрагийн үүсгүүр, химийн осол, халдварт өвчин

Keywords: Rescue chemist, radiation generator, chemical accident, infectious disease

Өнөөгийн байдлаар дэлхийд 10 сая гаруй нэр төрлийн химийн бодис бүртгэгдсэний 70 мянга орчим нь бидний ахуй амьдралд өдөр тутам ашиглагдаж байгаагаас 10 мянга гаруй нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд ямар нэг хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлж, эдгээрээс одоогийн байдлаар 200 гаруй нь хорт хавдрын эх үүсвэр болдог нь нэгэнт батлагдаад байна. Олон улсын зах зээлд жил тутам 1000 нэр төрлийн химийн бодис шинээр гардаг ба 100 мянга орчим нэр төрлийн 400 сая гаруй тонн аюултай хог хаягдал гарч байна.

Өнөөдөр манай улсад бүрэн бус тоогоор 3000 гаруй га талбай бүхий 450 цэгт хог хаягдлыг ил задгай хаяж байна. Хот, аймаг, сумын төвийн орчин, дээр нь уул уурхайнхны бохирдуулсан газрыг оролцуулбал 10 мянга гаруй га газар хог хаягдлаар, 4000 га газар химийн бодис, нефтийн

бүтээгдэхүүнээр бохирджээ. Огт цэвэрлээгүй 80000 шоо метр, дутуу хагас цэвэрлэсэн 360000 шоо метр бохир ус жил бүр гол горхиор дамжин байгаль орчныг бохирдуулж байна. [1]

Судалгаанаас харахад 2013-2015 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд жилд дунджаар 19 удаагийн химийн ослын тохиолдол гарч байгаа бөгөөд дийлэнх хувийг мөнгөн ус, аммиак, ууршимтгай органик нэгдэл, хүчил, шүлт, нэр нь үл мэдэгдэх бодисын холбогдолтой ослын дуудлага эзэлдэг.

Урьд нь гарч байсан химийн ослын шалтгаан, нөхцөлөөс дүгнэлт хийхэд химийн бодисын талаарх мэдлэг дутмаг, аюулгүй ажиллагааны зааварчилгааг баримтлан ажилладаггүй, ослын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ тодорхойгүй зэргээс болж гардаг байжээ.

Химийн хорт болон аюултай бодисын холбогдолтой ослын судалгаа

Хүснэгт 1. Хилийн ослын тоо



Онцгой байдлын албан хаагчид ажилласан химийн ослын дуудлага

Онцгой байдлын албаны хэмжээнд одоогоор 2500 шахам аврагч ажиллаж байна.Үүнээс гал сөнөөгч аврагч 62,1%, жолооч техникч 23,1%, төрөл мэргэжлийн аврагч 14,9% тус тус ажилладаг. 2021 оны байдлаар Үндэсний аврах бригадад орон тооны аврагч-химич 15, аврагч-тэсэлгээчин 6, бүлгийн дарга 4, нийслэлийн аврах ангид орон тооны аврагч 45, аврагч-химич 1, жолооч 12, жолооч-холбоочин 8, эмч 4, бүлгийн дарга 8 гэсэн бүрэлдэхүүнтэйгээр албан хаагчид албан үүргээ гүйцэтгэж байна.

Аврагч -химич болон аврагч бүрэлдэхүүний нөөцийн байдал

Аврагч-химичдийн хүйсийн харьцаа 3:1, аврагчдын хүйсийн харьцаа 33:1 байна.

[1] ОБЕГ-ын жил бүрийн тайлан





Аврагч-химич, аврагч нарын насны харьцааг харахад 30-39 насныхан эзлэж байна.





Онцгой байдлын албанд 1-10 жил ажилласан ажлын туршлагатай аврагч-химич, аврагч нар нийт албан хаагчдын ихэнх хувийг эзлэж байна.10-аас дээш жил ажилласан аврагч нарын тоо аврагч-химичдийнхээс их байна.





Аврагч-химичдийн 65% нь сургалтанд хамрагдаж, 35% нь сургалтанд хамрагдаагүй байна. Аврагчдын 58,8% сургалтанд хамрагдаж 41,2% нь сургалтанд хамрагдаагүй байна

Аврагч химичдийн сургалтанд хамрагдсан байдал
Техник хэрэгслийн бэлэн байдал





Үндэсний аврах бригадад тусгай ангийн аврагч-химичдийн цацраг, химийн ослын голомтонд ажиллахад өмсөж хэрэглэх ХХАА (хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны)-ны хувцас, хамгаалах хэрэглэлийг үйлдвэрлэгдсэн оноор нь ангилан үзвэл 65,2% нь 1980-2000 онд, 26% нь 2000-2010 онд, 4,6% нь 2010-2016 онд үйлдвэрлэгдсэн байна

Үндэсний аврах бригадын ангийн аврагч-химичдийн цацраг химийн, ослын голомтонд ажиллахад ашиглах багаж хэрэгслийг үйлдвэрлэгдсэн оноор нь ангилан үзвэл 66% нь 2000-2010 онд, 33% нь 1980-2000 онд үйлдвэрлэгдсэн байна.





НОБГ-ын аврагчдын цацраг, химийн ослын голомтонд ажиллахад ашиглах багаж хэрэгслийг үйлдвэрлэгдсэн оноор нь ангилан үзвэл 65,9% нь 2010-2016 онд, 34% нь 2000-2010 онд үйлдвэрлэгдсэн байна.



Дүгнэлт

Цацраг, химийн хорт болон аюултай бодисын холбогдолтой болзошгүй осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлаа хангах үүднээс онцгой байдлын албаны аврагч-химич, аврагчдын аврах ажиллагаа, ослын голомтод үүрэг гүйцэтгэхэд хэрэглэх багаж хэрэгсэл, нэг бүрийн болон нийтийн хамгаалах хувцас хэрэглэлийг сүүлийн үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэх, орчин үеийн шинэ арга аргачлалыг нэвтрүүлэх талаар зохих арга хэмжээ авах цаг болсон гэж үзэж байна.

Санал

1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын Аврагч - химичдийн бүтэц орон тоог нэмэгдүүлэх
2. Аврагч-химичдийг мэргэжил, ур чадвараар нь үнэлэх хөшүүргийн болон урамшууллын хэлбэрүүдийг судлан дагаж мөрдөх
3. Гамшгаас хамгаалах хуулийн заалтын дагуу алжаал тайлах, нөхөн сэргээх эмчилгээ үйлчилгээг тогтмол хийх.
4. Аврагч-химичдийн цацраг, химийн ослын үед ажиллах энгийн ойлгомжтой ном, сурах бичиг гарын авлагаар хангах.

Ашигласан эх сурвалж

1. Төмөр Х. Аврагчийн лавлах 1.2. УБ., 1997.
2. Үржин О. Байгалын болон технологийн үүдэлтэй аюул, ослын тухай ойлголт. УБ., 2004.
3. Онцгой байдлын ерөнхий газрын жил бүрийн тайлан

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫГ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН АГУУЛГА ДАХЬ ОНОЛ, ПРАКТИКИЙН ХАРЬЦАА

THEORETICAL AND PRACTICAL RELATIONSHIP IN THE CONTENT OF TRAINING FOR POLICE OFFICERS

Э.Дашгаадан
Дотоод хэргийн их сургуулийн докторант, цагдаагийн ахлах дэслэгч
Dashgaadan.E
Police Senior Lieutenant, Ph.D student, University of Internal Affairs, Mongolia

Хураангуй: Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх сургалтын зорилго нь сонсогчдод ажил мэргэжлийн талбарт хэрэгжүүлэхэд шаардлагатай түвшний мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлэхэд оршдог. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа нь хэт төлөвлөгөөний дагуу бус харьцангуй үйл явдалд тулгуурласан харилцаан дээр тогтдог бөгөөд тулгарч болзошгүй нөхцөл байдлуудыг урьдчилан таамаглах боломж бага юм. Энэ талаасаа сайн цагдаагийн алба хаагчийг бэлтгэх үндэс нь учирч болох нөхцөл байдлуудыг сайтар судлах явдал юм. Тэгвэл тэдгээр алба хаагчдын мэдлэг, боловсрол, мэргэжлийн ур чадварыг олгодог сургалтын агуулга дахь онол, практикийн зохист харьцааны талаар товч авч үзлээ.

Abstract: The overall goal of police officer training is to provide students with the level of knowledge, skills, and attitudes they need to apply in their careers. Police operations are based on relative events, not on a plan, and are less likely to anticipate situations. In this regard, the basis for training a good police officer is to carefully study the situations that may arise. It provides a brief overview of the theoretical and practical relationship between the training content that provides knowledge, education and professional skills to these employees.

Түлхүүр үгс: Сургалт, цагдаагийн алба хаагчийн сургалт, дадлагажих сургалт.

Keywords: Training, police officer training and internship.

Үндсэн хэсэг

Цагдаагийн боловсон хүчний нөхөн хангалтыг хийж, мэргэшсэн алба хаагчийг бэлтгэхэд практик болон танхимын сургалт чухал ач холбогдолтой.

Сургалт бол нийгмийн болон суралцагчийн эрэлт хэрэгцээг хангах зорилго бүхий багшийн сургах, суралцагчдын сурах хамтын бүтээлч үйл ажиллагаа юм.[1] Сургалтын тухай төгс бүрэн тодорхойлолт гарган түүнийг баримтлах нь боломжгүй зүйл бөгөөд сургагч багш нар судлаач, эрдэмтэн

[1] Ш.Ичинхорлоо. Насанд хүрэгчдийн сургалтын гарын авлага. УБ., 2013. 8 дахь тал

бүгд өөр өөрийн тодорхойлолттой байдаг нь ардчилсан нийгэмд хөгжлийн гол хөдөлгүүр болж байна.

Манай оронд уламжлалт сургалт их газар авсан бөгөөд мөн хөгжүүлэх, прагматик сургалт их газар авсан бөгөөд мөн хөгжүүлэх, прагматик сургалтын элементүүд зэрэгцэн оршиж байлаа. Энэ байдал зөвхөн манайд байгаа зүйл биш бөгөөд бусад улс оронд сургалтын янз бүрийн хэв маяг хамтдаа хэрэгжиж байдаг.

Цагдаагийн албa нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай албa мөн.[2] Тэгвэл энэхүү тусгай үүргийг гүйцэтгэдэг төрийн албa хаагчийг бэлтгэх сургалт нь өөрийн онцлогтой байдаг.

Мэргэшсэн албa хаагчийг бэлтгэхэд шинээр нөхөн хангах болон ажлын байранд тус бүр заавал явуулах сургалтын стандартыг тогтоож хэрэгжүүлэх, үүнд хөтөлбөр, түүнийг боловсруулж батлах, сургагчийг бэлтгэх, сургалтын орчин бааз суурийг оруулах бөгөөд албa хаагчдын боловсрол, бэлтгэгдсэн түвшин, туршлагад суурилан олон түвшинд явуулах шаардлага тулгардаг. Цагдаагийн албa хаагч болохоор бэлтгэгдэж байгаа сонсогчид бол насанд хүрсэн хүмүүс байдаг тул насанд хүрэгчдийн сургалтын онол, арга зүйг баримтлах нь гарцаагүй юм.

Андрогоги хэмээх нэршлийг анх 1833 онд Германы судлаач Александр Кап дэвшүүлж зүүн Европт дэлгэрчээ.

Педагогика хэмээх нэр томьёо анхнаасаа сурган хүмүүжүүлэх ухаан гэж 18-р зууны үеэс эхлэн хэрэглэгдэж ирсэн ба хүүхдийг сургах ажлын чиг зорилготой явуулж буй үйл ажиллагаанд хамаарсан ойлголт бөгөөд зөвхөн хүүхдийн боловсролыг нэрлэж байгаа юм. Харин М.С.Кноулес “Насанд хүрэгчдийн боловсролын өнөөгийн практик: андрогогика ба педагогика”[3] бүтээлдээ андрогогика гэсэн нэр томьёог насанд хүрэгчдийн боловсролд хамааруулан үзжээ. Энэ андрогогика гэсэн нэр томьёо нь анхнаасаа андр гэсэн грек үгнээс гаралтай бөгөөд энэ тохиолдолд хүн, насанд хүрсэн хүнийг сургах гэсэн утга агуулж байна. Андрогогика гэх үгийн гарлыг авч үзвэл зөвхөн эрэгтэй хүмүүсийн боловсролд хамаарах мэт санагдавч түүхээс үзэхэд ерөнхий утгаар нь буюу ахимаг, насанд хүрэгчдийн боловсролд хамааруулж үзсээр иржээ.

Андрогогикаг насанд хүрэгчдийг сургах үзэл орчин үед суралцагч төвтэй сургалтын үзэл санаа дэлгэрч, сургалт нь багшийн сурган

[2] Цагдаагийн албaны тухай хуулийн 4 дүгээр зүйл
[3] M.Knowles. A Theory of Adult Learning: Androgogy, The Adult Learner: A Neglected Species, 4th Ed., Houston: Gulf Publishing Company, 1990

хүмүүжүүлэх болон суралцагчийн сурч танин мэдэх үйл ажиллагааны нэгдэл гэж үзэх болсон.[4]

Сурч мэднэ гэдэг нь тухайн хүний зан төлөвийн үйлдлийг өөрчилнө гэсэн үг юм. Энэ өөрчлөлтийг гаргахын тулд мэргэжлийн онолын мэдлэгийг өмнө сурч мэдсэн үнэт зүйлтэй нэгтгэн ажил мэргэжилдээ хэрэглэхүйц түвшинд хүргэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл онолын мэдлэгийг бодит амьдралд хэрэглэх хандлага төлөвшүүлэх юм. Үүний тулд сургалтад практик, дадлагын хувь нэмрийг түлхүү дэмжих нь чухал ач холбогдолтой байна.

Цагдаагийн алба хаагчдыг бэлтгэхийн тулд тэдний сурах хэрэгцээ, зорилго, онцлогт тулгуурлан дараах зүйлийг анхаарах хэрэгтэй.[5] Үүнд:

- Идэвхтэй оролцоо
- Сургалтын орчин тайван, аюулгүй байх
- Сургалтын материал ач холбогдол сайтай байх
- Хүртэхүйн олон талыг ашиглах
- Практик хэрэглээ – эргэх холбоо – мотиваци

Идэвхтэй оролцоо: Сонсогчид сургалтын үйл явцад идэвхтэй оролцогч байж чадвал сургалт богино хугацаанд үр дүнтэй байна. Тэдэнд аль болох сурсан зүйлээ бодит нөхцөлд, амьдралд хэрэглэх нь чухал байдаг тул хийх явцдаа суралцах зарчмаар сургалтыг явуулах хэрэгтэй.

Сургалтын орчин аюулгүй, тайван байх: Сонсогчдын үзэл бодол, сонголт, туршлагыг үнэлж, харгалзан үзсэн, найрсаг, хүртээмжтэй сургалтын орчинг бүрдүүлбэл сургалт амжилттай болно.

Сургалтын материал ач холбогдол сайтай байх: Шинэ материал нь сонсогчдын өмнөх мэдлэг, туршлагатай холбогдсон байвал сургалт үр ашигтай болно. Иймд сонсогчид өмнө юу мэддэг, юу чаддаг байсан бэ гэдгийг урьдчилан мэдэх хэрэгтэй.

Хүртэхүйн олон тал: Бид нүдээрээ үзэж, гараараа барьж, сонсож, үнэрлэж, амталж, хийх явцдаа суралцдаг. Иймд аль болох олон төрлийн мэдрэхүй оролцож байвал сургалт амжилттай болохыг мартаж болохгүй. Хэрэв ямар ч үзүүлэх харуулах зүйлгүйгээр амьдралд хэрэглэж болох жишээгүйгээр ямар нэгэн зүйлийн талаар зөвхөн тайлбарлан яриад байвал сонсогчид хүлээн авах нь хомс байх болно.[6]

Практик хэрэглээ: Шинээр олгож буй мэдлэг, чадварыг практикт хэрэглэх боломж олговол сургалтын амжилтад сайнаар нөлөөлнө. Сонсогчид мэдэхгүй, чадахгүй байгаагаасаа ичих, нэрэлхэхээс гадна

[4] E.Lindeman. Насанд хүрэгчдийн боловсролын утга учир. 2001
[5] Н.Наранчимэг. Насанд хүрэгчдийг сургах онол, арга зүйн зарим асуудал. УБ., 2001
[6] Е.Батчулуун. Албан бус болон насанд хүрэгчдийн боловсрол. УБ., 2008

эвгүй байдалд оруулсан таагүй харьцаанд дургүй байдаг тул дэмжих, урамшуулсан зөвлөгөө өгөх байдлаар туслах хэрэгтэй.

Эргэх холбоо: Эргэх холбоо нь сургалтын явцад ямар дэвшил гарч буйг мэдэхэд тусалдаг мэдээлэл бөгөөд сургалтын чухал хэрэгсэлд тооцогддог. Иймд сургалтыг амжилттай үргэлжлүүлэхийн тулд сургалтын явцад суралцагчдаас хариу мэдээлэл авч байх нь зүйтэй. Өмнөх сорил, өгсөн даалгаврыг дуусгасны дараа явцын үнэлгээ эерэг байх нь сургалт амжилттай байгаагийн илрэл болдог. Нөгөө талаар үнэлгээний үр дүн тэднийг дэмжих, урам зориг өгөхөд ач холбогдолтой. Хүн мэдрэхүй ба хүртэхүйн тусламжтайгаар мэдээллийг хүлээн авч болох ч хийх явцдаа суралцах нь илүү үр дүнтэй.

Мотиваци: Крилл Хоул[7] насанд хүрсэн суралцагчдыг сэдэлжүүлдэг зүйлийн талаар судалгаа хийсэн нь ихэд түгсэн юм. Тэрээр сэдэл тэмүүллийн төрлийг гурван дэд бүлэгт ангилжээ. Үүнд:

1. Зорилго төвтэй суралцагчид нь тодорхой зорилгоо хэрэгжүүлэхэд сургалтыг ашигладаг.
2. Үйл ажиллагаа төвтэй суралцагчид нь гол хэсэг бөгөөд тэд нийгмийн холбоо сайтай.
3. Сургалт төвтэй суралцагчид нь өөрт хэрэгтэй мэдлэгийг эрж хайж байдаг байна. Мэдээллийн технологи, интернетийн хөгжил нь багш суралцагч хоёрын хоорондын гүүрийг эвдэж багш мэдлэгийн хаалгач байхаа нэгэнт больжээ.

Тодорхой туршлага нь үйл явцад орж баталгаажиж эзэмшигдснээр дахин шинэ мэдлэг эзэмших хэрэгцээ шаардлага гарах гэх мэтчилэнгээр энэ явц тасралтгүй үргэлжилнэ. Шинэ мэдлэг нь ерөнхий чиг хандлагын хувьд нэлээд урт хугацаа байдаг бөгөөд дэвшил ахицтайгаар шинэ алхам болон дээд түвшинд хэрэгжиж байдаг.

Цагдаагийн алба хаагч болохоор бэлтгэгдэж байгаа сонсогчдын гол онцлог бол аливаа өөрчлөлтийг мэдэрч шинэ нөхцөлд дасан зохицох чадвартай, эдийн засаг, үзэл бодлын хувьд хараат бус, бие даасан, амьдралд тохиолдох асуудлыг даван туулах чадвартай, хариуцлага хүлээх чадвартай, хатуужилтай, цэрэгжилттэй байх явдал юм.

Сонсогчид өөрсдийн сурах арга барилтай байдаг нь хувь хүний амьдралын явцад төлөвшсөн зан төлөв, амьдралын нөхцөл, өмнөх туршлага гээд олон зүйлээс хамаарна. Иймд сургагч багш, чиглүүлэгч, дэмжигчийн зүгээс хүн бүрт тохирсон арга барилаар ажиллах, тухайн хүний мэдлэг ур чадвар, хэрэгцээнд тулгуурлан өөр өөрийнх нь боломжийг нээхэд чиглүүлсэн үйл ажиллагаа явуулах нь чухал юм.[8]

[7] Н.Наранчимэг. Насанд хүрэгчдийг сургах онол, арга зүйн зарим асуудал. УБ., 2001
[8] Е.Батчулуун. Албан бус болон насанд хүрэгчдийн боловсрол. УБ., 2008

Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх сургалтын агуулгад онолын хичээл хэт их байдаг бөгөөд энэ нь практиктай уялддаггүй гэх шүүмжлэл байнга гардаг. Хэдийгээр сургалтын хөтөлбөрт онолын болон практик сургалтын зохист харьцааг тэнцвэржүүлэхийг зорьдог боловч бодит байдал дээр хэрэгждэггүй нь сул тал болсоор байна. Алба хаагчдыг бэлтгэх сургалтын онол, практикийн харьцааг судалсан судалгаа одоо ч гэсэн нийтлэг бус байна.[9] Эдгээр цөөн тооны судалгааны сул тал нь зөвхөн насанд хүрэгчдийн сургалтын арга зүйг ашигласан бөгөөд энэ арга зүйг цагдаагийн алба хаагчийг бэлтгэх сургалтын зарим нэгэн сэдэв, бүлэгт л тусгах нь ач холбогдолтой юм.

2012 онд Нийслэлийн цагдаагийн газар хэлтсийн нийт 241 алба хаагчаас /төгсөгч/ Цагдаагийн байгууллагын ажилтны мэргэжлийн стандартыг боловсруулах, Дотоод хэргийн их сургуулийн эрдэм шинжилгээ, сургалтын хэтийн чиг хандлагыг хөгжүүлэх бодлого, чиглэлийг тодорхойлох зорилгоор авсан судалгааны ажлын дүн, 2016 онд Цагдаа-хууль сахиулах ажил бакалаврын хөтөлбөрт шинжилгээ хийж, хөтөлбөрийг сайжруулах зорилгоор Нийслэлийн хүрээний цагдаагийн газар, хэлтсийн 101 төгсөгчөөс авсан судалгааны дүнг нэгтгэн дүгнэхэд Цагдаагийн ажил-эрх зүй хөтөлбөр нь амьдралд хэр нийцтэй байсан бэ гэсэн асуултад бүрэн нийцсэн гэж 3.7, боломжийн хэмжээнд гэж 36.5, дундаж буюу дунджаас доогуур гэж 32.3, огт нийцдэггүй гэж 1.7 хувь нь хариулсан.

График 1. Сургалтын хөтөлбөрийн амьдралд нийцдэг байдал /анкет асуулга/



Таны сургалтын хөтөлбөрөөр олж авсан мэдлэг албаны хэрэгцээ шаардлагыг хангаж байна уу гэсэн асуултад Цагдаагийн ажил-эрх зүй

[9] K.Ahmet. Polis Eğitiminde Vakaya Dayalı Uğretim Uygulamasının Farklı Davranış Bisimleri Geliştirmeye Etki-si, Polis Eğitiminde Modern Uygulamalar. Ankara., 2012

хөтөлбөрөөр төгсөгчид боломжийн хэмжээнд хангадаг гэж 51.4, Цагдаа-хууль сахиулах ажил хөтөлбөрийн төгсөгчид албаны хэрэгцээг хангадаг гэж 34.8 хувь нь хариулсан байна. Түүнчлэн эзэмшсэн ур чадварын тухайд бие даан ажиллах, ачаалал даах, бүтээлчээр ур чадварын түвшин дунджаас дээгүүр, компьютер, техник хэрэгсэл ашиглах, дүн шинжилгээ хийх, зэвсэг, тусгай хэрэгсэл ашиглах, цагийн менежментийг хэрэгжүүлэх ур чадвар дунджаас доош буюу хангалтгүй түвшинд гэж үзсэн байна.

Харин Цагдаа-хууль сахиулах ажил хөтөлбөрөөр төгсөгч нь практик сургалтыг нэмэгдүүлэх, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг сайжруулах чиглэлээр сургалтын хөтөлбөрт тусгах зэрэг саналыг өгчээ.

Мөн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан танхимын болон танхимын бус сургалтын хэлбэрийн харьцуулалтыг авч үзвэл:

Хүснэгт 1. Танхимын болон танхимын бус сургалтын хэлбэрийн харьцуулалт

Сургалтын хэлбэр / Огноо		2015	2016	2018	2019
Танхимын нийт цаг:		**3372**	**4400**	**3982**	**2452**
Үүнээс:	Лекц	914	1072	1038	956
	Семинар	938	944	850	660
	Дасгал	920	1296	818	516
	Лаборатори	492	468	676	320
	Сургалтын тоглолт /танхимын дадлага	108	620	600	0
Танхимын бус цаг		**2568**	**2056**	**2594**	**2876**

График 2. Танхимын болон танхимын бус сургалтын хэлбэрийн харьцуулалт



График 3. Сургалтын төлөвлөгөөнд тусгасан хичээлийн хүргэх хэлбэр



Сургалтын хөтөлбөрөөр тогтоосон танхимын сургалтын онолын мэдлэг олгох болон ур чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн цагийн багтаамжийг хичээлийн хөтөлбөрөөр тогтоосон үр дүнд хүргэхэд чиглэсэн, оновчтой хуваарилалт болно гэж үзэх үндэслэлтэй, сургалтын хөтөлбөрийн дагуу танхимын бус цаг, бие даалт, дасгал ажлын хичээлийн цагийн боломжит хэмжээгээр хуваарилан өгсөн боловч түүнийг дадалжуулах түвшинд хичээлийг чанартай зохион байгуулж чадахгүй байгаа нь нууц биш юм. Тухайлбал багш нар дасгал хичээлийг зохион байгуулахдаа ихэвчлэн анги, танхимд буюу бусад танхимын хичээлээс ялгаагүй явуулдаг бөгөөд сургалтын шинэлэг арга хэлбэрийг ашигладаггүй. Ихэвчлэн case study буюу тохиолдол шинжлэх байдлаар зохион явуулдаг байна.

Хичээлийн уялдаа холбоо, агуулгын хувьд дийлэнх цагийг дасгал, дадлагын цагаар зохион байгуулах шаардлагатай хичээлүүдэд ч лекц, семинар зэрэг танхимын цагаар хичээл түлхүү ордог нь сул тал болсоор байна. Үүний зэрэгцээ танилцах, үйлдвэрлэлийн дадлагыг үр дүнтэй зохион байгуулах нь хичээлээр олж авсан мэдлэг, чадварыг бататгах ач холбогдолтой юм.

Цагдаагийн алба хаагчийн сургалтын агуулгад онолын мэдлэг олгох асуудлын эзлэх хувь нь улс орон бүрт харилцан адилгүй байна. Тухайлбал Франц 50 хувь, АНУ 55 хувь, Нидерланд 75 хувь, Англи 64 хувь, Итали 66 хувь, Германд 49 хувийг онолын мэдлэгийн хичээл эзэлдэг[10] байна.

[10] A.Hьseyin, B.Fatih, Y.Mehmet. Tьrk Polis Eğitiminde Durum Eğitimi Modelinin Uygulanması, Polis Eğitiminde Modern Uygulamalar. Ankara., 2012

Сонсогчид насанд хүрсэн хүмүүс учраас өөрийн сурах арга барилаа тодорхойлсон өөрийн үзэл бодолдоо үнэнч байж хамгаалахыг хичээдэг учир сургагч багш тэр бүхнийг харгалзан өөрийн сургалтыг төлөвлөн бэлтгэл сайтай байх нь оролцогчидтой үл ойлголцох, үл тоох бэрхшээл үүсэхээс хамгаална. Суралцагч, сонсогч нарт цоо шинэ мэдээлэл гэж байдаггүй бөгөөд тухайн сэдэв, асуудлын талаар ямар нэгэн байдлаар мэдээлэл авч тэр талаараа уншиж судалсан өөрийн гэсэн туршлагатай байдаг тул туйлын үнэн болон үүнээс өөр арга зам байхгүй гэж сургалтад хандах нь хамгийн том бэрхшээл болдог.

Сургалтын агуулга, хөтөлбөрийг гаргахын тулд заавал хэрэгцээ болон одоогийн байдлыг судлах шаардлага урган гардаг. Учир нь өөрийн хэрэгцээнд тулгуурлан шийдвэр гарган зорилго дэвшүүлдэг. Хэрэв агуулга хөтөлбөр тэдэнд ач холбогдолгүй санагдвал сургалтыг орхин гарах зэрэг бэрхшээл үүсэх магадлалтай. Сургагч багш нар хэр ур чадвартай байгаагаас сонсогч, суралцагч нарын идэвх оролцоо хамаардаг болох нь ажиглагддаг. Тэдний анхаарал, асуудлыг хүлээн авч задлан анализ хийх чадвар хурдан учир сургалтын явцад няцаалт болон дэмжлэгийг үргэлж илэрхийлж байдаг.

Хувь хүн мэдлэг чадварынхаа ачаар материаллаг болон оюуны баялгийг бүтээн өөрийн түүхийг бичдэг, аливаа саад бэрхшээлүүд үүсэхэд мэдэх, сурах хүсэл урган гарч энэ сургалтын хэрэгцээ шаардлагыг нэмсээр байна.

Сонсогч, суралцагчид шударга үнэлгээг эрхэмлэх боловч бусдын өмнө эвгүй байдалд орохгүй байх, мэдэхгүй чадахгүй байгаагаа нуух, нэр хүндийг эрхэмлэх учир сургалтын явцад шууд үнэлгээг хэрэглэх, бусдын өмнө буруутгах, хувь хүнд чиглэсэн анхааруулга өгөхөд хүлээж авахгүй бөгөөд харилцаа болон дараагийн сургалтын үр дүнд шууд нөлөөлдөг бэрхшээл юм. Сургалтын агуулгад багтсан хичээлүүдийн хэрэгцээ, шаардлага, өөр хоорондын уялдаа холбоог тодорхойлж, бүр цаашлан хичээлийн агуулга дахь сэдвүүд тэдний хамаарал, хичээлийг хүргэх хэлбэр, танхимын болон танхимын бус цагийг тооцоолон гаргаж, бататгал, дадлага хичээлийг чанар, үр дүнтэй зохион байгуулахад сургалтын байгууллага анхаарах шаардлагатай юм. Энэ нь суралцагчдын сургалтын явцад үүсэн гарч байгаа бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд сургагч багш сургалтын бэлтгэл, хувийн бэлтгэл ажлуудыг орхигдуулалгүй бэлтгэн анхаарах хэрэгтэйг харуулж байна.

Дүгнэлт

Алба хаагчдыг бэлтгэх, насанд хүрэгчдийн сургалт, андрогокиг нь орчин үед эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд анхаарал татсан сэдэв болж байна.

Цагдаагийн алба хаагчдыг бэлтгэх сургалтын онолын үндэслэл нь насанд хүрэгчдийн боловсролын асуудал юм. Сургалтын тухай төгс бүрэн тодорхойлолт гарган түүнийг баримтлах нь боломжгүй зүйл бөгөөд сургагч багш нар судлаач эрдэмтэн бүгд өөр өөрийн тодорхойлолттой байдаг нь ардчилсан нийгэмд хөгжлийн гол хөдөлгүүр болж байна.

Сурч мэднэ гэдэг нь тухайн хүний зан төлөвийн үйлдлийг өөрчилнө гэсэн үг юм. Ийм өөрчлөлт нь хүний сэтгэхүйн хүч оюун ухааны эрчимжилт, сэтгэл хөдлөлийн илрэлийг заавал шаарддаг.

Цагдаагийн алба хаагч болохоор бэлтгэгдэж байгаа сонсогчдын гол онцлог бол аливаа өөрчлөлтийг мэдэрч шинэ нөхцөлд дасан зохицох чадвартай, эдийн засаг, үзэл бодлын хувьд хараат бус, бие даасан, амьдралд тохиолдох асуудлыг даван туулах чадвартай, хариуцлага хүлээх чадвартай, хатуужилтай, цэрэгжилттэй байх шаардлагатай тул багш болон сургалтын материал боловсруулагчид суралцагчдын сурах хэв маягт тохирсон сургалтын аргыг сонгох, сургалтын багаж хэрэгсэл, хэлж сурах загвараас татгалзаж, хийж сурах загварт шилжээд буй өнөөгийн шаардлага нь насанд хүрсэн суралцагчидтай ажиллах үед хамгийн тод илэрнэ.

“Цагдаагийн ажил-эрх зүй” хөтөлбөрийн төгсөгчдөөс дадлагын сургалтын хугацааг нэмэгдүүлэх, далд ухамсар, сэтгэхүй хөгжүүлэх, англи хэл, алба хэрэг хөтлөлтийн хичээл нэмэх, мэдээллийн технологийн чиглэлийн хичээлийн агуулга нь орчин, ном сурах бичиг хүрэлцээтэй, цаг үетэйгээ нийцсэн байх гэсэн саналыг өгч байсан. Харин Цагдаа-хууль сахиулах ажил хөтөлбөрөөр төгсөгч нь практик сургалтыг нэмэгдүүлэх, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг сайжруулах чиглэлээр сургалтын хөтөлбөрт тусгах зэрэг саналыг өгсөөр байна.

Цагдаагийн сургуулийн багшлах бүрэлдэхүүнээс дээр дурдсан эрх зүйн баримт бичиг, стандарт, сургалтын болон хичээлийн хөтөлбөрөөр тодорхойлсон үр дүн суурилсан сургалтын арга зүйг хэрэгжүүлэх замаар суралцагчдад цогц чадамжийг эзэмшүүлэх чиглэлд нилээдгүй анхаарч сургалтын шинэлэг арга, хэлбэрүүдийг туршиж байна.

Сонсогч, суралцагчдын сургалтыг зохион байгуулахад суралцагчийн хэрэгцээг судлан тодорхойлох, зорилгыг ойлгомжтой тодорхойлох, сургалтын явцад суралцагчдыг идэвхжүүлэх мэдлэг, чадварыг тодорхойлох ба үүнийг үндэслэн судлагдахууны хөтөлбөр, гарын авлага зэргийг хийх арга зүйн төлөвлөлтөд анхаарах, сурах үйлүүдийг урьдчилан бэлдэж, төлөвлөх, сургалтын хэрэглэгдэхүүн, гарын авлага, материалыг

бэлтгэх, суралцагчдыг үнэлэх, сургалтыг бататгах үйлийг сонгон бэлтгэх, суралцагчдад сэтгэл зүйн болон биет орчинг бүрдүүлэхээс гадна онолын мэдлэгийг бататган практикт хэрэгжүүлэх хандлагыг төлөвшүүлэх зэрэгт анхаарч бэлтгэл сайтай байх нь үүсэн гарах бэрхшээлийг шийдвэрлэх, үр дүнтэй сургалт болох гол хүчин зүйл болно.

Санал

Эргэх холбоо нь сургалтын явцад ямар дэвшил гарч буйг мэдэхэд тусалдаг мэдээлэл бөгөөд сургалтын чухал хэрэгсэлд тооцогддог. Иймд сургалтыг амжилттай үргэлжлүүлэхийн тулд сургалтын явцад суралцагчдаас хариу мэдээлэл авч сургалтын үр дүнг тооцон, байнга шинэчлэн сайжруулах ажлыг хэвшүүлэх.

Сургалтын хөтөлбөр нь зөвхөн заах зүйлсийн агуулга бус харин суралцахуйн үйл явц, оролцогч бүх талууд, сургалтын орчинг хамруулсан уялдаатай цогц ойлголт гэж тодорхойлжээ. Тэгэхээр энэ хоёр ойлголтын нэг нь гарах үр дүнг хэт чухалчилж авч үзсэн бол нөгөөх нь сургалтын үйл явцыг илүү чухалчилсан бөгөөд аль аль нь давуу болон сул талтай. Эхнийхийг хэт баривал хөтөлбөр баригдмал, бүтээлч чанаргүй болох талтай бол хоёрдахыг хэт баримталбал хэт задгай болох талтай. Тиймээс энэ хоёрыг аль алиныг нь тооцсон, ялангуяа ямар чиглэлээр хичээл зааж байгаагаас шалтгаалан онол, практикийн зохист харьцааг тооцож үзсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулах.

Сургалтад шинэлэг арга, технологи нэвтрүүлэх чиглэлээр багшлах бүрэлдэхүүнээс идэвх санаачлагатай ажиллаж, хичээлийн жил бүр үзүүлэх, нээлттэй хичээл, онол, арга зүйн семинарыг тогтмол зохион байгуулж, үр дүнг сургалтын чанар, агуулгыг шинэчлэх, арга зүйгээ сайжруулахад ашигладаг ч энэ нь тодорхой чанар, стандартгүй, дүр эсгэсэн байдалтай явагддаг тул үзүүлэх, нээлттэй хичээл, онол, арга зүйн семинараас дэвшүүлсэн санал, ололтыг бусад хичээлд ашиглах.

Цагдаагийн сургуулийн багшлах бүрэлдэхүүнийг үр дүн суурилсан сургалтын арга зүйг хэрэгжүүлэх замаар суралцагчдад цогц чадамжийг эзэмшүүлэх чиглэлд нилээдгүй анхаарч сургалтын шинэлэг арга, хэлбэрүүдийг туршиж байгаа бөгөөд case study, тонгоруу сургалт, асуудал дэвшүүлэн шийдвэрлэх, мэтгэлцээн, тохиолдол судлах зэрэг аргуудыг тухайн сэдэвт тохирсон хүргэх хэлбэртээ нийцүүлэн ашиглаж хэвших.

Цагдаагийн мэргэшсэн албаа хаагчийг бэлтгэх сургалтын бодлого, төлөвлөлт нь дан ганц захиалагч байгууллагын хэрэгцээ шаардлагаас гадна, эрх зүйн бодлогын шинэчлэл, төрөөс барьж буй бодлого, харьяа яамны нэгдсэн бодлого шийдвэр хөтөлбөрийн өөрчлөлт шинэчлэлтэд тодорхой байр суурийг эзэлдэг тул харилцан тэнцвэрийг хангах.

Цагдаагийн албаа хаагчийн эзэмшвэл зохих гол чадваруудыг тодорхойлж, түүнийг төлөвшүүлэх чадамжтай сургагч багш нарыг бэлтгэн

ажиллуулах нь ач холбогдолтой юм. Тухайлбал бие хамгаалах, гардан тулаан, мөрдөн байцаах, харилцааны чадвар, албан бичгийн боловсруулалт гэх мэт гол чадваруудыг тодорхой практик туршлагатай, багшлах ур чадвартай, эрдэм шинжилгээний бүтээл туурвидаг зэрэг онцлогтой алба хаагчийг бэлтгэх хэрэгтэй юм.

Ашигласан эх сурвалж

1. Цагдаагийн албаны тухай хууль
2. Е.Батчулуун. Албан бус болон насанд хүрэгчдийн боловсрол. УБ., 2008
3. Ш.Ичинхорлоо. Насанд хүрэгчдийн сургалтын гарын авлага. УБ., 2013.
4. Н.Наранчимэг. Насанд хүрэгчдийг сургах онол, арга зүйн зарим асуудал. УБ., 2001
5. M.Knowles. A Theory of Adult Learning: Androgogy, The Adult Learner: A Neglected Species, 4th Ed., Houston: Gulf Publishing Company, 1990
6. E.Lindeman. Насанд хүрэгчдийн боловсролын утга учир. 2001
7. K.Ahmet. Polis Eğitiminde Vakaya Dayalı Цğretim Uygulamasının Farklı Davranış Biэimleri Geliştirmeye Etki-si, Polis Eğitiminde Modern Uygulamalar. Ankara., 2012
8. A.Hьseyin, B.Fatih, Y.Mehmet. Tьrk Polis Eğitiminde Durum Eğitimi Modelinin Uygulanması, Polis Eğitiminde Modern Uygulamalar. Ankara., 2012

ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ОНЦЛОГ

LAW ON THE LEGAL STATUS OF FOREIGN CITIZENS FEATURES OF ADDITIONS AND CHANGES

Д.Мөрөн
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Аюулгүй байдал судлалын төвийн эрхлэгч, Монгол Улсын гавьяат хуульч, профессор, докторант, цагдаагийн хурандаа
Muren.D
Honored Lawyer of Mongolia, Professor, Ph.D Student, Police Colonel, Head of the Security Research Center of the Scientific Institute of the University of Internal Affairs

Хураангуй: Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн онцлог

Abstract: Features of amendments to the Law on the Legal Status of Foreign nationals

Түлхүүр үгс: Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль
Keywords: Law on the Legal status of Foreign nationals

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг Монгол Улсын хууль, уул иргэнийг харьяалсан улстай байгуулсан гэрээгээр тогтооно” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улс нутаг дэвсгэртээ байгаа харьяалалгүй хүний эрх, үүргийг өөрийн хуулиар тогтооно” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 161-д “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах эрх олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих бүрэн эрхийн хүрээнд хүсэлтийг шийдвэрлэх хугацаа, иргэдээс бүрдүүлэх баримт бичиг, хүсэлтийг буцаах үндэслэл зэрэг асуудлаар журам батлах эрхийг эрх бүхий этгээдэд олгох чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулна” гэж, мөн Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”– ийн 4.4.4-т “...жуулчин хүлээн авах хүчин чадлыг сайжруулж, гадаад жуулчдын тоог нэмэгдүүлж, хил дээр олгодог цахим виз, визийн дэвшилтэт төрлүүдийг бий болгоно.” гэж, 5.3.12-т “Гадаадын иргэнд үзүүлэх зарим үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлж, бүртгэл, хяналтыг сайжруулна” гэж тус тус заасан байна.

Монгол Улсын Их Хурал 2010 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд уг хуульд 2012, 2013, 2015, 2016, 2017, 2018, 2019 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд эдгээр нь Хилийн боомтын тухай, Хилийн тухай, Зөрчлийн тухай, Чөлөөт бүсийн тухай, Улсын бүртгэлийн тухай, Татварын тухай зэрэг хуулиудтай холбогдуулан нэр томьёоны өөрчлөлт хийх агуулгатай байсан. Төрийн үйлчилгээ цахим хэлбэрт шилжиж байгаа энэ цаг үед гадаадын иргэнд үзүүлэх зарим үйлчилгээг мөн цахим хэлбэрт шилжүүлж, бүртгэл, хяналтыг сайжруулах шаардлага зүй ёсоор тулгарч байгаа бөгөөд виз олгох үйлчилгээг цахимаар олгох боломжтой болсонтой холбоотойгоор түүний эрх зүйн үндсийг хуульд бий болгох, Монгол Улсын визийн тухай ойлголтыг өргөтгөж, тодорхойлолтыг өөрчлөх, визийн ангиллыг төрөлжүүлж, олшруулах боломжийг бүрдүүлэх шаардлагатай болсон байна.Түүнчлэн зарим харилцааг тухайлбал: Монгол Улсын визийн ангилал болон визийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэнийг Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох, Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх шийдвэр гаргах, гадаадын иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээлэл харилцан солилцох журмыг батлах, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам батлах зэрэг журмаар зохицуулагдаж байсан асуудлуудыг хуульчлах шаардлагатай болсон.

Хууль тогтоомжийн тухай хуульд Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийсний үндсэн дээр хуулийн төслийг боловсруулахаар тус тус заасны дагуу үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг харгалзан хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төсөлд виз, бүртгэл, хяналт, төрийн байгууллагын уялдаа холбоо хамтын ажиллагааг сайжруулах, үйл ажиллагааны шат дамжлагыг багасган олон улсын жишигт нийцүүлэх, гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх зэргээр нийт 60 гаруй төрлийн нэмэлт, өөрчлөлтийг тусгаж боловсруулан Монгол Улсын Засгийн газраас хууль тогтоох дээд байгууллагад өргөн барьснаар Улсын Их Хурлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Нэгдсэн чуулганы хуралдаанаар хууль батлагдаж 2021 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан байна.

*1. **Визийн тодорхойлолтыг шинэчлэн** Монгол Улсын визийн талаарх зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр улсын хилийн боомт дээр виз олгох, цахим виз олгох, визийн төвийг ажиллуулах, визийн хүчинтэй хугацааг уртасгах, зарим зориулалтын визийг халах*

зэрэг Монгол Улсын визийг олон улсын жишигт нийцүүлэх чиглэлийн зохицуулалтыг тусгасан.

• Визийг зөвхөн хэвлэмэл хуудсаар олгодог гэх ойлголтыг өөрчилж, дэлхий нийтийн хандлагад нийцүүлэн визийг хэвлэмэл хуудас болон цахим хэлбэрээр олгож болох эрх зүйн үндсийг тусгасан байна. /Хуулийн 11.3 дугаар зүйл/ Өөрөөр хэлбэл дэлхийн аль ч өнцгөөс визийн хүсэлтээ "цахим"-аар хүргүүлж асуудлаа шуурхай шийдүүлэх зохицуулалт билээ.

• Олон улсын хилийн боомт дээр визийн зөвшөөрөлгүйгээр "жуулчин" ангиллын виз олгож болох улсын жагсаалт, виз олгох журмыг энэ хуулийн 9.2.1-д заасан журмаар олгоно. Энэ заалт нь аялал жуулчлалыг дэмжих зорилготой бөгөөд ийм ангиллын визийг Хилийн боомт дээр олгож болох улсын жагсаалтыг Засгийн газар тогтоох юм.

• Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол нэг болон хоёр удаагийн орох виз нь гадаадын иргэн Монгол Улсын хилээр нэвтрэх хүртэл 150 хоногийн хугацаанд хүчинтэй байна. /Хуулийн 18.1 дугаар зүйл/

Энэ заалт нь Монгол Улсын визийг холбогдох газраас авснаас хойш 150 хоногийн хугацаанд хүчинтэй бөгөөд харин Монгол Улсын хилээр нэвтэрч орж ирснээс хойш Монгол Улсад байх хугацаа биш юм.

Монгол Улсын визийн хүчинтэй хугацаа нь бусад улс оронтой харьцуулахад харьцангуй богино байгаа бөгөөд энэ нь олон улс орноор дамжин аялал хийж байгаа болон аяллаа эртнээс төлөвлөдөг гадаад иргэдийн хувьд хүндрэл үүсгэдэг тул үүнийг өөрчилж олон улсын жишгийн дагуу визийн хүчинтэй байх хугацааг одоо байгаагаас уртасгах нь гадаадын иргэдэд учрах хүндрэлийг бууруулах, тоог нэмэгдүүлэх давуу талтай.

• Виз нь орох, гарах-орох, дамжин өнгөрөх зориулалттай байсныг өөрчилж гарах- орох зориулалтыг хассан. /Хуулийн 11.5 дугаар зүйл/

Энэ заалтыг олон улсын жишигт нийцүүлэн тусгасан бөгөөд Монгол Улсад удаан хугацаагаар оршин суух байгаа гадаадын иргэн Монгол Улсаас гараад буцаж орж ирэх шаардлагатай үед гарах-орох виз мэдүүлэх шаардлагагүй болсон гэсэн ойлголт юм.

• Монгол Улсын Засгийн газар гадаадын иргэний асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

9.2.1 Монгол Улсын визийг ангилал болон визийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, Монгол Улсын виз олгох журам батлах;

• Монгол Улс визийн ангиллыг хуулиар хатуу тогтоож өгсөн байдаг нь цаг үеийн шаардлага, олон улсын нөхцөл байдалд нийцүүлэн визийн шинэ ангилал нэмэх, өөрчлөх зэрэг зохицуулалт хийх боломжгүйд хүргэдэг байсан тул визийн ангиллыг төрөлжүүлж, олшруулах боломжийг

бүрдүүлэх үүднээс визийн ангиллыг хуулиар хатуу тогтоож байгааг өөрчлөн виз олгох журмын дагуу Засгийн газар тогтоодог байхаар оруулсан заалт юм.

• Визийн төв. /Хуулийн 13 дугаар зүйл/

Гадаад улс орнууд виз мэдүүлэх үйл ажиллагаатай холбоотой визийн материалын бүрдлийг хянах, зөвлөгөө, мэдээлэл өгөх зэрэг техникийн чанартай ажиллагааг визийн төв буюу хувийн хэвшлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх чиг хандлагыг баримталж байгаа бөгөөд манай улсын хувьд ч мөн Монгол Улсын визийг олон тоогоор мэдүүлдэг улс орнуудад визийн төв ажиллуулах шаардлагатай байгаа тул энэ талаарх зохицуулалтыг хуульд тусгаж оруулсан.

Визийн төвийн байгуулах, ажиллах журмыг Засгийн газар, байрлах улс, хотыг Гадаадын харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлахаар хуульд тусгажээ.

Өнөөдрийн байдлаар Дэлхийн 70 гаруй улсын Засгийн газар гадаадын 150 орчим улсад outsourcing service буюу Виз мэдүүлгийн төвийн үйлчилгээг нэвтрүүлээд байгаа ба Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод 16 улсын Визийн төв албан ёсоор үйл ажиллагаа явуулж байна.

Визийн төв нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар Гадаад харилцаа яам, ДТГ-т тусгайлан олгосон “виз олгох эсэх” шийдвэр гаргах бүрэн эрхийг нь хөндөхгүй, виз олгох үйл ажиллагааны аюулгүй байдал, улсын төсөвт төвлөрч буй визийн орлогыг бууруулахгүй, улсын төсвөөс аливаа нэмэлт зардал гаргахгүйгээр төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх хувийн хэвшлийн байгууллага юм.

2. Гадаадын иргэний бүртгэлийг сайжруулах зорилгоор :

• Гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрэх үед Монгол Улсын Хилийн тухай хуулийн 17.6-д заасны дагуу хил хамгаалах байгууллага нь биеийн давхцахгүй өгөгдлийг авч, улсын хилээр нэвтэрсэн зорчигчийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ. /Хуулийн 24.1 дүгээр зүйл/

Түүнчлэн Монгол Улсад 30 хоногоос дээш хугацаагаар ирсэн гадаадын иргэн тус улсад орж ирсэн өдрөөс хойш ажлын долоон өдрийн дотор бүртгүүлдэг байсан заалтыг хүчингүй болгож хуулийн энэ заалтын дагуу гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрэх үед бие давхцахгүй өгөгдөл буюу гарын хуруугны хээ, царай, нүд зэргээр техник технологийн хөгжлийг ашиглан бүртгэх бөгөөд Энэ нь гадаадын иргэнд бий болдог хүнд суртлыг бууруулах, төр нэгдмэл, үнэн мэдээллийн сантай болон хяналтын тогтолцоог сайжруулах зэрэг олон талын ач холбогдолтой юм.

• Албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэнд түүнийг харьяалах улсын товчлол, төрсөн он, сар, өдөр, хүйс зэрэг өгөгдлийг багтаасан хоорондоо давхцахгүй бүртгэлийн дугаарыг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно. /Хуулийн 24.3 дугаар зүйл/

• Гадаадын иргэнийг орон байраар хангасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага түүнийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад 48 цагийн дотор бүртгүүлэх бөгөөд бүртгэлийг цахимаар хийж болно. /Хуулийн 24.4 дүгээр зүйл/

Энэ заалт нь оршин суугч гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгох, гадаадын иргэнийг урьсан хугацаанаас үл хамааран уригчийн хариуцлагыг дээшлүүлэх зохицуулалтыг оруулсан заалт юм.

• Гадаадын иргэнд төрийн байгууллагууд тус тусдаа бүртгэлийн дугаар олгож байсан дутагдалтай байдлыг өөрчилж хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын хэмжээнд Гадаадын иргэнд ГИХГ бүртгэлийн нэг л дугаар өгч хяналт сайжрах ач холбогдолтой болсон билээ.

• Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан. /Хуулийн 40^1 дүгээр зүйл/

40^1.1. Монгол Улс нь гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай байна. Гадаадыг иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь төрийн өмч байх бөгөөд улсын хилээр нэвтрэх зорчигчийн бүртгэлийн нэгдсэн сантай холбогдоно.

40^1.2. Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь Монгол Улсын виз мэдүүлсэн, виз олгосон, виз олгохоос татгалзсан, Монгол Улсын хилээр нэвтэрсэн, Монгол Улсад түр ирэгч, албан хэргээр болон хувийн хэргээр оршин суусан, Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн, албадан гаргасан, албадан гаргахаас чөлөөлөгдсөн, Монгол Улсад тааламжгүй этгээдээр зарлагдсан зэрэг гадаадын иргэний талаарх цаасан болон цахим мэдээллийн сангаас бүрдэнэ.

40^1.5. Гадаадын иргэний виз, бүртгэл, нэгдсэн сангийн мэдээллийг ашиглах, мэдээлэл нийлүүлэх, солилцох журмыг хууль зүйн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

Гадаадын иргэний асуудлаар үүрэг хүлээж буй төрийн байгууллагууд нь өөр өөр мэдээллийн сан ашиглаж, харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагаа хангалттай хэмжээнд явагдаж чадахгүй байгааг цэгцэлж холбогдох байгууллагууд мэдээллийн нэгдсэн нэг сан ашиглах, уг санд мэдээлэл нийлүүлэх, солилцох, ашиглах талаарх зохицуулалтыг журмаар зохицуулахаар хуульчилжээ.

• Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлд гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах зохицуулалт

тусгагдсан боловч хүндэтгэн үзэх шалтгаантай иргэнийг албадан гаргахаас чөлөөлөх тухай асуудлыг зохицуулалтгүй орхигдуулсан байсныг хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр дараах байдлаар шинэчилсэн байна.

Энэ хуулийн 37.1.2,37.1.12-т заасан зөрчил гаргасан гадаадын иргэн хувийн нөхцөл байдал, ар гэрийн гачигдал, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон, эсхүл эрүүл мэндийн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хүсэлт гаргасан, эсхүл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 43.3 дугаар зүйлийн 1.6-д заасан үндэслэл бий болсон тохиолдолд гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн албадан гаргахаас чөлөөлөх эсэхийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга шийдвэрлэнэ. /Хуулийн 37.9 дүгээр зүйл/

3. Хуулийг дагалдаж гарсан бусад хуулиудын нэмэлт, өөрчлөлтүүд:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулийг батлахад дагалдаж гарсан Иргэний нисэхийн тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон заалтууд нь Монгол Улсад олон улсын нислэгээр ирэх зорчигчдын мэдээллийг иргэний агаарын хөлөг хөөрхөөс өмнө Монгол Улсын эрх бүхий байгууллагад урьдчилан хүргүүлэх талаар тусгасан ба хэрэв энэ үүргээ биелүүлээгүй тохиолдолд агаарын тээвэрлэгч хуулийн этгээдэд хариуцлага тооцон торгууль ноогдуулах тухай, валютын ханшны хэлбэлзлээс шалтгаалж олон жилийн өмнө тогтоосон визийн болон оршин суух зөвшөөрлийн үнийг бусад орны жишигт нийцүүлж үнийг нэмэгдүүлэх визийн үйлчилгээний хураамжийн талаар Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

МӨРДӨГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА /МОНГОЛ, ОХУ/

СРАВНИТЕЛЬНЫЙ АНАЛИЗ ПРАВОГО СТАТУСОВ /МОНГОЛИЯ, РФ/

Н.Сайнбаяр
ДХИС-ийн докторант, цагдаагийн ахмад
Сайнбаяр.Н
Адъюнктура Университета внутренных дел Монголии, капитан полиции

Хураангуй: Эрүүгийн хэрэг мөрдөн шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч мөрдөгчийн эрх зүйн байдлыг ОХУ-ын мөрдөн байцаагчийн эрх зүйн байдалтай харьцуулан дүгнэлт хийхийг зорилоо.

Абстракт: Определить правового статуса следователя и стремился оценить путем сравнительного анализа правого статуса следователя РФ между Государствам Монголии.

Түлхүүр үгс: мөрдөгч, мөрдөн байцаагч, эрх зүйн байдал, мөрдөгчийн эрх зүйн байдал, мөрдөн байцаагчийн эрх зүйн байдал.

Ключивые слава: детектив, следователь, правовой статус, правовой статус детективов, правовой статус следователя

Хууль зүйн шинжлэх ухаанд аливаа субьектийн эдлэх эрх, хүлээх үүргийг “эрх зүйн байдал” гэж томьёолдог бөгөөд эрх зүйн байдлыг эрх, үүргийн нэгдмэл цогц гэсэн тодорхойлолтыг дийлэнх судлаачид өгсөн байдаг. Тухайлбал, бие хүний эрх зүйн байдал нь Үндсэн хууль, бусад хууль тогтоомжоор хуульчлан баталгаажуулсан бие хүний эрх, үүргийн тогтолцоо мөн[1] гэж тодорхойлсон байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасанчлан эрүүгийн хэргийг мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий субъект нь мөрдөгч. Мөрдөгч нь Монгол улсын иргэний хувьд Үндсэн хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжид заасан эрх эдлэж, үүрэг хүлээлгэхийн зэрэгцээ төрийн тусгайлсан алба хаагчийн хувьд гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан тусгайлсан эрх эдлэж, үүрэг хүлээдэг төдийгүй эрх хэмжээгээ хэтрүүлэх, урвуулах тохиолдолд хүлээх хариуцлага, үр дагаврыг хуульчилсан байна. Мөн мөрдөгчийг чиг үүргээ хэрэгжүүлэх эрх зүйн баталгааг Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Цагдаагийн албаны болон Гүйцэтгэх албаны тухай хуулиудад бэхжүүлсэн байдаг.

Манай улсын хувьд мөрдөн шалгах ажиллагааг хойшлуулшгүйгээс бусад тохиолдолд цагдаа, тагнуулын байгууллага, АТГ зэрэг үндсэн 3 байгууллага явуулах хуулийн зохицуулалттай[2] ч, ямар байгууллага

[1] Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол. УБ.,2015
[2] Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйл

мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаагаас хамаарч тэдгээр байгууллагын мөрдөгчийн эрх зүйн байдал нь харилцан адилгүй байна..Тухайлбал, Цагдаагийн байгууллагын мөрдөгчийн ажлын ачаалал бусад албаны мөрдөгчөөс тогтмол 2-3 дахин их байдаг /сард 40-80 хэрэгт шалгах ажиллагаа явуулдаг/ төдийгүй үндсэн ажлын зэрэгцээ баяр ёслол, улс төрийн айлчлал, гамшгийн үед хүч нэмэгдүүлэн хамгаалалтанд ажилласнаар хэргийн хугацаа алдах, тийнхүү хугацаа алдсаныхаа төлөө хариуцлага хүлээдэг. Мөн цагдаагийн байгууллагын мөрдөгчийг баривчлах саатуулахад ямар нэгэн тусгай зөвшөөрөл шаарддаггүй бол, АТГ-н мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий ажилтныг тухайн байгууллагын даргын зөвшөөрөлгүйгээр баривчлахыг хориглодог. Энэ мэтчилэн эрх зүйн байдлын харилцан адилгүй зохицуулалт нь мөрдөгчийг эрсдэлтэй нөхцөлд оруулах, албандаа итгэх итгэлгүй болох зэрэг сөрөг үр дагавартайн дээр шударга бус гэж дүгнэж болохоор байна.

ОХУ-д Мөрдөн шалгах хороо, Холбооны аюулгүй байдлын алба, Дотоод хэргийн яамны харъяа байгууллагын мөрдөн байцаагчид мөрдөн шалгах ажиллагааг явуулах, хэрэг бүртгэлтийн ажиллагааг Дотоод хэргийн яам, Хил хамгаалах алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Гаалийн алба, Гал түймэртэй тэмцэх алба, Мөрдөн шалгах хороо зэрэг байгууллагууд явулдаг зохицуулалтай байна. ОХУ-ын эрүүгийн процессийн хуулийн 38 дугаар зүйлд: Мөрдөн байцаагч нь Эрүүгийн процессийн хуульд заасан эрх хэмжээний хүрээнд эрүүгийн хэрэгт урьдчилсан мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтныг хэлнэ.

Мөрдөн байцаагч дараах эрхтэй:

1) Эрүүгийн процессийн хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хэрэг үүсгэх,

2) хэргийг хүлээн авч мөрдөн шалгах ажиллагаа явуулах, эсхүл мөрдөн шалгах байгууллагын даргад харьяаллаар шилжүүлэхээр хүлээлгэн өгөх;

3) Эрүүгийн процессийн хуулинд шүүхээс болон мөрдөн шалгах байгууллагын даргын зөвшөөрөл авахаас бусад мөрдөн шалгах ажиллагааг авч хэрэгжүүлэх, тэдгээртэй холбоотой шийдвэрийг бие даан гаргах.

4) Эрүүгийн процессийн хуулинд заасан үндэслэл журмын дагуу хэрэг бүртгэх албанд шуурхай эрэн сурвалжлах, өөр мөрдөн шалгах ажиллагаа явуулах, баривчлах, саатуул, баривчлагдсан этгээдийг шилжүүлэх тогтоолыг биелүүлэх тухай, бусад процессийн шинжтэй үйл ажиллагааг гүйцэтгүүлэх, мөн түүнчлэн дээрх ажиллагааг хийж гүйцэтгэхэд хамтран оролцуулах талаар заавал биелэх бичмэл даалгавар өгөх,

5) Эрүүгийн процессийн хуулийн 221 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу мөрдөн шалгах байгууллагын удирдлагын зөвшөөрлийн дагуу эрүүгийн хэрэг үүсгэх тогтоолыг өөрчилсөн, яллаж буй агуулга эсхүл яллаж буй зүйл заалт, яллах дүгнэлтийг өөрчлөж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар хэргийг нэмэлт мөрдөн байцаалтанд буцаасан прокурорын шийдвэрт гомдол гаргах;

6) Эрүүгийн процессийн хуульд заасан бусад эрхийг эдлэнэ.

3. Урьдчилсан мөрдөн байцаалтын үед холбооны хуулийг зөрчсөн талаарх прокурорын шаардлагыг эс зөвшөөрвөл мөрдөн байцаагч бичгээр мөрдөн байцаах нэгжийн удирдлагад тайлбар гаргаж өгөх бөгөөд мөрдөн байцаах нэгжийн удирдлага энэ талаар прокурорт мэдэгдэнэ.

ОХУ-ын Мөрдөн шалгах хороо нь Прокурорын дэргэдэх мөрдөн шалгах хороо байсныг өөрчлөн 2011 оны 01 сарын 15-ны өдөр тусдаа бие даан үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх болжээ. Мөрдөн шалгах хорооны мөрдөн байцаагч нар Эрүүгийн процессийн хуулинд заасан эрх эдлэж, үүрэг хүлээхээс гадна Мөрдөн шалгах хорооны тухай холбооны хууль[3], ОХУ-ын Ерөнхийлөгчийн баталсан Мөрдөн шалгах хорооны үйл ажиллагааны журам[4] зэрэг эрх зүйн баримт бичгээр эрх зүйн байдал нь тодорхойлогддог байна. ОХУ-ын тухайд дээрх 2 үндсэн хэм хэмжээний актад мөрдөн байцаагчийн эрх зүйн байдлыг дэлгэрэнгүй тусгаж өгсөн байгаагаас мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагын үйл ажиллагаа бүрэн утгаараа хэрэгжиж байна гэж үзэж болохоор байна.

ОХУ-ын Прокурорын байгууллагын тухай холбооны хуулийн 51-р зүйлд “прокурорын байгууллага нь гэмт хэргийн нэгдсэн тоон мэдээллийг хөтлөхөөс гадна мөрдөн шалгах ажиллагааны талаарх судалгаа хөтөлдөг бөгөөд үүгээрээ мөрдөн байцаагч нарын ажлын ачааллыг тэнцвэржүүлдэг байна. ОХУ-д мөн мөрдөн байцаагчийн ажлын стандарт буюу ачааллын циклыг тодорхойлоогүй боловч уг үүргийг прокурорын байгууллага нь хэрэгжүүлдэг байна.

Дээрх харьцуулсан судалгааны үр дүнд мөрдөн байцаагч, мөрдөгчийн эрх зүйн байдлын элемент тус бүрээр харьцуулан хүснэгтээр харуулбал,

д/д	Эрх зүйн байдлын элемент	Монгол Улс	ОХУ
1	Үйл ажиллагааны зарчим	Цагдаагийн байгууллагын мөрдөгч нарын хувьд Цагдаагийн албаны тухай	ОХУ-ын Мөрдөн шалгах хорооны тухай хуулийн 5

[3] Федеральный закон "О Следственном комитете Российской Федерации" от 28.12.2010 N 403-ФЗ

[4] Указ Президента РФ от 14.01.2011 N 38 (ред. от 01.07.2020) "Вопросы деятельности Следственного комитета Российской Федерации"

		хуулийн 5 дугаар зүйл. АТГ-ын мөрдөгчийн үйл ажиллагааны зарчмыг тодорхойлсон хэм хэмжээ байхгүй. Тагнуулын байгууллагын мөрдөгчийн хувьд Тагнуулын байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлд үйл ажиллагааны зарчмыг тодорхойлсон. Гэсэн хэдий ч нийтлэг зарчмын тухай тодорхойлолт байхгүй.	дугаар зүйл. Үйл ажиллагааны зарчимын талаар тусгасан байдаг.
2	Эрх зүйн чадамж	Салбарын хуулиар зохицуулсан байдаг. ЦАТХ-ийн 66-р зүйл. АЭХ-ийн 19-р зүйл. ТБТХ-ийн 17-р зүйл.	ОХУ-ын Мөрдөн шалгах хорооны тухай холбооны хуулийн 5 дугаар бүлэгт ямар хүнийг мөрдөн байцаагчаар томилж болох талаар хуульчилсан.
3	Эрх, үүргээ хэрэгжүүлэх баталгаа	ЦАТХ-ийн 83-86 дугаар зүйл. АЭХ-ийн 5 дугаар бүлэг. ТБТХ-ийн 24-р зүйл.	ОХУ-ын Мөрдөн шалгах хорооны тухай холбооны хуулийн 31-р зүйл.
4	Эрх хэмжээ	Бүх байгууллагын мөрдөн шалгаха ажиллагаа явуулах эрх бүхий хүний хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйл.	УПК /Эрүүгийн процессийн тухай хууль/ 38-р зүйл.
5	Үүрэг		
6	Хариуцлага хүлээх	Нарийвчилсан зохицуулалт байхгүй.	Мөн хуулийн 29-р зүйлд ямар процессийн дагуу мөрдөн байцаагчийн эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаарх зохицуулалтыг заасан.

Уг хүснэгтээс үзэхэд, Монгол Улсын хувьд мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй эрх бүхий субьектийн эрх зүйн байдлыг бүрэн гүйцэт зохицуулаагүй, мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй байгууллагуудын онцлогоос хамаарч салбарын хэм хэмжээгээр харилцан адилгүй зохицуулалттай байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч прокурор, шүүхийн байгууллагууд нь бие даасан эрх зүйн байдлыг нь тодорхойлсон хуультай байхад, мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй албан тушаалтны эрх зүйн байдлыг тодорхойлсон хууль байхгүй байгаа нь мөрдөн шалгах институцийг зохион байгуулалтгүй байдалд хүргэж улмаар

мөрдөн шалгах ажиллагааны үед хүний эрх зөрчигдөх эрсдлийг бий болгосоор байна.

Иймээс мөрдөгчийн эрх зүйн байдлын талаар шинжлэх ухааны үндэслэл бүхий судалгаа хийж, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох, эрх зүйн зохицуулалтыг төгөлдөржүүлэх шаардлагатай байна.

Дүгнэлт

Онолын хувьд эрх зүйн байдал нь үйл ажиллагааны зарчим, эрх зүйн чадамж, эрх, үүрэг, баталгаа, хариуцлага зэрэг элементүүдийн нийлбэр цогц бөгөөд Монгол улсын хувьд мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй албан тушаалтны эрх зүйн байдлыг тусгасан нэгдсэн хууль батлагдаагүй, зохицуулсан хэм хэмжээ байхгүй, харин салбарын хуулинд дурьдах байдлаар зохицуулсан байна гэж үзэж болохоор байна. Энэ нь мөрдөн шалгах ажиллагааны онцлогыг харгалзан нарийн зохион байгуулаагүйгээс бусдын эрх, эрх чөлөөг үндэслэлгүйгээр хязгаарлах, зөрчих эрдслийг бий болгож байна.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа албан тушаалтны эрх зүйн байдлын асуудлыг хуулиар тогтоосноор хүний эрхийг хангах нэг том баталгаа төдийгүй мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй алба хаагчдын ажил үүргийн зохион байгуулалттыг сайжруулах, алба хаагчдын эрсдэлтэй нөхцөл байдалд орохоос урьдчилан сэргийлэх, албандаа итгэх итгэл дээшлэх зэрэг ач холбогдолтой.

Энэ бүхнийг нэгтгэн дүгнэхэл мөрдөгчийн эрх зүйн байдал гэх ойлголтод Эрүүгийн процессийн хуульд заасан эрх зүйн хэм хэмжээнээс гадна Үндсэн хууль бусад хуульд заасан эрх зүйн байдлын бэхжүүлсэн хэм хэмжээг цогц байдлаар авч үзэх шаардлагатай.

Санал

Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтны эрх зүйн байдлыг нэг мөр тодорхойлсон хуулийг батлах, нарийн зохицуулсан хэм хэмжээний актыг бий болгох.

Ашигласан эх сурвалж

Хууль, эрх зүйн акт

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он,
2. Цагдаагийн албаны тухай хууль 2017 он,
3. Авлигын эсрэг хууль 2006 он,
4. Тагнуулын байгууллагын тухай хууль 1999 он,
5. Прокурорын байгууллагын тухай хууль 2017 он,
6. Мөрдөн шалгах хорооны тухай холбооны хууль /ОХУ/ 2010 он,

7. Мөрдөн шалгах хорооны үйл ажиллагааны дүрэм /ОХУ/ 2011 он,

Ном, товхимол

1. Т.Оюунчимэг “Гэрч” УБ.,2002 он,
2. Ч.Нямсүрэн “Эрх зүйн ерөнхий онол” УБ.,2015 он,
3. Ч.Нямсүрэн “Гэмт хэргийн виктомологи” УБ.,2017 он,
4. А.И.Лепешкин “Проблемы права и свобод” журнал 12 Москва 2015г.

Цахим эх сурвалж

1. www.legalinfo.mn
2. www.consultant.ru
3. ОХУ-ын эрдэмтэн А.Б.Венгеров эрх зүйн байдлыг эрх, эрх чөлөө, үүрэг, хүлээх хариуцлагын нийлбэр, харин А.И.Лепешкин дээрх тодорхойлолт дээр тухайн этгээдийн эрх, үүргээ хэрэгжүүлэх баталгаа, Л.Д.Воеводин эрх зүй чадамж, үйл ажиллагааны зарчим гэх ойлголтуудыг хамруулан илүү өргөн хүрээнд тодорхойлсон байна.

ШИНЭ БОЛОН НЭН ШИНЭ ҮЕИЙН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ГЭМТ ХЭРГИЙГ ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААГ ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ

REGULATION OF THE STATUTE OF LIMITATION IN THE MODERN AND POST-MODERN CRIMINAL CODES OF MONGOLIA

Г.Халиунаа
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан, Дотоод хэргийн их сургуулийн докторант
Khaliunaa.G
Senior Researcher, The National Legal Institute of Mongolia, Ph.D. Candidate, The University of Internal Affairs

Түлхүүр үг: Эрүүгийн хууль, гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, шинэ үеийн эрүүгийн эрх зүй, нэн шинэ үеийн эрүүгийн эрх зүй

Keywords: Criminal Law; Statute of Limitation; Criminal Law in the Modern Era; Criminal Law in the Post-Modern Era

Товч агуулга: Энэхүү өгүүллээр Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан “гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа”-ны зохицуулалтыг шинэ болон нэн шинэ үеийн Эрүүгийн хуульд хэрхэн хуульчилж ирсэн түүхэн хөгжлийг харьцуулан, уг зохицуулалтын онцлогийг тодорхойлохыг хичээлээ.

Abstract: The article illustrates the Statute of Limitation which is regulated in Article 1.10 of the Criminal Code of Mongolia, compares its historical development by Criminal Codes during the Modern and Post-Modern Era, and tries to determine the nature of the regulation.

Удиртгал

Монголын нутагт төр, эрх зүй үүсэн хөгжсөн нь 2200 гаруй жилийн түүхтэй гэж үздэг.[1] Монгол Улс дахь эрүүгийн эрх зүйн үүсэл хөгжлийн түүхэн тоймын асуудлыг монголын төр, хууль цаазын түүхэн он дараалалд ангилан үзвэл:

1. Монголын эртний эрүүгийн эрх зүй;
2. Монголын дундад үеийн эрүүгийн эрх зүй;
3. Монголын шинэ үеийн эрүүгийн эрх зүй;
4. Монголын нэн шинэ үеийн эрүүгийн эрх зүй гэсэн үеүдэд МУ-ын төр, эрх зүйн түүхэн уламжлалын[2] зохицолтой уялдуулан үзэж болох юм.

Төрт ёсны хөгжлийн энэхүү үе шат бүхэнд нийгэм, эдийн засаг, улс төрийн онцлог байдалтай уялдан тухайн цаг үеийнхээ нийгмийн харилцааг зохицуулах хууль цаазыг, түүний дотор эрүүгийн хууль цаазыг боловсруулан дагаж мөрдөж иржээ. Эдгээр хууль цаазын түүхэн уламжлалын асуудлыг онол, арга зүйн үүднээс үнэн зөв ойлгон судлах нь ихээхэн ач холбогдолтой юм.

[1] И.Дашням. Монголын төр эрх зүйн түүх, III бүлэг, Монгол Улсын төр, эрх зүйн үндэс, Уб., 1998, 51 дэх тал.
[2] Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан, Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал, Уб., 1997 он, 9-10 дахь тал.

Тус өгүүллээр 1920-иод оноос өнөөг хүртэлх эрүүгийн эрх зүйн түүхэн хөгжил, түүний дотор гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны асуудлыг нарийвчлан авч үзэх тул эртний болон дундад үеийн эрүүгийн эрх зүйн ойлголтыг энд дурдаагүй бөгөөд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны талаарх зохицуулалтыг тусгасан Эрүүгийн хуулиудыг үндсэн хоёр бүлэгт хуваан авч үзлээ. Үүнд:

1/ шинэ үеийн Эрүүгийн хуулиуд буюу 1920-иод оноос 1990 он хүртэлх[3];

2/ нэн шинэ үеийн Эрүүгийн хуулиуд буюу 1990 оноос өнөөг хүртэлх[4].

Үндсэн хэсэг

Монгол Улсад 1924 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр анхны Үндсэн хуулийг батлан гаргасан нь эрүүгийн эрх зүйд томоохон өөрчлөлт оруулсан гэж үзэж болох юм. Үүнтэй уялдан 1926 онд Эрүүгийн хууль батлагдсан бөгөөд энэ хуулийг түүхнээ анхны бие даасан Эрүүгийн хууль[5] гэж үздэг.

Нэгэнт сэдвийн маань агуулга гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны түүхэн уламжлалын талаар бичигдэх учраас дээр дурдсан бүлгийн хүрээнд зохицуулалтыг харьцуулан авч үзье.

Нэг. Шинэ үеийн Эрүүгийн хуулиудад гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны талаар хуульчилсан нь:

Онолын хувьд гэмт хэргийг хөөн хэлэалцэх хугацаа нь 1/эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа, 2/шүүхийн таслан шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацаа гэсэн хоёр ойлголт бий. Хууль ёсны зарчмын үүднээс эрүүгийн хариуцлага гарцаагүй байх ёстой ч хөөн хэлэлцэх хугацаа дууссан тохиолдолд шударга ёсны зарчмыг удирдлага болгон гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж байгаа нь хууль зүйн үндэслэлтэй юм.

Хүснэгт 1. Шинэ үеийн Эрүүгийн хуульд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны талаар хуульчилсан байдал:

<table>
<tr><th>№</th><th>Хуулийн нэр</th><th>Батлагдсан огноо</th><th>Хуулийн бүтэц</th><th colspan="2">Холбогдох зүйл, заалт</th></tr>
<tr><td rowspan="2"></td><td rowspan="2">БНМАУ-ын Шүүх цаазын бичиг[6]</td><td rowspan="2">1926.10.21</td><td rowspan="2">31 бүлэг, 227 зүйл</td><td colspan="2">Тавдугаар бүлэг
Ялыг хорогдуулах ба хөнгөтгөх нь 28 дугаар зүйл</td></tr>
<tr><td>Аливаа гэмт явдал үйлдсэн хүн мэдэгдсэн үгүй явсаар дор заасан хугацааны дотор гэм</td><td></td></tr>
</table>

[3] Б.Ганболд, Монгол Улсын эрүүгийн эрх зүйн тойм, Уб., 2003 он, 14 дэх талаас дэлгэрүүлэн үзнэ үү.
[4] Мөн тэнд, 16 дахь талаас дэлгэрүүлэн үзнэ үү.
[5] Б.Содовсүрэн, БНМАУ-ын эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт, Уб., 1971 он, 45 дахь тал.
[6] Б.Баярсайхан нар, Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал 1911-2009, Уб., 2011 он, 285 дахь тал, Хууль зүйн үндэсний хүрээлэн

				(тийм гэмт явдал) үл гаргаваас ялыг үл хэлэлцэнэ. Үүнд дор ялыг хүнд хөнгөнд (тааруулж) дагалдуулж анхны гэмт явдал үйлдсэн өдрөөс бодож тогтоосон хугацааг нь: 1. Алах ял бүхий хэрэг дор 12 жил; 2. 8-10 жил хүртэл гянданд хоригдох ял бүхий хэрэгт 9-11 жил; 3. 5-7 жил хүртэл хоригдох ял бүхий хэрэгт 6-8 жил; 4. 2-4 жил хоригдох ял бүхий хэрэгт 3-5 жил; 5. 1 жил хүртэл хоригдох ял бүхий хэрэгт 2 жил болно.	
2.	БНМАУ-ын Шүүх цаазын бичиг[7]	1929.09.23	30 бүлэг, 227 зүйл	**Гуравдугаар бүлэг** **Ял үл хэлэлцэх нь 24 дүгээр зүйл**	
				Аливаа гэмт явдал үйлдсэн хүмүүн мэдэгдээгүй явсаар дор дурдсан хугацааны дотор дахин гэм гаргаагүй аваас ял үл хэлэлцмой. Үүнд дор ялын хүнд хөнгөн дор тооцоолж анх гэмт хэрэг үйлдсэн өдрөөс бодож тогтоосон хугацаа нь: 1. Буудан алах ял бүхий хэрэг дор 12 жил; 2. 8-10 жил хоригдох ял бүхий хэрэг дор 9-11 жил; 3. 5-7 жил хоригдох ял бүхий хэрэг дор 6-8 жил; 4. 2-4 жил хүртэл хоригдох ял бүхий хэрэг дор 3-5 жил;	

[7] Мөн тэнд, 315 дахь тал.

				5. 1 жил хүртэл хоригдох ял бүхий хэрэг дор 2 жил.	
3.	БНМАУ-ын Шүүх цаазын бичиг[8]	1934.05.14	14 бүлэг, 154 зүйл	**Гуравдугаар бүлэг Шүүх цаазны бодлогын ерөнхий үүсэл нь**	
				8 дугаар зүйл	**9 дүгээр зүйл**
				Шүүх цаазын ёсоор хөөн байцааж үл болох шалтгаануудад: 1. Гэмт хэрэг үйлдсэн бөгөөд энэхүү хэргийн тухайд шүүн таслах газраас нэгэн жил хүртэл хорих буюу өөр хөнгөн ял шийтгэх агсан боловч 3 жил өнгөрвөл; 2. Шүүн таслах газраас нэгэн жилээс дээш боловч таван жилээс илүүгүй хугацаагаар хорих ял шийтгэх агсан бөгөөд уул гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш таван жил хүртэл өнгөрвөл. 3. Шүүн таслах газраас таван жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэх агсан боловч нэгэнт уул гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван жил өнгөрсөн бол шүүх цаазын ёсоор хөөн байцааж үл болно. Хэрвээ дээр заасан хугацааны дотор гэмт хэрэг үйлдэгчээс дахин урьд лугаа нэгэн төрлийн буюу нэгэн мөн түүнээс хөнгөн бус гэмт хэрэг үйлдвээс удсаны хугацааг хоёрдугаар удаагийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн тоолмой.	Шүүн таслах газрын таслан шийтгэсэн тогтоол нь уул шийтгэн гаргасан өдрөөс эхлэн 10 жилийн дотор, хэрэв гүйцэтгэсэн үгүй аваас гүйцэтгэх явдал үгүй болмой
4.	БНМАУ-ын Эрүүг	1942.01.17	16 бүлэг, 219 зүйл	**13 дугаар зүйл**	**14 дүгээр зүйл**
				Эрүүгийн хуулийн ёсоор хөөн шийтгэж үл болох шалтгаануудад:	Шүүн таслах газрын таслан шийтгэсэн тогтоол нь уул

[8] Мөн тэнд, 346 дахь тал.

	ийн хууль [9]			1. Гэмт хэрэг үйлдсэн бөгөөд энэхүү хэрэгт шүүх таслах газраас нэгэн жил хүртэл хорих буюу өөр хөнгөн ял шийтгэх байсан боловч 3 жил өнгөрсөн байвал; 2. Шүүх таслах газраас нэгэн жилээс дээш, 5 жилээс хэтрэхгүй хугацаагаар хорих ял шийтгэх байсан боловч уул гэмт хэрэг үйлдсэнээс хойш 5 жил өнгөрсөн байвал; 3. Шүүх таслах газраас 5 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэх байсан боловч нэгэнт уул гэмт хэрэг үйлдсэнээс хойш 10 жил өнгөрсөн байвал тус тус хөөн шийтгэж үл болно. Хэрэв дурдсан хугацаанд уул үйлдсэн гэмт хэрэг нь мөрдөн байцаах буюу шүүх таслах газар мэдэгдээгүй байвал он удаж мэдэгдээгүй хэрэгт үзэж он улирсан явдлыг хэрэглэнэ. Ийнхүү удах завсар уул үйлдсэн гэмт хэрэг нь мөрдөн байцаах газар мэдэгдэх буюу мөн энэ хугацааны дотор уул хүн дахин нэг төрлийн буюу өөр хөнгөн бус гэмт хэрэг өдүүлбэл он удсаны хугацааг хоёр дугаар удаагийн гэмт хэрэг өдүүлсэн өдрөөс эхлэн тоолно. Тайлбарлах нь: Хувьсгалын эсэргүү гэмт хэргийн учир эрүүгийн хариуцлагад	шийтгэн гарсан өдрөөс эхлэн арван жилийн дотор гүйцэтгэгдээгүй байвал гүйцэтгэх явдалгүй болно.

[9] Мөн тэнд, 361 дэх тал.

				татагдах болбол он удаж улирсан явдлыг үл хэрэглэнэ.	
5.	БНМАУ-ын Эрүүгийн хууль[10]	1961.01.31	11 бүлэг 221 зүйл	**36 дугаар зүйл Эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа**	**37 дугаар зүйл Ял шийтгэлийг хөөн хэлэлцүүлж болохгүй хугацаа**
				Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэмт хэрэг үйлдсэнээс хойш дор дурдсан хөөн хэлэлцэх хугацаанд эрүүгийн хариуцлагад татаж болохгүй. 1. Хуульд зааснаар хорих ял оногдуулж болохгүй хэрэг үйлдсэнээс хойш хоёр жил өнгөрсөн; 2. Хуульд зааснаар 2 жилээс дээшгүй хугацаагаар хорих ял оногдуулж болох байсан боловч гурван жил өнгөрсөн; 3. Хуульд хоёроос доош таван жилээс дээшгүй хугацаагаар хорих ял оногдуулж болох байсан боловч гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн; 4. Хуульд таван жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болох байсан боловч гэмт хэрэг үйлдсэнээс хойш найман жил өнгөрсөн. Хэрэв уг этгээд хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байхад хоёр жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болох гэмт хэрэг шинээр үйлдвэл хөөн хэлэлцэх хугацааг тоолох явдал тасрах бөгөөд хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг	Ял шийтгэсэн тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн биелэгдээгүй дор дурдсан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн бол биелүүлэх явдалгүй. 1. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу өөр хөнгөн ялаар шийтгэгдсэн боловч хоёр жил өнгөрсөн; 2. Хоёр жилээс доошгүй хугацаагаар хоригдох, уг нутгаас зайлуулах, эсхүл ямар нэгэн тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу ажил хэрэг эрхлэхийг хориглох ялаар шийтгэгдсэн боловч гурван жил өнгөрсөн; 3. Хоёроос дээш таван жилээс дээшгүй хугацаагаар хоригдох ял шийтгэгдсэн боловч таван жил өнгөрсөн; 4. Таван жилээс дээш хугацаагаар хоригдох ял шийтгэгдсэн боловч найман жил өнгөрсөн. Хэрэв ял шийтгэгдсэн этгээд ял эдлэхээс зайлсхийсэн буюу 1 жилээс доошгүй хугацаагаар хорих буюу нутаг зааж

[10] Мөн тэнд, 430 дахь тал.

				шинээр үйлдсэн өдрөөс эхлэн тоолно. Хэрэв гэмт хэрэг үйлдсэн этгээд мөрдөн байцаалт ба шүүхээс оргон зайлсхийж байгаа бол хөөн хэлэлцэх хугацааг тоолох явдлыг зогсооно. Энэ тохиолдолд уг этгээдийг албадан саатуулсан буюу түүнийг хэргээ хүлээсэн, илчлэн ирсэн өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолно. Тэгэхдээ гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван жил өнгөрсөн бөгөөд гэмт хэрэг шинээр үйлдэж хөөн хэлэлцэх хугацаа тасраагүй бол эрүүгийн хариуцлагад татаж болохгүй. Цаазаар авах ял оногдуулж болох гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Хэрэв шүүх хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх боломжгүй гэж үзвэл цаазаар авах ял оногдуулж болохгүй, түүнийг хорих ялаар солино.	суулгах, эсхүл уг нутгаас зайлуулах нь оногдуулж болох гэмт хэрэг шинээр үйлдвэл хөөн хэлэлцэх хугацааг тоолох явдал тасрах бөгөөд хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг шинээр үйлдсэн буюу ял эдлэхээс зайлсхийсэн этгээд ялаа эдлэхээр ирсэн, эсхүл шийтгэгдэж оргосон этгээдийг албадан саатуулсан өдрөөс эхлэн тоолно. Тэгэхдээ шийтгэх тогтоол гарснаас хойш 10 жил өнгөрсөн бөгөөд гэмт хэрэг шинээр үйлдэж хөөн хэлэлцэх хугацаа тасраагүй бол уг тогтоолыг биелүүлж болохгүй. Цаазаар авах ял шийтгэгдсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Хэрэв шүүх хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх боломжгүй гэж үзвэл цаазаар авах ялыг хорих ялаар солино.
6.	Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Эрүүгийн	1986.12.05	13 бүлэг,301 зүйл	**44 дүгээр зүйл Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа**	**45 дугаар зүйл Таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацаа**
				1. Хэрэв дор дурдсан хугацаа өнгөрвөл гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй: а) Энэ хуульд зааснаар	1. Таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш дор дурдсан хугацаанд

	хууль[11]			хорих ял оногдуулж болохгүй гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш хоёр жил өнгөрсөн; б) энэ хуульд зааснаар хоёр жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болохгүй гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш гурван жил өнгөрсөн; в) энэ хуульд зааснаар таван жилээс дээш хугацаагаар хорих, эсхүл түүнээс хүнд ял оногдуулж болох гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш арван жил өнгөрсөн. 2. Хэрэв дээр дурдсан хугацаа өнгөрөөгүй байхад энэ хуульд зааснаар хоёр жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болох гэмт хэрэг шинээр үйлдвэл хөөн хэлэлцэх хугацаа тасрах бөгөөд энэ тохиолдолд уг хугацааг сүүлчийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн шинээр тоолно. 3. Гэмт хэрэг үйлдсэн этгээд мөрдөн байцаалт буюу шүүхээс оргон зайлсан бол хөөн хэлэлцэх хугацааг тоолох явдлыг зогсооно. Энэ тохиолдолд уг этгээдийг албадан саатуулсан буюу түүний хэргээ илчлэн ирсэн өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолно. Тэгэхдээ гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван таван жил өнгөрсөн бөгөөд гэмт	биелүүлээгүй бол биелүүлж болохгүй. а) Хорихоос өөр төрлийн хөнгөн ял шийтгүүлсэн боловч хоёр жил өнгөрсөн; б) Хоёр жилээс дээшгүй хугацаагаар хорих ял шийтгүүлсэн боловч гурван жил өнгөрсөн; в) Таван жилээс дээшгүй хугацаагаар хорих ял шийтгүүлсэн боловч таван жил өнгөрсөн; г) Таван жилээс дээш хугацаагаар хорих, эсхүл түүнээс хүнд ял шийтгүүлсэн боловч арван жил өнгөрсөн. 2. Хэрэв ялтан ял эдлэхээс зайлсхийсэн буюу хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байхад гэмт хэрэг шинээр үйлдэж шүүхээр нэг жилээс доошгүй хугацаагаар хорих, эсхүл гурван жилээс доошгүй хугацаагаар нутаг заах буюу уг нутгаас зайлуулах ял шийтгүүлсэн бол хөөн хэлэлцэх хугацаа тасарна. Гэмт хэрэг шинээр үйлдсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг уг гэмт хэргийг үйлдсэн өдрөөс, ял эдлэхээс зайлсхийсэн тохиолдолд ялтан ялаа эдлэхээр эргэж ирсэн буюу түүнийг албадан саатуулсан өдрөөс эхлэн шинээр тоолно. Тэгэхдээ

[11] Мөн тэнд, 527 дахь тал.

				хэрэг шинээр үйлдэж хөөн хэлэлцэх хугацаа тасраагүй бол эрүүгийн хариуцлагад татаж болохгүй. 4. Хуульд зааснаар цаазаар авах ял оногдуулж болох гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Хэрэв шүүх түүнд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх боломжгүй гэж үзвэл цаазаар авах ял оногдуулж болохгүй бөгөөд уг ялын оронд хорих ял хэрэглэнэ.	таслан шийдвэрлэх шийтгэх тогтоол гарсан өдрөөс хойш арван таван жил өнгөрсөн бөгөөд гэмт хэрэг шинээр үйлдэж хөөн хэлэлцэх хугацаа тасраагүй бол таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлж болохгүй. 3. Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Хэрэв шүүх хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх боломжгүй гэж үзвэл цаазаар авах ялыг хорих ялаар солино.

1926 болон 1929 оны Шүүх цаазын бичигт хөөн хэлэлцэх хугацааны зөвхөн нэг төрлийг буюу эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааны талаар заасан бөгөөд энэ нь 2-12 жил байхаар хуульчилжээ.

Харин 1934 оны Шүүх цаазын бичигт өмнөх оны Шүүх цаазын бичгүүдэд тусгаагүй байсан таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааны талаар анх удаа тусгасан бөгөөд энэ нь бүх шийтгэлд нэгэн адил 10 жил байхаар хуульчлагдсан байна.

Түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулж болох ялын байдалтай нь харьцуулан 3-10 жил (дээд, доод хязгаар) байхаар нарийвчлан тогтоожээ. Өөрөөр хэлбэл, өмнөх Шүүх цаазын бичгүүдтэй харьцуулахад гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааны доод хязгаар нь 1 жилээр нэмэгдэж, дээд хязгаар нь 2 жилээр багассан[12] байна.

БНМАУ-ын VII Их Хурал 1940 оны 6 дугаар сард хуралдан БНМАУ-ын шинэ Үндсэн хуулийг батлан гаргасан. Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд "БНМАУ болбоос эзэрхэг түрэмгий ба феодалын дарлалыг устгасан, цаашид нийгэм, журамд дэвшин орох учир улс орноо хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх явдлыг хангаж бүх хөдөлмөрчин (малчин, ажилчин, оюутан) ардын тусгаар тогтносон улс мөн болно" гэж тус улсын шинж байдлыг тодорхойлжээ.[13]

[12] Г.Гантөмөр, О.Амарсайхан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй дэх хугацаа, Уб., 2004 он, 79 дэх тал.

[13] Ж.Амарсанаа, О.Батсайхан, Монгол Улсын Үндсэн хууль: Баримт бичиг /1924, 1940, 1960, 1992/, Уб., 2004 он

Ийнхүү шинэчлэн баталсан Үндсэн хуулийн зарчимд нийцүүлэн бусад салбар эрх зүйн актыг шинээр батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагын хүрээнд 1942 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр хуралдсан Улсын 25 дугаар Бага Хурлаар Шүүх цаазын бичгийг Монгол Улсын эрүүгийн эрх зүйн түүхэнд анх удаа "БНМАУ-ын Эрүүгийн хууль" нэртэйгээр батлан гаргасан байна.

Өмнөх 1934 оны Шүүх цаазын бичгийн заалттай харьцуулахад 1942 оны Эрүүгийн хуульд хөөн хэлэлцэх хугацааны талаарх заалт нь зарчмын ялгаа байхгүй. Харин хувьсгалын эсэргүү гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхийг хориглох заалтыг шинээр нэмж өгчээ.[14]

БНМАУ-ын Ардын Их Хурлын II чуулганаар (1961 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр) Эрүүгийн хуулийг 11 бүлэг 221 зүйлтэй баталж, улмаар мөн оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн юм. Ингэхдээ 1942 оны Эрүүгийн хуульд хэд хэдэн үндсэн өөрчлөлтийг хийх шаардлагатай болсон бөгөөд уг хуулиар гэмт хэрэгт тооцогдож байсан зарим нийгмийн үзэгдлийг нийгэмд аюултай шинжээ алдсан гэх үндэслэлээр Эрүүгийн хуулиас хасч, нийгэмд аюултай зарим үзэгдлийг шинээр гэмт хэрэгт тооцож, Эрүүгийн хуульд нэмэлт оруулжээ. Тухайлбал, “Төрөөс шашныг тусгаарлах тухай хууль дүрэм зөрчих", "Ураг төрлийн ба феодалын байгууллын зан суртахууны үлдэгдэл болсон гэмт явдлуудын тухай" хэмээх 1942 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 5 болон 11 дүгээр бүлэг хасагдаж "Социалист өмчийн эсрэг гэмт хэргүүд", "Социалист аж ахуйн эсрэг гэмт хэргүүд", “Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэргүүд" хэмээх бүлгүүдийг шинээр нэмж оруулсан байна.

Энэхүү хуулиар "хөөн хэлэлцэх хугацаа" гэсэн нэр томьёог анх удаа томьёолж, уг ойлголтыг боловсронгуй болгосон юм. Тухайлбал, уг хуульд гэмт хэрэг үйлдсэн этгээд хэргийг нь мөрдөн шалгах явцад оргон зайлсан тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, уг этгээдийг албадан саатуулсан буюу түүнийг хэргээ илчлэн ирсэн өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолохоор, үүнээс гадна нэг төрлийн буюу өөр хөнгөн бус гэмт хэрэг үйлдэхэд хөөн хэлэлцэх хугацаа тасардаг байсныг өөрчилж зөвхөн 2 жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болох гэмт хэрэг шинээр үйлдвэл хөөн хэлэлцэх хугацаа тасардаг байхаар хуульчилжээ.

Мөн 1942 оны Эрүүгийн хуулиар Хувьсгалын эсэргүү гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэдэггүй байсан бол 1961 оны хуулиар тодорхой төрлийн хэрэгт биш зөвхөн цаазаар авах ял оногдуулж болохоос бусад бүх хэрэгт хэрэглэхээр заасан байна. Түүнчлэн цаазаар авах ял оногдуулж болох хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг ямар ч тохиолдолд хэрэглэдэг байсныг болиулж үүнийг шүүхийн эрх мэдэлд шилжүүлж шийдвэрлэх боломжгүй гэж үзвэл цаазаар авах ялыг хорих ялаар сольж байхаар[15] болжээ.

[14] Г.Гантөмөр, О.Амарсайхан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй дэх хугацаа, Уб., 2004 он, 80 дахь тал.

[15] Г.Гантөмөр, О.Амарсайхан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй дэх хугацаа, Уб., 2004 он, 83 дахь тал.

Энэ хуулиар эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааг 2-8 жил байхаар заасан бол таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааг нарийн ялгавартайгаар авч үзэн уг тогтоол нь 10 жилийн дотор гүйцэтгэгдээгүй бол гүйцэтгэх явдалгүй гэсэн ерөнхий баримжаалсан хугацааг өөрчилж энэ хугацааг гэм буруутай этгээдэд шүүхээс оногдуулсан ялын төрөл, хугацаагаар ялган 2-8 жил байхаар тогтоож өгсөн юм.

АИХ-ын Тэргүүлэгчдийн 21 дүгээр зарлигаар (1986 оны 12 дугаар сарын 5-ны өдөр) 1961 оны Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулж 1987 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлжээ.

1986 оны Эрүүгийн хуульд хөөн хэлэлцэх хугацааны талаар бэхжүүлсэн заалтууд нь 1961 оны Эрүүгийн хуулиас онцын ялгагдах зүйлгүй бөгөөд 5 жилээс дээш хугацаагаар хоригдох ял шийтгэгдсэн боловч 8 жил өнгөрсөн гэж байсныг 5 жилээс дээш хугацаагаар хорих, эсхүл түүнээс хүнд ял шийтгүүлсэн боловч 10 жил өнгөрсөн гэж, хөөн хэлэлцэх хугацааны дээд хязгаар 10 жил байсныг 15 жил болгон өөрчилжээ.[16]

Мөн уг нутгаас зайлуулах ял шийтгэсэн таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацаа 3 жил байсныг 2 жил, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял шийтгэсэн таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацаа 3 жил байсныг 2 жил болгон тус тус өөрчилсөн байна.

Хоёр. Нэн шинэ үеийн Эрүүгийн хуулиудад гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны талаар хуульчилсан нь:

Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн 1997 оны 04 тоот зөвлөмж, УИХ-ын мөн оны 89 дүгээр захирамжийг үндэслэн Засгийн Газраас Эрүүгийн хуулийн төслийг боловсруулж УИХ-д өргөн барьсан бөгөөд улмаар 2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр УИХ-аас Эрүүгийн хуулийг батлалсан.

Хүснэгт 2. Нэн шинэ үеийн Эрүүгийн хуульд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны талаар хуульчилсан байдал:

№	Хуулийн нэр	Батлагдсан огноо	Хуулийн бүтэц	Холбогдох зүйл, заалт	
1	Эрүүгийн хууль[17]	2002.01.03	12 хэсэг, 31 бүлэг 305 зүйлтэй	**Дөрөвдүгээр хэсэг Эрүүгийн хариуцлага болон ялаас чөлөөлөх**	
				Арван хоёр дугаар бүлэг Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх	**Арван гуравдугаар бүлэг Ялаас чөлөөлөх**

[16] Мөн тэнд, 84 дэх тал.
[17] Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 он, №5

				72 дугаар зүйл. Эрүүгийн хариуцлагад татах хугацаа өнгөрсөн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх 72.1 Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дор дурдсан хугацаа өнгөрвөл гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй: 72.1.1 хөнгөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш зургаан сар өнгөрсөн; 72.1.2 хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн; 72.1.3 хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван таван жил өнгөрсөн; 72.1.4 онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин таван жил өнгөрсөн. 72.2.Гэмт хэрэг үйлдсэн этгээд энэ хуулийн 72.1-д заасан хугацаа өнгөрөөгүй байхад гэмт хэрэг санаатай үйлдвэл хөөн хэлэлцэх хугацаа тасрах бөгөөд энэ тохиолдолд уг хугацааг сүүлчийн хамгийн хүнд гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн тоолно. 72.3. Шүүхийн өмнөх шат буюу шүүхийн шатнаас гэмт хэрэг үйлдсэн этгээд оргон зайлсан бол хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг оргон зайлсан өдрөөс зогсоож уг этгээд баригдсан буюу хэргээ өөрөө илчилж ирсэн өдрөөс хөөн хэлэлцэх	76 дугаар зүйл. Шийтгэх тогтоол биелүүлэх хугацаа өнгөрсөн тохиолдолд ялаас чөлөөлөх 76.1.Шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш дор дурдсан хугацаа өнгөрсөн бол ялтны үндсэн болон нэмэгдэл ялыг эдлүүлж болохгүй. 76.1.1 хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн боловч гурван жил өнгөрсөн; 76.1.2 таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн боловч таван жил өнгөрсөн; 76.1.3 таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн боловч арван жил өнгөрсөн; 76.1.4 арван жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн боловч арван таван жил өнгөрсөн. 76.2 Ялтан ял эдлэхээс зайлсхийсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсооно. Энэ тохиолдолд ялтан цагдан хоригдсон буюу өөрөө сайн дураараа хэргээ илчлэн ирсэн өдрөөс сэргээн тоолно. 76.3 Цаазаар авах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг арван таван жил өнгөртөл биелүүлээгүй бол хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх

				хугацааг сэргээн тоолно. 72.4. Энэ хуульд зааснаар цаазаар авах ял шийтгүүлж болох гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Хэрэв шүүх тухайн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх боломжгүй гэсэн дүгнэлтэд хүрвэл цаазаар авах ял оногдуулж болохгүй бөгөөд уг ялын оронд хорих ял оногдуулна. 72.5. Энэ хуулийн тусгай ангид заасан хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй.	шийдвэрлэнэ. Хэрэв шүүх хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх боломжгүй гэсэн дүгнэлтэд хүрвэл тухайн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд цаазаар авах ял оногдуулж болохгүй бөгөөд уг ялын оронд хорих ял оногдуулна. 76.4 Ялтан энэ хуулийн 76.1-д заасан хугацаа өнгөрөөгүй байхад шинээр гэмт хэрэг үйлдвэл хөөн хэлэлцэх хугацаа тасрах бөгөөд энэ тохиолдолд уг хугацааг сүүлчийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн тоолно. 76.5.Энэ хуулийн тусгай ангид заасан хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт шийтгэгдсэн ялтанд энэ зүйлд заасан хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй.
2	Эрүүгийн хууль [18]	2015.12.03	30 бүлэг, 30 зүйл	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ 1.10 дугаар зүйл. Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа 1.Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй: 1.1.энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын дээд	

[18] Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016 он, №7

				хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн; 1.2.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн; 1.3.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг арван таван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван хоёр жил өнгөрсөн; 1.4.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг арван хоёр жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг хорин жил хүртэл тогтоосон ба бүх насаар хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин жил өнгөрсөн. 1.5.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг зургаан	

				сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн. 2.Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно. 3.Гэмт хэрэг үйлдсэн этгээд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрөөгүй байхад гэмт хэрэг санаатай дахин үйлдвэл хөөн хэлэлцэх хугацааг сүүлчийн гэмт хэргийг үйлдсэн үеэс гэмт хэрэг тус бүрд шинээр тоолно. 4.Энэ хуульд бүх насаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг, хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй. 5.Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш таван жил байна. 6.Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдэж энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бол тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил	

				байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно.	

2002 оны Эрүүгийн хуулийн хөөн хэлэлцэх хугацааны талаарх зохицуулалтыг өмнө нь дагаж мөрдөж байсан Эрүүгийн хуультай харьцуулахад цоо шинэ байдлаар хуульчилсан гэж үзэж болох юм. Учир нь тухайн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан өөрөөр хэлбэл, гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилсан бөгөөд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа буюу эрүүгийн хариуцлагад татах хугацааг гэмт хэргийн ангиллаас[19] хамаарч тоолохоор зохицуулж, уг хугацааг 6 сараас 20 жил, таслан шийдвэрлэх шийтгэх тогтоол биелүүлж болохгүй хугацааг 3-15 жил байхаар хуульчилсан байна.

Тэгвэл 2015 оны Эрүүгийн хуулийг батлахдаа гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэргийн ангиллаас хамаарч биш оногдуулж буй ялын төрөл, дээд, доод хэмжээтэй уялдуулан 1-20 жил[20] байхаар тусгагдсан. Тус хуулиар хорих, зорчих эрхийг хязгаарлах, торгох, эрх хасах, нийтэд тустай ажил хийлгэх гэсэн 5 төрлийн ялыг оногдуулахаар тусгаснаас эрх хасах ял нь нэмэгдэл ял бусад нь үндсэн ял[21] бөгөөд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зөвхөн хорих болон зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахаар хуульчилсан гэмт хэргүүдэд л хөөн хэлэлцэх хугацааг тоолох боломжтой хуульчлагдсан байсан бол 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн гэмт хэрэгт буюу торгох ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохоор зохицуулалтыг нэмж хуульчилсан байна. Харин энэхүү хуульд шүүхийн таслан шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааны талаар тусгаагүй юм.

2002 болон 2015 оны Эрүүгийн хуулийг харьцуулан үзэхэд хөөн хэлэлцэх хугацааны хувьд доод хязгаар нь 6 сар байсан нь 1 жил болж, дээд хязгаар нь 20 жил хэвээр хуульчлагджээ.

Түүнчлэн 2002 оны Эрүүгийн хуульд “гэмт хэрэг үйлдсэн этгээд 72.1-д заасан хугацаа өнгөрөөгүй байхад гэмт хэрэг санаатай үйлдвэл хөөн хэлэлцэх хугацаа тасрах бөгөөд энэ тохиолдолд уг хугацааг сүүлчийн хамгийн хүнд гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн тоолно”[22] гэж зохицуулж байсан бол 2015 оны Эрүүгийн хуульд “гэмт хэрэг үйлдсэн этгээд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрөөгүй байхад гэмт хэрэг санаатай дахин үйлдвэл хөөн хэлэлцэх хугацааг сүүлчийн гэмт хэргийг үйлдсэн үеэс гэмт хэрэг тус бүрд шинээр тоолно”[23] гэж хуульчилжээ. Өөрөөр хэлбэл, 2015 оны Эрүүгийн хуулиар хөөн хэлэлцэх хугацаа тасрах гэсэн ойлголт байхгүй болсон.

[19] Гэмт хэргийн ангиллыг 2002 оны Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлд хуульчилсан.
[20] Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйл.
[21] Г.Халиунаа, Б.Ариунжаргал, “Эрүүгийн хуулийн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны асуудал хүний эрхийг зөрчих нь” , Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2019 он, №1
[22] Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 он, №5
[23] Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016 он, №7

2015 оны хуулиар хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй байхаар заасан нь 2002 оны Эрүүгийн хуулийн зохицуулалттай адил байгаа бол Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар бүх насаар нь хорих ялыг шинээр хуульчилж уг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй гэж зохицуулсан нь өмнөх хуулиасаа ялгаатай байна.

Мөн 2015 оны Эрүүгийн хуулиар тодорхой төрлийн буюу Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш таван жил байхаар шууд тусгаж өгсөн нь онцлог болжээ.

Дүгнэлт

Хөөн хэлэлцэх хугацааны түүхэн уламжлалыг судлан үзэхэд шинэ үеийн төрөлжсөн хууль болох 1926, 1929, 1934 оны Шүүхийн цаазын бичиг, 1942, 1961, 1986 оны Эрүүгийн хуульд тодорхой хэмжээгээр хуульчлагдаж иржээ. Ингэхдээ хөөн хэлэлцэх хугацааны нэг төрөл болох эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааны талаар төрөлжсөн Эрүүгийн хуулиуд батлагдаж байсан эхэн үед буюу 1926, 1929 оны Шүүх цаазын бичигт тусгасан бөгөөд шүүхийн таслан шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааны талаар анх 1934 оны Шүүх цаазын бичгээс эхлэн 2015 оны Эрүүгийн хууль батлагдах хүртэл хуульд тусгаж байжээ. Харин 2015 оны Эрүүгийн хуулийг батлахдаа хуульд шүүхийн таслан шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааны талаар тусгаагүй, зөвхөн эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааны талаар л тусгасан байна.

Түүнчлэн 1934 оноос гэмт хэрэг үйлдсэн этгээдийн ялын байдалтай нь харьцуулан хөөн хэлэлцэх хугацааг тооцдог болсон бол 1942 оноос эхлэн зарим төрлийн тухайлбал, хувьсгалын эсэргүү гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхийг хориглох заалтыг тусгаж байжээ. Харин 1961 оноос хөөн хэлэлцэх хугацаа зогсох, тасрах гэсэн ойлголтыг шинээр хуульчилж, зөвхөн цаазаар авах ял оногдуулж болохоос бусад бүх хэрэгт уг хугацааг тооцохоор хуульчилсан бол 1986 оны Эрүүгийн хууль нь 1961 оны Эрүүгийн хуулиас онцын ялгагдах зүйлгүй бөгөөд хугацааны интервалын хувьд бага зэргийн өссөн, буурсан байдлаар хуульчлагджээ. Харин 2002 оноос хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн ангиллаас хамаарч тооцдог байсан бол 2015 оноос оногдуулж буй ялын төрөл, түүний дээд, доод хэмжээтэй уялдуулан тооцохоор хуульчилсан байна.

Дээр дурдсан үе үеийн Эрүүгийн хуульд хөөн хэлэлцэх хугацааг тооцох доод болон дээд хязгаарыг график байдлаар харьцуулан дүгнэвэл:[24]

[24] Цэнхэр, улаан өнгийн шугамаар эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааг, ногоон болон нил ягаан өнгийн шугамаар таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааг илэрхийлэв.



Графикаас харахад,

1926, 1929 оны Шүүх цаазын бичигт хөөн хэлэлцэх хугацааны нэг төрөл болох эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааны талаар хуульчилсан бөгөөд доод хэмжээ нь 2 жил, дээд хэмжээ нь 10 жил байжээ.

1934, 1942 оны хуульд хөөн хэлэлцэх хугацааны хоёр төрлийг хуульчилсан бөгөөд эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааны доод хэмжээ нь 3 жил, дээд хэмжээ нь 8 жил байсан бол таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацаа нэгэн жигд 10 жил байхаар хуульчилсан байна.

1961 оны Эрүүгийн хуульд хөөн хэлэлцэх хугацааны хоёр төрлийг хуульчилсан бөгөөд доод хэмжээ нь 2 жил, дээд хэмжээ нь 8 жил байхаар ижил хязгаартай хуульчлагдсан бол 1986 оны Эрүүгийн хуульд мөн л хөөн хэлэлцэх хугацааны хоёр төрлийг хуульчилж доод хэмжээ нь 2 жил, дээд хэмжээ нь 10 жил байхаар ижил хязгаартай хуульчлагдсан байна.

2002 оны Эрүүгийн хуулиас энэхүү хөөн хэлэлцэх хугацааны интервалд эрс өөрчлөлт орсон бөгөөд уг хуульд хугацааны хоёр төрлийг хуульчилсан. Ингэхдээ эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааны доод хэмжээ нь 6 сар, дээд хэмжээ нь 20 жил байсан бол таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааны доод хэмжээ 3 жил, дээд хэмжээ 15 жил байхаар хуульчилжээ.

2015 оны Эрүүгийн хуульд хөөн хэлэлцэх хугацааны зөвхөн нэг төрөл болох эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааны талаар тусгасан бөгөөд доод хэмжээ нь 1 жил, дээд хэмжээ нь 20 жил байхаар хуульчилсан байна.

Ашигласан эх сурвалж

Нэг. Хууль тогтоомж:

- БНМАУ-ын Шүүх цаазын бичиг, 1926 он
- БНМАУ-ын Шүүх цаазын бичиг, 1929 он
- БНМАУ-ын Шүүх цаазын бичиг, 1934 он
- БНМАУ-ын Эрүүгийн хууль, 1942 он
- БНМАУ-ын Эрүүгийн хууль, 1961 он
- Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Эрүүгийн хууль, 1986 он
- Эрүүгийн хууль, 2002 он
- Эрүүгийн хууль, 2016 он

Хоёр. Ном, гарын авлага:

- Ж.Амарсанаа, О.Батсайхан, Монгол Улсын Үндсэн хууль: Баримт бичиг /1924, 1940, 1960, 1992/, Уб., 2004
- Б.Баярсайхан нар, Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал 1911-2009, Уб., 2011 он
- Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан, Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал, Уб., 1997
- Б.Ганболд, Монгол Улсын эрүүгийн эрх зүйн тойм, Уб., 2003
- Г.Гантөмөр, О.Амарсайхан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй дэх хугацаа, Уб., 2004 он
- И.Дашням. Монголын төр эрх зүйн түүх, III бүлэг, Монгол Улсын төр, эрх зүйн үндэс, Уб., 1998
- Б.Содовсүрэн, БНМАУ-ын эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт, Уб., 1971

Гурав. Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл:

- Г.Халиунаа, Б.Ариунжаргал, “Эрүүгийн хуулийн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны асуудал хүний эрхийг зөрчих нь”, Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2019 он, №1

ШҮҮХ ЭРХ МЭДЭЛ БА ШҮҮХИЙН ЭРХ ЗҮЙ

JUDICIAL JURISDICTION AND JUDICIAL LAW

Б.Өлзийсайхан
Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Билиг дээд сургуулийн захирал, хууль зүйн доктор, дэд профессор
Ulziisaikhan.B
Director, The Bilig Institute, University of the Humanities, Doctor of law, Associate Professor

Хураангуй: Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулиар төрийн эрх мэдлийг “Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл”-д хуваарилан, төрийн үйл ажиллагаанд баримтлах зарчмыг бэхжүүлж, улмаар уг Үндсэн хуульд заасан суурь хэм хэмжээнд нийцүүлэн эрх зүйн шинэтгэлийг эхлүүлсэн билээ.

Энэхүү эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Шүүх эрх мэдлийн шинэтгэлийг эрчимжүүлэхэд Шүүхийн тухай 1993, 2002 оны хууль, Шүүхийн 2012 оны багц хууль (Шүүхийн тухай, Шүүхийн захиргааны тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль) тодорхой хувь нэмрээ оруулж ирсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан W2019 оны нэмэлт, өөрчлөлтөд Шүүхийн багц хууль болон холбогдох бусад хуулийг нийцүүлэх, эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, төгөлдөршүүлэх үйл явцын хүрээнд Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга[1] (2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр баталж, 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөнө)-ыг тэргүүн ээлжид баталжээ.

Эдгээр эрх зүйн эх сурвалж нь Шүүхийн эрх зүйг бие даасан салбар эрх зүйн хувьд хөгжих шалгуур, эрх зүйн үндэслэлийг шинээр бүрдүүлсэн болно. Шүүхийн эрх зүйг бие даасан салбар эрх зүйн хувьд судлан хөгжүүлснээр Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухааны хөгжилд онолын ач холбогдолтойг илтгэн харуулахын зэрэгцээ эрх зүйн соёл, ухамсар, боловсролыг төлөвшүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах болно.

Abstract: Constitution of Mongolia (1992) divides state power into “legislative, executive and judicial branches”, strengthens the principles of state activity, and initiates legal reform in accordance with the basic norms set forth in the law.

Within the framework of this legal reform, the 1993 and 2002 Laws on Courts and the 2012 Law on Courts (Law on Courts, Law on Judicial

[1] Шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл. Монгол Улсын Их Хурлын албан ёсны мэдээлэл., 2021.02.05. №05/1155. 293-534 дэх тал.

Administration, Law on the Legal Status of Judges, Law on the Legal Status of Lawyers, and Law on the Legal Status of Citizens' Representatives) are needed to intensify judicial reform respectively) have made a significant contribution.

The revised version of the Law on Courts (approved on January 15, 2021 and effective on 1st of March 2021) in line with the 2019 amendments to the Constitution of Mongolia and the process of harmonizing the Judicial Package and other relevant laws, deepening and improving legal reform.

These legal sources provide the criteria and legal basis for the development of an independent branch of judicial law. We are confident that the study and development of judicial law as an independent branch of law will demonstrate the theoretical significance of the development of legal science in Mongolia and will make a real contribution to the development of legal education.

Түлхүүр үгс: Шүүх эрх мэдэл, шүүх, шүүгч, шүүхийн эрх зүй, бие даасан салбар эрх зүй, шүүхийн сахилгын хороо, шүүхийн ёс зүй, шүүхийн захиргаа

Keywords: Judicial power, Court, Judge, Judicial Law, Independent Branch Law, Judicial Disciplinary Committee, Judicial Ethics, Judicial Administration

Оршил

Монгол Улс 1992 оны Үндсэн хуульд анх удаа төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг хэрэгжүүлж хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн суурь үзэл баримтлалыг бэхжүүлснээр дэлхий нийтийн жам ёсны хандлагаар ардчилал, зах зээлийн шинэ нөхцөлд зохицон хөгжих нийгмийн амьдралын бүхий л хүчин зүйлсийг өөрчлөн шинэчлэх үндсийг бүрдүүлсэн байна.

Шүүх эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас бие даасан статустайгаар аливаа байгууллага, этгээдээс хараат бусаар хэрэгжүүлэх баталгааг 1992 оны Үндсэн хуулийн “Төрийн байгуулал” гэсэн Гуравдугаар бүлгийн 4 дэх хэсэг (47-56)-т заасан суурь хэм хэмжээг хэрэгжүүлэхийн тулд Шүүхийн тухай хуулийг 1993, 2002 онд баталсан. УИХ-ын 1993 оны “Шүүхийг өөрчлөн байгуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 60 дугаар тогтоол, УИХ-ын 1996 оны “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 26 дугаар тогтоол, “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”, “Хөтөлбөр, үндсэн чиглэл, төлөвлөгөө батлах тухай” УИХ-ын 1998 оны 18 дугаар тогтоол, “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлах тухай” УИХ-ын 2003 оны 41 дүгээр тогтоол, “Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө батлах тухай” УИХ-ын 2000 оны 39 дүгээр тогтоол, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2004 он хүртэл

боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын 2001 оны 44 дүгээр тогтоол гэх мэт бодлогын баримт бичиг, Шүүхийн тухай багц хууль (2012) (Хуульчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн захиргааны тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай), шүүхийн тухай багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиас үзэхэд шүүхийн захиргаа нь шүүн таслах үйл ажиллагаанаас тусдаа шинэчилсэн зохион байгуулалтад орсон нь шүүх нь бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны хувьд бие даасан эрх зүйн актаар зохицуулагдан салбар эрх зүйн шинжийг тодотгон агуулсан байх тул цаашид боловсронгуй болгох арга замыг судлан тогтоох хэрэгцээ шаардлага үүсч буйг харуулсан билээ.

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ыг баталсан УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоол, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсан УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын 2017 оны 11 дүгээр тогтоол, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” УИХ-ын 2016 оны 51 дүгээр тогтоол, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол зэрэг бодлогын баримт бичигт Монгол Улсын эрх зүйн шинэтгэл, түүний үзэл баримтлал, чиглэлийг тогтоож өгсөн, Шүүх эрх мэдлийн шинэтгэлийг шинэ төвшинд гаргаж буй 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд Шүүхийн багц хуулийг нийцүүлэн 2021 онд Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоол, “Монгол Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” УИХ-ын 2021 оны 23 дугаар тогтоолоор шүүхийн эрх зүйн шалгуур болох бие даасан тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжийг шинэчлэн батлахаар төлөвлөсөн нь цаашид шүүхийн эрх зүйг салбар эрх зүйн хувьд нарийвчлан судлах хэрэгцээ шаардлага үүсч буйг илтгэж байна.

Түүнчлэн шүүх эрх мэдлийн талаар гарсан бүтээлүүдийг судлан үзэхэд шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг судлан тодорхойлж, цаашид дагнан судлах хэрэгцээ буйг зарим судлаач бүтээлдээ дурдсан байдлыг салбар эрх зүйн хувьд тавигдах шалгуурыг хэрхэн агуулж буй талаар нь нарийвчлан судалснаа үүгээр толилуулж байна.

1992 оны Үндсэн хуульд төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл хэмээн хуваарилсан тогтолцоог Г.Совд[2], Д.Лүндээжанцан[3], Ч.Энхбаатар[4], С.Жанцан[5] нарын эрдэмтэд бүтээлдээ шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах онолын үндэслэл, түүний хэрэгжилтийн талаас нь судалсан бол Б.Чимид [6] бүтээлдээ шүүх эрх мэдлийн шинэтгэлийн үйл явцыг дүгнэн шүүхийн захиргааны байгууллагын талаарх Үндсэн хуулийн үзэл баримтлалыг тодотгон тухайлан судлах хэрэгцээ шаардлага буйг илэрхийлсэн, Л.Бямбаа[7] бүтээлдээ Үндсэн хуулийн үзэл баримтлал органик хуульд зарчмын хувьд тусгалаа олсон хэдий ч тэр бүр нарийвчлан зохицуулж чадахгүй байгаа талаар хөндөж, шүүхийн тухай хууль тогтоомжийг сайжруулж шүүхийн зохион байгуулалт, шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн ерөнхий зөвлөл (цаашид ШЕЗ гэх)-ийн тухай бие даасан хууль батлан шүүхийн захиргааны болон мэргэжлийн удирдлага, хяналтын чиг үүргийн хүрээ хязгаарыг тогтоох нь чухал байгааг хөндөж судалсныг тэмдэглэж буй нь салбар эрх зүйн хувьд эх сурвалж нь тодорхой байх шалгуурыг хангаж байна. Харин Н.Лүндэндорж[8] бүтээлдээ хууль тогтоомжийн хангалттай эх сурвалжтай болсноор тухайн эрх зүйн салбар үүсдэг гэж, Ц.Амарсайхан[9] бүтээлдээ эрх зүйг салбар эрх зүй болгон хуваадаг шалгуур нь зохицуулах зүйл бөгөөд нийгмийн харилцаа юм гэж, Б.Өлзийсайхан[10] бүтээлдээ шүүхийн эрх зүй нь бие даасан салбар эрх зүй байх боломжтой гэж тус тус хөндөн бичсэн нь Т.Сэнгэдорж “Аливаа салбар эрх зүйн үндсэн шалгуур нь өөрийн зохицуулах зүйл, зохицуулалтын аргатай, хууль тогтоомжийн зохих баазтай, нийгэм, улс төр, эдийн засаг, хууль зүйн зайлшгүй ач холбогдолтой, өөрийн тогтолцоо, дотоод бүтэцтэй, удирдлага болгох зарчимтай байх ёстой”[11] гэж бүтээлдээ салбар эрх зүйн шалгуур шинжийг тусгасантай нийцэж буйг илэрхийлжээ.

---

[2] Совд, Г. (1997). Шүүх, шүүгчдийн хараат бус байдлыг хангах асуудал. Монголын төр, эрх зүй. №2. Уб.
[3] Лүндээжанцан, Д. (2001). Монгол Улс дахь Төрийн эрх мэдэл хуваарилалт. Уб.
[4] Энхбаатар, Ч. (2001). Шүүхийн хараат бус байдлын харьцуулсан судалгаа. Унгар.
[5] Жанцан, С. (2005). Монгол Улсын шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын тогтолцоо. Уб.
[6] Чимид, Б. (2004). Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл. II дэвтэр. Уб.
[7] Бямбаа, Л. (2006). Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах эрх зүйн асуудлууд. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. Уб., МУИС-ийн ХЗС.
[8] Лүндэндорж, Н. (2017). Шүүх эрх мэдэл. Уб.
[9] Амарсайхан, Ц. (1995). Шүүхийн эрх зүйн үзэл баримтлалын зарим асуудал. Монголын төр, эрх зүй. №3. Уб., (2003). Монгол Улсын Шүүх эрх мэдлийн тогтолцоо ба Шүүхийн эрх зүйн үзэл баримтлалын зарим асуудал. Хууль дээдлэх ёс. №3. Уб.
[10] Өлзийсайхан, Б. (2018). Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд шүүхийн захиргааны гүйцэтгэх үүрэг: Эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. Уб.
[11] Сэнгэдорж., Т.(1994). Байгаль орчныг хамгаалах эрх зүйн асуудал: уламжлал, шинэчлэл. Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Уб.

1992 оны Үндсэн хууль батлагдахаас өмнө Монгол Улсад 10 гаруй салбар эрх зүй байсан гэж үздэг байсан бол, Үндсэн хууль батлагдсанаар эрх зүйг үндсэнд нь нийтийн ба хувийн эрх зүй гэж ангилж үздэг болсон байна. Чухам эрх зүйн ямар салбар байхыг эрдэмтэд эцэслэн шийдвэрлээгүй бөгөөд барилгын, эмнэлгийн гэх мэт ямар ч салбар эрх зүй бий болох боломжтойн нэгэн адил шүүхийн эрх зүй нь бие даасан салбар эрх зүйн байх үндсэн шалгуурыг дараахь байдлаар хангаж байгаа болно. Тухайлбал, 1/ өөрийн зохицуулах зүйлтэй, 2/ зохицуулалтын өвөрмөц аргатай, 3/ эрх зүйн эх сурвалжтай, 4/ бие даасан тогтолцоо, бүтэцтэй, 5/ удирдлага болгох тусгай зарчимтай байна гэдгийг эш үндэс болгож байна. Эдгээрийг үндэслэн шүүхийн эрх зүй нь бие даасан салбар эрх зүй байх боломжтой гэж үзсэний дээр бие даасан тогтолцоо, бүтэцтэй байх шалгуурыг хэрхэн хангаж буй талаар дараахь агуулгыг дурдвал:

Нэг. Үндсэн хуулийн үзэл санааг хэрхэн ойлгож нийтийн эрх зүйн ухамсарт нийцсэн эрх зүйн актыг хэрхэн боловсруулах нь нээлттэй боловч үндсэн эхлэл гэдэг холбоо үгийн язгуур чанарт үнэлэлт өгөх арга зүйгээр тодорхойлох учиртай.

Монгол Улс ардчилсан тогтолцоонд 1990-ээд оноос шилжиж эхэлснээр, хүний эрх, эрх чөлөөг Үндсэн хуулиар бэхжүүлсэн нийгмийн ардчилсан байгууллагыг хамгаалдаг хүчит хэрэглүүр болгох зорилгоор өөрчилж, шинэтгэж эхэлсэн[12] бөгөөд 1990-1992 оны “Үндсэн хуулийн нэмэлтийн хууль” түүний дараа батлагдсан 30 гаруй хууль, 1992 оны Үндсэн хууль баталснаар нийгмийн бүхий л салбарт өөрчлөлт шинэчлэлт хийх “иргэн-төр”-ийн харилцан хамаарал бүхий үзэл баримтлалыг бий болгосон. Монгол Улсын шүүхийн хөгжлийн нэн шинэ үеийн тогтолцооны учир утгыг өмнөхөөс нь сайтар ялган салгаж ойлгох нь эрхэм чухал[13] бөгөөд нийгэм улс төр, эдийн засаг, нийгэмшил, соёл-оюуны амьдралын олон талт харилцааг зохих эрэмбэд оруулан журамлаж, тохируулагч нь эрх зүй, түүний хэрэгжилтийг нягтлан хянан шалгагч нь шүүх гэж хэлж болох юм. Эрх мэдлийг хуваарилах зарчмаар төрийн байгууллагын “хууль тогтоох”, “гүйцэтгэх”, “шүүх” гэсэн гурван салаа бүхий тогтолцоог тодорхойлон бэхжүүлсэн нь Үндсэн хуулийн гол “үзэл баримтлал” - ын нэг, зарчмын эрс шинэлэг тал мөн[14]. Засгийн эрх мэдэл ард түмнээс үүсмэл бөгөөд төрийн эрх мэдлийг засгийн гурван салаанд хуваарилах зарчмыг Үндсэн хуулиар бататгасан нь угтаа /анхдагч утгаараа/ хүний эрхийг хамгаалах, бэхжүүлэх, хөхүүлэн дэмжихэд шууд чиглэсэн буюу зориулагдсан байна[15]. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн

[12] Чимид, Б. (2008). Үндсэн хуулийн мэдлэг. Уб., 305 дахь тал.
[13] Чимид, Б. (2002). Үндсэн хуулийн үзэл баримтлал.Тэргүүн дэвтэр Уб., 114 дэх тал.
[14] Чимид, Б. (2017). Үндсэн хуулийн үзэл баримтлал.Уб., 56 дахь тал.
[15] Чимид, Б. (2006). Үндсэн хууль дээдлэн шүтэх ёс. Уб., 85 дахь тал.

эрхийг сэргээн тогтоох эрхэм зорилго бүхий шүүхийн байгууллагын тогтолцоог Үндсэн хуулиар ийнхүү өөрчилсөн нь хууль зүйн шинэ, шинэ баталгааг бэхжүүлсэн явдал юм. Хөгжлийн философийг боловсруулан төрийн бодлогод хэрэгжүүлэхэд Үндсэн хуулийн хэрэглээ нэн чухал юм. Үндсэн хуулийн хэрэглээ нь Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хэрэгжүүлнэ гэсэн санаа. Үндсэн хуулиас гадуур элдэв үйлдэл, эрх зүй, ёс зүй гэж байж таарахгүй[16]. Шүүх эрх мэдлийн байгууллага нь шударга ёс, эрх зүйн үндсэн дээр гүйцэтгэх болон хууль тогтоох байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг засаг төрийн дур зоргын ажиллагаа, “хуульд дуулгаваргүй этгээд”-ийн халдлагаас хамгаалах гэхчлэн иргэний нийгэмдээ хүчин зүтгэх жам ёсны үүрэгтэй[17]. Шүүх эрх мэдлийн тухай асуудлыг Үндсэн хуулийн “Төрийн байгуулал” гэсэн Гуравдугаар бүлгийн дөрөв дэх зүйлд заасан нь шүүхийн нийгмийн үүрэг, тогтолцоо, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдал, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд баримтлах бусад үндсэн зарчим, тэдгээрийг хангах баталгаа буюу механизмын үндсүүдийг ардчилал, иргэний нийгэм, хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх эрх зүйт төрийн мөн чанарт нийцүүлэхэд уг үзэл баримтлал чиглэгдсэн гэж болно[18].

Ардчилсан нийгмийн нэг гол шинж бол бие даасан шүүх эрх мэдэл төлөвшсөн байх явдал юм. Ардчилсан тогтолцоотой ихэнх улсад шүүх эрх мэдлийг төрийн харилцан тэнцэл, хяналт бүхий бүтцийн нэг гэж үзэж Үндсэн хуулиар бататган бэхжүүлж, шүүн таслах үйл ажиллагааг зөвхөн төрийн шүүхийн байгууллага хэрэгжүүлж байна. Бие даасан шүүх эрх мэдэл төлөвшинө гэдэг нь шүүх бие даасан байж, зөвхөн хуульд захирагдах зарчим хэрэгжиж байна гэсэн үг. Шүүх эрх мэдлийн хараат бус, биеэ даасан байдал нь шүүхийн байгууллагын тогтолцоо, юуны өмнө түүний бүрэлдэхүүн болох шүүгчийн хараат бус байдал, бүтцийн нэгж болох шүүхийн бие даасан байдал болон үйл ажиллагааны үндсэн зарчим, тэдгээрийг хангах баталгаагаар тодорхойлогдоно[19]. Шүүх эрх мэдэл нь (Энэхүү өгүүлэлд Үндсэн хуулийн шүүх эрх мэдлийн талаар авч үзээгүй бөгөөд энэ талаар дараа тусгайлан өгүүлэх болно.) хүний эрх, эрх чөлөөг хамгаалдаг тул онцгой байр суурьтай. Мөн захиргааны эрх зүйн салбарт хамаарах ба эрх зүйт төрийн онцгой, өвөрмөц үүрэг гүйцэтгэдэг. Шүүх эрх мэдлийн нээлттэй, ил тод байдлыг харгалзан авч үзвэл түүний чиг үүрэг нь захирах ба албаны хариуцлага ногдуулах байгууллагын босоо

[16] Даш-Ёндон, Б. (2012). Монголын хөгжлийн философи. асуудал, аргачлал, ашиг тус. Уб., 145-146 дахь тал.
[17] Чимид, Б. (2017). Үндсэн хуулийн үзэл баримтлал. Уб., 102 дахь тал.
[18] Чимид, Б. (2017). Үндсэн хуулийн үзэл баримтлал. Уб., 256 дахь тал.
[19] Мөн тэнд. 258 дахь тал.

тогтолцоо бүхий гүйцэтгэх эрх мэдлийн хаалттай байдлаас эрс ялгаатай юм[20]. Засгийн үндсэн гурван салааны нэг болох “шүүх эрх мэдэл” гэсэн цогц ойлголтод шүүхийн байгууллагын тогтолцоо, зохион байгуулалтын үндэс, бүрэн эрх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх зарчим, боломж, шүүгчийн эрх зүйн байдал багтдаг[21]. Шүүхийн эрх зүй нь дээрх тодорхойлолт зохицуулж буй харилцааны хүрээнд бие даасан бүтэцтэй болохыг илэрхийлж байна.

Хоёр. НҮБ-ын 1985 оны 40/32, 40/46 дугаар тогтоолоор батлагдсан “Шүүхийн байгууллагын хараат бус байдлын үндсэн зарчим”-ын 1 дүгээр зүйлд Шүүхийн байгууллагын хараат бус байдлыг төр баталгаажуулж, өөрийн орны Үндсэн хууль, бусад хуулиар бататган тунхаглана[22] гэж заасанчлан Монгол Улс Үндсэн хуульдаа дээрх зарчмыг бэхжүүлсэн. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын тодорхойлолтыг гаргахдаа "Хүний эрхийн түгээмэл тунхаг", "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт"-д зааснаар шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал нь:

1. Эрх мэдэл бүхий байх (Тунхагийн 8 дугаар зүйл, Пактын 14 дүгээр зүйл);
2. Бусдын тэгш эрхийг хангах (Тунхагийн 10 дугаар зүйл, Пактын 14 дүгээр зүйл);
3. Бусдын нөлөөнд автахгүй байх (Тунхагийн 10 дугаар зүйл, Пактын 14 дүгээр зүйл);
4. Хуульд захирагдах (Тунхагийн 10 дугаар зүйл);
5. Шударга ёсны бүх шаардлагыг хангах (Тунхагийн 10 дугаар, Пактын 14 дүгээр зүйл);
6. Ил тод байх (Тунхаг, Пактад заасан хязгаарлалтыг харгалзан үзэх шаардлагыг тавьдаг болох нь тодорхой юм. Тунхагийн 10 дугаар зүйл) гэсэн шинжээр тодорхойлогдоно.

Шүүгч хараат бус байх нь түүний онцгой эрх бол шүүгч зөвхөн хуульд захирагдах нь түүний онцгой үүрэг[23] мөн.

Хүний эрхийн түгээмэл тунхагийнн 8 дугаар зүйлд “Үндсэн хууль, бусад хуулиар олгосон эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй”; мөн 10 дугаар зүйлд “... тэгш эрхийн үндсэн дээр, ил тод байдлаар, шударга ёсны бүх шаардлагын дагуу бусдын нөлөөнд автагдаагүй, гагцхүү хуульд

[20] Закомлистов, А.Ф. (2002). Судебная этика. Москва., С. 43
[21] Жанцан, С. (2003). Монгол Улсын шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын тогтолцоо. Уб., 8 дахь тал.
[22] НҮБ (1996). Хүний эрх. Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх. Уб.,179-184 дэх тал.
[23] Хууль зүйн үндэсний төв (2005). Захиргааны хэрэг маргаан хянан шийдвэрлэх зарчим. Цуврал 4. Уб.,15 дахь тал.

захирагдах, шүүхээр шийдвэрлүүлэх эрхтэй[24]" гэж хүний эрхийн баталгааг хангах олон улсын эрх зүйн суурь хэм хэмжээг бэхжүүлсэн нь шүүх бие даасан байдлаар ажиллах, шүүгч хараат бусаар хэрэг, маргаан хянан шийдвэрлэх, гагцхүү хуульд захирагдах харилцан хамаарал бүхий зарчим нь шүүх эрх мэдлийн хамгийн гол шинжийг илэрхийлсэн байна.

Нийгэм эдийн засаг хөгжихийн хэрээр эрх зүй тасралтгүй хөгжиж шинэ төрлийн эрх зүйн харилцааг зохицуулах хэрэгцээ шаардлага бий болж байна. Шүүгч зөвхөн хуульд захирагдах гэдэг нь Үндсэн хууль, түүнд нийцсэн, албан ёсоор нийтэлсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээг эрх зүйн онолын мэдлэг, соёл, ухамсрынхаа үндсэн дээр зөв тайлбарлаж хэрэглэнэ гэсэн үг[25] юм.

Шүүх, шүүгчийн ажил, албан тушаал, шүүхэд хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа буюу шүүн таслах ажиллагаа нь ямар нэг байдлаар улс төр, эдийн засгийн эрх мэдэл бүхий хүмүүсийн хүсэл зоригоос үл хамаарах нь хараат бус, бие даасан байдлын үндсэн шинж юм[26]. Шүүгчийн хараат бус байх зарчмыг олон улсын эрх зүйн баримт бичигт хэрхэн тусгасан талаар судлан үзвэл: НҮБ-аас (1985) баталсан "Шүүхийн байгууллагын хараат бус байдлын үндсэн зарчим"-ын Албаны нөхцөл ба бүрэн эрхийн хугацаа гэсэн 11 дүгээр зүйлд "Шүүгчдийн бүрэн эрхийн хугацаа, тэдний хараат бус байдал, аюулгүй байдал, зохих урамшуулал ажиллах нөхцөл, тэтгэвэр болон тэтгэвэрт гарах нас нь зохих ёсоор хуулиар баталгаажсан байна[27]";

НҮБ-аас (1998) баталсан "Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм"-ийн 40 дүгээр зүйлд "Шүүгчдийн хараат бус байдал"-ын тухайд: 1) Шүүгчид чиг үүргээ гүйцэтгэхдээ хараат бус байна; 2) Шүүгчид өөрсдийн шүүгчийн чиг үүргээ гүйцэтгэхэд саад учруулах буюу тэдгээрийн хараат бус байдалд эргэлзээ төрүүлж болох ямар ч үйл ажиллагаанд оролцохгүй. 3) Шүүгчид мэргэжлийн шинжтэй өөр ямар ч ажил, албан тушаал эрхлэх ёсгүй хэмээн заасан байна.

Үндсэн хуулийн болон олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн дээрх зарчмыг шүүхийн тухай материаллаг болон процессын бүхий л хуульд бэхжүүлжээ. *Тухайлбал*, хараат бус байх гэдэг нь зөвхөн хуульд захирагдах зарчим дээр үндэслэсэн байдаг. Шүүгчид зөвхөн хуульд захирагдсанаараа хараат бус байдаг. Шүүгчид ямар нэгэн тодорхой зорилт, зөвлөмж, санал бодол дээр бус, харин бичигдсэн болон бичигдээгүй эрх зүйн хэм хэмжээний нэгтгэл болсон "хууль" дээр үндэслэн

[24] Хүний эрх. (Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл). НҮБ. Уб., 1993. 3-4 дэх тал.
[25] Чимид, Б. (2008). Үндсэн хуулийн мэдлэг. Уб., 310 дахь тал.
[26] Алтансүх, Ж. (2016). Шүүх эрх мэдлийн хараат бус байдал. Хууль дээдлэх ёс. Уб., №1(56). 72 дахь тал
[27] НҮБ (1996). Хүний эрх: Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх. Уб., 179-184 дэх тал.

өөрсдийн шийдвэрээ гаргах ёстой. Шийдвэр гаргах ганц хэмжүүр нь гагцхүү хууль юм. Үүнийг баталгаажуулах, мөн шүүгчийн шийдвэрт нөлөөлж болохуйц хүчин зүйлд автагдахгүй байх явдалд шүүгчийн хараат бус байдлын утга учир, зорилго оршино[28]. Шүүгч хэрэг маргаан хянан шийдвэрлэхдээ хуульд захирагдаагүй бол *нэгдүгээрт,* хэргийг буруу шийдвэрлэнэ, *хоёрдугаарт,* мэргэжлийн алдаа гаргана, *гуравдугаарт,* ёс зүйн зөрчилд орно[29]. Иймд шүүгчийн хараат бус байдал нь гагцхүү хуульд захирагдах зарчимд тулгуурладаг.

Шүүгчийн хараат бус байх хүрээ нь: *нэгдүгээрт*, албан тушаал, ёс суртахуун, эд хөрөнгийн гэх мэтээр бусдын нөлөөнд үл автагдах; *хоёрдугаарт*, гагцхүү хуульд хатуу захирагдах; *гуравдугаарт*, бие дааж хуульд нийцсэн шийдвэр гаргах эрх мэдлийн нийлбэр юм[30]. Иймхүү хүрээг тодорхойлох нь шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдаж, хуулиа дээдлэх, эрх зүйн өндөр соёлтой, төвийг сахих, ухаалаг байх, бие хүнийг хүндэтгэж хүнлэг энэрэнгүй байх зэрэг зан чанарыг өөртөө бүрдүүлсэн байхыг шаардана.

Шүүгч хуулийг тайлбарлан хэрэглэснээрээ тухайн тохиолдол бүрд шударга ёсыг тогтоодог[31]. Шүүгч тодорхой хэрэг, маргааныг шийдвэрлэхдээ нотлох баримтыг хууль, эрх зүйн ухамсрыг удирдлага болгон өөрийн дотоод итгэлээр үнэлж байх хуулийн заалт нь шүүгч хэнээс ч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах зарчмын үндсэн агуулга болно. Энэ нь шүүгч нэн тэргүүн өөрийн мэдлэг, мэргэжлийн ур чадвар, шударга байдлаараа шүүгчийн хараат бус байдлыг өөрөө хангах ёстой[32]. Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлд заасан шаардлага хангасан хуульчийг шүүгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах үйл ажиллагааны дагуу томилогдсон шүүгч нь хараат бус байдлын хязгаараа өөрөө тодорхойлсон байх учиртайг илэрхийлжээ.

Шүүгчийн хараат бус байдал нь шүүгчийнхээ хараат бусаар ажиллах бүх талын нөхцөлийг бүрдүүлэн өгч байгаа төрийн үйл ажиллагаа ба жинхэнэ хараат бус ажиллаж чадаж байгаа шүүгчийн өөрийнх нь үйл ажиллагааны цогц нийлбэр[33] гэж үзэж буй нь шүүгчийн албан тушаал

[28] Карл Аугуст Беттерманн. (2000) Шүүгчийн хараат бус байдлын утга агуулга ба хязгаар. Ханнс-Зейделийн сан. Төр эрх зүйн хуудас. Эргэцүүлэл. №8.121 дэх тал.
[29] Нийслэлийн шүүх (2004). Шүүгчийн гарын авлага. Уб., 311 дэх тал.
[30] Жанцан, С. (2003). Монгол Улсын шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын тогтолцоо. Уб., 3 дахь тал.
[31] Каупманн, А. (2013). Толеранцын зарчим. Эрх зүйн онол: үзэл бодол, асуудал. Уб., №2(24). 38 дахь тал.
[32] Ганбаатар, Г. (2009). Шүүгчийн хараат бус байдал ба шүүгчийн ёс зүй. Монголын төр, эрх зүй. Уб., №1(57). 41 дэх тал.
[33] Ганбат, Ч. (2000). Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдал. Ханнс-Зейделийн сан. Төр эрх зүйн хуудас. Эргэцүүлэл. №8.120 дахь тал.

эрхэлж буй мэргэшсэн хуульчийн үйл ажиллагаа шударга ёсны илэрхийлэл байх учиртайг тодорхойлж байгаа юм.

Шүүгчийн хараат бус байдал нь нэг талаас гаргасан шийдвэрээсээ хамааралгүй, хараат бус байх явдал юм. Шүүгч нь заримдаа өөрөө өөрөөсөө хараат бус байх өндөр төвшинд хүрэх ёстой[34]. Ийнхүү шүүгч нэг бүр үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллах зарчмыг тодорхойлсон нь шүүгчийн дотоод итгэл үнэмшилтэй салшгүй холбогдож болохыг илэрхийлжээ.

Шүүгчийн хараат бус байдлыг хангахад шүүгчийн албаны ((Institutional independence) - хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдэл, бусад эх сурвалжаас хамааралгүйгээр ажиллах баталгааны нийлбэр цогц)[35] болон хувийн ((Individual independence) - ажил мэргэжилдээ өөрийгөө бэлтгэсэн хувийн чанарын нийлбэр цогц)[36] хараат бус байдлыг хангах, бэхжүүлэх шаардлагатай[37] гэдгийг тусгажээ. Мөн зарим судлаачид шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг де факто (шүүгч өөрийн итгэл үнэмшилдээ тулгуурлан шийдвэр гаргах, шүүхийн шийдвэр төрийн эрх бүхий бусад институцийн тусламжтайгаар зайлшгүй хэрэгждэг байх) болон де юре (шүүгчийг гадаад болон дотоод орчны зүй бус нөлөөллөөс тусгаарлахад чиглэсэн албан ёсны зохицуулалт) төвшнийх хэмээн ангилж[38] үзсэн байдаг. Шүүгч нь өөрийн итгэл үнэмшилтэй байх тухай тодорхойлсон нь хэрэг маргаан шийдвэрлэх үйл ажиллагаанд голлох эрх зүйн үр дагаврыг үүсгэдэг төдийгүй, хуульд захирагдсанаар эрхийн хамгаалалт нь баталгааждаг талаарх ойлголтыг бэхжүүлсэн нь шүүх байгууллагад ажиллаж буй шүүгчийн албан тушаалд томилогдон ажиллаж буй этгээдийн ажил үүргийн хамрах хүрээг тодорхойлсон нь шүүхийн эрх зүйн судлах зүйлийн нэгэн онцлог шинжтэйг илэрхийлж байна.

Гурав. Монгол Улсад шүүх анх байгуулагдсанаар шүүхийн захиргаа ажиллаж эхэлсэн бөгөөд Үндсэн (1992) хуулийн дагуу ШЕЗ нэртэй бие даасан байгууллага байгуулагдсан үед хамааруулж дараахь үе шатны талаар өгүүлж байгаа болно.

ШЕЗ-ийн түүхийг хөгжлийн дөрвөн үе шатанд хуваан үзэж болох юм.

---

[34] Эва Лентовска. (2014). Сайн шүүгчийн баримталбал зохих 10 зарчим. Шүүх эрх мэдэл. Уб., №1. 89 дэх тал.

[35] Монгол улсад шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь (Бодлогын тойм судалгаа). 2010. Уб., Нээлттэй нийгэм форум. 43 дахь тал.

[36] Мөн тэнд. 43 дахь тал.

[37] Human rights in the administration of justice. “A Manual on Human Rights for Judges, Prosecutors and Lawyers” . Professional training series No.9, P.120

[38] Шүүгчийн хараат бус байдлын баталгаа, хэрэгжилт. Бодлогын судалгааны тайлан. 2015. Уб., Нээлттэй нийгэм форум. 8 дахь тал.

1. 1992-1998 оны хооронд байгууллагын суурийг тавьсан үе-ШЕЗ үйл ажиллагаагаа эхлүүлж, дотоод дүрэм, журмаа боловсруулсан, санхүү, хүний нөөцийн хэлтсүүд бүрдэж, хөгжлийн эхэн үеийнхээ зорилтыг хэрэгжүүлсэн. Шүүхийн тухай (1993) хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт "ШЕЗ-ийн даргыг гишүүдийн дундаас, гишүүдийн олонхийн саналаар, 3 жилийн хугацаатай сонгохоор" заасан байна. ШЕЗ-ийн дарга нь Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч (1993-1996) байж, ШЕЗ-ийн ажлын албаны чиг үүргийг дээд шүүхийн тамгын газар гүйцэтгэж байсан бол Шүүхийн тухай хуульд 1996 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар орсон өөрчлөлтөөр Зөвлөлийн даргыг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хавсран гүйцэтгэхээр болж, ажлын албыг Хууль зүйн яамны шүүхийн зохион байгуулалтын удирдах газар эрхлэн гүйцэтгэх болжээ. Энэ өөрчлөлтийг хийх болсон үндэслэлийг Засгийн газарт төсөв хэлэлцэх явцад ШЕЗ илүү хүчтэй байр суурьтай байх явдал гэж тайлбарласан байдаг.

2. 1999-2012 он хүртэл үргэлжилсэн шүүхийн шинэчлэлийг тус улсын эрх зүйн шинэтгэлийн бие даасан бүрэлдэхүүн хэсэг болгон гүнзгийрүүлэх зорилгоор ажилласан үе буюу шүүгчийн сахилгыг сайжруулах механизмыг идэвхтэй ажиллуулсан цаг үе гэж үзэж болно.

3. 2012-2021 оноос эхлэн шүүх хараат бус, шударга байх зарчим амжилттай хэрэгжсэн шинэ үе[39]-Ерөнхийлөгчийн санаачилгаар боловсруулсан шүүхийн хараат бус байдал, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн шинэчлэлийн багц хууль (Шүүхийн тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн захиргааны тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай)-ийг УИХ 2012 оны I, II улиралд баталжээ. Шүүхийн тухай хуульд (1993) "Шүүхийн захиргаа" гэсэн тусдаа бүлэг баталсан хэдий ч хууль үйлчилсэн богино хугацаанд олон тооны нэмэлт, өөрчлөлт оруулж байсан нь голчлон шүүхийн захиргааны бүтэц, зохион байгуулалттай холбоотой байжээ. *Тухайлбал,* Шүүхийн захиргааны асуудлыг Шүүхийн тухай хуулиар (2002) үргэлжлүүлэн зохицуулж, харин Шүүхийн захиргааны тухай шинэ хууль батлагдсанаар ШЕЗ болон шүүхийн захиргааны бусад асуудлыг уг хуулиар зохицуулах болсон. Үүнтэй зэрэгцэн Олон улсын шүүгчдийн холбооны 2013 оны Ялтад болсон хурлын үеэр баталсан "Шүүхийн зөвлөлийн эрх хэмжээний тухай" тогтоолд: 1) Зөвлөл нь шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүхийн тогтолцоог үр нөлөөтэй ажиллуулахад чухал үүрэгтэй; 2) Шүүх болон төрийн бусад эрх мэдлийн хооронд зааглагчийн үүрэг гүйцэтгэдэг; 3) Шүүгч болон шүүхийг гадны болон

[39] Монгол Улсад Ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг (дүн шинжилгээ). Уб., 2015. 81-82 дахь тал.

дотоодын зүй бус нөлөөллөөс хамгаалах, зөвлөл өөрөө ямар нэгэн байдлаар шүүхэд нөлөөлөх, дарамт учруулах хэрэгсэл болох ёсгүй; 4) Зөвлөл нь бүх талаар улс төрөөс ангид байх, шүүгчид нэр дэвшигчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зэрэг зөвлөлийн бие даасан байдал, үйл ажиллагааных нь үр нөлөөтэй шинжийг баталгаажуулсан зарчмыг хүндэтгэхийг тэмдэглэсэн байна.

4. 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан, Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан, мөн зүйлийн 6 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн суурь зохицуулалттай холбогдуулан УИХ-ын 2020 оны 2 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-т заасны дагуу 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга (2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхлэх)-ын баталсан нь шүүхийн эрх зүйг төгөлдөршүүлэхэд нөлөөлөх олон сорилтыг даван туулах эхлэл болж байна.

Дөрөв. Шүүгчийн ёс зүйг хэрэгжүүлэх механизм буюу шүүгчийн ёс зүйн хяналтын албан ёсны хуулийн дагуу байгуулагддаг институт бол Шүүхийн ёс зүйн хороо (өмнөх хуулиудад Сахилгын хороо)[40] юм. Шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн талаарх иргэдийн гомдол, мэдээллийг шүүхийн шаталсан тогтолцооны дагуу хянаж үзээд сахилгын хэрэг үүсгэсэн тухай шүүх бүрэлдэхүүн тогтоол, ерөнхий шүүгч захирамж гарган, шүүгчийн сахилгын хороонд шилжүүлснээр шүүхийн ёс зүйн хяналтад хоёр шатлалт тогтолцоо бэхэжсэн билээ. Энэхүү бүтэц тогтолцоог Шүүхийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-иар нарийвчлан зохицуулахаар болсон байна.

Академич Ж.Амарсанаа “Шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх эрх бүхий орон тооны бус байгууллага (Шүүхийн тухай (2002) хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.Шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх эрх бүхий Шүүхийн сахилгын хороо /цаашид “Сахилгын хороо” гэх/ нь улсын хэмжээнд нэг байна.) Шүүхийн дэргэд хууль зүйн өөр өөр мэргэжлийн (Шүүхийн тухай (2002)

[40] Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 6. Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно. */Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн./* Шүүхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн Арван тавдугаар бүлэг. Сахилгын хороо (95-116 дугаар зүйл), 2021 он.

хуулийн 46 дугаар зүйлийн 46.3.Сахилгын хорооны гишүүнд Улсын ерөнхий прокурор, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Удирдах зөвлөлөөс тус бүр хоёр, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчийн хуралдаанаас тав, Шүүгчдийн зөвлөл бүх шатны шүүхээс тус бүр хоёр хүний нэрийг дэвшүүлнэ.) болон хуульч бус хүмүүсээс бүрдсэн 15 гишүүнтэй Сахилгын хороо байгуулсан. Шүүх эрх мэдэл шүүгчийг самуурууллаг. Онцгой эрх мэдэл онцгой самуурууллаг. Тийм учраас ардчилсан нийгэмд шүүх эрх мэдлийг бусад эрх мэдэлтэй харилцан тэнцвэржүүлж, хянаж шалгаж чаддаг тогтолцоо байх хэрэгтэй”[41] гэжээ. Шүүхийн тухай (2002) хуулийн дагуу хийгдсэн шүүхийн шинэтгэлийн нэг том алхам нь шүүгчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг бодитой болгох, шүүгчийн сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ болох Сахилгын хорооны бүрэлдэхүүн, ажлын зохион байгуулалтыг өөрчилж чаджээ[42]. Сахилгын хороо нь орон тооны ажлын албатай байна. Сахилгын хорооны ажлын алба нь ШЕЗ-ийн ажлын албанд харьяалагдана. Шүүхийн сахилгын хорооны ажлын алба нь ирүүлсэн гомдол хүсэлтийг хүлээн авч бүртгэн Сахилгын хорооны дарга (46.7.Сахилгын хорооны даргыг хорооны гишүүдийн санал болгосноор Ерөнхийлөгч томилно.), гишүүдэд танилцуулж хуульд заасны дагуу хянан шалгах ажиллагаа явуулж, сахилгын хэргийг анхан шатны журмаар хянан тогтоол, давж заалдах гомдлоор нийт гишүүдийн хуралдаанаас магадлал гаргана. Сахилгын хорооны магадлал эцсийнх байна. Шүүхийн сахилгын хорооны ажлын албанаас нийслэл болон аймаг, орон нутгийн шүүхээс 1970-2002 оны хооронд хянан шийдвэрлэсэн 225 сахилгын хэргийг хүлээн авч, нэгдсэн бүртгэлд оруулж, эмхэлж цэгцлэн, архивт хүлээлгэж өгсөн.[43] Ийнхүү бүрдүүлсэн архивын нэгжээс үзэхэд 32 жилийн хугацаанд шийдвэрлэсэн сахилгын хэрэг цөөн байгаа мэт харагдаж байгаа ч шүүгчийн ёс зүйн дүрэм (1997)-ээс хойш шийдвэрлэсэн сахилгын хэргийн талаар үзвэл тухайн бүхэл тооноос арай өөр үзүүлэлт гарч болох юм. Учир нь шүүгчид сахилгын хэрэг үүсгэн шалгах, түдгэлзүүлэх эрх нь тухайн шүүхийн ерөнхий шүүгчид хадгалагдаж байсантай холбоотой бөгөөд энэ нь хөндлөнгийн хяналтыг тухайн ажиллагаанд шаардаж байсны илрэл юм.

Хууль зүйн доктор, проф Б.Чимид: “Төрийн мэргэшсэн алба бол “явуулын” улс төрчдийг хуулиар зэвсэглэж, хуульд захирагдаж ажилладаг

[41] Амарсанаа, Ж. (2004). Шүүгчийн ёс зүй. Хуульчийн ёс зүй гарын авлага. Уб., 25 дахь тал.
[42] Төр-Од, Л. (2012). Эрх зүйн шинэтгэл, шүүх эрх мэдэл. Шүүх эрх мэдлийн шинэтгэл. Уб., 28 дахь тал.
[43] Шүүхийн ерөнхий зөвлөл (2009). Монгол Улсын шүүх 2008 оны ажлын тайлан. Уб., 26 дахь тал.

болгох “отчийн газар” мөн[44] гэж тэмдэглэн хэлжээ. Төр нь хууль тогтоох, хууль биелүүлэх, хууль хамгаалах үндсэн чиг үүргийг[45] хэрэгжүүлдэг ард түмний төлөөллийн байгууллага бөгөөд төрийн албанд ажиллаж буй этгээдийн ёс зүйн зан үйлээр тухайн байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ дүгнэгдэж байдаг. Ёс зүй нь албан хаагчид үйл ажиллагааныхаа бүхий л хүрээнд баримтлах ёс суртахууны зарчим, эрхэмлэх зүйлс юм. Эдгээр ёс суртахууны зарчимд үнэнч шударга байх, шударга байдал, шударга ёс суртахуун, хичээл зүтгэл, итгэлцэл, хүндэтгэл, зарчимч тууштай байх гэсэн үзэл баримтлалууд багтдаг. Ёс зүйд сонирхлын зөрчил, албан тушаалаа зүй бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх явдал мөн хамаарна[46]. Ёс зүй нь хүн төрөлхтөн дэлхий ертөнцтэй туйлын зохистой нийцэн оршихуйн үндэс гэсэн ойлголтыг агуулах бөгөөд эртний Грекийн гүн ухаантан Платон, Аристотель, Эпикурын хүний үнэн чанарын талаарх эргэцүүлэлд тусгалаа олжээ. Ёс зүйн бүтээлч чанар нь хүний ахуйгаас хөндийрч дээд ба доод хэмжээ нийлж уусанаар нийгэмд бүрэлддэг[47] байна.

Орчин үед ёс зүйн үндсэн зарчим нь ёс суртахууны бүхий л шинж чанараар дэмжигдэж, Үндсэн хуулиар баталгаажиж хүн бүрд байх ёстой чанар гэдгийг хүлээн зөвшөөрөх болсон[48] байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1996 оны 51/59 дугаар тогтоолоор батлсан “Төрийн албан тушаалтны олон улсын ёс зүйн дүрэм”-ийн 2-т Төрийн албан хаагчид хуулийн болон захиргааны дүрэм, журмын хүрээнд өөрсдийн үүргээ үр дүнтэй, үр ашигтай болон зарчмын дагуу гүйцэтгэнэ. Тэд байнга өөрийн хариуцлага дор байгаа төрийн нөөцийг хамгийн үр дүнтэйгээр удирдаж байгааг хянах ёстой; 3-т Албан хаагчид үүргээ гүйцэтгэхдээ, ялангуяа олон нийттэй харилцахдаа анхааралтай, алагчлахгүй, шударга байх ба хувийн ашиг сонирхлын үүднээс хандах ёсгүй. Тэд хэзээ ч өөрсдийн боломж, эрх мэдлээ ашиглаж иргэнийг эсвэл нийгмийн аль нэг давхаргыг ялгаж үйлчлэх болон үзэл суртлын үүднээс хандаж болохгүй [49]. Мөн НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2003 оны 58/4 дугаар тогтоолоор батлсан “Авлигын эсрэг НҮБ-ын конвенц”-ийн 8 дугаар зүйлийн 8.2-т Оролцогч улс бүр төрийн чиг үүргийг зөв, эрхэм бөгөөд зохистойгоор биелүүлэх ёс зүйн дүрэм буюу жишгийг өөрийн байгууллагын болон эрх зүйн тогтолцооныхоо хүрээнд хэрэглэхийг чармайна; 8.6-д Оролцогч улс бүр энэ зүйлийн дагуу тогтоосон ёс зүйн

[44] Чимид, Б. (2014). Төрийг засах ёс. Уб., 43 дахь тал.
[45] Лүндэндорж, Н. (2008). Төрийн онол. Уб., 196-197 дахь тал.
[46] Даваадулам, Ц. (2010). Засаглалын үзэл баримтлал, нэр томьёоны тайлбар толь бичиг. Уб., 40 дэх тал.
[47] Закомлистов. А.Ф. Судебная этика. Москва., 2002. С. 113
[48] Гусейнова А.А. и Дубко. Е.Л. Этика. Москва.,1999. С. 279
[49] Ёс зүйн гарын авлага. Уб., 2006. 25-27 дахь тал.

дүрэм буюу жишгийг зөрчсөн төрийн албан тушаалтанд сахилгын буюу бусад арга хэмжээг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авах асуудлыг авч үзнэ[50] гэж тусгажээ.

Иргэний ёс зүй бүх хүнд, албан хаагчийн ёс зүй тухайн албан тушаалтанд хамаатай байдаг бол хуульчийн ёс зүй зөвхөн хуульч хүнд л хамаарна. Түүнчлэн ёс зүйн нийтлэг шаардлагаас ангид хуульчийн ёс зүй гэж байх учиргүй.

Шүүгчийн ёс зүй гэдэг нь шүүгчийн мэргэжлийн онцлогоор нь нөхцөлдсөн ёс суртахууны хэм хэмжээ, зарчим ба бие авч явах байдлыг илэрхийлж байна. Шүүгчийн ёс суртахуун гэвэл ёс суртахууны зарчим, хэм хэмжээг ухамсарлах үйлдэл, үнэлэмж юм[51]. Шүүх эрх мэдлийн байгууллагуудын гол өндөрлөг нь болдгийн адил шүүх хуралдааны гол төв нь шүүгч байдаг. Шүүгчид өргөн эрх мэдэл олгогдож, шүүх хуралдааныг зөв чиглэл рүү удирдаж, хуралдааны танхимын уур амьсгалын үнэнийг олж тогтоох, гэм бурууг нотлох, эрх зүйн хүчинд итгүүлэн, үнэмшүүлэх өндөр ур чадварыг түүнээс шаарддаг. Шүүх хуралдаанд оролцогчид үг хэлэх, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж олгох, ямар нэг ялгаваргүйгээр адил тэгш хандах, эрхийг нь хуулийн хүрээнд эдлүүлэхийг анхаарах ёстой. Шүүх хуралдаанд оролцогчдын аль нэг талын байр суурийг үндэслэлгүйгээр илэрхий баримтлах, аль нэг талыг зориуд буруутгахыг оролдох зэргээр нэг тийш хэлбийх, өөртөө ашигтай талыг бодох зэрэг өрөөсгөл хандахаас зайлсхийх нь зүйтэй. Хэргийг саланги тусад нь бус, бүхэлд нь авч үзэж, цогц байдлаар дүгнэх, үнэн мөнөөр, бодит байдлаар харуулахыг чухалчлах нь шүүгчийн баримтлах гол чиг шугам байх ёстой[52].

Шүүгчийн ёс зүйн үнэт зүйлс нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх үндэс болсон хараат бус, хөндлөнгийн байх, шударга байж алагчлалгүй хандах зарчмаас бүрдэж байдаг. Шүүгч ёс зүйн хэм хэмжээгээ сайн сахиж, мөрдөж чадваас иргэдийн эрхээ шүүхээр хамгаалуулах сэдлийг өдөөж, шүүхэд итгэх итгэлийг сэргээж, үүгээрээ дамжуулан хууль дээдлэх үзэл санааг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулдаг. Шүүгч шударга байх тухай үзэл санаа нь хамгийн эртний хууль, ном зохиолд таарах ч, шүүгчийн ёс зүйг хүний эрх, эрх зүйт ёсны үзэл баримтлалаас авч үзэх хандлага нь орчин үеийн эрх зүйн түүхтэй холбогддог. Ялангуяа дэлхийн II дайны дараа шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлыг хангах нь хүний эрхийг хамгаалах чухал хөшүүрэг гэдгийг хүн төрөлхтөн хүлээн зөвшөөрч, олон улсын эрх зүйн төвшинд чухалчлан авч үзэх болжээ.

[50] Ёс зүйн гарын авлага. Уб., 2006. 27-28 дахь тал.
[51] Золзаяа, М., Сайнзаяа, М. (2008). Шүүгчийн ёс зүйн зөрчил, сахилгын шийтгэлийн тухайд. Философи эрхийн судлал. XXIII боть. Уб., 219 дэх тал.
[52] Сэнгэдорж, Т. (2003). Хуульч мэргэжил. Уб., 112 дахь тал.

Үүний тод илрэл нь НҮБ-ын ерөнхий Ассамблейн 1946 оны 217 /A/III тогтоолоор батлсан. Хүний эрхийн түгээмэл тунхагийн 8 дугаар зүйлд "Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй", 10 дугаар зүйлд "Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй шударгаар шүүлгэх эрхтэй" хэмээн хараат бус хөндлөнгийн шударга шүүхээр шүүлгэх хүний эрхийг тунхагласан нь орчин үеийн шүүгчийн ёс зүйн хэм хэмжээний үндэс болжээ. Мөн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 2200А (XXI) тоот тогтоолоор "Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт"-ыг баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд энэхүү пактын 14 дүгээр зүйлд "Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. Хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий хараат бус, тал үл харах шүүхээр нээлттэй шударгаар шүүлгэх эрхтэй" хэмээн шударга хараат бус хөндлөнгийн шүүхийн үзэл баримтлалыг олон улсын эрх зүйн дагаж мөрдөх хэм хэмжээ болгон баталгаажуулснаар нь бие даасан тогтолцоог бэхжүүлж байна.

Тав. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1-т "Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ. 2-т Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна; Тавин гуравдугаар зүйлийн 1-т Шүүн таслах ажиллагааг монгол хэлээр явуулна". гэж хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны суурь зарчмыг бэхжүүлсэн. Шүүх гэж Монгол Улсын Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуульд заасны дагуу байгуулагдан хэрэг[53], маргааныг[54] хянан шийдвэрлэж, заавал биелүүлэх шийдвэр гаргадаг шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг ойлгоно. Шүүх эрх мэдлийн оролцооны онцлог ялгаа нь өөрсдийн гүйцэтгэж байгаа үүргийн онцлогоос хамаардаг хэдий ч шүүн таслах ажиллагааны гол зорилгод нэгтгэгддэг тул зорилго, чиглэл нэг юм.[55] ОХУ-ын эрдэмтэн Тихомирова Л.В. болон Тихомиров М.Ю. нарын хамтран бүтээсэн "Юридическая энциклопедия" номонд "Шүүх гэдэг нь иргэний, эрүүгийн, захиргааны зөрчлийн тухай хэрэг, экологийн маргаан болон бусад төрлийн хэргийг процессын хуульд заасан

[53] *Хэрэг* гэж хууль зөрчсөн гэмт явдал. Баярсайхан, Б. нар (2011). Монгол хэлний тайлбар толь. Уб., 1620 дахь тал.
[54] *Маргаан* гэж санал зөрөлдөн тэмцэх асуудлыг эцэслэн дуусгах. Баярсайхан, Б. нар (2011). Монгол хэлний тайлбар толь. Уб., 687 дахь тал.
[55] Амарсайхан, Ц. (2003). Монгол Улсын Шүүх эрх мэдлийн тогтолцоо ба Шүүхийн эрх зүйн үзэл баримтлалын зарим асуудал. Хууль дээдлэх ёс. №3. Уб.

журам ёсоор шүүн таслах ажиллагааг явуулах замаар шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төрийн байгууллагыг хэлнэ”[56] гэж тодорхойлжээ. Энэ утгаар дэлхийн аль ч улсын шүүх байгууллага нь нийгэм, эдийн засгийн хувьсал өөрчлөлтийг тодорхой үе шаттайгаар даван туулж ирсэн байна. Манай улсын хувьд 1926 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр БНМАУ-ын Засгийн газрын гишүүдийн 15 дугаар хурал, Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн 21 дүгээр хурлаар “Аливаа шүүн таслах газруудыг байгуулах тухай дүрэм”-ийг баталснаар Шүүх явдлын яамны чиг үүргээс шүүн таслах чиг үүргийг зааглаасан эл өдрийг шүүх байгуулагдсан өдөр хэмээн эх сурвалжид тэмдэглэжээ. Энэхүү БНМАУ-ын аливаа шүүх таслах газруудыг байгуулах тухай дүрэм (1926)-ийн Нэгдүгээр зүйлийн 3-т “Дээд шүүх таслах газрын хэргийг ерөнхий ба цэргийн хэмээх хоёр анги гишүүд шийтгэнэ. Тайлбарлах нь: Дээр дурдсан аливаа шүүх таслах газруудын албан хаагчдын орон тоог Шүүх явдлын яамнаас хянан тогтоож, Засгийн газраар батлуулна.” гэж заасан нь шүүн таслах ажиллагаа, шүүхийн байгууллагын бүтэц, орон тоо, төсөв, дэд бүтцийг зааглах оролдлого бүхий эрх зүйн баримт бичиг болсон. Шүүх эрх мэдлийн процесс гэдэг нь “хууль хэрэглээний процессийн нэг онцгой төрөл бөгөөд шүүхийн болон шүүх эрх мэдлийн бусад байгууллагаас аливаа хэрэг маргааныг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа мөн”[57] гэж тодорхойлжээ. Монгол Улсын хувьд Шүүх нь Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай (1997) хуульд “Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг бүх талаас нь бүрэн гүйцэд, бодитой хянан үзэж, магадлан шийдвэрлэж Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгааг хангах”, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай (2002) хуульд “иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн иргэний эрх зүйн маргааныг шүүх иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах”, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай (2016) хуульд “хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах”, Арбитрын тухай (2017) хуульд “эрх зүйн маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх ажиллагаатай холбоотой харилцааг олон улсын стандартад нийцүүлэн зохицуулах”, Зөрчил шалган шийдвэрлэх тухай (2017) хуульд “зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, зөрчлийг шалгах, зөрчил үйлдсэн

[56] Процессын эрх зүй: онол, туршлага. (2014). Уб., 21 дэх тал.
[57] Мөн тэнд.

хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, энэхүү ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах", Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай (2017) хуульд "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх" гэсэн зорилтын хүрээнд хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг эрхэлж байна. Эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, журмыг шүүгчийн ёс зүйн болон хуулийн өмнө хүлээх хариуцлага, шүүн таслах ажиллагаанд мэтгэлцэх зарчмыг бүх шатанд жигд баримтлах, энэ ажиллагааны явцад хүний эрхийг дээдлэн хангах, аливаа чирэгдэл, хүнд суртлыг арилгах, шударга ёсыг чанд сахих зарчмыг удирдлага болгох нь хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны гол онцлог юм. Түүнчлэн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд арбитр, зуучлагч, хөндлөнгийн шүүхийн оролцоог дээшлүүлэн эрх зүйн орчин бүрдүүлснээр оролцогч талууд өөрийн эрх ашгаа хамгаалах асуудлыг өргөжүүлж өгдөг. Эдгээр процессын эрх зүйн харилцаа нь шүүхийн эрх зүйг бие даасан салбар эрх зүйн хувьд хөгжихөд зохицуулж буй нийгмийн харилцаанаас үл хамааран шүүн таслах ажиллагааны үндсэн зорилгыг хангадгаараа онцлог юм.

Дүгнэлт

Шүүхийн эрх зүй нь хууль зүйн шинжлэх ухаанд бие даасан салбар эрх зүйн хувьд хөгжиж, төлөвших үйл явцыг идэвхжүүлэхэд хууль зүйн салбарт ойрын ирээдүйд ажиллах хүний нөөцийн мэдлэг, чадвар, хандлагад нөлөөлөл үзүүлэх боломжтой юм. Шүүхийн багц хуулийн батлагдахаас өмнө манай улсын эрх зүйн хөтөлбөрийн сургалт эрхэлж буй их, дээд сургуульд "Үндсэн хуулийн эрх зүй, Хууль хамгаалах байгууллагын тогтолцоо" гэх хичээлийн хүрээнд шүүх эрх мэдлийн байгууллагын талаарх ойлголтыг тодорхой сэдвийн хүрээнд зааж байсан бол Шүүхийн багц хууль батлагдсанаар энэ чиглэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй зарим их, дээд сургууль "Шүүх эрх мэдэл" гэх хичээлийг сонгон судлах хичээл болгон хичээлийн хөтөлбөрийг нь боловсруулан батлуулж, сургалт явуулж ирсэн билээ. Энэхүү туршлага нь Шүүхийн эрх зүй бие даасан салбар эрх зүйн хувьд заавал судлах нийтийн эрх зүйн нэг салбар байх хэрэгцээ шаардлага буйг илтгэн дараахь агуулгаар сургалтын хөтөлбөр, гарын авлага, хэрэглэгдэхүүн боловсруулан судлах нь зүйтэй гэсэн дүгнэлт хийж байна.

Нэг. Шүүх эрх зүйн ойлголт

1.1. Шүүхийн эрх зүй бие даасан салбар эрх зүй болох нь

1.2. Шүүхийн эрх зүйн судлах зүйл, онцлог
1.3. Шүүхийн эрх зүйн судлах арга
1.4. Шүүхийн эрх зүйн эх сурвалж
Хоёр. Шүүхийн эрх зүйн хэм хэмжээ, зарчим
2.1. Шүүхийн эрх зүйн хэм хэмжээ
2.2. Шүүхийн эрх зүйн зарчим
Гурав. Шүүх эрх мэдлийн үндэслэл
3.1. Шүүх эрх мэдлийн талаарх Үндсэн хуулийн үзэл баримтлал
3.2. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн хяналт тэнцэл, харилцан хамаарал
3.3. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогчид
3.4. Үндсэн хуулийн шүүх эрх мэдэл
Дөрөв. Шүүхийн үндсэн тогтолцоо, шатлал
4.1. Шүүхийн тогтолцоо
4.1.1. Сум буюу сум дундын, дүүргийн шүүх
4.1.2. Аймаг, нийслэлийн шүүх
4.1.3. Улсын дээд шүүх
4.1.4. Тойргийн шүүх
4.1.5. Дагнасан шүүх (Захиргааны хэргийн шүүх)
4.2. Шүүхийн шатлал
4.2.1. Анхан шатны шүүх
4.2.2. Давж заалдах шатны шүүх
4.2.3. Хяналтын шатны шүүх
4.2.4. Хуулийн албан ёсны тайлбар
Тав. Шүүхийн захиргаа
5.1. Шүүхийн ерөнхий зөвлөл, түүний чиг үүрэг
5.2. Шүүхийн тамгын газар
5.3. Шүүхийн мэргэжлийн хороо
5.4. Шүүхийн сургалт, судалгаа
Зургаа. Шүүгчийг шилж олох үйл ажиллагаа
6.1. Шүүгчийг сонгон шалгаруулах
6.2. Шүүгчид нэр дэвшүүлэх
6.3. Шүүгчийн албан тушаалд томилох
6.4. Шүүгчийг сэлгэн ажиллуулах
Долоо. Шүүхийн сахилгын хороо
7.1. Шүүхийн сахилгын хорооны чиг үүрэг
7.2. Шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх
7.3. Шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах
7.4. Шүүгчийг огцруулах
Найм. Шүүхийн ёс зүй
8.1. Ёс зүйн тухай ойлголт шинж

8.2. Шүүгчийн ёс зүй

8.3. Шүүхийн захиргааны ажилтны ёс зүй

Ес. Шүүхийн эрх зүй ба процессын эрх зүй

9.1. Үндсэн хуулийн процессын эрх зүй

9.2. Захиргааны процессын эрх зүй

9.3. Иргэний процессын эрх зүй

9.4. Эрүүгийн процессын эрх зүй

9.5. Арбитрын процессын эрх зүй

Дээрх агуулга нь шүүхийн эрх зүй өөрийн зохицуулах зүйл, бие даасан тогтолцоо, бүтэц, өөрийн судлах арга, эх сурвалж, тусгай зарчим бүхий салбар болохыг тодорхойлж байна.

МОДЕЛИ УГОЛОВНО-ПРОЦЕССУАЛЬНОЙ МЕДИАЦИИ: ТЕОРЕТИЧЕСКИЙ АСПЕКТ

MODELS OF CRIMINAL PROCEDURAL MEDIATION: THEORETICAL ASPECT

Градский Владимир Евгеньевич,
преподаватель кафедры гражданско-правовых дисциплинФедерального государственного казенного образовательного учреждения высшего образования «Уральский юридический институт Министерства внутренних дел Российской Федерации» (ФГКОУ ВО УрЮИ МВД России) лейтенант полиции
e-mail:gradskij-v@mail.ru
тел: +79505640316
Gradsky Vladimir Evgenievich,
Lecturer of department of civil law disciplines,
Ural Law Institute of the Ministry of Internal Affairs of Russia
e-mail:gradskij-v@mail.ru
Work address: Russia, Yekaterinburg, Korepina str. 66, 620057,
tel: +79505640316

Аннотация. Статья посвящена сравнительно-правовому анализу моделей уголовной медиации. Автор статьи приходит к выводу о необходимости внедрении процедуры примирения в Российское законодательство в качестве альтернативы уголовному судопроизводству.

Ключевые слова: модели медиации, альтернатива уголовному судопроизводству, процедура примирения.

Annotation. The article is devoted to the comparative legal analysis of criminal mediation models. The author of the article comes to the conclusion that it is necessary to introduce the procedure into Russian legislation as an alternative to criminal proceedings.

Keywords: models of mediation, alternative to criminal proceedings, conciliation procedure.

В настоящее время одним из актуальных и все чаще обсуждаемых правовых вопросов является целесообразность распространения и использования во многих странах мира процедуры медиации. Что вполне объяснимо, поскольку медиация имеет ряд преимуществ по сравнению с традиционными судебными системами. Во-первых, отсутствие жестких процессуальных форм, во-вторых, добровольное исполнение принятых

решений, в-третьих, большая вероятность сохранения партнерских отношений после разрешения конфликта. В преимущества, так же следует добавить, непродолжительный характер данной процедуры, что является востребованным в условиях, загруженности судебных систем.

Правовые механизмы включения медиации в ряд официальных способов реагирования на преступления зависит от выбора «модели примирения»[1]. В мировой практике отражены различные виды процедуры медиации, разрешающие уголовно-правовые споры. Критерии их разграничения зависят от того, как процедура медиации расположена по отношению к традиционному уголовному процессу, присущему данному государству.

Медиация по уголовным делам выступает и в качестве процедуры, в которой реализуется модель восстановительного правосудия, и как часть уголовного процесса, и как компонент, его дополняющий. С целью построения определенного механизма процедуры медиации в УПК Российской Федерации, необходимо определиться с той моделью альтернативного решения спора, которую мы выберем в качестве основы для создания собственного аналога процедуры примирения.

На сегодняшний день имеется множество видов и моделей медиации, различия которых определяются исходными концептуальными представлениями, конкретными целями и процедурными особенностями[2].

Нам интересна классификация данная М. Гроенхейзеном[3], которую мы рассмотрим более подробно.

Для начала, проанализируем **медиацию как альтернативу уголовному судопроизводству,** так называемая - полицейская медиация. Она предполагает разрешение конфликта вне уголовного процесса и характеризуется тем, что уголовное дело либо вообще не возбуждается, либо выводится из судопроизводства на максимально ранних стадиях. По итогу, медиация становится внепроцессуальным методом разрешения конфликта. Интерес модели в том, что результат примирения полностью заменяет собой любую другую реакцию государства, а полномочия вынесения решения по делу находятся в руках должностных лиц.

---

[1]Карнозова Л.М. Введение в восстановительное правосудие (медиация в ответ на преступление): монография. – Москва: Проспект, 2021. – 264 с.

[2] Медиация. Практическое руководство по применению Гаагской конвенции от 25 октября 1980 года О гражданско-правовых аспектах Международного похищения детей. [Электронный ресурс] — URL:https://mediacia.com/wp-content/uploads/2018/06/Practical-Guide_RUS.pdf (Дата обращения: 02.03.2021)

[3] Гроенхейзен М. Медиация жертвы и правонарушителя: правовые и процедурные гарантии. Эксперименты и законодательство в некоторых европейских странах// Восстановительное правосудие/Под ред. И.Л. Петрухина. М., 2003. С. 16–19.

Примером такой модели выступает опыт Австралии. Законодатели сфокусировались на идеях, разработанных Д. Брейтауетом в 1989 году. Контроль над реализацией процедур примирения всецело передан полиции настолько, что сама процедура проходит в полицейском участке. Еще одним примером является, опыт Республики Франции, в которой проведение примирения возможно только до начала судебного разбирательства. Правонарушителю дается право самостоятельно ходатайствовать о назначении процедуры медиации, однако ее использование в каждом отдельном случае целиком отдано на усмотрение прокурора. В 2015 году, таким образом, было проведено более 33,600 медиаций. Из них 60% провели ассоциации медиаторов, а 40 % — медиаторы, работающие самостоятельно[4].

На наш взгляд, производство процедуры примирения на ранних стадиях расследования невозможно, так как в момент возбуждения уголовного дела у должностных лиц органов предварительного расследования, зачастую недостаточно информации для формирования полной картины происшествия. Аргументом в пользу нашей позиции выступает и тот факт, что стороны на протяжении всего уголовного судопроизводства имеют право отказаться от участия в процедуре примирения на любом этапе примирительной процедуры. Такое условие вытекает, прежде всего из Рекомендации Комитета министров Совета Европы № R (99) 19 «О медиации в уголовных делах», а также зачастую закреплено в уголовно-процессуальном законодательстве государства, использующего институт медиации. Представляется, что причины отказа могут быть самыми разнообразными. Поэтому очевидным является вопрос о злоупотреблениях правом с обеих сторон. Такая ситуация возможна, когда мотивом потерпевшего является получение возмещения несоразмерного с причиненным ущербом. Злоупотребление лица, совершившего деяние, может отразиться в затягивании сроков уголовного преследования посредством обращения к процедуре примирения. Помимо этого, стороны конфликта могут прийти к выводу о невозможности примирения по данной ситуации. И в таких случаях правоохранительные органы обязаны проводить полноценное производство по делу. Процедура медиации занимает определенное количество времени, при отказе от примирения должностные лица ОВД могут столкнуться с ситуацией невыполнимости закрепления следов преступления, что в очередной раз доказывает неспособность медиации удовлетворить потребности всех участников уголовного

[4]Crawford A., Goodey J. Integrating a multi-victim perspective into criminal justice through restorative conferences, 2015. 227–251 p.

судопроизводства на стадии возбуждения уголовного дела.

Не в пользу применения примирительной альтернативы на первоначальном этапе уголовного судопроизводства выступает и основной ее принцип конфиденциальности, который подразумевает под собой неразглашение сведений, полученных в ходе проведения медиации. Данное правило действует как на медиатора, так и на других участников процедуры. Они не вправе разглашать полученную информацию третьим лицам, в том числе компетентным органам, ведущим производство по уголовному делу. Этот факт приобретает особую значимость в случаях, когда результат медиативной сессии был неудачным.

Несмотря на рекомендации, указанные в международно-правовых актах, применять медиацию в уголовном процессе на начальных стадиях, считаем более разумным в реалиях нашего государства, проведение процедуры примирения при существовании хотя бы минимальной доказательственной базы. Это в свою очередь обезопасит участников уголовного процесса от возможных негативных последствий при неудачном проведении процедуры.

Далее рассмотрим медиацию, **как дополнение к уголовному процессу** – это проведение медиативных процедур, параллельно уголовному процессу.

Данная модель заслуживает внимания, так как является более гибкой относительно других форм медиации, ее использование возможно по тяжким составам преступления. Так же допустимо примирение после вынесенного судебного решения, в частности в местах лишения свободы.

Здесь необходимо отметить опыт Бельгии, в которой на данный момент действует развитая система восстановительного правосудия. Процедура медиации используется как для несовершеннолетних преступников, так и для совершеннолетних. Применение возможно для всех видов преступлений и на всех этапах уголовного процесса.

Особый интерес, в контексте рассматриваемого вопроса, вызывает опыт Шотландских процессуалистов. Система права в Шотландии напоминает российско-германскую концепцию разделения частного и публичного права. Поэтому необходимо затронуть вопрос разграничения принципов «законности» и «целесообразности» в контексте уголовного преследования. В уголовном процессе Шотландии позаимствован опыт английских коллег. Переговоры сторон осуществляются вне уголовного судопроизводства и без участия (контроля) правоприменителя. В процессуальном кодексе, в данном случае, содержится лишь указание на возможность обвиняемого и потерпевшего обратиться к медиации по делам, допускающим компромисс сторон.

Далее рассмотрим процедуру медиации, **как части уголовного процесса.** Главная особенность этой модели заключается в том, что результаты предыдущих стадий будут учитываться на каждом последующем этапе производства по делу. Предполагается, что она включена в судопроизводство как его составляющая. Это не означает, что посредничество регулируется уголовно-процессуальными нормами, но оно становится неким технологическим (внепроцессуальным) элементом судопроизводства. Здесь медиация не является полной альтернативой уголовному преследованию, просто последующая стадия судопроизводства учитывает результаты восстановительной программы, в частности, когда суд выносит окончательное решение с учетом результатов медиации. Если соглашение достигнуто, возможно, освобождение подсудимого от уголовной ответственности, либо смягчение наказания.

Ярким примером такой модели процедуры медиации выступает Республика Словения. Основной фигурой здесь является прокурор. Он решает, могут ли лица, проходящие по делу, реализовать процедуру медиации, и на какой стадии это должно произойти. Прокурор должен учесть природу, степень и обстоятельства правонарушения, личность и уголовное прошлое правонарушителя, а также уровень ответственности, который правонарушитель должен принять. Преступление не должно наказываться штрафом или сроком заключения более трех лет. В случае успешного завершения медиации (то есть выполнение соглашения, достигнутого между потерпевшим и правонарушителем), прокурор отклоняет уголовный иск. Основание проведения медиации возникает только по делам небольшой и средней тяжести[5].

В Австрии используется прямая непосредственная медиация между пострадавшим и правонарушителем. Как и в предыдущем примере, основным субъектом правоприменения выступает прокурор. Применение или неприменение медиации находится в его юрисдикции[6]. Однако прокурор в Австрии являтся лицом не только инициирующим процедуру медиации, но и осуществляющим контроль над передачей дела в судебное рассмотрение. Он следит за дальнейшей судьбой дела вплоть до отказа от уголовного преследования.

В Российской Федерации на данный момент довольно сложно представить себе ситуацию, при которой прокурор имел бы полномочия,

[5] Braithwaite J. Restorative justice: assessing an immodest theory and a pessimistic theory. In Crime and Justice: A Review of Research, Tonry, M, Chicago Press. 1999. 25–27 p.
[6] Dignan J., Cavadino M. Towards a framework for conceptualising and evaluating models of criminal justice from a victim's perspective. International Review of Victimology, № 4, 1996, 153–182 p.

касающиеся оценки виновности лица, его способности к исправлению, а также назначения справедливого наказания. Однако, проведя анализ некоторых стран и существующих в их правовом поле медиативных моделей, мы приходим к выводу о том, что во многих странах такая система уже встроена и работает[7].

В разных государствах имеются различия в подходах к применению альтернативных процедур примирения. Наблюдается зависимость от устоявшихся правовых институтов в уголовном процессе каждого конкретного государства и того механизма который, законодатель выстраивает для реализации примирительных процедур. В Бельгии они влияют на ход процесса на всех этапах судебного разбирательства (перед началом полицейского расследования, пред началом суда, при определении наказания, после отбывания наказания); в некоторых странах они только на одном этапе (Франция и Голландия — до начала судебного процесса; Дания — при определении наказания). В других случаях результаты медиации или иных процедур восстановления имеют значение на досудебном этапе и при определении наказания. Стоит заметить, что медиация и другие программы восстановительного правосудия, используемые в уголовном процессе, давно зарекомендовали себя с положительной стороны не только в большинстве Европейских стран, но и по всему миру.

Несмотря на существование разных моделей восстановительных программ уголовной медиации, наиболее предпочтительной, на наш взгляд, для применения в Российской Федерации является модель медиации, как составной части уголовного процесса. Для этого в уголовное судопроизводство требуется ввести медиатора как участника дела, а сами переговоры сторон с привлечением посредника должны проходить в соответствии с нормами УПК и в рамках производства по уголовному делу.

[7]Градский В.Е. Предпосылки внедрения процедуры медиации в уголовном процессе России// Вестник Уральского юридического института МВД России. – 2020. – №2. – С. 11–15.

Список используемой литературы:

1. Карнозова Л.М. Введение в восстановительное правосудие (медиация в ответ на преступление): монография. – Москва: Проспект, 2021. – 264 с.

2. Практическое руководство по применению Гаагской конвенции от 25 октября 1980 года «О гражданско-правовых аспектах Международного похищения детей» [Электронный ресурс]. — URL:https://mediacia.com/wp-content/uploads/2018/06/Practical-Guide_RUS.pdf (Дата обращения: 02.03.2021)

3. Гроенхейзен М. Медиация жертвы и правонарушителя: правовые и процедурные гарантии. Эксперименты и законодательство в некоторых европейских странах// Восстановительное правосудие/Под ред. И.Л. Петрухина. М., 2003. С. 16–19.

4. Crawford A., Goodey J. Integrating a multi-victim perspective into criminal justice through restorative conferences, 2015. 227–251 p.

5. Braithwaite J. Restorative justice: assessing an immodest theory and a pessimistic theory. In Crime and Justice: A Review of Research, Tonry, M, Chicago Press. 1999. 25–27 p.

6. Dignan J., Cavadino M. Towards a framework for conceptualising and evaluating models of criminal justice from a victim's perspective. International Review of Victimology, № 4, 1996, 153–182 p.

7. Градский В.Е. Предпосылки внедрения процедуры медиации в уголовном процессе России// Вестник Уральского юридического института МВД России. – 2020. – №2. – С. 11–15.